



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
СУДАЛГААНЫ ТӨВ

## БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)



- ◊ Эдийн засгийн бодлого
- ◊ Нийгмийн бодлого
- ◊ Илтгэл, өгүүлэл, нийтлэл ...  
бусад

СУДАЛГААНЫ САН

DDC  
328015  
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (XI боть, 2012)  
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусурэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун, О. Нарантуяа



ISBN 978-99929-895-6-4

**ГАРЧИГ**

Судалгааны эмхтгэл - XI боть

**УИХ -ЫН 2011 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН  
СУДАЛГААНЫ АЖЛУУД****УДИРТГАЛ ХЭСЭГ**

• ӨМНӨХ ҮГ	7
------------	---

**1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ**

1.1. УИХ –д өргөн баригдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн тогтоолын төсөлд хийсэн шинжилгээ	10
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Б. Дуламсүрэн, Ц. Элбээзаяа	
1.2. Монгол Улсын 2012 оны төсвийн төслийн шинжилгээ	21
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Ц. Батдорж, Г. Билгээ	
1.3. Монгол Улсын төсвийн харилцаан дахь төсвийн төвлөрөлийн асуудал, төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн дүн шинжилгээ	39
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Д. Мягмарцэрэн, Ц. Батдорж, Г. Билгээ, Б. Дуламсүрэн, Ч. Онончимэг	
1.4. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаа, түүнийг эрхлэх байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал	56
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Г. Гэрэл, Ц. Болормаа, Б. Тамир	
1.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулж буй тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний нэр төрөл болон хувь хэмжээний харьцуулалт	115
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Ч. Онончимэг, Ц. Элбээзаяа	
1.6. Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого ба хэрэгжилтийн явц, олон нийтийн санал шүүмж	189
Д. Мягмарцэрэн, Ч. Базар ( <i>Ph.D.</i> ), Ц. Батдорж, С. Дорждагва, Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг, Ч. Онончимэг, Н. Түвшинтөгс, Ц. Элбээзаяа	
1.7. Нидерландын вант улсын албан татварын зарим төрөл	218
Ц. Норовдондог ( <i>Ph.D.</i> ), Г. Билгээ	

1.8	<b>Мөнгөний бодлогын алтернатив хэлбэрүүд, тэдгээрийн давуу болон сул талууд</b>	225
	<i>Ц. Норовдондог (Ph.D) , Ж. Элбэгзаяа, Б. Болортуюа</i>	
1.9	<b>Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн тулгамдсан асуудал: Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж болон кастодиан үйлчилгээ</b>	236
	<i>Ц. Норовдондог (Ph.D)</i>	
1.10	<b>Монгол Улсын нийгэм, эдийн засаг дахь төрийн бодогын уялдаа холбоо, иргэдийн оролцоо</b>	256
	<i>Ц. Норовдондог – УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Эдийн засгийн ухааны доктор (Ph. D) Хамтран оролцсон: Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа, Ц. Болормаа, Г. Билгээ</i>	

## 2. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

2.1	<b>Энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмжийн талаархи харьцуулсан судалгаа</b>	276
	<i>Ц. Төвүүсүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг, А. Паgма, Б. Хатантуул</i>	
2.2	<b>Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн стандарт, эрх зүйн орчны талаархи олон улсын туршлага, харьцуулсан судалгаа</b>	300
	<i>Г. Алтан - Оч (Ph.D), С. Дорждагва, Ө. Мөнхтунгалаа, Б. Мөнхцэцэг</i>	
2.3	<b>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, бодлого эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ</b>	313
	<i>Ц. Төвүүсүрэн, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа</i>	
2.4.	<b>Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА, 2011) -ийн товч танилцуулга</b>	330
	<i>УИХ -ын Тамгын газрын Эрх зүй хууль тооцтоомжийн хэлтэс, Судалгааны төв</i>	
2.5	<b>Ясли цэцэрлэгийн тоо болон барилга байгууламж, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн бус өмчит их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудын төлбөрийн талаахи судалгаа</b>	334
	<i>T. Мягмаржав</i>	

УИХ  
СУДАЛГААНЫ САН

**3. ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад**

3.1 Эдийн засгийн ёсөлт ба хөрөнгийн зах зээлийн хөгжлийн харилцан хамаарлын асуудал	.....	350
--	-------	-----

*Ц. Норовдондог /УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, доктор Ph.D/, Хамтран оролцсон:  
Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа*


3.2 Байгалийн баялгийн зохицтой ашиглах нь: Иргэдийн оролцоог хангах болон эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодитой хэрэгжүүлэх талаар	.....	363
---	-------	-----

*Ч. Базар (Ph.D)*

**• ХАВСРАЛТ**

УИХ -ын 2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа	.....	372
--	-------	-----

*(XII ботид орсон бусад судалгааны жагсаалт)*



**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ӨМНӨХ ҮГ

Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд УИХ -ын Тамгын газраас үзүүлж буй судалгаа -шинжилгээ, мэдээлэл, лавлагааны үйлчилгээ нь УИХ-аар батлан гаргаж буй хууль тогтоомж, бодлогын шийдвэрүүдийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, хууль хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтээс үүдэн гарах эерэг, сөрөг үр дагаврыг бодитойгоор урьдчилан харж тооцоо судалгаатайгаар асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийг нийгмийн эрэлт шаардлагад нийцүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2009 оноос хойш Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв нь ээлжит чуулган бүрийн төгсгөлд УИХ-ын гишүүдийн захиалгаар гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг эмхэтгэн цуврал боть болгон хэвлүүлж эрхэм гишүүдийн ажлын хэрэгцээнд хүргүүлдэг уламжлал тогтсон юм. 2009 оноос хойш тус төв нь нийтдээ 12 боть судалгааны эмхэтгэл номыг хэвлүүлэн гаргасан нь УИХ -ын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг болоод зогсохгүй төрийн бодлого боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэхэд нь төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачид, уншигчдад мэдээллийн эх сурвалж, гарын авлага болон ашиглагдаж байна.

Энэ удаад эрхэм гишүүд, уншигчид та бүхэнд УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эмхэтгэн гаргадаг “Бодлогын судалгаа, шинжилгээ” номын XI, XII дугаар эмхэтгэлийг толилуулж байна. Эдгээр эмхэтгэлд 2011 оны намрын чуулганы хугацаанд Судалгааны төвийн гүйцэтгэсэн 34 судалгааны тайлан, 9 эрдэм шинжилгээний илтгэл багтсан бөгөөд эдгээр нь Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн болон хэлэлцэхээр төлөвлөж буй асуудлууд, улс орны өмнө тулгамдсан чухал асуудлуудыг хөндсөн цаг үеийн ач холбогдол бүхий лавлагаа мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний ажлууд юм.

Улсын Их Хурал 2011 оны намрын чуулганы хугацаанд УИХ -ын сонгуулийн тухай хууль, Төрийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Компанийн тухай хууль, 2012 оны Монгол улсын төсөв, мөнгөний бодлого зэрэг 24 бие даасан хуулийг батлан гаргаж, 104 хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Мөн 48 тогтоолыг УИХ-аар батлан гаргасан байна.

Эдгээр хууль, тогтоомжид холбогдох асуудлаар УИХ -ын гишүүдийн захиалгаар болон Судалгааны төвийн санаачлагаар судалгаа, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгсөөр ирлээ. Цаг үеийн тулгамдсан асуудлууд, гишүүдийн сонирхсон танин мэдэхүйн болон хуулийн төсөл боловсруулахтай холбоотой судалгааны ажлуудыг ч мөн эдгээр эмхэтгэлд оруулав.

2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төв УИХ -ын гишүүдийн захиалгаар 22, төвийн санаачлагаар 28, УИХ -ын Тамгын газрын захиалгаар 3 судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Сүүлийн жилийн дэд Монгол улсад бодлого судлалын салбар улам бүр эрчтэй хөгжих шаардлага бий болж байна. Төрийн бодлого, шийдвэрийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, аливаа асуудалд судалгаа тооцоотой хандахыг хууль тогтоогдоос ард түмэн улам их хүсэх боллоо.

Нэг талаас, мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа иргэдийн боловсрол мэдлэг, мэдээллийн хангамж нэмэгдсэнээр төр засгийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандах байдал нэмэгдэж байна. УИХ -аар батлагдан гарч буй хууль, тогтоомжууд нийгэм-эдийн засгийн харилцааг зөв зүйтэй зохицуулж чадаж байгаа эсэх, хууль батлагдан гарсанаар улсын төсөвт хэдийн хэмжээний ачаалал ирэх, төрийн санхүү, мөнгөний бодлого зөв явж байгаа эсэх зэрэг тодорхой асуудлуудад иргэд шүүмжлэлтэй хандаж байна. Нөгөө талаас,

улам бүр даяарчлагдаж байгаа дэлхийн эдийн засгийн орчил дунд олон улсын стандарт болон өөрийн орны өвөрмөц онцлогт тохирсон ухаалаг, уян хатан бодлого явуулахыг эрхэм түшээд маань хичээж, аливаа асуудалд мэдлэг, мэдээлэлтэй хандахыг хүсэж байна.

Эдгээр зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Тамгын газрын Судалгааны төв чухал үүрэг гүйцэтгэж, УИХ -ын гишүүдийг шуурхай мэдээлэл, судалгаагаар тогтмол хангаж байна. УИХ -ын гишүүдийг судалгаа, мэдээллээр хангах үйл ажиллагааг улам бүр боловсронгуй болгохын тулд УИХ -ын номын санг цахим хэлбэрт шилжүүлэх төслийг БНТУ -ын ТИКА олон улсын байгууллага, БНСУ -ын КОИКА олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн АНУ -ын Конгрессын Судалгааны алба, IRI, HDP зэрэг олон улсын байгууллага, бусад орнуудын ижил түвшний парламентын судалгааны албадтай хамтран ажиллаж судлаачдын ур чадварыг сайжруулах, мэргэшүүлэхэд анхаарч байна. Судалгааны төв нь зөвхөн судалгаа, мэдээллээр хангах төдийгүй эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, сургалт семинар зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг мэргэшсэн алба болон өргөжих учиртай юм.

УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргадаг эдгээр судалгааны эмхэтгэлүүд нь мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангасан системтэй, цэгцтэй мэдээлэл болохоос гадна бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, судлаачдын гарын авлага, ширээний ном болон ашиглагдана гэдэгт найдаж байна.

*УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц. Шараавдорж*



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**1**

**БҮЛЭГ**

---

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**УИХ -Д ӨРГӨН БАРИГДСАН ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2012 ОНД  
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ  
ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Ц. Норовдондог (*Ph.D*), Б. Дуламсүрэн, Ц. Элбэгзаяа

Улс орон бүр өөрийн орны онцлогт тохирох мөнгөний бодлогын хэлбэрийг сонгох нь тухайн цаг үеийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх угтвар нөхцөл хэр хангагдсан зэргээс хамаардаг. Хэдийгээр манай улсад эдийн засаг өсч байгаа боловч инфляцийн түвшин зорилтот түвшингөөс хэтэрч 10-аас дээш хувьтай гарсаар байгаа тул Монголбанк мөнгөний бодлогоо дахин эргэн харж, тухайн нөхцөл байдалд таарсан шинэчлэлт хийх шаардлага гарч байна.

Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох бодлого буюу инфляцийг тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгдсэн бодлого явуулж ирсэн. Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэх нь инфляцийг бага түвшинд тогтвортой барьж, улмаар ирээдүйн тодорхой бус байдлыг бууруулж өгдөг давуу талтай хэдий ч, хэтэрхий их болгоомжлороос болж эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, валютын ханшиг угян хатан нөхцөлд явуулахыг шаарддаг учраас ханшийн тогтвортгүй байдлыг ихэсгэж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Инфляцийг онилох бодлогын гол хэрэгсэл нь хүүний түвшин бөгөөд Төв банк бодлогын хүүгээ өөрчлөх замаар захын болон арилжааны банкуудын хүүнд, улмаар нийт эрэлт болон инфляцид нөлөөлдөг. Инфляцийг онилох мөнгөний бодлогыг баримтлахад Засгийн газрын үүрэг чухал байдаг бөгөөд уг бодлогын гол үр дүн Монголбанк болон Засгийн газар хэрхэн хамтран ажиллахаас шууд шалтгаалдаг байна.

Харин манайд энэ үүргийг зөвхөн Төвбанк хэрэгжүүлж байгаагаас Монголбанк болон Засгийн газрын хооронд бодлогын уялдаагүй зөрчилдөөнтэй байдал гарч байна. Тухайлбал: Эдийн засаг өсөхийн хэрээр төсвийн зарлага тэлэх нь гарцаагүй юм. Төсвийн зарлага тэлэхээр инфляци өсөх учир Монголбанк бодлогын хүүгээ өсгөж ингэснээр эдийн засгийн өсөлт саарч байна. Зарим орны туршлагаас хараад инфляцийн зорилтыг дан ганц Төвбанк тодорхойлдоггүй Засгийн газар, Төвбанк, эсвэл хамтран тодорхойлдог байна. Тухайлбал:

Хүснэгт 1: Инфляцийн зорилтот түвшинг тогтоох үүрэг

Төвбанк	<ul style="list-style-type: none"> <li>Чили, Колумби, Финлянд, Испани, Мексик, Польш, Швейцарь, Тайланд</li> </ul>
Засгийн газар	<ul style="list-style-type: none"> <li>Бразил, Исланд, Израйл, Норвеги, Англи</li> </ul>
Засгийн газар болон Төвбанк хамтран	<ul style="list-style-type: none"> <li>Австрали, Канад, Чех, Унгар, Солонгос, Шинэ Зеланд, Өмнөд Африк</li> </ul>

Мөн инфляцийг оилсон бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн нөхцөл бүрдсэн байхыг шаарддаг байна. Үүнд:

- Хараат бус байдал
- Эдийн засгийн бүтэц
- Эрүүл санхүүгийн салбар

- Өндөр хөгжсөн техникийн дэд бүтэц

Хараат бус байдал гэдэгт төсвийн болон улс төрийн дарамтаас хамааралгүй үйл ажиллагаагаа бие даан явуулдаг байх ёстай.

Эдийн засгийн бүтэц.

- Инфляцийг үр дүнтэй хянахын тулд эдийн засаг экспортын голлох бүтээгдэхүүний үнэ ханшаас хэт мэдрэмтгий биш байх, долларжих явц бага түвшинд байх шаардлагатай байдаг байна. Харин манайх дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ ханшнаас хараат гэж хэлэх боломжтой юм.

Өндөр хөгжсөн техникийн дэд бүтэц.

- Инфляцийг онилох бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд оновчтой инфляцийн таамаглал судалгаашинжилгээг тогтолчийх, загварчлалхийх, мэдээлэл боловсруулах техник хангамж, нарийн мэргэшсэн боловсон хүчин зийлшгүй шаардлагатай.

Эрүүл санхүүгийн салбар.

- Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүгийн систем тогтвортой, банкны систем эрүүл, хөрөнгийн зах зээл сайн хөгжсөн байх шаардлагатай байдаг. Манайд өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээл сайн хөгжсөн гэж үзэх боломжгүй юм. Санхүүгийн системийн 95 хувийг банкны салбар эзэлж байгаа. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаагаас хувийн секторын мөнгө босгох боломжийг хязгаарлаж, санхүүгийн салбар дахь банкны давамгайлал багасахгүй, банкны санхүүжилтээс хараат хэвээр байх, банкнаас зээл авахаас өөр санхүүжилтийн сонголтгүй болгож байна.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, үр ашигтай, үйл ажиллагаагаа явуулах эдийн засаг, хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, урт хугацаат, хямд эх үүсвэр татах боломжийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгслүүдийг олшуулж, хөрөнгийн захын хөрвөх чадварыг сайжруулах нь зээлийн хүүг бууруулах нэг хүчин зүйл болох юм. Мөн богино хугацаанд илүүдэл эх үүсвэрээ байршуулах хөрвөх чадвар сайтай үнэт цаас, бонд зэрэг санхүүгийн хэрэгслүүд түгээмэл биш байгаа нь банкууд илүүдэл хөрөнгөө оновчтой байршуулах боломжийг хязгаарлаж, эрсдэлээс айж үр ашиггүй барьж, эрсдэлийн болон бусад зардлыг зээлийн хүүгээ өндөр тогтоо замаар нөхөхөд хүргэж байна.

Монголбанк бодлогын хүнгээ өсгөж бууруулсны ачаар л инфляци ийм хувьтай гарсан, бодлогын хүүг өсгөөгүй байсан бол үүнээс илүү ч байх байсан мэтээр тайлбарладаг. Бодлогын хүнг зарлахдаа одоогийн инфляцийн хурсэн түвшинг харгалзан бодлогын хүнг хөдөлгөж байна. Одоогийн инфляци биш харин ирээдүйн инфляцийг урьдчилан тооцоолсны үндсэн дээр шийдвэр гаргах ёстай. Ямар эрсдэл байгааг нарийн судлах ёстай.

Дээрхээс дүгнээд харахад манайд инфляцийг онилох бодлого баримтлах нөхцөл бүрэн бүрдээгүй байхад уг бодлогыг баримталж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бүтэц болон санхүүгийн салбарын нөхцөл нь уг бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих нөхцөл болж чадахгүй байна. Хэдийгээр Дэлхийн банк болон ОУВС зэрэг олон улсын байгууллагууд Монгол банкны явуулж буй бодлогыг сайшааж төсвийн зардал тэлэхийн хэрээр бодлогын хүүг нэмэх шаардлагатай хэмээн зөвлөж байгаа хэдий ч Монгол банк мөнгөний бодлогын илүү оновчтой сайн хувилбарыг дахин бодолцож үзэх хэрэгтэй байна.

\* \* \*

**Бодлогын хүү:**

Монголбанк 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.25 хувьд хүргэх шийдвэр гаргасан. YCHX-ноос мэдээлснээр 2011 оны 9 дүгээр сарын байдлаар ХҮИ-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотынх жилийн 11.9 хувьд хүрээд байгаа бөгөөд төсвийн зардал хурдтай тэлж, Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож, зээлийн өсөлт хурдасч байгаа зэрэг нь нийт эрэлтийг нэмэгдүүлж байна.

Нийт нийлүүлэлт болон эдийн засгийн бодит хүчин чадал дорвитой өсч амжаагүй байхад нийт эрэлт ийнхүү огцом өсөх нь сурь үнэ өсөх дарамтыг бий болгож байгаа тул бодлогын хүүг нэмэхээс өөр аргагүйд хүрсэн гэж Монголбанк тайлбарлаж байна. Харин бодлогын хүү өсөхөд бусад хүү болон арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүү дагаж өөрчлөгддөг. 2007 оноос хэрэгжүүлж эхэлсэн бодлогын хүүний өөрчлөлтүүдийг харууллаа.

**Хүснэгт 2: Монголбанкны хүү, жилийн хувь**

Хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн	Бодлогын хүү	Репо	Овернайт	Барьцаат зээл
2011.10.25	12.25	16.25	21.25	20.25
2011.08.29	11.75	15.75	20.75	19.75
2011.04.28-6.23	11.50	15.50	20.50	19.50
2010.05.12 - 2011.2.24	11.00	15.00	20.00	19.00
2009.09.30	10.00	14.00	19.00	18.00
2009.06.12	11.50	17.50	21.50	20.50
2009.05.12	12.75	18.75	22.75	21.75
2009.03.11	14.00	17.00	21.00	20.00
2008.11.19	9.75	18.00	23.00	13.86
2008.09.10 - 2011.11.13	10.25	18.00	23.00	13,86
2008.03.19	9.75	18.00	23.00	
2007.11.21	8.40	18.00	23.00	
2007.10.17	7.40	18.00	23.00	
2007.07.09	6.40	18.00	23.00	

Эх сурвалж: <http://www.mongolbank.mn/dblistmongolbankrate.aspx>

Бодлогын хүү өсөхөд бусад хүү болон арилжааны банкуудын хадгаламж, зээлийн хүү өсдөг. Эдгээр хүүний өөрчлөлтийн үр дүн нь хэзээ мэдэгдэх вэ, тухайлбал бодлогын хүү өссөнөөр зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт багасч, зээл олголт буурч, банкин дахь хадгаламжийн хэмжээ өсдөг. Тэгвэл бодлогын хүүг хэдэн хувиар нэмсэнээс дээрх үзүүлэлтүүдэд ямар өөрчлөлт орсныг тухай бүрд нь мэдэх боломжгүй байдаг. Учир нь мөнгөний бодлогын хүүний нөлөөлөл тэр даруйдаа мэдрэгдэггүй тодорхой хугацааны хоцролттойгоор нөлөөлдөг. Нийт зээлийн өсөлт болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь нэрлэсэн ДНБ -ний өсөлтөөс давсан үед эдийн засаг халалттай байна гэж үздэг. Энэ үзүүлэлтийг тооцож үзье:

## Хүснэгт 3

д/д	Үзүүлэлт	2009 он		2010 он		2011-9 сар	
		Мөнгөн дүнгээр тэрбум төгрөг	Өсөлтийн хувь	Мөнгөн дүнгээр тэрбум төгрөг	Өсөлтийн хувь	Мөнгөн дүнгээр тэрбум төгрөг	Өсөлтийн хувь
1	Нийт зээл	2655,0	0,7%	3264,8	23,0%	5060,4	64,0%
2	Мөнгөний нийлүүлэлт	2880,0	26,9%	4677,0	62,5%	6063,9	57,4%
3	Нэрлэсэн ДНБ	6590,6	42,5%	8255,1	25,2%	10157,2	23,0%

Дээрх хүснэгтэд тооцоолсноор 2010 - 2011 онд зээл болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлт огцом нэмэгдэж харин нэрлэсэн ДНБ -ний өсөлт бага байгаагаас харахад манай эдийн засаг халалттай байгаа нь харагдаж байна. Түүнчлэн манай орны хувьд эдийн засгийн "халалт"-тай жилүүдэд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангартаг нийтлэг шинж ажиглагддаг. Энэ үед гадаад валютын нөөц өсч, үүний сөрөг үр дагавар болох мөнгөний нийлүүлэлт эрс өсдөг хандлага бий.

Энэ байдал нь эргээд инфляци, санхүүгийн тогтвортгуй байдлыг дагуулдаг. Өөрөөр хэлбэл эдийн засаг дахь нийт эрэлт маш ихээр нэмэгдэж, бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өсөлт, нийлүүлэлтийн дутагдалаар дамжин эдийн засгийг халааж байгаагаар тайлбарлагдаж байна. Нөгөө талаас уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, түүнийг дагасан их хэмжээний мөнгөн ургалын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт огцом нэмэгдэж улмаар мөнгөний зөрүүг халааж байгаа ба төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр нийт эрэлтийг урамшуулж иргэдийн хэрэглээгээр дамжин эдийн засаг халж байна гэж үзэж болохоор байна.<sup>1</sup>

Эдийн засгийн халалтын нэг илрэл нь цалин хөлс, тэтгэврийн өсөлтөөр илэрдэг гэж эдийн засагчид үздэг ч нөгөө талаас цалин хөлс, тэтгэвэр нэмэгдэх нь хөгжих буй эдийн засагтай манай орны хувьд эдийн засгийн халалт гэж үзэж болохгүй бөгөөд харин халалтын үр дагавар хэлбэрээр илрэн гарч ирж байж болно. Өнөөдөр иргэдийн авч буй бодит цалин эдийн засгийн төлөвтэй харьцуулахад тийм ч өндөр биш байгаа тул цалин хөлсийг өсгөх нь буруу гэж үзэх үндэслэл багатай байна.

2012 оны төсвийн төслийн нийт зардал өмнөх оныхтой харьцуулахад 3453,0 тэрбумаар өссөн бөгөөд үүнээс цалин, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл 446,3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн буюу энэ нь нийт зарлагын өсөлтийн 12,9 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, цалин хөлс 56,5 хувиар нэмэгдэх өндөр өсөлт харагдаж байгаа боловч бодит байдал дээр энэ 56,5 хувийн өсөлтийн 20,0 хувь нь эргээд улсын төсөвт татвар хэлбэрээр буцаж төвлөрнэ. Үүнээс гадна цалингийн өсөлтөөс инфляцийн түвшинг хасаж тооцоход бодит цалингийн өсөлт ойролцоогоор 26,5 орчим хувиар нэмэгдэнэ. Төсөвт байгууллагад ажиллагсадын цалинг 56,5 хувиар нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгасны дагуу сүүлийн хэдэн жилийн цалингийн жигнэсэн дундаж өсөлт болон инфляцийн хоорондын хамаарлыг харья:


Зураг1 -ээс харахад цалингийн өсөлтөөс шалтгаалж инфляци шууд өсдөг гэсэн таамаглал нотлогдохгүй байна. Тухайлбал:

- 1998 онд цалингийн өсөлт 26,5 хувь байхад инфляци 6,0 хувь /өмнөх онд инфляци - 20,5 хувь/

<sup>1</sup> Хэт халалтаас хэт эрсдэл рүү, П.Хишигбаяр. <http://iishig.blogspot.com/2011/09/blog-post.html>

- 2000 онд цалингийн өсөлт 33,2 хувь байхад инфляци өмнөх оныхоо үзүүлэлтээс буурч 8,1 хувьтай болсон байна. /өмнөх онд инфляци - 10,0 хувь/
- 2002 онд цалингийн өсөлт 23,7 хувь байхад инфляци 1,7 хувь /өмнөх онд инфляци - 7,9 хувь/
- 2003 онд цалингийн өсөлт 9,2 хувиар буурсан байхад инфляци 4,7 хувь /өмнөх онд инфляци - 1,7 хувь/
- 2006 онд цалингийн өсөлт 31,0 хувь байхад инфляци 4,7 хувь болж буурсан /өмнөх онд инфляци - 9,5 хувь/ байгаагаас цалингийн өсөлт инфляцийг хөөрөгдөх шууд нөхцөл болохгүй байна.

Зураг 1. Төсөвт байгууллагад ажиллагсдын жигнэсэн дундаж цалин, түүний өсөлт



Дээрх зургаас харахад цалин болон инфляци нь адил чиглэлтэй буюу эерэг хамааралтай байна гэж дүгнэж боломгүй байна. Эндээс бид инфляци болон цалин бие биенийхээ өсөлтийн шалтгаан болж байна гэж шууд хэлэх боломжгүй юм.

Судалгаанаас үзэхэд манай орны хувьд цалингийн түвшинг 10% хүртэл хувиар нэмэгдүүлж буй тохиолдолд тийм хүчтэй инфляци бий болгохгүйгээр бодит цалинг хамгийн их өсөлттэй байлагах боломжтой байна. Мөн цалинг өсгөхдөө нэг дор өндөр хувиар бус харин 20-30 хувь өсгөхөөр төлөвлөж буй тохиолдолд 10-15 хувиар 2 удаа хооронд нь 2 улирлын зйтэй (1 жилдээ багтаан) нэмэгдүүлэх нь эдийн засагт өндөр уүнийн өсөлт дагуулахгүйгээр бодит худалдан авах чадварыг дээшлүүлэх бүрэн боломжтой байна.<sup>2</sup> Нөгөө талаас эдийн засагт нэмсэн бэлэн мөнгөний нийлүүлэлтийг импортын бараа худалдан авахад бус бодит үйлдвэрлэл руу оруулахад Засгийн газар онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна.

#### Инфляцийн түвшин:

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд

<sup>2</sup> "Цалин болон орлого, инфляци хоорондын уялдаа" Мөнгөний Бодлогын Хэлтсийн эдийн засагч Д.Ган - Очир

Судалгааны эмхтгэл, XI боть

дурьдсанаар хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тоонд буюу 10 хувиас хэтрүүлэхгүй байхаар, 2013-2014 онд 8 хувиас хэтрүүлэхгүй байхаар тусгасан байна. Бусад орнуудын инфляцийн түвшинтэй харьцуулахад 10 хувь гэдэг хэдий өндөр боловч манай орны нөхцөл байдалд үүнээс нам зорилт дэвшигүүлэх боломжгүй хэмээн Монголбанк үзэж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар үндсэн чиглэлд инфляцийг хэдэн хувьд барихаар зорилт тавьсан, үр дүн буюу хэрэгжилтээр хэдэн хувьтай гарч байсныг хүснэгт 1 -д харууллаа.

Хүснэгт 4

Үзүүлэлтүүд	Үндсэн чиглэлээр батлагдсан инфляцийн зорилтот түвшин	Гүйцэтгэлээр гарсан үр дүн буюу инфляцийн түвшин	Төв банкны бодлогын хүү	Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь	ДНБ-ний өсөлт хувь
2007 он	5,0	17,8	7,4	37,9	10,2
2008 он	6,0	22,1	10,25	40,2	8,9
2009 он	<10%	4,2	14,0	48,6	-1,3
2010 он	<10%	13,0	11,0	43,3	6,1
2011 он ХБГ	<10%	11,9	12,25	52,1	20,0
2012 он төсөөлөл	<10%	-	-	39,4	25,6

\*2011 оны эхний 9 сарын байдлаар

Хүснэгтээс үзэхэд 2007-2008 онуудад инфляцийн түвшин үндсэн чиглэл дэх зорилтот түвшнээс 3,0-3,5 дахин их гарсаныг судлаачид нь эдийн засгийн хямралтай холбон тайлбарлаж байсан. Өөрөөр хэлбэл, сүүлийн таван жилийн байдлаар үндсэн чиглэлд инфляцийг 10-аас доош хувьд барихаар зорилт тавьсан нь 2009 онд л хэрэгжсэн байна. Онолын хувьд Төвбанк нь мөнгөний: хатуу зөвлөн бодлогын алийг нь сонгох вэ гэдэг асуулт тулгардаг.

Мөнгөний зөвлөн бодлого гэдэг нь зах зээлийн эдийн засгийн нөхцөлд Төвбанкнаас явуулж буй мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх зорилготой бөгөөд гол зорилго нь хөрөнгө оруулалтыг дэмжих, үндэсний нийт бүтээгдэхүүнийг өсгөх, банкны нөөцлөх хэрэглээг бууруулж, ажилгүйдлийг багасгахад чиглэгддэг. Эдийн засгийн уналтын үед ажилгүйдлийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг өсгөн зөвлөн бодлогыг хэрэгжүүлэх нь зохимжтой байдаг.

Мөнгөний хатуу бодлого гэдэг нь заавал байлгах нөөцийг ихэсгэх, зээлийн хүүг өндөрсгөх гэх мэт мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглан мөнгөний нийлүүлэлтийг багасгахад чиглэгддэг бөгөөд зорилго нь дотоодын үнийн өсөлтийг бууруулж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортжуулах буюу ханш уналтыг хязгаарлахад чиглэгддэг. Эдийн засгийн мөчлөгийн сэргэлтийн болон оргил үед үнийн ерөнхий түвшний өсөлтөөс урьдчилан сэргийлэх, улмаар бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлдэг.

Манайд эдийн засгийн хямралаас хойш мөнгөний хатуу бодлогыг баримталж байгаа бөгөөд эдийн засаг нэг үеэд бодоход сэргэж энэ жил гэхэд эдийн засаг 3 дугаар улирлын байдлаар 17,0 хувиар өсөөд байна. Уг нь эдийн засаг өсөхийн хэрээр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх зүй ёсны боловч Монголбанк бодлогын хүүгээ дахин нэмэгдүүлж 12,25 болголоо.

Хэдийгээр, 2011 оны 3 дугаар улиралын байдлаар эдийн засгийн өсөлт 16,7<sup>3</sup> хувьтай гарсан ч энэ нь бодит өсөлт мөн үү гэдэг нь эргэлзээтэй юм. Учир нь эдийн засаг өсөлттэй гарсан ч иргэдийн худалдан авах чадвар өмнөх үеийнхээс буурсан үзүүлэлт гарсан байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлт 17,0 хувь гарсан боловч энэ бодитой өсөлт мөн үү, энэ нь ард иргэдийн амьдралд яж мэдрэгдэж байна гэсэн асуудал гарч ирж байна. Үүнээс харахад онолын хувьд манай улс мөнгөний бодлогоо зөөлрүүлэх нь эдийн засгийн бодит өсөлт бий болгох суурь нөхцөл болох юм.

Гэтэл, Монголбанк инфляцийг онилсон мөнгөний хатуу бодлого баримталж байна. Ийнхүү хүчээр инфляцийг барих гэж оролдох нь эдийн засгийн өсөлттэд сөргөөр нөлөөлдөг. Үнийн өсөлт зорилтот түвшнээс хэтэрч нэмэгдэх хандлагатай бол мөнгөний хатуу бодлого явуулдаг бөгөөд энэ нь зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг хумиж, зээлийн хүүг өсгөж, ингэснээр зээлийн хэмжээг бууруулж, бодит эдийн засгийг бууруулахад хүргэдэг. Ийм шийдвэр гаргах үндэслэл нь нэг бол гадаад зах зээлийн нөлөөллөөс, нөгөө талаас сангийн бодлогын шийдвэрээс үүдэлтэйгээр гардаг.

Иймээс ч Монгол Улсын хувьд мөнгөний болоод сангийн бодлогын хамгийн муу, буруу хослолыг хэрэгжүүлж байна гэж судлаачид үздэг. Тухайлбал, Төсвийн зарлага тэлэхийн хэрээр монгол банк мөнгөний хатуу бодлого явуулж бодлогын хүүг нэмэгдүүлэх арга хэмжээ авдагаас төрийн 2 байгууллагын бодлого зөрчилтэй, уялдаагүй байдалтай нь харагдаж байна. Иймээс сангийн болон мөнгөний бодлогыг хэрхэн зөв уялдуулахыг тодруулахын тулд сангийн бодлогын талаар товч авч үзье.

Манай улсын хувьд хэдийгээр, сангийн тэлэх бодлого явуулж байгаа ч 2012 оны төсвийн төсөлд тусгаснаас харахад төсвийн нийт зарлагын /цэвэр зээлийг хассан дүнгээс/ 32 хувийг хөрөнгийн зардал, 68 хувийг урсгал зардал эзэлж байна. Төсвийн зарлага бодит хөрөнгө оруулалт руу биш урсгал зардалд чиглэсэн байгаа нь сангийн тэлэх бодлого буруу тийшээ тэлж байгаа бөгөөд энэ нь инфляцийг өсгөхөд нөлөөлж байна.

Эдийн засгийн онолын хувьд сангийн тэлэх бодлого нь эдийн засгийн нийт эрэлтийг нэмэгдүүлж, нөгөө талаас хөрөнгийн зардлыг нэмэгдүүлснээр нийт нийлүүлэлт өсч үнийн түвшин өөрчлөгдхөгүйгээр эдийн засгийн шинэ тэнцвэрт орж болдог. Түүнчлэн, Монголбанк инфляци өсөхөөс айж зах зээлд нийлүүлсэн мөнгийг хумиж суух нь эдийн засгийн бодит салбарийн хөгжлийг боомилж байгаа хэрэг юм.

Мөнгөний хатуу бодлого баримталж байна хэмээн бодлогын хүүг өсгөхөөс өөр арга хэмжээг Төвбанк авахгүй байгаа нь эдийн засгийн бодит өсөлтийг бууруулж, дотоодын аж үйлдвэрлэлийн салбарыг зогсонги байдалд оруулж байна. Өөрөөр хэлбэл, мөнгөний хатуу бодлого нь гүйлгээнд буй мөнгөний хэмжээг бууруулан, зээлийн хүү өссөнөөр бодит секторт олгох зээл олголтыг бууруулж байна.

Эдгээр бодлогууд нь өндөр инфляци, эдийн засгийн доогур өсөлтийг бий болгодог тул бодлогын ийм муу сонголтоос аль болох татгалзах, түүнээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна. Иймд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах буюу инфляцид бага нөлөөлөх, эдийн засгийн бодит өсөлтийг хангах, сангийн бодлогыг дэмжсэн зохистой мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хэрвээ макро эдийн засгийн гол 2 бодлогын уялдааг сайтар хангаж, санхүү-мөнгөний зохистой харьцааг баримталбал эдийн засгийн өсөлтийг өндөр түвшинд хүргэж, үнийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах боломжтой юм.

Инфляцийн түвшинд маш олон хүчин зүйл нөлөөлөх нь тодорхой боловч 2012 онд

<sup>3</sup> [http://www.nso.mn/v3/index.php?page=news\\_more&id=778](http://www.nso.mn/v3/index.php?page=news_more&id=778)

Судалгааны эмхтгэл, XI боть

инфляцийн түвшнийг хэдэн хувьтай байхыг урьдчилан таамаглахын тулд инфляцийн түвшинд хамгийн ихээр нөлөөлж болох дараах таван хүчин зүйлсийг энэ удаад авч үзлээ. Төсвийн нийт зардал болон урсгал зарлагын ДНБ -нд эзлэх хувь, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь, махны үнийн өсөлтийн хувь болон цалингийн өсөлтийн хувийг нөлөөлөх хүчин зүйлс гэж үзэн эдгээр үзүүлэлтүүдээр олон хүчин зүйлсийн регрессээр тооцоолж үзье.

Хүснэгт 5

Он	Ү=инфляци	$X_1 = \text{Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь}$	$X_2 = \text{Нийт мөнгөний өсөлтийн \%}$	$X_3 = \text{Махны үнийн өсөлт}$	$X_4 = \text{Төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь}$	$X_5 = \text{Жигнэсэн дундаж цалингийн өсөлтийн хувь}$
2000	8,1	42,2	17,5	12,4	30,8	33,2
2001	8,0	43,9	27,9	14,8	32,9	2,1
2002	1,6	42,1	42	14,8	33,3	23,7
2003	4,7	44,2	49,5	18,3	30,5	9,2
2004	11,0	39,3	20,4	22,6	27,5	21,9
2005	9,5	33,7	34,6	16,51	21,2	13,0
2006	6,2	33,3	34,8	16,39	26,4	31,0
2007	17,8	32,0	56,3	19,75	29,7	32,9
2008	22,1	40,2	-5,5	21,84	29,3	73,9
2009	4,2	37,1	26,9	20,14	29,6	1,3
2010	13	43,3	62,5	28,9	32,6	6,1
2011** <sup>1</sup>	11,9	52,1	64,0	34.07	40,2	4,7
2012**		39,4	70,0	30.0	28,2	56,5

Эх сурвалж: [www.Mongolbank.mn](http://www.Mongolbank.mn) 2011-9 сарын бюллетеңь

Энэ тооцооллыг хийхдээ 2011 оны гүйцэтгэлийг 3 дугаар улирлын байдлаар авсан тул оны эцсийн гүйцэтгэлээр тодорхой хувиар өөрчлөгдөх нь тодорхой юм. Мөн зарим үзүүлэлтийг тухайлбал ирэх жил эдийн засаг өснө гэж тооцоолж байгаа учир мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг 70 хувиар өсөхөөр, махны үнийн өсөлт энэ энэ оны түвшинд байна гэж тооцоолсон.

SUMMARY OUTPUT	
Regression Statistics	
Multiple R	0,830703
R Square	0,690067
Adjusted R Square	0,431789
Standard Error	4,402106
Observations	12

ANOVA						
		df	SS	MS	F	Significance F
Regression	5	258,877928	51,775586	2,6718	0,13168	
Residual	6	116,271239	19,37854			
Total	11	375,149167				

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95,0%	Upper 95,0%
Intercept	3,243227	11,6306035	0,2788528	0,78972	-25,2158	31,70229	-25,2158	31,7023
X Variable 1	-0,19589	0,49837566	-0,393061	0,70786	-1,41537	1,023589	-1,41537	1,02359
X Variable 2	-0,00937	0,10669378	-0,087799	0,932893	-0,27044	0,251703	-0,27044	0,2517
X Variable 3	0,617234	0,27228141	2,2668959	0,06394	-0,04901	1,283482	-0,04901	1,28348
X Variable 4	-0,04715	0,60934447	-0,077386	0,940833	-1,53817	1,443857	-1,53817	1,44386
X Variable 5	0,183076	0,09222253	1,9851571	0,094347	-0,04258	0,408737	-0,04258	0,40874

Эдийн засгийн онолын хувьд мөнгөний нийлүүлэлт болон төсвийн урсгал зардал ёссэн нь инфляцийг хөөрөгдөх хүчин зүйл болдог боловч бидний хийсэн регрессийн үр дүнгээс харахад инфляцийн түвшинд махны үнэ болон цалингийн өсөлт ялангуяа махны үнийн өсөлт хамгийн их нөлөөлнө, төсвийн зардал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт тодорхой нөлөө үзүүлэхгүй гэсэн үр дүн харагдаж байна. Эндээс 2012 онд инфляцийн түвшин дээрх үзүүлэлтийн үр дүнд 21,0 хувьтай гарахаар байна. Гэхдээ энэ зөвхөн сүүлийн хэдэн жилийн тоон мэдээлэл дээр сууриссан таамаглал юм.

Иймээс манай орны хувьд мөнгөний бус шалтгаантай инфляци илүү давуу байгаа гэж үзээд мөнгөний бодлого, сангийн бодлогын харилцан хамаарлаар мөнгөний нийлүүлэлтийг эрэлттэй нь уялдуулан хийж, богино хугацаанд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мөнгөний дотоодод шингээх чадамжийг дэмжих, харин дунд болон урт хугацаанд үйлдвэрлэлийн салбарын бүтэц, гадаад худалдааны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн макро эдийн засгийн бодлого явуулах замаар инфляцийг бууруулах боломжтой гэсэн таамаглалыг тавьж байна.

Энэхүү таамаглалын дагуу инфляцтai тэмцэхийн тулд одоо хэрэгжүүлж байгаа богино хугацааны мөнгөний хатуу бодлогын арга хэмжээний зэрэгцээ дунд болон урт хугацаанд уул уурхай түшиглэсэн үндэсний үйлдвэрүүдийг бий болгоход чиглэсэн зөөлөн дэд бүтцийг боловсронгуй болгох, хатуу дэд бүтцийг сайжруулах төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлбэл эдийн засаг харьцангуй тогтворжино хэмээн үзэж байна.

Монголд өнөөдөр эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа инфляцийг хянах, зогсооход чиглэсэн бодлогын оновчтой ямар хувилбарууд байна вэ гэсэн судалгааны үндсэн асуултад хариулт олохын тулд инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлсийг дөрвөн төрлийн инфляцийн шалтгаантай уялдуулан дараах нөлөөллүүдийн хүрээнд бүлэглэн асуудлуудыг судалж үзэж тооцоолох зайлшгүй шаардлагатай байна. Үүнд:

- Мөнгөний тэлэх бодлогын нөлөөлөл. Сүүлийн жилүүдийн хурдацтай нэмэгдэж буй мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, мөн гадаад валютын эсрэг дотоодын мөнгөн тэмдэгт супарч байгаа байдал буюу гадаад валютын ханшийн чангарталт
- Сангийн тэлэх бодлогын нөлөөлөл. Төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн

- өсөлт, нийгмийн шинжтэй олон арга хэмжээнд зарцуулагдаж буй мөнгөний өсөлт
- Гадаад зах зээлийн нөлөөлөл. Гадаадаас импортлогдон орж ирж буй үйлдвэрлэлийн нөөцүүдийн болон түүхий эд материалын үнийн өсөлт
  - Эдийн засгийн дотоод хүчин зүйлс. Манай орны эдийн засгийн салбарын бүтэц, түүний үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн мөчлөгийн өсөлт<sup>4</sup>

Эдгээр болон бусад хүчин зүйлсийн аль нь манай орны хувьд ажиглагдаж буй инфляцийн өсөлттэй хамгийн хүчтэй хамааралтай байгааг тооцоолон судалснаар инфляцийн эсрэг бодлогын оновчтой хувилбар боломжтой болно.

\* \* \*

## ДҮГНЭЛТ

Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлснээр инфляцийг бага түвшинд барьж байгаа мэт боловч хэтэрхий их болгоомжлогоос болж эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Мөн манайд инфляцийг онилох бодлогыг баримтлахад бүрдсэн байвал зохих нөхцөл бүрэн бүрдээгүй байхад уг бодлогыг баримталж эхэлсэн учраас тус бодлогын үр дүн сайн мэдрэгдэхгүй инфляци өссөөр байна. Өөрөөр хэдбэл эдийн засгийн бүтэц болон санхүүгийн салбарын нөхцөл нь уг бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих нөхцөл болж чадахгүй байна.

Хэдийгээр Дэлхийн банк болон ОУВС зэрэг олон улсын байгууллагууд Монгол банкны явуулж буй бодлогыг сайшааж төсвийн зардал тэлэхийн хэрээр бодлогын хүүг нэмэх шаардлагатай хэмээн зөвлөж байгаа хэдий ч Монгол банк мөнгөний бодлогын илүү оновчтой сайн хувилбарыг дахин бодолцож үзэх хэрэгтэй байна.

Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаа нь хувийн секторын мөнгө босгох боломжийг хязгаарлаж, банкны санхүүжилтээс хараат хэвээр байх, санхүүгийн салбар дахь банкны давамгайлал багасахгүй байх, банкнаас зээл авахаас өөр санхүүжилтийн сонголтгүй болгож, улмаар банкууд санхүүгийн зуучлалын өртгийг өндөр түвшинд хадгалахад нөлөөлж байна.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, үр ашигтай, үйл ажиллагаагаа явуулах эдийн засаг, хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, урт хугацаат, хямд эх үүсвэр татах боломжийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгслийдийг олшруулж, хөрөнгийн захын хөрвөх чадварыг сайжруулах нь зээлийн хүүг бууруулах нэг хүчин зүйл юм. Мөн богино хугацаанд илүүдэл эх үүсвэрээ байршуулах хөрвөх чадвар сайтай үнэт цаас, бонд зэрэг санхүүгийн хэрэгслийд түгээмэл биш байгаа нь банкууд илүүдэл хөрөнгөө оновчтой байршуулах боломжийг хязгаарлаж, эрсдэлээс айж үр ашиггүй барьж, эрсдэлийн болон бусад зардлыг зээлийн хүүгээ өндөр тогтоо замаар нөхөнхөд хүргэж байна.

Банкууд том хадгаламж эзэмшигчдийг татах зорилгоор зах зээлийн бус өндөр хүүг амлаж төлөх, том хадгаламж эзэмшигчид нэг банкнаас нөгөө банк руу хадгаламжаа шилжүүлэх замаар хүүг өсгөх, зарим жижиг, дунд банкууд зах зээлд эзлэх хэмжээгээ нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийн бус өндөр хүүг амлах зэрэг үзэгдлүүд зээлийн хүү буурахгүй байхад нөлөөлж байна гэж үзэж байна.

Инфляцийн хүлээлт тогтвожихи хүртэл үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг тууштай, олон нийтэд ил тод баримтлах, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх

<sup>4</sup> Θ. Баттулга. "Мөнгөний бодлогын оновчтой хэлбэр" монголбанкны судалгааны ажлын эмхэтгэл. 2004 он;

хэлбэр, авах бодлогын арга хэмжээний талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, инфляцийн хүлээлтийг бууруулах шаардлагатай байна. Санхүүгийн гол харилцагчдын шийдвэр, харилцагчийн мөнгөө хадгалуулах, зээл авах эсэх нь макро эдийн засгийн суурь үндсэн нөхцлүүдээс хамаарч байдаг. Зээлийн хүүг бууруулахад гол нөлөөтэй хүчин зүйл нь тогтвортой нам инфляци урт хугацаанд хадгалагдах явдал юм.

Инфляци нам түвшинд тогтвортой урт хугацаанд байвал банкуудын тогтвортой үйл ажиллагаа урт хугацаанд хангагдаж, иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэж, банкуудын гол эх үүсвэр болох хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, улмаар зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэргээр зээлийн хүү буурахад зергээр нөлөөлнө.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ***Ц. Норовдоондог (Ph.D), Ц. Батдорж, Г. Билгээ***1. 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ****1.1. Төсвийн хүрээний мэдэгдэл**

Засгийн газар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-д өргөн мэдүүлсэн холбогдох материалд Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлж 2012 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дараах байдлаар өөрчлөх саналыг оруулсан байна:


**Хүснэгт 1.1. 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах өөрчлөлтийн санал**

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Батлагдсан хуулийн дагуу <sup>1</sup>	Өөрчлөлт оруулах санал	Зөрүү, хувиар
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	16.6	25.6	54.2
2.	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	9	9	0.0
3.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ / тэрбум төг./	4,176.1	6,352.2	52.1
	• ДНБ-д эзлэх хувь	29.8	35.3	18.5
4.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ / тэрбум төг./	5,113.5	7,093.1	38.7
	• ДНБ-д эзлэх хувь	36.5	39.4	7.9
5.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ / хувь/	25.2	3,009.0	11840.5
	• ДНБ-д эзлэх хувь	7.3	16.7	128.8
6.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл / тэрбум төг./	-937.4	-740.9	-21.0
	• ДНБ-д эзлэх хувь	-6.7	-4.1	-38.8
7.	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ / тэрбум төг./	1,098.3	2,390.9	117.7
	• ДНБ-д эзлэх хувь	7.8	13.3	70.5
8.	Улсын өрийн нийт хэмжээ / тэрбум төг./	7,277.5	9,901.1	36.1
	• ДНБ-д эзлэх хувь	51.9	55.0	6.0
9.	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ / тэрбум төг./	218.8	222.5	1.7
	• ДНБ-д эзлэх хувь	1.8	1.2	-33.3

## 1.2. 2012 оны нэгдсэн төсөв

Төсвийн зарлагыг зохицой түвшинд хязгаарлан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж, төсвийг алдалгүй байлах Засгийн газрын бодлого 2012 оны төсвийн төлөд биелэлээ олоогүй байна. Төсвийн нийт тэнцлийн алдагдал бүтцийн хувьд улсын төсвийн алдагдал ХХС-ийн алдагдал байна. Төсвийн алдагдалыг Засгийн газрын бонд шинээр гаргах, гадаад төслийн зээлээр санхүүжлэхээр тооцжээ. Иймд нийт тэнцлээр алдагдалтай байгаа төсвүүдийн тооцоо дахин нягтлан үзэх хэрэгтэй.

Зураг 1.1. Монгол Улсын нэгдсэн төсөв – 2003-2012 он (Тэрбум төгрөгээр)



Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийн үр дүн ДНБ-д эзлэх хувиар буурсан нь 2012 оны ДНБ-ий үзүүлэлт 18.003,3 тэрбум төгрөг болж 2011 оныхос 43.6 хувиар өссөнтэй холбоотой.

Зураг 1.2. Монгол Улсын нэгдсэн төсөв, 2003 - 2012 он (ДНБ-нд эзлэх хувиар)



\* \* \*

## 2. 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСЛИЙН ОРЛОГО

### 2.1. 2012 оны нэгдсэн төсвийн нийт орлогын үзүүлэлт

2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг хоёр дахь жилдээ тооцож, 2012 нэгдсэн төсөвт тусгасан байна.

Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт орлогын хэмжээ 2011 оны тодотголоос 61.5 хувь, нийт тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 62.0 хувь, тогтвожуулалтын сан 57.4 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцсон байна. Ийнхүү нэмэгдсэн боловч ДНБ -д эзлэх хувиар буурсан нь 2012 оны ДНБ-ий үзүүлэлт 2011 оныхоос 43.6 хувиар өссөнтэй холбоотой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн баялгийг “гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого” гэдэгт зэс болон нүүрснээс төвлөрөх орлого хамаарч байна.

Хүснэгт 2.1.

#### • Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн төслийн орлогын үр дүнгийн үзүүлэлт

	Дүн /тэр.төг/		ДНБ-д эзлэх хувь	
	2011 Тод.	2012 Төсөл	2011 Тод.	2012 Төсөл
Нийт орлого ба тусламжийн дүн	4,139.0	6,733.4	40.7	37.4
Тогтвожуулалтын сан	219.0	381.2	2.2	2.1
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,919.9	6,352.2	38.6	35.3
Үргал орлого	3,908.3	6,271.4	38.5	34.8
Татварын орлого	3,472.3	5,166.8	34.2	28.7
1. Орлогын албан татвар	762.7	1,039.4	7.5	5.8
2. Нийтмийн даатгалын шимтгэл, хураамж	408.4	548.0	4.0	3.0
3. Өмчийн татвар	12.4	15.9	0.1	0.1
4. Нэмэгдсэн өртөгийн албан татвар	1,091.8	1,678.9	10.7	9.3
5. Онцгой албан татвар	308.1	361.1	3.0	2.0
6. Тусгай зориулалтын орлого	19.6	36.4	0.2	0.2
7. Гаалийн албан татвар	344.0	792.1	3.4	4.4
8. Бусад татвар	525.4	695.1	5.2	3.9

Татварын бус орлого	408.4	1,104.6	4.3	6.1
Хөрөнгийн орлого	3.3	0.8	0.0	0.0
Тусlamжийн орлого	8.6	80.0	0.1	0.4

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2012 онд эрдэс баялгийн үнийн ёсөлтийг харгалзан Тогтвэржулалтын санд 381.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төсөвлөсөн нь 2011 оны тодотголоос 42 хувиар нэмэгдүүлж тооцсон бөгөөд 2012 оны эцэст тус сангийн нийт хуримтлал 600.2 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Засгийн газар олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зарладаг үнийн төсөөлөлд үндэслэн ашигт малтмалын үнийг тэнцвэржүүлсэн үнээр авч тооцсон бөгөөд 2012 оны төсөвт эрдэс баялгийн зах зээлийн үнийг дараах байдлаар тооцсон байна:

	ам.доллар
• алт	1723.7
• зэс	9760.5
• боловсруулсан нүүрс	199.9
• коксжих нүүрс	135.0
• чулуун нүүрс	88.9
• хүрэн нүүрс	75.0

Монгол Улсын хувьд ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт 2002 оны байдлаар нийт экспортын 50 орчим хувийг эзэлж байсан бол өнөөдөр 90 орчим хувийг эзэлж байна. 2012 оны төсөвт уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас 1,669.5 тэрбум төгрөгийн орлогыг төсөвлөсөн нь нийт тэнцвэржүүлсэн орлогын 42 хувийг эзэлж байна. Энэхүү уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогын 925.1 тэрбум төгрөг буюу 55 хувь нь нүүрснээс орох орлого байна. Үлдсэн уул уурхайн салбараас орох татварын орлогын 35 хувийг зэс, 6 хувийг тэмрийн худэр, 4 хувийг алт, цайр, жонш зэрэг бусад бүрэлдэхүүн бүрдүүлнэ. Эндээс үзэхэд 2012 оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд зэсийн орлого бус нүүрсний орлого тэргүүлж байна.

2012 оны төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн орлогод урсгал орлого 98,8 хувь, хөрөнгийн орлого 0,012 хувь, тусlamжийн орлого 1,2 хувийг тус тус эзэлж байна. Ирэх оны урсгал орлогт 6,271.4 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 38.0 хувиар нэмэгдүүлсэн. Урсгал орлогын 81.3 хувийг татварын орлого, 17.7 хувийг татварын бус орлого тус тус бүрдүүлж байна.

## 2.2. Татварын орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн дийлэнхийг хувийг бүрдүүлж байдаг татварын орлогыг 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд 2011 оныхос 1,694.5 тэрбум төгрөг буюу 32.8 хувиар нэмэгдүүлсэн байна. 2006-2010 онд татварын орлогын дийлэнхи хувийг бүрдүүлж байсан Орлогын албан татварын орлого сүүлийн хоёр жил буурсан бол НӨАТ-ын орлого өссөн байна. Ирэх жилийн татварын орлогын бүрэлдэхүүнийг 2011 оны тодотголтой харьцуулахад Гаалийн албан татвар – 56.6 хувь, Тусгай зориулалтын орлого 46.1 хувиар тус тус нэмэгдүүлэн тооцсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлогыг төрлүүдээр нь дэлгэрүүлэн авч үзье.




### 2.2.1. Орлогын албан татвар

2006-2010 онд татварын орлогын дийлэнхи хувийг буюу 36-43 хувийг бүрдүүлж байсан Орлогын албан татварын орлого сүүлийн хоёр жил буурч 2012 онд 20 хувь болсон байна. 2012 оны төсвийн төсөлд орлогын албан татварын орлого 2011 оны төсвийн тодотголтой харьцуулахад 276,7 тэрбум төгрөг буюу 26,6 хувиар нэмэгдүүлсэн байна.


2012 оны төсвийн төсөлд Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын орлого 2011 оныхтой харьцуулахад 30.6 хувиар өсөж байгаа нь аж үйлдвэрийн бүтэгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, тэр дундаа уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой аж. Хүн амын орлогын албан татварын 2012 оны орлогыг 2011 оныхтой харьцуулахад 38.0 хувиар нэмэгдэхээр байгаа нь төрийн албан хаагчдын цалинг шатлалаар нэмэгдүүлэх болсонтой холбоотой. Мөн уул уурхайн салбарын бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, ажлын байр шинээр нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.

### 2.2.2. Нийгмийн даатгалын орлого


Ирэх жилийн нэгдсэн төсвийн төсөлд Нийгмийн даатгалын орлогыг 2011 оныхтой харьцуулахад 139.6 тэрбум төгрөг буюу 25.5 хувиар нэмэгдүүлсэн байна. 2012 оны нэгдсэн төсөвт Нийгмийн даатгалын шимтгэлээс орох орлого 2011 оны тодотголтой харьцуулахад Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 29.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлого 11.5 хувиар нэмэгдүүлсэн байна.



Зураг 2.2. Орлогын албан татварын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



Зураг 2.3. Нийгмийн даатгалын орлогын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



### 2.2.3. Өмчийн татвар

2012 оны Өмчийн татвараас орж ирэх орлого нь 2011 оныхтой харьцуулахад 22.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 2012 онд Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогоор 15.7 тэрбум төгрөг, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоор 25.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр тусгасан байна.

### 2.2.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар

2006-2010 онд НӨАТ-ын орлого татварын орлогын 28-20 хувийг бурдүүлж байсан бол 2012 онд дийлэнхи хувийг буюу 32 хувь болсон бөгөөд 2011 оны тодотголтой харьцуулахад 30.0 хувиар өссөн байна. Ирэх онд төсөвт Нэмэгдсэн өртгийн албан татвараас хамгийн их орлого орохоор төсөвлөсөн бөгөөд 2011 оны төсвийн тодотголоос 587,1 тэрбум төгрөг буюу 35 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Үүнд Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 36 хувиар, Импортын барааны НӨАТ -ын орлогыг 30 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байна.



Ийнхүү нэмэгдэж байгаа нь уул уурхайн салбарын эрчимтэй хөгжил, стратегийн томоохон ордын бүтээн байгуулалтын ажилтай уялдан дотоодын барааны худалдан авалт болон хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл ихээр орж ирж байгаа зэрэг нь дотоодын болон импортын барааны НХАТ-үүд нэмэгдэхээр тооцоолсон байна.

## 2.2.5. Онцгой албан татвар

2012 оны төсөвт ОАТ-ын орлогыг 2011 оны тодотголтой харьцуулахад 53.0 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар нэмэгдүүлэхээр төсөвлөсөн байна. Үүнд дотоодын пивоны ОАТ-аар 2012 онд 23.3 тэрбум төгрөг төвлөрөхөөр тусгасан байна. Дотоодын пивоны үйлдвэрлэлийн хэмжээ 2008-2010 оны хооронд 19.9 сая литрээс 44.8 сая литр болж нэмэгдсэн нь бусад ижил төрлийн барааны үйлдвэрлүүдээс хамгийн их буюу 55 хувиар нэмэгдсэн байна.

Мөн 2012 оны улсын төсөвт архи, тамхины болон пивоны ОАТ-ын орлогоос нийт 53.1 тэрбум төгрөгийн орлого нэмэгдэхээр байгаа нь 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 29-31 хувиар нэмэгдэхээр байна. 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 41700 суудлын автомашин импортлохоор тооцолж байгаа нь сүүлийн 4 жилийн дунджаас 50 гаруй хувиар өссөн, түүнчлэн Засгийн газраас УИХ-д өргөн бариад байгаа Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу 101,5 тэрбум төгрөгийг ОАТ-ын орлогоор улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна. Автобензин, дизелийн түлшний хэрэглээ жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2012 оны төсөвт автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоор 69.0 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Зураг 2.2. Онцгой албан татварын үзүүлэлт, 2010 - 2012 (Тэрбум төгрөгөөр)


	2010	2011 Тод.	2012 Төсөв
Онцгой албан татвар	268.5	308.1	361.1
Дотоодын архины	68.0	79.5	91.9
Импортын архи, тамхины	24.8	31.3	44.1
Импортын пивоны	5.1	6.2	9.0
Суудлын автомашины	54.5	89.4	101.5

Автобензин, дизель түлшний	92.5	65.1	69.0
Дотоодын тамхины	11.3	15.6	19.1
Дотоодын пивоны онцгой	12.2	21.0	26.6

## 2.2.6. Тусгай зориулалтын орлого

2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Тусгай зориулалтын орлогоор 361.1 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 16.8 тэрбум төгрөг буюу 46.1 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Уул уурхайн томоохон төслийн бүтээн байгуулалт эхэлж байгаагийн зэрэгцээ барилгын салбар, газар тариалангийн салбар сэргэж байгаатай холбогдож нефть бүтээгдэхүүний хэрэглээ өсөх хандлагатай бөгөөд 2012 оны төсөвт автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоор 10.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасан байна.

Зураг 2.5. Тусгай зориулалтын орлогын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын орлогоор нийт 25,9 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголоос 58.3 хувиар өссөн байна. Үүний 8.3 тэрбум төгрөгийн орлого нь Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр нэмж төвлөрхөөр байна.

## 2.2.7. Гаалийн албан татвар

2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Гаалийн албан татварын орлогоор 792.1 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 448.1 тэрбум төгрөг буюу 56.6 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Мөн Гаалийн албан татварын орлого нь ДНБ-нд эзлэх хувиар 2011 оныхтой харьцуулахад 22.7 хувиар өссөн байна. Ийнхүү нэмэгдэхэд Импортын барааны гаалийн албан татварын орлого 2011 оныхтой харьцуулахад 37 хувь, Экспортын гаалийн албан татварын орлого 100 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Экспортын гаалийн албан татварын орлогын хувьд Засгийн газраас УИХ-д өргөн бариад байгаа Зарим барааны экспортын гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан тохиолдолд нийт 305.1 тэрбум төгрөг төвлөрөх бөгөөд үүнээс улсын төсөвт 246.5 тэрбум төгрөг, Тогтвортжуулах санд 58.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна.

Зураг 2.5. Гаалийн албан татварын бүтэц (Тэрбум төгрөгөөр)



## 2.2.8. Бусад татвар

Ирэх оны нэгдсэн төсвийн төсөлд Бусад татвар /төлбөр, хураамж/-ын орлого 2011 оны тодотголтой харьцуулахад 169.7 тэрбум төгрөг буюу 24.4 хувиар нэмэгдүүлсэн байна. Бусад татварын орлогоор нийт 695.1 тэрбум төгрөг төсөвлөсөний 84.0 хувийг Улсын тэмдэгтийн хураамж, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг бүрэлдэхүүнүүдээс төвлөрүүлнэ. Эдгээрээс Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2011 оныхтой харьцуулахад хамгийн өндөр буюу 42.4 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна.

Зураг 2.5. Бусад татварын гол бүрэлдэхүүний үзүүлэлт (Тэрбум төгрөгөөр)



## 2.3. Татварын бус орлого


2012 оны нэгдсэн төсвийн төсөлд Татварын бус орлогоос 1,104.6 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 2011 оны тодотголтой харьцуулахад 668.8 тэрбум төгрөг буюу 60.5 хувиар нэмэгдүүлсэн

байна. Мөн Татварын бус орлого нь ДНБ-нд эзлэх хувиар 2011 оныхтой харьцуулахад 29.5 хувиар өссөн байна. Ийнхүү нэмэгдэхэд Хувьцааны ногдол ашиг, Газрын тосны орлого болон Гарын үсгийн төлбөрийн орлогууд нөлөөлсөн байна. Тодруулбал, Гарын үсгийн төлбөрийн орлогыг 2011 оныхтой харьцуулахад 539.9 тэрбум төгрөг буюу 99.0 хувиар, Ногдол ашгийн орлого 84.0 тэрбум төгрөг буюу 55.2 хувиар, Газрын тосны орлого 25.0 тэрбум төгрөг буюу 26.4 хувиар өссөн байна.

#### 2.4. Хөрөнгийн ба Гадаад тусlamжийн орлого

2012 оны нэгдсэн төсвийн Хөрөнгийн орлого 2011 оны тодотголтой харьцуулахад 2.5 тэрбум төгрөг буюу 76.4 хувиар буурсан байна. Харин ирэх оны төсөвт Гадаад тусlamжийн орлого энэ оныхтой харьцуулахад 71.7 тэрбум төгрөг буюу 89.6 хувиар нэмэгдсэн төдийгүй мөн ДНБ-нд эзлэх хувийг харьцуулахад 75.0 хувиар өссөн байна. БНХАУ-ын Засгийн газраас манай улсад амалсан буцалтгүй тусlamжийн мөнгөн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэл 412.1 сая юань буюу 80.0 тэрбум төгрөг аж.

Зураг 2.5. Бусад татварын гол бүрэлдэхүүний үзүүлэлт (Тэрбум төгрөгөөр)



\* \* \*

### 3. МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

#### 3.1. Нэгдсэн төсвийн зарлага

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хэмжээг жил бүр бууруулах бодлого хэрэгжүүлэх, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төсвийн тодотголтыг боловсруулах, батлахад улсын төсвийн нийт зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 33 хувиас хэтрүүлэхгүй байх, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинжтэй зарлагаас бусад зайлшгүй шаардлагатай бус ургсал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, гадаад өрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах бодлогыг баримтлж төсвийн хүрээний мэдэгдэлд тусган боловсруулжээ.

Засгийн газар баримтдаж буй бодлогоо 2012 оны төсөвт хэрхэн тусгасныг авч үзье. Монгол улсын 2012 оны нэгдсэн төсвийн төсөлд шинжилгээ хийж 2003 оноос 2012 он хүртлэх зарлагын үзүүлэлтуудийг харьцуулан өсөлт, бууралт, түүний хувь хэмжээг зарлага тус бүрээр нь гаргалаа.

Монгол улсын нийт зарлага ирэх онд 7093.1 тэрбум төгрөг, буюу ДНБ-ний 39.5 хувь байхаар төлөвлөж нийт зардлын хэмжээ нэмэгдсэн байна. Нийт зардал нэмэгдэхэд урсгал зардал 1341.6 тэрбум төгрөг буюу 40.7 хувиар, хөрөнгийн зардал 1203.9 тэрбум төгрөг буюу 101.4 хувиар тус бүр нэмэгдэж, эргэж төлөгдөх цэвэр зээл 364.8 тэрбум төгрөгөөр буурахаар төсөвлөгдсөнөөс болжээ. Доорхи хүнэгтэд 2010-2012 оны нэгдсэн төсвийн зарлагын бүлгийн зардлууд өмнөх онынхаосоо хичнээн төгрөгөөр өссөн өсөлтийг харууллаа. /Хүснэгт 3.1/


### Хүснэгт 3.1. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлт (Тэрбум төгрөгөөр)

			2010 Гүйц	2011 тод	2012 төс
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			603,1	828,2	2,180,7
A.	УРСГАЛ ЗАРЛАГА		394,2	149,1	1,341,6
1.	Бараа, үйлчилгээний зардал		192,9	65,3	620,3
1.1.	Цалин, хөлс		65,1	12,2	434,0
1.3.	Нийгмийн даатгалын шимтгэл		0.0	0.0	0.0
1.2.	Бараа, үйлчилгээний бусад зардал		127,8	53,1	186,3
2.	Зээлийн үйлчилгээний төлбөр		0,9	0.0	153,7
3.	Татаас ба урсгал шилжүүлэг		200,4	83,7	567,5
3.1.	Татаас		37,0	29,9	-13,2
3.2.	Урсгал шилжүүлэг		163,3	53,8	580,7
B.	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		79,8	342,1	1,203,9
1.	Хөрөнгө оруулалт		68,2	283,3	700,4
2.	Их засвар		17,8	5,8	7,6
3.	Хөрөнгийн бусад зардал		-3,6	52,9	9,3
4.	Гадаад төслийн зээлээр санхүүжих хөрөнгө оруулалт		-2,6	0.0	486,6
B.	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ		129,1	337,0	-364,8
1.	Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл		201,9	337,0	-415,0
2.	Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл		0.0	0.0	50,2

Нэгдсэн төсвийн нийт зарлагын бүлгийн зардлуудын өсөлтийг хурдыг өмнөх оныхтой харьцуулахад нийт зарлага 2011 онд 828.2 тэрбум төгрөгөөр өсч байсан бол 2012 оны төсөлд 2180.7 тэрбум төгрөг буюу 2.6 дахин, урсгал зарлага 9 дахин, хөрөнгийн зардал 3.5 дахин өссөн дүнтэй гарсан бол эргэж төлөгдөх цэвэр зээл 1.1 дахин буурсан байна.

Өмнөх жилүүдэд нэгдсэн төсвийн зарлагын өсөлт өндөр байсан хэдий ч 2012 оны төсвийн төсөлд тусгагдсан шиг өндөр өсөлт бараг байгаагүй байна. Доорхи графикт /Зураг 3.1./ 2003 оноос 2012 он хүртэл нэгдсэн төсвийн нийт зарлага, урсгал зарлага, хөрөнгийн зардал, цэвэр зээл зэргийн өсөлт бууралтийг дүрслэн үзүүллээ. 2003 оноос хойш нийт зарлага 11.5 дахин. Урсгал зарлага 10.7 дахин, хөрөнгийн зардал 26.4 өссөн дүнтэй байхад цэвэр зээл харилцан адилгүй тухайн жилийнхээ зээлийн хэмжээнээс хамаарч өсч, буурсан байна.

Зураг 3.1. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн өсөлт (Тэрбум төгрөгөөр)



ДНБ, Төсвийн нийт зарлага, ургал зардалын өсөлтийг 2004-2012 он хүртэл харьцуулан шинжиллээ. Сүүлийн жилүүдэд ДНБ тасралтгүй өссөн дүнтэй байгаа бөгөөд нийт зарлага 2009 онд -5.3 хувиар буурч харин ургал зардал тогтмол өссөн байна.

Доорх хүснэгт /Хүснэгт 3.2/-ээс хараад сүүлийн жилүүдэд нийт зарлага болон ургал зардал ДНБ-ний өсөлтөөс илүү хурдтай өсч байсан бөгөөд 2012 ДНБ 77.2 хувь буюу 18003.3 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон нь урьд өмнө байгаагүй өндөр өсөлт юм. ДНБ, нийт зарлага, ургал зардлын өсөлтийг хүснэгт болон график /Зураг 3.2/-аар үзүүллээ.

### Хүснэгт 3.2.


- ДНБ, төсвийн нийт зарлага ба ургал зардлын өсөлт оны үнээр, хувиар (Тэрбум төгрөгөөр)

		2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011 тод	2012 төсөл
ДНБ	оны үнээр	1910.9	2266.5	3714.9	4599.5	6019.8	6055.7	7171.4	10157.2	18003.3
	хувиар	30.8	18.6	63.9	21.8	35.4	0.6	18.4	41.6	77.2
ТНЗ	оны үнээр	752.5	764.6	1237.0	1747.3	2466.7	2336.6	3080.7	4912.3	7093.0
	хувиар	22.1	1.6	61.8	41.3	41.2	-5.3	31.8	59.4	44.3
ТУЗ	оны үнээр	538.7	600.3	982.3	1367.6	1761.1	1788.1	2256.6	3295.4	4637.1
	хувиар	23.9	11.4	63.6	39.2	28.8	1.5	26.2	46.0	40.7

\*\*\*

Судалгааны эмхтгэл, XI боть

Зураг 3.2. ДНБ, төсвийн нийт зарлага ба урсгал зардлын өсөлтийн хурд, хувиар




Төсвийн нийт зарлага, урсгал зардал 2003-2006 онд ДНБ-ээс бага хувь хэмжээгээр нэмэгдэж байсан бол 2007 оноос илүү хувь хэмжээгээр өсч байсан ч 2012 оны төсвийн төсөлд ДНБ 2011 оныхоос 77.2 хувиар өсөхөөр төсөвлөгдсөн байна.

ДНБ-нд эзлэх зарлагын хувь хэмжээ 2012 онд 39.4 хувь болж Засгийн газрын 33 хувиас хэтрүүлэхгүй байх бодлогоос давж төсөвлөгдсөн байна. ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэмэгдэх болсон шалтгааныг Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлтийн суурийг бий болгох, дэмжих, бэхжүүлэх, эдийн засгийн гүн хямралаас ангижрах чиг баримжаатай “тэлсэн” сангийн бодлогын хүрээнд эдийн засгийн бодит сэргэлт ажиглагдаж байгаа тул цаашид төсвөөр дамжуулан эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлхээр ажиллаж байгаатай холбон тайлбарласан байна.

2012 онд ДНБ-ийг 18003.3 тэрбум төгрөг байхаар тооцож түүнд эзлэх нийт зарлага болон урсгал зарлагын эзлэх хувь хэмжээг өмнөх онуудтай харьцуулан гаргалаа. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагын хэмжээг бууруулах бодлогыг Засгийн газраас баримтлаж байгаа боловч төдийлөн үр дунд хүрэхгүй байгаа юм. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл тусгаснаар бол ирэх жилүүдэд бууруулахаар зорилт тавьж байгаа боловч ДНБ-ний өсөлт удааширч төсвийн зарлагын хувь хэмжээ нэмэгдсээр байвал тодорхой үр дунд хүрч чадахгүй юм.

Зураг 3.3. ДНБ-д эзлэх нийт зарлага, урсгал зардлын хувь



### 3.1.1. Урсгал зардал


Нийт зарлагад эзлэх урсгал зарлагын тоон үзүүлэлтүүдийг дээрх хүснэгт болон графикт тодорхой тусган харуулсан байгаа. Харин Урсгал зарлагын бүлгийн зардлуудын өсөлт, бууралтын харилцан хамаарлыг авч үзье.

2006 оноос 2012 он хүртэл урсгал зардал 4.7 дахин, хөрөнгийн зардал 12.4 дахин нэмэгдсэн байна. 2011 оныхоос урсгал зардал өсөхөд барааны үйлчилгээний зардалын зүйл ангийн зардлууд болох цалин хөлс 446.3 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 186.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Урсгал зардалын дунд хамгийн их өсөлттэй гарсан зардал болох бараа үйлчилгээний зардал 620.3 тэрбум төгрөг буюу 41.6 хувь, татаас ба урсгал шилжүүлэг 567.6 тэрбум төгрөг буюу 24.3 хувь, тус тус өсч харин зээлийн үйлчилгээний төлбөр 191.1 тэрбум төгрөг болж өссөн байна. /Зураг 3.4 дээрх зардлуудын өсөлт, бууралтыг харна уу/

Дээрхи зардлууд өсөхөд 2012 оны төрийн албан хаагчдын цалинг нэмэх, мөн хүний хөгжил сангийн мөнгийг 2012 онд 892.1 тэрбум төгрөг, өндөр насты тэтгэвэр нэмэх, сонгуулийн үйл ажиллагааны зардал, оюутны тэтэглэг зэрэг олон зүйлээс хамааран өсч байгаа бөгөөд бараа үйлчилгээний бусад зардал доторхи зарим зардлууд зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн өсөлт болон бусад хүчин зүйлээс хамаарч нэмэгдсэн байна.

Татаас ба урсгал шилжүүлэг нэмэгдэхэд татаас 446.2 тэрбум төгрөгөөр, застийн газар хоорондын шилжүүлэг 221.0 тэрбум төгрөгөөр, өрх гэрт олгох шилжүүлэг 567.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Өрх гэрт олгох шилжүүлгийн бүлгийн зардлууд болох тэтгэвэр тэтгэмжийн зардал өмнөх оныхоос 207.5 тэрбум төгрөг болж үүн дотор өндөр настын тэтгэвэр 128.6 тэрбум төгрөгөөр, тахир дутуу боловсдын тэтгэвэр 36.5 тэрбум төгрөгөөр, цэргийн тэтгэвэр 13.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэн төсөвт тусгагдсан нь дээрх зардалууд өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 3.4. Урсгал зардлын бүлгийн зардлуудын өсөлт, бууралт



### 3.1.2. Хөрөнгийн зардал ба цэвэр зээл

2011 онд ДНБ -ий 11.7 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтанд зарцуулахаар тодотголд тусгасан бөгөөд 2012 онд 13.3 хувь байхаар батлсан бөгөөд хөрөнгө оруулалтын зардал 72.1 хувиар, их засвар 14.5 хувиар, хөрөнгийн бусад зардал 13.3 хувиар, гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 522.6 хувиар тус бүр нэмэгдсэн.

## Зураг 3.3. Хөрөнгийн зардал ба цэвэр зээлийн өсөлт (Тэрбум төгрөгөөр)

	2008	2009		2010		2011 тод		2012		
		тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	
Хөрөнгийн зардал	624.4	108%	460,6	-26.2%	590.6	28,2%	1187.1	100.9%	2390.9	101.4%
1 Хөрөнгө оруулалт	482.6	101.7%	396.6	-17.8%	515.2	29.9%	971.6	88.5%	1672.1	72.1%
2 Их засвар	27.5	-3.1%	11.7	-57.4%	30.2	158.1%	52.5	73.8%	60.1	14.5%
3 Хөрөнгийн бусад зардал	94.0	1005%	25.5	-72.8%	15.8	-38.8%	69.8	341.7%	79.1	13.3%
4 Гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт	20.1	-13.3%	26.6	32.3%	29.4	10.5%	93.1	216.6%	579.7	522.6%
Эргэж төлөгдхөн цэвэр зээл	81.1	1.3%	87.9	8.3%	233.3	165.4%	429.8	84.2%	65.1	-84.8%
1 Эргэж төлөгдхөн дотоод цэвэр зээл	16.7	125.6%	1.0	-94%	184.2	99.4%	426.9	131.7%	11.9	-97.2%
2 Эргэж төлөгдхөн гадаад цэвэр зээл	64.5	-11.2%	86.9	34.7%	49.1	-43.4%	2.9	-94.1%	53.1	1731%

Хөрөнгө оруулалтын зардал төсвийн дунд хугацааны мэдэгдэлтэй нийцэж байгаа бөгөөд цаашид тооцоо судалгаа, үнэслэл муутай хөрөнгө оруулалтыг арга хэмжээг төсөвт суулгахгүй байх нь чухал юм.

Эргэж төлөгдхөн цэвэр зээл 2011 онд 429.8 тэрбум төгрөг байхаар тодотгосон бол 2012 онд 65.1 тэрбум төгрөг болгож 84.8 хувиар бууруулжээ. Эргэж төлөгдхөн дотоод цэвэр зээл 2011 онд 426.9 тэрбум төгрөг байхаар тодотгосон бол 2012 онд 11.9 тэрбум төгрөг буюу 97.2 хувь болгож бууруулж гадаадцэвэр зээл 53.1 тэр бум төгрөг буюу 17 дахин нэмэгдэж төсөлгэдсөн байна.

### 3.2. Улсын болон орон нутгийн төсөв

Улсын төсвөөс 2012 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 5,587,950.7 сая төгрөгөөр баталсан байна. Улсын төсвийн нийт зарлагын ДНБ, Нэгдсэн төсвийн нийт зарлагад элзэх хувь хэмжээ мөн өсөлтийн хувийг доорхи хүснэгтэд харууллаа. 2003 онд Улсын төсвийн ДНБ –д эзлэх хувь 40.1 байсан бол 2005, 2008, 2009 онуудад 30 хувиас доош бууж харин бусад жилүүдэд 37-31-ийн хооронд хэлбэлзэж дүхнэдэй байхад нэгдсэн төсвийн нийт зарлагад эзлэх хувь хэмжээ нь 2003-2009 онуудад тогтмол буурч байсан бол 2010 оноос эргээд өссөн дүнтэй байна. /Хүснэгт 3.4-өөс харна уу/


Улсын төсвийн нийт зарлага				
	тэрбум төг	өсөлтийн хувь	ДНБ-нд эзлэх %	НТЗ-д эзлэх%
2003	585.4	-	40.1	95.1
2004	711.2	21.4	37.2	94.5
2005	717.8	0.9	25.8	93.8
2006	1176.7	38.9	31.7	95.1
2007	1652.9	40.4	35.9	94.5
2008	1745.5	5.6	28.5	70.7
2009	1746.6	0.1	27.8	74.7
2010	2423.1	38.7	33.8	76.8
2011	3591.1	48.2	35.4	75.1
2012	5587.9	55.6	31.0	78.8

#### Хүснэгт 3.4. Улсын төсвийн ДНБ, НТЗ-д эзлэх хувь хэмжээ болон өсөлтийн хувь

Монгол улсын засгийн газрын дунд хугацааны зорилтод засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг боловсронгуй болгон, орон нутгын бие даасан байдлыг хангаснаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэж заасан байна. Монгол Улсын хувьд орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ улсын төсвийн зарлагаас харьцангуй бага байгаа нь иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг Засгийн газар голчлон санхүүжүүлдэгийн илэрхийлэл юм.

Сүүлийн арван жилийн дунджаар ДНБ-д улсын төсвийн зарлагын эзлэх хувь хэмжээ 33.4 хувь байгаа бол орон нутгийн төсвийн зарлагын хувь хэмжээ 6,6 хувь буюу ДНБ -д эзлэх улсын төсвийн зарлага орон нутгийн төсвийн зарлагаас 5 дахин их байна. Орон нутгийн хариуцан нийлүүлж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхой хэсгийг 2002 оны ТБУСТ хуулиар засгийн газар хариуцах болсноор ДНБ -д эзлэх улсын төсвийн зарлагын хэмжээ өсч харин орон нутгийн төсвийн зарлагын ДНБ -д эзлэх хэмжээ 75 хувиар буурсан байна. Улс орны төвлөрсөн болон төвлөрсөн бус удирдлагатайг ДНБ-д орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь хэмжээгээр илэрхийлдэг. Улсын төсөв болон орон нутгийн төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг Зураг 3.5-аас харна уу/

#### Зураг 3.5. Улсын ба орон нутгийн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ




Орон нутаг үндэсний нийт баялгийн маш бага хувийг захиран зарцуулж байгаа бөгөөд орон нутаг нь санхүүгийн талаар бие даасан бус байгаа нь үүнээс харагдаж байна. Орон нутгийн төсвийн зарлага нь 2012 онд ДНБ-ий 4 хувийг эзэлж байгаа нь бага үзүүлэлт юм. Мөн улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх орон нутгийн зарлагын хэмжээ 2002 онд 30.8 хувь байсан бол 2011 оны байдлаар 10.4 хувь, 2012 онд 10.2 хувь болж буурсан байна. 2012 онд орон нутгийн төсөвт дээмжлэг болгож 1 тэрбум төгрөг хуваарилаж байгаа боловч энэ нь нийт тийм төсвийн нийт дүнд эзлэх хувьд нөлөөлхгүй байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын 78.2 хувийг 2008 онд, 87.5 хувийг 2009 онд, 93.7, хувийг 2010 онд, 75.0 хувийг 2011 онд, 70.8 хувийг 2012 онд тус тус төсвийн урсгал зардал эзэлж байгаа бол орон нутгийн нийт төсвийн зарлагад эзлэх хөрөнгийн зардлын хэмжээ 2008 онд 21.6 хувь, 2009 онд 12.5 хувь, 2010 онд 6.1 хувь болж буурч байсан боловч 2011 онд 24.9 хувь, 2012 онд 29 хувь болж нэмэгдсэн дүнтэй байна.

ТБУСТ хууль батлагдан гарсанаас хойш орон нутгийн төсвийн зарлагын дийлэнх хувь орон нутгийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байгаа бөгөөд энэ дүн сүүлийн жилүүдэд өсч, харин орон нутгийн төсвийн зарлагын багахан хувийг эзэлдэг хөрөнгийн зардлын хувь хэмжээ буурсаар байсан боловч 211-2012 онд /Зураг 3.6-аас харна уу/ нэмэгдсэн байна.

**Зураг 3.6. Орон нутгийн төсвийн урсгал зардалын бүлгийн зардлуудын динамик  
(Тэрбум төгрөгөөр)**





2012 оны байдлаар нийт ургал зардлын 40 хувийг бараа, үйлчилгээний зардал, 59.9 хувийг татаас ба ургал шилжүүлэг эзэлж байна. Татаас шилжүүлэг нэмэгдэхэд орон нутгийн төсөвт өгөх татаас өнгөрсөн оноос нэмэгдэж байгаатай холбоотой юм. Төсвийн орлого бүрдүүлэлт 2007, 2008 онуудад харьцангуй өндөр буюу орон нутагт хөрөнгө оруулалтад тодорхой санхүүжилт хийх боломжтой байсан үе бөгөөд 2009 онд болсон эдийн засгийн хямрал, төсвийн алдагдал зэргээс шалтгаалан энэ байдал муудсан ч 2011 оны төсөвт 106.6 тэрбум төгрөг буюу орон нутгийн нийт төсвийн 25 хувь, 2012 он 211 тэрбум төгрөг буюу орон нутгийн нийт төсвийн 29.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр тусгасан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварт зориулж нийт 210,9 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа нь хөрөнгө оруулалт орон нутаг руу чиглэж байгааг харуулж байна.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙН АСУУДАЛ,  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Ц.Норовдондог (*Ph.D*), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж,  
Г.Билгээ, Б.Дуламсүрэн, Ч.Онончимэг

**Агуулга**

**Нэг. Оршил хэсэг**

1. Төсвийн төвлөрлийн онол, арга зүйн тайлбар

**Хоёр. Тоон шинжилгээ**

2. Төсвийн харилцаан дахь төвлөрлийн үзүүлэлтүүд

**Гурав. Эрх зүйн орчны шинжилгээ**

3. Төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн шинжилгээ
  - Монгол Улсын Төсвийн тухай хууль. /1992-2002 онуудад/
  - Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль
  - Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль. /2003-2011 онуудад/
  - Монгол Улсын Төсвийн тухай хууль.
  - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. /2012 оноос хойш/

\* \* \*

**ОРШИЛ**

Тус Судалгааны төвд Улсын Их Хурлын гишүүн Р. Гончигдоржкоос ирүүлсэн захиалгын дагуу төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн үзүүлэлт, төсвийн эрх мэдлийн хуваарилалт 1990 оноос хойш батлан хэрэгжүүлж буй төсвийн тухай хууль тогтоомжуудаар хэрхэн зохицуулагдаж ирсэнийг тухайн үед мөрдөж байсан болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжуудын концепци, мөн тоон судалгааны үзүүлэлтүүдэд тулгуурлан дараахь үечлэлээр дүн шинжилгээ хийв. Үүнд:

- “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хууль батлагдахаас өмнөх үед /1992-2002 он/
- “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хууль хэрэгжиж байсан үед / 2002-2011/
- “Төсвийн тухай хууль” шинэчлэгдэн батлагдсанаас хойшихи үед /2011 оноос хойш/

Судалгааны зорилго нь төсвийн төвлөрлийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, одоо мөрдөгдөж байгаа болон өмнө нь хэрэгжиж байсан хуулиудын зерэг, сөрөг үр дагаварыг тоон болон чанарын судалгааны аргаар тодорхойлоход чиглэгдсэн болно.

**1. Төсвийн төвлөрлийн талаархи онол, арга зүйн тайлбарууд**

Төрийн удирдлагын тогтолцоог үндсэндээ төвлөрсөн буюу төвлөрлийг сааруулсан гэж онолын сурх бичгүүдэд ангилсан байдаг. Чөлөөт эдийн засаг бүхий ардчилсан нийгмийн харилцааг хэт төвлөрсөн төрийн тогтолцоогоор зохицуулах боломжгүй тул төвлөрлийг

сааруулах зайлшгүй шаардлага бий болдог. Учир нь Төв Засгийн газрын болон Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын хариуцан шийдвэрлэх асуудал, үүрэг функц нь ялгаа заагтай ч зарим үүрэг функцийг хамтран хэрэгжүүлэх шаардлага гардаг.

**Төвлөрөл гэдэг нь:** Аливаа чиг үүргийн талаарх хариуцлага, эрх мэдэл нь тухайн байгууллагын нэг нэгж юм уу, эсвэл тухайн салбарын нэг байгууллагад төвлөрөх. Төрийн бүх үйлчилгээ, эрх мэдлийг /төсөв, татвар, бодлого г.м/ засгийн газрын төв, эсвэл үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл явц. Шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагыг байгууллагын дээд шатанд барих<sup>5</sup>.

**Төвлөрлийг сааруулах гэдэг нь<sup>6</sup>:** Анх “төвөөс зугтаах” гэсэн утгатай латин үгнээс гарсан байна. Толь бичгийн тодорхойлолт нь “аливаа төвлөрсөн эрх мэдэл, хяналтыг өөр хэсгүүд, үүнд үйл ажиллагаа явагддаг хэсэг рүү шилжүүлэх” гэсэн байна.

Төвлөрлийг сааруулах нь улс төр, захиргаа, төсвийн талаар шийдвэр гаргах эрх мэдлийг төв засгийн газраас орон нутгийн захиргаа, байгууллагад шилжүүлэх үйл явц юм. Төвлөрлийг сааруулах гэдэг нэр томъёо нь эрх мэдлийг дээрээс доош нь шилжүүлэх гэсэн ойлголтыг илэрхийлнэ.

**Төсвийн төвлөрлийг сааруулах гэдэг<sup>7</sup> нь:** Төсвийн зарлага, орлогын хариуцлагыг төв засгийн газраас орон нутгийн захиргаадад шилжүүлэх. Төвлөрөл хэт саарсныг орон нутгийн захиргаадын төв засгийн газраас хараат бус байдал хэр зэрэг дээшилснээр хэмждэг. Төвлөрөл саарсан түвшинг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Нягтралыг сааруулах: Захиргааны ажлын ачааллыг улсын нийслэл дэх төрийн захиргааны төв байгууллагуудааст тэдгээрийн харьяабус, нутаг, дүүрэгдэх байгууллага, ажилтнуудад шилжүүлэх үйл явц юм. Нягтралыг сааруулах нь үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагын дотор хэрэгжүүлж буй арга хэмжээ болохоос шийдвэр гаргах эрх мэдэл, өөрөө засаглах эрхийг төв засгийн газраас доод түвшинд шилжүүлэх үйл явцыг агуулдаггүй. Гэхдээ засгийн газрын үйл ажиллагааг иргэдэд орйтуулах утгаараа ялангуяа шилжилтийн эдийн засгийн газруудын хувьд төвлөрлийг сааруулах эхний алхам гэж үзэж болно.
- Эрх мэдэл төлөөлүүлэх: Эрх мэдлийг а/ тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх техникийн болон захиргааны чадавхитай; б/ боловсон хүчний талаархи төвийн бодлогоос ангид байж болох; в/ үйлчилгээний шууд төлбөр ногдуулах боломжтой; г/ төвийн яамдын шууд хяналтгүйгээр шийдвэр гаргах, хэрэгжүүлэх өргөн эрх мэдэлтэй байгууллагуудад шилжүүлэх хэлбэр.
- Эрх мэдэл бүрэн шилжүүлэх: Бие дааж шийдвэр гаргах эрх мэдлийн хамгийн дээд хэмжээг илэрхийлж, орон нутгийн захиргаадад тодорхой чиг үүргийг шилжүүлэн өгөх үйл явц. Энэ нь а/ бие даасан статустай; б/ боловсон хүчинээ өөрсдөө томилдог; в/ эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн газар нутгатай; г/ хариуцсан чиг үүргээ санхүүжүүлэх орлого бүрдүүлэх чадавхитай; д/ төрийн захиргааны тогтолцоон дахь бусад байгууллагуудтай харьцдаг, өөрөө засаглах эрхтэй орон нутгийн засгийн газрыг бий болгоно гэсэн үг юм.

<sup>5</sup> Ц.Даваадулам “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг” УБ хот 2010 он 19 тал

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Ц.Даваадулам “Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг”УБ хот 2010 он 34-35 тал

**“Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти”** (1985 он)-д “Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан субъектээс өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм” гэсэн бий.<sup>8</sup> Харин энэхүү үзэл санааг амьдралд хэрэгжүүлэх гол арга механизм нь төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах явдал юм. Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулах үйл явц нь орон нутгийн төсөв, санхүүгийн бие даасан байдал, тэнд төсвийг захиран зарцуулах эрх мэдлийг хэрхэн олгосон байдлаар хэмжигддэг.

**“Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти”**-ийн 9-р хэсгийн 1-р зүйлд “Нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгөтэй байх ба үүнийгээ бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.” хэмээн заасан байдаг.

Манай улсын хувьд орон нутгийн хөгжил сүл дорой, хот, хөдөөгийн хооронд эдийн засаг, нийгмийн хөгжлийн төвшний асар их зөрүү гарснаас хөдөөнөөс хот, суурин газар уруу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн улам нэмэгдсээр байгаа билээ. Энэ нөхцөлд төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулж, төсвийг төлөвлөхөөс эхлээд төсвийн орлогыг бүрдүүлэх, захиран зарцуулах хүрээнд орон нутгийн эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, орон нутгийн иргэдэл төрийн үйлчилгээг ойртуулах боломж бүрдүүлэх, энэ үндсэн дээр зарцуулсан хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх явдал хойшилуулшгүй шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг болж байна.

## 2. Төсвийн харилцаан дахь төвлөрлийн үзүүлэлтүүд

Сүүлийн жилүүдэд манай улсын төсөвт төвлөрч буй орлогын хэмжээ үлэмж нэмэгдэж байгаа ч Улсын нэгдсэн төсөв болон ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн орлогын хувь хэмжээ тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Аливаа улс орны төсвийн төвлөрсөн, эс төвлөрсөн байдлыг илтгэдэг гол үзүүлэлтүүд ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн орлого болон Улсын төсвийн орлогод орон нутгийн орлогын эзлэх хувь юм.

Төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2000 онд 33,4 хувь байсан бол улмаар 2008 онд 43,7 хувь болон өсчээ. Харин орон нутгийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ эсрэгээр 2000 онд 6,5 хувь байснаа 2008 онд 2,8 хувь хүртэл буурсан байна.

Орон нутгийн орлогод эзлэх хувь мөн ижил динамикаар өөрчлөгдөж, 1991 онд 50.9 хувь байсан бол 1993 оноос буурч 20.5 хувь хурсэн байна. Энэхүү бууралт 1999 он хүртэл тогтмол шинжтэйгээр байсан бөгөөд 2000 онд 19,2 хувь, 2008 онд 6,4 хувь болтол буурсан байна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнуудын хувьд ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн зарлагын хувь дунджаар 10-15, төсвийн зарлагад эзлэх хувь дунджаар 20-25 байдаг. Үүнтэй харьцуулан үзэхэд Монгол Улсад санхүү, төсвийн төвлөрөл их байгаа нь харагдана.

1992 оноос хойш Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого нь орон нутгийг санхүүгийн хувьд илүү бие даалгах үзэл баримтлалыг зарчмын хувь дэмжиж байсан ч бодит байдалд орон нутгийн орлого буурч байв.

Хүснэгт 1-ээс үзвэл орон нутгийн төсвийн орлого нь 1991, 1992 онуудад 50.9-46.4% байсан бол 1993 оноос эрс буурсан байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл улсын төвлөрсөн төсөвт орон нутгийн орлогыг төвлөрүүлэх хандлага бий болсон.

<sup>8</sup> Б.Чимэд. Нутгийн өөрөө удирдах ёсыг өргөтгөн бэхжүүлэхэд төрийн санхүүгийн үзүүлэх нөлөө 2008 он “Хариуцлагатай төр: Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёс” форумд тавьсан илтгэл, 4 дэх тал,

## Хүснэгт 1.

- Монгол Улсын 1991-2002 оны төсөвт орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь, оны үнээр /сая төг/

Он	Улсын төсвийн нийт орлого	Орон нутгийн төсвийн орлого	Нийт төсөвт орон нутгийн төсвийн орлогын эзлэх хувь	Улсын төсвийн нийт зарлага	Орон нутгийн төсвийн зарлага	Нийт төсөвт орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хувь
1991	5,328.7	2,713.8	50.9	7,104.2	3,870.9	54.5
1992	10,483.6	4,859.2	46.4	12,522.6	6,177.0	49.3
1993	60,058.8	12,297.1	20.5	69,081.8	23,233.4	33.6
1994	81,931.2	20,674.8	25.2	97,496.7	33,577.5	34.4
1995	129,228.1	31,331.4	24.2	140,296.2	53,412.5	38.1
1996	146,721.6	38,384.1	26.2	175,060.2	61,753.4	35.3
1997	221,109.9	52,898.0	23.9	294,652.2	87,817.8	29.8
1998	268,497.3	60,816.0	22.7	350,707.2	104,998.4	29.9
1999	291,136.1	58,849.0	20.2	382,142.1	101,266.6	26.5
2000	346,119.2	68,536.3	19.8	440,648.3	131,077.2	29.7
2001	408,882.1	84,433.4	20.6	479,967.3	154,841.8	32.3
2002	443,122.5	102,604.8	23.2	525,899.6	164,330.9	31.2
2003	553,889.3	52,312.8	9.4	615,771.3	50,112.1	8.1
2004	713,113.6	68,766.6	9.6	752,486.4	68,802.3	9.1
2005	837,858.3	78,308.9	9.3	764,597.1	79,343.2	10.4
2006	1,360,409.8	96,202.1	7.1	1,237,008.0	95,574.1	7.7
2007	1,880,488.9	153,508.4	8.2	1,747,310.5	145,998.0	8.4
2008	2,170,370.0	202,494.3	9.3	2,466,774.4	203,315.8	8.2
2009	1,993,995.6	283,717.0	14.2	2,336,629.7	268,150.7	11.5
2010	3,122,464.2	361,531.3	11.6	3,080,685.1	353,251.5	11.5
2011 Тод.	3,942,533.8	423,972.8	10.8	4,931,214.4	425,172.8	8.6
2012 Төл.	5,825,663.2	755,187.2	13.0	6,309,450.0	757,204.7	12.0

Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.



Орон нутагт үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийн хэрээр орон нутгийн түвшинд орлогын эх үүсвэр дутагдаж байсан. Үндсэн нэр төрлийн татварын орлогыг төвлөрсөн төсөвт хуваарилж байв.

#### Хүснэгт 2.

- Монгол Улсын 1991-2002 оны нэгдсэн төсөвт ДНБ-ний эзлэх хувь, /сая төг/

Он	Улсын төсвийн нийт орлого	Улсын төсвийн нийт зарлага	ДНБ (оны үнээр)	Нэгдсэн төсвийн орлогод ДНБ эзлэх хувь	Нэгдсэн төсвийн зарлагад ДНБ эзлэх хувь
1991	5,328.7	7,104.2	18,909.6	28.2	37.6
1992	10,483.6	12,522.6	47,298.0	22.2	26.5
1993	60,058.8	69,081.8	166,219.1	36.1	41.6
1994	81,931.2	97,496.7	283,263.0	28.9	34.4
1995	129,228.1	140,296.2	550,253.7	23.5	25.5
1996	146,721.6	175,060.2	646,559.3	22.7	27.1
1997	221,109.9	294,652.2	832,635.6	26.6	35.4
1998	268,497.3	350,707.2	817,393.4	32.9	42.9
1999	291,136.1	382,142.1	925,345.7	31.5	41.3
2000	346,119.2	440,648.3	1,044,600.0	33.1	42.2
2001	408,882.1	479,967.3	1,130,518.7	36.2	42.5
2002	443,122.5	525,899.6	1,245,000.0	35.6	42.2
2003	553,889.3	615,771.3	1,461,169.2	37.9	42.1
2004	713,113.6	752,486.4	1,910,880.9	37.3	39.4
2005	837,858.3	764,597.1	2,266,505.5	37.0	33.7
2006	1,360,409.8	1,237,008.0	3,715,000.0	36.6	33.3
2007	1,880,488.9	1,747,310.5	5,464,300.0	34.4	32.0
2008	2,170,370.0	2,466,774.4	6,130,300.0	35.4	40.2
2009	1,993,995.6	2,336,629.7	6,293,600.0	31.7	37.1
2010	3,122,464.2	3,080,685.1	7,171,400.0	43.5	43.0
2011 Тод.	3,942,533.8	4,931,214.4	10,157,200.0	38.8	48.5
2012 Төл.	5,825,663.2	6,309,450.0	16,133,500.0	36.1	39.1


\* \* \*

### 3. Төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн шинжилгээ

#### 1.1 Монгол улсын төсвийн тухай хууль /1992 - 2002 онуудад/

1992 оны Төсвийн тухай хууль нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, санхүү төсвийн харилцааг өөрчлөн боловсронгуй болгох ажлын хүрээнд хийгдсэн Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан хууль бөгөөд уг төсвийн тухай хууль нь 5 бүлэг 21 зүйлтэйгээр батлагдсан байна.

#### Зураг 4. 1992 оны Төсвийн тухай хуулиар төсөв, түүний бүрэлдэхүүн



Монгол улсын төсвийн тогтолцоо нь 1992 оноос 2002 оныг хүртэл нилээд төвлөрсөн, дээрээс доош чиглэсэн зарчмаар хуваарилагддаг, төлөвлөлт нь дан ганц зардалд суурилсан, үр ашгийн бус мөнгөний удирдлагад анхаарсан байдалтайгаар явж ирсэн. 1992 оны Төсвийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалтын хувьд Орон нутгийн төсөв нь Засгийн газраас бүрэн хараат, төсвийн төлөвлөлтийн хувьд авч үзвэл эхлээд сум зардалдаа үндэслэсэн төсвийн төслийг гаргаж аймагтаа хүргүүлнэ, аймаг нь бүх сумдын төсвийг нэгтгээд Санхүү, эдийн засгийн яаманд /тухайн үеийн нэрээр/ хүргүүлж энэ Засгийн газраар дамжигдаад УИХ-аар батлагддаг байна.

Санхүү, эдийн засгийн яам нь орон нутгаас ирсэн зардалдаа тулхүү анхаарал хандуулсан төсвийн төслийг нилээдгүй хэмжээгээр танаж, УИХ-д оруулна. Батлагдсан төсөв Сангийн яамаар дамжин аймагт, аймгаас суманд хүрнэ. Шат дамжлага бүрт төсөв хянагдаж, танагддаг байв. Нөгөө талаас орон нутаг ч төсвөө аль болох өндөр зардалтай төлөвлөдөг.

Орон нутгийн төсвийн татварын орлого бэхжээгүй ба үндсэн нэр төрлийн татварууд нь төвлөрсөн төсөвтөө ороод зарим хэсэг нь татаас байдлаар дахин хуваарилагддаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хувь хэмжээгээр нь бус байгууллагаар нь төсөвт хуваарилж байсан бөгөөд Засгийн газраас ямар аж ахуйн нэгжүүд орон нутгийн төсөвтэй, ямар нь төвлөрсөн төсөвтэй харилцахыг жил бүр тогтоодог байсан байна. Төвлөрсөн төсөвт томоохон аж ахуйн нэгжүүдийг хуваарилаад орон нутагт орлого багатайг нь үлдээдэг. Энэ систем нь орон нутгийн орлогын төвортой байдал, түүний баталгааг хангаж өгдөггүй.

1992 онд батлагдсан Төсвийн тухай хуулийн 9-р зүйлийн 1.1-д орон нутгийн төсвийн орлогод “Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын, худалдааны болон онцгой албан татвар” орно гэж заасныг 2001 онд хүчингүй болгосон бөгөөд энэ нь орон нутгийн төсвийн орлогыг бууруулах гол шалтгаан болсон гэж үзэж болох юм.

1999 онд Засгийн газрын шийдвэрээр орон нутгийн аж ахуйн нэгжийн нэмэгдсэн өргтгийн албан татварын орлогын 20%-ийг орон нутгийн төсөвт үлдээж байсан ч 2003 оноос 100 хувь төвлөрсөн төсөвт оруулж байхаар болжээ. 1996 онд Засгийн газраас төвлөрлийг сааруулах, орон нутгийн захирагааг бэхжүүлэх бодлогын зорилтуудыг дэвшүүлж байсан хэдий ч бодитойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хууль эрх зүйн шинэчлэл зэрэгээс харахад зарчмын хувьд өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос нэг их өөрчлөгдөж ахиц гараагүй болно.

## **1.2 Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль /2003-2011 онуудад/**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиуд 2002 онд батлагдснаар төсөв, санхүүгийн тогтолцооны шинэчлэл эрчимжсэн. Эдгээр баримт бичгүүдэд тус Судалгааны төвөөс тухайн үед хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж байсан. Энэ хэсэгт уг судалгааны үр дүнгээс товчлон авав.

**Нэгдсэн төсвийн тухай хууль** нь Монгол Улсын нэгдсэн төсөв, түүний бүтэц бүрэлдэхүүн, төсөв захирагчийн эрх, үүрэг, төсвийн орлого, зарлагын ангилалд төсвийн гүйцэтгэлийг тайлгахаа, төсвийн бүртгэлтэй холбогдсон төсвийн ерөнхий харилцааг зохицуулж байсан.

**Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль** (ТБУСТХ) нь төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлгахаа үйл явц, төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтын эрх, үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, улсын болон орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн хяналт хариуцлага зэрэг төсвийн үйл явцтай холбогдсон харилцааг зохицуулж байсан.

ТБУСТХ хэрэгжик эхэлснээс хойш төсвийн төлөвлөлтөд баримтлах бодлогод зарчмын өөрчлөлт шинэчлэлт хийгдэж түүнд тулгуурлан боловсруулсан төсвийн байгууллагын хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, Төсвийн хүрээний мэдэгдэл (ТХМ), холбогдох байгууллагаас гаргасан удирдамж, чиглэл, төсвийн теслийг зохиох үндэс бий болсон.

Бодлого тодорхойлогчид, орон нутгийн удирдлага, судлаачид 2002 онд батлагдсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжик эхэлснээс хойш төсөв салбарын яамд, агенлэгт төвлөрч орон нутгийн төсөв хумигдаж, нутгийн удирдлагын байгууллагын төсвийн эрх хэмжээ буурсан талаар ихээхэн шүүмжилдэг. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл хийгдсэнээс хойш эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж зэрэг салбарын үйлчилгээг нийлүүлэх, санхүүжүүлэх үүрэг орон нутгийн удирдлагаас салбарын яамдад төвлөрөн шилжсэн нь орон нутгийн төсвийг бууруулах гол шалтгаан болсон байна.

Төсөв, хөрөнгө оруулалт яамдад ийнхүү төвлөрснөөр орон нутгийн удирдлага төрийн үйлчилгээтэй холбоотой жижиг асуудлыг ч шийдэх боломжгүй болжээ. Тухайлбал, аливаа сумын ИТХ, Засаг даргад орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдэх зориулалт бүхий өөрийн бүрэн эрхийн хүрээнд захиран зарцуулах төсөв, хөрөнгөгүй болсон.

Орон нутагт үүссэн гэнэтийн нөхцөл байдлыг аймаг, сумдад шийдэх хөрөнгө байхгүй, аль нэг сумын эмнэлэг, сургуулийн барилгад засвар хийх, өмчийн ашиглалтыг сайжруулахад шаардагдах хөрөнгийг шийдэх боломжгүй зэрэг олон сөрөг үр дагавар гарсан. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль хэрэгжих эхэлсэн 2003 оноос орон нутгийн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ өмнөх оныхоосоо 10.2 хувь буюу 118.8 тэрбум төгрөгөөр буурсан байгаа нь төсвийн төвлөрөл. Төв засгийн газарт шилжсэнийг тодорхой харуулж байна.

### Зураг 5.

- ТБУСТХ-ийг хэрэгжүүлснээр төвлөрлийг сааруулах бус, харин төвлөрлийг нэмэгдүүлэх хандлагатай болсон гэдэгтэй санал нийлж буй эсэх байдал



#### Эх сурвалж:

УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилт. 2006 он.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулахад Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль ямар нэлэө үзүүлж байна гэж Та үздэг вэ? гэсэн асуултанд оролцогчдын хариулсан байдлыг хүснэгтээр үзүүлбэл;

#### Хүснэгт 3. ТБУСТХ-ын үзүүлж буй нөлөө

Хариулт	Эерэг			Серөг			Зарим талаар эерэг, зарим талаар сөрөг	
	Засаг дарга	Аудиттор	Албан хаагч	Засаг дарга	Аудиттор	Албан хаагч		
Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэхд	0	3.0	20.4	100.0	63.6	43.1	59	35.3
Орон нутгийн бие даасан байдлыг хангахад	0	9.1	22.7	93.8	72.7	47.0	55	30.4

Төвлөрлийг сааруулахад	0	0	14.7	93.8	60.6	57.7	45	18.1
---------------------------	---	---	------	------	------	------	----	------

**Эх сурвалж:**

УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилт. 2006 он. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, орон нутгийн төсвийг хэлэлцэхэд хуулиар тодорхой үүрэг гүйцэтгэдэг ч бодит амьдрал дээр тэр нь төсвийг хэлэлцсэн хэлэлцээгүйтэй яг адилхан болдог гэж аймгийн Засаг дарга нар үзжээ.

**Хүснэгт 4.**


Орон нутгийн бие даасан байдлыг хангахын тулд ямар арга хэмжээ авбал зохистой вэ? гэсэн асуултанд хариулсан байдал

	Хариулт	Хувь
1.	Татварын хуульд өөрчлөлт оруулж төвлөрсөн төсөвт татан авдаг татварын хэмжээг багасгах	41.3
2.	Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог өөрчлөх	13.5
3.	Төсөвт байгууллагууд өөрийн орлогоо бие даан зарцуулах боломжийг өргөтгөх	45.2
4.	Хариулаагүй	7.3

**Эх сурвалж:**

УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилт. 2006 он.

Тэдний үзэж байгаагаар төсөв, санхүүгийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг хангахын тулд Татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж төвлөрсөн төсөвт татан авдаг татварын хэмжээг багасгах, төсөвт байгууллагад өөрийн орлого, хэмнэсэн зардлыг бие даан зарцуулах боломж олгох нь зүйтэй гэж үзсэн байна. Түүнчлэн орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй компаниудын зохих орлогын хэмжээнээс орон нутгийн захирагаа татаас авч бус нутгийн хөгжилд зориулах зүйтэй гэсэн ч саналуудыг дэвшүүлж байлаа. Иймээс Аймаг, сумын, дүүргийн Засаг дарга нарын ихэнх нь уг харилцааг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзээд 81.3 хувь нь хуулийг бүхэлд нь өөрчлөх ёстой гэж саналаа өгсөн байна.

**Зураг 6. Хуулийг боловсронгуй болгох тухай санаа бодол****Эх сурвалж:**

УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилт. 2006 он.

### ТБУСТХ -ЫН ХЭРЭГЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ЗЭРЭГ ҮР ДҮН:

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж, төрийн болон төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн зарчим, албан тушаалтны эрх үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, санхүүжих механизмыг хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулж өгснөөр дараах үр дүнд хүрч байжээ. Үүнд:

- ✓ Тухайн байгууллага нь хийх ажлаа нарийн төлөвлөж, тодорхой зорилт дэвшүүлэн, бүтээгдэхүүнээ бага зардлаар чанартай сайн нийлүүлэх, нөөц чадавхия оновчтой дайчилж идэвх санаачлагатай ажиллан гарах эцсийн үр дүнгээ тодорхойлсны дараа санхүүжүүлдэг журамд шилжин хэвшиж байна.
- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн байгууллагын ерөнхий менежертэй гэрээ байгуулснаар үр дүнг нь үнэлж урамшуулал, хариуцлага тооцдог механизмыг бий болсон.
- ✓ Тухайн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагаа нь төрөөс зайлшгүй үзүүлэх ёстой ажил, үйлчилгээ мөн эсэхийг тодорхой шалгуураар тогтоосны дараа төсвөөс санхүүжүүлэх эсэхийг шийддэг журамд шилжсэнээр байгууллага, бүтэц, орон тоо бүрийг санхүүжүүлдэг журам түүх болон үлдэв.
- ✓ Өмчлөгч-төр буюу түүнээс эрх олгосон этгээд өмчлөгчийн ашиг сонирхлыг хөндсөн бодлогын шинжтэй асуудал болон байгууллагын менежментийн асуудлын хүрээ, ялгаа зааг тодорхой боллоо.
- ✓ Төсвийн байгууллага, албан тушаалтны улсын төсвийн талаархи эрх, үүрэг нь хуулиар нарийвчлан зохицуулагдсанаар төсвийн ерөнхийлөн захирагч болон менежерүүдийн үүрэг хариуцлага дээшилж, бие даасан, санаачлагатай ажиллагаа тогтвортжуулж байна.
- ✓ Төсөв зохиох, хянах, батлах, төсвийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнахтай холбогдсон харилцаа, тэдгээрт тавигдах шаардлагыг хуульчлан баталгаажуулснаар төрийн нэгдсэн сангийн тогтолцоо бий болж, цалин тэтгэврийг хугацаанд нь олгож, гадаад дотоодын өр авлагаас ангижирч, төсвийн хөрөнгийн ашиглалт сайжирч, төсвийн сахилгыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.
- ✓ Төсвийн байгууллагын ерөнхий менежер болон ажилтныг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг боловсруулж УИХ-аар баттуулан, улсын төвлөрсөн төсвийн байгууллагын ерөнхий менежер, аймаг, нийслэлийн засаг даргын Тамгын газрын ерөнхий менежер, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилоход сонголт хийх бололцоотой тооны хүмүүсийг нэр дэвшүүлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгон, хэрхэн сонгосноо нэр дэвшигчдийн нэrsийн жагсаалтын хамт нийтэд мэдээлэх, дээрх албан тушаалтны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үндэслэн урамшууллынх нь талаар холбогдох этгээдэд саналоруулах, төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох удирдах албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчидтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг дүгнэх заавар, журмыг батлах, биелэлтэд нь хяналт тавих, дүгнэх, төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хангахтай холбогдсон боловсон хүчиний бодлогыг хэрэгжүүлэх ажил сайжрав.
- ✓ Төсвийн байгууллагын албан хаагчдын ижилсгэсэн цалин урамшууллын системийг боловсронгуй болгож, байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэхэд болон ажлын үр дүнг сайжруулах талаар тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмэр, байгууллагын нийт үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харгалzan албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал олгох эрхийг тухайн байгууллагын дарга эдлэх боллоо.
- ✓ Тухайн орон нутгийн эрхлэх асуудал буюу орон нутгийн хэрэгцээнд нийлүүлэх

Үндсэн бүтээгдэхүүний нэр төрлийг тогтоож, ингэснээр төв болон орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт тодорхой болж “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ” гэсэн Үндсэн хуулийн заалт хэрэгжих хувуль зүйн орчин бүрдэх **эхлэл** тавигдсан.

- ✓ Аймаг, нийслэл болон Засгийн газар хоорондын санхүүгийн харилцааны зааг хүрээг тодорхой болгож, орон нутаг өөрийн хэрэгцээт үндсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд шаардлагатай төсөвтэй байх, орон нутаг өөрийн хэрэгцээт үндсэн бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр улсын төвлөрсөн төсөвт нийлүүлж байна.
- ✓ УИХ-ын бодлого болон Засгийн газраас нийгэмд үзүүлэх ажил үйлчилгээг зөв тогтоох, үр нөлөөтэй хэрэгжүүлэх бололцоо, үүрэг нөлөө, чадавхи нэмэгдэх нөхцөл бүрдэв.
- ✓ Засгийн газрын үйл ажиллагаа зах зээлийн эдийн засгийн шаардлагад илүү нийцтэй болж, төсөв, санхүүгийн хариуцлага, сахилга бат, үр ашиг сайжран, нийтэд нээлттэй, ил тод болсноор УИХ, ард түмний зүгээс түүнийг хянах бололцоо өргөжив.
- ✓ Төр, засгийн хариуцах үүрэг тодорхой болохын хэрээр хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хувь хүний оролцоо хөгжих орон зай, сонирхол бий болон улмаар иргэний нийгэм төлөвшин сайн засаглал бүрдэх боломж алхамаар бий болж байна.
- ✓ Нийт төсвийн байгууллага төрийн бодлого, шийдвэрт захирагдаж шуурхай ажиллах чадвартай болж нийгэмд үзүүлэх үйлчилгээний чанар сайжран, татвар төлөгчдийн хөрөнгийг зарцуулах үүрэг, хариуцлага эрс нэмэгдсэнээр засаглал чадварлаг, мэдрэмжтэй болж төлөвших бололцоо бүрдэж байна.

Хууль болон түүний үндсэн дээр хийгдсэн шинэчлэлийн **үр дүн нь** төсвийн харилцааг боловсронгуй болгож, нэг талаас ард түмнийг төлөөлөн төрийн өмчийг өмчлөгч төр буюу тухайн засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нийгмийн өмчийн зүйлсийг өмчлөгч Иргэдийн төлөөлөгчдийн хурал, нөгөө талаас улсын төсвийн нийт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, мөн тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага хоорондын харилцааг үйл ажиллагааны эцсийн үр дүнд чиглүүлэн цогц байдлаар зохицуулсан явдал юм. өөрөөр хэлбэл эдгээр байгууллагын зорилт, үр дүнг төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх ажлын явц байдлыг хянан зохицуулж, үр дүнг нь үнэлэн, урамшуулах эсвэл хариуцлага тооцдог **санхүү төсөв, удирдлагын иж бүрэн тогтолцоо** бий болсонд оршино.

#### **ТБУСТХ -ын хэрэгжилтээр бий болсон сөрөг үр дүн:**

УИХ-аас улсын төсвийг хэлэлцэн баталснаар, орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах үе эхэлдэг. Төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэн батлах дэгийг ЗЗНДНТУТХ, НТТХ, ТБУСТХ болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд тухайллан заагаагүй байна. Орон нутгийн төсөв нь үндсэндээ урсгал зардлыг санхүүжүүлэхэд чиглэж байгаа учир ИТХ-ын хуралдаан дээр бүтээлч хэлэлцүүлэг өrnөхгүй байна. БНГ-ний дагуу хуваарилагдсан төсвийн байгуулагуудын төсвийг ИТХ хэлэлцэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

Дээд шатны байгууллагууд нь төсвийг хянаж батлахдаа орон нутгийн санал, газар зүй эдийн засаг, нийгмийн онцлогийг төдийлөн харгалзахгүйгээр урьд оны төсвийн гүйцэтгэл, тогтсон жишгийг баримталж байна. Төрийн сангаас баримтлаж байгаа төсвийн сар, улирлын хуваарь нь уян хатан биш байна. Зах зээлийн үнэ, ханшны өөрчлөлтийг харгалzan төсвийн тодотгол хийж чадахгүй байна. Засгийн газраас хөтөлбөр, бодлогын баримт бичгийг гаргахдаа түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэдэггүй тохиолдол байна. Төсвийн гүйцэтгэлийг хяналт үнэлгээ нь ИТХ, Засаг

даргын хяналт, Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын алба, төрийн аудитын байгууллагаас, тавих хяналтаас бүрдэнэ. Гэхдээ төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьж буй хяналт нь зөвхөн эцсийн гүйцэтгэлийн хяналт болжээ. Харин үйл явцын хяналт үндсэндээ хийгдэхгүй байна.

Оролцооны асуудал нь шинэ Үндсэн хууль батлагдсанаар бодитой хэрэгжиж эхлэж байгаа билээ. Өнөөгийн байдлаар төсвийг боловсруулах, хэлэлцэн батлах үйл явц дахь иргэд, баг сум, төсвийн байгууллагын оролцооны түвшин харилцан адилгүй байна. Иргэдийн оролцооны үндсэн хэлбэр нь сумын удирдлага, төрийн албан хаагчид сонгуульнуудаар дамжуулан саналаа амаар буюу бичгээр илэрхийлэх явдал байна. Сум аймгийн төсвийг зохиох, зарцуулах, хяналт тавих үйл явц дахь иргэдийн оролцоо хангалтгүй байна. Энэ нь нэг талаас төсвийн талаарх мэдээлэл дутмаг, нөгөө талаас оролцох аргаа мэдэхгүй байгаатай холбоотой. Төсвийн харилцаан дахь багийн оролцоо хязгаарлагдмал, оролцооны арга хэлбэр тодорхойгүй байна. Энд иргэд, сумын удирдлагын санаачлага дутагдаж байна.

Төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй, төрийн албан хаагчдад иргэдийн өмнө хариуцлага хүлээх сэтгэлгээ баттай төлөвшөөгүй, удирдлага ба иргэдийн хооронд байнгын нягт харилцаа бий болж чадаагүй байна. Сумын түвшинд төсвийн харилцаанд голлон оролцогчид нь сумын ЗД, түүний Тамгын газар, ИТХ, түүний Тэргүүлэгчид, улсын төсвөөс санхүүждэг байгууллагууд юм. Сумын ИТХ нь орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах гүйцэтгэлд хяналт тавих үүрэгтэй. ТБУСТХ хэрэгжиж эхэлснээр суманд үйл ажиллагаа явуулдаг сургууль эмнэлэг, соёлын байгууллагын төсвийг дээд шатнаас хуваарилан шууд ирүүлдэг болсон. Ийм учраас ИТХ нь зөвхөн ИТХ, ЗД, ЗДТГ-ын төсвийг хэлэлцэн баталдаг болжээ

Төсвийн байгууллагуудын зүгээс төсвийн төлөвлөлтөд илүү идэвхтэй оролцох сонирхол байна. ТБУСТХ-ийн дагуу ЕМ-үүдэд бие даан ажиллах боломж олгосон бөгөөд тэдний төсвөө тооцох, мэдэж зарцуулах чадвар өсч байгаа нь сүүлийн 2 жилийн төсвийн зарцуулалтын тайлангаас харагдаж байна. Сум аймаг хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан тэргүүлэх чиглэлээ тогтоож байна. Гэвч төсвийн хэмжээ зайлшгүй урсгал зардлыг санхүүжүүлэх төдий учир батлагдсан төсөв хөгжлийн зорилттой уялдаж чадахгүй байна. Урьд оны төсвийн гүйцэтгэлд тулгуурлан зардлын норматив, үнийн өөрчлөлтийг харгалзан ирэх оны төсвийн саналыг хянаж, хуваарилж байна. Төсвийн саналыг хянах, хуваарилахад хэрэглэдэг тусгайлан боловсруулсан шалгуур, аргачлал байхгүй байна.

Орлого нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага их байгаа ч сум аймаг төсвийн орлогоо бие даан нэмэгдүүлэх боломж хомс байна. Иргэдийн амжирааны түвшин доогуур, татварын орлогын бааз суурь хязгаарлагдмал байгаа нь орон нутгийн орлогыг бүрдүүлэхэд бэрхшээл учруулж байна. Сумын төсөвт төвлөрүүлж байгаа өөрийн орлого нь сумын ИТХ, ЗД, ЗДТГ-ын зардлыг бүрэн санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байна. Сум аймгийн төсвийн өөрийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд улсын төсөвт төвлөрүүлдэг татварын орлогын тодорхой хувийг аймаг, суманд нь үлдээх, татвар ноогдох орлого, хөрөнгө, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний бүртгэлийг сайжруулах, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг зээл, татварын бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Сум, аймгийн нийт зарлагыг төсвийн болон төсвийн бус эх үүсвэрээр санхүүжүүлж байна. Сум, аймаг нь орон нутгийн төсвийн өөрийн орлого, санхүүгийн дэмжлэгээр орон нутгийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг санхүүжүүлж байна. Орон нутгийн хэрэгцээт бүтээгдэхүүнд сум аймгийн ИТХ, ЗДТГ, багийн ЗД-ын болон аймгийн төсвөөс санхүүжилт авдаг агентлагуудын ажил үйлчилгээ багтаж байна. Харин улсын төсвийн хөрөнгөөр сумын сургууль, цэцэрлэг, соёлын төв, хүн эмнэлэг зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудын ажил үйлчилгээг санхүүжүүлж байна. Төсвийн хөрөнгийн үр ашиг, үр дүнг үнэлэхдээ төсвийн зарлагын

хэтрэлт, төсвийн зарлагын хэмнэлт, өр авлага, төлөвлөсөн орлогоо нэмэгдүүлсэн байдал зэрэг шалгуурыг хэрэглэж байна. Үр дүн, үр нөлөөг хэмжих үзүүлэлт байхгүй байна. Үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг судлан шинжлэх, түүнийг үнэлэх талаар ямар нэгэн санаачлага гаргасан тохиолдол судалгаанд хамрагдсан сумдын хувьд байхгүй байна.

Төсөв боловсруулах, батлах, баталсны дараа захиран зарцуулах үйл ажиллагаанд НӨҮҮБ байгууллага, нутгийн захиригаа, иргэний нийгмийн оролцоо хязгаарлагдмал байна. ТБУСТХ-ийн дагуу аймаг нийслэлийн Засаг дарга нар төсөв ерөнхийлөн захирагчийн хувьд Ерөнхий сайдтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулна. Харин тухайн салбарынхаа төсвийн багцыг захиран зарцуулах эрх бүхий төсвийн ерөнхийлөн захирагч-сайдуудтай төсөв хуваарилалтын талаар болон бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний талаар тохиролцдог.

Аймгийн төсөвт тухайн аймагт ажиллаж буй эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагууд, татварын болон гаалийн газар, хүнс хөдөө аж ахуй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар хэлтсүүд, гамшигтэй тэмцэх газар, хууль зүй, дотоод хэрэг (цаадаагийн газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар), нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, нутгийн захиригааны байгууллагуудын төсөв багтдаг. Эдгээр нь улсын төсөвт тусгагдаадаа салбар хариуцсан сайдын багцад хуваарилагддаг. Эцсийн эцэст төсөв ерөнхийлөн захирагч нь салбар хариуцсан сайд байдаг учраас төрийн сангийн шаталсан босоо тогтолцоогоор сайдын хатуу хяналтанд зарцуулагдана. Энэ бүхнээс хамаарч орон нутагт төсвийн бие даасан байдал хангальгүй байгаа болно.

**Нэгдүгээрт,** Төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын баримт бичиг, хөтөлбөр, үзэл баримтлал гараагүй байна. Энэ нь төвлөрлийг сааруулах ач холбогдол, арга механизмын талаархи нэгдсэн ойлголт төлөвшөөгүй, зарим нэр томьёог ойлгохгүй байгаагаас удирдлагын түвшинд янз бүрийн шийдвэр гарах нөхцлийг бүрдүүлж байна.

**Хоёрдугаарт,** Төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт, шалгуур боловсронгуй биш, хэтэрхий их бичиг цаастай ноцолдсон, менежертэй байгуулсан гэрээгээ дүгнэхгүй, сунгахгүй байх, төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх мэдлийг өргөтгөх, төвлөрлийг сааруулах нэрийн дор зохицуулалттай, хяналттай байх явдлаас зайлсхийж чөлөөтэй дураараа байх гэсэн санаархал газар авах зэрэг субъектив хүчин зүйлүүдийн нөлөөлөл их байна. Ийм учраас хуулийн үзэл санаа, гол зарчмыг олон нийтэд ойлгомжтой арга хэлбэрээр сурталчилах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

**Гуравдугаарт,** ТБУСТХ хэрэгжсэнээр орон нутгийн эрх хэмжээ буурч, орон нутгийн ИТХ Сангийн яамнаас тогтоосон дотацийг ёс төдий батлах болсон. Өөрөөр хэлбэл аймаг, сумдын ИТХ нь дээрээс хуваарилсан төсвийг өөрчлөх эрхгүй, зөвхөн хэлэлцэх батлах үүрэг хүлээж байна. Тэгэхлээр НТТХ, ЗЗНДНТУТХ, Татварын хууль, холбогдох бусад хуулиуд, мөн ТБУСТХ-ийн зохих заалтуудад шаардлагатай зарим нэмэлт, өөрчлөлт оруулж, өөр хооронд уялдуулах үндсэн дээр эрх зүйн суурь орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.

**Дөрөвдүгээрт,** Төсвийн төсөл боловсруулах, батлах, зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагаанд ИНХ, Багийн ЗД, ИТХ-ын оролцоо хангальгүй, тэднээс хяналт тавих эрх мэдэл дутагдалтай байна. Нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиригааны байгууллагын чиг үүрэгт шууд болон шууд бусаар хамаарах асуудлаар төрийн захиригааны төв байгууллагаас шийдвэр гаргах явдал байсаар байна. Ийм шийдвэр зайлшгүй боловч чухам ямар төвшний, ямар асуудлаар хэн шийдвэр гаргах, шийдвэр гаргах үйл явцыг ямар байх, түүнд иргэд, олон нийтийн оролцоог хэрхэн хангах вэ? гээд олон асуудлыг нарийн журамлах хэрэгтэй гэдгийг судалгааны дүн харуулж байна.

**Тавдугаарт,** Орон нутгийн эдийн засгийн чадавхи муутай байгаа нь сум, аймгийн төсвийн өөрийн орлогод сэргөөр нөлөөлж, орлого бүрдүүлэх боломжийг хязгаарлаж байгаагаас

Судалгааны эмхтгэл, XI боть

гадна удирдлагын идэвх санаачлага бага байгаа нь нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулж байна. Орон нутгийн, ялангуяа, ихэнх сумын төсвийн бүрдэлтэд өөрийн орлого дунджаар 10 орчим хувь, үлдсэн 90 орчим хувь төсвийн “дотаци” буюу төвөөс шилжүүлгээр бүрдүүлж байгаа одоогийн практикийг аль болох өөрчилж олон нутгийн санхүү, төсвийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн болон зохион байгуулалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

**Зургадугаарт,** Төсвийн шинэчлэлийн талаархи шинэ мэдлэг, ажлын ур чадвар, мэдээ, мэдээлэл дутмагаас YAXT боловсруулах, орлого бүрдүүлэх, төсөв зохиох, хянах, батлах ажлуудыг зөвхөн удирдлагын үүрэг мэтээр ойлгож, асуудлыг төвлөрүүлэн шийдвэрлэх сэтгэлгээ ноёрхон иргэдийн оролцоо дутагдаж, ялангуяа төсвийн зарцуулалтын тайлан мэдээтэй иргэд танилцах ажил бараг хийгдэхгүй байна. Энэ нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд бэрхшээл учруулж байгаа төдийгүй төсвийн ил тод нээлттэй байдал, тайлагналт байдалд муугаар нөлөөлж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчид, сайд, Засаг дарга нар, төсөвт байгууллагын ерөнхий болон хэсгийн менежерүүд төсвийн талаар ил тод тайлагнах, олон нийтдээ мэдээлэл хийх тогтсон журам, механизмыг бий болгохыг олон нийт дэмжих байна.

**Долдугаарт,** ТБУСТХ-ийг хэтэрхий хэлбэрдсэн байдлаар, механикаар хэрэгжүүлж байна. Хуулийн үг үсэг бүрийг явцуу ойлгож, нэг бүрчилэн дагаж мөрдөхийг оролдож, хуулийн суурь үзэл санаа, гол зарчмыг орхигдуулах тал хуулийн хэрэгжилтийн явцаар нэлээд ажиглагдаж байна. Хэрэгжилтийг ийм хялбарчилсан, хэлбэрдсэн байдлаар зохион байгуулж байгаа нь хуулийг хэт нүсэр, цаг цаас их зарцуулсан хууль гэсэн сэтгэлгээг бий болгох байна. Улсын үйлдвэрийн газрууд төрийн өмчид хэвээр байгаа нөхцөлд Засгийн газар хариуцлага хүлээх ёсгүй гэсэн буруу ойлголт байгаа нь хуулийн хэрэгжилтийг механик явцуу утгаар тайлбарлаж буй хэрэг юм<sup>9</sup>. Тэгэхээр хуулийг өөрчлөх, боловсронгуй болгох тухай ярихын зэрэгцээ энэ хуулийн үзэл санаа зарчмыг сайн хэрэгжүүлж, боломжээрэг сөрөг талыг нь сайтар судлан тодруулах ёстой гэсэн саналыг ч бас анхаарахгүй байж болохгүй.

**Наймдугаарт,** ТБУСТХ-д төсвийн төслийг боловсруулахдаа Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрхэн тусгах, хоорондын уялдааг хангах талаар тодорхой заалт тусгагдаагүй, хуулинд байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь байгууллагын төсөв боловсруулах үндэслэл болохоор заасан нь Үндсэн чиглэлийн ач холбогдлыг бууруулж байна. HTTX болон Үндсэн чиглэлийн улдаа холбоог хангах арга зам, энэ хүрээнд учирч буй зарим бэрхшээл, сорилтуудын талаар тухайлсан судалгаа хийж бодлого, практикийн хувьд чухал үнэ цэнтэй санал дэвшүүлснийг ТБУСТХ-ийг боловсронгуй болгоходо шийдвэр гаргах төвшинд анхаарах учиртай.

### 1.3 Монгол Улсын төсвийн тухай хууль /2012 оноос хойш/

Монгол Улсад сүүлийн жилүүдэд төсөв мөнгө их хэмжээгээр нэмэгдэж, төсвийн нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ өндөр түвшинд байгаа. Татварын бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор нийтлэг татварын хувь хэмжээ буурсан ч гол нэр төрлийн экспортын барааны үнийн өсөлтөөс үүдэлтэй гэнэтийн их орлого төсвийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн билээ. Харин энэ богино хугацааны таатай байдал нь төсвийн бодлого оновчгүй, төсвийн зарцуулалтыг улс төрийн болон бусад нөлөөллөөс тусгаарлаж чадаагүй байгааг харуулсан.

Орлого орох хэмжээгээр зарцуулалтыг нэмэх хандлага, түүний дотор улс төрийн амлалт

<sup>9</sup> ТБУСТХ-ийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ. Улаанбаатар хот. 7,8 дахь тал

дээр үндэслэсэн нийгмийн халамжийн зардал, мөн үр ашиг, төлөвлөлт муутай хөрөнгө оруулалтын зардлыг их хэмжээгээр нэмдэг нь орлого буурах үед төсөвт их дарамт үзүүлж, амлалт биелүүлэх, нэгэнт эхлүүсэн төслүүдийг дуусгахад хүндрэл учраад зогсохгүй нийтэд зайлшгүй хэрэгцээтэй төрийн үйлчилгээг хангахад хөрөнгө мөнгө дутагдаад хүргэдэг. Төсвийн эрх мэдэл яамдад их төвлөрч, орон нутгийн эрх мэдэл хязгаарлагдмал байгаа нь төрийн үйлчилгээний чанарт сергөөр нөлөөлж байгааг судлаачид тэмдэглэж байгаа. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн эрх мэдэл бага тул төсвийн зарцуулалтад хяналт тавих хөшүүрэг үүсэхгүй байгаа нь хяналт тавих хамгийн боломжтой бүтэц энэ чиглэлд анхаарлаа хандуулахгүйд хүргэж байна.

Төсвийн харилцааны шинэтгэлийн хүрээнд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэсэн хоёр хуулийг УИХ-аас батлан гаргасан. Төрийн үйлчилгээний чанар, эдийн засгийн ёсөлт, хүн амын амьжиргаа төсвийн бодлогоос шууд хамаарах тул төсвийн суурь хууль тогтоомжийгамьдралд бодитой хэрэгжижүйц, гэхдээ татвар төлөгчдийн мөнгийг хамгийн оновчтой, үр дүнтэй, үр ашигтай зарцуулах тийм бүтэц, механизмыг бүрдүүлсэн байдлаар гаргах шаардлагатай. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь төсвийн төвлөрлийн талаархи асуудлыг авч үзээгүй, харин төсвийн орлогын хуримтлалыг бий болгоход чиглэсэн үзэл баримтлалтай тул судалгаанд уг хуулийг авч үзээгүй болно. Төсвийн тухай хууль нь төсвийн харилцааг зохицуулах суурь хууль байх учиртай ба бусад холбогдох хууль тогтоомж, тухайлбал татварын багц хууль нь энэхүү хуулийн үзэл санаа, зарчимд нийцсэн байх нь учиртай.

Төсвийн хэт төвлөрлийг сааруулж, зохих хариуцлагыг ч төв болон орон нутагт зохистой хуваарилах шаардлагатай. Хуулинд орон нутгийн төсвийн харилцааны асуудлыг тусгайлан оруулж өгсөн нь сайшаалтай ч асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, орон нутагт татварын хувь хэмжээ тогтоох, хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх зэрэг эрх мэдлийг тодорхойлоогүй байна. Мөн хуульд заасан шилжүүлэг олгох нөхцлүүд нь урьдчилан тодорхойлоход төвөгтэй тул орлогын тогтвортой эх үүсвэр болж чадахгүй байх магадлалтай. Түүнчлэн зарим нэгэнт төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийг гэрээний үндсэн дээр аймаг, нийслэлд шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн байгаа ч боловсрол, эрүүл мэндийн салбарын зарим нэгэн санхүүжилт, тухайлбал, хөрөнгө оруулалтын зардлыг ч аймаг, нийслэлд шилжүүлэх боломжтой юм.

Төсөв, санхүүгийн төвлөрлийн өнөөгийн тогтолцоо нь улсын төсвөөс аль болох их хөрөнгө хуваарилуулан авах орон нутгийн сонирхлыг өөгшүүлж, зардлаа хэмнэх санаачилгыг төрүүлэхгүй, хэмнэсэн хөрөнгөө өөрийн эрх мэдлийн хүрээнд захиран зарцуулах боломжийг тэр бүр олгохгүй байгаад асуудлын гол нь оршиж байна. Зардлаа хэмнэсэн бол урамшуулах журам байгаа ч элдэв шалтгаанаар хасах, шийдэхгүй уддагаас үр нөлөөтэй механизм болж чадахгүй байна.

Төвлөрлөөс олон сөрөг үр дагавар гарч буй хэдий ч төсвийн төвлөрлийг сааруулах асуудлыг оновчтой шийдвэрлэх нь нэлээд түвэгтэй юм. Манай орны хувьд хэд хэдэн онцлог байгаа нь судалгаагаар<sup>10</sup> нотлогдсоор байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, төсвийн орлогын бааз нь хүн ам төвлөрсөн, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ хөгжсөн цөөн тооны аймагт төвлөрсөн байдаг. Эдгээрт Улаанбаатар, Орхон, Дархан хот болон зарим ашигт малтмалын нөөц бухий аймгууд багтаж байна. Монгол Улсад нийслэл хотоос гадна 5 аймаг өөрийн орлогоороо зарлагаа санхүүжүүлдэг ба бусад аймаг улсын төсвөөс шилжүүлэг авдаг байна. Эдгээр аймгийн хувьд нийт зарлагынхаа 4-60 хувь орчмыг улсын төсвийн шилжүүлгээр санхүүжүүлж байна. Энэ үзүүлэлт баруун таван

<sup>10</sup> Л.Лувсанжамц, Б.Мөнхсоёл. Төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын шинэтгэл. Нээлттэй нийгэм форум.

аймагт хамгийн өндөр буюу 43 хувиас дээш байдаг. Энэ мэтээр Монголын дийлэнх аймаг, сумдын төсвийн өөрийн орлогын эх үүсвэр маш муу байна.

Орон нутгийн төсвийн орлогын дийлэнхийг (90 хувиас дээш) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар зэрэг хэдхэн нэр төрлийн татвараар бурдүүлж байна. Түүнчлэн хуулиар орон нутгийн татвар хэмээн 12 нэр төрлийн татварыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт оноосон хэдий ч эдгээр татварын хувь хэмжээг тогтоох, ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт хийх эрх мэдлийг нь тухайн орон нутгийн Хурал бус УИХ, Засгийн газар эдэлдэг байна. Бодит амьдрал дээр орон нутгийн татвар сонгодог утгаараа алга байна гэж хэлж болох юм. Ингэж орон нутгийн татварын эрх мэдлийг хумьсан нь байгалийн нөөц, баялгаа зохистой ашиглах, онцлог байдал, давуу талдаа сууриссан төсөв, татварын бодлого баримтлах, орлогын тогтвортой эх үүсвэртэй болж, түүнийг хураах, ашиглах чадавхи, тогтолцоо бий болоход сөрөг нөлөө үзүүлж байна.

**Хоёрдугаарт,** Ихэнх аймаг, ялангуяа сумдад дэд бүтэц муу хөгжсэн, үйлдвэрлэл, худалдаа хөгжих боломж муу, хүн ам маш цөн, тархай, бутархай суурьшсан, газар нутаг томтой зэрэг заяамал нөхцөл байдал нь цаашид ч орлогын тогтвортой эх үүсвэр бий болоход саад учруулах юм.

**Гуравдугаарт,** Монгол Улс нь нэгдмэл засагтай улсын хувьд төрийн үйлчилгээний стандартыг орон даяар жигд мөрдүүлэхийг зорьдог. Энэ үүднээс аймгуудын нэг хүнд ногдох төсвийн зарлагын хэт ялгааг үүсгэхгүй байх төсвийн тэнцвэрийг хангах бодлогыг цаашид барих хэрэгтэй. Иймээс аймаг хоорондын орлогын ялгааг бий болгоход хүчтэй нөлөөлдөг ашигт малтмалын нөөцийн төлбөр, хүн амын орлогын татварыг дахин хуваарилах шаардлага зайлшгүй гарч байна.

**Дөрөвдүгээрт,** аймаг, сумдын хувьд жил бүр төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийн хэмжээгээ урьдчилан тооцох, тодорхойлох боломжгүй байна. Учир нь өнөөгийн дэмжлэгийн систем нь тухайн засаг захиргааны нэгжийн төсвийн өөрийн орлогын чадавхи, зарлагад нөлөөлөх хүн амын тоо, төрийн үйлчилгээний хэрэглэгчдийн тоо, газар нутгийн алслалт, засаг захиргааны нэгжийн тоо зэрэг объектив үзүүлэлтэд суурилан олгогдоггүй зөвхөн зөрүүг санхүүжүүлэх зарчмаар жил бүр хэлэлцээр хийх байдлаар явагддаг. Дэмжлэгийг зөвхөн орон нутгийн төсвийн урсгал зарлага, орлогын зөрүүг нөхөх байдлаар, тодорхой зарчим, түүнийг хадгалсан томъёонд суурилж олгодоггүй байна.

**Тавдугаарт,** өнөөгийн орон нутгийн төсөв нь зөвхөн аймаг, сумдын захиргааны урсгал зардал буюу захиргааны албан хаагчдын цалинд дийлэнх хэсэг нь зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь Засаг даргын тамгын газрын байрны ашиглалтын зардал (дулаан, цахилгаан гм) төдийд дөнгөж хүрэлцэхүйц байна. Аймаг сумд хуулиар хариуцсан чиг үүргээ хангалттай биелүүлэх хөрөнгө оруулалтын болоод урсгал зардал маш хомс байна. Ялангуяа орон нутгийнхаа хөгжилд зориулан хэнээс ч хамааралгүй бие даан захирсан, зарцуулах хөрөнгийн эх үүсвэр огт алга. Ихэнх улс орнуудад орон нутгийн төсөв нь улсын төсвөөс тусдаа орлого, зарлагатай байж тусгай хууль, эрх зүйгээр баталгаажсан байдаг бол манайд улсын төсвийн салшгүй нэг бүрдэл хэсэг мэтээр ташаа ойлгож иржээ.



**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХАДГАЛАМЖ, БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ  
ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ АСУУДАЛ**

*Ц. Нороөвдөнбог (Ph.D), Г. Гэрэл, Ц. Болормаа, Б. Тамир*

## ОРШИЛ

### I бүлэг.

- Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын олон улсын стандарт, бусад орнуудын туршлага /Харьцуулсан судалгаа/

- 1.1 Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага/ IOSCO/-аас үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцоо, бүртгэлийн байгууллагуудад зориулан гаргасан G30-ын зөвлөмж, хэрэгжүүлэх боломж
- 1.2 Үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцооны үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын талаархи бусад орнуудын туршлага
  - 1.2.1 Англо-саксоны загвараар /АНУ/
  - 1.2.2 Баруун Европын туршлага /ХБНГУ, Англи/
  - 1.2.3 Хуучин социалист орон /ОХУ, Казахстан/
  - 1.2.4 Азийн орнууд / Япон, Солонгос/

### II бүлэг.

- Монгол улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцоо, бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт болон тулгамдсан асуудлууд /Нөхцөл байдлын шинжилгээ/

- 1.1 Монгол улсын үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчны өнөөгийн байдал
- 1.2 Монгол улсын хөрөнгийн зах зээл дэх төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт
- 1.3 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллага / УЦТТТХТ/ - ын үйл ажиллагааны өнөөгийн байдал
  - 1.3.1 Төлбөрийн үүргийг тодорхойлох чиглэлээр
  - 1.3.2 Төвлөрсөн хадгаламжийн чиглэлээр
  - 1.3.3 Төлбөр тооцооны чиглэлээр
  - 1.3.4 Харилцагчдын үйлчилгээний чиглэлээр
  - 1.3.5 Үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагааны чиглэлээр
  - 1.3.6 Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн урсгалыг сайжруулах чиглэлээр
  - 1.3.7 Эрсдэлийг бууруулах чиглэлээр
- 1.4 Монгол улсын үнэт цаасны зах зээл дэх төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаан дахь тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам

### III бүлэг.

- Монгол улсын үнэт цаасны зах зээлийн хөгжилд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, дэд бүтцийн тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгүй болгох талаархи судалгааны дүгнэлт, санал зөвлөмж

- Монгол улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн систем дэх үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, тогтолцоог боловсронгуй болгох
- Монгол улсын хөрөнгийн зах зээл дэх мэдээ, мэдээллийн аюулгүй байдал, учирч болох эрсдлээс хамгаалах
- Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллагын статус, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал

#### 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

\*\*\*

#### ОРШИЛ

Чөлөөт эдийн засгийн харилцааны үед өмчийн олон хэлбэр оршин тогтоно ба төр нь түүнд нийцсэн эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй. Өмч хөрөнгө шударгаар олж авах, өмчийн аливаа хэлбэрийг хуулиар хамгаалах буюу иргэдийн эдийн засгийн эрхийг баталгаатай эдлүүлэх асуудал үүнтэй салшгүй холбоотой. Өмч хөрөнгө шударгаар олж авах олон хэлбэр байдгийн нэг нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцох замаар өмчтэй болох асуудал юм. Үнэт цаасны зах зээл нь улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын хувьд томоохон байр суурь эзлдэг тул түүнийг хөгжүүлэхэд улс орнуудын бодлого тодорхой түвшинд чиглэгдэж байна. Манай орны хувьд ч үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар Засгийн газар тодорхой арга хэмжээ авч байна.

Байгалийн баялагийг иргэдэд шударгаар хуваарилахад үнэт цаасны зах зээлийн тогтолцоог ашиглах нь тохиромжтой хэмээн үзэж МУ-ын Засгийн газар 2011 оны 98 дугаар тогтоолоороо Монгол Улсын иргэн бүрт “Эрдэнэс Тавантолгой” компанийн 536 ширхэг хувьцааг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Түүнчлэн улс орны хөгжилд уул уурхайн салбарын эзлэх байр суурь өргөжиж орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах санхүүгийн эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлийт ашиглан олох хандлага ч нэмэгдэж байна. Эдгээр байдал нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн өнөөгийн байдлыг цогц байдлаар судлан үзэх, боловсронгуй болгох шаардлагатай болсныг харуулж байгаа ба үнэт цаасны зах зээл гарч буй хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэж буй байдал зэрэг нь уг харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг судлан үзэх зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм.

Хэдийгээр үнэт цаасны зах зээлийн харилцаанд мэргэжлийн олон байгууллага оролцдог боловч эдгээрийн дотроос үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн байгууллагыг онцлон авч үзэж эрх зүйн аспект талаас нь судалсан болно. Учир нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд нэг талаас хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчийн өмчлөх эрх түйлын байдлаараа хангагдаж, хамгаалагдсан байх ёстой. Нөгөө талаас хөрөнгө оруулагч нь мэн чанартай өмч хөрөнгө шударгаар олж авах зорилгын үүднээс үнэт цаасны харилцаанд оролцдог тул түүний өмчлөх эрхийн эдийн засаг, хууль зүйн баталгааны найдвартай байдлаас үнэт цаасны зах зээлийн хөгжил шууд хамааралтай юм. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн байгууллага нь энэхүү эдийн засгийн эрхийн баталгааг хангаж байдаг онцлогийг харгалzan үзэж энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгаа ажлыг гүйцэтгэхэд хамтран оролцож үнэтэй санал зөвлөмж өгсөн багийн зөвлөх, эдийн засгийн ухааны доктор (Ph.D) Ц. Норовдондог болон “ҮЦТТТХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т. Гандулат нарт гүн талархал илэрхийлье.

\*\*\*

**I БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ, БҮРТГЭЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, БУСАД  
ОРНУУДЫН ТУРШЛАГА**

Орчин үед үнэт цаасны зах зээл нь улам бүр глобалчлагдах чиг хандлагатай болж байгаа тул олон улсын хэмжээнд мөрдж буй стандарт, нийтлэг хэм хэмжээг судлан үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчны суурь концепц болгон ашиглах нь Монгол улсын үнэт цаасны зах зээлийг дэлхийн санхүүгийн зах зээлд гарцтай болгох томоохон боломж юм.

Эдийн засгийн боломж, цар хүрээнээс үл хамааран үр ашигтай, эрсдэл багатай, “цэвэр тунгалаг” зах зээлийн системийг бүрдүүлэх нь гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн шинэ хэрэгсэлүүдийг ашиглах таатай нөхцөлийг бий болгож байна. Ялангуяа GDR ( Global depositary receipt), ADR (American depositary receipt) зэрэг санхүүгийн хэрэгсэлүүдийг cross-listing хийж хилийн чанадад арилжаалах болсон нь мэдээллийн технологийн өндөр түвшинд орон зай харгалзахгүйгээр арилжаа явуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх, мэдээлэл солилцох боломжтой болгож байна.

Олон Улсын Үнэт Цаасны Хороодын байгууллага /IOSCO/ -аас гаргасан үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын зарчим нь үнэт цаасны зах зээл өндөр хөгжсөн 30 орны санаачлагаар гаргасан зөвлөмж бөгөөд дэлхий нийтээр санхүүгийн зах зээлийг нэг стандартад нийцүүлэх, нэгдсэн байдлаар санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилготой юм. Ихэнх улс орнууд эдгээр зарчмыг удирдлага болгон хууль эрх зүйн орчноо бүрдүүлэхийг зорьж байгаа нь зах зээлийг илүү ойлгомжтой, нээлттэй, ил тод болгож системийн эрсдэлийг бууруулах үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдгээр зарчмууд хэрэгжсэнээр үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа илүү тодорхой болж санхүүгийн хэрэгслийн арилжааны таатай орчин бүрдэж, санхүүгийн гүйлгээ болон үнэт цаас гаргах үйл ажиллагааг шударгаар явуулах, үнэт цаасны эргэлтийн орчныг хөнгөвчлөх, санхүүгийн хэрэгсэлд шударга үнэ тогтоох, хөрөнгийн зах зээлийг тухайн улс орон төдийгүй дэлхий нийтээр бүрэн ашиглах замаар үндэсний эдийн засгaa хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нөхцөл бүрдэх юм.

Энэхүү судалгаа нь үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн систем дэх үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцоо, хадгаламж, харилцагчдын үйлчилгээтэй холбоотой асуудлыг эрх зүйн болон үйл ажиллагааны талаас нь харьцуулан судлахад чиглэгдсэн ба Монгол улсын үнэт цаасны зах зээлийн систем дэх үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцоо, хадгаламж, харилцагчдын үйлчилгээний өнөөгийн байдалд эрх зүйн дүн шинжилгээ хийж цаашид боловсронгуй болгох хувилбарыг тодорхойлох зорилтыг дэвшүүлсэнээрээ онцлогтой юм.

Дэлхийн худалдааны байгууллага/ДХБ/ -ийн гишүүн орнууд нь дотоодын хууль тогтоомж, хэм хэмжээг тогтоохдоо нэгдэн орсон ДХБ -ийн хэлэлцээрүүдийн дагуу хүзээсэн үүрэгтээ нийцүүлэх арга хэмжээ авах ёстой. Эдгээр багц хэлэлцээрийн нэг болох General Agreement on trade in services( GATS) -ийн Хавсралт 1-д заасан санхүүгийн зах зээл дэх ажиллагаа болон тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааны төрөлд биржийн болон биржийн гадуурхи зах зээлийн үйл ажиллагаа, брокер дилерийн үйл ажиллагаа, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа, хамтын хөрөнгө оруулалтын бүх төрлийн үйл ажиллагаа, үнэт цаас хадгалагчийн үйл ажиллагаа, төлбөр тооцооны үйл ажиллагаа, клирингийн үйл ажиллагаа зэргийг нарийвчлан зааж өгсөн байна.

Мөн Ерөнхий хэлэлцээрийн 5-р зүйлд аливаа гишүүн улс бүр боложмтой бүх тохиолдолд үйлчилгээ үзүүлэх ажиллагааны дотоодын зохицуулалтдаа олон улсын стандарт, шалгуурыг харгалзах ёстай хэмээн заасан байна. Монгол улс 1997 онд ДХБ -д элсэн орсоноос

**1.1 Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага/ IOSCO/-аас үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцоо, бүртгэлийн байгууллагуудад зориулан гаргасан G30-ын зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх боломж**

Олон улсын хэмжээнд Үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээнд дагаж мөрддөг Үнэт Цаасны Хорооны Олон Улсын Байгууллага /IOSCO/-аас 1998 онд гаргаж 2003 онд шинэчлэн баталсан “**Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим**” / Objectives and Principles of Securities Regulation/, мөн 2001 онд баталсан “**Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж**” хэмээх баримт бичгүүд байдаг.

“**Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим**” хэмээх баримт бичигт Үнэт цаасны зохицуулалтын дараахь үндсэн З зорилтыг нийтээр дагаж мөрдөхөөр тодорхойлсон. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдыг хамгаалах
- Зах зээлийн үнэнч шударга, үр ашигтай, ил тод механизмыг бүрдүүлэх
- Системийн эрсдлийг багасгах

Энэхүү З зорилтын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын 8 төрлийн 30 зарчмыг баталгаажуулж Олон Улсын Үнэт Цаасны Хорооны Байгууллага /IOSCO/-ын гишүүн орнууд холбогдох хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд:

- ✓ Зохицуулагчтай холбоотой зарчмууд
- ✓ Өөрийгөө зохицуулах байгууллагын зарчмууд
- ✓ Үнэт цаасны зохицуулалтын албадан хэрэгжүүлэх зарчмууд
- ✓ охицуулалтын хамтын ажиллагааны зарчмууд
- ✓ Үнэт цаас гаргагчдын дагаж мөрдөх зарчмууд
- ✓ Хамтын хөрөнгө оруулалтын зарчмууд
- ✓ Зах зээлд зуучлагчдын зарчмууд
- ✓ Хоёрдогч зах зээлийн зарчмууд

IOSCO –гийн “Хоёрдогч зах зээлийн зарчмууд” –ын 30-р зарчимд “**Үнэт цаасны хэлцлийн клиринг, төлбөр тооцооны систем нь зохицуулах байгууллагын хяналтанд байх ба үнэнч шударга, үр ашигтай, системийн эрсдэлийг аль болохоор бууруулсан байхаар зохион байгууллагдах шаардлагатай.”**

Зохицуулах байгууллага нь үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системд дараахь чиглэлээр хяналт тавих үүрэгтэй. Үүнд:

- Клиринг- төлбөр тооцооны системийн үйл ажиллагааны зохион байгуулалт, дүрэм журам нь зах зээлд оролцогчдод нээлттэй байх
- Клиринг, төлбөр тооцооны систем болон түүнд оролцогчдын үйл ажиллагааг Зохицуулах байгууллагын зүгээс шууд хяналт тавих боломж бүрдсэн байх
- Зохицуулах байгууллага нь клиринг, төлбөр тооцооны байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх заавар журмыг батлан гаргах ба мониторинг хийх, шаардлагатай бол үйл ажиллагааг нь шалгах, зөрчлийг арилгуулах, хариуцлага хүлээлгэх эрхтэй байх. Холбогдох байгууллагуудаас тайлан, мэдээлэл гаргувал авах систем бүрдсэн байх.
- Зохицуулах байгууллага нь КТТБ-ын үйл ажиллагаанд байнгын хяналт шалгалт хийх, тайлан мэдээг тогтмол гаргувал авч байх, хөндлөнгийн хяналтын байгууллагаар шалгуулах эрхтэй байх
- КТТБ нь арилжааны болон төлбөр тооцооны мэдээлэлийг шалгаж нягтлах,

эцэслэн тооцоолох, хугацаанд нь төлбөр хийх, зах зээлд оролцогчдын хооронд шууд төлбөр хийх, зах зээлийн болон зээлийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн хөрвөх чадвар болон үйл ажиллагааны эрсдэлийг удирдах олон улсын стандартад нийцсэн байхаар зохион байгуулагдах

- Эрсдэлийг явцын дунд/ on-going/ олж илрүүлэх, удирдах процедурыг бий болгох
- Үүсмэл үнэт цаасны төлбөр тооцооны систем нь хөрвөх чадварын эрсдэлийг бууруулсан байх.
- Маржийн болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьдаг байх
- Хэлцлийн суурь активийг нийлүүлэхгүй байх эрсдэлээс сэргийлэх, ялангуяа үнэт цаас зээлэх, богино хугацаат арилжааны үед
- Эрх зүйн орчинг талуудын эрх ашгийг тэнцүү хангасан, өөрийгөө хянах боломж олгосон, неттинг болон бусад үйл ажиллагааг хуульчилсан, төлбөр тооцоо бүрэн хийгдсэн, төлбөрийг үндэслэн харилцан шилжүүлэг хийгдсэн, эрсдэл болон хөрвөх чадварыг удирдах олон улсын стандартад нийцсэн байхаар бүрдүүлэх

2001 онд IOSCO-гийн Техникийн Хороо болон Төлбөр тооцооны Хороо хуралдаж энэхүү зарчмыг хэрэгжүүлэх “Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж” хэмээх баримт бичгийг батлан гаргасан. Энэхүү аргачлалд Үнэт цаасны төлбөр тооцооны процесс болон төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах аргачлал, нийтлэг стандартыг тусгасан байна.

**Үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны процесс нь** зах зээлд оролцогч 2 талын хэлцлийн нөхцлийг баталгаажуулах - 2 талын хүлээх үүргийг / мөнгөн хөрөнгө болон үнэт цаас/ тооцоолж гаргах - талууд хооронд үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх гэсэн дарааллаар хийгдэнэ. Үүнд:

1. **Баталгаажуулалт /confirmation/** буюу зах зээлд оролцогчдын хооронд хийгдсэн хэлцлийн арилжааны нөхцөлийг баталгаажуулах
2. **Клиринг / calculation** буюу clearance/- баталгаажуулсан нөхцөлийн дагуу талуудын хүлээх үүргийг тооцоолж гаргах
3. **Төлбөр тооцоо / settle/** буюу арилжаанд оролцогч талуудын хооронд мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг шилжүүлэх

Үнэт цаасны клиринг төлбөр тооцооны стандарт, эрсдэлийг бууруулах зөвлөмжүүд:

1. **Хуулийн эрсдэл /legal risk/** - Үнэт цаасны төлбөр тооцооны систем нь зөв зохион байгуулалттай, ойлгомжтой, ил тод эрх зүйн орчинд ажиллах ёстой.
2. **Төлбөр тооцооны өмнөх эрсдэл /Pre-settlement risk/**

Trade confirmation- Зах зээлд шууд оролцогчдын хооронд хийгдсэн хэлцлийг арилжаа дуусангуут аль болох хурдан баталгаажуулах (T+0). Шууд бус оролцогчид буюу институциональ оролцогчдын хэлцлийг мөн аль болох арилжаа дууссаны дараа шууд баталгаажуулах, болж өгвөл (T + 0) хугацаанд (T + 1) -ээс доошгүй өдрийн дотор байж болно.

Төлбөр тооцооны цикл - Төлбөр тооцооны эргэлтийн хугацааг үнэт цаасны зах зээлд бүхэлд нь тогтоох ба төлбөр бүрэн хийгдэх эцсийн хугацаа нь T+3-аас илүү байж болохгүй. Үүнээс бага хугацаанд төлбөрийн ашиг болон зардал боломжийн түвшинд байна.

Арилжаанд оролцогч талууд / Central counterparties CCPs/ - Хэлцэлд оролцогч 2 талын олох ашиг, төлөх төлбөр нь харьцангуй тэнцвэртэй байх. Эрсдэл гарахаас сэргийлж талууд бие биендээ хяналт тавих механизмыг бүрдүүлэх

Үнэт цаас зээлдүүлэх – Үнэт цаасыг зээлэх болон зээлдүүлэх ажиллагааг үнэт цаасны хэлцлийн төлбөрийг хурдавчлах хэрэгсэл болгон ашиглахыг дэмжих. Үнэт цаас зээлдүүлэх ажиллагааг хориглосон аливаа барьер, хоригийг практикт арилгах

### **3. Төлбөрийн эрсдэл / Settlement risk/**

4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж (CSDs) - Үнэт цаасыг аль болох боломжтой хэмжээгээр татан төвлөрүүлэх, биет бус хэлбэртэй болгох, шилжүүлэх ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд book-entry хэлбэрээр гүйцэтгэх

Үнэт цаасны нийлүүлэлтийн төлбөр / Delivery versus payment DVP)- CSDs нь үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн эрсдэлийг Төлбөр хүргэлтийн систем DVP-гийн холболтыг ашиглан аль болох бууруулах

Төлбөр тооцоог эцэслэн гүйцэтгэх хугацаа –Төлбөр тооцооны эцсийн өдөр нь төлбөр тооцоог гүйцэтгэхээр товлосон хугацаанаас хэтэрч болохгүй. Өдрийн туршид бодит цагийн горимд (real time)-төлбөр тооцоо байнга хийгдэж байх нь эрсдэлийг бууруулна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн эрсдэлийн хяналт нь оролцгчдын төлбөр гүйцэтгэх чадварыг хянахад чиглэгдсэн байх ёстой- УЦТХ нь аль болохоор арилжаанд оролцогчдод өдрийн зээл олгоход чиглэгдэх, ялангуяа төлбөр тооцооны нэттинг системийн үед. Институциональ эрсдэлийг аль болох бууруулах үүний тулд хугацаатай төлбөрт сайтар хяналт тавих, ялангуяа томоохон хэмжээний төлбөрийн үүрэг хүлээсэн оролцогчын төлбөрийн чадварыг анхаарах. Хамгийн тохиромжтой арга нь нэмэлт шаардлага буюу барьцаа шаардах, лимит тогтоох зэрэг аргууд байж болно.

Мөнгөн хөрөнгийн төлбөр (Cash settlement assets)- үнэт цаасны хэлцлийн төлбөрт зориулагдан шилжүүлэх мөнгө нь хөрвөх чадварын, зээлийн болон бусад ямар нэгэн эрсдэлээс ангид байх ёстой. Хэрвээ Төв банкаар дамжуулан төлбөр тооцоо хийгдэхгүй тохиолдолд төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь нь харилцагчдын мөнгийг банк санхүүгийн байгууллага дампуурах зэрэг томоохон хэмжээний эрсдэлээс хамгаалсан байх шаардлагатай.

### **5. Үйл ажиллагааны эрсдэл (Operational risk)**

Үйл ажиллагааны найдвартай байдал (Operational reliability)

- Үнэт цаасны қдилинг, төлбөр тооцоотой холбогдон гарч буй эрсдэлийн шалтгааныг цаг тухай бүрт нь илрүүлэх аль болох оновчтой системийг бий болгох, хяналтын болон үйл ажиллагааны процедурыг сайжруулах замаар эрсдэлээс хамгаалах. Систем нь өөрөө найдвартай, аюулгүй, бодит нөөц, хүчин чадалдаа тохирсон байх ёстой. Урьдчилан төлөвлөлт болон дагалдах үйл ажиллагаа нь төлбөр тооцооны процессийг үе шаттайгаар сайжруулахад чиглэгдэх ёстой.

### **6. Кастодиан эрсдэл**

Харилцагчдын үнэт цаасыг эрсдэлээс хамгаалах - харилцагчдын үнэт цаасыг хадгалж буй этгээд нь нягтлан бодох бүртгэлийн болон үнэт цаасыг бүрэн бүтэн найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн, мэргэшсэн боловсон хүчинээр хангагдсан байх ёстой. Харилцагчдын үнэт цаас нь кастодианы хөрөнгө оруулагчдын үнэт цааснаас тусгаарлагдсан, хамгаалагдсан байх шаардлагатай

## 7. Бусад асуудал

Засаглал - Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж(CSD) болон зах зээлд оролцогч талууд (ССР)-ын засаглал нь олон нийтийн эрх ашиг, эздиийн эрх ашиг, үйлчлүүлэгчдийн эрх ашигт аль алинд нь нийцсэн байх шаардлагатай.

Хандалт (access) - ҮЦТХ (CSD) болон зах зээлд оролцогч талууд (ССР) нь бодитой, олон нийтэд нээлттэй мэдээллийн критери гаргах, үнэнч шударга, аль болох нээлттэй хандалтын системийг бий болгох

Үр ашиг ( efficiency)- Найдвартай, аюулгүй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ харилцагчдын шаардлагад нийцсэн ажил үйлчилгээг өртөг зардлаа нөхсөн, ашигтай хэлбэрээр явуулах

Олон улсын сүлжээ болон стандарт ( communication procedures and standards) – төлбөр тооцооны систем нь олон улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн тохирсон систем болон стандартын дагуу хил дамнасан арилжааны төлбөрийг гүйцэтгэхээр үр ашигтай зохион байгуулагдсан байх

Ил тод байдал / transparency / - төлбөр тооцооны болон зах зээлд оролцогчдын үйлчилгээг авч буй харилцагчдыг эрсдэлээ тооцох, өртөг зардал болон үр ашгаа тооцож шийдвэр гаргахад нь шаардагдах үйлчилгээ болон холбогдох мэдээллээр хангах

Зохицуулалт болон хяналт / regulation and oversight / - Үнэт цаасны төлбөр тооцооны систем нь ил тод, үр ашигтай зохицуулалт, хяналтын дор байна. Төв банк болон үнэт цаасны зах зээлийг зохицуулах байгууллага нь өөр хоорондоо болон холбогдох бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

Олон улсын зах зээлд холбогдох үеийн эрсдэлийг бууруулах - Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж(CSD) нь үнэт цаасны олон улсын арилжааны системд холбогдох, үүнээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах, олон улсын хэмжээнд төлбөр тооцоо гүйцэтгэх техникийн нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

## I БУЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ, БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

### 1.1 Англо-саксоны загвараар / АНУ/

#### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

а/ АНУ-ын зах зээл дэх үнэт цаасны клиринг, төлбөр тооцоо, хадгаламжийн үйлчилгээ

АНУ-ын үнэт цаасны зах зээлийн гол хэрэгслүүд нь Засгийн газрын үнэт цаас, корпорацийн үнэт цаас ба тогтмол орлогын зах зээл /fixed income market/ юм. АНУ-д анхдагч болон үүсмэл үнэт цаасны арилжааны хэд хэдэн томоохон биржүүд бий. Тухайлбал, New York-ын хөрөнгийн бирж /New York Stock Exchange/, the National Association of Securities Dealers Automated Quotations (NASDAQ) ба АНУ-ын хөрөнгийн бирж /the American Stock Exchange/- үүдэд анхдагч үнэт цаасны арилжаанууд хийгддэг бол бонд, дериватив, коммодити, фьючерс гэх мэтийн тогтмол орлоготой болон үүсмэл үнэт цаасны хэрэгсэлүүдийг New York Stock Exchange, NASDAQ, New York Mercantile Exchange (NYMEX), Chicago Mercantile Exchange (CME), Intercontinental Exchange, Chicago Board of Trade (CBOT) гэх мэт биржүүд голлон арилжаалдаг байна.

Клиринг ба төлбөр тооцооны механизм нь санхүүгийн хэрэгслүүдийнхээ төрлөөс хамааран янз бүр байх ба ихэвчлэн тусгайлсан санхүүгийн зуучлагчдаар дамжуулан хийгддэг (specialised financial intermediaries, clearing корпораци болон depositary гэх мэт). АНУ-ын үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйлчилгээний үндсэн байгууллагууд нь:

1. DTCC Depository Trust and Clearing Corporation
2. NSCC National Securities Clearing Corporation
3. GSCC Government Securities Clearing Corporation
4. MBSCC Mortgage-Backed Securities Clearing Corporation
5. DTC Depository Trust Company

**DTCC Depository Trust and Clearing Corporation:** DTCC 30 гаруй жилийн турш өөрийн сүлжээгээр дамжуулан автомат, төвлөрсөн, стандартчлагдсан хэлбэрээр хөрөнгийн зах зээлд нөлөө бүхий мэргшсэн үйлчилгээ үзүүлж байна. Тус компани нь өөрийн салбаруудаар дамжуулан клиринг, төлбөр тооцоо болон мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд хувьцаа, компанийн болон орон нутгийн, Засгийн газрын бонд, мөнгөний зах зээлийн хэрэгсэлүүд, дериватив арилжааны хэрэгсэлүүдийн клиринг- төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж байна. Мөн түүнчлэн хамтын сан, даатгал, холболтын сангудын хооронд шилжүүлэг хийдэг сүлжээний лидер компани юм. DTCC –ийн депозитари нь АНУ болон 121 өөр орон, газар нутагт ойролцоогоор 34 триллион долларын 3.6 сая үнэт цаасны гаргалтын кастодиан болон хөрөнгийн шилжүүлгийн үйлчилгээг үзүүлж байна.

DTCC –ийн Thomson Reuters, Omgeo-той хамтарсан joint venture компани нь дэлхий 45 оронд 6000 гаруй харилцагчидтай. Арилжааны дараах процесс, мэдээллийн менежмент, брокерууд, хөрөнгө оруулалтын менежерүүд, кастодиан банкуудад чухал үйлчилгээ үзүүлдэг.

DTCC-ийн Maerkit болон Markit SERV-тэй хамтарсан joint venture компани нь DTCC Deriv/SERV болон Market wire арилжааны хэлцлийг баталгаажуулах томоохон платформ бөгөөд зээл, хүү, хувьцаа, таваарын дериватив зэрэг олон төрлийн хөрөнгийн арилжааны хэлцлийг биелүүлэхэд үйлчилгээ үзүүлдэг байна.

DTCC 10 салбартай, салбар бүр нь өөр өөрийн гэсэн онцлог чиг үүрэг, хариуцсан сегмент болон эрсдэлийн профилтэй байдаг. Үүнд:

- [National Securities Clearing Corporation \(NSCC\)](#)
- [Depository Trust Company \(DTC\)](#)
- [Fixed Income Clearing Corporation \(FICC\)](#)
- [DTCC Deriv/SERV LLC / The Warehouse Trust Company LLC](#), DTCC Derivatives Repository Ltd.
- [DTCC Solutions LLC / DTCC Loan/SERV LLC/](#)
- [EuroCCP Ltd.](#)
- [Avox Ltd.](#)




Хадгаламж итгэмжлэл, клирингийн корпорац (DTCC)-ийн үйл ажиллагааны төрлүүд:

- Үйлчлүүлэгчийн дансны автоматчилагдсан шилжүүлгийн үйлчилгээ/ Automated Customer Account Transfer Service (ACATS)
- Цэвэр төлбөрийг тогтмол тодорхойлох /Continuous Net Settlement (CNS)
- Индекс хуваарилах үйл ажиллагаа / Index Share Processing
- Арилжааны харьцуулалт ба тайлагнал / Trade Comparison and Reporting
- Бодит цагийн горимд арилжааг хянах, удирдах/ Real - Time Trade Matching (for

fixed income securities)

- Үнэ тогтоо болон хэлцлийг дахин баталгаажуулах үйлчилгээ / Reconfirmation and Pricing Service
- Төлбөр тооцооны үйлчилгээ / Settlement Services
- Үнэт цаас зээлдүүлэх хөтөлбөр / Stock Borrow Program гэх мэт

Хадгаламж итгэлцэл, клирингийн корпораци (DTCC) болоод түүний охин компаниудыг схемээр үзүүлбэл:



**National Securities Clearing Corporation (NSCC):** DTCC-ын охин компани болох National Securities Clearing Corporation (NSCC) нь 1976 онд байгуулагдсан. Клиринг, төлбөр тооцоо, эрсдлийн удирдлага, хэлцэлд оролцогч талуудын үйлчилгээ /central counterparty services/, хэлцэлийн баталгаа гаргах чиглэлээр хувьцаа, корпораци ба орон нутгийн засаг захиргааны өрийн бичиг, америкийн хадгаламжийн гэрчилгээ, биржийн болон хөрөнгө оруулалтын сангүүдад үйлчилж байна.

NSCC –гийн сүлжээнд T+3 хугацаанд неттинг, клиринг, төлбөр тооцооны үйлчилгээ хийгдэх ба ойролцогоор нийт хийгдсэн хэлцлийн 98% орчим нь энэ хугацаанд бүрэн хийгдэж байна. Үйлчилгээний сервис төрлүүд нь:

- Automated Customer Account Transfer Service (ACATS)
- Continuous Net Settlement (CNS)
- Index Share Processing
- Trade Comparison and Reporting
- Real-Time Trade Matching (for fixed income securities)
- Reconfirmation and Pricing Service
- Settlement Services
- Stock Borrow Program

**Fixed Income Clearing Corporation (FICC):** 2003 онд байгуулагдсан, DTCC-ийн салбар бөгөөд Government Securities Clearing Corporation and the Mortgage - Backed Securities Clearing Corporation –тай хамтран тогтмол хүүтэй хэрэгсэлийн арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэж зардлыг багасгах үүрэгтэйгээр байгуулагдсан.

Дээрх 2 корпорацийн үйл ажиллагааны чиглэл нь: The Government Securities Division (GSD)- Засгийн газрын үнэт цаасны хэлтэс Үндэсний төлбөр тооцоо клирингийн корпораци (DTCC) –ын охин компани болох Тогтмол /төлөвлөгдсөн/ орлогын төлбөр тооцооны корпораци (FICC)-ын Засгийн газрын үнэт цаасны хэлтэс (The Government Securities Division (GSD)) нь АНУ-ын Засгийн газрын өрийн бичгийн худалдаанд тухайн хугацааны арилжааны тохирол, клиринг, эрсдэлийн удирдлага ба нэгдсэн бүртгэлд хамруулах үйлчилгээг үзүүлэх бөгөөд дараах үйл ажиллагааг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Бодит цагийн арилжааны менежмент/ Real-Time Trade Management (RTTM)
- Үнэ хаялцуулах худалдаа – Auction take-down
- Төлбөр тооцоо цэвэршүүлэх болон гүйцэтгэх / Netting and settlement
- Засгийн газрын үнэт цаасны арилжааны эрсдэлийн менежмент /Risk management for government securities trades
- Эргүүлэн худалдаж авах гэрээ / Repurchase agreements
- GCF repo service -
- Буцаан худалдаж авах буюу барьцааг орлуулах үйлчилгээ /Repurchase agreement collateral substitution service
- Маржийг дамжуулах /Cross-margining
- Автоматчилагдсан дансаар хийх бэлэн мөнгөний төлбөр тооцооны үйлчилгээ / Automated funds-only (cash-only) settlement service гэх мэт.
- The Mortgage-Backed Securities Division (MBSD)- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны хэлтэс

Хадгаламж итгэмжлэл, клирингийн корпораци (DTCC) –ын охин компанийн Тогтмол /төлөвлөгдсөн/ орлогын төлбөр тооцооны корпораци (FICC)-ын Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны хэлтэс (The Mortgage-Backed Securities Division (MBSD) нь үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны зах зээлд (mortgage-backed securities market) бодит цагийн горим дахь худалдааны тохирол, клиринг, эрсдэлийн удирдлага ба цэвэр төлбөрийг тооцон гаргах (netting) болон электрон мэдэгдэл өгөх үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Бодит цагийн горим дахь гүйлгээ / Real-Time Trade Matching
- Электрон мэдээллийн сангийн үйлчилгээ/ Electronic Pool Notification Services
- Цэвэр төлбөрийг тооцон гаргах үйлчилгээ /Netting Services
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны клирингийн үйлчилгээ / Mortgage-Backed Securities Clearing Services

**Depository Trust Company (DTC):** 1973 онд байгуулагдсан, DTCC-ын салбар компани. Үнэт цаас эзэмшигчдийн нэр дээр “book-entry” зарчмаар өмчлөх эрхийн шилжүүлэлт хийх, клиринг, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. NSCC сүлжээнд болон интституциональ оролцогчдын / кастодиан банк хооронд, брокер-дилер хооронд, мөнгөний зах зээлд / төлбөр тооцоо хийх үндсэн чиг үүрэгтэй. Үзүүлж буй үйлчилгээнүүд нь:

- Аюулгүй хадгаламж болон харилцагчдын үйлчилгээ / Custody & Safekeeping Services
- Андеррайтерийн үйлчилгээ / Underwriting Services
- Урьдчилгааг байршуулах болон гүйлгээг хаах үйлчилгээ/ Deposit & Withdrawal Services
- Ногдол ашиг тараах, компани өөрчлөн байгуулах, итгэмжлэл хэрэгжүүлэх үйлчилгээ / Dividend, Reorganization and Proxy Service
- Хаалттай компанийн үнэт цаасны үйлчилгээ - Restricted Securities Family of Ser-

vices

- Үнэт цаасны шууд бүртгэлийн үйлчилгээ – Direct Registration Service

DTC нь АНУ-ын Холбооны Нөөцийн системийн гишүүн бөгөөд New York State банкны хуулиар /New York State banking law/ хязгаарлагдмал үүрэгтэй траст компани, АНУ-ын үнэт цаас биржийн комисс /the U.S. Securities and Exchange Commission (SEC)/-д бүртгэлтэй, клирингийн агентлаг юм.

**European Central Counterparty Ltd.(EuroCCP)** Энэхүү байгууллага нь Европын хэмжээнд зардал багатай клирингийн үйл ажиллагааг явуулах Үндэсний төлбөр тооцоо клирингийн корпораци (DTCC) DTCC-ийн охин компани юм. Euroclear нь Turquoise, SmartPool, NYSE Arca Europe болоод Pipeline financial Group -ийн клирингийн үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн энэхүү байгууллага нь NASDAQ OMX-тэй Хельсинк, Копенгаген, Стокхолм дээр хийгдсэн арилжааны клирингийн үйлчилгээг хийж байх зөвшилцлийн гэрээг байгуулсан байдаг.

**New York Portfolio Clearing (NYPC)** Энэхүү байгууллага нь NYSE Euronext болоод Үндэсний төлбөр тооцоо клирингийн корпораци (DTCC) -ийн хамтарсан охин компани юм. NYPC нь Commodity Futures Trading Commission (CFTC) эд хөрөнгө коммодити, фючерс арилжааны комисс хэмээн бүртгэгдсэн дериватив клирингийн байгууллага (DCO) юм.

**Omgeo LLC** нь 1999 онд байгуулагдсан бөгөөд үнэт цаасны зах зээл дээрх брокер дилерүүдийн, хөрөнгө оруулалтын менежерүүдийн болоод кастодиан банкуудын үнэт цаасны зах зээл дээрх мэдээллийг боловсруулах, хянах төвлөрсөн үйл ажиллагааг эрхэлдэг. Omgeo нь арилжааны төгсгөл дэх, төлбөр тооцооны өмнөх худалдааны менежментийг хийдэг байгууллага юм.

#### **б/ АНУ-ын хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпорац /DTCC/-ийн мэдээллийн аюулгүй байдлын бодлого**

DTCC болон түүний охин компаниудын мэдээллийн аюулгүй байдлын бодлого болон мэдээлийн аюулгүй байдлыг хангах үйл явц дор дурдагдсанаар явагддаг.

АНУ -д мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэгдсэн тусгай хууль байдаггүй хэдий ч мэдээллийн аюулгүй байдлын талаар тусгасан, зохицуулсан акт, баримт бичгүүд байдаг. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал талаас нь тусгасан гол баримт бичиг бол “Нууцлалын баримт бичиг” (Privacy act 1974) болоод (Computer Matching and Privacy Act) зэрэг юм. Гэсэн ч энэхүү баримт бичгүүд нь хувь хүний мэдээллийг улсын буюу Засгийн газрын хэмжээнд боловсруулах, хэрэглэх асуудал тусгагдсанаас хувийн болоод нийтийн байгууллагууд хувь хүний мэдээлэлтэй хэрхэн харьцах талаар тусгагдаагүй байдаг.

“Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпорац”-д (DTCC) “Нууцлалын бодлого” (Privacy Policy) гэж байдаг байна. Энэхүү бодлого нь Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпорац (DTCC) болоод түүний охин компаниудад хамааралтай байдаг байна. Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпорацийн (DTCC)-ийн болоод түүний охин компанийн үйл ажиллагаа ямар нэг байдлаар Англи улстай холбогдсон үед (UK Data Protection Act of 1998) буюу Англи улсын мэдээллийг хамгаалах 1998 оны актаар зохицуулдаг байна. Дээрх баримт бичгээр Англи улсад үзүүлж буй Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпорац (DTCC) болоод түүний охин компаниуд үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг авч болно гэж заасан байдаг. Энэхүү хувийн мэдээлэлд нэр, ажлын е-мэйл хаяг, утасны дугаар, бизнес хаяг гэх мэт үйлчлүүлэгчид хамааралтай мэдээлэл ордог байна.

Энэхүү Нууцлалын бодлогын зорилго нь Хадгаламж итгэлцэл, клирингийн корпорац (DTCC) болоод түүний охин компаниуд явуулж буй үйлчилгээний үйл ажиллагаатай нь

холбоотойгоор ирж буй нийтийн бус хувийн мэдээллэлтэй хэрхэн харьцах, хэрэглэх ерөнхий бодлого болоод үйл ажиллагааг тодорхойлоход чиглэгддэг.

Нууцлалын бодлогын дагуу нийтийн бус хувийн мэдээлэл гэдэгт :

- Үйлчлүүлэгчийн санхүүгийн бүтээгдэхүүн болоод үйлчилгээ авахаар гаргаж өгсөн мэдээлэл,
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлсний үр дүнд мэдэж авсан үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээлэл,
- Бүтээгдэхүүн болоод үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор бий болсон үйлчлүүлэгчийн мэдээлэл зэрэг ордог.

Хадгаламж итгэлцэл, клирингийн корпораци (DTCC) болоод түүний охин компаниудад нэгэн нэгдсэн бодлого байдаг нь үйл ажиллагаагаа явуулахдаа нийтийн бус хувийн мэдээлэл, хувь хүний мэдээлэл болоод үйлчлүүлэгчийн мэдээлэл зэрэг буюу өөрөөр хэлбэл итгэмжлэгдсэн буюу үйлчилгээ үзүүлэх үед олж авсан мэдээллийг ашиглахгүй байх явдал юм. Хадгаламж итгэлцэл, клирингийн корпораци (DTCC) нь энэхүү нууцлалын бодлогоо цаг хугацааны явцад үйл ажиллагаандaa хяналт тавих замаар, Хадгаламж итгэлцэл, клирингийн корпораци (DTCC) болоод түүний охин компаниудын үйл ажиллагааны өөрчлөлт мөн хууль тогтоомжын өөрчлөлтүүдээс шалтгаалан өөрчлөх бололцоотой юм.

#### Итгэмжлэгдсэн мэдээллийг нууцлах

Энэ нь Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) болоод түүний охин компаниуд үйлчлүүлэгчийн итгэмжлэгдсэн мэдээллийг ашиглах болон олонд ил тод болгохгүй байх бодлого юм. Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) болоод түүний охин компаниудын үүрэг бол хувь хүний мэдээллийг гуравдагч талд гаргаж өгөхгүй байх явдал бөгөөд зөвхөн үйлчлүүлэгчийн хүсэлтээр түүнд шаардлагатай тодорхойлолт гэх мэт зүйлст мэдээллийг ашиглан гаргаж өгөх үүрэгтэй байдаг.

#### Мэдээлэлийн хяналт

Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) – ийн нууцлалын ахлах ажилтан нь Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) болоод түүний охин компаниудын нууцлалын бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүрэг бүхий этгээд байна.

#### Мэдээллийн аюулгүй байдал

Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах программтай байдаг. Энэхүү программын зорилго нь:

- Итгэмжлэгдсэн мэдээллийн нууцлал болоод аюулгүй байдлыг хангах,
- Итгэмжлэгдсэн мэдээллийг учирч болох аюулаас хамгаалах,
- Итгэмжлэгдсэн мэдээлэлд эрхгүй этгээд нэвтрэх, хэрэглэхээс хамгаалах гэх мэт. Эдгээр стандартууд нь охин компаниудад мөн хамаарлтай байдаг.

Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) нь мэдээллийн системийн аюулгүй байдалд байнга хяналт тавьж, шалгаж байдаг бөгөөд гол үйл ажиллагаа болон удирдлагатай холбогдох мэдээллийн аюулгүй байдал, Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) болоод түүний охин компаниудын үйл ажиллагааны улмаас хувь хүнд учирч болох гадаад, дотоод эрсдэлийг тогтмол хянадаг байна.

Хувь хүний мэдээллийг боловсруулах нэмэлт үйл ажиллагаа

Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) болоод түүний охин компаниуд нь хувь хүний мэдээллийг маркетингийн зорилгоор буюу бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилах зорилгоор, е-мэйл явуулах гэх мэтээр ашиглаж болдог. Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) түүний охин компаниуд нь хувь хүний мэдээллийг хуулиар заасан эрх бүхий гуравдагч этгээдэд тодорхой шаардлагын дагуу гаргаж өгч болно.

Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) нь хувь хүний мэдээлэлийг нарийн чанд болоод бодитой хадгалах хуулийн үүргийг хүлээдэг энэхүү үүргийнхээ дагуу үйлчлүүлэгчдээс мэдээлэлээ өгөх хүсэлт гаргадаг бөгөөд үйлчлүүлэгч нь харин өгөхгүй байх эрхтэй. Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) –ийн нийтийн website-тай холбоотой нууцлалын асуудал

Энэхүү вебсайт нь мэдээллийг түгээхэд зориулагддаг бөгөөд Хадгаламж итгэлцэл, төлбөр тооцооны корпораци (DTCC) нь хувь хүний мэдээллийг зөвхөн мэдээлэл тараах үйлчилгээний зориулалтаар цуглуулдаг байна.

## 1.2 Баруун Европын туршлага /ИБУИНВУ, ХБНГУ/

### ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Улсын үнэт цаасны зах зээлийн үндсэн хэрэгсэлүүд нь Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын бонд, дотоод болон гадаадын үнэт цаас, өрийн бичиг, мөнгөний зах зээлийн бусад хэрэгсэлүүд орно. Мөн бусад хэрэгслүүд дээр үндэслэсэн деривативийн зах зээл хамарагдана. Энэхүү зах зээлийн хамгийн идэвхитэй оролцогчид нь дотоодын болоод Олон Улсын банк, Үнэт цаасны байгууллагууд байдаг.

1980 оноос Их Британи нь хөрөнгийн зах зээлийн өргөн хүрээний шинэтгэлийг хийсэн<sup>11</sup> бөгөөд 1986 онд **Санхүүгийн үйлчилгээний тухай хууль**<sup>12</sup> баталж үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг системчилж өгсөн. Энэ хуулиар үнэт цаасны зах зээлийг зохицуулах **Үнэт цаас ба хөрөнгө оруулалтын хороо** байгуулжээ.

Санхүүгийн салбарын шинэтгэлийн хүрээнд 1997 онд тус салбар дахь зохицуулах бусад байгууллагуудыг Үнэт цаасны болон хөрөнгө оруулалтын зөвлөлийн үндсэн дээр нэгтгэж **Санхүүгийн үйлчилгээний хороо**<sup>13</sup>(Financial Service authority)-ийг байгуулжээ. Одоо тус байгууллага нь 2000 оны “Санхүүгийн үйлчилгээ болон зах зээлийн акт” –аар олгогдсон эрхийг хэрэгжүүлж байна. Үүнд: Банк, даатгалын компаниуд, санхүүгийн зөвлөгөө өгөх байгууллагууд, барьцаат зээлийн, даатгал зуучлагчдын гэх мэт санхүүгийн зах зээлд оролцогч субъектууддэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг нь хянах гэх мэт зохицуулах үүргийг гүйцэтгэдэг.

2000 оны Санхүүгийн үйлчилгээ болон зах зээлийн баримт бичигт энэхүү байгууллагын дөрвөн үндсэн үүргийг тодорхойлсон. Үүнд:

- Зах зээлийн болон санхүүгийн тогтолцооны найдвартай байдлыг хангах;
- Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн тогтолцооны талаар иргэдэд

<sup>11</sup> <http://www.dtcc.com/about/subs/ficc.php> 2011 оны 5 дугаар сар 30-нд хамгийн сүүлд зочилсон.

<sup>12</sup> “Information privacy policies and procedures of the depository trust & clearing corporation (DTCC) and subsidiaries”

<sup>13</sup> <http://www.iassistdata.org/downloads/iqv01223stratford.pdf>

мэдлэг олгох;

- Үйлчлүүлэгч, харилцагчдыг хамгаалах;
- Эдийн засгийн гэмт хэргийг бууруулах гэх мэт болно.

2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Парламентаас батлагдсан **Санхүүгийн үйлчилгээний акт** -аар Санхүүгийн үйлчилгээний хороонд Нэгдсэн Вант Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүргийг нэмж оногдуулсан байдаг.<sup>14</sup> Энэхүү байгууллага нь АНУ-ын Үнэт цаасны арилжааны комисс (SEC)-той адил ерөнхий зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэдэг.

Арилжааны хувьд үнэт цаас, хувьцаа, өрийн бичиг болон бусад Англи улсад бүртгэлтэй үнэт цааснууд Лондонгийн хөрөнгийн биржээр арилжаалагддаг. Биржийн бус арилжааны хэрэгсэл болох деривативийн гэрээнүүд London International Financial Futures and Options Exchange (LIFFE), London Metal Exchange (LME), OM London Exchange, International Petroleum Exchange (IPE) зэрэг биржүүдээр арилжаалагддаг.

### **Лондонгийн клирингийн байгууллага (London Clearing House Clearnet)**

LCH.Clearnet нь биржийн бус зах зээлийг оролцуулан олон улсын томоохон биржүүд болон сүлжээнүүдэд үйлчилгээ үзүүлдэг бие даасан, тэргүүлэх зэргийн төлбөр тооцооны байгууллага юм. Энэхүү байгууллага нь үнэт цаас, биржийн деривативууд, таваарын арилжааны хэрэгсэлүүд, эрчим хүч, тээврийн гэрээ, зээлийн өрийн своп, евро, стерлингээр илэрхийлэгдсэн бонд, репо зэрэг санхүүгийн хэрэгсэлийн арилжааны төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээг эрхэлдэг, зах зээлд оролцогчид болон биржүүдтэй ойр ажиллаж тэдгээрт клирингийн үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн байгууллага юм. Толгой компани нь LCH.Clearnet Group Limited компани бөгөөд нийт хувьцааны 83%-ийг үйлчлүүлэгчид, 17%-ийг нь биржүүд эзэмшдэг байна.

LCH.Clearnet нь Санхүүгийн үйлчилгээний хорооны хяналтан дор Financial services and markets act (FSMA 2000)-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. LCH.Clearnet-ийн үйл ажиллагаанд Үнэт цаасны зах зээлийг зохицуулах байгууллага болон Төв банк нь өөр өөрсдийн хуулиар олгогдсон эрхийн хүрээнд зохицуулах болон хяналт тавих үүрэг гүйцэтгэж байна.

LCH.Clearnetийн үндсэн үүрэг нь арилжааны үед хэлцэлд оролцогч 2 талын эрсдэлийг зохицуулах үүрэгтэй дундын байгууллага хэлбэрээр ажилладаг. Талууд LCH.Clearnet-д хэлцлийг бүртгүүлснээр санхүүгийн гүйлгээ хийх хуль ёсны эрх үүснэ. Хэрвээ аль нэг тал нь үүргээ зөрчсөн тохиолдолд LCH.Clearnet хөндлөнгөөс оролцож эрсдэлийг зохицуулсанаар санхүүгийн зах зээлийн найдвартай байдлыг хангах, арилжааг хэвийн явуулах, зах зээлд итгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.

LCH.Clearnet нь эхний болон нэмэлт марж/ барьцаа/-ийг клирингийн гишүүдээс цуглуулж хэрвээ талууд үүргээ биелүүлэх чадваргүй болсон тохиолдолд үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор ашиглана. Барьцаа хөрөнгө/марж/-ийн тодорхой хэсгийг өндөр ур чадвар бүхий эрсдэлийн удирдлагын баг удирдан зах зээлийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах, хэлцэлд оролцогчдын позици болон эрсдэлийг удирдахад ашиглана. Тус байгууллагын эрсдэлийн удирдлагын болон зах зээлийг уян хатан зохицуулах ажиллагааг сүүлийн үед улам бүр боловсронгуй болж байна.

LCH.Clearnet Group Limited нь 2 салбар компанийтай бөгөөд LCH.Clearnet Limited компани нь Лондонд байрладаг бөгөөд Нью-Йоркт төлөөлөгчийн газартай. LCH.Clearnet SA

<sup>14</sup> <http://www.dtcc.com/privacy.php>

компани нь Парист байрладаг бөгөөд Амстердам Брусселд салбар, Порто-д төлөөлөгчийн газартай.

LCH.Clearnet нь дараах үйл ажиллагааг явуулдаг:

1. Commodity - Бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоо
2. Credit default swap - Зээллэгийн солилцоо
3. Derivatives - Дериватив
4. Energy – Эрчим хүч
5. Equities – хувьцаа / хөрөнгө оруулалтын үнэт цаас/
6. Fixed Income – Тогтмол орлого
7. Freight -Тээвэр
8. Interest Rate Swaps – Хүүгийн түвшний солилцоо гэх мэт.

#### 1. Commodities – (Бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоо)

LCH Clearnet нь санхүүгийн хэрэгслүүдийн төлбөр тооцоог 1888 онд байгуулагдсан цагаасаа хийж ирсэн. LCH Clearnet нь арилжааны болоод арилжааны бусаар худалдаалах зах зээлд клирингийн үйлчилгээ, төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг.

#### 2. Credit default swap - Зээллэгийн солилцоо

2010 оны 1 дүгээр сар гэхэд CDS гэрээгээр ойролцоогоор 25000 тэрбум Еврогийн гүйлгээ хийгдсэн байдаг.

#### 3. Derivatives – Дериватив

LCH Clearnet нь деривативын клирингийн үйлчилгээг үзүүлдэг хэрэглэгчийн эзэмшилийн буюу хэрэглэгчээр удирдуулсан хамгийн том байгууллага юм.

#### 4. Energy - Цахилгаан

LCH Clearnet нь АНУ-ын цахилгаан худалдаалдаг байгууллагуудын биржийн бус худалдааны клирингийн үйлчилгээг үзүүлдэг.

#### 5. Equities – Хувь, хувьцаа

LCH Clearnet нь хувьцаа болоод хувьцаатай адил үнэт цаас болох арилжаалагддаг бондууд, арилжаалагддаг эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын бичиг болоод арилжаалагддаг бонд гэх мэт хувьцааны клирингийн үйлчилгээг хийдэг. Энэхүү клирингийн үйлчилгээ нь Лондонгийн хөрөнгийн бирж, SIX Swiss-ийн бирж, BATS Europe, Equiduct&Plus Market Group худалдаа, Chi-X Europe болоод Chi-East зэрэг дээр худалдаалагдсан хувьцаанд сууринсан үйлчилгээг үзүүлдэг Нью Иоркийн хөрөнгийн бирж, Euronext, Bourse de Luxembourg, Equiduct and SecFinex зэрэг дээр хийгдсэн гүйлгээний клирингийн үйлчилгээг хийдэг байна.

#### 6. Fixed income - Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсээл

LCH Clearnet нь тогтмол орлогын зах зээлтэй 1998 оноос хойш ажиллаж ирсэн.

#### 7. Freight – Тээвэр

LCH Clearnet нь 2005 оны 9 дүгээр сараас тээврийн үйлчилгээ эхэлсэн бөгөөд арилжааны бус тээврийн гэрээний бүртгэл, клирингийн үйлчилгээг үзүүлдэг.

#### 8. Interest Rate Swaps – Хүүгийн түвшний солилцоо

1999 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 14 төрлийн мөнгөний нэгжээр клирингийн гүйлгээ хийж байна.

### **Euroclear UK and Ireland**

CREST нь 1996 оны 6 дугаар сарын 15-нд байгуулагдсан бөгөөд хувийн хэвшлийн CREST. Со –ийн эзэмшилд үйл ажиллагаагаа явуулж байсан. 2002 оны 9 дүгээр сард Euroclear-тэй нэгдэж CREST. Со нь Euroclear банкны бүрэн эзэмшлийн охин компани болсон. CREST нь санхүүгийн үйлчилгээний хорооны хяналтын дор “Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн баримт бичиг” (FSMA 2000)-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. International Central Securities Depository (ICSD) (Олон улсын үнэт цаасны хадгаламжын төв) нь Eurobondoor арилжаалагдаж буй үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээг үзүүлдэг.

Олон Улсын хэмжээнд үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ үзүүлдэг 2 үндсэн байгууллага байдаг нь Clearstream, Euroclear 2 юм.<sup>15</sup> Euroclear UK and Ireland нь Англи улс, Ирланд, Жерсей, Guernsey, Isle of man зэрэг улсуудын Үнэт Цаасны Хадгаламжийн төв юм. Лондон болоод Ирландын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж байгаа Засгийн газрын болоод корпорациудын үнэт цааст холбогдох үйлчилгээг бага зардлаар зохицуулах боломжийг олгодог байна.

Гишүүнчлэлийн хувьд нээлттэй бөгөөд оролцогч болон хэрэглэгч гэж ялгагддаг. Оролцогч гэдэг нь CREST-ийн хувьцаа эзэмшигч этгээд болоод төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч (банкууд), бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгч (бүртгэгч) нар юм. Харин хэрэглэгч гэдэг нь оролцогчдоор дамжуулан CREST. Со-той холбогдож байгаа этгээдүүдийг хэлнэ. Өдөрт 1,6 тэрбум орчим фунт стерлингийн үнэлгээ бүхий үнэт цаасны шилжүүлэг CREST-ийн системд хийгддэг байна.

CREST-ийн үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль нь Uncertificated Securities Regulations 2001 ( Биет бус үнэт цаасны зохицуулалт) хэмээх хууль юм. Энэхүү хуулиар үнэт цаасны бүртгэл, төлбөр тооцоо болон холбогдох бусад асуудлуудыг зохицуулсан байдаг.

Үйл ажиллагаа:

Euroclear UK болон Ireland нь өндөр зэрэглэлийн, өргөн хүрээтэй, бага зардалтай, шууд үйл ажиллагаагаар Засгийн газрын болон корпорацийн үнэт цаасны төлбөр тооцоог хийдэг байгууллага юм. Энэ дотор Лондон болон Ирландын Хөрөнгийн бирж, өөр бусад газар худалдаалагдсан үнэт цаасны хувьд төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой.

- Бодит хугацааны тохиролцоо. Гүйлгээгээ бүхий л өдрийн туршид шууд хянах, удирдах боломжийг олгодог.
- Төлбөр хулээн авах үеийн хяналт. Энэ нь бэлэн мөнгө худалдагч руу шилжиж, үнэт цаас худалдан авагч руу нэгэн зэрэг шилжиж буй үед мөнгө нь төв банкинд байх үйл явц юм. Ингэснээр талууд болох худалдан авагч үнэт цаасыг, худалдагч бэлэн мөнгийг нэгэн зэрэг шилжүүлэх баталгаа болж өгдөг байна.
- Хууль зүйн бүрэн эрхийн дагуу тохиролцоог шилжүүлэх: Английн бүх бүртгэлтэй хувьцаанууд болон Засгийн газрын бондын бүртгэл нь ил тод байна.
- Үнэт цаасыг зээлдэгч, зээлдүүлэгч болон бусад туслах зохицуулалтын боломжууд
- Корпорацийн үйл ажиллагаанд агент болоод нэхэмжлэгчтэй шууд харилцаатай байж бүрэн оролцох.

<sup>15</sup> [http://en.wikipedia.org/wiki/Central\\_Securities\\_Depository](http://en.wikipedia.org/wiki/Central_Securities_Depository)

Үнэт цаас:

Хүлээн зөвшөөрөгдсөн үнэт цаас нь:

- Англи болон Ирландын хувьцаа ,
- Английн засгийн газрын бонд, мөнгөний зах зээлийн хэрэгслүүд,
- Олон Улсын өргөн хүрээний үнэт цааснууд буюу хувьцаа, Евробонд болон Олон Улсын баталгаа гэх мэт ордог.

### **Мөнгөн зах зээлийн алба (The Central Moneymarkets Office (CMO))**

Энэхүү байгууллагын эзэмшил Английн банкнаас CREST.Со-д 1999 оны 9 дүгээр сард шилжсэн бөгөөд CREST.Со-той адил зохицуулагддаг. Гишүүнчлэлийн хувьд Лондонгийн үнэт цаасны зах зээлд оролцогчдод хувьд нээлттэй бөгөөд одоогийн байдлаар 31 гишүүнтэй. СМО-ийн гишүүн болохын тулд гэрээл хэлцэл хийх ёстай байдаг. СМО нь стерлинг болоод еврогоор илэрхийлэгдсэн үнэт цааснуудыг найдвартай хадгалж төлбөр тооцоог хийх үйл ажиллагааг явуулдаг.

**Мэдээллийн хамгааллын тухай хууль** (Data Protection Act 1998) нь Англи Улсын парламентаас батлагдсан хууль бөгөөд Англи Улс дахь тодорхойлж болох бүх хүмүүст холбогдох мэдээллийг боловсруулах асуудлыг зохицуулсан гол баримт бичиг юм. Энэхүү актаар мэдээллийг хамгаалах 8-н зарчмыг тодорхойлсон бөгөөд хувь хүн, хуулийн этгээдүүдийг хувийн мэдээллээ өөрсдөдөө хадгалахыг шаарддаг байна. Мэдээллийг хамгаалах 8-н зарчмыг авч үзвэл:

1. Мэдээллийг зөвхөн ямар зориулалтаар авсан тэр зориулалтын дагуу л ашиглах.
2. Мэдээллийг гуравдагч этгээдэд гаргаж өгөх бол хуульд заасан болоод тодорхой зохицуулалтаар тухайн мэдээллийг гаргаж өгөхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн этгээдээс өөрөөс нь зөвшөөрөл авах, эс бөгөөс хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
3. Хувь этгээдүүд өөрсдийнх нь мэдээлэл тусгагдсан мэдээллийг хүлээн авах эрхтэй.
4. Хувийн мэдээлэл шаардлагатай хугацаанд хадгалагдах бөгөөд шинэчлэлтийг байнга тусгах ёстай.
5. Хувийн мэдээлэл, мэдээллийг илгээх урьдчилсан гэрээгүйгээр Европийн эдийн засгийн бүсээс гадагш илгээгдэх ёсгүй.
6. Хувийн мэдээллийг хамгийн энгийн хэлбэрээр боловсруулдагаас бусад хувийн мэдээллийг боловсруулдаг бүх байгууллагууд Мэдээллийн комиссаруудын байгууллагад бүртгүүлэх ёстай.
7. Хувийн мэдээллийг боловсруулах асуудлыг хариуцдаг байгууллагын хэлтэс, тасаг нь тохиromжтой мэдээллийн аюулгүй байдлыг хангах техникийн болоод байгууллагын ажилтнуудыг бэлтгэх гэх мэт баталгааг бүрдүүлсэн байх.
8. Холбогдох этгээдүүд бодит бус мэдээллийг баталгаажуулах үүрэгтэй байдаг.

Энэхүү баримт бичиг нь зөвхөн цахим хэлбэрээр системчлэгдсэн мэдээллийн хүрээнд үйлчилдэг байна. Зарим тохиолдолд цаасан дээр буусан хаягийн дэвтэр ч системчлэгдсэн мэдээллийн хэлбэрт хамарагддаг байна. Энэхүү актаар мөн мэдээллийг хянагч нарын хариуцлагын талаар тусгасан иргэний болоод эрүүгийн хэд хэдэн зөрчлийн талаар тусгасан байдаг. Эдгээр нь:

21 дүгээр хэсэг. Энэхүү хэсэгт хувийн мэдээллийг бүртгүүлэх ёстай байгууллагад бүртгүүлээгүй этгээд боловсруулах нь зөрчилд тооцогддог байна. 55 дугаар хэсэг. Хувийн мэдээллийг хууль бусаар олж авах. Энэхүү хэсэгт тусгаснаар эрх олгогдоогүй этгээдүүдэд

буюу тухайн байгууллагад ажилладаггүй гадны этгээд тухайн мэдээллийн санд хууль бусаар нэвтрэхийг зөрчилд тооцдог байна. 56 дугаар зүйл. Энэхүү хэсэгт тусгаснаар хэн нэгнийг хүний хувийн мэдээлэл рүү нэвтрэхийг шаардах нь эрүүгийн зөрчилд тооцогддог байна.

### **ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

ХБНГУ-д арилжааны банк нь үнэт цаасны зах зээлд оролцогч үндсэн мэргэжлийн байгууллага байна. Иймд үнэт цаасны зах зээлийг зохицуулах чиг үүрэгт банкны хяналт ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. **Банкны холбооны хяналт шалгалтын танхим** нь банкны болон үнэт цаасны компаниудад хөрөнгийн босгын хэмжээг баримталж буй байдал, балансын бүтэц гэх мэт үйл ажиллагаанд хяналт тавина. Сүүлийн жилүүдэд ХБНГУ-ын Үнэт цаасны зах зээл АНУ-ын адил илүү нээлттэй болж байна.

Хөрөнгийн биржийн худалдааг зохицуулах хууль зүйн зарчим нь хөрөнгийн биржийн системтэй холбогдох бүхий л асуудлыг ганцхан хуулиар зохицуулах боломжгүйд оршино. Мөн Хөрөнгийн биржийн худалдаа нь хууль зүйн өөр, өөр системд үндэслэх нь ч бий. Хөрөнгийн биржийн акт ба Германы үнэт цаасны худалдааны тухай акт, Хөрөнгийн биржийн дүрэм зэрэг нь нийтийн эрх зүйн хүрээн дэх актуудад хамаардаг харин ХБНГУ-ын хөрөнгийн бирж дэх худалдааны нөхцөл, нэр томъёонууд нь хувийн эрх зүйн хүрээнд багтдаг.

Хөрөнгийн биржийн хууль зүй байгууллын шинж чанар нь энэхүү эрх зүйн өөр өөр системээр зохицуулгадагийн нэгээхэн жишээ юм. Нэг талаас нь харвал Хөрөнгийн биржийн нэгжүүд нь нийтийн эрх зүйн удирдлагатай, нөгөө талаас хараад тэдгээрийн худалдааны үйл ажиллагаа нь нийтийн болон хувийн эрх зүйн харилцааны дунд оршиж байдаг. ХБНГУ-ын үнэт цаасны зах зээлд хяналтын үүргийг гүйцэтгэдэг 2 гол байгууллага байдаг нь BaFin, Deutsche Bundesbank 2 юм.

#### **Холбооны Улсын санхүүгийн хяналтын байгууллага – BaFin**

Энэхүү байгууллагын бүтэн нэр нь “Bundesanstalt fur Finanzdienstleistungsaufsicht” Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх мэдлийг хэрэгжүүлэх Холбооны Улсын байгууллага (Federal Financial Supervisory Authority) (Supervisory Authority) бөгөөд бизнесийн харилцаанд BaFin нэрээр оролцдог.

ХБНГУ-ын бүхий л санхүүгийн зах зээлд төвлөрсөн зохицуулалт хийх чиг үүрэг, зорилго бүхий Санхүүгийн үйлчилгээний, нэгдлийн акт хэмээх баримт бичгийг 2002 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр батлан гаргасан. BaFin энэхүү баримт бичгийн дагуу байгуудагдсан.

Үндсэн 4 газраас бүрддэг:

1. Зохицуулалтын үйлчилгээ, хүний нөөц
2. Банкны хяналт
3. Даатгалын салбарын хяналт
4. Үнэт цаасанд хяналт тавих<sup>16</sup>.

Эдгээр газрууд нь дотроо хэлтэс хэсгүүдтэй бөгөөд тэд өөрсдийн хариуцсан салбарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү байгууллага нь ХБНГУ-ын 2700 гаруй банк, 800 гаруй санхүүгийн үйлчилгээний байгууллагууд болоод 700 гаруй даатгалын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байна. 2003 онд Банкны баримт бичигт

<sup>16</sup> <http://www.legislation.gov.uk/ukpga/1998/29/contents>

орсон нэмэлт өөрчлөлтөөр BaFin-д санхүүгийн байгууллагуудын олгож буй зээлд хяналт тавих, эдгээр санхүүгийн байгууллагуудын нарийвчилсан мэдээллийг цуглуулах гэх мэт үүргүүдийг нэмж өгсөн байна.

BaFin-ий банкны хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь Банкны баримт бичиг юм. BaFin нь ХБНГУ-ын Үнэт цаас худалдах тухай баримт бичгийн дагуу үнэт цаас болоод деривативийн зах зээлийг хянах үргийг хүлээдэг. Энд үнэт цаасны хууль бус худалдаа, шилжүүлэг, үнийн хөөрөгдөл гэх мэтээс сэргийлэх үүргүүд ордог байна. BaFin энэ чиг үүргийнхээ хүрээнд гарсан гэмт хэрэгтэй холбогдуулан албадлагын арга хэмжээ авах эрхтэй байдаг. Bafin нь эдгээр чиг үүргээ Deutsche Bundesbank-тай хамтран хэрэгжүүлдэг байна.

### **Deutsche Bundesbank**

BaFin болоод Deutsche Bundesbank 2 банкны хяналтыг хувааж хэрэгжүүлдэг тухай дээр өгүүлсэн. Энэхүү хамтран ажиллах эрх зүйн үндсийг Банкны тухай хуулийн 7 дугаар хэсэгт зохицуулсан байдаг бөгөөд энэхүү 2 байгууллага нь зохицуулах чиг үүргийн хүрээнд харилцан ойлголцлын санамж бичгээр тохиролцсон байдаг. Deutsche Bundesbank нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төв банк бөгөөд евросистемийн мөнгөний бодлого нь Bundesbank-ны үйл ажиллагааны гол зүйл юм. Санхүү болоод мөнгөний систем, банкуудын хяналт, бэлэн бус болоод бэлэн төлбөр тооцоо гэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

Deutsche Bundesbank болоод BaFin 2-ийн үндсэн зорилго нь ХБНГУ-ын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үйлчлүүлэгчдийн эрх зөрчигдөхөөс хамгаалахад чиглэгддэг. ХБНГУ-ын хөрөнгийн бирж нь төрийн онцгой статус бүхий байгууллага бөгөөд хуулийн дагуу биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай эрх авсан байгууллага нь "Deutsche Borse" буюу ХБНГУ-ын хөрөнгийн бирж гэсэн хувьцаат компани байдаг байна. Энэхүү ХК нь 1993 онд байгуулагдсан хувь нийлүүлсэн компани юм. Төв нь Франкфуртэд байдаг. Ази, Европ, Америкт 3200 гаруй ажиллагсадтай. Герман, Люксенбург, Швейцарь, Чех, Испанид улсуудад салбартай. Лондон, Парис, Чикаго, Хонконг, Дубайд төлөөлөгчийн газартай.

Биржийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь төрд, харин тэр эрхийг ашиглагч нь хувийн өмчлөлийн, ашгийн төлөөх аж ахуйн нэгж болно. Тэр утгаараа төр нь хяналтаа сайн тавьдаг бөгөөд 2008 оны хямралыг бусад биржтэй харьцуулахад сайн давсныг төрийн хатуу хяналттай холбон тайлбарлах нь бий. Хямралын дараагаар ихээхэн хохирол амссан Англи, Америкийн Хөрөнгийн биржүүд энэхүү Европ стандартыг сонирхох хандлагатай байна. Германы биржийн хатуу хяналт, хууль эрх зүйн тогтолцоо нь дэлхийд шилдэгүүдийн жишээнд тооцогддог. Хөрөнгийн зах зээлийн оролцогчид электрон худалдааны систем XETRA-г ашигладаг бөгөөд арилжаагаа танхимын болон электрон хэлбэрээр явуулдаг байна.

Клиринг, Төлбөр тооцоо. Герман улсын үнэт цаасны клирингийн үйлчилгээг Clearstream болоод Eurex Clearing AG гэсэн байгууллагууд үзүүлдэг байна. Clearstream Banking S.A нь Deutsche Borse-ийн клиринг болоод төлбөр тооцооны үүргийг гүйцэтгэдэг салбар байгууллага юм. Гол үүрэг нь Олон Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болоод ХБНГУ-ын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үүргийг гүйцэтгэдэг байна.

Үнэт цаасыг банкинд аюулгүй хадгалах үйлчилгээг зохицуулах гол хууль нь Аюулгүй хадгалалтын баримт бичгийн тухай хууль (Safe Custody Act of 1937) юм. Энэхүү баримт бичиг нь үнэт цаас банкинд хадгалуулсан эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг.

Банк нь хадгалуулагчийн үнэт цаасыг өөрийн нэрийн өмнөөс өөр хадгалагчид (гуравдагч

тал) хадгалуулж болдог. Энэ нь хадгалуулагчийн эрхийг зөрчдөггүй байна. ХБНГУ-ын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь Clearstream Banking AG Frankfurt юм. Энэхүү байгууллага нь BaFin-aac 1949 онд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байдаг. 1999 оны эцэс хүртэл энэхүү байгууллага нь хуучин нэр болох Deutsche Borse Clearing AG нэртэйгээр Deutsche Borse AG-ийн эзэмшилийн охин компани байсан. 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Deutsche Borse Clearing AG нь Deutsche Borse Clearing AG-ийн хувьцаагаа Clearstream International SA-д шилжүүлсэн.

Clearstream-ийн үйлчлүүлэгчид нь дотоод гадаадын санхүүгийн үйлчилгээний байгууллага байх боломжтой. Clearstream International SA нь Европын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн нэгдлийг үндэслэн байгуулагч гишүүдийн нэг юм.

Clearstream нь бирж дээр болоод биржийн бус арилжаалагдсан бүхий л хэрэгслиүүдийн хувьд төлбөр тооцоог хийдэг гол байгууллага юм. Үнэт цаас арилжих дүрэм журмын дагуу бүхий л шилжүүлэг арилжаа хийгдсэний дараагийн өдөр хийгдэх ёстой байдаг. Харин биржийн бус арилжааны хувьд үнэ төлбөргүйгээр төлбөр тооцоо хийгдэх боломжтой байдаг.

### 1.3 Хуучин социалист орон /ОХУ/

ОХУ-ын хувьд үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулж буй гол эрх зүйн акт нь Иргэний хууль, “Үнэт цаасны зах зээлийн тухай”, “Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай” холбооны хуулиуд юм. Түүнчлэн өдгээр хуулиудад нийцүүлэн гаргасан Ерөнхийлөгчийн үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар гаргасан зарлиг, Засгийн газрын тогтоол, Үнэт цаасны зах зээлийг зохицуулах эрх бүхий байгууллагудаас батлан гаргасан хэм хэмжээний актууд орно<sup>17</sup>. Үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн актуудыг зорилгыг харвал дараах байдалтай байна.

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн зорилт нь үнэт цаасны төрлөөс үл хамааран үнэт цаас гаргах, түүний эргэлт болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчийг үүсгэн байгуулах, үйл ажиллагааны онцлогтой холбоотой харилцааг зохицуулахад оршдог. Уг хуулийн 2 дугаар хэсгийн 2 дугаар бүлэгт үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа эрх зүйн үндэсийн талаар хуульчилсан байна. Харин 3 дугаар бүлэгт Хөрөнгийн биржийг тусад нь авч үзсэн бөгөөд хөрөнгийн бирж нь үнэт цаасны зах зээлд зөвхөн арилжаа зохион байгуулах бөгөөд харилцан үүрэг тодорхойлох /клиринг/, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэхээс бус үйл ажиллагааг давхар эрхэлж болохгүй<sup>18</sup> гэж заасан байна.

Мөн уг хуульд судалгааны сэдэвтэй холбоотой асуудлыг хуульчлахдаа 6 дугаар эзүйлд Төлбөр тооцоо /Клиринг/, 7 дугаар зүйлд Хадгаламж, 8 дугаар зүйлд Үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийн үйл ажиллагааг тус тус тусгажээ. Эдгээр зохицуулалтаас харахад Бүртгэлийн үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн бусад мэргэжлийн үйл ажиллагаатай давхар эрхлэхгүй<sup>19</sup>, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэгч нь үнэт цаасны хэлцлийн үүргийг гүйцэтгэхгүйн улмаас үүсэх эрсдэглийг бууруулах үүднээс тусгай сан байгуулах үүрэгтэй. Клирингийн байгууллагын сангийн хөрөнгийн доод хэмжээг Холбооны үнэт цаасны зах зээлийн хороо нь ОХУ-ын Төв банктай зөвшилцсөний үндсэн дээр тогтоодог<sup>20</sup> байна.

“Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай” хуулийн зорилт нь ”Үнэт цаасны арилжаан дахь хөрөнгө оруулагчийн /үнэт цаасанд хөрөнгө

<sup>17</sup> [http://www.bafin.de/cln\\_171/nn\\_720786/SharedDocs/Aufsichtsrecht/EN/Gesetze/findag\\_en.html](http://www.bafin.de/cln_171/nn_720786/SharedDocs/Aufsichtsrecht/EN/Gesetze/findag_en.html)

<sup>18</sup> Под ред Галанов В.А. (2008)Рынок ценных бумаг: теория и практика Москва: Финансы и статистика. 508

оруулсан иргэн, хуулийн этгээд/ эрх, ашиг сонирхлыг хамгаалах тэр, нийгмийн баталгааг хангах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын хууль бус үйлдлийн улмаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тодорхойлоход оршино” гэсэн байна.

Энэхүү хуулийн концепци нь төрийн болон өөрийн зохицуулалтын байгууллагын / СРО/<sup>19</sup> удирдлагыг хослуулах замаар үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах юм. Учир нь уг хуульд үнэт цаасны зах зээлийн өөрийн зохицуулалтын байгууллага нь өөрийн гишүүдийн үйл ажиллагааны үр дүнд хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлөх зорилго бүхий болон бусад санг байгуулж болдог. Түүнчлэн уг хуульд хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах, тэр дундаа хохирол нөхөн төлөх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах зорилгоор холбооны сан байгуулна гэж заасан. Уг сан нь шүүхийн шийдвэрийн гарсан боловч хариуцагчид мөнгөн хөрөнгө, бусад хөрөнгө байхгүй байгаа тохиолдолд хохирлыг нөхөн төлдөг.

ОХУ-ын эрх зүйн зохицуулалтаас харахад үнэт цаасны зах зээлийг тогтвортой байлгах, уг харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, чиг үүргийг “Үнэт цаасны тухай”, үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчдыг хамгаалах, уг харилцаанд үнэт цаасны мэргэжлийн болон бусад оролцогчид ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгайлсан хуульчилжээ. Энэ нь үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийг онцгой ач холбогдолтой хэмээн үздэгтэй холбоотой байж болох юм.

Ерөнхийлөгчийн зарлиг ба Засгийн газрын тогтоол нь үнэт цаасны зах зээл тэр дундаа үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулдаг. Жишээ нь, 1997 оны “ үнэт цаас эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрхийг хангах тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг үндэслэн Засгийн газар “Үндэсний хадгаламжийн тогтолцоон дахь эрхээр баталгаажсан үнэт цаас, бусад баримт бичгийг Төв хадгаламжийн санд гаргаж өгөх журам”-ыг 1999 оны 291 дүгээр тогтоолоороо баталсан байна. Уг тогтоопын 2 дахь хэсэгт “Төв хадгаламж нь ОХУ-ын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд өмчлөг болон бусад хууль ёсны хувьцаа эзэмшигчдийн данс, үнэт цаасны хэлцэл, түүний эргэлтээс олсон ашиг орлого, үр дүн болон хөрөнгийн зах зээлийн хадгаламжийн тухай мэдээлэл тараах эрхгүй хэмээн заасан байна.

#### Үнэт цаасны зах зээлийн бүтэц

Үнэт цаасны зах зээлийг бүтцийг олон талаас нь харж болох бөгөөд нөхцөл байдлаас хамааран түүний шинжээр нь өөр өөр сегментэд хувааж болно.<sup>20</sup> Үүний нэг нь үнэт цаасны зах зээлийн бүтцийг оролцогчдоор нь авч үзэх юм. Үнэт цаасны зах зээлд худалдагч, хөрөнгө оруулагчид, хөрөнгийн зуучлагчид, үнэт цаасны зах зээлд үйлчлэгч байгууллагууд, зохицуулах болон хянах байгууллага гэсэн бүлэг оролцогчид байна<sup>21</sup>. Үнэт цаасны зах зээлд үйлчлэгч байгууллагад

- Үнэт цаасны арилжааг зохион байгуулагчид /хөрөнгийн бирж, биржийн гадуурх арилжааг зохион байгуулагчид/
- Тооцооны төвүүд /тооцоо, клиригийн төвүүд/
- Хадгаламжийн байгууллага
- Бүртгэлийн байгууллага орно.<sup>22</sup>

<sup>19</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль - 11

<sup>20</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль - 10

<sup>21</sup> Саморегулируемая организация

<sup>22</sup> Батяева А.Т, Столяров И.И (2010) Рынок ценных бумаг Москва: Инфра-М. 13

- Мэдээллийн агентлага, бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллага.

ОХУ-д төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг компанийн хэлбэрээр тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг нь манай эрх зүйн зохицуулалттай адил юм. Харин онцлог шинж нь үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны онцлгоос хамааран өөрийн зохицуулалтын байгууллага үнэт цаасны зах зээлийн харилцааны оролцогч болж байдаг. “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 48 дугаар зүйл заасны дагуу өөрийн зохицуулалтын байгууллага нь мэргэжлийн оролцогчдын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан ашгийн бус нэгдэл байна.<sup>23</sup>

Гэхдээ энэхүү өөрийн зохицуулалтын байгууллага нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын ёс зүйн дүрэм, үйл ажиллагааны стандартыг мөрдүүлэх, гишүүн байгууллагынхаа харилцагч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах байдлаар оролцдог.<sup>24</sup> Ийм өөрийн зохицуулалтын байгууллагууд томоохон жишээ нь ПАРТАД<sup>25</sup> юм. Түүнчлэн Өөрийн зохицуулалтын байгууллагын дүрмийн 2.2-т заасны дагуу Өөрийн зохицуулалтын байгууллага нь гишүүдийнхээ хооронд үүсэн маргааныг хянан хэлэлцдэг хөндлөнгийн шүүх (трейтейский суд) байгуулах /эсвэл тогтмол үйл ажиллагаа явуулдаг хөндлөнгийн шүүхтэй гэрээ хийх/ үүрэгтэйг заавал дурдах хэрэгтэй юм.<sup>26</sup>

ОХУ-ын үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг хувийн эрх зүйн хуулийн этгээд /компани/, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг байдлаараа манай улсын эрх зүйн зохицуулалттай адилхан. Өөрөөр хэлбэл, уг үйл ажиллагааг төрийн байгууллага эрхлэхгүй бөгөөд төрөөс зөвхөн зохицуулж байдаг. ОХУ-ын үнэт цаасны зах зээлийг уг харилцаанд оролцогчдоор нь байдлаар үзүүлсэн байна.



<sup>23</sup> Под ред Треушников М.К (2000) Формы защиты прав инвесторов в сфере рынка ценных бумаг  
Москва: Городец.14

<sup>24</sup> Мөн тэнд

<sup>25</sup> Профессиональная ассоциация регистраторов, трансфер-агентов и депозитариев буюу  
Хадгаламж, шилжүүлэг, бүртгэлийн байгууллагын мэргэжлийн ассоциаци гэсэн үгний товчлол. /  
ХЗҮХ/

<sup>26</sup> Под ред Треушников М.К (2009) Формы защиты прав инвесторов в сфере рынка ценных бумаг  
Москва: Городец.380

Зураг 1<sup>27</sup>

Энэхүү зураг болон эрх зүйн зохицуулалтаас хараад ОХУ-д төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллагууд нь үнэт цаасны зах зээлийн дэд бутцэд бие даасан байр суурь эзэлдэг. Нөгөө талаас дэд бутцийн эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг “Үнэт цаасны зах зээлийн тухай”, “Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах замаар зохицуулж байдаг. Өөрөөр хэлбэл, уг хуулиудаар дэд бутцийн байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээг зааж өгсөн байхаас гадна хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор гаргасан бусад актаар зохицуулж байдаг.

#### 1.4 Азийн орнууд / Япон, Солонгос/

#### ЯПОН УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН ТӨВ

Үнэт цаасны хадгаламжийн төвийн үүсэл

1948 онд Япон улсад үнэт цаас болон биржийн комисс байгуулагдсан ба 1951 онд энэ байгууллагын чиг үүргийг сангийн яамны харьяанд шилжүүлж, үнэт цаас болон биржийн зөвлөл байгуулсан. 1998 онд санхүүгийн шинэтгэлээр санхүүгийн зах зээл бүрэн либералчлагдаж хамтарсан хөрөнгийн хэрэгслээр арилжих эрхийг санхүүгийн холдингудад олгогосон.

Үнэт цаасны компаниуд санхүүгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлгүйгээр хадгалах, бүртгэх, ашиглах үйлчилгээ явуулах болон брокерын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн. Үүний зэрэгцээ ерөнхий сайд<sup>28</sup>-ын дэргэд санхүүгийн хяналтын агентлагуудыг байгуулсан. Энэ

<sup>27</sup> [http://images.yandex.ru/yandsearch?text=chastniki\\_investitsionnogo\\_protsessa.jpg&rpt=simage](http://images.yandex.ru/yandsearch?text=chastniki_investitsionnogo_protsessa.jpg&rpt=simage)

<sup>28</sup> Санхүүгийн үйлчилгээний байгууллагын захирал

Судалгааны эмхтгэл, XI боть

байгууллага нь улсын хэмжээнд бүх санхүүгийн тогтолцоог хянах байгууллага юм. Сангийн яам нь зөвхөн санхүүгийн бодлогыг тодорхойлох, валютын болон Олон Улсын санхүүгийн харилцааг чиглүүлэх үүрэгтэй.<sup>29</sup>

Үнэт цаасны хадгаламжийн байгууллагын эрх зүйн орчин

Япон улсын үнэт цаасны эрх зүйн харилцааг зохицуулах гол хууль нь “Санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хууль” /Financial Instruments and Exchange Law/ бөгөөд энэхүү хууль нь 2006 оны 6 дугаар сарын 14-ний батлагдсан.<sup>30</sup> Тус хуулийн зорилго нь үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг тодорхой болгох, санхүүгийн хэрэгслийн арилжааны таатай орчинг баталгаажуулах, санхүүгийн гүйлгээ болон үнэт цаас гаргах үйл ажиллагааг шударгаар явуулах, үнэт цаасны эргэлтийн орчинг хөнгөвчлөх, санхүүгийн хэрэгсэлд шударга үнэ тогтох, хөрөнгийн зах зээлийг бүрэн ашиглаар замаар үндэсний эдийн засгийг хөгжүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад оршдог.<sup>31</sup>

Санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хуульд зааснаар Үнэт цаасны үйл ажиллагааг зөвхөн Ерөнхий сайдаас зөвшөөрөгдөн бүртгэгдсэн этгээд эрхлэх бөгөөд шаардлага хангасан<sup>32</sup> бол бүртгүүлэх хүсэлт гаргаж болно. Мөн үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаанд “Act on Transfer of Bonds, Shares, etc” буюу Бонд буюу хувьцаа шилжүүлэх тухай акт үйлчилдэг бөгөөд энэ актын зорилго нь үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасны эрх болон үнэт цаасыг эзэмшигчийн эрхийг хамгаалах зорилгоор бүртгэл, шилжүүлэг, данс бүртглийн үйл ажиллагаатай холбоотой байгууллагын үйл ажиллагааг зохицуулан үнэт цаасны төлбөр тооцооны гүйлгээг хэвийн явуулахад оршино.

Арилжаа, Клиринг, Төлбөр тооцооны байгуулгуудын үндсэн чиг үүрэг

Японы үнэт цаасны гүйлгээ нь зах зээл дээр арилжаа хийгдэх, клирингийн байгуулагад клиринг хийгдэх, төлбөр тооцооны байгууллагаар дамжуулан төлбөр тооцоог хийх гэсэн үндсэн 3 үе шатаас бүрддэг. Үүнээс үнэт цаасыг арилжаалах, бүртгэх, хадгалах, төлбөр тооцоо хийх, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг зохицуулах үйл ажиллагааг “Японы үнэт цаасны хадгаламжийн төв” XК буюу JASDEC групп эрхлэн явуулдаг. Харин Клиринг/ Clearing/-ийн үйл ажиллагааг Japan Securities Clearing Corporation/JSCC/, JASDEC DVP Clearing Corporation /JDCC/, Japanese Government Bond Clearing Corporation /JGCC/ хэмээх гурван компани эрхлэн явуулдаг.

#### **Японы үнэт цаасны хадгаламжийн төв /JASDEC групп/**

“Act on Transfer of Bonds, Shares, etc”<sup>33</sup> актад зааснаар үнэт цаасны бүртгэл, шилжүүлгийг хийх үндсэн байгууллага нь Японы үнэт цаасны хадгаламжийн төв буюу JASDEC групп

<sup>29</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн “Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт” судалгааны тайлан. 2009 он. 59 дэх тал

<sup>30</sup> [http://en.wikipedia.org/wiki/Financial\\_Instruments\\_and\\_Exchange\\_Law](http://en.wikipedia.org/wiki/Financial_Instruments_and_Exchange_Law)

<sup>31</sup> <http://www.fsa.go.jp/common/law/fie01.pdf>

<sup>32</sup> - Үйл ажиллагааны нэр /худалдаа, арилжаа/  
- Байршуулсан хөрөнгө болон татварын нийт дүн  
- Албан тушаалтны нэр  
- Ажлын байрны нэр , /Засгийн газраас тусгайлан заасан ажлын байр/  
- Үйл ажиллагааны ангилал  
- Удирдах байгууллагын нэр болон хаяг, байршил  
- Дээрх этгээдийн эрхэлж буй бусад албан тушаалын төрөл.

<sup>33</sup> [www.tse.or.jp/english/rules/clearing/index.html](http://www.tse.or.jp/english/rules/clearing/index.html)

юм. Энэ групп нь Японы санхүүгийн болон хууль зүйн сайдын зөвшөөрлөөр байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаагаа хөнгөвчлөн 2009 оноос цаасгүй технологит шилжин дотоодын үнэт цаасны бүртгэл, шилжүүлгийн үйл ажиллагааг явуулах болсон.

### **JASDEC групп нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

1. Хувьцааны бүртгэл, шилжүүлэг хийх;
2. Үнэт цаасны бүртгэл, шилжүүлэг хийх;
3. Корпорацийн бонд бүртгэх, шилжүүлэх;
4. Хөрөнгө оруулалтын илтгэлцлийн бүртгэл, шилжүүлэг хийх;
5. Биржийн бус үнэт цаасны гүйлгээнд DVP төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;
6. Төлбөр тооцооны өмнөх холбоу систем;
7. Гадаадын үнэт цаасыг хадгалах ;
8. Бусад үйлчилгээ

Төлбөр тооцооны үйл ажиллагаа нь үнэт цаасны төлбөр тооцоо хийх, мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог хийх гэсэн 2 үндсэн төрөлтэй. Үнэт цаасны төлбөр тооцоог “Японы үнэт цаасны хадгаламжийн төв” ХК буюу JASDEC групп эрхлэн явуулдаг бол мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог Японы төв банк /Төлбөр тооцооны банк (BOJ / Fund Settlement Bank) хийдэг.

### **Үнэт цаасны бүртгэл**

Үнэт цаасыг бүртгэхдээ Япон улсын Итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу JASDEC-н үнэт цаас бүртэлийн системд үнэт цаас гаргагчийн зөвшөөрлөөр хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс доорх төрлийн үнэт цаасыг бүртгэн байрлуулах эрхтэй.

1. Хөрөнгийн биржид арилждаг болон хөрөнгийн биржид арилжих гэж байгаа хөрөнгө оруулалтын сан (foreign stock trust)
2. Хөрөнгийн биржид арилжих гадаадын хөрөнгө оруулалтын сан. (foreign ETF trust)
3. Хөрөнгийн биржид арилжих гадаадын спот хөрөнгө оруулалтын сан
4. Хөрөнгийн биржид арилжаалагддаг дотоодын спот хөрөнгө оруулалтын сан.

Гадаадын хөрөнгө оруулалтын сан болон спот хөрөнгө оруулалтын сан нь Японы хадгаламжийн бичиг гэж нэрлэгддэг ба эдгээр нь японд үүсгэн байгуулагдсан гадаадын компаниас гаргадаг баримт бичиг юм. (beneficial certificate) Японы санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хуулинд Японы хадгаламжийн бичгийг “гадаадын үнэт цаасыг төлөөлсөн баттламж бичиг” гэж тодорхойлсон байдаг ба уг бичгийг бүрдүүлж байгаа хөрөнгийг тусгайлан заасан.

Хөрөнгө оруулалтын сан нь Япон улсад хийгдсэн алт, мөнгө гэх хөрөнгөөс бүрдсэн итгэмжлэлийн хуулинд захирагддаг хөрөнгө оруулалтын бичиг юм. Дээрхи үнэт цаасыг бүртгэхдээ хөрөнгийн биржээр дамжуулан тусгай программд боловсруулалт хийх ба JASDEC нь Татварын хуулид зааснаар Японы Хөрөнгийн Биржид бүртгэлтэй гадаад компаниудын төлсөн ногдол ашгаас олсон орлогын татварыг хадгална. Энэ нь Япон дахь ногдол ашиг олгогч итгэмжлэгдсэн банкаар /харилцагч банк/ дамжиж хэрэгждэг.

Япон улсын Компанийн тухай хуульд компани хувьцаа гаргах талаар заагаагүй бөгөөд харин компани байгуулах хуулиндаа үнэт цаас гаргах тухай заалтыг дүрмэндээ зааж өгөх боломжийг олгосон ба хувьцааг шилжүүлэхийн хориглоогүй байна.

## Японы клирингийн корпораци /JSCC/

Японы клирингийн корпораци JSCC нь Японы ерөнхий сайдын зөвшөөрлөөр байгуулагдсан.<sup>34</sup> Клиринг нь үнэт цаасыг шилжүүлэх болон мөнгөн хөрөнгийг төлөхийн өмнө хийгддэг бөгөөд энэ нь төлбөр тооцоог эцэслэх өдөр шилжүүлбэл зохих үнэт цаасны тоо болон мөнгөн дүнг тодруулах үйл явц юм”<sup>35</sup>.

Clearing Corporation party /CCP/ буюу төлбөр тооцооны байгууллагууд нь энэ үйл явцыг гүйцэтгэх үүрэгтэй ажилладаг бөгөөд түүний гол үүрэг нь арилжаа хийгдэх, хэлцлийг баталгаажуулах, Клиринг-(Бэлэн бус төлбөр тооцоог бодох), төлбөр тооцоог дуусгах юм. “Клиринг/ Төлбөр тооцооны төв нь худалдагч болон худалдан авагчийн хоорондын байрлан ‘худалдагчийн хувьд худалдан авагч нь болж худалдан авагчийн хувьд худалдагч’ нь болж “төлбөр тооцоог баталгаажуулагч” нь болдог.

Санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хуульд зааснаар Клирингийн төв нь бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглодог бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн лицензийн эрх Ерөнхий сайдаас олгосон тохиолдолд бизнесийн үйл ажиллагаа явуулах эрхтэй. Мөн Ерөнхий сайд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд клирингийн төвийн үйл ажиллагааны тайланд аудит хийлгэх эрхтэй ажилладаг.

Үнэт цаасны арилжааг биржийн ба биржийн бус гэж ангилан үзэх бөгөөд биржийн арилжааны клирингийн үйл ажиллагааг Japan Securities Clearing Corporation /JSCC/ буюу “Японы үнэт цаасны төлбөр тооцооны корпораци” эрхлэн явуулдаг бол биржийн бус арилжааны клирингийн үйл ажиллагааг JASDEC DVP Clearing Corporation /JDCC/ эрхлэн явуулдаг. Харин Japanese Government Bond Clearing Corporation /JGBCC/ буюу “Японы Засгийн газрийн бондын төлбөр тооцооны корпораци” нь Японы Засгийн газрийн бондын арилжааны клирингийн үйл ажиллагааг хийх үүрэгтэй байдаг.

### Клирингийн байгууллагын үндсэн чиг үүрэг

1. Талууд эрх үүргийг хүлээн авах /Assumption of obligations/
2. Нэттинг хийх /Netting/
3. JASDEC болон Японы төв банк /Арилжааны банкинд төлбөр тооцооны заавар өгөх /Settlement instructions/
4. Төлбөр тооцооны баталгаа гаргах /Settlement guarantee/.

### Талууд эрх үүргийг хүлээн авах /Assumption of obligations/

Арилжаа хийгдснээр худалдагч нь үнэт цаасыг шилжүүлэх үүрэг хүлээж, үүний хариуд төлбөрийг хүлээн авах эрх олж авдаг бол худалдан авагч нь төлбөрийг төлөх үүрэг хүлээж, үнэт цаасыг хүлээн авах эрхийг олж авдаг. Талуудын хооронд үссэн эдгээр эрх, үүргийг Клирингийн байгууллага нь хүлээн авч, худалдааны төлбөр тооцоо хийх жинхэнэ тал нь клирингийн байгууллага болон өөрчлөгддөг. Ингэснээр талууд арилжааны негөө талын зээлийн эрсдэлд санаа зовохгүйгээр арилжаанд оролцох боломжтой болдог.

### Нэттинг хийх /Netting/

Клирингийн байгууллага нь төлбөр тооцооны үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор зохицуулалт хийх ба худалдах, худалдан авах үнэт цаас болон мөнгөн төлбөрийн нийт

<sup>34</sup> <http://www.tse.or.jp/english/rules/clearing/index.html>

<sup>35</sup> <http://www.tse.or.jp/english/rules/clearing/index.html>

дүнг тэнцүүлэн тохируулна.

### **JASDEC болон Японы төв банк /Арилжааны банкинд төлбөр тооцооны заавар өгөх/ Settlement instructions**

Клирингийн байгууллага нь төлбөрийн нийт үнийн дүнг тодорхойлох ба клирингийн оролцогчдод энэхүү үнийн дүнг мэдэгдэнэ. Төлбөр тооцооны байгууллагад мөн мэдэгдэх ба тэд төлбөр тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Төлбөр тооцоо хийх аргаас хамааран клирингийг талуудад клирингийн байгууллагын мэдэгдлийн дагуу төлбөр тооцооны байгууллагаас заавар өгөх арга хэмжээг авна.

### **Төлбөр тооцооны баталгаа гаргах /Settlement guarantee/**

Энэхүү баталгаа нь оролцогч талуудын арилжааны аюулгүй байдлыг хангах зохицуулалт юм. Клирингийн байгууллага нь талуудын хувьд төлбөр тооцоо хийх тал болж байдаг тул клирингийн нэг тал төлбөр тооцоо хийх боломжгүй болсон нөхцөлд хохирол нь JSCC буюу үнэт цаасны төлбөр тооцооны корпорацид учирдаг. Иймд JSCC нь дараах байдлаар төлбөр тооцоог баталгаажуулдаг байна. Үүнд:

- а. Зөрчил гаргасан оролцогчийн JSCC - ийн клирингийн санд хадгалагдаж байгаа актив хөрөнгөөр хохирлыг нөхөн төлүүлдэг.
- б. Хохирлыг барагдуулахад дээрх актив хөрөнгө нь хангалтгүй байгаа нөхцөлд бусад оролцогчдод үлдсэн хохирлыг барагдуулах үүрэг үүсдэг. Хохирлыг барагдуулах үйл ажиллагаа нь зөрчил гаргасан тал зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчимд суурилдаг хэдийч “2 талын баталгаа” гаргасан тохиолдолд дээрх байдлаар бусад оролцогчдод хохирлын үлдсэн хэсгийг барагдуулах үүрэг үүсдэг.

### **Мэдээллийн аюулгүй байдал**

Дэлхий нийтийн мэдээллийн техникийн хөгжил болон техник ашиглан мэдээлэл тараах явдал ихэссэн тул 2005 оны 4 дүгээр сард хувийн нууцыг хамгаалах тухай хууль батлагдан гарсан. Энэ хууль нь:

- Нийтлэх, гомдлыг авч үзэх, судалгаа хийх, суралцах, хамтран ажиллах;
- Захиргааны байгууллага хувийн нууцыг хамгаалах;
- Тусгай салбаруудад авдаг онцгой арга хэмжээ (нийгмийн халамж, санхүү гм.)
- Хувийн мэдээлэлтэй холбоотой гомдол, санал авах газруудад хамааралтай юм.

Энэ хуулиар бизнесийн байгууллагууд тус бүртээ хувийн нууцын дүрэм, журам боловсруулах, нууцыг хянах систем боловсруулан хариуцлага тооцох, ажилтнуудыг сургах гэх мат асуудлыг хариуцан ажиллах үүрэгтэй байдаг. JASDEC нь төлбөр тооцооны дэд бүтцийг авч явдагийн хувьд маш том хэмжээний мэдээллийг хадгалдаг бөгөөд нийгмийн үүргээ биелүүлэхийн тулд JASDEC нь мэдээллийг аюулгүй удирдах нь маш чухал байдаг<sup>36</sup>.

### **JASDEC-н Хувийн мэдээллийг хамгаалах талаарх бодлого:**

1. Хувийн мэдээллийг олж авах:  
JASDEC нь хувийн мэдээллийг зохих журмаар буюу хууль дүрмийн дагуу олж авна.
2. Хувийн мэдээллийг ашиглах зорилгоор хэвлэх:

<sup>36</sup> [www.jscct.co.jp/en/cash/csd.html](http://www.jscct.co.jp/en/cash/csd.html)

JASDEC нь хувийн мэдээллийг ашиглах зорилгоо журмандаа тодорхой заах бөгөөд хууль тогтоомжинд зааснаас өөр зорилгоор хувийн мэдээллийг ашиглах, хэвлэх, мэдээлэхийг хориглоно.

3. Хувийн мэдээллийг ашиглах:

JASDEC нь “хувийн мэдээллийн тухай журмандаа”<sup>37</sup> заасан хүрээнд хувийн мэдээллийг ашиглана.

4. Хувийн мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах:

Хувийн мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн, үнэн зөв байлгахыг зорино.

5. Ажилтнуудыг сургах:

Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах менежментийн хүрээнд хувийн мэдээллтэй харьцдаг ажилтан, албан хаагчиддаа зохих хяналт тавих төдийгүй тэдний хувийн мэдээллийг хамгаалах тухай мэдлэгийг дээшлүүлэх үүднээс сургалтанд хамруулна.

6. Хувийн мэдээллийг нууцлан хамгаалах:

JASDEC нь хувийн мэдээлэл гэмтэх, алдагдах, өөрчлөгдхөн зэргээр хор хохирол учрахаас сэргийлэхийн тулд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зохих ёсоор, байнга хяналт тавина.

7. Гуравдагч этгээдээс хамгаалах

Хууль тогтоомжид зааснаас өөрөөр тухайн этгээдийн зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд өгч задруулахгүй. Хувийн мэдээллийг зөвшөөрөлтэйгээр, хуульд заасны дагуу гуравдагч этгээдэд өгч болно.

8. Хувийн нууцыг хамтран ашиглах:

Хувийн мэдээллийг гуравдагч этгээдтэй хамтран ашиглахдаа журам батална.

9. Гэрээт байгууллагуудыг хянах:

10. JASDEC нь хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд ашиглуулахдаа мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаад зохих ёсоор хяналт тавина.

11. Хувийн мэдээллийг нийтэд мэдээлэх:

Хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол JASDEC нь хувийн мэдээллийг нийтэд мэдээлэх, засварлах, түтгэлзүүлэх эрх бүхий этгээдийн гаргасан хүсэлтийн үндсэн дээр тэднийг мэдээллээр хангаж болно.

12. Лавлагаанд хариулах:

JASDEC нь өөрийн зохицуулж буй хувийн мэдээллийн тухай лавлагаа болон саналыг хүлээн авна.

13. Хувийн мэдээллийг хамгаалах систем:

Хувийн мэдээллийг хянах, зохицуулах ерөнхий үүргийг JASDEC-ын ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал нар хариуцана. Мөн хувийн мэдээллийг хамгаалах нэгдсэн системийг байнга шалгаж, шинэчлэх төдийгүй хөгжүүлэхэд анхаарч ажилна.

14. Хууль биелүүлэх:

JASDEC нь хувийн мэдээллийн тухай журам болон холбогдох бусад стандартад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

15. Хувийн мэдээллийг хамгаалах бодлогыг шинэчлэх:

JASDEC нь нийгмийн нөхцөл байдал болон холбогдох хууль тогтоомж өөрчлөгдсөн-тэй холбогдуулан хувийн мэдээллийг хамгаалах бодлогоо шинэчилнэ.

<sup>37</sup> Санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хуулийн 156 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

## JASDEC-ын хувийн мэдээллийг хамгаалах дотоод журам

Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлогод<sup>38</sup> үндэслэн энэхүү журамд JASDEC-ын хувийн мэдээллийг ашиглах зорилго, зориулалт болон ашиглах үйл явцыг тодорхойлсон болно.

1. JASDEC-д хамаарах хувийн мэдээлэл  
Нэр, хаяг, утасны дугаар, е-мэйл, төрсөн он, сар, өдөр, хүйс, эрхэлдэг ажил.
2. JASDEC-ын Хувийн мэдээллийг лавлах зорилго:  
Үнэт цаасны бүртгэлийг зөв хөтлөхийн тулд;
  - JASDEC-ын бизнес хамтрагчтай үйл ажиллагаа явуулахын тулд;
  - Асуулт хариултаар зах зээлийн судалгаа болон зах зээлийг үнэлэхийн тулд;
  - JASDEC-ын сургалт уулзалтад хамруулахын тулд;
  - Эрхийг нь хэрэгжүүлэх ба иргэнийг тодруулахад;
  - JASDEC-ын үйл ажиллагааны асуултанд хариу өгөх зорилгоор тус тус нэхэмжилнэ.
3. JASDEC-аас хувийн мэдээлэл лавлах тухай:  
JASDEC-аар зохицуулагдаж байгаа мэдээллийг нийтэд мэдээлэх, засварлах, түдгэлзүүлэх тухай аливаа хүсэлтийг журмын дагуу гаргана. Хүсэлтийн хэлбэрийг JASDEC-с е-мэйл болон шуудангаар илгээнэ. Хүсэлтээ JASDEC-ийн оффисын хаяг руу илгээнэ. Хувийн мэдээлэл задрахаас сэргийлэх зорилгоор хүсэлт гаргач этгээд нь баталгаатай байгаа нөхцөлд л мэдээлэл өгөх, засах, түтгэлзүүлэхийг зөвшөөрнө.

Мэдээллийн аюулгүй байдлын журмын ерөнхий зарчим нь:

1. Мэдээллийн аюулгүй байдалд захиргааны хяналт тогтоох  
JASDEC групп нь шударга, итгэл даах удирдлагын хүрээтэй ба удирдах албан тушаалтан болон ажилтнууд нь үүргээ ухамсарлан амлалт өгөн ажилладаг. Өөрөөр хэлбэл, Үнэт цаасны тухай хууль болон хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, группын дотоод дүрмийн дагуу ажилладаг.
2. Мэдээллийн аюулгүй байдлыг бүхэлд нь хянах систем тогтоох  
JASDEC групп нь мэдээллийн аюулгүй байдалд зөвшөөрөлгүй нэвтрэх, мэдээлэл алдагдах, хуурамч мэдээлэл оруулах, мэдээлэл устах, нөлөөлөх, болон мэдээлэл тасрах зэрэгээс бүрэн хамгаалах аргыг хэрэгжүүлэн ажилладаг.
3. Мэдээллийн аюулгүй байдлыг ойлгон сайжруулах  
JASDEC групп нь мэдээллийн аюулгүй байдлын сургалт, боловсролыг удирдлага болгон ажилладаг бөгөөд ажилтнууд нь мэдээллийн аюулгүй байдлыг сайтар ухамсарлан ойлгон үйл ажиллагаагаа явуулдаг.
4. Дотоод аудит нэвтрүүлэх  
JASDEC групп нь мэдээллийн аюулгүй байдлыг хянан ажиллаж дотоод аудитыг хуулийн дагуу оруулдаг ба хурдан хувьсан өөрчлөгддөг цаг үедээ тохируулан санал хариултыг тусган ажилладаг болно.
5. Гэрээт ажилтанг албан ёсоор хяналтанд хамруулах  
Гэрээгээр тохиролцон бусдаар мэдээллийн ажлыг хийлгэх болсон нөхцөлд зөвхөн үйл ажиллагааны найдвартай байгууллагыг сонгон ажиллуулдаг. Мөн тус

<sup>38</sup> [www.jsc.co.jp/en/cash/ccp\\_kikan.html](http://www.jsc.co.jp/en/cash/ccp_kikan.html)

байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин тайлан гарган мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлнэ.

Япон улсад Мэдээллийн аюулгүй байдлыг тусгай стандарт бүхий системээр хамгаалдаг бөгөөд тухайн мэдээлэлд зөвшөөрөлгүй иргэн, байгууллагууд нэвтрэх боломжгүй, үнэн зөв, бүрэн бодит байдалд хамгаалалт хийж чаддаг, эрх бүхий байгууллага шаардсан үед мэдээллийг хэрэглэх боломжтой. Үнэт цаасны хадгаламжийн төв JASDEC групп нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бүтэцтэй ба энэ нь дотроо:

#### A. Эрдслийн удирдлагын хороо

Хороо нь нийт эрсдлийг бууруулах арга хэмжээг авдаг ба дотоод системд байнгын хяналтыг явуулдаг.

- Дарга: Захирал
- Гишүүд: Удирдах захирал (орон тооны ажилтан)
- Аудитор (орон тооны ажилтан)
- Бүх салбарын захирал нар
- Нарийн бичиг: Байгууллагын төлөвлөгөөний алба гэсэн бүтэцтэй.

#### B. Дотоод аудит

Аудитын төлөвлөгөөг үндэслэн JASDEC нь гомдол хүлээн авах газар байгуулсан ба дотоод аудитын систем нь санал асуулгаар дамжуулан үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгдөг. Япон улсад Санхүүгийн хэрэгсэл ба Арилжааны тухай хууль, Бонд болон хувьцаа шилжүүлэх тухай акт гэсэн хоёр үндсэн эрхийн актаар үнэт цаасны хадгаламжийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг. Үнэт цаасны бүртгэл, шилжүүлэг, хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаа нь Ерөнхий сайд /Санхүүгийн байгууллагын захирал/-ын эрхлэх асуудлын хүрээнд байдаг ба ямар нэгэн тусгай зөвшөөрөл шаардлагагүй, харин хэд хэдэн болзول хангасан тохиолдолд ерөнхий сайдын зөвшөөрснөөр үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Япон улсад биржийн ба биржийн бус гэсэн арилжаа хийгддэг бөгөөд Үнэт цаасны төв хадгаламжийн төв /JASDEC групп/ аль алинд нь оролцдог. Үнэт цаасны төлбөр тооцоог Япон Улсын үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог төв банкаар дамжуулан гүйцэтгэдэг. JASDEC групп нь Tokyo stock exchange буюу Токиогийн хөрөнгийн биржээс тусдаа үйл ажиллагаа явуулдаг төдийгүй бие даасан хадгаламж, төлбөр тооцооны тухай хуультай.

Харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг Олон Улсын стандартад нийцсэн тусгай програмын тусламжтайгаар хадгалдаг бөгөөд харилцагчдын өмчийг хамгаалсан гэрээ байгуулан ажилладаг. Харилцагчийг хамгаалах гэрээ нь хуулийн дагуу хийгдэх ба түүний зорилго нь хувьцаа эзэмшигчдийн өмчийг данс бүртгэлийн байгууллага болон дансны бүртгэл шилжүүлэх байгууллагуудын алдаанаас буюу буруу бүртгэгдэх, алдагдах зэрэгээс хамгаалах гэрээ юм. Гэрээний бүтэц нь:

- Итгэмжлэгч буюу JASDEC групп
- Итгэмжлэгдсэн этгээд буюу банк
- Гэрээг гүйцэтгэгч нь Японы диллерүүдийн холбоо
- Гэрээний хөрөнгө гэсэн бүтэцтэй байна.

Бүртгэлийн байгууллага болон шилжүүлгийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг харилцагчийг хамгаалах данснаас төлдөг тогтолцоотой байдаг байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах буюу нууцын тухай хуультай улс бөгөөд хувь хүний нууцтай холбоотой аливаа мэдээллийг тараахыг хориглосон ерөнхий заалттай. Энэ хуулиар бизнесийн байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний нууцтай холбоотой дотоод журам гаргаж мөрдүүлэхийг үүрэг болгосны дагуу JASDEC групп нь мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах дотоод журмыг удирдах зөвлөлөөс баталсан.

## БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

### Солонгосын Үнэт цаасны хадгаламжийн газар /KSD/

1974 онд Солонгосын Үнэт цаасны зохицуулах корпораци нь үнэт цаасны арилжааг зохицуулах тогтолцооны хурд, нарийн нягт байдлыг сайжруулах зорилгоор байгуулагдсан ба 1994 онд уг корпорацийг бүтцийн өөрчлөлтөнд оруулж, түүний суурин дээр үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, ашгийн бус “Солонгосын үнэт цаасны хадгаламжийн төв” хэмээх байгууллагыг байгуулсан.

Солонгосын үнэт цаасны хадгаламжийн төвийн голлох чиг үүрэг нь үнэт цаасны шилжүүлгийн бүртгэл, хадгаламжийн аюулгүй байдал, хувьцааны ногдол ашгийн төлбөр, бондын хүү, клиринг бөгөөд уг төв нь Солонгосын хөрөнгийн бирж болон KOSDAQ-ийн үйл ажиллагааны төлбөр тооцооны байгууллага бөгөөд гэрээний үндсэн дээр төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэж байх хооронд Солонгосын хөрөнгийн бирж нь клирингийн үйл ажиллагаа явуулж байдаг. Солонгосын үнэт цаасны хадгаламжийн төв нь клирингээс авахуулаад байрших хүртэл KOSDAQ-ийн ижил төрлийн хөрөнгө оруулагчидтай хийх шилжүүлэг, тэр дундаа үнэт цаасны шилжүүлгийг ерөнхийлөн хариуцдаг<sup>39</sup> мөн уг төв нь эрх олгох, хэрэгжүүлэх, шинээр олгох, хадгаламж болон байршуулалт гэх мэт үнэт цаастай холбоотой олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг Солонгосын цорын ганц үнэт цаасны төв хадгаламжийн байгууллага юм.

Солонгосын хөрөнгийн бирж болон үнэт цаасны хадгаламжийн байгууллагууд нь тусдаа байдаг бөгөөд хадгаламжийн байгууллагууд нь үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагуудыг эзэмшиж байна. Солонгосын үнэт цаасны хадгалалтын компанийг ойролцоогоор 100 компани хувь нийлүүлж эзэмшдэг. Үүнд: Солонгосын үнэт цаасны диллерийн холбоо, үнэт цаасны компаниуд, банкууд, даатгалын компаниуд зэрэг орно. Эдгээрээс хамгийн том хувь нийлүүлэгч нь Солонгосын үнэт цаасны диллерүүд бөгөөд тэд нийт хувьцааны 70%-ийг эзэмшдэг.

Үнэт цаас хадгаламж гэдэг нь бодит хөдөлгөөний биет гэрчилгээгүйгээр үнэт цаасыг бүртгүүлэх, шилжүүлэх, өөрчлөх болон хүчингүй болгох эрх бүхий ажиллагаа юм. Брокер, санхүүгийн байгуулага гэх мэт оролцогчид үнэт цаас хадгаламжийн системээс ашиг олох зорилгоор Үнэт Цаас Хадгаламжийн Төв Газарт данс нээх болон үнэт цаасыг хадгалаалах шаардлагатай болдог. Солонгос Үнэт Цаасны Хадгаламжийн газар /Ки Эс Ди/ нь Солонгос дахь цорын ганц Си Эс Ди / Central Securities Depositories Үнэт Цаас Хадгаламжийн Төв Газар/ бөгөөд үнэт цаас хадгаламжийн үйчилгээ үзүүлдэг.

### KSD-ийн Төлбөр тооцооны үе шат

KSD-ийн Төлбөр тооцооны үе шат нь /T+2/ үнэт цаасны гүйлгээ болон KSD нь DVP загвар 3-ийг ашигладаг. Одоогоор Ки Эс Ди нь арилжааны гүйлгээ, нэг төрлийн гүйлгээ болон OTC гүйлгээ зэрэг төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг ба биржийн хувьцааны тодорхой хэсгийг худалдаалах бүхий л үйл явц /худалдааны тайлан, баталгаа, бүтээгдэхүүний

<sup>39</sup> Korean Securities Market in Transition. Sang-Koo Nam, Kyung Suh Park, and Yu Kyung Kim

төлбөр тооцоо болон төлбөр тооцооны үр дүнгийн талаарх мэдээлэл/ нь Ки Эс Ди -ээр дамжиж хийгддэг бөгөөд Ки Эс Ди -ийн үйл ажиллагаа нь биржийн хувьцааны тодорхой хэсгийг худалдаалах автоматчилагдсан стандартчилагдсан үйлчилгээгээр удирдагдаж явагддаг.

### **Үнэт цаасны хадгаламжийн байгууллагад бүртгүүлсэний давуу тал:**

Ки Эс Ди арилжааг үнэт цаасны бодит хөдөлгөөнгүйгээр нэвтрэх дансаар зохицуулах тул оролцогч болон тэдгээрийн харилцагчид үнэт цаасаа худалдсан тохиолдолд авахгүйгээр Ки Эс Ди-д байршуулж, Ки Эс Ди энэ үйлчилгээг тэдний өмнөөс хийдэг. Мөн түүнчлэн KSD нь бондын бүртгэл болон үнэт цаасыг зээлүүлэх брокерийн албыг ажилуулдаг.

### **Солонгосын үнэт цаасны хадгаламжийн газрын үйл ажиллагаа:**

- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж
- Үнэт цаасны дэвтэр дээр бичилт хийх, шилжүүлэг хийх
- Хувьцааны зах зээлийн дотор болон гадна хийгдсэн үнэт цаасны шилжүүлгийг байршуулах
- Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын байгууллагад данс нээх замаар шилжүүлгийг байршуулах, болон үнэт цаасыг шилжүүлэх дэвтэрт тэмдэглэл хөтлөх, хадгалах
- Үнэт цаастай холбоотой агентын үйлчилгээний шилжүүлэг (ногдол ашгийн төлбөр, үйлчлүүлэгчийг төлөөлөн үнэт цаас болон түүний гаргалттай холбоотой хүү болон үндсэн буцаан төлөлт гэх мэтийг оруулан)
- Үнэт цаасны тусгай хадгаламж
- Бондны бүртгэлийн үйлчилгээ
- Үнэт цаасны нэгдсэн сертификатын маягтын хэрэгжилт
- Үнэт цаасны зээлэх болон зээлдүүлэхтэй холбоотой зуучлагчийн үйлчилгээ
- Фьючерсийн (опционыг оролцуулан) гүйлгээтэй холбоотойгоор үнэт цаасны менежментийн үйлчилгээг орлон гүйцэтгэх
- Фьючерсийн (опционыг оролцуулан) гүйлгээтэй холбоотойгоор үнэт металын дипозитийн үйлчилгээг үзүүлэх
- Санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ болон хөрөнгийн зах зээлийн хууль болон бусад хуулийн зүйл заалтаар үүрэг болгосон бусад үйлчилгээ
- Мэдээллийн үйлчилгээ
- Дээр жагсаасан үйлчилгээ тус бүртэй холбоотой зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Үл хөдлөх хөрөнгө хөлслөх, түрээслэх
- Дээр дурьдсан үйлчилгээ нэг бүртэй зайлшгүй холбоотой бусад үйлчилгээ

Эрсдлийн олон талт менежментийг бий болгох зорилгоор Солонгосын Үнэт Цаасны Хадгаламжийн Газар 2010 оны 1 дүгээр сараас дотоодын хяналтын системийг нэвтрүүлсэн. Энэхүү тогтолцоо нь ажилтан, албан хаагчдын ажлын хэрэгжилтийн нөхцөл байдал, ажил үүрэгтэй холбогдох эрсдэл болон бизнесийн үйл ажиллагаа зэргийг хянах боломж олгодог учраас үйл ажиллагааны эрсдлийг дээд зэргээр багасгадаг.

### **Солонгосын үнэт цаасны хадгаламжийн төвд хяналт тавих эрх бүхий байгууллага**

Солонгосын Үнэт Цаасны Хадгаламжийн Газар нь Стратеги, Санхүүгийн Яам, Санхүүгийн удирдлага хяналтын хороо болон Санхүүгийн Хяналт удирдлагын үйлчилгээ зэрэг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлага хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг ба Санхүүгийн зах зээлийн үндсэн зохицуулалтын хяналтын бүтэц нь 1976

онд Үнэт цаас ба арилжааны хуулиар бий болсон юм. Үнэт цаас ба арилжааны хороо болон түүний гүйцэтгэх байгууллага болох Үнэт цаасны удирдах зөвлөл нь 1977 оны 2 дугаар сарын 19 -ны өдөр Үнэт цаас ба арилжааны хуулийн дагуу байгуулагдан ба 1997 оны Санхүүгийн шинэчлэлийн хуулиар тус улсын хөрөнгийн зах зээлийн хамгийн чухал өөрчлөлтүүд бий болсон.

Үг хуулиар санхүүгийн шинэчлэлийн “Том тэсрэлт” загвар нь FSC буюу Санхүүгийн хяналтын хороо нь үнэт цаасны хяналтын чиг үүргийг гүйцэтгэх болсон. Санхүү, эдийн засгийн яамны хяналтын чиг үүргийн дийлэнх нь Санхүүгийн хяналтын хороонд шилжсэн. Гэсэн хэдий ч Санхүү, эдийн засгийн яам нь санхүүгийн зах зээл дэх томоохон эрх мэдэл бүхий байгууллага хэвээр тул зарим нэг зохицуулалтын эрх мэдэл нь Санхүүгийн хяналтын хорооны чиг үүрэгтэй давхсан, зөрчилдөөнийг үүсгэдэг байна. Иймд үнэт цаасны зах зээлд тавих хяналтыг илүү үр өгөөжтэй болгохын тулд Санхүү, эдийн засгийн яам нь бодлого тодорхойлох, Санхүүгийн хяналтын хороо нь бодлогыг хэрэгжүүлэх буюу хууль сахиулах чиг үүрэгтээ илүү анхаарал хандуулах хэрэгтэй.

Санхүүгийн шинэчлэлийн хууль нь 1998 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр батлагдаж Санхүүгийн хяналтын хорооны мэдэлд үнэт цаасны зах зээлийн хяналтын хариуцлагыг багтааж, ингэснээрээ санхүүгийн хяналтын тогтолцоог нэгтгэж чадсан. Тус хороо нь өөрийн бие даасан, эрх тэгш байдлыг хангахын үүднээс Санхүү, эдийн засгийн яамны сайдын мэдэлд бус Ерөнхий сайдын бүрэн эрх дор байдаг. 1999 онд тус тусдаа салангид байсан хяналтын гүйцэтгэх нэгжүүд нэгдэж, Санхүүгийн хяналтын хороо хэмээх нэг бүтцэд нэгдсэн бөгөөд одоогийн байдлаар тус хороо нь санхүүгийн бүхий л нэгжийг тухайлбал, банк, үнэт цаасны зах зээл, даатгалын салбарыг хянадаг. Санхүү, эдийн засгийн яам өөрийн банк бус санхүүгийн байгууллагыг хянах хяналтын чиг үүргээ Санхүүгийн хяналтын хороонд шилжүүлсэн.

### **Солонгосын үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд**

Дараахь зохион байгуулалтын нэгжүүд Солонгос улсын үнэт цаастай холбогдох үйл ажиллагааг явуулна.

1. Санхүү, эдийн засгийн яам (Ministry of finance and economy)
2. Санхүүгийн хяналтын хороо (Financial supervisory commission)
3. Үнэт цаас ба ирээдүйн хороо (Securities and futures commission)
4. Санхүүгийн хяналтын алба (Financial supervisory service)
5. Өөрийгөө удирдах байгууллага (Self regulatory organizations)
6. Санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн хүрэлцээ (Capital Adequacy of Financial Institutions)
7. Төв хадгаламж ба Dematerialization-ыг сахиулах (Enforcement of Central Deposit and Dematerialization)
8. Зохицуулах байгууллагуудыг цомхотгох (Streamlining the Settlement Organization)
9. Үнэт цаасны компаниудын эзэмшилийн бүтэц (Ownership Structure of Securities Companies)
10. Солонгосын хөрөнгийн бирж (Korea stock exchange)
11. Солонгосын үнэт цаасны диллерүүдийн холбоо (Korea securities dealers association)
12. Солонгосын үнэт цаасны хадгаламж (Korea securities depository)
13. Солонгосын үнэт цаас, санхүүгийн корпораци (Korea securities finance corporation)
14. Үнэт цаасны компаниуд (Securities companies)

### **Санхүү, эдийн засгийн яам (Ministry of finance and economy)**

Санхүү, эдийн засгийн яам нь үнэт цаасны зах зээлийн дээд эрх бүхий байгууллага хэдий ч ихэнх хяналтын чиг үүргээ Санхүүгийн хяналтын хорооны мэдэлд шилжүүлсэн ба одоогоор тус яам нь үнэт цаасны зах зээлтэй холбоотой хууль, дүрэм, журам санаачлах, боловсруулах зэрэг үүрэгтэй. Мөн **шинэ санхүүгийн байгууллагуудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох** болон санхүүгийн байгууллагуудыг чухал хэрэгцээт бичиг баримт болон нэмэлт мэдээлэлээр хангах эрхтэй бөгөөд тус яам нь үнэт цаасны зах зээл болон харьяа байгууллагуудыг хянах эрх мэдэл нь хязгаарлагдмал боловч захирагааны хариуцлага болон ёс суртахууны зөрчил гэх мэтээр тэдгээрийн үйл ажиллагааг хянасаар ирсэн нь зарим тохиолдолд Санхүүгийн хяналтын хорооны чиг үүрэг, эрх мэдэлтэй давхцан, зөрчил үүсгэдэг.

### **Санхүүгийн хяналтын хороо (Financial supervisory commission)**

Санхүүгийн хяналтын хороо нь одоогоор Солонгосын санхүүгийн эрх мэдлийн зарим хэсгийг санхүү, эдийн засгийн яамнаас шилжүүлэн авч хэрэгжүүлж байгаа. Үүнд: банкны үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээл, даатгалын салбар хамаардаг. Үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг ихэвчлэн дээрх санхүүгийн хяналтын хороонд гаргадаг мөн ерөнхийлөгчийн зарлигаар тусгайлан эрх олгож эрхлэх үйл ажиллагаа байх ба тэдгээр үйл ажиллагааг эрхлэхийн тулд ерөнхийлөгчийн зарлигт үндэслэн Санхүүгийн хяналтын хороонд бүртгүүлснээр эрх нь олгогддог.

Санхүүгийн хяналтын хорооны зөвлөл нь тэргүүлэгч, дэд тэргүүлэгчийг оролцуулан нийт 9-н гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд тэргүүлэгч болон дэд тэргүүлэгчийг ерөнхийлөгч томилдог ба санхүүгийн хяналтын хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд Санхүү, эдийн засгийн яамны дэд сайд, Солонгосын банкны дэд ерөнхийлөгч болон Солонгосын хадгаламжийн даатгалын корпорацийн ерөнхийлөгч байх ба үлдсэн 4-н гишүүнийг ерөнхийлөгч томилно. Энэ 4-н гишүүний 3 нь хугацаат, 1 нь байнгын гишүүн байна.

Санхүүгийн хяналтын хорооны тэргүүлэгч нь хороог төлөөлөх ба хорооны уулзалтыг даргалдаг. Тэргүүлэгч нь Санхүүгийн хяналтын хорооны хэрэгжүүлэгч байгууллага болох Санхүүгийн хяналтын албыг<sup>40</sup> мөн тэргүүлдэг. Санхүүгийн хяналтын хороо нь санхүүгийн зах зээлийг хянах дээд эрхт байгууллага юм. Хэдийгээр Санхүү, эдийн засгийн яам нь шинэ хууль, дүрэм, журам боловсруулах бүрэн эрхтэй хэдий ч Санхүүгийн хяналтын хороо нь тэрхүү дүрэм, журманд нэмэлт өөрчлөлт оруулах, эрхтэй. Түүнчлэн Санхүүгийн хяналтын хороо нь санхүүгийн хяналтын хуулинд нөлөөлөх, санхүүгийн байгууллагыг шалгах, хууль зөрчсөн этгээдүүдийн эсрэг үйл ажиллагаа явуулах эрхтэй

### **Үнэт цаас ба фьючерсийн хороо (Securities and futures commission)**

Салангид болон бие даасан зохицуулалтын нэгж болох Үнэт цаас ба ирээдүйн хороо нь үнэт цаасны зах зээлд холбогдолтой голлох асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан. Үнэт цаасны ба ирээдүйн хороо нь Үнэт цаасны арилжааны хорооны<sup>41</sup> ихэнхи үүрэг, хариуцлагыг хүлээн авсан. Тус хороо нь 5-н гишүүнээс бүрддэг. Гишүүдийн бүрэлдэхүүнд Санхүүгийн хяналтын хорооны дэд ерөнхийлөгч байх ба тэрээр Үнэт цаас ирээдүйн хорооны дарга байна. Үлдэх 4-н гишүүнийг Санхүүгийн хяналтын хорооны даргын саналыг үндэслэн Ерөнхийлөгч томилно. Эдгээрийн 3 нь түр зуурын, нэг нь байнгын гишүүнчлэлтэй.

<sup>40</sup> Мөн тэнд.

<sup>41</sup> <http://www.ksd.or.kr/eng/html/introduction/history.home>

### Санхүүгийн хяналтын алба (Financial supervisory service)

Санхүүгийн хяналтын алба нь Санхүүгийн хяналтын хороо болон Үнэт цаас ба ирээдүйн хороодын тогтоолыг биелүүлэх, хорооны шууд удирдлаган доор санхүүгийн зах зээлийг хянах зорилгоор 1999 онд байгуулагдсан. Тус алба нь дарга, түүний орлогч дөрвөн гишүүн, болон нэг аудиторын бүрэлдэхүүнтэй.

### Өөрөө удирдах байгууллага (Self regulatory organizations)

Тус улсын хөрөнгийн зах зээл дэх хамгийн чухал хоёр өөрөө удирдах байгууллага<sup>42</sup> бол Солонгосын Хөрөнгийн бирж болон Солонгосын үнэт цаасны диллерүүдийн холбоо юм. 1998 оны байдаар Солонгосын Хөрөнгийн Бирж нь ашгийн бус 38 энгийн гишүүд, үүний 7 нь гадны болон хамтарсан үнэт цаасны компани мөн онцгой 5 гишүүдтэй байсан. Эдгээр нь<sup>43</sup> үнэт цаасны худалдаа болон тэрхүү зах зээл дэх өрсөлдөөний шударга байдлыг хангах, хянан зохицуулах бүрэн эрхтэй.

Түүнчлэн гишүүн фирмүүд болон тэдгээрийн үйлчлүүлэгчдийн гомдол, санал, худалдааны аливаа доголдолтой үйл ажиллагааг Солонгосын хөрөнгийн биржийн дүрэм, журмын дагуу хянана. Мөн Үнэт цаас ба ирээдүйн хороотой хамтран ажиллаж, хууль бус арилжаа, залилан, дотоод худалдаанд анхаарал хандуулдаг. Гэсэн хэдий ч Үнэт цаас ба ирээдүйн хорооны мөрдөн шалгах эрх хэмжээ нь Солонгосын хөрөнгийн биржийн эрх хэмжээтэй давхzan, зөрчил үүсгэдэг.

Энэ нь шинэ үнэт цаасны зохицуулах тогтолцоо хэрэгтэй буйг сануулсан чухал асуудлыг хөнддөг. Мөн Үнэт цаас ба ирээдүйн хорооны эрх хэмжээ нь өргөжин худалдааны практик, бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, гишүүн фирмүүдийн хүрэлцээгүй байдал зэрэгт оролцлоо болсноор энэ нь Солонгосын хөрөнгийн биржийн өөрөө удирдлага, Үнэт цаас ба ирээдүйн хорооны удирдлага хоорондын зөрчил бий болгодог.

**Солонгосын үнэт цаасны диллерүүдийн холбоо** нь 1953 онд гишүүдийнхээ үйл ажиллагааг зохицуулах, гишүүд хоорондын зөрчлийг зохицуулах, өөрөө удирдах замаар үнэт цаасны зах зээлийг дэмжих зорилгоор байгуулагджээ. Тус холбооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс Санхүү, эдийн засгийн яам байнга оролцдог байдаас болоод тус холбоо нь өөрөө удирдлагатай байгууллага хэмээн тооцогдоггүй байсан. Харин явцын дунд арилжааны зах зээлд илүү мэргэшиж, тэр хирээр тэр дангаараа тэр бүх үйл явцыг удирдаж чадахгүйд хүрсэн юм. Ингэснээр өөрөө удирдах тогтолцоо нь төрийн зохицуулалтын чиг үүргийн заримыг авсан.

Ирээдүйд хөрөнгийн зах зээлд бие даасан, хариуцлага хүлээх чадвартай “өөрөө удирдах байгууллага” гол байр суурь эзлэх ёстой. Мөн төрийн зүгээс хөрөнгийн зах зээлийг удирдах явдлыг багасгаж, тэрхүү төрийн эрх хэмжээг “өөрөө удирдах байгууллага”-д шилжүүлэх үйл хэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй. Зөвхөн тэр цагт хөрөнгийн зах зээл төрөөс хамааралгүй болох юм<sup>44</sup>.

### Солонгосын үнэт цаас, санхүүгийн корпораци (Korea securities finance corporation)

Солонгосын үнэт цаас, санхүүгийн корпораци нь 1955 онд байгуулагдсан, тус улсын анхдагч болон хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны арилжааны санхүүжилтиг дэмжих чиг

<sup>42</sup> <http://www.ksd.or.kr/eng/html/introduction/history.home> /Хамгийн сүүлд 2011.6.4-ний өдөр үзсэн./

<sup>43</sup> Financial supervisory commision

<sup>44</sup> Korean Securities Market in Transition. Sang-Koo Nam, Kyung Suh Park, and Yu Kyung Kim. 57

үүрэгтэй байгууллага юм. Түүний санхүүжилтын хүрээ нь бие даасан хөрөнгө оруулагч нарт зориулсан margin loans, үнэт цаасны зээл болон хамтарсан хөрөнгө оруулагч нарт хандсан андеррайтинг үнэт цаасны зээл, үйл ажиллагааны зээл, үнэт цаасны зээлийн барьцааны зээл, мөн хөрөнгийн зах зээлийн байгууллага бөгөөд Үүнд: үнэт цаасны фирмд зориулсан үнэт цаасны худалдан авах зээл зэрэг хамаарна. Мөн хязгаарлагдмал орчин дахь үнэт цаасны хамгаалалт, хөрөнгийн биржид шинэхэн бүртгэгдсэн фирмийн эхний нийтэд зарласан хөрөнгийг хадгаламжинд хүлээн авах болон ахин худалдаж авах гэрээ болон буцаан өгөх ажиллагааг зохицуулна. Солонгосын үнэт цаас, санхүүгийн корпораци нь 15 хэлтэс, удирдах ажилтнууд багтаад нийт 318 ажилчидтай<sup>45</sup>.

### Үнэт цаасны компаниуд (Securities companies)

1998 оны байдлаар гадаад болон дотоодын хамтарсан фирмийг оролцуулаад 34 үнэт цаасны фирм Санхүү, эдийн засгийн яаманд бүртгэлтэй байсан, Эдгээр үнэт цаасны компаниуд нь андеррайтинг, деалинг, брокер гэсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. Санхүү, эдийн засгийн яам эдгээр компаниудыг үйл ажиллагааны хүрээнээс хамаарч, шаардгахаа хөрөнгийн хэмжээг багаар тооцсон. Гэсэн хэдий ч үнэт цаасны компаниуд хоорондоо үйл ажиллагааны стратеги, менежментээрээ төдийлөн ялгагддаггүй ба дээрх 3-н чиглэлээс брокерын үйл ажиллагаагаар дагнасан фирм төдийлөн байдаггүй учраас брокерын тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлт хамгийн доод түвшинд байна.

Мөн Санхүү, эдийн засгийн яамны зөвшөөрлөөр, үнэт цаасны компаниуд өөрийн гол бизнестээ нэмэлт байдлаар хөрөнгө оруулагч нарт зээл олгох, үнэт цаасны хадгалалт, Bond Management Fund /Үнэт цаасны удирдлагын сан-/ийн үйл ажиллагаа, корпоратив бондын баталгааны төлбөр зэрэг үйл ажиллагаа явуулна<sup>46</sup>.

### Үнэт цаасны хадгаламжийн байгууллагын тогтолцоо хэрхэн ажилладаг вэ?

Ки Эс Ди нь бизнес эрхлэгч, оролцогч тэдгээрийн харилцагч болон үнэт цаасны хадгаламж /үнэт цаасны эрхтэй хадгаламж/-аас бүрдэнэ. Үнэт цаас эзэмшдэг оролцогч данс хөтлөх дэвтэр дээрх зээл зарлагын тэмдэглэгээг Ки Эс Ди үндэслэн хадгаламж эзэмшиж, бүртгэх эсэхийг шийдвэрлэдэг ба Хууль ёсны нэгдсэн дансыг Ки Эс Ди болон оролцогчид бүртгэж хадгалдаг.



### Солонгосын хөрөнгийн бирж

/Korea Stock Exchange/ нь үнэт цаасны худалдаа болон хувьцаа, бонд, KOSPI дээрх фючерсийн зохицуулалтыг хийдэг ашгийн бус байгууллага бөгөөд Korea Securities

<sup>45</sup> Securities And Exchange Act (Republic of Korea)

<sup>46</sup> KDIC

Computer Corporation (KOSCOM); Korea Securities Depository (KSD) гэсэн 2 салбартай. Эдгээр нь Санхүү, эдийн засгийн яам болон Үнэт цаас ба ирээдүйн зөвлөлд үйл ажиллагаа мэдээлэх ба тэдэнтэй хамтран ажиллана. Мөн KSE, KOSDAQ-тай хамтран үнэт цаасны клиринг болон төлбөр тооцоо хийдэг ба дээрх төлбөр тооцоог хийхдээ Bank of Korea Wire (BOK-Wire)-тай хамтран хийдэг.

Солонгосын хөрөнгийн бирж ба KOSDAQ-ын үйлчилгээтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй. Энэ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй фирмүүдийн хувь эзэмшигчдийн гүйвуулгын зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг. Солонгост KSE, KOSDAQ зэрэг хөрөнгийн биржүүд байдаг ба **Солонгосын хөрөнгийн бирж** нь үнэт цаас, бонд зэрэг үнэт цаасны арилжааны зах зээлийг явуулах үүрэгтэй. Хөрөнгийн зах зээлд албан ёсны зуучлал хийх, гишүүн фирмүүдийг хянах, анхдагч зах зээлийг тодорхойлох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны арилжааг шударга явагдаж буйд хяналт тавих эрхтэй<sup>47</sup>.

Солонгосын хөрөнгийн бирж нь 1956 оны 2 дугаар сард байгуулагдаж тус улсын эдийн засгийн гол тоглогч байсаар ирсэн. Тэрээр ашгийн төлөө бус байгууллага бөгөөд 38 энгийн гишүүн, 5 онцгой гишүүний бүрэлдэхүүнтэй. Жирийн гишүүдийн 31 нь дотоодын үнэт цаасны фирм, 3 нь дотоодын ба гадаадын хөрөнгө оруулагчид хоорондын хамтарсан фирм, 4 нь гадаадын үнэт цаасны фирмүүд юм. Жирийн гишүүд нь хөрөнгийн биржид үнэт цаасны худалдаа хийх, Солонгосын хөрөнгийн биржид хөрөнгийн талаар нэхэмжлэл гаргах, нэгдсэн уулзалтанд санал өгөх эрхтэйгээс гадна захирлуудын зөвлөлд сонгдох эрхтэй. Онцгой гишүүд бол зөвхөн хөрөнгийн биржид худалдаа хийх л эрхтэй.



**Korea Securities Dealers Association (KSDA)** - Өөрөө удирдах байгууллагын бутэцтэйгээр 1953 онд байгуулгасан. Тус холбооны жирийн гишүүд нь үнэт цаасны фирмүүд байх ба банк, хөрөнгө оруулалт - итгэлцлийн компаниуд зэрэг үнэт цаастай холбоотой үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн институциуд юм. Холбоо нь гишүүдийн татвар, үнэт цаасны арилжааны төлбөрөөс үүдсэн нөөцийн фонд зэргээс санхүүжинэ.

Солонгосын үнэт цаасны диллерүүдийн холбоо нь 7 салбар, 4 хэлтэс, 4 оффистой. Тэрээр өөрийн гишүүн фирмүүдийг дэмжих, гишүүдийн хоорон дахь сонирхлын зөрчлийг зохицуулах, Солонгосын хөрөнгийн биржийн хөрөнгийн зах зээлийг бие даан зохицуулах

<sup>47</sup> Financial supervisory service

ажилд дэмжих үүрэгтэй. Ингэхдээ гишүүдийн үйл ажиллагаан дахь дүрмийг батлах, тэдний эрх ашгийг дээд шатны байгууллагын өмнө төлөөлөх зэрэг үйл ажиллагаа явуулна.

Тухайлбал, Солонгосын үнэт цаасны дилерүүдийн холбоо нь гишүүн фирмүүд болон хөрөнгө оруулагчид хоорондын маргаантай асуудлыг Хөрөнгө оруулагчдыг хамгаалах төв эвлэрүүлэх, зуучлахад нөлөө үзүүлэх болон гишүүн фирмүүдийн хөрөнгө оруулалтын шаардлага, хувьцаа худалдах ажиллагаанд “шударга Практикын дүрэм” -ийг сахиулах үүрэгтэй, өөрийн дотоод дүрэм бүхий байгууллага бөгөөд үнэт цаасны фирмүүд, үнэт цаастай холбоотой санхүүгийн байгууллага, банк болон хөрөнгө оруулалтын итгэмжлэгдсэн компаниудыг гишүүнчлэлдээ оруулан тэдгээрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг<sup>48</sup>.

#### **Үнэт цаасны зах зээлийг зохицуулж буй эрх зүйн актуудаас**

**Солонгосын үнэт цаас ба арилжааны тухай хууль /Securities And Exchange Act/ Энэхүү актаар үнэт цаасны арилжаа, худалдаа, бусад наймаа ба хуулийн дагуу үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийг хамгаалах, үнэт цаасны эргэлтийн хүрээг өргөтгэж идэвхижүүлэн үндэсний эдийн засгийн хөгжилд дэмжлэг болох зорилтыг дэвшүүлсэн. Үнэт цаасны зах зээлийн гол эрх зүйн акт юм. Уг хуулиар үнэт цаасны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч этгээд, тэдгээрийн эрхлэх үйл ажиллагааны төрөл болон эрх олгох, бүртгэх, үнэт цаасын төрөл, “securities business” буюу үнэт цаасны үйл ажиллагааны төрлүүдийн тухай нарийвчлан зохицуулсан.**

**Санхүү хөрөнгө оруулалтын үйлчилгээ ба хөрөнгийн зах зээлийн тухай хууль / Financial Investment Services and Capital Markets Act/ уг хуулийн зорилго нь шударга ёсыг бэхжүүлэх, үнэнч шударга байдал, хөрөнгийн зах зээлийн ашигт байдлыг эдийн засгийн шинчлэл болон хөрөнгийн зах зээл дээрх шударга өрсөлдөөнийг бий болгох замаар өсгөх, эдийн засгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээг хөнгөвчлөх болон хөрөнгө оруулагчийг хамгаалах замаар үндэсний эдийн засгийн хөгжил дэвшилд дэмжлэг болоход оршино. Уг хуулиар эдийн засгийн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагч тэр дундаа гадаадын хөрөнгө оруулагчийн тухай зохицуулалтыг ихэвчлэн зохицуулсан ба уг хууль нь Derivatives Market Business Regulation дүрэмтэй хамтран KOSPI, KOSDAQ болон зарим байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлдог байна.**

#### **Үнэт цаас, арилжааны тухай хууль /Бүгд найрамдах Солонгос улс/ Securities And Exchange Act (Republic of Korea)<sup>49</sup>**

Chapter V-2 investment advisory business, etc.

/Бизнес эрхлэгч, хөрөнгө оруулалтын зөвлөгөө/

70-2. Бүртгэл Article 70-2 (Registration, etc.)

1. Санхүүгийн хороо нь бирж дээр худалдаа хийх гэж байгаа хувьцаа эзэмшигч нарт зөвлөгөө өгөх, тэднийг цаашид удирдан чиглүүлэх, бирж дээр хийсэн худалдааг бүртгэх үүрэгтэй.
2. Санхүүгийн хянан шалгах хороо нь хувьцаа эзэмшигч компаниудыг бүртгэдэг
3. Тавигдах шаардлагууд болон 1, 2 дугаар хэсэгт зассан бүртгэлийн үйл ажиллагаа бусад шаардлагатай материалууд нь Ерөнхийлөгчийн зарлигаар тодорхойлогоно.
4. Энэ акт болон хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэн ч явуулж болохгүй.

<sup>48</sup> SEC

<sup>49</sup> <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/apcity/unpan011491.pdf>

Хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх компани нь бүртгүүлсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг эрхэлж болохгүй ба бүртгэгдсэн үйл ажиллагаатай шууд хамааралтай Санхүүгийн хяналтын хорооноос зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа энд хамаарахгүй. Хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх компани нь Ерөнхийлөгчийн шийдвэрээр тодорхойлогдсон нөхцлүүдийн дагуу санхүүгийн байгууллагатай үйл ажиллагааны барьцааны мөнгөний хадгаламжийг эрхэлнэ. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын зөвлөгөөний компани нь үйл ажиллагааны барьцааны мөнгө, үнэт цаасуудыг шилжүүлэхийг хориглоно.

#### 70-6 үнэт цаасны арилжааны хязгаарлалт /хориг/

Хөрөнгө оруулалтын зөвлөгөөний компани болон албан тушаалтан, ажилтнууд нь энэ үйл ажиллагаатай холбоотой дараах дэд хэсэгт заасны дагуу үйл ажиллагаа явуулж болохгүй.

1. Актын 2 дугаар зүйлийн 8 хэсэгт заасан үйл ажиллагаа;
2. Үйлчлүүлэгчээс үнэт цаас, мөнгөн хадгаламж, тэтгэлэг авах;
3. Үйлчлүүлэгчид үнэт цаас, мөнгө зээлүүлэх, гуравдагч этгээдээс үйлчлүүлэгчид мөнгө болон үнэт цаас зээлэхэд зуучлах, зохион байгуулах;
4. Үнэт цаасны хөрөнгө оруулалттай холбоотой үйлчлүүлэгчийн алдагдлыг бүтнээр нь эсвэл хагасыг нь хариуцах тухай болон үр ашгийн хувь, ашгийн тогтмол байдлын баталгааны тухай амлалт өгөх;
5. Үйлчлүүлэгчдээс ашиг олох зорилгоор болон үйлчлүүлэгчдээс бусад гуравдагч этгээдэд үнэт цаасны зөвлөгөө өгч буй үйлчлүүлэгчийн худалдаа, арилжаа болон үнэт цаасны үнийн хэлбэлзлээс ашиг олох тухай хуулийн үндэслэлгүй зөвлөгөө өгөх;
6. Үндэслэлгүй ямар нэгэн цуу яриа болон худал мэдээлэл тараах;
7. Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын шийдвэрийг төөрөгдүүлэх, Ерөнхийлөгчийн зарлигаар тодорхойлогдсон арилжааны журмыг зөрчих.

**Солонгосын үнэт цаасны хууль** Санхүүгийн хяналтын алба нь /FSS/ санхүүгийн хяналтын хорооны /FSC/ хэрэгжүүлэгч байгууллага ба Өмнөд солонгосын санхүүгийн зохицуулалт болон хяналтын эрх мэдлийг нэгтгэж үйл ажиллагаагаа явуулна. Санхүүгийн хяналтын алба нь улирал тутмын дүгнэлт мөн жил бүрийн албан ёсны хяналттайгаар үйл ажиллагаагаа явуулна.

**Санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ ба хөрөнгийн зах зээлийн тухай акт нь** 2009 оны 2 дугаар сард хучин төгөлдөр болж Солонгосын зах зээлийн зохицуулалтын эрх зүйн тогтолцоог шинэчилсэн. Дээрх актаар худалдааны пүүсүүдийн бүртгэлийг дахин шинэчилэх болон эрх олгох зөвшөөрлийн тухай асуудлыг зохицуулсан. Актаар худалдааны пүүсүүдэд тавигдах шаардлагуудыг илүү нарийвчлан зохицуулсан ба хөрөнгө оруулагчийн хамгаалалтыг сайжруулахыг хичээсэн.

**Санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ ба хөрөнгийн зах зээлийн тухай хууль:** Энэхүү хуулийн зорилго нь шударга ёсыг бэхжүүлэх, шударга байдал, хөрөнгийн зах зээл дээрх өрсөлдөөний шударга байдал ба санхүүгийн шинэчлэлийг идэвхжүүлснээр хөрөнгийн зах зээлийн ашигт байдалд нөлөөлөх, хөрөнгө оруулагчийг хамгаалах, болон санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ, түүнтэй холбоотой үйл ажиллагааг хөнгөвчилж үндэсний эдийн засгийн хөгжилд нааштайгаар нөлөөлөх юм.

#### 4. Мэдээллийн аюулгүй байдлын талаар:

Ки Эс Ди оролцогчид болон тэдгээрийн харилцагчид Ки Эс Ди-ээс эрхлэх үнэт цаасны бүх талын мэдээллийн үйлчилгээнээс ашиг олж болно. Ки Эс Ди үнэт цаасны хадгаламжтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, хариуцдаг. Үүнээс цөөн хэдийг нэрлэхэд


Судалгааны эмхтгэл, XI боть

хадгаламжтай холбоотой хэвлэгдсэн мэдээлэл, алдагдсан үнэт цаас болон хамтарсан арга хэмжээний талаархи мэдээлэл зэрэг болно. Харин KOSCOM-ийн FSISAC (Financial Service Information Sharing & Analysis Center) нь хакерийн дайралт болон кибер террористуудаас мэдээллээ хамгаалах сөрөг арга хэмжээг хэрэгжүүлдэг.

**Үнэт цаас, арилжааны тухай хуулийн 70-8 хөрөнгө оруулалтын зөвөлгөөний үйл ажиллагаа, түүнтэй төстэй үйл ажиллагааны мэдэгдэл.**

- Хөрөнгө оруулалт зөвөлгөөний үйл ажиллагааг /энэ нь шууд хэвлэл мэдээллээр г.м олон нийтэд зөвөлгөө өгөх/ эрхлэхээр хүсэгч нь 2.10 болон 1 дүгээр зүйл заалтууд болон ерөнхийлөгчийн зарлигийн дагуу санхүүгийн хяналтын хорооноос гаргасан хэлбэрээр санхүүгийн хяналтын хороонд мэдэгдэнэ
- Санхүүгийн хяналтын хороо нь ЗГ -ын санхүүгийн хяналтын албаны 1 дүгээр хэсэгт нийцүүлэн дээрх мэдэгдсэн үйл ажиллагааг нь итгэмжилнэ.

#### Солонгосын хөрөнгийн бирж



## Үнэт цаасны хадгаламжийн газрын голлох чиг үүрэг



### 1.4 Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага/ IOSCO/ болон төлбөр тооцооны байгууллагуудад зориулан гаргасан G30-ын зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх боломж

Олон улсын хэмжээнд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйлажиллагаанд баримтлах үндсэн баримт бичиг нь Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага / IOSCO/-аас гаргасан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим” /Objectives and Principles of Securities Regulation/, “Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж” юм. Үүнийг нэгталаас Олон Улсын нийтлэг стандарт гэж үзэж болох бөгөөд түүнийг хууль тогтоомждоо тусгахыг гишүүн орнууддаа зөвлөмжилдэг. Нөгөө талаас эдгээр баримт бичгийн мөн чанар нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээг 30 зарчим болгон тодорхойлж, энэ нь үнэт цаасны зах зээлд тавигдах нийтлэг шаардлагыг илэрхийлж байдаг. Түүнчлэн уг баримт бичгүүд нь

- Хөрөнгө оруулагчдыг хамгаалах
- Зах зээлийн үнэнч шударга, үр ашигтай, ил тод байдлыг хангах
- Тогтолцооны эрсдлийг бууруулах үндсэн зорилготой

Мөн “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим”-ын зорилгыг хангахын тулд уг зарчмыг нийт 8 төрөл болгон багцлан дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

#### A. Зохицуулагчтай холбогдсон зарчим

1. Зохицуулагчийн хариуцлага нь тодорхой байх, бодитойгоор заагдсан байх;
2. Зохицуулагч нь эрх мэдэл, үйл ажиллагаагаа биелүүлэхийн тулд биеэ даасан байх, хариуцлага хүлээх чадвартай байх;
3. Зохицуулагч өөрт олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлж, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах эрх мэдэл, нөөц үр чадвартай байх;

4. Зохицуулагч нь тодорхой бөгөөд тогтвортой зохицуулалтын үйл явцыг жишиг болгох;
5. Зохицуулагчийн албан хаагчид итгэлцлийн холбогдох стандартуудыг мэргэжлийн өндөр түвшинд стандартыг мөрддөг байх;

**В. Өөрийгөө зохицуулах байгууллагын зарчим**

6. Зах зээлийн тохиромжтой хэмжээ болон иж бүрдлийн хэмжээнд өөрийн өрсөлддөг хүрээнд шууд хянах үүргийг хэрэгжүүлдэг өөрөө зохицуулагч байгууллагуудыг зохицуулагч нь зөв зохистой байдлаар ашиглах;
7. Өөрөө зохицуулах байгууллагууд нь зохицуулагчийг хянаж байх субъект болох ба эрх мэдлээ хэрэгжүүлэх болон өөрт оногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхдээ шударга ёс болон итгэлцлийн стандартыг баримтлах;.

**С. Үнэт цаасны зохицуулалт дахь албадлага**

8. Зохицуулагч нь хяналт, шалгалт явуулах, мөрдөн байцаах, нууцаар мөрдөх эрх мэдэлтэй байх;
9. Зохицуулагч нь албадлагыг хэрэгжүүлэх;
10. Зохицуулалтын систем нь хяналт шалгалт явуулах, мөрдөн байцаах, нууцаар мөрдөх үйл ажиллагааг үр ашигтай, өгөөжтэй байдлаар ашиглах, мөн холбогдох хөтөлбөрүүдийг үр өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэх;

**D. Зохицуулалт дахь хамтран ажиллах зарчим**

11. Зохицуулагч гадаад, дотоодын харилцагч нартай нийтийн болон нийтийн бус мэдээллэлтэй адил хуваалцах эрх мэдэлтэй байх;
12. Зохицуулагчид гадаад, дотоодын харилцагчтай нийтийн болон нийтийн бус мэдээллийг хамтран хэзээ болон яаж ашиглах талаар мэдээлэл солилцох механизмыг бий болгох;
13. Зохицуулалтын систем гадаадын зохицуулагчдад өөрсдийнх нь эрх мэдэл, чиг үүргийг нь хязгаарласан талаар асуудал тавихад дэмжлэг туслалцаагаар хангах боломжийг олгох;

**E. Үнэт цаас гаргагчдын зарчим**

14. Хөрөнгө оруулагчид шийдвэр гаргах үндэслэл болох санхүүгийн үр дүн, бусад мэдээллийг цаг тухайд нь бүрэн, үнэн зөв мэдээлэх;
15. Компанийн үнэт цаасны хувьцаа эзэмшигчидтэй өөр хооронд нь ялгаваргүйгээр шударга, тэгш байдлаар харьцах;
16. Нягтлан бодох болон аудитын стандарт нь олон улсын шаардлагад нийцсэн байх ба өндөр чанартай байх;

**F. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцооны зарчим**

17. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоог ажиллуулах, зах зээлд оруулах хүсэлтэй этгээдэд зориулж тавигдах шаардлагатай стандартыг зохицуулалтын систем бий болгох;
18. Зохицуулагч систем нь хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо болон үйлчлүүлэгчдийн эд хөрөнгийг хамгаалах болон тусгаарлахад шаардагдах хууль зүйн маят, түүний бүтцийн талаархи дүрэм журмаар хангах;
19. “E”-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоо нь тодорхой нэг хөрөнгө оруулагчид хэр зохистой болох мөн тухайн зохицуулалт түүний ашиг сонирхлыг үнэлэн дүгнэхэд шаардагдах мэдээллийг хангасан байх

зохицуулалтыг бий болгох;

20. Хамтын хөрөнгө оруулалтын тогтолцоонд нэгжийн төлбөр, үнэ болон эд хөрөнгийн үнэлгээг хийх тохиромжтой үндэс суурийг тусгахыг зохицуулалтаар бататгах;

#### G. Зах зээлд зохицуулагчийн зарчим

21. Зохицуулалт нь хөрөнгийн зах зээлийн хөндлөнгийн зуучлагч оролцох наад захын стандартыг хангасан байх;
22. Зуучлагчид учирч болох аливаа эрсдлийг тусгасан анхдагч болон одоо байгаа эд хөрөнгө мөн бусад шаардлагыг тавих;
23. Үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, эрсдлийн зохистой менежментийг бататгах болон тэдгээртэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүйг дотоод журам болон үйл ажиллагааны стандартыг зах зээлийн зуучлагчид дагаж мөрднө.
24. Системийн эрсдлийг бууруулахад хөрөнгө оруулагчдыг хамгийн бага эрсдэлд оруулахад зуучлагчдын зах зээл шударга зарчмаар үйл ажиллагаа явуулах;

#### H. Хоёрдогч зах зээлийн зарчим

25. Үнэт цаасны зах зээлийн солилцоог багтаасан арилжааны системийг бий болгох асуудал нь зохицуулалтын эрх хэмжээ, хяналтын зүйл байх;
26. Арилжааны нэгдсэн байдлыг хангах зорилгоор арилжаа солилцооны системийг зохицуулагч байнга хангаж байх бөгөөд ийнхүү хангах үйл ажиллагаа нь зах зээлийн олон янзын шаардлагыг тэнцвэрт байдалд нөлөөлөх шударга тэгш байдлын дүрэм журмаар тогтоогдох;
27. Арилжааны ил тод, нээлттэй байдлыг дэмжих;
28. Зохицуулалт нь худалдаа арилжааны аливаа шударга бус практик, хууран мэхлэх үйл ажиллагааг олж илрүүлэх, түүнийг хориглоход чиглэгдэх;
29. Зохицуулалт нь зах зээлийн замбараагүйдэлд хүргэх, тохиролцсоноо үл биелүүлэх, их хэмжээгээр эрсдэлд орохоос сэргийлэх зүй зохистой менежментийн баталгааг гаргахад чиглэгдэх;
30. Үнэт цаасыг шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлж тодорхой болсон систем нь зохицуулагчийн хяналтад байх бөгөөд үр өгөөжтэй, шударга, ашигтай байхаар тогтоож өгснөөр системийн аливаа эрсдлийг бууруулах байна.

Энэхүү баримт бичгийн зорилго, зарчим, түүнийг тайлбарласан байдлаас харвал дараах дүгнэлтийг хийж болно. Баримт бичиг нь үндсэндээ үнэт цаасны зах зээлийн зохистой хөгжлийг хангах механизмыг бүрдүүлэхэд шаардлагатай факторуудыг бий болгоход чиглэгдсэн байна. Энэ нь баримт бичигт дурдсан зорилтыг хангахын тулд юуны өмнө үнэт цаасны зах зээлд оролцогчдын баримталбал зохих зарчмыг хууль тогтоомждоо тусгахаас эхлэх юм. Нөгөө талаас эдгээр зарчмуудыг хангах үндсэн 2 алхамыг зааж өгсөн гэж үзэж болох бөгөөд энэ нь зорилготойгоо логик холбоотой байна. Үүнийг дараах байдлаар тайлбарлай.

Зарчмыг хангах эхний алхам нь өөрийн орны эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн зохистой тогтолцоог боловсруулсан байх явдал юм. Үүний дараа тухайн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, ил тод байдал, эрсдэлийн хуваарилалт, хяналт, зохицуулалтын зарчмыг тусгасан эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор баримт бичигт тусгагдсан зорилго биелэх нөхцөл бүрдэнэ гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл, эхлээд үнэт цаасны зах зээлийн нийтлэг зарчимд нийцүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, дараа нь түүнийгээ эрх зүйн хувьд баталгаатай болгох нь шаардлагатай. Тийм ч учраас Үнэт цаасны хадгаламжийн

байгууллагад зориулсан зөвлөмжийн үндсэн зарчимд:

1. Улс болгон үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвтөй байх шаардлагатай.
2. Улс болгон үнэт цаасны хадгаламжийн байгууллагын үндсэн засаглалд улсаас анхааран ажиллаж, хянач байгууллагуудын нэгд Төв банкийг заавал хамааруулсан байх.
3. Олон улсын хөрөнгийн зах зээлийн хамтрап, мэдээлэл солилцоог сайжруулах, хөрөнгө оруулагчдын өртөгийг багасгах үүднээс улс болгон төлбөр тооцооны стандартыг хэрэгжүүлэн нэгдсэн зарчимд орох.
4. Мэдээллийн аюулгүй байдал, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулан хамгаалах үүднээс төвлөрсөн төлбөр тооцоо болон хадгаламжийн байгууллагыг хөрөнгийн зах зээлийн системийн төв гэдгийг анхааран, хяналт болон үндсэн эрсдлийг бууруултан талаас үйл ажиллагааг сайжруулах гэж тусгажээ.

Манай улсын хувьд энэхүү зөвлөмжийг хууль тогтоомжидоо тусгах чухал ач холбогдолтой нь ойлгомжтой юм. Мөн зөвлөмж болон зарчмыг тодорхой хэмжээгээр тусгасан, хуульчилсан. Жишээ нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн бие даасан институцийг бий болгосон бол, ҮЦЗЗтХ-д хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаар зохицуулалт бий. Гэсэн хэдий ч бодит байдалд хөрөнгө оруулагч, ялангуяа “бага” хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол илүү хөндөгдэж, ногдол ашгаа авч чадахгүй байх, хувь нийлүүлэгчдийн хуралд болон шийдвэр гаргахад оролцох боломжгүй байх, мэдээлэл хязгаарлагдмал зэрэг асуудлыг тэр бүр зохицуулж чадахгүй байгаа<sup>50</sup>, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн бие даасан тогтолцоог бий болгосон боловч түүнтэй холбоотой зарим харилцаанд эрх зүйн зохицуулалт дутагдаар байна.

Энэ нь үнэт цаасны арилжаанаас үүдэлтэй эрүү, иргэн, захиргааны журмаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааныг маргааны зүйл нь ижил боловч хуулийн өөр өөр зохицуулалт баримтлан шийдвэрлэх, огт шийдвэрлэх боломжгүй болох<sup>51</sup>, арилжааны хэлцэл буцааснаар бусад хөрөнгө оруулагчийг хохироох зэрэг сөрөг үр дагавар гарч байгаагаас тодорхой харагдана.

Олон Улсын байгууллагын эдгээр зарчим, зөвлөмжийг манай орны нөхцөлд зарим талаар хэрэгжүүлэх боломж нь бий бөгөөд хэрэгжүүлж ч байна. Гэхдээ Олон Улсын Үнэт цаасны зохицуулах байгууллагаас гаргасан үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын зарчим нь нэг талаас зах зээлийг илүү глобалчлагдсан, ойлгомжтой болгож байгаа ч нөгөө талаас манайх шиг зах зээлийг багтаамж багатай, хөгжил буурай орнуудын хувьд зах зээлийн нүсэр бүтцийг сонгодог хэлбэрээр нь төлөвшүүлэхэд тодорхой бэрхшээлийг бий болгож байгаа юм.<sup>52</sup> Жишээлбэл, өнөөгийн байдлаар үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг улсын хэмжээнд ганцхан байгууллага эрхэлж байгаа тохиолдолд баримт бичигт тусгагдсан өөрийн зохицуулалтын зарчмыг шууд авч хэрэглэх боломж хомс юм.

Харин үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын эрх зүйн зохицуулалтын болон менежментийн шинэтгэлийн асуудлууд яригдаж буй энэ үед уг өөрийн орны нөхцөлд тохирсон цомхон, эдийн засгийн хувьд хэмнэллтэй, үр нөлөөтэй, эрсдэл багатай дэд бүтцийн тогтолцоог боловсруулж түүнд нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгоход энэхүү зарчим, зөвлөмжийг баримжаалах нь зүйн хэрэг юм.

<sup>50</sup> <http://www.bis.org/publ/cpss94.pdf>, Principles of financial market infrastructure CPSS/IOSCO report

<sup>51</sup> “Үнэт цаасны зах зээлийн тухай монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт” судалгааны тайлан, ХЗҮХ, 2009 он, 10 дахь тал

<sup>52</sup> Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрөх, Эрүүгийн хууль -72

Түүнчлэн цаашид Олон улсын энэхүү зарчим, зөвлөмжийг үндэсний хууль тогтоомждоо тусгах арга замыг хайх нь түүнийг хэрэгжүүлэх бас нэг боломж юм. Үүнд төрөөс үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих бодлого чухал байр суурь эзлэнэ. Тодруулбал, дээрх зарчим, зөвлөмжийг Монгол Улсын Олон Улсын гэрээний статустай болгосон тохиолдолд уг баримт бичгүүд нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хууль зүйн хүчин чадалтай болж, олон улсын гэрээнд өөрөөр заасан бол гэрээний заалтыг баримтлана гэсэн зарчмын дагуу рецепци хийх боломж бүрдэх юм.

**II БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТОГТОЛЦООН  
ДАХЬ ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ, БҮРТГЭЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУЛГАМДСАН  
АСУУДЛУУД /НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ/**

**1.1 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны  
эрх зүйн зохицуулалт**

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг авч үзэхийн тулд юуны өмнө уг харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зорилтыг авч үзэх хэрэгтэй юм. Хэдийгээр аливаа салбар эрх зүй гэдэг нь тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр цогц гэж үзэх хандлага байдаг ч энэхүү судалгааны зорилго нь одоогийн зохицуулж буй хэм хэмжээнд үнэлэлт дүгнэлт өгөх замаар нөхцөл байдлыг тогтооход чиглэгдэж байгаа тул эрх зүйн зохицуулалтын зорилтыг шалгуур болгон хэм хэмжээг сонгон авсан болно. Түүнчлэн эрх зүйн онолд хэм хэмжээг зорилгоор нь тайлбарлах арга өргөн дэлгэрсэн байdag.

Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хууль байхгүй. Энэхүү үйл ажиллагааг үндсэнд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуулиар зохицуулагдаагүй харилцааг бусад хууль, эрх зүйн актаар зохицуулж байна. Өмнө нь дурдсаны дагуу үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хэм хэмжээг түүний зорилго, шүүхийн практикийн үүднээс авч үзэн шууд болон шууд бус байдлаар зохицуулж буй хэм хэмжээ хэмээн ангилан авч үзсэн болно.

Шууд зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын тухайд

**Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зорилт нь үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаархи мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино<sup>53</sup> гэж заажээ.**

Эдгээр харилцааны хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах харилцааны эрх зүйн зохицуулалт нь үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж үйл ажиллагаанд шууд хамааралтай юм. Хуулийн 20, 24, 25 дугаар зүйлд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг бус уг үйл ажиллагааг эрхлэх байгууллагын эрх зүйн байдал, чиг үүргийг заасан байна.

<sup>53</sup> Норовдондог Ц. Монгол улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн тулгамдсан асуудлууд, Бодлогын судалгаа шинжилгээ /судалгааны эмхэтгэл/, УИХ-ын Тамгын газар Судалгааны төв, УБ, 2011 он, 229 дэх тал

Судалгааны эмхтгэл, XI боть

Чиг үүргийг тодорхойлсон байдлаас харахад ерөнхий болон тусгай гэж хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчийн нийтлэг буюу ерөнхий чиг үүрэг<sup>54</sup>, үйл ажиллагааны төрлийн онцлогоос шалтгаалсан буюу тусгай чиг үүргийг<sup>55</sup> хуульд тус тус тусгажээ. Мөн үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих байгууллагын /СЗХ/ эрх хэмжээг заасан байна.

Хуулийн зохицуулалтаас харахад үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэх харилцаа, үнэт цаасны хадгаламжтай холбоотой бүртгэлийн харилцаа зэрэг нь уг хуулиар зохицуулагдахгүй гэж ойлгогдохоор байна. Харин эдгээр зохицуулагдаагүй харилцааг СЗХ нь ҮЦЗТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.3-т заасны дагуу дүрэм, журам, заавар буюу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ батлах /салбарын хэмжээнд/ замаар зохицуулах боломжтой байхаар хуульчилжээ.

**Эрүүгийн хууль.** Уг хуулийн 158 дугаар зүйлд (Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчих) Үнэт цаас гаргах, гүйлгээнд оруулах, худалдах, арилжих, түүгээр төлбөр тооцоо хийх, брокер, дилперийн үйл ажиллагаа явуулах журмыг зөрчисны улмаар бусдад их хэмжээний хохирол учирсан бол Эрүүгийн хариуцлага хүлээлгэээр заасан байна. Энэхүү зохицуулалтад анхаарвал зохих дараах 2 асуудал байна. Үүнд:

- Үнэт цаасны тухай **хууль тогтоомж** зөрчих гэж заасан атлаа томъёолоходоо уг гэмт хэргийг объектив талын үйлдлийг **журам** зөрчих гэж зөрүүтэй байдлаар тодорхойлсон.
- Үнэт цаасаар төлбөр тооцоо хийх гэсэн гэмт хэргийн объектив талын шинжийг нарийвчлан тодорхойлохгүйн улмаас энэ төрлийн эрүүгийн хэрэг огт шийдвэрлэгдэхгүй байна.

### **СЗХ -оос баталсан журмууд.**

Шууд зохицуулж буй дараагийн эрх зүйн баримт бичиг нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт юм. Хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан олгогдсон эрх бүхий этгээдээс гаргасан, нийтээр дагаж мөрддөг, төсөөтэй тохиолдолд дахин давтаж хэрэглэдэг, нийтлэг зохицуулалт бүхий гадагш чиглэсэн шийдвэрийг хэлнэ.<sup>56</sup> Үүний дагуу СЗХ-ноос үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн харилцааг зохицуулахаар гаргасан журмууд нь уг үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт болно. Учир нь хуулиар СЗХ нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон этгээд мөн. Тийм учраас СЗХ-ноос гаргасан эрх зүйн акт нь тухайн харилцаанд хуулийн адил хүчин төгөлдөр үйлчилэх бөгөөд одоогоор дараах журмуудыг батлан гаргасан байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам /2006.08.04-ны 29-р тогтоол/ Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Үнэт цаас тусгаарлах, үнэт цаасны хадгаламж дахь дансны гүйлгээг түр зогсоо тухай журам. Энэхүү журмын зорилго нь үнэт цаас тусгаарлах, тусгаарлалтыг цуцлах, төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоо, гүйлгээг сэргээх, тусгаарлагдсан үнэт цаасны болон дансан дах мөнгөн хөрөнгийн гүйлгээг түр зогсоо ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн бүртгэл

<sup>54</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-1

<sup>55</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-19

<sup>56</sup> Одгэрэл П, Хэм хэмжээний акт, УБ, Лотар: 15

хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам. Энэхүү журмын зорилго нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу үнэт цаасны зах зээлийн оролцогчдоос Санхүүгийн зохицуулах хороон дахь Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “Мэдээллийн сан” гэх)-д ирүүлэх мэдээллийн төрөл, хуваарийг тогтоон, холбогдох мэдээллийг хүлээн авах, мэдээллийг боловсруулах, хянах, хадгалах, мэдээллийн сан дахь мэдээллийг ашиглах, олон нийтдэд мэдээлхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам. Энэхүү журам нь “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид компани гэх/-ийн төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Үнэт цаасны дотоод мэдээлэл түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны хороноос /цаашид “Хороо” гэх/ үнэт цаасны дотоод мэдээлэл/цаашид “дотоод мэдээлэл” гэх/ болон түүнийг эзэмшигчийг тогтоох, үнэт цаасны зах зээл дээр дотоод мэдээлэл эзэмшигчээс явуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчлах тухай журам. Энэ журмаар үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, аттестатчилахтай холбоотой харилцааг зохицуулна.

Хэдийгээр эрх олгогдсон этгээд буюу СЗХ-ноос үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг журамлан зохицуулж байгаа хэдий ч уг үйл ажиллагаатай бүх харилцааг зохицуулах боломжгүй нь ойлгомжтой юм. Жишээ нь, СЗХ нь үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах чиг үүрэгтэй тул уг харилцаанаас үүдэлтэй шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааныг журамлан зохицуулах боломжгүй.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн ямар төрлийн мэдээлэл хаалттай ба нээлттэй байх зэрэг асуудал нь дан ганц СЗХ-оос хамаарах асуудал биш бөгөөд үүнийг мэргэжлийн оролцогч, харилцагчдын хооронд байгуулах гэрээгээр зохицуулна. Гэвч мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаан дахь мэдээ мэдээллийн харилцаа нь бүрэн хэмжээгээр зохицуулагдаагүй байгаа нь зөвхөн СЗХ ч бус зарим тохиолдолд хэрэг маргаан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд ч нөлөөлж байна.

Шууд бус байдлаар зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын тухайд

**Иргэний хууль** нь Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг шууд бус байдлаар гэхээсээ илүүтэйгээр дараах байдлын улмаас ҮЦЗЗтХ-аар зохицуулагдаагүй харилцааг нөхөж зохицуулдаг гэж үзэж болно. Үүнд:

- Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн үйл ажиллагаа нь үнэт цаасны арилжаанд оролцогчийн эзэмших, өмчлөх эрхийг объектив байдлаар шилжүүлж, баталгаажуулдаг буюу эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн баялагтай холбоотой харилцаа тул иргэний эрх зүйн харилцааны объект болно.
- Шүүхийн практикаас харахад уг харилцаатай холбоотой маргааныг ихэвчлэн Иргэний хууль баримтлан шийдвэрлэж байгаа
- Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлдэг
- Хөрөнгө оруулагчийн эрх нь ҮЦЗЗтХ-иас гадна Иргэний хуулиар хамгаалагдаж байдаг.

Үүнээс гадна Иргэний хуульд үнэт цаастай холбоотой зарим суурь харилцааг зохицуулсан байдаг. Гэхдээ хуулийн энэхүү зохицуулалт нь тухайн харилцааг зохицуулахаас илүүтэйгээр түүний хэрэглээний асуудал нь хуульчдын дунд ихээхэн маргаан өрнүүлдэг. Тухайлбал үнэт цаасаар гэрчлэгдсэн зөрчигдсөн эрхийг сэргээх маргааныг СЗХ, шүүх өөрсдөд нь олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэж буй боловч, эдгээр нь өөр хоорондоо зөрчилдэх, уялдаа холбоогүй байх, нэг шийдвэр нь нөгөө шийдвэрийг үгүйсгэх зэрэг үзэгдэл ажиглагдаж байна. Иргэний хуулийн тайлбар /өрөнхий анги/ номонд бичсэнээр “Энэ зохицуулалт их хүндрэлтэй зохицуулалт байна”<sup>57</sup> Мөн Иргэний хуулийн үнэт цаасны зах зээлийн харилцаатай холбоотой зарим зүйл, заалт нь ойлгомжгүй, шүүхийн практикт хэрэглэхэд хүндрэлтэй байна<sup>58</sup> гэж судлаачид үздэг.

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд зайлшгүй зохицуулагдах бас нэг байх объект нь мэдээ мэдээлэл, түүний нууцлалтай холбоотой харилцаа юм. Учир нь уг үйл ажиллагаа биет бус байдлаар буюу мэдээлэлд тулгуурлан явагддаг онцлогтой. Иймээс энэ харилцаан дахь мэдээлийн үнэн бодит, аюулгүй байдал нь ихээхэн ач холбогдолтой, гүйцэтгэх үүрэг ихтэй байдаг тул мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй хэм хэмжээ нь мөн эрх зүйн зохицуулалтад хамаарна.

Судалгааны хүрээнд авч үзсэн гадаадын зарим орон мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс тусгайлсан дүрэм журмыг боловсруулсан байх нь бий.<sup>59</sup> Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдал, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулан хамгаалах үүднээс төвлөрсөн төлбөр тооцоо болон хадгаламжийн байгууллагыг хөрөнгийн зах зээлийн системийн төв гэдгийг анхааран, хяналт болон үндсэн эрсдлийг бууруулах талаас үйл ажиллагааг сайжруулахыг Үнэт цаасны хорооны олон улсын байгууллын зөвлөмжид тусгасан байдаг. Нөгөө талаас мэдээлэл нь үнэт цаасны зах зээлд шударга өрсөлдөөн, үнэт цаасны өөрийн үнэ тогтоход нөлөөж байдаг гэж үздэг. Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой харилцааг манай улсад эрх ашиг нь илэрхийлэгдэж буй субъектээр нь дараах байдлаар зохицуулж байна. Үүнд:

- Хувь хүний нууцын тухай хууль. Хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл. Хувь хүний нууцын тухай хуульд зааснаар хувь хүний нууц нь хөрөнгийн гэсэн төрөлтэй байхаар заасан тул хувь хүн хичнээн нэр төрөл, тоо ширхэг үнэт цаас өмчилдөг, эзэмшдэг эсэх нь тухай харилцагчийн хувийн нууц байна. Энэхүү нууцыг үнэт цаасны арилжаанд оролцох үе шатны мэдээлэлтэй хольж болохгүй. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны арилжаанд оролцох /үнэт цаас худалдах, худалдан авах/, төлбөр тооцоо, бүртгэлийн үеийн мэдээлэл нээлттэй боловч, харилцагчийн данс болон хадгаламж дахь мэдээллүүд бусад этгээдийн хувьд нууц байна. Уг хуулиар хувь хүний хадгаламж нь нууц байж болно<sup>60</sup> гэж заагаад хувь хүн нууцаа өөрөөр хамгаална<sup>61</sup> гэж хэдий ч энэхүү нууцыг хадгалах, хэрэг маргаан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас бусад

<sup>57</sup> Тэмүүлэн Б.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.11-р зүйл, Иргэний хуулийн холбогдох заалтын хэрэглээ, Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд гарч байгаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал /эмхэтгэл/, ХЗДХЯ, УБ, 2011 он, 19 дэх тал

<sup>58</sup> Доржготов А, Хөрөнгийн зах зээл дээр гарч буй иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэж буй практик, тулгамдсан асуудал, Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд гарч байгаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал /эмхэтгэл/, ХЗДХЯ, УБ, 2011 он, 17 дахь тал

<sup>59</sup> “Үнэт цаасны зах зээлийн тухай монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт” судалгааны тайлан, ХЗҮХ, 2009 он, 7 дахь тал

<sup>60</sup> Дэлгэрэнгүйг судалгааны 1 дүгээр бүлгээс үзнэ үү

<sup>61</sup> Хувь хүний нууцын тухай хууль-4

этгээдэд нээлттэй болгохгүй байх нь мөн хадгаламжийн байгууллагын үүрэг болно.

- Байгууллагын нууцын тухай хууль. Байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг дотор нь 2 хуваан авч үзнэ.

2.1 Үнэт цаасны эзэмшигч, өмчлөгч нь хуулийн этгээд байж болно. Энэ харилцаа нь мөн чанарын хувьд хувь хүний нууцтай адил боловч субъектын хувьд ялгаатай байна.

2.2 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл. Уг үйл ажиллагааг одоогоор зөвхөн нэг байгууллага /"ҮЦТТХТ" ХХК/ эрхэлж байгаа бөгөөд төвлөрсөн хадгаламж буюу Монгол улсын үнэт цаасны хадгаламжийн бүх мэдээлэл энд төвлөрч байдаг. Энэ нь тухайн мэдээллийн ач холбогдол, үр дагаврыг илэрхийлж байгаа тул уг үйл ажиллагааг эрхэлж буй байгууллагын нууц байх нь зайлшгүй асуудал юм. Нөгөө талаас энэхүү үйл ажиллагааг эрхэлж буй байгууллага нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч бусад субъектүүдээс ялгарах өөрийн гэсэн дараах онцлогтой тул уг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь нууц байх зайлшгүй хэрэгтэй байдаг. Үүнд:

- Өмнө нь дурдсаны дагуу уг үйл ажиллагааг одоогоор улсын хэмжээнд нэг байгууллага эрхэлж байгаатай холбоотойгоор уг байгууллагын үйл ажиллагаа нь хадгаламж эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдын нийтлэг ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэх ёстай. Өөрөөр хэлбэл, бусад мэргэжлийн оролцогчид нь тус бүрийн ашиг сонирхлын үүднээс үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцдог бол уг байгууллагын үйл ажиллагаа нь нийтлэг ашиг сонирхолд чиглэгддэг.
- Уг үйл ажиллагааг эрхэлж буй байгууллагын мэдээллийн аюулгүй байдал нь үнэт цаасны зах зээлийг зүй ёсоор хөгжихэд ихээхэн нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, хадгаламж эзэмшигч буюу хөрөнгө оруулагчдын талаарх мэдээллийн аюулгүй байдар хэдий чинээ найдвартай байна тэдий хэмжээгээр үнэт цаасны зах зээлийн харилцаа шударгаар явагдаж, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, өрсөлдөөн бий болох үндсийг бүрдүүлнэ гэсэн санаа юм. Үүнийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд “дотоод мэдээлэл” гэж тодорхойлсон байдаг. Түүнчлэн уг хуульд заасны дагуу байгууллага нь нууцаа өөрөө тогтоож болдог бөгөөд нууцаа хамгаалах журмаа өөрөө тогтоож мөрднө.

- Төрийн нууцтай холбоотой мэдээлэл. Монгол улсын Засгийн газар 2011 оны 98 дугаар тогтоолоороо Монгол Улсын иргэн бүрт “Эрдэнэс Тавантолгой” компанийн 536 ширхэг хувьцааг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхээр шийдвэрлэж энэхүү ажлыг зохион байгуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үүрэг болгосон. Үүний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас “ҮЦТТХТ” ХХК-д шилжүүлсэн Монгол улсын иргэний бүртгэл шинэчлэсэн бүртгэлтэй холбоотой мэдээлэл нь Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 17-д заасны дагуу маш нууц мэдээлэл болно.

“ҮЦТТХТ” ХХК-ийн Төлөөлөнудирдах зөвлөлөөс үйлажиллагаа явуулахтай холбоотойгоор баталсан журам бий. Эдгээр журам нь үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулах нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болохгүй. Учир нь “ҮЦТТХТ” ХХК нь нийтийн эрх зүйн хэм хэмжээний акт гаргах эрх бүхий субъект биш. Нөгөө талаас уг журам нь гадагш чиглэсэн буюу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бус дотогш чиглэсэн буюу уг байгууллын үйл ажиллагааг журмалсан хэм хэмжээ тул эрх зүйн зохицуулалт гэж авч үзэх боломжгүй юм. Гэхдээ үүнийг позитив талаас нь харвал үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалт

дутагдаж буйг харуулж байгаа хэрэг юм.

Манай улсын үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Олон Улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, судлагдсан гадаадын бусад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулж үзвэл эрх зүйн зохицуулалт үнэхээр дутмаг байна гэж дүгнэж болохоор байна. Учир нь Олон Улсын байгууллагаас гаргасан зарчим, зөвлөмжийн зарим хэсгийг л эрх зохицуулалтад хэлбэрийн төдий тусгасан, үнэт цаасны зах зээлийг бүхэлд нь ганцхан хуулиар зохицуулж байгаа, уг хууль нь зарим талаар зохицуулах ёстой харилцаагаа бүрэн зохицуулж чадахгүй байгаа, нөхөн зохицуулж буй хэм хэмжээ нь хуульчдын дунд маргаантай байдаг зэрэг нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна.

Судалгааны хүрээнд судлагдсан гадаад улсын эрх зүйн зохицуулалтаас хараад үнэт цаасны зах зээлийг хамгийн багадаа дөрөв буюу түүнээс дээш эрх зүйн актаар зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр улсууд бүгд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуультай боловч, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт нь тусгайлсан зохицуулалт бүхий олон эрх зүйн актаас бүрдэж байна. Үүнээс заримыг тусгайлан авч үзэж хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт 1

“Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн тухай” хуультай орон	АНУ, Япон
“Мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай” хуультай орон	АНУ, Япон, Солонгос
“Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах тухай” хуультай орон	АНУ, ОХУ

#### 1.2 Үнэт цаасны зах зээл дэх төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, дэд бүтцийн байгууллага хоорондын уялдаа холбоо

Үнэт цаасны зах зээл дэх төлбөр тооцоо, хадгаламж бүртгэл үйл ажиллагааны зохион байгуулалтыг авч үзэхийн тулд уг зах зээлийг эрх зүйн бие даасан харилцаа, түүнд оролцогч бүрээр нь авч үзэх хэрэгтэй болов уу. Үүнийг бүдүүвчлэн<sup>62</sup> авч үзэж болох юм. ҮЦЗЗТХ-д тусгагласан байдлаар бол үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагыг

- Үнэт цаас гаргагч
- Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага /СЗХ/
- Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага /хөрөнгийн бирж/
- Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага
  - БДК /хөрөнгө оруулагч/
  - “ҮЦТТТХТ” ХХК
  - Мөнгөн төлбөр тооцоо гүйцэтгэх байгууллага
  - Төв банк
  - Арилжааны банк

гэсэн оролцогчид бүрдүүлж байна. Эдгээр оролцогчид нь хэдийгээр үнэт цаасны зах зээлийн харилцааны бие даасан оролцогч, тус бүрийн чиг үүрэгтэй боловч үйл ажиллагаа нь харилцан бие биенээсээ хамааралтай байж үнэт цаасны зах зээлийг бүрдүүлж

<sup>62</sup> Бүдүүвчийг хавсралтаас харна уу

байдаг.

Харилцан хамаарал нь бүдүүвчид үзүүлсний дагуу шаталсан байдалтай буюу харилцааны хувьд дээрээс доош чиглэсэн буюу босоо тогтолцоотой байна. Харин уг харилцаа нь ямар нэг захирагааны албадлагаар бус оролцогчдын хүсэл зоригийн үндсэн дээр явагдаж, мэргэжлийн гэсэн шалгуур тавигддаг тул дороос дээш чиглэсэн үйл ажиллагаа явагдахгүй. Өөрөөр хэлбэл, бүдүүвчид үзүүлсний дагуу эрх зүйн харилцаа бүр нь тухай үе шатандaa дуусч дараагийн үе шатанд шинэ харилцаа үүсч байдаг тул дороос дээш үйлчлэх харилцаа гэж байхгүй. Нөгөө талаас тухайн үе шат бүрийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ нь өөр өөр байдаг.

Жишээ нь: Үнэт цаасны арилжаа хийгдэж, уг арилжааны үр дүнд төлбөр тооцоо, бүртгэлийн үйл ажиллагаа хийгдсэн гэж үзье. Үнэт цаасыг арилжаалахтай холбоотой харилцааг УЦЗТХ-иар зохицуулах бол, төлбөр тооцоо, бүртгэл хийгдсэний дараа уг үнэт цаас нь худалдан авсан этгээдийн өмч, эзэмшил болох тул уг харилцаа нь Иргэний хуулиар зохицуулагдана.

Үнэт цаасны зэх зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо нь үндсэндээ үнэт цаасны арилжааны талаарх мэдээлэл дамжуулах явдал юм. Үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч бүр тодорхой чиг үүргийн хүрээнд явуулж буй үйл ажиллагааныхаа талаарх хэрэгцээт мэдээллээр бусад оролцогчдоо хангах нь уг зах зээлийн харилцаа хэвийн явагдах нөхцлийг хангаж байдаг.

/Зураг 1/

### Үнэт цаасны зах зээл



### 1.3 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллагын эрх зүйн байдал, чиг үүрэг

Энэхүү үйл ажиллагааг эрхлэх байгууллагын эрх зүйн байдлыг УЦЗТХ-д компани хэлбэртэй байхаар тодорхойлсон байна. Иймээс энэ төрлийн үйл ажиллагааг хуульд заасны дагуу аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Иргэний болон Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд эрхэлнэ.

УЦЗТХ-ийн 24, 25 дугаар зүйлд үнэт цаасны төлбөр тооцоо болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг тодорхойлж, хувь нийлүүлсэн хэмжээний доод хязгаарыг зааж өгсөн байдаг. Үүний дагуу одоогоор үнэт

цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг төрийн өмчит “ҮЦТТХТ” ХХК эрхэлж байна. Хэдийгээр энэ нь төрийн өмчийн оролцоотой боловч эрх зүйн харилцаанд бусад хувийн эрх зүйн этгээдийн адил эрх эдэлж үүрэг хүлээнэ. Харин үйл ажиллагаандаа ҮЦЗ3ТХ, эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн актыг дагаж мөрдөнө. “ҮЦТТХТ” ХХК-ийн эрхэлж буй үйл ажиллагааны төрөл, ҮЦЗ3ТХ-д тодорхойлсноос харвал нийтлэг, тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тусгай чиг үүрэг нь дараах 2 төрөлд хуваана. Үүнд:

Үнэт цаасны төлбөр тооцоо. Энэ хүрээнд:

- үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны холбогдох компаниас ирүүлсэн мэдээ, баримтыг тулган хянаж, харилцагч хоорондын төлбөрийн үүргийг тодорхойлж, тооцоог хийж гүйцэтгэх, холбогдох баримтыг бүрдүүлэх;
- үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдох баримтыг хадгаламжийн байгууллагад шилжүүлэх;
- эрсдэлийн сан байгуулах замаар болзошгүй эрсдэлээс хамгаалах, харилцагчийн төлбөрийн үүргийн биелэлтийг шуурхай хангах;
- үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх.

Үнэт цаасны хадгалмжийн үйл ажиллагаа. Энэ хүрээнд:

- үнэт цаас шинээр гаргах болон үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхэд гарсан өөрчлөлтийг эрх бүхий этгээдээс ирүүлсэн хүсэлт, бусад баримтыг үндэслэн бүртгэх;
- Төлбөр тооцооны байгууллага болон үйлчлүүлэгчээс хүлээн авсан баримтыг үндэслэн үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх;
- Хороо, Хөрөнгийн бирж бусад эрх бүхий этгээд болон үнэт цаас гаргагчийн хүсэлтээр үнэт цаас эзэмшигчийн бүртгэлийн мэдээг үнэн зөв гаргаж өгөх гэсэн чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

#### **1.4 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллага / ҮЦТТХТ/-ын үйлчилгээ, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн урсгал, эрсдэлийн асуудал**

“ҮЦТТХТ” ХХК-ийн 2010 оны жилийн тайлангаас харвал “компани нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын арилжааны болон арилжааны бус хэлцлийн үр дүнд үссэн төлбөрийг тодорхойлж, төлбөр тооцоог хийх үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэх, үнэт цаас хадгалах зэрэг үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг”.

Гүйцэтгэх чиг үүрэг нь арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн баталгаажсан хэлцлийг үндэслэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх, төвлөрсөн хадгаламж дахь харилцагчдын данснаас хийгдэх мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн гүйцэтгэх гэж тус тус тодорхойлжээ. Түүнчлэн ҮЦЗ3ТХ-д шууд тодорхойлоогүй боловч бүртгэлийн /реестр/ үйлчилгээг давхар эрхэлж байна гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн нэгдсэн бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа нь мэдээлэлд суурилдаг болохыг өмнө нь дурдсан билээ. Үүний

дагуу үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны гол цөм нь мэдээлэл, бүртгэл юм. Өөрөөр хэлбэл, мэдээлэл суурилан үйл ажиллагаа явуулдаг тул мэдээллийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай болдог. Ялангуяа зарим тохиолдолд төрийн нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл суурилан үйл ажиллагаа явуулах шаардлага тулгарч байгаа нь түүний аюулгүй байдалд онцгой анхаарах хэрэгтэйг харуулж байгаа юм.

Үүнээс үзвэл мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд эрсдэлийн асуудлыг зайлшгүй авч үзэх хэрэгтэй болох нь ойлгомжтой юм. Гадаадын зарим оронд үнэт цаасны зах зээлийн мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах харилцааг тусгайлан авч үзэн эрсдэлийг тооцож зохих зохицуулалтыг хийсэн байдаг. Жишээ нь, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах харилцааг зохицуулсан бие даасан хуультай байх, мэдээллийн аюулгүй байдлыг бусад субъетив хүчин зүйлээс хамгаалах алба, хэлтэстэй байх зэрэг юм.

Манай орны хувьд уг асуудал нь мөн л тулгамдсан асуудлын нэг юм. Хэдийгээр ҮЦЗЗТХ-д энэ талаар тусгасан, СЗХ-оос дотоод мэдээлийн талаар журам баталсан боловч энэ нь бүрэн дүүрэн зохицуулалт гэж үзэхдээ учир дутагдалтай юм. Үүний нэг жишээ нь, үнэт цаасны дэд бүтцийн байгууллагуудын СЗХ-нд мэдээлэл өгөх харилцааг л зохицуулснаас бус дэд бүтцийн байгууллагууд хоорондоо мэдээллийг хэрхэн солилцох талаар зохицуулалт байхгүй, өөр өөрийн дотоод журмаар зохицуулагдаж байна гэж хэлж болно. Нөгөө талаас төрийн нууцад хамаарах мэдээллийг хэрхэн хадгалах, бусдад дамжуулах харилцаа нь мөн зохицуулалтгүй байгаа нь эрсдэлийг үүсгэж байна.

### **1.5 Монгол улсын үнэт цаасны зах зээл дэх төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаанд дахь тулгамдсан асуудлууд**

“ҮЦТТТХТ” ХХК-ийн тодорхойлсноор үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаанд дараах тулгамдсан асуудлууд байна гэж үзжээ. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үнэт цаасны хадгаламж, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн бүртгэл, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан, тодорхой тусгах;
- СЗХ болон “ҮЦТТТХТ”-ийн журмаар зохицуулагдаж байгаа харилцааг хуульд тусгах;
- Засгийн газраас МУ-ын иргэдэд “Эрдэнэс таван толгой” компанийн 10 хувийг эзэмшиүүлэхтэй холбоотой УБЕГ-аас Төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн 17-д заасан мэдээ, мэдээллийг хүлээн авч байгаатай холбогдуулан мэдээ мэдээллийн аюулгүй байдал, системийн аюулгүй байдал мөн нууцийн мэдээллийг хариуцаж буй ажилтны эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулах
- Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээлэл, түүнийг ашиглах, хамгаалах талаарх зохицуулалтыг тодорхой болгох;
- Хуурамч итгэмжлэл /нотариатын тамга тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах/, мөн нотариатын үүрэг гүйцэтгэгчийн гэрчилсэн аливаа баримтыг шалгах;
- 5-10 жилийн өмнө олгогдсон өвлөх эрхийн гэрчилгээ;

Эдгээр тулгамдсан асуудал нь үнэт цаасны зах зээлд гарч буй болит факт бөгөөд үүнийг судалгааны аспектийн үүднээс авч үзвэл үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой бусад харилцаа нь бараг зохицуулалтгүй байгаа нь тулгамдсан асуудлын суурь шалтгаан болж байна гэж үзэх үндэслэлтэй юм. Учир нь ҮЦЗЗТХ-иар үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын эрх зүйн байдал, чиг үүрэг,

тэдэнд хяналт тавих харилцааг л зохицуулснаас бус үйл ажиллагааг журамлаагүй байна. Нөгөө талаас хуулиар зохицуулаагүй бусад харилцааг СЗХ-оос баталсан журмуудаар нөхөж зохицуулах боломжгүй гэж судалгааны баг үзсэн болно. Үүнийг дараах байдлаар тодруулан тайлбарлай.

- Юуны өмнө байгаа нь нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болжээ. Өөрөөр хэлбэл, уг харилцааг нарийвчлан зохицуулаагүйгээс зарим тохиолдолд Энэ нь үнэт цаасны зах зээлд гарч байгаа хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэж буй байдлаас тодорхой харагдана. Өөрөөр хэлбэл, хэрэг маргаанд хариуцагчийг буруу тодорхойлох, шийдвэр нь хэрэг маргааны оролцогч бус этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх, эрүүгийн журмаар хэрэг маргаан шийдвэрлэгдэхгүй байх явдал гарч байна.
- Одоо үйлчилж буй үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжих харилцааг нарийвчлан зохицуулах
- Үнэт цаасны зах зээлд үүсч байгаа шинэ харилцааг хэрхэн зохицуулах

**III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛД ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР  
ТООЦОО, ХАДГАЛАМЖ, БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ДЭД БҮТЦИЙН  
ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ТАЛААРХИ СУДАЛГААНЫ  
ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ**

**3.1 Монгол улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн систем дэх үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, тогтолцоог боловсронгуй болгох нь**

Үнэт цаасны зах зээл нь эдийн засгийн салбарт хэрэгцээтэй байгаа хөрөнгийг татан төвлөрүүлэх, дахин хуваарилах гэсэн маш чухал 2 үүргийг гүйцэтгэж байдгаараа зах зээлийн эдийн засагт зайлшгүй хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэгцээтэй байгаа хөрөнгө оруулалтыг үнэт цаас гаргах замаар үнэт цаасны зах зээлээс олох, үнэт цаас худалдан авагч буюу хөрөнгө оруулагч нь хөрөнгөө ашигтай зүйлд зарцуулж орлого олох гэсэн харилцан ашигтай нөхцлийг бүрдүүлж энэ нь улс орны эдийн засагт эзэрг нөлөө үзүүлж байдгаараа түүний зайлшгүй шинж нь илэрхийлэгдэнэ. Нөгөө талаас үнэт цаасны зах зээл нь мэргэжлийн оролцогчид буюу дэд бүтцийн байгууллага, тэдгээрийн харилцан уялдаа, хамаарал бүхий үйл ажиллагаанаас бүрдэж байдаг. Тийм учраас эдгээр дэд бүтцийн байгууллагуудыг зах зээлийн эдийн засагт тохируулан зөв зохистой системчлэн хөгжүүлэх нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд шууд хамааралтай юм. Үүний нэг нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэл гэсэн дэд бүтцийн байгууллага юм.

Энэ нь үнэт цаасны зах зээлийг бүрдүүлэгч дэд бүтцийн бусад байгууллагаас тусдаа байж бие даасан институци болно гэдгийг улс орнууд нэгэнт хүлээн зөвшөөрч энэ тал дээр маргаангүй болижээ. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны дэд бүтцийн байгууллагуудын харилцан бие биенээ нөхцөлдүүлсэн хамтын үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээлийг бүрдүүлэх боловч тэдгээрийн гүйцэтгэх чиг үүрэг бүр тусдаа байж үйл ажиллагааг нь хэрхэн эрсдэл багатай, найдвартай байлгах тал дээр түлхүү анхаарч байна. Үнэт цаасны төлбөр тооцоо нь үнэт цаасны арилжааны хэлцлийг үндэслэн талуудын харилцан үүргийг тодорхойлж байдаг бол, хадгаламж, бүртгэл нь хэлцлийн үр дүн болж байдаг.

Мэдээж үнэт цаас эзэмшигчийн эрх нь хадгаламж болон бүртгэлийн дансанд бичилт хийсэнтэй холбоотойгоор үүсэхгүй, энэ түүнийг зөвхөн баталгаажуулж байгаа хэлбэр юм. Гэхдээ энэхүү баталгаагүйгээр үнэт цаасны эрх нэг эзэмшигчээс нөгөө эзэмшигчид шилжиж байгааг тогтоох боломжгүй бөгөөд шинэ эзэмшигчийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх хангагдахгүй.

Судалгаанд авагдсан гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, үнэт цаасны зах зээлийн

тогтолцооноос харахад ч үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн байгууллагыг уг зах зээлийн бие даасан институт байдлаар авч үзжээ. Ялангуяа хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг онцгой анхааран үзэж уг үйл ажиллагааны найдвартай, аюулгүй байдлыг объектив буюу эрх зохицуулалтыг боловсронгуй болгох, субъектив байдлаар буюу эдгээр үйл ажиллагааг үнэт цаасны мэргэжлийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэхгүй байх зохицтой нөхцлийг хангах нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэй болохыг хүлээн зөвшөөрч байгаа нийтлэг байдал ажиглагдаж байна.

Түүнчлэн нэгэнт үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаа нь бие даасан институци гэж үзээд түүний зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны эрсдэлийг багасгахад үнэт цаасны зах зээлийн бодлого чиглэгдэж байна. Нөгөө талаас Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллага/ IOSCO/-аас гаргасан зөвлөмжид ч үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах талаар тусгасан байdag. Тухайлбал, уг институцийн чадавхийг өөрийн зохицуулалтын механизмийг бий болго замаар сайжруулах нь хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн нэг алхам болно гэж үзэж үүнийг тусгасан эрх зүйн орчныг бүрдүүлэхийг гишүүн улсуудад зөвлөмжилсөн байdag. Манай улсын хувьд ч өөрийн орны үнэт цаасны зах зээлийг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн зохих алхамуудыг хийсээр ирсэн.

Жишээ нь, Хөрөнгийн бирж үнэт цаасны бүртгэл, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн чиг үүргийг төвлөрүүлэн эрхэлж байсан нь зах зээлийн нийтлэг горим, хяналт зохицуулалтыг тодорхой хэмжээнд алдагдуулж байна гэж үзсэн тул Азийн хөгжлийн банкны хөтөлбөрийн хүрээнд үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн чиг үүргийг салгаж “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” 100% төрийн өмчит компанийг бие даасан хэлбэрээр байгуулсан байна. Түүнчлэн 2010 оны 5 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн бэлэн төлбөр тооцоог бүрэн зогсоож, харилцагчдын мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог арилжааны банкаар гүйцэтгэх болсноор харилцагчид арилжааны банкин дах дансандаа шилжүүлэн авах боломжтой болсон.<sup>63</sup>

Энэ нь үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн систем дэх үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгамжийн үйл ажиллагааны зохион байгуулалт, тогтолцоог боловсронгуй болгож буй алхамууд бөгөөд үүнийг цаашид ч үргэлжлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нь шууд утгаараа “ҮЦТТХТ” ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой мэт ойлгогдож байгаа боловч, нөгөө талаас үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт гэсэн өргөн агуулгыг илэрхийлж байгаа юм.

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох үндсэн зарчим нь эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн байна. Зах зээлийн эрсдэл хэдий чинээ бага байна төдий чинээгээр хөрөнгө оруулагчийг татна гэсэн үг юм. Энэ үүднээс улс орнууд янз бурийн санхүүгийн хэрэгслиүүдээр уг тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч байна. Гэвч зарим тохиолдолд тухайн орны эдийн засгийн бүтэц, улс төрийн байгууламж /холбооны улс/ зэргээс хамааран хөрөнгийн бирж нь хадгаламжийн үйлчилгээг давхар эрхлэх, брокер дилперийн компани нь төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах практик байсаар байна.

### **3.2 Монгол улсын үнэт цаасны зах зээл дэх мэдээ, мэдээллийн аюулгүй байдал, учирч болох эрсдлээс хамгаалах**

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудалд мэдээ, мэдээллийн аюулгүй байдал томоохон байр суурь эзэнэ. Ялангуяа үнэт

<sup>63</sup> “ҮЦТТХТ” ХХК-ийн 2010 оны жилийн тайлан, 5 дахь тал

цаасны арилжaa нь уламжлалт цаасан хэлбэр бус тоон технологид суурилан явагдах хандлага давамгайлж байгаа нөхцөлд түүний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах тал дээр ихээхэн анхаарал хандуулж байна. Зах зээлд оролцогчид өөрсдийн санаснаар тухайн үнэт цаасны котировкид өөрчлөлт оруулах, үнэ ханшийг өсгөх бууруулах замаар “мөнгө хийх” боломж нь байдаг учраас харилцагчдын дансны талаарх мэдээллийг тусгаарлах, нууцлах нь үнэт цаасны зах зээлд чухал асуудал байдаг.<sup>64</sup>

Мөн мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах гадаадын улс орнуудын туршлагаас харахад энэхүү харилцааг тусгайлан зохицуулсан хуультай орон ч байна. Манай улсын хувьд ч энэхүү асуудал нь тулгамдаж байгааг хэлэх нь зүйтэй юм. Учир нь бух харилцагчдын хадгаламж төвлөрсөн байдалтай байгаа, МУ-ын Засгийн газрын шийдвэрээр МУ-ын иргэн бүр хувьцаа эзэмшигч болсонтой холбогдуулан УБЕГ-аас Төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн 17-д заасан мэдээ, мэдээллийг “ҮЦТТХТ” ХХК хүлээн авсан. Нөгөө талаас үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тусад нь бус Үнэт цаасны дотоод мэдээлэл хэмээн нийтлэг байдлаар авч үзэн СЗХ-оос тогтоосон журмаар зохицуулж байгаа зэрэг нь үүнд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм. Үнэт цаасны зах зээлийн мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангахгүй байх нь зах зээлд хиймэл үнэ тогтох, манипуляци хийх, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зарчим алдагдах зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэх нь ойлгомжтой.

Гадаадын зарим оронд тусгайлсан хууль гаргах, программ боловсруулах, үнэт цаасны зах зээлийг зохицуулах байгууллага нь нууц гэж үзсэн мэдээллийг хадгалах нөхцөл, түүнтэй хэрхэн харилцахыг тусгасан журам боловсруулах, мэргэжлийн оролцогчид өөрсдөө журам тогтоо зэрэг харилцан адилгүйгээр мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна. Гэхдээ улс орнуудын практикт дараах нийтлэг шинжүүд байна. Үүнд:

- Мэдээ мэдээллийг зөвхөн анх олж авсан зорилгын дагуу ашиглах
- Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг ялгамжтай байдлаар авч үзэж мэдээллийн хэт төвлөрөлийг бууруулах.
- Мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах тусгай программтай байх /зөвхөн тухайн үйл ажиллагаанд зориулсан/
- Мэдээ мэдээллийн аюулгүй байдлын талаарх хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах /мэргэжлийн байгууллагуудын үйлчлүүлэгчтэй хийж буй гэрээнд мэдээ мэдээллийн талаар заавал тусгаж, талуудын эрх үүргийг тодорхойлох/

Манай улсын хувьд энэ харилцааг ҮЦЗЗтХ, СЗХ-оос тогтоосон журмаар зохицуулж байгаа хэдий ч нэгталаас хэт ерөнхий байна гэж үзэж болохыг өмнө нь дурдсан билээ. Үнэт цаасны зах зээлийн мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд юуны өмнө уг зах зээлийг бүрдүүлэгч дэд бүтцийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг тусгасан мэдээ мэдээллийн журмыг боловсруулах шаардлагатай юм. Тодруулбал, үнэт цаасны хадгаламжийн хувьд ямар төрлийн мэдээллийн санг зайлшгүй бүрдүүлэх ёстой, ямар төрлийн мэдээлэл нээлттэй байж болох, ямар мэдээллийг зөвхөн үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ болон зөвшөөрлийн үндсэн дээр бусдад нээлттэй болгох, мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар дэд бүтцийн байгууллага нь үнэт цаасны зах зээлийг хянах зохицуулах байгууллагын өмнө ямар эрх эдэлж үүрэг хүлээх гэх мэт харилцааг нарийвчлан зохицуулах нь мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах суурь болох юм.

<sup>64</sup> “ҮЦТТХТ” ХХК-ийн танилцуулгаас

Одоогийн байдлаар энэхүү харилцааг хэм хэмжээчилж болох 2 үндсэн арга байна. Үүнд:

1. Эрх бүхий байгууллагаас журам батлах. Дэд бүтцийн байгууллагууд СЗХ-той хамран журмын төсөл боловсруулж батлуулах. Энэ нь одоогийн нөхцөлд тухайн харилцаандaa хууль зүйн хувьд хамгийн дээд хүчин чадал бүхий эрх зүйн акт болно. Нөгөө талаас энэ журам нь мэргэжлийн оролцогдоос заавал дагаж мөрдөх буюу гадагш чиглэсэн хэм хэмжээ болох тул зөвхөн нэг байгууллага гэлтгүй түүнтэй үйл ажиллагааны хувьд харилцаатай бусад этгээдүүд ч дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Жишээлбэл, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн үнэт цаасны зах зээлийн бусад оролцогчтой харилцах мэдээ мэдээллийн хүрээг тогтоон журамласан тохиолдолд бусад оролцогчид уг журмаас гадуур мэдээлэл шаардах эрхгүй болно.

Түүнчлэн угжурамд мэдээ мэдээллийг ажил үүргийн дагуу чөлөөтэй олж авах субъектыг тодорхой зааж өгөх нь мөн ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах чиг үүрэг бүхий байгууллага, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг журамд нэг бүрчлэн зааж өгөн тэдгээр байгууллагуудад мэдээ мэдээлэл гаргаж өгөх харилцааг журмаар зохицуулах юм. Мөн уг журмаар нийтэд заавал мэдээлж байх мэдээ мэдээллийн төрлийг тогтоох нь зүйтэй юм. Ингэснээр үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулагч болон бусад оролцогчдын хооронд мэдээ мэдээллийн зохистой харилцаа үүсэх бөгөөд энэ нь уг зах зээлд гарч болзошгүй эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулахад нөлөөлөх юм.

2. Байгууллагын дотоод журам. Үнэт цаасны дэд бүтцийн байгууллага нь хөрөнгө оруулагч, харилцагчдын өмнө түүнтэй холбоотой мэдээ мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй болохыг өмнө нь дурдсан билээ. Энэ нь байгууллагын нууцыг хамгаалахаас ялгаатай ойлголт юм. Эхний тохиолдол нь ажил үүргийн дагуу олж авсан мэдээллийг **хадгалах** ойлголт бол дараагийн тохиолдол нь байгууллага өөрөө нууц гэж үзсэн мэдээллээ **хамгаалах** явдал юм.

Ялангуяа “ҮЦТТТХТ” ХХК нь үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчдын хадгаламжийг төвлөрүүлсэн, УБЕГ-аас төрийн нууцад хамаарах мэдээллийг хүлээн авсан тул үнэт цаасны зах зээлийн хөгжил, нийтлэг эрх ашгийн үүднээс нууцын журамтай байх зайлшгүй шаардлагатай юм. Уг журамд ямар мэдээллийг нууцад хамруулах, нууцыг ямар субъект эрхлэн хамгаалах, ямар нөхцөлд хэний зөвшөөрлөөр нууц мэдээллийг түгээх зэргийг зааж өгөхөөс гадна уг байгууллагын мэдээллийн нэгдсэн санг төрийн хамгаалалтад авах асуудал ч хөндөгдөх юм. Үүнтэй холбоотойгоор төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн мэдээ мэдээллийг одоо боловсруулж буй “Кибер аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн төсөлд зайлшгүй тусгах нь зүйтэй юм.

Мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах дараагийн нэг алхам нь мэдээллийн технологийн талаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ юм. Энэ нь бусад улс орнуудад нэвтэрсэн туршлага бөгөөд мэдээллийн нэгдсэн сант гадны хадлагаас сэргийлэх, найдвартай, тогтвотой ажиллагааг хангах арга хэмжээ юм.

### **3.3 Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, бүртгэлийн байгууллагын статус, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал**

Судлагдсан гадаадын зарим орнуудын үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт нь хэд хэдэн хуулиас бүрдэж байгаа жишээг 1 дүгээр бүлэгт авч үзсэн. Энэ нь үнэт цаасны дэд бүтцийн байгууллагуудыг эрх зүйн зохицуулалтаар системчлэх, эдгээр эрх зүйн зохицуултуудын нийлбэр цогц нь үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж байна гэж хэлж болно. Жишээ нь ОХУ-ын хувьд “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-аас гадна “Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тухай” хуулиар давхар зохицуулж байдаг бол АНУ-д уг зах зээлийг 7 гол хуулиар

зохицуулж байдаг.<sup>65</sup>

Негеө талаас үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн байгууллага нь үнэт цаасны зах зээлийн бусад мэргэжлийн оролцогчдоос эрх зүйн байдал, чиг үүрэг, үйл ажиллагааны хувьд тусдаа байж уг зах зээлийн хэвийн ажиллагааг хангах, хөрөнгө оруулагчдийн эрх ашиг сонирхолын хамгаалах баталгаа болж байдаг. Учир нь үнэт цаасны арилжааны эдгээр үе шатанд хөрөнгө оруулагчийн эрх объектив байдлаар баталгаажин хамгаалагдаж байдаг нь нэгэнт тодорхой тул түүний бие даасан, эрсдэлгүй байдлыг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх нь юу юнаас чухал юм.

Манай улсын үнэт цаасны зах зээлд гарч буй хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэж байгаа байдал нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаа бүрэн хэмжээгээр эрх зүйгээр зохицуулагдаагүй, үнэт цаасны арилжаан дахь хэлцлийн онцлогийг тусгасан зохицуулсан хэм хэмжээ байхгүй зэрэг нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд эрх зүйн зохицуулалт дутагдаж буйг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны онцлог, хөрөнгө оруулагч нь үнэт цаасныхаа хувьд шударга өмчлөгч болдог байдал, түүний эрх, ашиг сонирхлын эрх зүйн хамгаалалтын онцлог зэргийг тусгайлан хуульчиллаагүйгээс хуульчдын дунд нэгдсэн ойлголт байхгүй, практик тогтоогүй нь хэрэг маргаанууд нь өөр өөрөөр байдлаар шийдвэрлэх, дахин хянах зэрэг үр дагаврууд үүсч байна. Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн харилцаа бүрийг нарийвчлан зохицуулаагүйгээс Эрүүгийн хуулийн 158 дугаар зүйлд заасан “Үнэт цаасны хууль тогтоомж зөрчих” гэмт хэргийн объектив талын шинжийг тогтооход ихээхэн хүндэрлэлтэй болж энэ төрлийн хэрэг эрүүгийн журмаар шийдвэрлэгдэхгүй байна.

УИХ 2009 оны 5 сарын 14 өдөр “Монгол улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг 38 дугаар тогтоолоороо баталж, уг тогтоолын 39-т “Үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн тогтвортой хөгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь шинэчлэн сайжруулах”-аар заасан. Үүний дагуу “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчлэсэн найруулгын төслийг боловсруулж байна.

Хэдийгээр “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах нь зүйтэй боловч зөвхөн нэг хуулийг шинэчилэн найруулснаар үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь шинэчлэн сайжруулах зорилгод хүрнэ гэдэгтэй судалгааны баг санал нийлээгүй болно. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны зах зээл нь нийгмийн болон олон талын шинжлэх ухааны харилцааг агуулдаг тул энэ бүх харилцааг нэг хуулиар зохицуулах боломжгүй юм. Иймээс судалгааны баг дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Юуны өмнө үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын одоогийн тогтолцоог дэмжинэ. Тодруулбал, мэргэжлийн үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагаагаар эрхлэх буюу дэд бүтцийн байгууллагууд нь эрх зүйн байдлын хувьд компани хэлбэртэй байх. Мөн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж бүртгэлийн байгууллага нь үйл ажиллагааны хувьд бие даасан байх.

Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлд оролцогчдын шударга бус өрсөлдөөн, хууль бус үйлдлээс харилцагчдын дансанд байгаа үнэт цаас мөнгөн хөрөнгө найдвартай хамгаалагдсан байх ёстой. Үүний тулд депозстарийн үйл ажиллагаа эрхлэх бие даасан байгууллага байгуулдаг нь олон улсын жишиг.<sup>66</sup> Негеө талаас одоогийн

<sup>65</sup> Дэлгэрэнгүйг судалгааны 1 дүгээр бүлгийн АНУ хэсгээс харна уу.

<sup>66</sup> Норовдондог Ц. Монгол улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн тулгамдсан асуудлууд, Бодлогын судалгаа шинжилгээ /судалгааны эмхэтгэл/, УИХ-ын Тамгын газар Судалгааны төв,

байгаа тогтолцоог заавал өөрчлөх шаардлага, үндэслэл байхгүй байгаа бөгөөд энэхүү тогтолцоо нь үүдэлтэй үнэт цаасны зах зээл лэх эрсдэлийг багасгах эерэг талтай гэж ёудалгааны баг үзсэн болно.

2. “Үнэт цаасны зах зээлийн тухай” багц хуультай болох. Энэхүү эрх зүйн зохицуулалтыг хийхдээ ерөнхийгөөс тусгай уруу гэсэн зарчмыг баримтлах бөгөөд дараах хуулиудыг юуны өмнө боловсруулах нь зүйтэй гэж судалгааны баг үзсэн болно. Үүнд:
  - “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиар үнэт цаасны зах зээлийн ерөнхий бүтэц, үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах тогтолцоо, үнэт цаас гаргах нийтлэг зарчим шаардлага, дэд бүтцийн байгууллагуудын тогтолцоо, чиг үүрэг зэрэг харилцааг зохицуулах
  - Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын тухай хуулиар үнэт цаасны мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээ, үнэт цаасны зах зээлд оролцох эрх үүрэг, харилцагчидтай байгуулах гэрээний стандарт, үйл ажиллагаанд нь хяналт тавих механизм, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэргэжлийн оролцогчидтой холбоотой маргааныг шийдвэрлэх тусгайлсан журам зэрэг харилцааг зохицуулна.
  - “Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай” хуулиар хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаарх үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх бүхий байгууллагын эрх хэмжээ, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааны болон мэдээ мэдээллийн хувьд харилцагчийн өмнө хүлээх үүрэг, хэрэг маргаан шийдвэрлэхэд анхаарах хүчин зүйл<sup>67</sup> зэрэг харилцааг зохицуулна.
  - Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль

Эдгээр хуулийг боловсруулах нь олон талын мэдлэг, мэргэжил шаардсан ажил боловч үүнийг зайлшгүй хийх нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх эрх зүйн хөрөнгө суурь болох нь тодорхой юм.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

---

УБ, 2011 он, 244 дэх тал

<sup>67</sup> Хэрэг маргаан шийдвэрлэх журамд Иргэний хуулийн биржийн хэлцлийн онцлог, шударга өмчлөгчийн эрхийг илүү нарийвчлан авч үзэх санааг илэрхийлсэн болно. /судалгааны баг/

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БҮЙ  
ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ БОЛОН ХУВЬ  
ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ**

Ц. Норовдоондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын захиалгын дагуу 1993, 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль болон 2011 онд “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар зохицуулсан тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний төрөл, зүйлийн харьцуулалтыг УИХ -ын ТГ -ын Судалгааны төвийн судлаачид гүйцэтгэлээ.

#### **Судалгааны бүтэц**

1-р хэсэгт “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх үндэслэл, шаардлагыг уг хуулийн хувийн хэрэг дээр тулгуурлан судаллаа. 2-р хэсэгт 1993 оноос хойш мөрдөгдж байсан “Улсын тэмдэгтийн тухай” хууль болон 2010 оны шинэчилсэн найруулга, 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зохицуулсан тэмдэгтийн хураамжийн төрөл, үйлчилгээний чиглэл тус бүрийн хураамжийн хэмжээний харьцуулалтыг гаргалаа.

Захиалгад дурьдсан дагуу тэмдэгтийн хураамж төлөгчдийн судалгаа болон улсын тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний төрөл тус бүрээр орлогын хэмжээг гаргах боломжгүй байсан. Учир нь Сангиин яам болон Татварын Ерөнхий газраас 1993 онд батлагдсан хуулийн хүрээнд тэмдэгтийн хураамжийн орлогыг үйлчилгээний төрөл тус бүрээр гаргадаггүй. Харин 2010 онд батлагдсан хуулийн дагуу 2011 оны 3 дугаар улирлаас эхлэн тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний төрөл тус бүрээр гаргах боломжтой болно гэсэн хариу ирүүлсэн.

#### **СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

УИХ-аас 2010 оны 11 сарын 25-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хууль 2011 оны 1 сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлснээр нийгмийн зүгээс шүүмжлэлд өртөн, бизнес эрхлэгчдээс санал гомдол ихээр гарах болсон. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн актууд болон бусад орнуудын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсоноор “Тэмдэгтийн хураамж” гэдэг бол нэг төрлийн татвар гэж үзэж болох юм. 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийг Монгол Улсын 2011 оны төсвийн төсөлтэй хамт УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд ингэхдээ ямар нэг нарийвчилсан судалгаа, тооцоо гаргаагүй байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоохдоо тухайн хураамж авч байгаа салбарын ач холбогдол болон үйлчилгээний цар хүрээ, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, төрөөс баримталж буй бодлого зэргийг харгалзан тодорхой аргачлалаар тооцоо шаардлагатай байна.

Судалгаанаас үзэхэд тэмдэгтийн хураамжийн төрлөөр авч үзвэл, 1993 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар төрийн захиргааны байгууллага болон Засаг даргаас нийт 18 төрлийн 84 үйлчилгээнээс хураамж авдаг байсан бол 2010 онд батлагдсан хуулиар 42 төрлийн 564 үйлчилгээнээс төлбөр хураамж авах болж, 2010 оны хуулиар нийт 24 төрлийн 480 үйлчилгээнээс төлбөр хураамж авахаар нэмэгдсэн байна. Харин 2011 онд “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар нийт 7 төрлийн 149 үйлчилгээнээс тэмдэгтийн хураамж авах заалтыг хүчингүй болгож, 43 төрлийн үйлчилгээг нэмэлт оруулсан байна.

**“УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ” ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БҮЙ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ  
ХУРААХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ БОЛОН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ**

Нэг. “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын үндэслэл, шаардлага

Засгийн газраас “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 2011 оны “Монгол Улсын төсвийн тухай” хуулийн төсөлтэй хамтад нь өргөн мэдүүлсэн. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль 1993 онд батлагдан мөрдөгдсөнөөс хойших 10 гаруй жилийн хугацаанд “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулиар зохицуулж бүй үйлчилгээний төрөл болох эрх бүхий этгээдээс эрх олгох, эрх шилжүүлэхтэй холбогдсон баримт бичиг олгох, бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлан гэрчлэх, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, зохих этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, нотариатын үйлчилгээ үзүүлэх болон бусад улсын тэмдэгтийн хураамж тогтоох шаардлага бүхий үйл ажиллагаануудыг зохицуулсан хуулиуд үндсээрээ өөрчлөгдсөн болон шинээр батлагдан гарсан байдаг.

Мөн эд хөрөнгө өмчлөх, газар өмчлөхтэй холбогдон тэмдэгтийн хураамж тогтоох төрийн шинэ үйлчилгээнүүд бий болсон, үйл ажиллагааныхаа орлогоор санхүүждэг засгийн газрын агентлагуудын үйл ажиллагааны орлогын зарим хэсгийг тэмдэгтийн хураамжаар бүрдүүлж түүнийг төсөвт төвлөрүүлдэг болгох, хуулийн хүрээнд олгогдож байгаа зөвшөөрөл лицензүүдийг олгогдсон хугацаатай нь уялдуулан тэмдэгтийн хураамж тогтоож байх зэрэг нөхцөл шалтгаануудын улмаас уг шинэчилсэн найруулгын төслийг төсөл санаачлагч боловсруулсан байна.

2000-2008 онд гарсан хуулиудын шинэчлэлтээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, эрхийн бүртгэл хийх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх эрх зүйн зохицуулалтад олон өөрчлөлт орж, төрөөс зайлшгүй зөвшөөрөл олгох, хяналт тавих шаардлагатай Галт зэвсгийн тухай”, “Хувийн хамгаалалтын тухай”, “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” болон “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Татварын ерөнхий хууль” гэх мэт олон хуулийг шинэчлэн найруулж баталсан юм.

Хоёр. 1993, 2010 онд батлагдсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль болон 2011 онд “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар зохицуулсан тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний төрөл, зүйлийн харьцуулалт 1993 онд батлагдсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар төрийн захиргааны байгууллага болон Засаг даргаас нийт 18 төрлийн 84 үйлчилгээнээс хураамж авдаг байсан бол 2010 онд батлагдсан хуулиар 42 төрлийн 564 үйлчилгээнээс төлбөр хураамж авах болж, 2010 оны хуулиар нийт 24 төрлийн 480 үйлчилгээнээс төлбөр хураамж авахаар нэмэгдсэн байна. Харин 2011 онд “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар нийт 7 төрлийн 149 үйлчилгээнээс тэмдэгтийн хураамж авах заалтыг хүчингүй болгож, 43 төрлийн үйлчилгээг нэмэлт оруулсан байна.

Тэмдэгтийн хураамж авах хэмжээний хувьд өөрчлөлт оруулсан нь харилцан адилгүй байсан бөгөөд энэ судалгаанд 1993, 2010 онуудад батлагдсан “Тэмдэгтийн хураамжийн тухай” хууль болон 2011 онд “Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиудын тус бүрийн хуулийн зүйл заалт тус бүрээр харьцуулсан болно. Хүн амын амьжиргааны доод түвшин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь жил тутам тогтмол тодорхой хувиар нэмэгдэж байсан бол 2010 онд батлагдсан Тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй ямар нэг байдлаар уялдаагүй огцом буюу хэд дахин нэмэгдсэн байна.

Тухайлбал: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар 1993-2010 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилэх тусгай зөвшөөрлийн хэмжээ нь 12 500 төгрөг байсан

Судалгааны эмхтгэл, XI боть

бол 2010 оны хуулиар 20 000 000 хүртэл нэмэгдэж, харин 2011 оны нэмэлт, өөрчлөлтөөр спиртын агууламж болон нийслэл, аймаг, сумдад 1 500 000 хүртлэх төгрөгөөр ялгамжтай тогтоосон болно.

\* \* \*

Хураамж хураах үйлчилгээг 1993, 2010 онд батлагдсан” Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль болон 2011 оны 6 сарын 09-ний өдөр “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хоорондын харьцуулалт:

№	1993 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль			2010 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хууль			2011 оны 6 сарын 09-ний өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт			Тайлбар
	Хуулийн зүйл	Төрөл	Хувь, хэмжээ	Хуулийн зүйл	Төрөл	Хувь, хэмжээ	Хуулийн зүйл	Төрөл	Хувь, хэмжээ	
(A)	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)	(10)

1.

(A)	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)	(10)
6-р зүйл Шүүхэс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх	6.1.эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд	50 төгрөг, 0.5-2 хувь	7-р зүйл Шүүхэс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх	7.1.1. эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дунгээс хамаарч	60 төгрөг, 0.5-3.5 хувь	7.1.1. эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дунгээс хамаарч	4550 төгрөг 0.5-3 хувь	2010 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн тус заалтын хувь хэмжээ нь 1993 оны хуулиас 20 хувиар нэмэгдэж байсан бол, 2011 оны хууль 2010 оныхоос 75,8 дахин есцен байна.	2010 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн тус заалтын хувь хэмжээ нь 1993 оны хуулиас 20 хувиар нэмэгдэж байсан бол, 2011 оны хууль 2010 оныхоос 75,8 дахин есцен байна.	
	6.2.эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд	250 төгрөг;		7.1.2. эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд	550 төгрөг		7.1.2 эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд	70 200 төгрөг	2010 онд 1993 оныхоос 2,2 дахин, 2011 онд 2010 оныхоос 127,6 дахин нэмэгдсэн.	2010 онд 1993 оныхоос 2,2 дахин, 2011 онд 127,6 дахин нэмэгдсэн.
	6.3.хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход	хуудас тутмаас 25 төгрөг		7.1.3. хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход	хуудас тутамд 55 төгрөг		7.1.3.хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход	хуудас тутамд 100 төгрөг.	2010 онд 1993 оныхоос 2,2 дахин, 2011 онд 1,8 дахин нэмэгдсэн.	2010 онд 1993 оныхоос 2,2 дахин, 2011 онд 1,8 дахин нэмэгдсэн.

2.

(A)	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)	(10)
6 <sup>1</sup> Арбитрын эжилтганд шүүх оролц	6 <sup>1</sup> .1.арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт шийдвэрлэхэд	нэхэмжлэлийн үнийн дунгийн 0,1 хувь	8-р зүйл арбитрын эжилтганд шүүх оролцох:	8.1.1.арбитрын шийдвэрийг хүчингүй болгох, баталгаажулах, гүйцэтгүүлэх тухай хүсэлт шийдвэрлэхэд	8.1.2. Арбитрын тухай хуульд заасан бусад асуудлаар шийдвэр гаргахад	нэхэмжлэлийн үнийн дунгийн 0,1 хувь	нэхэмжлэлийн үнийн дунгийн 0,05 хувиар	Өөрчлөлтгүй.	Өөрчлөлтгүй.	Өөрчлөлтгүй.
	6 <sup>1</sup> .2.арбитрын шийдвэрийг баталгаажулах, гүйцэтгүүлэх тухай хүсэлт шийдвэрлэхэд	нэхэмжлэлийн үнийн дунгийн 0,1 хувь;								
	6 <sup>1</sup> .3.Арбитрын тухай хуульд заасан бусад асуудлаар шийдвэр гаргахад	нэхэмжлэлийн үнийн дунгийн 0,05 хувиар.								

3.

(A)	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(10)
3 7-р зүйл Нотариатын үйлчилгээ үзүүлэх; 9-р зүйл Нотариатын үйлчилгээ үзүүлэх;	1. эд хөрөнгийн бус, үнэтж болохгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд	500 төгрөг;		9.1.3. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд	1100 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	2.эд хөрөнгийн бус, үнэтж болохгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд	500 төгрөг;		9.1.4. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд	1100 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	3.эд хөрөнгө хэлслэх, түрээслэх гэрээ,хэлцэл гэрчлэхэд	750 төгрөг;		9.1.5. эд хөрөнгө хэлслэх, түрээслэх гэрээ,хэлцэл гэрчлэхэд	1100 төгрөг;	2010 онд 1993 оныхос 46,7 хувиар нэмэгдсэн.	
	4.хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг гэрчлэхэд	2000 төгрөг;		9.1.6. хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд	4400 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	5.хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд	500 төгрөг;		9.1.7.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд	1100 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
				9.1.8.хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг нотариатаар гэрчлэхэд	2000 төгрөг;	2010 оны хуулиар шинээр орж ирсэн.	
	6.итгэмжлэл гэрчлэхэд	500 төгрөг;		9.1.9.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт материал гэрчлэхэд	20000 төгрөг;	2010 оны хуулиар шинээр орж ирсэн.	
	7.бичиг баримтыг гэрчлэхэд	хуудас тутмаас 50 төгрөг;		9.1.10.итгэмжлэл гэрчлэхэд	1100 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	8.орчуулсан бичиг баримтыг гэрчлэхэд	хуудас тутмаас 100 төгрөг;		9.1.11.баримт бичгийг болон түүний хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас	110 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	9. бичиг баримтад зурсан гарын үсгийг гэрчлэхэд	1000 төгрөг		9.1.12.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас	300 төгрөг;	2010 онд 1993 оныхос 3,0 дахин нэмэгдсэн.	
	10. гарчилгээдсэн бичиг баримтын хуулбарыг гэрчлэхэд	хуудас тутмаас 50 төгрөг;		9.1.13.баримт бичигт зурсан гарын үсгэг гэрчлэхэд	2500 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,5 дахин нэмэгдсэн.	
	11. үйлчлүүлэгчийн хүснэгтээр үндсэн материалыг шалгахад	2000 төгрөг;		9.1.14.гарчилгээдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд	хуудас тутмаас 110 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	12. гэр бурийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр имчлэх эрхийг гэрчлэхэд	250 төгрөг;		9.1.15.үйлчлүүлэгчийн хүснэгтээр үндсэн материалыг шалгахад	4400 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	13. өв замгамжлах эрх, гэрээслэлийг гэрчлэхэд	500 төгрөг;		9.1.17.гэр бурийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд	550 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	14. үл хэдлэх эд хөрөнгийн холбогдолтой бичиг баримт гэрчлэхэд	2000 төгрөг;		9.1.1.үл хэдлэх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичиг гэрчлэхэд	4400 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдсэн.	
	15. өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүмүүст өв замгамжлах эрхийн гэрчилгээ олгоход	4000 төгрөг;		9.1.18.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүнд өв замгамжлах эрхийн гэрчилгээ олгоход	10000 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,5 дахин нэмэгдсэн.	
	16. үл хэдлэх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхэд	гэрээний үнийн дунгээс 0,03 хувь, бусад хүмүүст 0,05 хувь;		9.1.2.үл хэдлэх эд хөрөнгийн гэрээ гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд	гэрээний үнийн дунгээс 0,03 хувь, бусад хүнд 0,05 хувь;		Өөрчлөлт ороогүй

## Судалгааны эмхтгэл, XI боть

4.

(A)	(2)	(3)	(5)	(6)	(8)	(9)	(10)
	17. энэ хэсгийн 1,2,3,16-д зааснаас бусад гэрзэ, хэлцлийг гэрчлэхэд.	үнийн дүнгийн 1 сая хүртэл төгрөгөөс 0,02 хувь, 1сая төгрөгөөс давсан хэсгээс 0,01 хувь	9.1.21.энэ хуулийн 9.1.2-9.1.5-д зааснаас бусад гэрзэ, хэлцлийг гэрчлэхэд	үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.02 хувь, 1 000 000 төгрөгөөс давсан дүнгээс 0.01 хувиар			Өөрчлөлт ороогүй
			9.1.19.үнэт цаас өмчлөх эрхийн гэрчилгээ гэрчлэхэд	5000 төгрөг;			2010 оны хуулинд шинээр орсон.
			9.1.20.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд	үнийн дүнгийн 1.2 хувь.			2010 оны хуулинд шинээр орсон.
	2/ гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход	125 төгрөг ;	10.1.2.гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход	300 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	3/гэрлэлтийг цуцалсан тэмдэглэл хийхэд хүн бүрээс	250 төгрөг;	10.1.3.гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоход	хүн тус бүрээс 550 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	4/эцэг, эхийн болон хүүхдийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсөн баримт бичиг олгоход	100 төгрөг;	10.1.4.гэрлэлт сэргээснийг бүртгэхэд	хүн тус бүрээс 440 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	5/гэрлэлт сэргээснийг бүртгэхэд	хүн тус бүрээс 200 төгрөг;	10.1.5.эцэг, эх тогтоосныг бүртгэж, гэрчилгээ олгоход	330 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	6/үрчлэлтийг бүртгэж , гэрчилгээ олгоход	150 төгрөг;	10.1.6.үрчлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход	330 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	7/ эцэг, эх тогтоосныг бүртгэхэд	150 төгрөг;	10.1.7.овог, эцэг / эх-/ийн нэр, нэр өөрчилснийг бүртгэж, гэрчилгээ олгоход	220 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		
	2/ иргэний үнэмлэхийн хугацаа сунгахад	75 төгрөг	10.3.3.иргэний үнэмлэхийг 25, 45 настай иргэнд сольж олгоход	3300 төгрөг;	10.3.3.иргэний үнэмлэхийг 25, 45 настай иргэнд сольж олгоход	3300 төгрөг;	2010 онд 1993 оныхос 2,2 дахин нэмэгдэж, 2011 онд өөрчлөлт ороогүй байна.
			10.3.2.иргэний үнэмлэхээ алдаж үрэгдүүлсэн, гээгдуулсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход	25000 төгрөг;	2011.06.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон		2010 онд 1993 оныхос 44 дахин нэмэгдэж, түүнээс хойш өөрчлөлт ороогүй.

(A)	(2)	(3)	(5)	(6)	(8)	(9)	(10)
	39.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаядал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл олгоход	950 000 төгрөг.		39.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаядал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл олгоход	950 000 төгрөг.	Өөрчлөлт ороогүй

	40-р зүйл Баримт бичиг баталгаажуулж, “Апостиль” гэрчилгээ олгоход	40.1.Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны баримт бичгийг терийн захирагааны төв байгууллагаас баталгаажуулж, “Апостиль” гэрчилгээ олгоход	20 000 төгрөг	40-р зүйл. Баримт бичиг баталгаажуулж, “Апостиль” гэрчилгээ олгоход	40.1.Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны баримт бичгийг терийн захирагааны төв байгууллагаас баталгаажуулж, “Апостиль” гэрчилгээ олгоход	8000 -20 000 төгрөг	Өөрчлөлт ороогүй
--	--	---	---------------	---	---	------------------------	------------------



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО  
БА ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ОЛОН НИЙТИЙН САНАЛ ШҮҮМЖ**  
(Лавлагаа мэдээлэл)

Д. Мягмарцэрэн, Ч. Базар (Ph.D), Ц. Батдорж, С. Дорждагва, Б. Дуламсүрэн,  
Б. Мэнхцэцэг, Ч. Оончимэг, Н. Түвшинтөгс, Ц. Элбэгзаяа

## ОРШИЛ

Судалгааны энэхүү хэсэгт “Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, олон нийтээс гарч буй санал шүүмжид хийсэн контент анализ ” сэдвийн хүрээнд УИХ-ын 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийн үр дүн болон орд ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон нийтээс санал болгож буй хувилбар зэргийг нэгтгэн лавлагаа мэдээллийн хэлбэрээр бэлтгэв. Судалгааны үр дүнд Тавантолгойн нүүрсний орд ашиглалтын талаар төрөөс баримталж буй өнөөгийн бодлогын хүрээнд уг ордыг Монгол улсад үр өгөөжтэйгээр ашиглаж чадах эсэх, энэ талаар олон нийт ямар саналтай байгаа зэргийг тодруулахыг зорьсон болно.

### Судалгааны бүтэц:

- Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого, холбогдох шийдвэрүүд
- УИХ болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээ, хийгдсэн ажлууд
- Таван толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарчим, хэрэгжилт
- Тендерт оролцогч, шалгарах магадлал бүхий гадаадын хөрөнгө оруулагч компанийд
- Ордын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар төрийн болон олон нийтийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдын санал болгож буй хувилбарууд гэсэн үндсэн хэсгүүдтэй.

### Судалгааны үр дүн:

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар өнөөг хүртэл хийгдсэн ажлуудын үр дүнг нэгтгэн харахад одоогоор Монгол улс уг ордоос хэдий хэмжээний ашиг хүртэх эсэхийг шууд дүгнэхэд хэцүү байна. Хэдий хэмжээний ашиг хүртэхийг тооцохын тулд эхний ээлжинд дор хаяж Тавантолгойн ордын ТЭЗҮ, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ шаардлагатай. Гэтэл судалгааны явцад цуглуулсан мэдээллүүдээс харахад одоо болтол ТЭЗҮ, үнэлгээний талаар тодорхой тоо баримт байхгүй байна.

Тавантолгойг ашиглаад эхлэхээр Монгол улс ашиг олно гэсэн тойм багцаа л байгаа болохоос уг орд чухам ямар үнэ цэнэтэй, эдийн засгийн хэр өгөөжтэй, хэчнээн хэмжээний хөрөнгөөр ямар бүтээн байгуулалт хийгдэх нь тодорхойгүй байна. Гэтэл ийнхүү урьдчилсан тооцоо байхгүйгээр Ажил гүйцэтгэх, Хөрөнгө оруулах талаар эхний хэлэлцээрүүд хийж оролцогчдыг тодруулж байгаа нь ордоос олох ашгийн хэмжээг бууруулсан байдлаар тохиролцох, магадгүй зарим тохиолдолд Монгол улсад ашиггүй гэрээ хэлэлцээрүүд байгуулагдаж болох талтай.

Иймээс ордын ТЭЗҮ-г хийж, нөөцийг нь олон улсын стандартын дагуу тогтоож, удирдлагын багаа бүрдүүлсний дараа олон улсад нэр хүнд бүхий компаниар үнэлгээ

хийлгэх шаардлагатай. Ингэснийхээ дараа сонгосон биржтэйгээ харилцаж, биржээс томилогдсон зөвлөхүүдтэй хамтран ажилласнаар олон улсын бирж дээр IPO хийх эрхтэй болно. Хамгийн гол зүйл нь “ЭрдэнэсТавантолгой” ХК-ийн 30 хувийн хувьцаа ямар үнэд хүрэх вэ гэдэг тодорхойгүй байна. Тавантолгой ордын баялагт бодитой үнэлгээ хийгдээгүй болохоор одоо хaa хаанаа зөвхөн бүдүүн бараг тооцоогоор л ярьцааж байна. Энэ нь олон нийтэд Тавантолгой орд ашиглалтын гэрээг Засгийн газар хийж чадахгүй гэсэн урьдчилсан болгоомжлол үүсгэсэн байна.

Гэхдээ одоогоор эдгээрийг буруутгах аргагүй бөгөөд ТЭЗҮ боловсруулах явц болон бусад холбогдох гэрээ хэлэлцээрийн явц эхлэлийн шатандаа байгаа тул цаашид сайжрах болно гэж найдаж болох юм. Судалгааны зорилго ч орд ашиглалтын талаар одоо хийгдэж байгаа ажлуудыг үнэлж дүгнэхэд чиглээгүй бөгөөд болж буй үйл явцыг л нэгтгэн харуулахыг зорьж лавлагаа мэдээлэл бэлтгэсэн. Цаашид холбогдох тоо баримтууд тодорхой болохын хэрээр дүн шинжилгээнд чиглэсэн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж болно.

## **1. ТАВАНТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ХОЛБОГДОХ ШИЙДВЭРҮҮД**

### **УИХ-ЫН 39 дүгээр тогтоолын хэрэгжилт**

Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийг “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулж, Төрийн өмчийн хорооны 2010 оны 425 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн дүрмийг баталж, орд ашиглалтын ажил толгой компаниас охин компанийд шилжих үйл явц хэрэгжиж байна. Энэ оны эхний улиралд багтаж ордын ашиглалтын тусгай зөвшөөрлүүд Эрдэнэс Таван толгой охин компанийд шилжих болно.

Засгийн газар 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг баталсан. “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх, 10 хувийг аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр худалдах ажлын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж байна.

### **Монгол Улсын нийт иргэнд компанийн хувьцаа эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын хэмжээнд 2011 оны 2 дугаар сарын байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд нийт 2,785,194 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд иргэний шинэчилсэн бүртгэлд 2,546,852 иргэн буюу нийт мэдээллийн санд бүртгэлтэй иргэдийн 94.6 хувь нь хамрагдаад байна. Монгол Улсын хэмжээнд 16-аас дээш насны 1,794,479, 16-аас доош насны 752,103 иргэн иргэний шинэчилсэн бүртгэлээр урьдчилсан байдлаар тоологдоод байна. Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй буюу гадаадад байгаа, бүртгэлийн зөрчилтэй 238,342 иргэн байгаа болно. Одоо эдгээр үлдсэн иргэнийг шинэчилж бүртгэх ажил явагдаж байна.

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн нийт хувьцааны 10 хувь болох 1.5 тэрбум ширхэг хувьцааг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн нэгдсэн тоогоор тооцож хуваахад нэг иргэнд эзэмшүүлэх хувьцааны тоог гаргах боломжтой болно.

### **Үндэсний аж ахуйн нэгжүүдэд компанийн хувьцааг худалдах тухай**

а/ Эрдэнэс-Таван толгой компани нийт 15 тэрбум хувьцаатай байхаар дүрмэндээ тусгасан бөгөөд тогтоолын дагуу нэг иргэнд 536, нэг аж ахуйн нэгжид 28123 ширхэг хувьцаа ногдож байхаар, хувьцааны нэрлэсэн үнийг 300-1000 төгрөг байхаар сонгон шалгаруулалтад

Судалгааны эмхтгэл, XI боть

оролцсон хөрөнгө оруулалтын банкууд урьдчилсан таамаглал дэвшиүүлсэн байна.<sup>68</sup>

б/ УИХ-ын 39 дүгээр тогтоолын энэ заалтад өөрчлөлт оруулж УААН-дэд ноогдох 10 хувийг иргэдэд шилжүүлэх 2 хуулийн төсөл нэр бүхий УИХ-ын гишүүдээс өргөн баригдсан байгааг бүрэн эхээр нь дурдвал:

### **1. УИХ-ын гишүүн Я.Батсуурь нарын санаачилсан хуулийн төсөл:<sup>69</sup>**

“Үндэсний аж ахуйн нэгж” гэснийг тодорхойлсон ямар нэг хууль тогтоомж байхгүй бөгөөд хувьцааг худалдан авах эрх бүхий аж ахуйн нэгжийг ямар шалгуураар тогтоох нь тодорхой бус байна. Урьдчилсан тооцоогоор манай улс 50 гаруй мянган аж ахуйн нэгж энэхүү хувьцааг худалдаж авах эрхтэй хэмээн тооцож байна. Эдгээр аж ахуйн нэгж нь улсын төсөвт төлсөн татварын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээгээрээ эрс тэс ялгаатай учир тэдэнд Таван толгойн хувьцааг ийм маягаар хавтгайруулан тэгшигтгэж олгох нь шударга бус юм.

УИХ-ын 39 дүгээр тогтоолд зөвхөн 2010 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийг хамруулахаар заасан нь нийгмийн шударга ёсны зарчимд ч харшилж байна. Тухайлбал, 2010 оны 06-р сарын сарын 30-наас хойш байгуулагдсан хэдий ч олон зуун ажлын байр бий болгож, улсын төсөвт их хэмжээний татвар төлж, улсын эдийн засгийн өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүд Таван толгойн хувьцааг худалдан авч чадахгүй ялгаварлагдана.

Ер нь аж ахуйн нэгжүүдэд Таван толгойн хувьцааг худалдах нь улс орны эдийн засгийг уул уурхайгаас улам хамаарлтай болгох төдийгүй хувьцааг шударгаар хуваарилах нь ихээхэн хүндрэл, маргаан дагуулсан асуудал болох тул хувьцааг нийт иргэддээ тэгш хувааж, иргэн бүрт Таван толгойн 1072 хувьцааг үнэ төлбөргүй олгох асуудлыг энэхүү тогтоолоор шийдвэрлэж байна.

### **2. УИХ-ын гишүүн Одбаяр нарын санаачилсан хуулийн төсөл:<sup>70</sup>**

Монгол Улсын 53336 үндэсний аж ахуйн нэгж бүрд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 28123 ширхэг хувьцааны нэрлэсэн үнийг хэт үнэтэй тогтоовол зарим аж ахуйн нэгж нь худалдан авах санхүүгийн чадамжгүй, хэт хямд байвал нийгмийн тэгш байдал, шударга ёс алдагдах үндэстэй. Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 1000 төгрөг гэвэл нэг аж ахуйн нэгж 28.0 сая төгрөг, 300 төгрөг гэвэл 8.5 сая төгрөгийн төлбөр төлж өөрт ногдох хувьцааг эзэмшихээр тооцоо байна.

Татварын ерөнхий газрын судалгаагаар нийт аж ахуйн нэгжийн 88.02 %-ийг үйл ажиллагаа эрхлээгүй, алдагдалтай, 10 саяас доош төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд эзэлж байгаа бөгөөд нэг компанид ногдох хувьцааг 28.0 орчим сая төгрөгөөр худалдаж авах санхүүгийн чадамжтай компани багахан хувийг эзэлж байна. Мөн Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1.2.б-д “хувьцааны 10 хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр худалдах” гэж хатуу заасан нь татварын зөрчилгүй аж ахуйн нэгжийг тодорхойлоход хүндрэлтэй, манай улсын нийгэм, эдийн засгийн шилжилтийн цаг үед идэвхтэй үйл ажиллагаа явуулж, татвараа төлж байсан үндэсний аж ахуйн нэгжид хувьцаа эзэмших эрх нээгдэнэ гэвэл бас л хамрагдах үндэсний аж ахуйн нэгжийн тоо эрс буурна.

<sup>68</sup> Эрдэнэт –Таван толгой компанийн дүрмээс

<sup>69</sup> Интернет “Хуулийн төсөл” цэсээс

<sup>70</sup> Интернет - Хуулийн төсөл цэсээс

“Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг дээр дурдсан нэрлэсэн үнээр тогтоож, нийт хувьцааны 10 хувийг аж ахуйн нэгжүүдэд худалдах тохиолдолд дараах нөхцөл байдал үүснэ гэж үзлээ. Үүнд:

- Иргэд болон аж ахуйн нэгжүүдэд ногдох хувьцааны тоо харьцангуй зөрүүтэй байна. Нэг аж ахуйн нэгжид нэг иргэнээс 52.7 дахин их хувьцаа ногдооор байна;
- Нэг иргэн олон тооны аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан байна. Татварын ерөнхий газрын судалгаагаар 1 иргэн 35 аж ахуйн нэгжид, 1482 иргэн тус бүр 3 аж ахуйн нэгжид, 1 компани 53 аж ахуйн нэгжид, 54 компани тус бүр 3 аж ахуйн нэгжид тус тус хөрөнгө оруулжээ;
- Гэрчилгээтэй боловч үйл ажиллагаа эрхлээгүй, татвар төлдөггүй аж ахуйн нэгжүүд иргэдтэй харьцуулахад их хэмжээний хувьцаа эзэмших боломжтой болоод байна. Нийт аж ахуйн нэгжийн 59% -ийг үйл ажиллагаа эрхлээгүй (46.3%), алдагдалтай (12.7%) аж ахуйн нэгжүүд эзэлж байна;
- Аж ахуйн нэгж тус бүр өөрт ондох хувьцаагаа хоёр дахь зах зээл нээгдэх хүртэлх хугацаанд худалдан авахыг санал болгон, худалдан аваагүй тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн хувьцааг яах нь тодорхойгүй байна;
- Дээр дурдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь хоёрдогч зах зээл эхлэхэд хувьцаагаа зарах магадлалтай бөгөөд энэ нь зах зээл дээрх хувьцааны нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлж зах зээлийн үнийг унагах нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай.

Үндэсний аж ахуйн нэгжүүдэд иргэдтэй адил нийт хувьцааны 10 хувийг худалдахаар шийдвэрлэсэн нь аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан иргэд болон бусад иргэдийн хувьд хэт ялгавартай хандаж, тэгш бус хуваарилалт болох нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн шударга ёс алдагдах үндэс болох бөгөөд “Хүнийг ... нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэсэн Үндсэн хуулийн зарчимтай нийцэхгүй байна.

Иймд хувьцааны нэрлэсэн үнийг хэт өндөрөөр тогтоох нь хөрөнгө оруулалтын эрсдлийг бий болгож, IPO амжилтгүй болох нөхцөлийг бүрдүүлэх тул “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах хувийг хүчингүй болгож, иргэдэд эзэмшүүлэх хувьцаан дээр нэмж олгох нь зүйтэй гэж үзэн, УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах саналтай байна

#### **Компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалах тухай**

Сонгон шалгаруулах хороо Эрдэнэс Таван Толгой компанийн хувьцааны тодорхой хэсгийг олон улсын хөрөнгийн биржид арилжаалах асуудалд зөвлөлгөө өгөх, зохион байгуулахад оролцох олон улсын банкийг шалгаруулах ажлыг хийж дуусгасан. Эдгээр банкуудаас гол зохион байгуулагч буюу спонсороор Дойче Банк (Герман), Голдман Сакс (АНУ) сонгогдов. Түүнчлэн хувьцааны борлуулалтад оролцох, зуучлах (book runner, underwriter) үүрэг бүхий бэлтгэл ажилд хамтран оролцох банкаар БиЭнПи Париба банк (Франц), Маквэари банк (Австрали) тус тус шалгарсан бөгөөд банкуудыг хэлэлцээрт урьсан. Компанийн хувьцааг олон улсын аль хөрөнгийн биржид арилжаалах шийдвэрээс шалтгаалж хувьцааны борлуулалтад оролцох, хөрөнгийн биржид зуучлах, хамтран ажиллах 1-2 банкийг тодорхой хугацааны дараа нэмж авах боломжтой гэж сонгон шалгаруулах хороо болон захиалагч үзсэн.

Банкнуудыг сонгож авахдаа хувьцааг арилжаалах бүс нутгийн (тивийн) төлөөлөл, IPO хийсэн ажлын туршлага, глобал болон бүс нутгийн хөрөнгийн зах зээл дээр явуулдаг үйл ажиллагаа, ирүүлсэн санал зэргийг нь харгалzan үзсэн. Дээр дурьдсан банкууд оролцооор санал ирүүлж байгаа нь манай улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгааг харуулж байна. Сонгож авсан банк, санхүүгийн байгууллагуудтай олон улсын хөрөнгийн

Судалгааны эмхтгэл, XI боть

биржид хувьцаагаа арилжаалах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Компанийн хувьцааны тоо, хувьцаа эзэмшүүлэх, худалдах нөхцөлтэй холбоотой зарим асуудлаар холбогдох Ажлын хэсэг Засгийн газарт танилцуулга хийхээр бэлтгэж байна.<sup>71</sup>

### **“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг өөрчлөн зохион байгуулах талаар**

“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг Үндсэн хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах асуудлаар Төрийн өмчийн хороон дээр төвлөрч ажиллаж байна. 2010 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрд ногдох ашгаас Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээх, хувьцаа эзэмшүүлэх талаар загвар боловсруулж танилцуулсан бөгөөд загварыг дэмжсэн. Энэ дагуу Ажлын хэсэг байгуулж Эрдэнэс МГЛ ХХК-ийн дүрэм, бүтцийг шинэчлэх, холбогдох бусад саналыг боловсруулж байгаа бөгөөд анхны хувилбар төслүүдийг боловсруулаад байна.

“Эрдэнэс МГЛ” ХХК-ийг энэ оны эхний улиралд багтаан өөрчлөн зохион байгуулж, тус компанийн давуу эрхийн хувьцааг Хүний хөгжлийн сангийн хуулийн дагуу нийт иргэдэд эзэмшүүлэх болно. Ингэхдээ иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн, бүртгэлийн зөрчилгүй Монгол Улсын нийт иргэнд компанийн давуу эрхийн хувьцааг эзэмшүүлэх болно. Нэг иргэнд эзэмшүүлэх давуу эрхийн хувьцааны тоо, үнийг сонгон авсан зөвлөх банктай зөвшилцэж, УИХ, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ

### **Стратегийн буюу гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани/консорциум шалгаруулах талаар:**

УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дээрх заалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захиралыаар 2010 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан. Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэж Таван толгой ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани (консорциум)-ийг сонгох урьдчилсан шалгаруулалтыг олон улсын хэмжээнд нээлттэй зарлаж, зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо, урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичгийг Төрийн өмчийн хорооны 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар баталсан.

Таван толгойн нүүрсийг хөрш орны болон бус нутаг, олон улсын зах зээлд гаргах хэрэгцээ шаардлага, УИХ-ын тогтоолын заалтын дагуу Таван толгой ордын Цанхийн талбайн баруун хэсэг, Бор тээгийн нүүрсний талбайн зарим хэсгийг багтаасан талбайд нүүрс олборлох, түүнчлэн бүтээгдэхүүн борлуулалт болон орд ашиглах, бүтээгдэхүүн тээвэрлэхтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөлд хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой нээлттэй зарласан. 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр оролцогчдын материалыг хүлээж авсан.

Энэ шалгаруулалтад уул уурхайн олборлолт, бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн асуудлаар олон улсад нэр хүнд бүхий тэргүүлэгч, том компаниуд, түүнчлэн хөрш орнуудын компани, нийт 15 компани/консорциум оролцоо санал ирүүлсэн. Оролцогчдын ирүүлсэн материалыд үнэлгээний хороо үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний дүнд Пибоди Энержи (АНУ), Шинхуа Энержи болон Мицүи, компаниудын консорциум (БНХАУ, Япон), Оросын Төмөр Зам болон Японы консорциум, Өмнөд Солонгосын

<sup>71</sup> Өдрийн шуудан сонин 2011,10,13ны өдрийн дугаараас

компаниудын консорциумуудын нэгдэл (ОХУ, Япон, Өмнөд Солонгос), Экстрата Коул (Австрали-Швейцарь), Валэ (Бразил), АрсэлорМитал (Люксембург) зэрэг 6 компани/консорциум хураангуй жагсаалтад багтсан.

Энэ зургаагаас гурван консерциум нь бидний тавьсан нөхцлүүдийг зөвшөөрсөн болохоор АНУ-ын Пибоди 24, Хятадын “Шиньхуа” 40, Оросын төмөр зам Япон, Солонгостой нийлээд 18 хувь эзэмшихээр болж Монгол улс өөрөө “Эрдэнэс MGL”-ээ 18 хувьд нь оруулах юм. Ийм ерөнхий тоон дээр тохиролцож нөгөө талууд маань зөвшөөрсөн учраас ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж төслийг УАБЗ-д хүргүүлээд байна. Ингэж хэлэлцээд УАБЗ-д хэлэлцээд санал онол гарвал 3Г дахин хэлэлцээд УАБЗ-д танилцуулахаар бэлэн болсон

Эрдэнэс таван толгой компани Зүүн цанхийн олборлогчийн тендерт ялсан Германы “Би Би Эм оперта”, Австралийн “Макмахон” тай 5 жилийн хугацаатай 500 сая ам, долларын гэрээ байгууллаа.

## **1. УИХ БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ХИЙГДСЭН АЖЛУУД**

Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн нүүрсний ордыг ашиглах асуудлаар Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 39 тоот тогтоол баталсан билээ. Үг тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газар Таван толгой ордыг ашиглахтай холбоотой асуудлыг олон удаа хэлэлцэж холбогдох тогтоол, шийдвэр гаргасан. Таван толгой ордоос нүүрс олборлох, бүтээгдэхүүн борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой зарим ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд Таван толгой төслийн цахилгаан эрчим хүчний хангамж, усны хангарт, баяжуулах үйлдвэр зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлууд хийгдэж эхэлсэд байна.

### **Уурхай, олборлолтын ажлын талаар**

Эрдэнэс МГЛ ХХК нь Таван толгой ордын Цанхийн зүүн хэсгийн талбайд 2010 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Эрдэнэс-ТТ уурхай байгуулах уулын ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ ажлыг Эрдэнэс Таван толгой охин компани байгуулан уурхайн ашиглалтын ажил толгой компанийас охин компанийд шилжээд байна. Одоогоор Эрдэнэс Таван толгой компанийн уурхай болон хотхоны ажилчид нийлсэн 150 гаруй ажиллагсадад 2-3 эзлжээр ажиллаж байна. 2011 оны 9 дүгээр сарын эхний байдлаар 2 700 000 м<sup>3</sup> уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн ба ингэснээр сайн чанарын коксжих нүүрсний давхаргад хүрч нүүрсний олборлолт эхэлсэн.

Уурхайн олборлолтын ажлыг шинэ үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд ашиглан батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа бөгөөд олборлолтын хэмжээгээ жил бүр нэмэгдүүлж 3-4 жилд багтаан 15 сая тонн нүүрс олборлох ил уурхай байгуулахыг зорьж ажиллаж байна.

### **Нүүрсний экспорт, борлуулалтын талаар**

Таван толгой ордын нүүрсийг хөрш орны болон бүс нутаг, олон улсын зах зээлд гаргах хэрэгцээ шаардлагын үүднээс Эрдэнэс Таван толгой уурхайгаас 2011 оны 8 дугаар сарын 4-ны өдөр анхны нүүрсний экспортыг эхлүүлсэн. Эрдэнэс Таван толгой уурхайгаас 300,000 тонн нүүрс олборлоход бэлэн болгоод байна. Одоогоор уурхайн агуулахад 70,000 тонн нүүрсийг ачиж экспортлох ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Цагаан хадны гаалийн хяналтын талбайд 20,000 тонн нүүрсийг тээвэрлэж хүргээд байна.

Эрдэнэс МГЛ ХХК болон Эрдэнэс Таван толгой компани Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Хүний хөгжил санд төвлөрүүлэх мөнгийг нүүрсний урьдчилсан борлуулалтын орлого хэлбэрээр бүрдүүлэх,

Судалгааны эмхтгэл, XI боть

Таван толгойн нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлын хүрээнд БНХАУ-ын төрийн өмчийн Чиналко (Aluminum Corporation of China) компанийн 100%-ийн борлуулалт эрхэлдэг Чалко (China Aluminum International Trading) компани, Хятадын Хэбей мужийн Жинан стийл интернэйшнл компанитай нүүрс борлуулалтын гэрээг 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Энэхүү нүүрс борлуулалтын гэрээний хүрээнд Эрдэнэс Таван Толгой компани нь жилд олборлох нүүрсний 80 хувийг Хятадын зах зээлд болон эцсийн хэрэглэгч болох гангийн үйлдвэрт болон гуравдагч орны буюу Япон, Өмнөд Солонгосын зах зээлд борлуулах боломжтой болж байна. Мөн нүүрсний экспортын үнийг өндөр байлгах зорилгоор олон улсын нүүрсний индексийн дагуу улирал болгон шинэчлэн тогтоох механизмыг гэрээнд оруулж өгсөн болно.

### **Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Эрдэнэс МГЛ ХХК-ийн эзэмшиж байгаа Тавантолгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг түүний охин компани Эрдэнэс Тавантолгой ХК-д шилжүүлэхдээ бүтээгдэхүүн гаргахад бэлэн байгаа Цанхийн талбайгаас эхлэх, бусад хэсгийг нэмэлт хайгуул, судалгаа хийсний үндсэн дээр шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Эрдэнэс МГЛ ХХК нь Таван толгой ордын бүтээгдэхүүн гаргахад бэлэн байгаа буюу Цанхийн талбайг хамарсан тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу Эрдэнэс Таван толгой ХК-д эхний ээлжинд шилжүүлсэн болно.

Таван толгой нүүрсний ордын Оорцог, Онч хараат, Бортээгийн зарим хэсэг, Бор толгойн нүүрсний талбайнуудад хийгдсэн геологи хайгуулын үр дүнгийн тайланд тулгуурлан, нөөцийг шинчлэн тооцож, ЭБМЗ-р хэлэлцүүлэн улсын нөөцдөн шинчлэн бүртгүүлэхтэй холбогдсон нэмэлт ажил хайгуул судалгаа хийхэд тодорхой хугацаа шаардлагатай байгаа тул эдгээр талбайд хийгдсэн нарийвчилсан хайгуулын үр дүнгийн тайланд нөөцийн тодотгол судалгаа хийж, шилжүүлэхээр ажиллаж байна.

### **Гэрээт олборлогч (оператор) компанийн талаар**

Таван толгой ордын Цанхийн зүүн хэсэг буюу Эрдэнэс-ТТ уурхайд гэрээгээр олборлолтын ажил гүйцэтгэх гэрээт олборлогч (оператор) компанийг сонгох тендер шалгаруулалтыг дотоод, гадаадад нээлттэйгээр зарласан. Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг хууль, журмын дагуу үнэлж, шийдвэр гаргасан.

Тендерт оролцогч Австралийн Макмахон Лимитед, Германы БиБиЭм Опера компаниуд Эрдэнэс Таван толгой уурхайд гэрээгээр олборлолтын ажлыг хамтран гүйцэтгэхээр санал ирүүлсэн. Эрдэнэс Таван толгой компанийн ТУЗ нь дээрх компанийдтай УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд заасан үндсэн зарчмын дагуу тодорхой хугацаанд Эрдэнэс таван толгой уурхайн буюу Цанхийн зүүн талбайд гэрээт олборлогчийн (оператор) ажил гүйцэтгэхтэй холбоотой хэлэлцээ хийх шийдвэр гаргасан болно. Энэ дагуу Эрдэнэс Таван толгой компани хэлэлцээ хийж эхэлсэн ба ойрын хугацаанд хэлэлцээг дуусгаж, олборлогч (оператор) компанийтай гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэхээр төлөвлөж байна.

### **Компанийн хувьцаа болон хөрөнгийн зах зээл дээр гарагтай холбоотой ажлын талаар**

Таван толгой ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааг нь иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, худалдах, гадаад, дотоодын хөрөнгийн зах зээл дээр арилжаалах (IPO) бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу дэс дараатайгаар хийж байна.

Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны 10 хувийн хувьцааг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн Монгол Улсын иргэн эзэмшүүлэх тухай шийдвэрийг гаргасан. Ингэснээр Монгол Улсын иргэн компанийн 536 ширхэг хувьцаа эзэмшигч болох боломжтой болсон. Мөн хуралдаанаар “Эрдэнэс Таван толгой” компанийн хувьцааг хоёр дахь зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн шийдвэр гаргасны дараа иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хувьцааг нийтэд арилжаалах ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын иргэн бүрийн нэр дээр Эрдэнэс Таван толгой компанийн 536 ширхэг хувьцаа эзэмших үнэт цаасны бүртгэлийн ажил хийгдэж байна. Монгол Улсын иргэн энэхүү бүртгэлийн ажилтай холбоотой мэдээллийг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн <http://www.schcd.mn/> гэсэн цахим хуудсанд хандаж мэдэх боломжтой болсон.

Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны 10 хувийг шаардлага хангасан үндэсний аж ахуйн нэгж тус бүрт тэнцүү хэмжээгээр нэрлэсэн үнээр санал болгон худалдах болно. Татварын ерөнхий газрын мэдээгээр 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө байгуулагдаж анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргасан нийт 53336 үндэсний аж ахуйн нэгж байгаа бөгөөд энэ тохиолдолд нэг аж ахуйн нэгжид 28123 ширхэг хувьцаа ногдохоор урьдчилсан тооцоог хийгээд байна.

Хувьцаа худалдан авах үндэсний аж ахуйн нэгжийг ямар шалгуураар тогтоох нь төдийлөн ойлгомжтой бус, ахуйн нэгжид хувьцааг худалдах нь нийгмийн тэгш байдал, шударга ёсны талаар гомдол, маргаан гарах, эдийн засаг хэт уул уурхайгаас хамааралтай байдал бий болох зэрэг үндэслэлээр үндэсний аж ахуйн нэгжид худалдах хувьцааг нийт иргэддээ тэгш хувааж, иргэн бүрд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх тухай УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолыг төслийг зарим гишүүд санаачилсан байна. Эрдэнэс Таван толгой компанийн хувьцааны нэрлэсэн үнэтэй холбоотой асуудлаар сонгон авсан зөвлөх компанийтай хамтран холбогдох саналыг боловсруулж байна.

Эрдэнэс-Таван толгой компанийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалахтай арилжаалах бэлтгэл ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд компанийн хувьцааг олон улсын аль хөрөнгийн биржид арилжаалах судалгаа, телеконференц болон уулзалтыг тогтмол хийж байна. Олон улсын хөрөнгийн бирж дээр компанийн хувьцааг арилжаалах ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд банкууд болон аудитор, хуулийн зөвлөхүүдтэй хамтран компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж (МХБ), Лондонгийн Хөрөнгийн Бирж (ЛХБ) болон Хонг Конгийн Хөрөнгийн Биржүүд (ХКХБ) дээр гурвалсан аргаар бүртгүүлэх бүтцийг урьдчилсан байдлаар гаргаж энэ асуудлаар шаардлагатай судалгааны ажил хийгдэж байна. Түүнчлэн компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалах ажил төлөвлөгөөний дагуу дараах ажлууд хийгдэж байна:

- Ордын нөөцийг олон улсын стандартаар тооцопон гаргах;
- Компанийн засаглал, үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийг олон улсын шаардлага стандартад нийцүүлэх;
- Олон улсын аль хөрөнгийн биржид гарах бүтцийг тодорхойлох;
- Хөрөнгө оруулагчдад танилцуулах, танилцуулга “проспектус” боловсруулах;
- Санхүүжилтийн (Bankable) Техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгах гэх мэт.

Цаашид олон улсын хөрөнгийн биржид хувьцаа гаргах зөвшөөрөл авах, хувьцааны арилжааны сурталчилгаа, танилцуулга (roadshow) хийх зэрэг олон ажлууд хийгдэхээр төлөвлөгджэй байгаа бөгөөд компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргахад нелөөлөх хүчин зүйлүүд болох IPO-д зориулсан судалгаа хийх, уурхайн болон нүүрс тээвэрлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гэрээт олборлогчийг сонгох зэрэг чухал ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

### **Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар**

Засгийн газраас Таван толгой төслийн цахилгаан эрчим хүч, усан хангамжтай холбоотой асуудлаар шаардлагатай зөвшөөрлийг Эрдэнэс МГЛ болон Эрдэнэс Таван толгой компанийд олгохоор шийдвэрлэсэн. Тавантолгой төслийн хүрээнд шаардагдах эрчим хүчиний хангамжийг шийдвэрлэх зорилгоор Тавантолгойн ордыг түшиглэн 600 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барих асуудлыг судлах, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил хийгдэж эхлээд байна.

Одоогоор Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барих цахилгаан станцын урьдчилсан ТЭЗҮ бэлэн болсон бөгөөд хоёр талын ажлын хэсэг уг ТЭЗҮ болон судалгааг Оюутолгой төслийн талбайд барих цахилгаан станцын ТЭЗҮ -тэй харьцуулалт хийн дүгнэлт гаргаж, цахилгаан станцын байршлыг сонгохоор ажиллаж байна. Энэхүү цахилгаан станц нь Оюутолгой болон Тавантолгой төслийн хүрээнд шаардагдах эрчим хүчиний хангамж, түүнчлэн.govийн бүсийн эрчим хүчиний асуудлыг шийдвэрлэхэд голлох үргийг гүйцэтгэх юм.

Таван толгой уурхайд жилдээ дунджаар 8.5 сая тонн коксжих нүүрс, 3.7 сая тонн эрчим хүчиний нүүрс, 1 сая тонн завсрлын бүтээгдэхүүн, нийтдээ 15 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий угаах, боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөн холбогдох бэлтгэл ажлыг мөн эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор холбогдох байгууллагаас хуульд заасан хугацаа, нөхцөлөөр ус ашиглах зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаад байна.

### **Стратегийн буюу гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани/консорциум шалгаруулах талаар**

Таван толгой ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой компани (консорциум)-ийг сонгон шалгаруулах шийдвэр гарч, уг сонгон шалгаруулалтыг 2010 оны 12 дугаар сараас 2011 оны 2 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтанд уул уурхайн олборлолт, бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн асуудлаар олон улсад нэр хүнд бүхий, тэргүүлэгч том компаниуд болон хөрш орнуудын, дотоодын нийт 15 компани, консорциум оролцсоноос 6 оролцогч шалгарч үлдсэн.

Эдгээр оролцогчтой УИХ-ын 39 дүгээр тогтоол, УАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхий сайдын захирамжаар баталсан удирдамжийн дагуу дамжин өнгөрөх тээвэр, боомт ашиглалт, борлуулалт, хөрөнгө оруулалтын нөхцөл, урьдчилгаа төлбөр зэрэг асуудлаар хэлэлцээ хийж эхэлсэн. Хэлэлцээний багийн ахлагчаар Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар ажиллаж байгаа бөгөөд 2011 оны 3 дугаар сараас эхлүүлэн хураангуй жагсаалтад багтсан компани, консорциумтай хэлэлцээ хийж эхэлсэн ба хэлэлцээ үргэлжилж байна.

Хэлэлцээний явцад орд ашиглах хувилбарын хүрээнд нүүрсний борлуулалт, урьдчилгаа төлбөр, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, байгаль орчинд эзлтэй технологи, нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах санал, ордыг түшиглэсэн үйлдвэр, барилга байгууламж, дэд бүтэц, зам барьж байгуулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах, Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд авч хэрэглэх нөхцөл болзлыг хэрэгжүүлэх үндсэн асуудлыг тусгасан хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулсан.

2011 он бол Таван толгой ордыг ашиглаж эхлэх үйл ажиллагааны гол жил бөгөөд тус ордоос эхний ээлжинд 2 сая хүртэл тонн нүүрс олборлож экспортлох, төслийн санхүүжилтийг босгох, гэрээт олборлогч компани болон стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох, олон улсын банкууд болон аудитор, хуулийн зөвлөхүүдтэй хамтран Эрдэнэс Таван толгой

компанийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржид арилжаалах бэлтгэл ажлыг хангах, усны хангамж, баяжуулах үйлдвэр байгуулах, уурхайчдын орчин үеийн хоткон барих, цахилгаан станц, авто замын зэрэг их бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх чухал жил юм.

## **1. ТАВАН ТОЛГОЙ ОРДЫГ АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ЗАРЧИМ, ХЭРЭГЖИЛТ**

Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн зарчим бол “Тогтвортой хөгжлийг бий болгох<sup>□</sup>”-д чиглэх ёстай. Өөрөөр хэлбэл, гэрээний жижиг заалтуудыг авч үзэхгүйгээр тухайн хөрөнгө оруулалтын гэрээ нь

- Хөрөнгө оруулалт урт хугацаанд өгөөжөө тогтвортой өгөхийн тулд юу хэрэгтэй вэ? Хөрөнгө оруулалтын гэрээнд урт хугацаанд юуг тогтвортой барих вэ? гэсэн суурь асуудлыг шийдвэрлэхэд “үндсэн зарчим, үзэл баримтлал” чиглэх ёстай юм. Уул уурхайн ажил бол урт хугацаанд үйл ажиллагаа явуулдаг, зардлаа нөхөх хугацаа урт байдаг онцлогтой. Хөрөнгө оруулалтын гэрээнд оролцогч талууд харилцан өөрийн ашиг сонирхлоо хамгаалах хэрэгцээ үүснэ. Тэгэхээр хөрөнгө оруулагч тал болон төрийн хооронд хөрөнгө оруулалтын гэрээгээр гүйцэтгэж байгаа ажил “Харилцан ашигтай байх” нь хамгийн гол суурь юм.

Уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулагчид нь ихэвчлэн улсын том компаниуд байдаг. Иймэрхүү үйлдвэрийн газрын удирдлагын гол анхаардаг зүйл нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн үнэ цэнэ болон хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой, дээд хэмжээнд байлгах явдал юм. Үүнтэй холбоотойгоор бодитой болон байж болох эрсдэлийг удирдах нь удирдлагын гол үүрэг болдог. Эрсдлийг удирдах нь ихэвчлэн өөр өөр оронд өөр өөр төрлийн баялагт хөрөнгө оруулалт хийх замаар хэрэгждэг. Ингэхдээ хөрөнгө оруулагчид нь санхүүгийн орчин нь таатай бөгөөд тогтвортой гэж үзсэн орныг бусад техникийн үзүүлэлтүүдтэй нь харьцуулсны үндсэн дээр сонголтоо хийдэг байна.

Засгийн газрын зүгээс анхаардаг зүйлс нь ихэвчлэн орлого бий болгох, ажлын байр бий болгох, нийт эдийн засгийн өсслэтийн болон эдгээр зорилгод тухайн салбарын оруулж буй хувь нэмэр байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах нь богино болон урт хугацаанд үр нэлөөгөө үзүүлдэг гэж ихэнх Засгийн газар үздэг. Удаах хүчин зүйлс нь төслийн нийт эдийн засагт үзүүлэх нэлөөг байж болох дээд хэмжээнд хүргэх явдал юм. Тухайн салбарын гэрээнүүдийн эдийн засагт бүхэлд нь нэлэөлөх нэлэөлөл түүний урт хугацааны үр дагаварыг тооцох хамгийн чухал гэдгийг Засгийн газар анхаарах ёстай.

Хөрөнгө оруулагч компаниуд нь аль илүү өндөр хүлээгдэж буй өгөөжтэй, хүлээн зөвлөөрөхүйц хэмжээнд эрсдэлтэй төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг байна. Тэдгээр төслүүдийг үнэлэхдээ харж үздэг хүчин зүйлүүдэд тухайн орны санхүүгийн орчин, мөн төсөлтэй холбогдох техникийн, санхүүгийн, зах зээлийн болон улс төрийн эрсдэлүүд, түүнчлэн уг төсөлтэй өрсөлдөгч бусад төслүүд болон санхүүжилийн хязгаарлалт зэрэг багтана. Өнөөгийн Монгол улсад хөрөнгө оруулалт хийж байгаа хандлагаас хараад манай улсад дараах давуу байдлууд байна гэж үздэг.

- Хятадын зах зээлд хамгийн ойр
- Хэдий дэд бүтэц сул хөгжсөн ч түүнийг шийдвэрлэхэд газар зүй, орчны нэлэөлөл, хүндрэл багатай, зардал бага байх бүрэн боломжтой
- Хэдий эрх зүйн зохицуулалт тогтвортгүй ч улс төр, нийгмийн орчин харьцангуй тайван орны тоонд ордог
- Ажиллах хүчний зардал хямд, гадаадын хөрөнгө оруулалтад таатай ханддаг

Уул уурхайн зөвлөгөө өгдөг Бехре Долбейр компани уул уурхайн хөрөнгө оруулалт хийхэд тааламжтай болон тааламжгүй улс орнуудын жагсаалт хийдэг бөгөөд энэ нь нэг ёсондоо

Судалгааны эмхтгэл, XI боть

уул уурхайн хөрөнгө оруулагчдын гарын авлага болдог байна. Тус компани 1999 оноос хойш энэхүү жагсаалт-үнэлгээг гаргаж байгаа бөгөөд жагсаалтыг гаргахад улс орнуудын эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, нийгэмд тулгарч буй хүчин зүйлс, нэн ялангуяа тухайн улс орны уул уурхайд нөлөөлж байгаа нийгмийн хүчин зүйлс, уул уурхай, ашигт малтмалтай холбоотой зөвшөөрөл өгөх авах, авилгал, хээл хахууль, мөнгөний нэгжийн тогтвортой байдал болон татварын систем голлох үүрэг гүйцэтгэдэг буюу нэг ёсны шалгуур үзүүлэлт болдог байна.

Бехре Долбейр 2011 онд ямар улсад хөрөнгө оруулаад хэрэггүй вэ гэсэн ээлжит зөвлөмж-судалгаагаа гаргажээ. Судалгаанд нийт таван тивийн 25 орон хамрагдсаны дотор Монгол улсыг мөн авч үзжээ. Судалгаанаас үзвэл Монгол улс 2004-2005 онуудад дээрх 25 ороос 11-т жагсаж байсан бол 2006 онд хоёр нэгжээр дээш ахиж 9-р байранд оржээ. Хөрш орнуудын хувьд Хятад 10-р (2011 онд 13-14) байранд, Орос улс 19-т (2011 онд 25) байсан байна. Тэгвэл энэ 2011 онд манай улс 2010 оныхос 2 нэгж уруудаж 9-10 дугаар байрыг Гана улстай хуваан эзэлжээ.

**BEHRE DOLBEAR'S 2011 RANKING OF COUNTRIES**

2011 Rank	Country	Economic System	Political System	Social Issues	Permitting Delays	Corruption	Currency Stability	Tax Regime	2011 Total Points	2011 Change versus 2010
1	Australia	9	8	8	8	10	9	5	57	-4
2	Canada	9	9	4	4	10	9	7	52	-4
3	Chile	9	9	7	6	8	8	4	51	+2
4	Brazil	7	8	5	5	5	9	6	45	+3
5	Mexico	8	8	2	7	6	6	7	44	-1
6	United States	8	9	3	1	10	7	3	41	-1
7	Colombia	6	7	6	6	5	5	4	39	0
8 TIE	Botswana	6	5	5	5	5	5	6	37	+1
8 TIE	Peru	6	6	4	4	5	7	5	37	+4
10 TIE	Ghana	6	5	2	6	3	6	6	34	-2
10 TIE	Mongolia	6	6	5	5	2	6	4	34	-2
12	Tanzania	5	5	3	7	3	4	5	32	0
13 TIE	China	6	1	3	5	3	8	5	31	-4
13 TIE	Namibia	4	5	3	5	3	5	6	31	0
15 TIE	Argentina	5	3	4	6	4	4	4	30	-1
15 TIE	India	6	6	2	3	3	6	4	30	+1
17	Philippines	5	5	3	5	2	4	4	28	+2
18	Indonesia	5	6	4	3	2	3	4	27	+6
19 TIE	Zambia	5	4	3	5	2	2	3	24	+1
19 TIE	South Africa	3	4	2	5	2	6	2	24	+1
21 TIE	Kazakhstan	3	3	4	3	1	4	4	22	-2
21 TIE	Papua New Guinea	4	4	1	2	2	4	5	22	0
23	D.R. Congo	3	3	3	3	2	1	4	19	0
24	Bolivia	2	1	1	4	3	3	3	17	-1
25	Russia	1	1	3	3	1	2	5	16	-3

Уг тайланд дурьдсанаар Монгол Улс авилгын асуудлаа шийдвэрлэх талаар ахиц сайн гараагүй болон орон нутгийн иргэд, ТББ-үүд хөрөнгө оруулагчдад эсэргүүцэл үзүүлж тэмцлээ идэвхжүүлж байгаа зэргээс шалтгаалж ухарсан гэдгийг тэмдэглэжээ.

Эдгээр судалгаа дүгнэлтээс харахад манай орон хөрөнгө оруулах таатай нөхцөлтэй, ашигтай орнуудын тоонд багтаж байна. Тэгэхээр эдгээр орнуудын Засгийн газар хөрөнгө оруулалтын гэрээнд илүү давуу байр суурьтай орох боломжтой буюу хөрөнгө оруулагчид ямартай ч ашигтай ажиллах боломжтой гэдэг байр суурь баримтлах магадлалтай. “Монгол улс бол хөрөнгө оруулахад таатай орон. Түрүүлж буусан шувуу илүү ихийг хүртдэг гэдгийг биеэрээ мэдэрсний хувьд та бүхнийг Монголд хөрөнгө оруулахыг уриалж байна.” Энэ үгийг Монголд хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхлээд 12 жил болж байгаа “Монголиан Стар Мелшерс” компанийн захирал Лоренц Мелшерс “Дисковери Монголиа 2010” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын индрээс хэлсэн юм.

Тэрбээр хөрөнгө оруулагчдыг төлөөлөн тавьсан илтгэлдээ “Өнөөдөр Монголын уул уурхайн хангамжийн бүхий л салбарт хөрөнгө оруулах орон зай эзнээ хүлээсээр байна” гэв. Энэ үгийг нэгэн компанийн захирлын үг гэлгүйгээр Монголд хөрөнгө оруулалт хийж, үр шимийг нь хүртсэн олон зуун хөрөнгө оруулагчдын үг гэж ойлгож болох юм.

Монгол улсын эдийн засаг ойрын жилүүдэд огцом өснө гэдгийг дотоод гадаадын олон байгууллага, судлаачид хэлж байгаа. 2020 он хүртэлх хугацаанд манай улсын эдийн засаг 14-15 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ Малайз, Индонез, Тайванийн түвшинд очих боломжтой гэсэн таамгийг мэргэжлийн байгууллагууд дэвшигүүлсэн байна. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ 12 мянган ам.доллар болж, 2021 он гэхэд улсын ДНБ-ий хэмжээ 41 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн өөдрөг төсөөллийг Засгийн газраас гаргаад байгаа.

Ийм нөөц бололцоо бий гэдгийг гадаадын мэргэжилтнүүдийн таамаг ч баталж буй. Тухайлбал “Голомт” банкны Гүйцэтгэх захирал Жон Финиган хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт дээр “2016 он гэхэд Монгол улсын уул уурхайн салбарт эргэлт гарна. Хэдий хаяанд мэт бодогдовч боломжкоо зөв ашиглаж чадвал Монголын эдийн засагт эргэлт хийж болох цаг хугацаа. 2016 он гэхэд зэс олборлолтын хэмжээ жилд 36 мянган тоннд хүрэх бөгөөд үүнийг 2005 онтой харьцуулахад үлэмж хэмжээний өсөлт” гэсэн юм.

Байгалийн баялаг, газрын тоосор баялаг Арабын Нэгдсэн Эмират улсын ДНБ 2.8 тэрбум ам.доллараас 230 тэрбум ам.доллар буюу 82 дахин өссөн, Катар улс ДНБ-ийхээ хэмжээг 15 жилийн дотор 12 дахин нэмсэн амжилтаараа дэлхий нийтийг гайхуулж байна. Монгол улсын эдийн засаг ч үүнтэй адил үсрэнгүй өсөлттэй байж болно. “Голдмен Сакс”ын хийсэн судалгаанд 2050 он гэхэд АНУ зэрэг хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн эдийн засгийн 2/3-ыг одоогийн хөгжиж байгаа орнууд эзлэх болно хэмээн дурдсан байна. Өөрөөр хэлбэл өнөөдөр байгалийн баялгаа ашиглаж эхэлж байгаа, эдийн засгaa хөгжүүлэхээр чармайн ажиллаж буй орнууд 40 жилийн дараа дэлхийн эдийн засгийн талаас илүүг эзлэх нь байна.

Энэ бүхнийг дүгнэж үзвэл Монгол Улсад хөрөнгө оруулахад ашигтай учир хөрөнгө оруулагчид бага зэрэг эрсдлийг ч тооцохгүйгээр тэмүүлж байгаа тул манай Засгийн газар хэлэлцээрийн ширээний ард “давуу боломжтой суух буюу тоглоомын дүрмийг Монгол улс тогтооно”. Гэхдээ олон улсын өмнө хүлээсэн үүрэг, зарчмаа даган “ХАРИЛЦАН АШИГТАЙ БАЙХ” зарчмаа алдагдуулахгүй байх шаардлагатай.

### **Зарчмын асуудлууд**

Аливаа “зарчим бол хэрэгцээнд тулгуурлан” гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, УИХ-ын 2010 оны 39-р тогтоолд тусгагдсан үзэл баримтлал, зарчмууд бол Монгол Улсын хэрэгцээ гэж үзэж болно. Эдгээрийг багцалж авч үзвэл:

- Тавантолгойн ордын ашиглалтын лицензийг төр бүрэн эзэмшиж, тухайн ордод үйл ажиллагаа явуулах “Эрдэнэс-ТТ” компанийн хувьцааны 50 хувийг төрийн эзэмшилд байлгах
- Олборлосон нүүрсийг орчин үеийн технологиор боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Шаардагдах дэд бүтцийг барьж байгуулах. Энэ нь эдийн засгийн болоод экологийн ач холбогдолтой байлгах, энэ ажилд хөрөнгө оруулагчдыг татах
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид нь “Эрдэнэс-ТТ” компанийн хувьцааны 50 хүртэл хувийг (30+10+10) нэгдсэн компани /консорциум/ байдлаар эзэмшиж олборлох, үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа явуулах боломжтой байх

Эдгээр зарчим бол ТТ-н ордыг ашиглах явцад тогтвортой байх үндсэн суурь асуудал, үзэл баримтлал нь болох юм. Бас нэгэн үндсэн зарчим бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.2-т “Гадаадын аль нэг ороос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад ороос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална”

Судалгааны эмхтгэл, XI боть

гэж заасанчлан хөрөнгө оруулагчдын оролцооны тэнцвэрийг хэрхэн хангасныг авч үзэх шаардлагатай юм.

“Харилцан ашигтай байх” зарчим гэдэг ойлголт бол зөвхөн ашиг, орлого талаасаа бус хариуцлага талаасаа ч мөн “ashiagtay” байх зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд “Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад бүртгэлтэй байх”-аар заасан нь өөрийн хөрөнгө багатай салбар компани сонгон шалгаруулах магадлал өндөр байна. Иймээс хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө, ашиглах технологи, мөн байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаарх үүргүүдийг толгой компани нь давхар хариуцахаар баталгаажуулах асуудлыг гэрээнд тусгах нь зүйтэй юм<sup>72</sup>. Ингэснээр хөрөнгө оруулагч талын хариуцлагын асуудал өндөрсөх боломж бурдэнэ гэж үзэж байна.

Судлаачид, уул уурхайн мэргэжилтнүүд одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын хуулийн болон энэхүү 39 дүгээр тогтоолыг мөрдөхөд санаа нь хоёрдмоп байна гээд олон олон заалтуудыг жишээ болгож тайлбарладаг. Үг зүй, найруулга талаасаа яаж тайлбарлаж байгаагасаа шалтгаалж олон үндэслэлүүдийг гаргаж ирж болох ч дээр дурьдсан үндсэн зарчмыг баримтлах нь түлхүүр асуудал болж байна.

Засгийн газрын стратегийн хөрөнгө оруулагчдтай хийж байгаа хэлэлцээрээр тус ордын Цанхийн хэсгийг үндсэн 2 хэсэгт хувааж үйл ажиллагааг нь явуулахаар төлөвлөж байна. Бизнесийн утгаараа, төр нь аль ч цаг үед “хамгийн муу менежер”-ээр шалгарч явж ирсэн байдал. Өөрөөр хэлбэл, хувьцаат компанийд төр 50 хувь эзэмшинэ гэдэг бол цаад утгаараа “менежментийг өөрөө хийнэ” гэсэн үг.

Үүнээс гарах гарц нь Баруун Цанхийн хэсэгт үйл ажиллагаа явуулах стратегийн хөрөнгө оруулагчид “Уурхайн асуудлыг хэрхэн шийдэх, тоног төхөөрөмж, борлуулалтаа яаж хийх, уурхайтай холбоотой дэд бүтцийн асуудал буюу нүүрс угаах үйлдвэр, цахилгаан станц, усны хангамжийн системд яаж оролцох, байгаль орчны нөхөн сэргээлт, ажилтнуудын сургалтын асуудал, хөдөлмөрийн аюулгүй байдал зэргийг шийдэх эрхийг” олгож байгаа<sup>73</sup> нь уурхайн менежментийг сайн хийх боломжийг олгож байгаа явдал гэж үзэж болох юм.

Гэхдээ, УИХ-ын тогтоолд “2/Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс-Таван толгой” компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх ...” гэж заасан учир уг стратегийн хөрөнгө оруулагч компани (консорциум)-ий хувьцааны 50 хувийг эзэмшинэ гэдгийг тодорхой ойлгож болох юм. Харин энэ тохиолдолд “муу менежер” байхгүйн тулд түүнээс зайлсхийж хөрөнгө оруулалтын гэрээгээр менежментийг хөрөнгө оруулагч талд шилжүүлэх хувилбар гарч ирнэ. Энэ нь эргээд төрд ирэх ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, олборлолт, борлуулалтаас орох ашгийг нэмэгдүүлэх хувилбар болж болох юм.

Нэг талаас төр, тухайн улсын иргэд “яавал хамгийн их ашиг хүртэх вэ?” хэмээн эрмэлзэж өөрийн эзэмшлийн хувия нэмэгдүүлэх, татвараа өсгөхийг эрмэлзэнэ. Нөгөө талаас хөрөнгө оруулагч “яавал хамгийн богино хугацаанд зардлаа нөхөж ашигаа нэмэгдүүлэх вэ?” гэдэгт анхаарал хандуулна. Энэ хоёрын огтлолцол дээр “эрх ашгийн зөрчил” үүсэх нь гарцаагүй<sup>74</sup>. Үүнийг шийдвэрлэхэд “урт хугацааны, тогтвортой, харилцан ашигтай хамтын

<sup>72</sup> “Investment contracts and sustainable development - How to make contracts for fairer and more sustainable natural resource investments” Lorenzo Cotula. First published by the International Institute for Environment and Development (UK). in 2010

<sup>73</sup> <http://www.ot.mn>

<sup>74</sup> Investment contracts and sustainable development: How to make contracts for fairer and more sustain-

ажиллагаа" тун чухал болно.

Сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэж, ялангуяа уул уурхайн салбарт дийлэнх нь чиглэж байна. Монгол улсад бизнес явуулахад эрсдэл ихтэй байсан бол ийм хандлага маш бага байх байсан. Үүнийг дүгнэх хэлэхдээ Монгол улсын эдийн засгийн болон төр нийгмийн байдлын тухай гадаадын шинжээчид "Discover Mongolia – 2011" чуулга уулзалтад оролцох үедээ "энэ 2011, 2012 онд Монгол улсад хөрөнгө оруулахад хамгийн тохиromжтой ўе юм" гэж тодорхойлж байна.

Чуулганд оролцогчдын болон зохион байгуулагчид, салбарын яамдын илтгэл, дүгнэлтээр дараах зүйлс харагдаж байна. Үүнд:

- Татварын хэмжээ хэд байх нь Монгол Улсын дотоод асуудал: Гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол улсын уул уурхайн салбарын татварын хэмжээ хэд байх нь "хамааралгүй" буюу онцын чухал асуудлын хэмжээнд авч үзэхгүй байна гэж болохоор байна. Угаас, манай улсын орлогын албан татварын хэмжээ шинэчилсэн түвшингээрээ Азид төдийгүй, дэлхийн хэмжээнд бага татвартай орны тоонд орж байгаа юм. Уул уурхайн салбарын татварын хэмжээ дэлхийн дундаж нь 28% орчим байгаа бол манайх дээд тал нь 25% байгаа нь үүнийг гэрчилж байна. (Дор хүснэгтэд үзүүлэв)



able natural resource investments. Lorenzo Cotula. First published by the International Institute for Environment and Development (UK) in 2010

Судалгааны эмхтгэл, XI боть

Ази болон Австралийн бүсийн орлогын албан татварын харьцуулалт<sup>75</sup>:

Улсын нэр	Орлогын албан татварын хувь		НӨАТ
	Аж ахуйн нэгж	Хувь хүн	
Australia	30%	17-45%	10%GST
China	25%	5-45%	17%
India	30-40%	10-30%	12.50%
Indonesia	28%	5-30%	10%
Japan	30%	5-50%	5%(consump)
New Zealand	30%	0-39%	15%gst
Pakistan	35%	0-25%	15%
Philippines	30%	5-32%	12%
Thailand	30%	5-37%	7%
Vietnam	25%	5-35%	10%
AVAREGE	28%		

(Last partial update, August 23, 2011)

- Ашигт малтмалын хууль эргэлзээ төрүүлдэггүй, “цор ганц” байх хэрэгтэй: Монгол улсын хууль, эрх зүйн орчин тогтвортой байх л хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, “Монгол улсын хууль нь цор ганц, тогтвортой байж” чадвал хөрөнгө оруулагчид Монголд хөрөнгөө оруулахад эрсдэл буурч, өндөр сонирхлыг бий болгож байна. УҮҮА-ийн гүйцэтгэх захирал Н.Алгаагийн тодорхойлсноор гадаадын хөрөнгө оруулагчид ердөө хоёр л зүйлийг Монгол Улсын төрөөс хүсэж байна. Энэ нь “1. Тогтвортой байдал, 2. Тодорхой байдал” Энэ 2 үзээр хүсэлт, хандлагын санааг бүрэн илэрхийлэх боломжтой гэж үзэж байна.
- Хөрөнгө оруулагчдын хувьд “ул уурхайн салбарын анхны хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, үйл ажиллагаа зогслоо гэхэд түүнийг буцаан авах боломжгүй байдаг, зардлаа нөхөх хугацаа урт байдал, эрх зүй, татварын орчин тогтвортой байх баталгааг гаргаж чадахгүй” гэсэн байр суурийг аль ч төрлийн компани, хөрөнгө оруулагч илэрхийлж байдаг учраас тогтвортой, тодорхой байдлыг төрөөс хүсэж байдаг.
- Экологийн хувьд хөнгөлөлт үзүүлэхгүй байх: Монгол улсын хувьд “хөрөнгө оруулагчидтай аливаа нөхцөл, хувилбарыг хөрөнгө оруулалтыг хэлэлцсэний үндсэн дээр тохирч аль аль талаасаа хөнгөлөлт үзүүлэх, тохиролцох асуудал байж болно. Гагцхүү, экологийн асуудлаар ямар ч хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй” гэдгийг хөрөнгө оруулагчдад анхааруулсан бөгөөд үүнийг тэд бүрэн хүлээн зөвшөөрсөн байдаг<sup>76</sup>. Зөвшөөрч ярих нэг асуудал, хэрэгжүүлэх бас өөр асуудал. Ярьсны дагуу хэрэгжүүлэхэд “Тодорхой байдал” маш чухал юм.

\* \* \*

<sup>75</sup> <http://www.worldwide-tax.com/#partthree>

<sup>76</sup> “Discover Mongolia – 2011” чуулга уулзалтын хэлэлцүүлгээс судлаачийн хийсэн дүгнэлт

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ШАЛГАРАХ МАГАДЛАЛ БУХИЙ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ КОМПАНИУД

### 1. ОХУ, Япон, БНСУ-ын хамтарсан консорциум

#### 1.1. ОХУ-ын компаниуд

- “РЖД” (Оросын төмөр зам/ОТЗ)

Оросын төрийн өмчтөй компани. Улсдаа толгойлох, монополь компани. ОХУ-ын ДНБ-ий 2.5%-ийг бүрдүүлдэг. Эзэмшлийн төмөр замын урт нь 85,500 км.

- “СҮЭК” (Сибирийн эрчим хүч, нүүрсний компани)<sup>77</sup>

ОТЗ-тай хамтарч тендерт оролцож байгаа. 2001 онд байгуулагдсан, нээлттэй хувьцаат нийгэмлэг. Киприйн аралд бүртгэлтэй. Нийт хувьцааны 99.84%-ийг Киприйн “Donalink Ltd” компани эзэмшдэг, үлдсэн 0.16% нь “Красноярский уурхай” компанийн нэр дээр байдаг. Орос орны өнцөг булан бүрт нүүрс олборлож, үзүүлэлтээрээ 1-р байрт итгэлтэй орсон. Нийт 46,000 ажилтантай. Ойрын 10 жилд нүүрс олборлолт төдийгүй боловсруулах үйлдвэрлэлд дэлхийд тэргүүлэх байрыг эзлэх бизнесийн уриатай.

Буриад, Кемеров муж, Красноярск, Приморын хязгаар, Хакасид олон тооны уурхайтай. Европын улсууд, Япон руу нүүрс экспортолдог. Сонирхол татах олон төсөл хэрэгжүүлж байгаа. Юуны өмнө Ванино боомтод (Мучке өртөө) жилдээ 12 сая тн нүүрс экспортлох хүчин чадалтай терминал ашиглалтанд оруулна. Мөн Хабаровск мужид нүүрс боловсруулах (угаах) үйлдвэр байгуулахаар төлөвлөжээ. 2007 онд “Газпром” компанийн нэгдэж нүүрс, нефть, хийн аварга консорциум байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч ОХУ-ын Монополийн эсрэг алба ба Эрчим хүчний нэгдсэн сүлжээний эсэргүүцэлтэй тулгарч хэрэгжээгүй.

#### 1.2. Японы компаниуд

- “Itochu” (Иточу)

Тус компани үйл ажиллагаагаа 1858 онд кимоногийн худалдаагаар эхэлж байв. Компаний цэвэр ашиг 2007 онд 218.6 тэрбум юен хүрч байв. Эрчим хүч, эрдэс баялаг, металл, даавуу, санхүү, ой мод, содон бүтээгдэхүүн, даатгал, үл хөдлөх хөрөнгө, машин техникийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

- “Marubeni” (Марубени)

1858 онд байгуулагдаж, зотон даавууны худалдаагаар үйл ажиллагаа нь эхэлсэн. Үйл ажиллагаа нь жилээс жилд өргөжсөөр “Тоцу”, “Нанё Буссан” компаниудыг нэгтгэсэн.

- “Sumitomo” (Сумитомо)

1615 онд байгуулагдаж, номын дэлгүүрийн худалдаагаар үйл ажиллагаа нь эхэлсэн. Хүнд үйлдвэр, банк санхүү, цемент, хөнгөн үйлдвэр, химийн бүтээгдэхүүн, уул уурхай, автомашин, компьютерийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, дэлхийг хэрсэн сүлжээтэй.

- “Sojitz” (Сожиц)

2004 онд “Нисшо Ивай”, “Ничимэн” корпораци нэгдэж байгуулсан. Олон салбарт

<sup>77</sup> Монголын Уул уурхайн Ассоциацийн вэбсайт, <http://mmpa.mn>

үйл ажиллагаа явуулдагаас уул уурхай томд нь тооцогдоно. 2010 онд 95 сая ам. долларын ашигтай ажиллажээ.

### 1.3. БНСҮ-ын компаниуд

- “Koreas” (Kopres) Групп.

### 2. ”Mitsui & Co” (Мицуй, Япон)<sup>78</sup>

1947 онд байгуулагдсан. 65 улсад 151 салбартай. Хөрөнгө оруулалтаар дэлхийд тэргүүлдэг. Японы голлох компаниудын нэг. Үйл ажиллагаа: ган төмрийн үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл, эрчим хүч, жижиглэн худалдаа, хоол хүнс, автомашин, харилцаа холбоо, дэд бүтэц, тээвэр Тавантолгойн тендert Хятадын “Шинхуа”-тай нэгдэл болон оролцож буй.<sup>79</sup>

### 3. “Xstrata Coal” (Экстрата Коол, Австраль-Швейцарь)

Консорциум. “Нүүрсний акул”. Коксжих нүүрсний 5 дахь том үйлдвэрлэгч. Өмнөд Африкийн томоохон нүүрс олборлогч. Австралийн нүүрсний экспортын манлайлагч. Дэлхийн 30 гаруй улсад үйл ажиллагаа явуулдаг.

### 4. “Vale” (Валэ, Бразил)

Үндэстэн дамнасан компани. “Нүүрсний шуналтан”. 1942 онд байгуулагдсан. Уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн хүчин чадлаараа дэлхийд хоёрт жагсдаг. Төмрийн хүдэр, зэс, төмрийн хайлш, нүүрс хүчлийн кали, хөнгөн цагаан салбарт амжилттай ажиллаж байгаа. Бразилийн нийт экспортын 11.9% Валэд ноогддог. 2010 онд 5.5 тэрбум долларын цэвэр ашигтай ажилласан. 5 тивийн 38 оронд салбар нэгжтэй. Мозамбикт жилдээ 14 сая тн металлургийн болон эрчмийн нүүрс олборлох, 70 жилийн нөөцтэй уурхайтай. Австралид 2.7 тэрбум тн нүүрсний нөөцтэй ордыг эзэмшдэг.

### 5. “Arcelor Mittal” (Арсэлор Митал, Люксембург)

Дэлхийн “гангийн үйлдвэрлэлийн магнат” тодотголтой энэ компани 1989 онд байгуулагдсан. 2010 онд 90.6 сая тн боловсруулаагүй гангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж (дэлхийн гангийн бүтээгдэхүүний 8%-ийг эзэлнэ), 78 тэрбум долларын ашигтай ажилласан. 60 оронд өөрийн төвтэй. 4 тивийн 20 орны аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг.

### 6. Пийбоди Энержи /Peabody energy/ компанийн танилцуулга

Харьялал: АНУ,

Хаяг: Peabody Energy, 701 Market street, St.Louis, Missouri 63101. [www.peabodyEnergy.com](http://www.peabodyEnergy.com)

Товч түүх: Тус компани нь 125 жилийн турш уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа хувийн компани. Гол үйлдвэрлэл нь нүүрс үйлдвэрлэл - ил уурхай. Дэлхий даяар нийт есөн тэрбум тонн нүүрсний батлагдсан нөөц олборлох эрхтэй. Дэлхийн эрчим хүчний үйлдвэрлэлийн хоёр хувь, АНУ-ын арван хувийг дангаараа бүрдүүлдэг. 2011 оны эхний улирлын байдлаар нийт 61.2 сая тонн нүүрс олборлож, тонн тутмынхаа ашгийг 43 хувиар нэмэгдүүлжээ.

Гол үйлдвэрлэл нь Вайоминг муж улсын Паудэр голын хөндийд байрлах Хойд Антелопын

<sup>78</sup> Б.Алисиа, Mongolian Mining Journal

<sup>79</sup> Монголын Уул уурхайн Ассоциацийн вэбсайт, <http://mimpa.mn>

Рошемлийн нүүрсний уурхай. Хойд Антелопын Рошемлийн уурхай 100-аас дээш сая тонн нүүрс үйлдвэрлэх хүчин чадалтай, 1200 ажлын байртай. Цагт 11.000 тн нүүрсийг галт тэрэгний цуваанд ачаалдаг. Уурхайгаас өдөрт 28 галт тэрэгний цувааг ачиж гаргах хүчин чадалтай. Энэ нь жилд 10 000 галт тэрэгний цувааг ачих боломжтой гэсэн үг.

Уурхайн технологи: Хамгийн сүүлийн үеийн технологи, тоног төхөөрөмжийг уурхайд хэрэглэдэг. Модулын уурхайн систем гэж нэрлэгдсэн нэг систем нь:

- Ачааны машины маршрутыг удирдан хянаадаг. Энэхүү хяналтын үр дүнд үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд шаардлагатай байгаа үзүүлэлт бүхий нүүрсийг холих боломжтой
- Машины операторууд, жолооч болон диспетчерүүд угсистемийг ашиглан хөдөлмөрийн бүтээмжээ цаг тухайд нь үнэлэх боломжтой.
- Дэлхий нийтийн байрлалын системийг /GPS/ ашигласнаар талбай дээр ажиллаж буй нийт ачааны машины хөдлөх бүрэлдэхүүний байршлыг тогтоож, экскаватороос ачааны машин, ачааны машинаас галт тэргэнд очих циклийг хянах боломжтой.
- Диспетчериин баг болон машины оператор хоорондоо шууд харилцаж, нүүрсний холимгийг тохиуулах, нүүрсний үзүүлэлт, чанарыг дээшлүүлэх бололцоотой.

Түүнчлэн хамгийн сүүлийн үеийн технологийг ашигладаг драглайн /экскаватор/, конвейерийн дамжуулах бус болон нүүрс холих системд хөрөнгө оруулалт хийсэн нь хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлж, зардал хэмнэж, нүүрсний чанарыг сайжруулсан гэж үзэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа: Пийбодид ажиллаж буй хүн бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар доорхи зарчим үйлчилдэг.

- Хамгийн үнэ цэнтэй хөрөнгө болох ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд бол тус компанийн бүхий л үйл ажиллагааг хамарсан үнэ цэнэ гэж тооцогддог.
- Бүхий л төрлийн осол аваар түүний дотор гэмтэл, мэргэжлийн өвчин, өмч хөрөнгөд учрах хохирол болон осол аваар үүсгэх байдлыг бүгдийг нь урьдчилан сэргийлж арилгаж болно.
- Ажилчны аюулгүй байдал, эрүүл мэндийн талаар удирдлага менежмент нь ерөнхий хариуцлага хүлээнэ.
- Ажилчин бүр өөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хариуцахаас гадна хамтран ажиллагдахынхаа аюулгүй байдлын төлөө санаа тавьж ажиллана.
- Ажилчин бүр өөрийн эрхэлсэн ажлыг аюулгүй байдлаар явуулахын тулд зохих мэдлэг, ур чадвар, эрх мэдэлтэй байх ёстой.
- Бүх ажилчин тогтоосон хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмыг ягштал биелүүлэх ёстой.
- Аюулгүй байдлын талаарх нэн шаардлагатай мэдээлэл, харилцааг ил тодоор, үнэнч шударга, үр бүтээлтэйгээр явуулж байх ёстой.
- Аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тавьж буй бүхий л хүчин чармайлтыг байнга туштай хэрэгжүүлж байх ёстой бөгөөд тогтмол эргэж харж, сайжруулж байх ёстой.
- Пийбодигийн ажилчин ажлаа явуулж байгаа бүхий л орчинг ажлын байр гэж тооцно.

Энэхүү зарчмыг компанийн удирдлагаас авахуулаад уурхайчин хүртэл хүн бүр даган мөрддөг байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төвлөрсөн баг баг ажилладаг. Уурхай бүр дээр бас ийм багтай. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Осол аваар гаргахгүйн төлөө харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагааны ётандарт журмыг сайжруулах, осол аваарын үндэс суурь болсон шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийхэд анхаарч ажилладаг. Сүүлийн 7 жилийн хугацаанд Пийбодигийн уурхайнууд нь АНУ-ын Хөдөлмөрийн яамнаас олгодог “Аюулгүй байдлын харуул” хэмээх өндөр шагналыг хүртсэн байна.

Байгаль орчныг хамгаалах чиглэлд:

Судалгааны эмхтгэл, XI боть

Уурхайн үйл ажиллагаа явуулсан газрыг өмнөх байдалтай ижил эсвэл түүнээс илүү байдалтай болгох чиглэлээр нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг. Үүнд:

- Бэлчээрийн газар
- Зэрлэг амьтад оршин амьдрах орчин
- Ой
- Намаг
- Соёл амралтын газрууд бий болгох
- Соёлын өвийг хадгалах чиглэлээр нөхөн сэргээлт хийдэг.

Нөхөн сэргээлт хийхдээ анхаардаг зүйлс:

- Нутгийн иргэдтэй хамтран ажилладаг
- Байгаль орчны чиглэлийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажилладаг. Тодорхой жишээ: 2010 онд Булган аймгийн Эрээний уурхайг ашигласны дараа Монгол улсын Засгийн газар, ХААИС, Монголын Бэлчээрийн үр, ургамлыг тариалагчдын холбоотой хамтран нөхөн сэргээлт хийсэн нь Монгол улсад анх удаа нүүрсний уурхайн газарт иж бүрнээр нь нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулсан тохиолдол юм.

## 7. Уул уурхайн Макмахон /Macmahon/ компанийн танилцуулга

Харьялал: Австрали улс

Хаяг: Macmahon Holding Limited and Macmahon Contractors Pty Ltd. PO Box 198, Cannington, WA, 6987 Australia.

Гол үйлдвэрлэл нь: ил далд уурхай, уул уурхайн тоног төхөөрөмж нийлүүлэлт, уул уурхайн компанийн менежментийн удирдлага, дэд бүтцийн /зам, төмөр болон усан зам, усан сан/ барилга байгууламж.

Товч түүх: Тус компани нь Австралийн барилга үйлдвэрлэл болон Австрали, Шинэ Зеланд, Зүүн, Өмнөд Ази болон Африкийн томоохон төслүүд дээр ажилладаг уул уурхайн гэрээ хэлцлийн тэргүүлэгч компани.

50 гаруй жилийн ажлын туршлагатай.

Гол удирдлага нь Perth/ байрлах бөгөөд Сидней, Брисбан, Дарвин, Аделайд, Куалалумпур, Хонг Конг, Лагост салбарууд нь бий. Нийт ажиллагсдын тоо 3000 гаруй.

Тус компанийн бусдаас ялгагдах онцлог нь бүх төрлийн тээвэр, далайн хөлөг онгоц, ус болон дэд бүтцийн үйлчилгээний нөөцөөрөө илүү давамгай бөгөөд энэ чиглэлээр Засгийн газрын болон хувийн секторын байгууллагуудтай хамтран ажилладаг.

Мөн ажиллагсдынхаа эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад ихээхэн туршлага хурилтуулсан.

Уул уурхайн чиглэлээр ил болон далд уурхайн үйлдвэрлэлээс авахуулаад дэлхийн томоохон хэд хэдэн уурхайн компанийг менежментийн удирдлагаар хангаж ажилладаг. Макмахон нь уул уурхайн төрөл бүрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлчлүүлэгчээ дээдэлсэн гэрээ контракт хийх талаар маш их мэргэжсэн компани.

Компанийн алсын хараа ба үнэт зүйлс нь:

Тус компанийн үйл ажиллагааны алсын хараа болон үнэт зүйлс тэдний ажиллагсад болон хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчдийнхээ эрх ашгийг дээдлэхэд оршдог байна.

Алсын хараа нь:

- Ажиллагсдынхаа төлөө ажиллах
- Хэрэглэгчдийнхээ төлөө зарцуулах
- Хувьцаа эзэмшигчдийнхээ төлөө хөрөнгө оруулах гэсэн уриаг гол болгодог.

Үнэт зүйлс нь:

Нийт ажиллагсдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дээдлэх. Үүнд:

- Аюулгүй байдал- Өөрийгөө, багынхныгаа, бусдыг халамжлах
- Багаар ажиллах-Ухаалга ажиллах, мэрийж ажиллах, хамтдаа ажиллах
- Хөгжил цэцэглэлт буюу амжилт-Бүх харилцагч, хувьцаа эзэмшигч, ажиллагсад, үйлчлүүлэгчдийнхээ төлөө үнэт зүйлсийг бүтээх
- Шударга байдал-Хэлснээ биелүүлэхийн төлөө чармайх
- Байгаль орчин: ЗР зарчим буюу бууруулах /багасгах/, дахин ашиглах, сэргээн засварлах /шинэчлэн босгох/

Компанийн зарчим нь:

- Алсын хараа ба үнэт зүйлс /Vision and Values/
- Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Байгаль орчин ба Чанар /HSEQ-Health, Safety, Environment, Quality/
- Эрсдлийн менежмент /Risk Management/
- Ажлын байран дахь Workplace Relations

Монголын нүүрсний төсөлд онцгой эрхтэй гэрээ байгуулагчийн мэдээлэл

Макмахон /Macmahon Holdings Limited/ ХХК нь Германы Би Би Эм Оперта груптийн хамтран Монгол улсын нүүрсний уурхай Таван толгойд оператор компаниар ажиллах болсноо зарлаж байна.

Таван толгойн нүүрсний төслийн эзэмшигч төрийн эзэмшлийн Эрдэнэс Таван толгой JSC нь Германы Би Би Эм Оперта груптийн хамтрагч Макмахон /Macmahon Holdings Limited/ ХХК –ийг онцгой гэрээ байгуулагч гэж зарласан.

Энэхүү гэрээ нь Улаанбаатараас өмнө зүгт 540 орчим км алс хол, Монголын Өмнөговь аймагт орших Таван толгойн Зүүн Цанхид их хэмжээний ил уурхайн операторын үйл ажиллагааг хамрах болно. Урьдчилан төлөвлөснөөр, дэд бүтэц тавигдсан /шийдэгдсэн/ тохиолдолд жил бүр олборлох нүүрс 15 сая тонн /15 million tones/ нүүрсээр нэмэгдэх төлөв байгаа.

Масмахон ХХК-ийн Гүйцэтгэх албаны дарга Ник Бовен “Тус компанийн ололт амжилтууд нь Монголын нүүрсний салбарын аюулгүй ажиллагааг сайжруулна” гэж хэлэв. Тэрбээр цааш нь “Таван толгойн төслийн хөгжил дэвшил нь одоогоор Масмахоны бат суурьд нөлөөлж байгаа бөгөөд гол хүчин чармайлт нь дэлхийн хамгийн том хөгжжик буй уул уурхайн бусийн урт хугацааны бизнесийн суурийг тавихад оршино” гэжээ. Масмахон болон Би Би Эм Оперта хамтарсан групп нь Эрдэнэс Таван толгой компанийтай ирэх сард гэрээний зүйл заалтыг дуусгахын тулд хамтран ажиллах болно.

\* \* \*

## 8. Шинхуа Энержи /China Shenhua Energy Company Limited/ компанийн танилцуулга

Харьялал: БНХАУ

Байрлал: БНХАУ, Бээжин хот

Гол үйлдвэрлэл: нь нүүрс олборлолт, тээвэрлэлт, цахилгаан эрчим хүчний нүүрс нийлүүлэлт.

Товч түүх: “Шинхуа групп” корпораци нь 2004 оны 8-р сард Хятадын Шинхуа Энержи ХХК /China Shenhua Energy Company Limited/-ийг тусгайлан үүсгэн байгуулжээ. /зарим хэвлэлийн мэдээнд 1995 онд гэж бичжээ/

Шинхуай Энержи нь Хятадын төрийн өмчит компани.

Н болон А хувьцаа нь 2005 оны 7-р сар, 2007 оны 10-р сард тус тусдаа Хонг-Конг, Шанхайн хөрөнгийн бирж дээр бүртгүүлсэн. “Шинхуа Энержи” нь нийт 224.8 сая тонн нүүрсний нөөц өзэмшиж, Хятадын нүүрсний экспортын 38 хувийг дангаараа хангагдаг компани. Нүүрс олборлолтоороо улсдаа тэргүүлдэг, харин дэлхийд гуравдугаарт ордог. Хятадын Шинхуа Энержи нь нүүрс үйлдвэрлэлд сууринласан дэлхийн томоохон эрчим хүчний компани. Тус компанийн гол бизнес нь нүүрс үйлдвэрлэлт болон борлуулалт, төмөр болон усан замын нүүрс тээвэрлэлт. Тус компанийн нүүрсний бизнес нь Хятадын нүүрсний үйлдвэрлэлийн хамгийн аюулгүй болон өндөр үр ашигтай өргөн цар хүрээтэй үйлдвэрлэлээр шалгарчээ.

2009 оны 12-р сарын 31-ний өдрийн байдаа Шинхуа Энержи нь Хятад улсын уул уурхайн үйлдвэрлэлийн стандартын дагуу урьдчилан тооцоолсоноор 11.306 тэрбум тонн олон удаа ашиглаж болохуйц нүүрсний нөөцийг өзэмших, олон улсын JORC байгууллагын урьдчилан тооцоолсоноор 6.927 тэрбум /billion tons/ тонны нүүрснийг борлуулах чадвартай гэж тогтоогдсон.

2009 онд Шинхуа Энержи 210.3 сая тонн нүүрс үйлдвэрлэсэн нь өмнөх жилийнхээс 13.2%-иар, 254.3 сая тонн нүүрс борлуулсан нь өмнөх жилийнхээс 9.3%-иар тус тус өссөн байна. 2009 онд түүхий нүүрсний хорогдол /тонн тутамд/ нь 0.017 байж.

Шинхуа нь усан болон төмөр замын өргөн хүрээний тээврийн сүлжээтэй бөгөөд үүнд Хятадын Өрнөөс Дорно руу нүүрс тээвэрлэдэг /уртаараа Хятаддаа 2 дахь/ Shenshuo-Shuohuang төмөр замын оператор компани, Хуанхуа усан онгоцны боомт, Шинхуа, Тэнжиний нүүрсний боомт зэрэг 5 том байгууламжийг ажиллуулдаг. Эдгээр нь үйлдвэрлэлийн үр ашиг асар их өндөр бөгөөд тээвэрлэлтийн зардлыг маш ихээр хэмнэдэг байна.

2009 тус компанийн хувийн өзэмшлийн төмөр замын нүүрс тээвэрлэлтийн эргэлт нь 138.2 тэрбум тонн-км, усан замын боомтоор нүүрс тээвэрлэлт нь 159.2 сая тн-д хүрчээ. Шинхуа Энержи компани тухайн улсын эрчим хүчний сүлжээнд ороогүй 413 мегаваттын хүчин чадалтай 13 дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан туршлагатай.

2009 онд Шинхуа Энержи 105.09 тэрбум киловатт цагийн үйлдвэрлэл явуулсан нь өмнөх жилээс 7.5 хувиар өсчээ. 2009 онд Шинхуагийн бүтэн жилийн орлого нь 121.372 тэрбум юаньд хурсэн байна. Бизнесийн байгууллагын стандартын дагуу компанийн нийт үндсэн хөрөнгө 310.514 тэрбум юань болсон бөгөөд үүнээс хувьцаа өзэмшигчдийнх нь 30.276 тэрбум, нэгж хувьцааны ашиг орлого нь 1.522 юань байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд:

	Unit(RMB)	2007	2008	2009
--	-----------	------	------	------

• Орлого /Revenues /	Сая юань million yuan	82,107	107,133	121,312
• Үйл ажиллагааны ашиг/ Operating profit	million yuan	32,497	39,675	47,108
• Жилийн ашиг /Profit for the year	million yuan	24,037	29,899	36,186
• Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн хамааруулж болох ашиг / Profit attributable to equity shareholders of the Company	million yuan	20,581	26,641	31,706
• Нэгж хувьцаанд ноогдох ашиг/ Earning per share	Yuan	1.110	1.339	1.594
• Нийт актив /Total assets	million yuan	238,527	275,540	311,677
• Нийт өр/Total liabilities	million yuan	88,723	103,797	114,259
• Нийт тэнцэл / Total equity	million yuan	149,804	171,743	197,418
• Компанийн энгийн хувьцаанд хамааруулж болох хөрөнгө/ Of which: equity attributable to equity shareholders of the Company	million yuan	129,788	147,432	170,661

\* \* \*

#### Нүүрс үйлдвэрлэх технологи:

2009 онд тус компани Шинхуа Энержи групптэй хамтран Шинхуа груптын нүүрс үйлдвэрлэлийн технологи болон тоног төхөөрөмжийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

- Шинхуа групийн уул уурхайн тоног төхөөрөмжид нарийвчилсан шалгалт хийх нөхцөл
- Шинхуа груптын тоног төхөөрөмжийн техникийн тайлан болон уул уурхайн тоног төхөөрөмжийн хаягдлыг зайлцуулах стандарт
- Тоног төхөөрөмжийн хүчин чадлыг дээд зөргээр ашиглах зорилт
- Нүүрс үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт
- Уул уурхайн тоног төхөөрөмжийн стандарт болон нүүрс үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд багтжээ.

#### ОРДЫН АШИГЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААРХИ ТӨРИЙН БОЛОН ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГУУД, ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН САНАЛ ШҮҮМЖ

Тавантолгойн ордыг ашиглах боломжит хувилбаруудын талаар олон нийтийн зүгээс гарч буй санал шүүмжлэлд контент анализ хийхдээ өдөр тутмын хэвлэл болох “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Ардын эрх”, “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан” зэрэг сонини 2009-2011 оны 10 сарын 4-ний өдрийг хүртлэх дугаарууд болон өдөр тутмын мэдээллийн вэб сайтуудаар гарсан нийтлэлүүд болон 2011оны 08 дугаар сарын 18-ны өдөр Иргэний танхимд зохион байгуулагдсан “Тавантолгойн нүүрсний ордыг хэрхэн үр ашигтай ашиглах вэ?” сэдэвт хэллэлцүүлгээс гарсан санал, шүүмжлэл зэргийг судаллаа.

Судалгааг гүйцэтгэх явцад Тавантолгойн ордыг ашиглах боломжит хувилбаруудын талаар олон нийтээс гарсан саналыг 3 үндсэн чиглэлээр гаргасан болно.

## 1. Ордын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар олон нийтээс гарч буй санал

Олон нийтээс гарч буй саналын хувьд дараахь хэд хэдэн асуудлыг хөндсөн байна. Үүнд:

1/ Тавантолгой ордноос зөвхөн нүүрс олборлох бус харин дэд бүтэц, эрх зүйн орчин болон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын орлого түүнээс үүдэн гарах татварын бодлогыг төрийн зүгээс тодорхой болгох шаардлагатай байна.

2/ Нүүрсний ханшид нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл болох тээврийн маршрутын талаар хэд хэдэн хувилбарыг гаргасан байна. Тавантолгойн нүүрсийг БНХАУ, ОХУ гэсэн хөрш орнуудаар дамжуулан дэлхийн зах зээлд борлуулах бөгөөд харин яг ямар маршрутаар тээвэрлэх нь манай улсын хувьд ашигтай болох талаар дараахь хувилбарыг гаргажээ.

Нийтлэлийн нэр, огноо	Санал болгож буй хувилбарууд
Сэтгүүлч О.Хосцэцэг “Боломж, гэхдээ алтан давуу тал...” Өдрийн сонин 2009.11.23-ны өдрийн 282 дугаарын 5-р нүүрт	Манай улсын импортын гол гарц болох Замын-Үүд боомтын хүчин чадал өнөөдөр Таван толгойн коксжих нүүрсийг нэмж нэвтрүүлэх боломж олгохгүй юм. Тиймээс Замын Үүд боомтын хүчин чадлыг сайжруулах, Гашуун сухайт, Нарийнсухайтын чиглэлийн төмөр зам байгуулах, ингэснээр Монгол Улс нүүрс тээвэрлэх хойшоо, урагш чиглэсэн олон гарцтай болох боломжтой юм.
Сэтгүүлч А.Алтантуяа “Яагаад хоёр гурван салаа замтай байж болохгүй гэж?” Ардын эрх сонини 2009.12.01-ний өдрийн 233 дугаарын 1, 3-р нүүрт	Гашуун сухайт руу төмөр зам тавихад 240 км, богино бөгөөд тээвэрлэлтийн зардал бага байх магадлалтай. Харин Даланзадгад, Сайншандын чиглэлээр 554 км зам тавин өнөөгийн төмөр замын төв терминалттай холбогдо цаашилбал Хятадаас гадна ОХУ гэх мэт бусад гарц руу холбогдо боломжтой.
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Алтанхуяа “Таван толгойн орд газрыг яаралтай эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай” Ардын эрх сонини 2009.12.02-ны өдрийн 234 дугаарын 2-р нүүрт	Монгол Улсын Засгийн газар Тавантолгойн орд газраа аль болох хугацаа алдалгүйгээр эдийн засгийн эргэлтэнд оруулж, нүүрсний экспортыг нэмэгдүүлж, хатуу хучлагатай зам тавих ажлыг эхлүүлэх шаардлагатай байгаа юм. Тавантолгойн орд газраас 250 км-ын зайнд орших Гашуунсухайт боомтын хувьд хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
УИХ-ын гишүүн ЗТБХБ-ийн сайд Х.Баттулга “Өнгөц харахад алсур, өртөг өндөр мэт харгдах боловч ирээдүйн өгөөжийг нь харах учиртай” Ардын эрх сонини 2009.12.07-ны өдрийн 237 дугаарын 3, 4-р нүүрт	Орхон аймагт Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Дархан-Уул аймгийн төмөрлөгийн үйлдвэртэйгээ уялдуулан хөгжүүлэхийн тулд одоогийн төмөр замтайгаа огтолццуулан Тавантолгойгоос Сайншанд хүртлэх 500 орчим км төмөр замыг шинээр барих, Цаашилбал энэ зам Чойбалсан хотын өргөн төмөр замаар дамжин ОХУ-ын транс Сибирийн төмөр замын сүлжээтэй холбогдон Европын зах зээлрүү хагас боловсруулсан бүтээгдэхүүн гаргах бас нэгэн гарц байгаа
УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн “Бодлого тодорхой биш учраас бид ажлынхаа дэс дарааг алчихаж” Өнөөдөр сонини 2009.12.11-ний өдрийн 285 дугаарын A2-р нүүрт	Оюутолгой, Тавантолгойг холбох төмөр замыг гол төмөр замтайгаа холбох хэрэгтэй. Уул уурхайн бүтээгдэхүүн урд хөршид нийлүүлэхийн зэрэгцээ Таньжин боомт хүрч байж л дэлхийн зах зээлд гарна. Тийм учраас шууд урагш чиглэсэн төмөр замаа ч барих хэрэгтэй, төв төмөр замтайгаа ч холбох нь зүйтэй. Хоёулаа л баригдах ёстой.

Сэтгүүлч Н.Хулан “Монголын хоёр дахь саалийн үнээ Сайншандын цогцолбор” Монголын мэдээ сонины 2009.12.14-ний өдрийн 245 дугаарын 5-р нүүрт	Ухаахудагаас Сайншанд руу төмөр зам тавьж, Монгол Улсын төмөр замын төв магистральтай холболов Тавантолгойн нүүрс олон улсад гаруу нээгдэнэ. Цаашлаад Сайншандыг хүн аж үйлдвэрийн цогцолбор болгоод, нүүрсээ боловсруулаад гаргавал нэмүү өртөг нь манайд үлдэнэ. Манай улсын эдийн засаг ч тэр хэмжээгээр сэргэн гэсэн уг юм.
“Эрс шинэчлэл” хөдөлгөөний төргүүн С.Ганбаатар: “Оросын олигархиас салах хэрэгтэй.” Зууны мэдээ сонины 2009.12.14-ний өдрийн 291 дугаарын 5-р нүүрт	Нүүрсээ борлуулъя гэж байгаа бол хамгийн ойрхон, хамгийн том зах зээл болох Хятад руу гаргах хэрэгтэй. Үүний тулд цаанаас угтуулан барьсан Таньжин боомт руу аль болох ойрхон темер зам барих ёстой.
Сэтгүүлч Д.Болдуяг “Тавантолгой, Монголчуудын хожил” Зууны мэдээ сонины 2009.12.15-ны өдрийн 292 дугаарын 3-р нүүрт	“Ухаахудаг”-аас Таньжин хүрэх тээврийн өртөг ч өргөн царигитай тойруу маршрутаас дор хаяж гурав дахин хямд байх тооцоо гарчээ. Гашуунсхайт-Бугатын чиглэлийн нарийн төмөр зам нь зөвхөн Хятад биш Япон, Солонгос, Энэтхэг гэсэн гурван том худалдан авагчид Таньжин боомтоор дамжин хүргэх дөт зам юм. Находкагаар дамжилаас гурав дахин, Ваниногоор дайруулахаас бараг дөрөв дахин богино юм. Гашуунсхайт-Бугатын чиглэлийн нарийн төмөр зам нь зөвхөн Хятад биш Япон, Солонгос, Энэтхэг гэсэн гурван том худалдан авагчид Таньжин боомтоор дамжин хүргэх дөт зам юм. Находкагаар дамжилаас гурав дахин, Ваниногоор дайруулахаас бараг дөрөв дахин богино.
“Угтуулан тавих нөхцөлөө яасан бэ?” Ардын эрх сонины 2010.07.05-ны өдрийн №130 дугаарын 3, 5 –р нүүрт	Хэрвээ Оросын компанийг сонгохгүй бол Алс Дорнодын уудам замаар Тавантолгойн нүүрсийг дотоодын тээврийнхээ тарифыг гурав дахин нугалсан өндөр үнээр зөөнө өө. Хятадын компани оператор болоогүй нөхцөлд тус улсын төмөр замын тээврийн маш их ачаалалтай графикт Тавантолгойн нүүрстэй вагон хэзээ ч нэвтэрч чадахгүй ээ. Далайн боомт ашиглах боломжийг ч Монголын нүүрсэнд тийм амархан олгохгүй ээ.
Д.Доржпагма “Төмөр зам хоёр хөршийн алин руу нь чиглэх вэ?” Өдрийн сонины 2009.11.25-ний өдрийн 284 дугаарын 2-р нүүрт	Таван толгойгоос Зүүн баян-Сайншандаас цааш Чойбалсан-Алс Дорнод хүртэл 1000-аад км үргэлжлэх төмөр зам барьж ОХУ-ын Транссибирийн төмөр замтай холбоно нь эдийн засгийн хувьд илүү ач холбогдолтой гэж тооцоолжээ. Мөн Тавантолгойгоос Гашуун сухай хүтэл 260 км төмөр зам барих учир өртөг зардал нь ОХУ-ын чиглэлэд тавьсанаас хамаагүй бага, 300-500 сая ам.доллар шаардлагатай ажээ.

3/ Тавантолгойн нүүрсийг түүхийгээр нь экспортлох бус харин боловсруулан үнэ хүргэж, зах зээлд борлуулах, үүний тулд нүүрсийг боловсруулах чиглэлийн үйлдвэрийг байгуулах явдал юм. Тавантолгой коксжсон нүүрсний асар их нөөцтэй. Үүнийг ашиглаад тан үйлдвэрлэж, төмөртэй болж болно. Мөн нүүрсээ боловсруулаад экспортлоход нэмүү өртөг нь нэмэгдэж, тэр хэрээр манай улсын эдийн засаг сэргэх юм.

Тавантолгойн нүүрсийг боловсруулах талаар олон нийтийн зүгээс гаргасан саналыг нэгтгэн үзвэл:

- Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон алхам гэж үзсэний үндсэн дээр Сайншандын хүнд үйлдвэрийн цогцолбор барих. Сайншандын цогцолбор нь олборлох салбарт түшиглэсэн манай явцуу эдийн засагт өөрчлөлт авчрах нь ойлгомжтой юм. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл, наад зах нь түүхий эдээс гурав дахин их ашиг, 400 мянга орчим ажлын байр бий болох ажээ.<sup>80</sup>

<sup>80</sup> Г.Өлзийсайхан “Түүхий эдийн бааз болгох урд хөршийн сонирхол” Өнөөдөр сонины 2009 оны

- Сайншандад босгохоор төлөвлөсөн хүнд аж үйлдвэрийн цогцолбортой Тавантолгой, Оюутолгой, Нарийн сухайтыг холбочих нь өнөөдөртөө хамгийн зөв шийдвэр. Нүүрснээс коксыг нь ялгаж авбал, нэг ёсондоо өрмийг нь засчихвал тонн нь өнөөдөр 400 шахам долларт хүрч байна. Харин түүхий шороотой нь зөөвөл 60 ам доллар байна.<sup>81</sup>
- 30 сая тонн нүүрс боловсруулах хучин чадал бүхий уурхай байгуулахаар төлөвлөж байна. 1200 ажлын байр тэнд гарна. 25 сая тонн нүүрс угааж баяжуулах үйлдвэр байгуулахад мэргэжилтэй 700 ажилчин хэрэгтэй. Мэдээж уурхайт дагаад хот байгуулалт түүнийг дагасан үйлдвэр, үйлчилгээний салбарууд бий болно. Мөн түүнчлэн Үйлдвэрээс гарах коксын хийгээр 40-50 мвт-ын цахилгаан станцыг хангах бололцоотой юм. Жилд 300 мянган тонн зэс үйлдвэрлэх зэс хайлуулах үйлдвэр, хоёр сая тонн ган, арматур, гөлмөн төмөр, төмөр замын рельс үйлдвэрлэх ган төмөрлөгийн үйлдвэр Тавантолгойн ордыг түшиглэж байгуулна. “Тавантолгой” төсөл 14 тэрбум долларын хөрөнгө оруулалтаар босож, ДНБ-ий хэмжээг 41 тэрбум долларт хүргэх тооцоотой, 76 мянган ажлын байр бий болгох Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, энэ оноос барьж эхлэх 1770 км төмөр замын төсөл,.govийн дэд бүтцийн тесэлтэй шууд холбоотой юм.

Аж үйлдвэрийн паркад кокс химийн үйлдвэр барьснаар бүтээгдэхүүний 72 хувь кокс, дөрвөн хувь нь хүхэр, зургаан хувь нь давирхай, 18 хувь нь коксын хий байх юм. Жилд 300 мянган тонн зэс үйлдвэрлэх зэс хайлуулах үйлдвэр, хоёр сая тонн ган, арматур, гөлмөн төмөр, төмөр замын рельс үйлдвэрлэх ган төмөрлөгийн үйлдвэр Тавантолгойн ордыг түшиглэж байгуулна.

4/ Стратегийн ордуудаас засгийн газар авбал зохих ашгийг авах гол арга зам бол аж ахуй нэгжийн орлогын албан татварыг ашигт малтмалын төрлөөр ялгавартай тогтоох, нөөц ашигласны /рояльтийн/ төлбөрийт өндөр тогтоох, зарим ордыг бүтээгдэхүүн хуваах, зарчмыг нь гэрээ түрээсээр /концессээр/ хөрөнгө оруулагчдад ашиглуулах.

## **2. Ордыг ашиглахад шаардагдах санхүүжилт /Гадаадын хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгө, дотоодын хөрөнгө оруулагчдын олон улсын зах дээрээс хөрөнгө татах боломжууд/**

Тавантолгойн ордыг ашиглахад шаардагдах санхүүжилтийн хувьд тухайн ордыг хэрхэн ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулахад хэдий хэмжээний санхүүжилт шаардлагатай байгааг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын зүгээс нийт 14-20 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтаар босч, ДНБ-ний хэмжээг 41 тэрбум долларт хүргэхээр дийлэнх нь дурьдсан байна. Харин үүнээс Тавантолгойн ордод эхний ээлжинд 3-5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзсэн бөгөөд шаардагдах санхүүжилтийг Олон Улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцааг гаргах замаар босгох боломжтойг дурьджээ. Энэхүү санхүүжилтэнд шаардагдах хөрөнгийг гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг Олон улсын зах дээрээс хэрхэн татах, мөн ордыг ашиглахад шаардагдах санхүүжилтийг хэрхэн босгох хувилбаруудыг хүснэгтээр гаргалаа.

272 дугаарт

<sup>81</sup> Д.Болдхуяг “Тавантолгой:Хятад руу нүүх үү, Монголд үлдэх үү” Зууны мэдээ сонины 2009 оны 279 дугаарт

Олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах болон хувьцаа борлуулах	<p>“Монгол 999” үндэсний нэгдэл Өдрийн сонины 2010.06.30-ны өдрийн 155 дугаарын 1, 6-р нүүрт: Тавантолгойн ордын хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргахад 30 сарын дараа 15-20 орчим тэрбум ам.доллар олоо бололцоо бий гэж тооцоолж байгаа юм. Мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 28 мянган аж ахуйн нэгж бүгдээрээ нэг сая төгрөг нийлүүлээд эхлэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх боломжтой. Таван толгойн ордыг хоёр хувьцаа гадаадын компанийг оператороор сонгог ажиллуулж, 10%-ийг ард иргэддээ үзүүгийн тарааж, 10%-ийг үндэсний үйлдвэрлэгчдээ худалдаа давуу эрхийг олгоно гэх байгаа. Харин Монгол 99 үндэсний нэгдлийнхэн төр буюу Засгийн газар 34, ард түмэн 33, Үндэсний үйлдвэрлэгч 33 хувийг эзэмшиж өөрсдөө олон улсын зах зээл дээрээс мөнгө босгох хувилбарыг санал болгож байна.</p>
	<p>МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар Өнөөдөр сонины 2010.07.05-ны өдрийн 155 дугаарын А4-р нүүрт: Замаа 250 тэрбум төгрөгөөр босгоно. Үүний урьдчилгаа 150 тэрбум төгрөгийг Монголын Засгийн газар эхний эзлэхийнд гаргаад Монголын автозамын 30 компанийг тендер шалгаруулалтаар шалгаруулаад арав, арван км-ээр замаа хуваарилан, мөнгөнийх нь 50-60 хувийг нь урьдчилж өгөөд үлдсэндийг нь дараа гүйцэтгэлээр тооцоход манай компаниуд 250 км замыг хоёр сарын дотор тавина. Хоёрдугаарт, 50-100 тоннын даацтай нүурс зөөх машиныг дэлхийд алдартай ямар ч компаниуд зээлээр өгнө. Үүнийг зөвхөн зохион байгуулан, менежментийг нь хийгээд Монголчуудаа ажиллуулахад коксжих үйлдвэр барихад шаардлагатай 2 тэрбум долларыг хоёр жилийн дотор олно.</p>
	<p>Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Р.Содхүү Үндэсний шуудан сонины 2010.7.06-ны өдрийн 159 дугаарын 5-р нүүрт: Үндэсний компаниудад зээмшүүлэх 10, гадаадын хөрөнгө оруулагчдад борлуулах 30 хувийн хувьцааны мөнгө орж ирнэ. Тэр цагт бид хэнээс ч гүйхгүйгээр Тавантолгойн орд дээр олборлох, боловсруулах үйлдвэр барих хөрөнгийг босгоно.</p>
	<p>УИХ-ын гишүүн О.Чулуунбат Зууны мэдээ сонины 2010.07.06-ны өдрийн 161 дугаарын 3-р нүүрт: Тавантолгой дээр хөрөнгө босгох боломж их байна. Дэлхийн том том хөрөнгө оруулалтын банкууд төслийн зээл өгчихөөр сайхан баялаг байна. Хонг хонг, Лондонгийн бирж дээр баячууд хамтарсан фондууд байна. Тэнд мөнгө элбэг болохоор хөрөнгө хурдан босно. Заавал Монголын хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалаад байх шаардлага алга. Яваандаа монголчууд мөнгөтэй, хөрөнгөтэй бирж нь дэлхийн стандартын хэмжээнд хүрэхээр хувьцаа гаргаж мөнгө босгож болно.</p>
	<p>Доктор, профессор Г.Пүрэвбаатар Зууны мэдээ сонины 2010.07.07-ны өдрийн 162 дугаарын 5-р нүүрт: Гадаадын корпорациуд их нөөцтэй ордуудын хувьцааг хөрөнгийн биржүүд дээр борлуулж, босгосон мөнгөөрөө хөрөнгө оруулж байна. Бодит байдал дээр тэд хөрөнгө оруулагч биш, жижиг хувьцаа зээмшигчдэн хувьцааг багцалж зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, өөрсдийн захиргааны зардал, өндөр цалин хангамж өртөг зардлаа шингээж, ашгаас нь хүтэж, стратегийн ордыг өмчлөгч Монголын талд ногдо ашгийг баагасгаж, хохироож байна.</p>
	<p>Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Өдрийн сонин 2010.07.14-ний өдрийн 165 дугаарын 1, 5-р нүүрт: Мөнгө босгох хоёр хэлбэр байдаг. Эхний нь банкаас зээл авах. Хүү төлөх хэрээр өртөг өндөр болдог. Төсвөөс хөрөнгө оруулж болох ч зах зээлийн зарчмаар асуудалт хандах ёстой гэж бид үзэж байгаа. Нөгөө хувилбар нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох. Бид бүх хувилбараар мөнгө босгохыг эрмэлзж байна. Иргэн, аж ахуйн нэгжийнхээ оролцоог хангах зорилгоор дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцаа борлуулах боломжтой. Гадаадын үнэт цаасны зах зээлээс хөрөнгө татахыг үгүйсгэхгүй. Хэзээ, яаж үнэ хүргэх вэ гэдэг зарчмыг гол болгоно</p>

## Судалгааны эмхтгэл, XI боть

	<p>Х.Баттөгс Өдрийн сонины 2011.02.18-ний өдрийн 48 дугаарын 15-р нүүрт “Энержи ресурс” компани 13 сая тонн нүүрснээс нүд ирмэхийн зуур 700 сая ам.доллар босгожээ. Таван толгойн нэг хувиас 700 сая ам.доллар босгосон гэсэн уг юм. Энэ жишгээр тооцвол бүтэн Таван толгойгоос олжсан 70 тэрбум ногон боловч боломжтой. Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугарын үзэж буйгаар хөрөнгө оруулагч банк хувьцааны үнийг тогтоох гэнэ. Яагаад бид өөрсдөө тогтоох болохгүй гэж. Гадныхан өөрсдөдөө ашигтай байх үнийг тогтоохыг оролдоно.</p> <p>Мэдээж анхны үнэ хувьцааны бодит ханшигийг тогтоохгүй боловч дэлхийд тэргүүлэгч 16 банкны сонирхжээ байгаа хувьцаа хямд байх учиргүй. Өнөөдөр нэг хувьцаа нь мянган ам.доллар хол давсан олон компани бий. Хэдийгээр эхний эзлжинд Таван толгойн хувьцааны үнэ авран мянга биш боловч нэг мянган ам.доллараас доош байх учиргүй. Эхний эзлжинд IPO хийх нь хөрөнгө оруулалт, цаашын үйл ажиллагааны зардлыг олох учраас өндөр байх нь ашигтай.</p> <p>Гэхдээ энэ нь хувьцааны ашиг авран мянгаас их байна гэсэн уг биш юм. Учир нь компани нэгж хувьцаанд ногдох ашигийг хувьцааны үнээр биш компанийн ашигаас нийт хувьцаанд ногдох ашигийг л хуваарилна. Өөрөөр хэлбэл авран мянган ногоноо үнэтэй нэг хувьцаанд нэг доллар ч ногдож болно. Тиймээс Таван толгойн нэг хувьцааны үнэ зуун ногоноос хамд үнэлэгдэхгүй л болов уу.</p>
Ордыг ашиглахад шаардагдах эхний санхүүжилтийг дотоодын хөрөнгө оруулагчдыг түшиглэн бий болгох	<p>Монголын хүссэн бүх компанийг нэгтгэх нэхцэлөөр хувьцааных нь 33 хувийт эзэмшигүүлбэл, нөөцийн хэмжээг тогтоох, техник-эдийн засгийн үндэслэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэнүүдээр хийлгэх, олон улсын зах зээлд гаргах хүртэл компанийн үйл ажиллагаанд гаргах зардлыг санхүүжүүлэх боломжтой болно. Энэ ажилд мэргэжилтэнүүдийн тооцоолноор 20 гаруй тэрбум төгрөг шаардлагатай. Энэ мэнгийг монголын үндэсний компаниуд гаргах чадвартай байгаа гэж үзэж байна.</p>
	<p>Доктор Ч.Хурц Зууны мэдээ сонины 2010.07.06-ны өдрийн 161 дугаарын 11-р нүүрт:</p> <p>Тавантолгойн нүүрсний орд газрын тонн нүүрс газрын дор байхдаа 7-10 ам.доллар, гараад ирэхээр 18 ам.доллар, баяжуулж борлуулахаар 40 ам.доллар болно гэж ярьж байна. Газрын доор байгаа нүүрснийхээ үнийг тонн тутмаар үржүүлэхээр авран тэрбум ам.доллар болно. Энэ бидийн оруулах хөрөнгө. Үйлдвэр барихдаа миний үндсэн хөрөнгө 10 тэрбумыг үйлдвэрийн фонд гэж тооц, тэгээд одоо хэдийн хэр хөрөнгө хэрэгтэй вэ үүнийгээ ярья гэж болно шүү дээ. Үнэлгээг тэжж хийдэг систем тогтоод байна.</p> <p>Тэр их нөөцтэй байна уу, бага нөөцтэй байна уу хамаагүй нөөц батлагдсан бол бүгдийг үнэлгүүлж, улс орныхоо эдийн засгийн үнэлгээг бүртгэж, зөв тогтоох ёстай. Тавантолгой эзэмшихэд саналаа өгсөн 15 компани байгаа шүү дээ. Зарим нь хоорондоо нийлчихсэн, зарим нь нийлэгүй байгаа. Тэр компаниудыг бид бүгдийг нь аваад, тэр засгийн хэмжээнд маш сайн боловсруулсан удирдамжийн хэмжээнд саналаа тавих ёстай юм. Та нар тус бүрдээ нэг тэрбум долларын хөрөнгө оруулалт хий, энэ хөрөнгө оруулалтыг эзэмшиж, ажиллуулах консорциумыг хамтын хүчээр байгуульяа, хамтарсан консорциумын үйл ажиллагааг хамтарч удирдья, ийм нөхцлийг оруулж ир гэх хэрэгтэй.</p>
	<p>Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч Д.Содном: Миний гол санал бол ер нь эхнээсээ тавиад байгаа гол санал бол Тавантолгой орд ашиглалтыг гадны хөрөнгө оруулагчад биш. Монголынхоо үндэсний хөрөнгө оруулагчад хариуцуулнах нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм. Яагаад монголчууд бид нар Тавантолгойнхоо ордыг өөрсдөө ашиглаж чадахгүй байна вэ. Хойд хэсэг дээр нь Энээрхи ресурс хувийн компани олборлолт хийгээд тэр байтугай баяжуулах үйлдвэр байгуулаад явж болж байна. Ингэж болж байхад заавал гадныханд ягех гээд байдаг энэ бол буруу гэж бодогдоод байна. Манайхан нүүрсний олборлолт баяжуулалтын хамгийн сайн техникийг олж ашиглах тийм чадвартай боловсон хүчинтэй болсон.</p> <p>Хэрвээ зарим онц чухал мэргэжилтэй хүн гадаадаас авах хэрэгтэй бол түүнийг уриад хөлслүүлж ажиллуулж болно. Төсөө санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрлийг бас олж болно. Одоо энэ олон банкууд чинь манайд ирээд танай энэ төсөл чинь ийм их үр ашигтай юм байна манайхаас зээл ал гээд өөрсдөө санал тавиад явж байна. Хэрэв бид зээл авч төслийн хэрэгжүүлвэл зээлээ төлсний дараа Монголын нутаг дээр үлдэнэ. Хэрэв гадаадын хөрөнгө оруулагчийг оруулах юм бол тэр бүх ашигийн чинь тодорхой хэсэг нь, тэгээд эзэлийн хэлэлцээрийн бүх хугацаанд татварын дараах ашиг гадагшаа явна.</p>

\* \* \*

**Гурав. Тавантолгой ордыг ашиглах замаар Монгол Улсын иргэдэд хувь хүртээх боломж түүний хэлбэрүүд**

Тавантолгойн ордыг ашиглах замаар Монгол Улсын иргэдэд хувь хүртээх боломж бий эсэх, энэхүү хувьцааг хүргэхдээ ямар арга замаар хүртээх тухай нарийвчилсан мэдээллийг олон нийтийн зүгээс гаргаагүй бөгөөд харин төрийн болон төрийн бус байгууллагаас Монгол Улсын нэг иргэнд хичнээн хувьцааг олгох ёстой, Тавантолгойн ордын хувьцааны хичнээн хувийг иргэдэд хүртээх талаар дараах саналуудыг гаргасан байна.

**Жич:** Энэхүү контент анализыг хийхдээ 2009 - 2011 оны 10 сарын 04-ний өдрийг хүртлэх мэдээллийг ашигласан болно.

Үндэсний үйлдвэрлэгч, татвар төлөгч 2000 орчим компани, аж ахуйн нэгжийн санаачилсан байгуулсан “Монгол 999 үндэсний нэгдэл”-ийн Тавантолгой төслийн хүрээнд хийсэн тооцоо судалгаагаар

- Монгол хүн бүрт 25.9 мянган долларын үнэ цэнэ бүхий хувьцаа ноогдоно. Үүнээс жил бүр хамгийн багадаа 7 хувийн ногдол ашиг хүртэнэ гэж үзвэл иргэн болгон жил бүр 2.4 сая төгрөг авна.
- Тавантолгой төсөл дээр Засгийн газрын зүгээс баримталж байгаа бодлого нь оператор компанийг шалгаруулна, хөрөнгө оруулагчдын гэрээг байгуулна гэж байна. Оператор компани бол ажил хийх үүрэгтэй компани болохоос хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах шаардлагагүй. Уг нь энэ төсөл дээр үндэсний компаниуд нэгдэж хувь зээмшиж чадвал үндэсний эрх ашигт хэрэгтэй болохоос цөөн хэдэн компаниудын эрх ашигийн асуудал биш юм.

Хамгийн сүүлд гэхэд Тавантолгойг ашиглах эрхтэй үндэсний компанийн хувьцааны 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан ард түмэндээ, 10 хувийг мөн биржээр монголын компаниудад худалдаад 51 хувийг нь төрийн мэдэлд авч үлдэнэ, 29 хувийг гадаадынханд олон улсын хөрөнгийн зах зээлээр дамжуулан худалдана гэсэн хувилбарыг оруулаад байна. Энэ хувилбарын сул тал нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжих үед гэсэн нэрийн дор Засгийн газартай тохиролцож 29 хувийг нь гадаад эзэд нь нэмж аваад хяналтын багцтай болно.

МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар:

- Нийт ард түмэнд Тавантолгойн хувьцааг 100 хувь өгөх ёстой. Монголын 2.7 сая ард түмэнд хүн нас барлаа, төр хувьцааг нь буцааж авна. Шинэ хүн төрөхөд тэр хувьцаанаасаа өгнө. Энэ маягаар хэдэн үеийнхэн маань Тавантолгойн эзэд болно. Харин парламент, Засгийн газар ард түмний эн өмчийн тодорхой хувь, ашгаар үйлдвэр, эмнэлэг, сургууль барихаар бол ард түмний төлөөлөл болсон парламентаар хэлэлцэж, шийддэг байх нь шударга ёсонд нийцнэ. Энэ бол үндсэндээ өмчийн эзэн болсон ард түмэн жинхэнэ хэлбэрээр эзэн нь байна гэсэн үг юм.

Тавантолгойн ордыг ашиглах замаар иргэдэд хувь хүртээх нь зөв, гэхдээ ямар байдлаар, хэдий хэмжээгээр хүртээх вэ гэдэг санал, хувилбарууд янз бүр байна. Нийтлэлүүдээс үзэхэд дээрх ерөнхий саналууд байгаа боловч зарим эрдэмтэдийн хувьд Тавантолгойн ордыг эзэмших хувьцааг ард нийтэд олгох нь буруу юм гэсэн санал ч гарсан байна. Тухайлбал:


- Доктор, профессор Г.Пүрэвбаатар: Тавантолгойн ордын хувьцааны 10 хувийг Монголын 2,8 сая иргэнд үнэ төлбөргүй эзэмшүүлж, байгалийн баялгийн орлогоосоо бүх ард түмэндээ хүртээнэ гэдэг бол эдийн засгийн бус, байж болохгүй арга юм. Ийм туршлага олон улсын практикт байдаггүй юм. Харин ногдол ашиг хуваах туршлага бий. Ингэхэд манай төр засгийн түшээд өөрсдөө иргэдийн хувьцааг цуглувуж

хөрөнгө зоорио арвижуулах далд санаагаар нийт ард түмэнд 10 хувийн хувьцаа эзэмшүүлэхийг санаачилсан ч байж мэдэх юм.

Тавантолгойн ордын хувьцааны 30 хувийг гадаад дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулж, мөнгө босгож, тэр мөнгөөр тус ордод хөрөнгө оруулна гэдэг бол стратегийн ордын хувьд байж болохгүй зүйл. Яагаад гэвэл, гадаад дотоодын хөрөнгийн бирж дээр борлуулсан 30 хувийн хувьцааны ногдол ашгийг хувьцаа худалдаж авсан этгээдүүд л авна. Засгийн газар зөвхөн зуучлалын үүрэг гүйцэтгэнэ. Таван толгойн хамтран ажиллагч гадаадынхан 30 хувийн хувьцааг худалдан авч, монголын талын эзэмших хувьцааны жин, захиран зарцуулах давуу эрхийг бууруулж мэднэ.

- Д. Батбаатар /"Иргэдийн шударга хөдөлгөөний тэргүүн" ТББ/: Эдийн засгийн тооцоогоор 30 жилээр 15 жилээр жилд 15 сая тонноор, 30 сая тонноор гэж тооцоод гаргасан байна. Та 15 сая тонноор гэж байна . 450 сая тонн нүүрс олборлох юм байна 30 жилийн хугацаанд. Үүний цэвэр ашиг нь болохоор 5 тэрбум 492 сая доллар. Тэгэхээр энийгээ бид нар өнөөдөр энэ хувьцаандаа хуваагаад үзэхээр үнэхээр нэг хүнд маань 15 тэрбум хувьцаандаа хуваахаар 1 хувьцаа маань 0,36 доллар буюу 536 хувьцаандаа хуваахаар 196 доллар болж байна 30 жилийн хугацаанд. Тэгэхээр 196 доллароо 30 жилийн хугацаандаа хувааж үзэхээр 1 хүнд сард ойролцоогоор 1,09 доллар ногдож байна. Тэгэхээр эдийн засгийн тооцо үнэхээр ийм ашиггүй юм бол заавал ингэж хувьцаа хэлбэрээр ард түмэнд тараах нь зөв юм уу буруу юм уу.

(2011 оны 10 дугаар сар 20)



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛСЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРИМ ТӨРӨЛ

*Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ*

1. Орлогын албан татвар
2. Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар
3. Цалингийн татвар
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар
5. Монгол Улс, Нидерландын Вант улс хоорондын гэрээ

\* \* \*

### **Оршил**

УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн захиалгаар “Нидерландын Вант улсын татварын зарим төрөл” сэдэвт лавлагаа-мэдээллийг хийж гүйцэтгэв. Лавлагаа-мэдээлэлд Нидерландын Вант улсын орлогын дараах төрлийн албан татваруудыг хамруулсан:

- Орлогын албан татвар,
- Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар,
- Цалингийн татвар,
- Нэмэгдсэн өртгийн албан татвар.

Албан татварын төрлүүдийг дараах дэд сэдвээр задлаж оруулсан:

- Албан татвар төлөгч,
- Албан татвар ногдох орлого,
- Албан татварын хувь хэмжээ,
- Албан татварын хөнгөлөлт,

2002 оны 3 дугаар сарын 8-нд Монгол Улс, Нидерландийн Вант Улсын Засгийн газар хооронд Орлогын албан татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийг явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенцийг байгуулсан ба уг конвенцийн тухай 5 -р хэсэгт оруулсан.

### **1. Орлогын албан татвар**

#### **1.1. Албан татвар төлөгч**

Орлогын албан татвар нь хувь хүний орлогод ногдуулах татвар бөгөөд татвар төлөгч нь Нидерландын Вант улсад байнга оршин суудаг хувь хүн (байнга оршин суугч), Нидерландын Вант улсад байнга оршин суудаггүй боловч тус улсад орлого олдог хувь хүн (түр оршин суугч) хамаарна.

Байнга оршин суугчийн орлогын эх үүсвэрээс нь үл хамааран бүх орлогод албан татвар ногдуулна. Өөрөөр хэлбэр, Нидерландын нутаг дэвсгэр болон түүний гадна олсон бүх орлогыг ойлгоно. Харин түр оршин суугчийн гагчүү Нидерландын улсын нутаг дэвсгэрт шууд холбоотой эх үүсвэрээс олсон орлогод албан татвар ногдуулна.

## 1.2. Албан татвар ногдох орлого

Тус улсын хувь хүний орлогын албан татвар 2001 оны 1 дүгээр сарын 1-ээс гурван төрөл /хайрцаг/ болж ангилагдсан байна:

- Хайрцаг 1 – Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар,
- Хайрцаг 2 – Бодит ашгийн орлогод ногдуулах албан татвар,
- Хайрцаг 3 – Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдуулах албан татвар.

### 1.2.1. Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар

Хайрцаг 1 буюу ажил болон орон байрны дараах орлогод албан татвар ногдуулна:

- Бизнес болон мэргэжлийн үйл ажиллагаанаас олсон орлого;
- Цалингийн орлого;
- Бусад үйл ажиллагаанаас олсон орлого;
- Тогтмол төлбөр болон тэтгэлэг (Засгийн газрын тусlamж, амьжирааны тэтгэмж гм.);
- Орон сууцнаас олсон орлого;
- Орлогын бүрдүүлэлт дэх зарцуулалт (тэтгэвэр, тэтгэмжийн урамшуулал, асран хамгаалагчдад олгох тэтгэмж гм.);
- Орлогын бүрдүүлэлтийн зарцуулалтыг хасах (орлогоос нь урьдчилан суутгасан тэтгэвэр, тэтгэмжийн урамшуулал гм.);
- Хувь хүний суутгалыг хасах (хувь хүнээс өмнөх жилд суутгасан төлбөрийг буцаан төлөх гм.)
- Хувийн суутгал (энэхүү суутгал нь хэсэгчлэн 3 -р Хайрцаг руу шилжиж болох ба үүнийхээ дараа 2-р Хайрцаг руу шилжих боломжтой).

### 1.2.2. Бодит ашгийн орлогод ногдуулах албан татвар

Байнга оршин суугч-татвар төлөгч нь өөрөө дангаараа, эсхүл хамтрагчтайгаа шууд, эсхүл шууд бусаар компанийн хамгийн багадаа 5 хувийн хувьцааг эзэмшдэг, компаниас бодит ашиг авдаг бол татвар төлөгчид тооцогдоно. Бодит ашгийн орлого нь зардалаа хассан ногдол ашгийн нийт дун болон худалдааны орлого юм.

Түр оршин суугчийн хувьд компани нь Нидерланд улсад сүүлийн арван жилд хамгийн багадаа 5 жил байнга оршиж байсан бол мөн тус улсын байнгын татвар төлөгчид тооцогдоно.

### 1.2.3. Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдуулах албан татвар

Энэ төрлийн орлого нь бодит орлогоос хамааралгүй гагцхүү цэвэр хөрөнгөөс хийгдсэн тохиолдолд хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогын татварын суурь болно. Цэвэр хөрөнгө нь хуанлийн жилийн (1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31) дунджаар үнэлэгдэнэ.

Хайрцаг 3 -т хамаарах албан татвар ногдох орлогын зарим жишээ:

- хадгаламж,
- хоёр дахь орон байр, эсхүл зөвшөөрөгдсөн хөрөнгө,
- хувьцаа болон бусад үнэт цаас,

- даатгалын тэтгэмж,
- хэрэглэгчийн зээл,
- Хайрцаг 1, эсвэл Хайрцаг 2-т хамааралгүй өр.

Түр оршин суугчийн зөвхөн Нидерланд улс дахь хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод татвар ногдуулна.

Хайрцаг 3-т дараах орлого хамаarahгүй:

- эзэмшигчийн эзэмшилд байгаа орон байр (Хайрцаг 1-д хамааралтай) болон орон байртай хамааралтай хандивийн даатгал,
- ахуйн хэрэглэл, хөнгөн автомашин, чиргуул зэрэг хувийн хэрэгцээний эдлэл,
- хөрөнгө оруулах зорилгогүйгээр хадгалсан урлагийн болон шинжлэх ухааны бүтээл,

### **1.3. Албан татварын хувь хэмжээ**

**Хайрцаг 1** – Ажил болон орон байрны орлогод ногдуулах албан татвар

- Ангилал 1: эхний 18,218 €-ны орлогод 33.45 хувийн татвар (33.45 хувийн татвар нь 2.3 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 2: дараагийн 14,520 € -ний орлогод 41.95 хувийн татвар (41.95 хувийн татвар нь 10.8 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 3: дараагийн 21,629 €-ний орлогод 42 хувийн татвар.
- Ангилал 4: үлдэгдэл орлогод 52 хувийн татвар.

Эхний 2 ангилалд орлогын хэмжээ бага, мөн түүнчлэн 65 болон түүнээс дээш насыханд хамаарна.

**Хайрцаг 2** – Бодит ашгийн орлогод ногдох албан татварын хувь хэмжээ тогтмол 25 хувь байна.

**Хайрцаг 3** – Хадгаламж болон хөрөнгө оруулалтаас олсон орлогод ногдох албан татварын хувь хэмжээ тогтмол 30 хувь байна.

### **1.3. Албан татварын хөнгөлөлт**

Зөвхөн голландын нийгмийн хамгаалалд орсон ажилтан нь татварын хөнгөлөлтийг авах эрхтэй. Мөн түүнчлэн татвар төлөгчийн орлогын хэмжээ болон хувийн нөхцөл байдлыг харгалзан бусад нэмэлт хөнгөлөлтийг үзүүлнэ.

Байнгын оршин суугчийн татварын хэмжээ урамшууллалын дүнгээр багасна. Ерөнхий урамшуулалыг бүх байнгын оршин суугч татвар төлөгчдөд хамааралтай бөгөөд татварын элемент ба нийгмийн хамгаалалтын хандивийн элементийг бүрдүүлнэ.

Хайрцаг 3 -т татвар төлөгч 20,014 €-д татвараас чөлөөлөгдөх эрхтэй. Татвараас чөлөөлөгдөх энэ хэмжээ нь татвар төлөгчийн 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар асран хамгаалж буй 18 нас хүртэлх хүүхэд бүрд 2,674 €-гоор нэмэгдэнэ. Иргэдийн орлого, баялагаас хамаарч 65 ба түүнээс дээш насын татвар төлөгчийн татвараас чөлөөлөгдөх хэмжээг дээд тал нь 26,494 € хүртэл нэмэх эрхтэй.

### **1.4. Орлогын албан татварын буцаан олголт**

Тухайн санхүүгийн жилийн татварын тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний

дотор Татварын Удирдах газарт мэдүүлсэн байх ёстой. Хэрэв Татварын Удирдах газар заасан хугацаанд тайланг хүлээж аваагүй бол холбогдох байгууллагад сануулга өгөх, эсхүл торгууль ногдуулах хүртэл арга хэмжээ авна. Татварын Удирдах газарт тайланг хойшилуулах тухай бичгээр хандаж болно. 4 дүгээр сарын 1-ний дотор татвар буцаан авахаар бүртгүүлсэн хүн бүр 7 дугаар сарын 1-ний дотор Татварын албанаас мэдэгдэл хүлээн авна.

## **2. Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар**

### **2.1. Албан татвар төлөгч**

Аж ахуй нэгж байгууллагын албан татварын тухай хуульд зааснаар компанийг төрийн хязгаарлагдмал (NV<sup>82</sup>) ба хувийн хязгаарлагдмал (BV<sup>83</sup>) гэж ангилна. Нидерландын нутаг дэвсгэрт байгуулагдсан компани нь байнгын татвар төлөгч байна. Нидерландын нутаг дэвсгэрт байгуулагдаагүй боловч тус улсын нутаг дэвсгэр дээр ашиг орлого олдог тодорхой компаниуд нь байнгын бус татвар төлөгч байна.

### **2.3. Албан татварын хувь хэмжээ**

Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын хувь хэмжээ татвар ногдох орлогын эхний 200,000 €-нд 20 хувь, 200,000 € -ноос дээш орлогод 25.5 хувийн татвар тус тус ногдуулна. 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн патент ашиглан олсон орлогод 5 хүртэлх хувийн татвар ногдуулна.

### **2.4. Албан татварын хөнгөлөлт**

Дотоодын болон гадаадын хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид татвараас чөлөөлөгднө. Хэрэв татвар төлөгч нь бүхлээрээ, эсхүл хэсэгчлэн хувьцаа болж тараагдаж номинал болон төлөгдсэн компанийн хөрөнгийн 5-аас багагүй хувийг эзэмшдэг бол үйл ажиллагааг нь харж үзнэ. Хэрэв охин компани нь захирагдах шаардлагыг дагах бол түүний пассивын 5 ба түүнээс дээш хувийн ашиг нь үйл ажиллагааг нь харна. Хэрэв татвар төлөгч, эсхүл түүний охин компани нь хөрөнгө оруулагч хуулийн этгээд бол татвараас чөлөөлөгдхүгүй. 5-аас илүүгүй хувийн ашигийг татвараас чөлөөлөх боломжгүй.

### **2.5. Албан татварын буцаан олголт**

Төрийн (NV) ба хувийн (BV) хязгаарлагдмал хариуцлагатай компани нь санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор Татварын Удирдах газарт жилийн татварын тайланг электрон хэлбэрээр мэдүүлэх ёстой. Хэрэв буцаан олголт олгогдоогүй бол байцаач урьдчилсан үнэлгээг гаргана. Эцсийн үнэлгээг тухайн санхүүгийн жилээс хойш 3 жилийн дотор гаргасан байх ёстой.

## **3. Цалингийн татвар**

Нидерланд улсад ажил хийж цалин авдаг хүн бүр цалингийн татвар төлнө. Цалин олгож

<sup>82</sup> Naamloze vennootschap (N.V., эсвэл NV гэж товчилно) – төрийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн голланд нэр томъёо. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байдаг, харин компаний хувьцаа нь тодорхой эзэмшигчийн нэр дээр бүртгэлгүй учир нээлттэй хөрөнгийн зах зээлд борлогдох боломжтой.

<sup>83</sup> Besloten Vennootschap (BV гэж товчилно) – хувийн хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн голланд нэр томъёо. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байдаг, харин компаний хувьцаа нь бүртгэгдсэн бөгөөд чөлөөтэй борлогдох боломжгүй.

буй ажил олгогч, эсхүл хуулийн этгээд нь цалингийн орлогын татвар төлөлтийг хойшлууж, Татварын Удирдах газарт тодорхой цаг хугацааны дараа төлж болно. Цалингийн татвар нь цалингийн орлогын татвар болон нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ. Нийгмийн хамгааллын хураамж нь өндөр настны тэтгэвэр (AOW), нас барагчийн ар гэрийхэнд нь олгох тэтгэмж (ANW) болон онцгой эмнэлгийн зардал (AWBZ) зэрэгт төлөгдөнө. Нидерланд улсад ажиллагсад нь нийгмийн хамгаалалд хамрагддаг учир нийгмийн хамгааллын хураамжийг төлөх үүрэгтэй.

### **3.1. Албан татвар төлөгч**

Ажилагсад цалингийн татвар болон нийгмийн хамгааллын хураамжийг өөрийн ашиг орлогоос төлөх ёстой. Мэргэжлийн жүжигчид болон тамирчид ажил хийж байгаа, эсхүл хийгээгүйгээс үл хамааран цалингийн татварыг заавал төлөх ёстой. Ажил олгогч болон ажилтан хоёр хоёулаа Татварын Удирдах газарт мэдүүлгээ өгөх үүрэгтэй.

### **3.2. Албан татварын хувь хэмжээ**

65 ба түүнээс дээш насны этгээдэд тусдаа буюу 1-р Ангилалын хувь хэмжээг ногдуулна. Энэхүү тусгайлсан хувь хэмжээ нь татвар төлөгч нь өндөр настны тэтгэврийг (AOW) заавал төлөх шаардлагагүй. Гэхдээ тэд Онцгой эмнэлгийн зардлын ерөнхий хууль (AWBZ) болон Тэтгэврийн тухай хууль (ANW)-д заасан 42 хувь болон 52 хувийн хураамжийг тус тус төлнө.

- Ангилал 1: эхний 18,218 €-ны орлогод 33.45 хувийн татвар (2.3 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 2: дараагийн 14,520 €-ний орлогод 41.95 хувийн татвар (10.8 хувийн татвар ба 31.15 нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ).
- Ангилал 3: дараагийн 21,629 €-ний орлогод 42 хувийн татвар.
- Ангилал 4: үлдэгдэл орлогод 52 хувийн татвар.

### **3.3. Татварын хөнгөлөлт**

Хөнгөлөлтөнд ерөнхий хөнгөлөлт, хөдөлмөр эрхлэлтийн хөнгөлөлтөөс бүрдэнэ. Ерөнхий хөнгөлөлт нь бүх ажилагсадад хамаарах бөгөөд татвар болон нийгмийн хамгааллын хураамжаас бүрдэнэ. Зөвхөн голландын нийгмийн хамгаалалд зайлшгүй орсон ажилтан нь ерөнхий хөнгөлөлтийг авах эрхтэй. Ажил олгогч нь ажилтны хувийн нөхцөл байдалтай холбоотой ямар ч хөнгөлөлт, чөлөөлтийг авахгүй.

### **3.4. Албан татварын буцаан олголт**

Татвар төлөгч нь татвар буцаан авах мэдүүлгийг Татварын Удирдах газарт өгөх ёстой. Татварын буцаан олголт бол цалингийн татварын, нийгмийн хамгааллын хураамж болон Эрүүлийн хамгаалахын тухай хуульд заасан даатгалын урамшуулалт зэргийг багтаасан хосолсон татварын буцаан олголт юм.

## **4. Нэмэгдсэн өртгийн албан татвар**

### **4.1. Албан татвар төлөгч**

Бизнес эрхлэгч хувь хүн болон хуулийн этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна. Олон нийтийн бус салбарт үйл ажиллагаа яввуулдаг төрийн байгууллагад мөн НӨАТ-ыг ногдуулна.

#### **4.2. Албан татвар ногдох орлого**

Нидерландын Вант улсад Европын нэмэгдсэн өргтийн албан татварын тухай 6 дугаар удирдамж /6th European VAT Directive/-д заасны дагуу үйлдвэрлэлийн шат дамжилга бүрт, бараа таваар хуваарилалт болон үйлчилгээнд НӨАТ-ыг ногдуулна.

Дараах үйл ажиллагаанууд нь НӨАТ ногдох орлого болно:

- Компаниар бараа нийлүүлэх,
- Компаниар үйлчилгээ хийлгэх,
- Компаниар Европын холбооны бусад гишүүн улсаас бараа олж авах,
- Барааны импорт,
- Хувь хүнээр Европын холбооны бусад гишүүн улсаас шинэ болон шинэвтэр тээврийн хэрэгсэл (автомашин, усан онгоц, нисэх онгоц) олж авах.

#### **4.3. Албан татварын хувь хэмжээ**

НӨАТ-ын ерөнхий хувь хэмжээ нь 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно. Бууруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кинотеатр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тогтоомын парк, амьтаны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

#### **4.4. Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**

Дараах бараа, үйлчилгээнд 0 хувийн татвар ногдуулна:

- Европын холбооны улсуудаас оруулж ирсэн бараанууд,
- Олон улс хооронд хэрэглэх усан онгоц болон нисэх онгоц,
- Төв банкны алт.

Түүнчлэн Европын холбооны бусад гишүүн орон руу бараа тээвэрлэхэд НӨАТ ногдуулахгүй. Зарим төрлийн хэлцэл НӨАТ-аас чөлөөлөгднө. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгө зарим шилжүүлэлт, түрээс,
- Эмнэлгийн үйлчилгээ,
- Боловсролын байгууллагын үйлчилгээ,
- Нийгэм-соёлын үйлчилгээ,
- Ихэнхи банкны үйлчилгээ,
- Даатгалын хэлцэл,
- Олон нийтийн мэдээллийн байгууллагын арилжааны бус үйл ажиллагаа,
- Зарим шуудангийн үйлчилгээ,
- Оршуулга болон чандарлах,
- Спортын байгууллагын өөрийн гишүүдэд зориулагдсан үйлчилгээ (тогтолтын тасалбарт хамаарахгүй),
- Хөгжмийн зохиолч, зохиолч, сэтгүүлчдийн үзүүлж байдаг үйлчилгээ,

- Гэрийн арчилгааны үйлчилгээ.

#### **4.4. Албан татварын буцаан олголт**

Татвар төлөгч НӨАТ-ын мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгнө. Татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтоо сар бүр, улирал бүр, жил бүр авах эсэхээ өөрөө тогтоох боломжтой. Татварын удирдах газар мэдүүлгийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор буцаан олголтыг шалгаж шийдвэрлэнэ. Татвар төлөгч нь мэдүүлгийн маягтыг хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна.

#### **5. Монгол Улс, Нидерландын Вант улс хоорондын конвенц**

Нидерландын Вант улс нь орлогын татварыг давхардуулан ногдуулахгүй байх гэрээг дэлхийн олон улс оронтой байгуулсан. 2007 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар тус улс дэлхийн 77 улстай гэрээ, конвенц байгуулсан байна. Үүнд, Монгол Улс багтаж байгаа бөгөөд орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх зорилготойгоор Монгол Улсын Засгийн газар ба Нидерландын Вант улсын Засгийн газрын хооронд хэлэлцэн тохиролцож уг конвенцийг 2002 оны 3 дугаар сарын 8-ны байгуулсан.

Энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч хоёр улсын нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдэд хамаарна. Конвенцид дараах төрлийн орлогын татваруудыг давхардуулахгүй байхаар заасан байна. Үүнд: Монголын хувьд – хүн амын орлогын албан татвар, аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар, Нидерландын хувьд – орлогын татвар, цалингийн татвар, компанийн татвар, ногдол ашгийн татвар орсон байна.


Конвенцийн бүтцийг авч үзвэл 5 бүлэг, 33 зүйлтэй. Монгол Улс, Нидерландын Вант улсын хоорондын Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенцид гарын үсэг зурах үед 16 заалттай Протоколд мөн гарын үсэг зурсан бөгөөд уг Протокол нь Конвенцийн салшгүй хэсэг болсон.

Уг конвенцийн заалтыг ашиглан гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Нидерланд улсад толгой компанияа бүртгүүлэн, тус улсаар дамжуулан Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, улмаар татвараас зайлсхийх явдал гарах болсон. Иймд Монгол Улсын Сангийн яам Нидерландын Вант улстай байгуулсан давхар татварын гэрээнд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа аж. Яамны зүгээс гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг негеө тал буюу Нидерландын Вант улсад тавьсан бөгөөд хэрэв өөрчлөлт оруулах саналыг хүлээн авахгүй бол гэрээний эрхийнхээ дагуу Монгол Улс дангаар цуцлах болно гэдгээ мэдэгдсэн тухай холбогдох албаныхан мэдэгдэж байна.

\* \* \*

#### **Ашигласан материалын жагсаалт**

- <http://english.minfin.nl/Subjects/Taxation>
- Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай Монгол Улсын Олон улсын хэлэлцээрүүд. Боть 2. Эмхтгэсэн Я.Пүрвээ. УБ хот., 2011 он.



**MINFIN  
СУДАЛГААНЫ САН**

## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АЛТЕРНАТИВ ХЭЛБЭРҮҮД ТЭДГЭЭРИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

*Ц. Нороөвондоог (Ph.D) , Ж. Элбэгзаяа, Б. Болортуюяа*

### **Агуулга**

1. Оршил
2. Мөнгөний бодлогын хэлбэрүүд ба арга хэрэгсэлүүд, тэдгээрийн онцлог
3. Мөнганий бодлогын зарим аргууд, тэдгээрийн давуу ба сул талууд
  - a. Инфляцийг онилсон бодлого
  - b. Валютын ханшид чиглэсэн бодлого
  - c. “Зүгээр л хий” стратеги
  - d. Мөнгөний агрегатад чиглэсэн бодлого
4. Дүгнэлт
5. Ном зүй

\* \* \*

### **Оршил**

Аливаа улс орон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ өөрийн орны онцлог, эдийн засаг нийгмийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил, мөн тухайн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ шаардагдах урьдчилсан нөхцөл хэрхэн бүрдсэн зэргийг харгалзан мөнгөний бодлогын оновчтой арга хэлбэрийг сонгон авч хэрэгжүүлдэг байна.

Дэлхийн бусад орнуудад үр дүнтэй хэрэгжиж буй мөнгөний бодлогын арга хэлбэрүүд нь тодорхой эдийн засгийн угтвар нөхцөл бүрдсэн байхыг шаарддаг. Мөнгөний бодлогоор тухайн орны эдийн засгийн өсөлт, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд Төв банкнаас мөнгөний нийлүүлэлтэнд хяналт тавих, хүртээмжтэй байлгах, мөнгөний үнэ цэнэ, хүүг зохицуулах шаардлагатай. Мөнгөний бодлогын гол зорилго нь зээлийн хүү ба мөнгөний нийт нийлүүлэлтийн харилцан шүтэлцэнд тулгуурлан үнийн түвшинг харьцангуй тогтвортой байлгах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. Ийнхүү мөнгөний бодлогоор эдийн засгийн өсөлт, инфляци, валютын ханш, ажилгүйдлийн харилцан уялдааг хангаж, үр дүнг хянахын тулд төрөл бүрийн арга хэлбэрийг ашигладаг.

### **Мөнгөний бодлогын хэрэгсэлүүд**

1. Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа Төв банк нь үнэт цаас, компанийн бонд, гадаад валют зэрэг олон төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг худалдан авах буюу зарах аргаар эргэлтэнд буй мөнгөний хэмжээг зохицуулах үйл ажиллагаа юм. Ийнхүү үнэт цаасаар дамжуулан мөнгөний эрэлт нийлүүлэлтийг уян хатан зохицуулах замаар Төв банк банкуудын зээлийн эх үүсвэрт нөлөө үзүүлээд зогсохгүй эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг давхар зохицуулж байдаг. Мөнгөний удирдлагын энэхүү хэрэгсэл нь хэрэглэхэд хялбар бөгөөд үр дүн нь богино хугацаанд илэрдэг давуу талтай. Өнөөдөр энэ аргыг дэлхийн бараг бүх орны Төв банкууд мөнгөний удирдлагын хамгийн чухал хэрэгсэл болгон өргөнөөр ашиглаж байна.
2. Заавал байлгах нөөц Төв банк арилжааны банкинд заавал байлгах нөөцийн доод хэмжээг тогтоон өгч, гүйцэтгэлийг хянах замаар мөнгөний нийлүүлэлт, нөөц

мөнгийг зохицуулах арга хэмжээ авч байдаг. Заавал бэлэн байх нөөц хөрөнгө нь банкны төлбөрийн чадварыг тогтвортой байлгах, зээл олгох, төлбөр гүйцэтгэх чадварыг хэвийн хэмжээнд байлгахад чухал үүрэгтэй.

3. Хүүгийн нэгдсэн бодлого явуулах Төв банкнаас явуулдаг хүүгийн нэгдсэн бодлого нь мөнгөний бодлогын чухал хэрэгсэл бөгөөд хэрэгжүүлэх механизм нь энгийн, эдийн засгийн чухал хэрэгсэлд тооцогддог тул өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнууд энэ аргыг өргөн хэрэглэж байна.

Төв банк бодлогын хүүгээр дамжуулан зээлийн хүүгийн хувь хэмжээг өөрчлөх замаар зах зээл дэх зээлийн эрэлт нийлүүлэлтэд нөлөөлж банкуудын нийт мөнгөний хэмжээг хянаж нийлүүлэлтийг зохицуулдаг. Ийнхүү Төвбанк бодлогын хүүгээ нэмэх эсвэл бууруулах нь мөнгөний бодлогоо чангатгаж эсвэл супруулж байгааг харуулна. Гэвч практик дээр эдийн засаг нь тогтвржоогүй хөгжиж буй орнуудад хүүгийн чангатгах бодлого явуулах нь тэр бүр үр дүнд хурдэгүй байна. Иймээс зах зээл дээрх зээлийн эрэлт, нийлүүлэлт мөнгөний зах зээлийн чиг хандлагыг сайн судалж анализ хийсний үндсэн дээр бодлогын хүүг өөрчлөх арга хэмжээ авах хэрэгтэй байдаг. Тухайлбал:

**Хөгжиж буй орнуудын хувьд оновчтой,** үр дүнтэй мөнгөний бодлогыг сонгож хэрэгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Ихэнхи хөгжиж буй орнуудын Төв банкны мөнгөний бодлого шүүмжлэлд өртөж байгаа нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь засгийн газраас хараат бус байж чадахгүй, улс төрийн сонирхлоор мөнгөний бодлогыг гажуудуулах зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй.

Сүүлийн үед ардчилалыг хөгжүүлэх, санхүүгийн зах зээлийг шинэчлэх бодлогын хүрээнд Төв банкууд нь банк санхүүгийн институтыг дахин капиталжуулах зэрэг тодорхой үе шаттай мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Төв банк бодлогын хүүндээ өөрчлөлт оруулахад 6-12 сарын дараа үр дүн нь гарах буюу инфляцид нөлөөдөг гэж үздэг. Тиймээс Төв банк бодлогын хүүндээ өөрчлөлт оруулах шийдвэр гаргахдаа 6-12 сарын дараах нөхцөл байдлыг урьдчилан харах шаардлагатай болно. Монгол улсын хувьд ийм хугацааны дараа инфляци ямар байх вэ гэдгийг тооцоолоход бэрхшээлтэй юм. Учир нь инфляцийн түвшин байнгын савлагаатай байдаг бөгөөд объектив, субъектив зэрэг хүчин зүйлсээс хамаардаг.

Дэлхийн бусад орнууд мөнгөний бодлогын үндсэн 6 төрлийн арга хэлбэрүүдийг ашиглаж байна. Эдгээрт:

1. Инфляцийг онилсон бодлого- дунд хугацааны инфляцийн түвшинг зарлаж Төв банк үйл ажиллагаагаа түүнд чиглүүлэх бодлогын хувилбар
2. Мөнгөний агрегатуудын өсөлтийг зорилт болгосон
3. Үнийн түвшинд чиглэсэн мөнгөний бодлого
4. Валютын ханшийг тогтвржуулахад чиглэсэн мөнгөний бодлого
5. Алтан стандарт
6. Холимог бодлого<sup>84</sup> зэрэг болно.

Дээрх мөнгөний бодлогын хэлбэрүүд болон бодлогын арга хэрэгслүүдийн зорилго нь адил боловч үйл ажиллагааны болон завсрын зорилтууд нь ялгаатай байдаг. Жишээ нь: эдийн засаг дахь мөнгөний эрэлт өсч хүүний түвшин нэмэгдсэн үед инфляцийг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч Төв банк хүүг зорилтот түвшинд барих зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн ажилладаг бол мөнгөний агрегатыг зорилт болгож

<sup>84</sup> [http://en.wikipedia.org/wiki/Monetary\\_policy](http://en.wikipedia.org/wiki/Monetary_policy)

Судалгааны эмхтгэл, XI боть

буй Төв банк мөнгөний нийлүүлэлтийг өөрчлөлгүй тэнцвэрийг хүүгийн өсөлтөөр хангаж байдаг байна.

АНУ-ын нэрт эдийн засагч, Колумбийн бизнесийн их сургуулийн профессор, мөнгөний бодлого судлаач Фредрих Мишкины ангилснаар мөнгөний бодлогын дараахь 4 хэлбэр буюу стратеги байдаг гэж үздэг. Үүнд:

1. Мөнгөний агрегатад чиглэсэн бодлого
2. Валютын ханшид чиглэсэн бодлого
3. Инфляцийг онилох бодлого
4. “Зүгээр л хий” стратеги

Монгол банкнаас зарласан эрдэм шинжилгээний илтгэл шалгаруулах уралдааны зорилгод нийцүүлэн дээрхи мөнгөний бодлогын стратегиудыг харицуулан судалж давуу болон сул талуудыг тоймлон доорх хүснэгтэд харууллаа.

#### **Хүснэгт 1. Мөнгөний бодлогын хэлбэрүүдийн харьцуулсан хүснэгт**

д/д	Мөнгөний бодлогын хэлбэрүүд	Давуу тал	Сул тал
1	Инфляцийг онилсон мөнгөний бодлого	<ul style="list-style-type: none"> <li>- Олон нийтэд хялбар ойлгогддог, ил тод байдаг.</li> <li>- Инфляцийг бага түвшинд тогтвортой барьж, ирээдүйн тодорхой бус байдлыг бууруулдаг.</li> <li>- Төв банкны бие даасан байдлыг урамшуулж, нээлттэй, ил тод болгодог.</li> <li>- Бодлогын ил тод байдал Төвбанкны хариуцлагыг нэмэгдүүлдэг.</li> <li>- Бодлогын уян хатан байдлыг дэмждэг.</li> <li>- Өртөг бага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн өсөлтийг хязгаарладаг.</li> <li>- Ханшийн тогтвортгүй байдлыг ихэсгэж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд муугаар нөлөөлдөг.</li> <li>- инфляцид чиглэсэн мөнгөний бодлогын тодорхой бус үр дүн нь Төв банкыг инфляцийг хялбар удирдах боломжгүй болгодог.</li> <li>- Бодлого боловсруулагчид инфляцийн зорилтыг хэрэгжүүлэхэд валютын ханш ба мөнгөний агрегатед чиглэсэн бодлогоос илүү хэцүү байдаг</li> <li>- Цаашид инфляцид чиглэсэн мөнгөний бодлогын үр дүн нь маш урт хугацаанд гардаг тул аж үйлдвэржсэн орнуудад ихэвчлэн хоёр болон түүнээс дээш жилээр тооцдог.</li> <li>- Инфляцийн зорилтот түвшин хүрснийг үнэлэхэд тодорхой хугацаа шаарддаг.</li> </ul>
2	Валютын ханшийг зорилт болгосон		Валютын ханшийг илүү хатуу барьсан орнуудын инфляцийн түвшин бага байдаг ч эдийн засгийн өсөлт нь ханшийн уян хатан бодлоготой орнуудаас доогуур байдаг байна.

3	Мөнгөний агрегатыг зорилт болгосон	Мөнгөний агрегатыг зорилтоо болгож буй мөнгөний бодлого нь мөнгөний нийлүүлэлтийг өөрчлөлгүй тэнцвэрийг хүүгийн өсөлтөөр хангаж байдаг байна. Иймээс ханшийг завсрын зорилт болгон гадаад валютын зах дээр интервенци хийх замаар валютын эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлж ханшийг өөрчлөх болон валютын ханшийн хэлбэлзлийг бууруулах замаар валютын ханшийг зорилтот түвшинд барьдаг.	Төв банкууд нь хараат бус бие даасан байдлаа алдах, долларжилт эрс нэмэгдэх, ханшийг тогтвортой байлгах зардал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай.
4	Эцсийн зорилго албан ёсоор зарладаггүй мөнгөний бодлого ("Зүгээр л хий" стратеги)	Ямар нэгэн зорилго, зорилтыг онцлогчийг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайкруулахад чиглэгдэх бөгөөд гол давуу тал нь үрдүүчилж харсан мөнгөний бодлого хэрэгжүүлдэг тул цаг хугацааны нийцгүй байдал үүсдэггүй байна.	Өнөөдөр явуулсан мөнгөний бодлого 2 жилийн дараа инфляцид нөлөөлөх бөгөөд 2 жилийн дараа инфляци еснө гэж таамаглаж буй тохиолдолд албан ёсоор зорилго зарлалгүйгээр мөнгөний нийлүүлэлтийг хумиж эхэлдэг. Сул тал нь албан ёсоор зорилго зарладаггүй, ил тод байддаггүй.

\* \* \*

### Инфляцийг онилох мөнгөний бодлого:

Инфляцийг онилох мөнгөний бодлогын зорилт нь инфляцийг тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгддэг бөгөөд үнийн ерөнхий түвшинг тогтвортой байлгахыг зорино гэсэн уг юм. Инфляцийг онилох бодлогын гол хэрэгсэл нь хүүний түвшин бөгөөд Төв банк бодлогын хүүгээ өөрчлөх замаар захын болон арилжааны банкуудын хүүнд, улмаар нийт эрэлт болон инфляцид нөлөөлдөг. Гэвч буурай хөгжилтэй оронд хүүгийн суваг сул байх тул бусад хүү болон инфляцид үзүүлэх бодлогын хүүний нөлөөлөл бага байдаг байна.

Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох бодлого буюу инфляцийг тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгдсэн бодлого явуулж ирсэн. Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэх нь инфляцийг бага түвшинд тогтвортой барьж, улмаар ирээдүйн тодорхой бус байдлыг бууруулж өгдөг давуу талтай хэдий ч, хэтэрхий их болгоомжлолоос болж эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, валютын ханшийг уян хатан нөхцөлд байлгахыг шаарддаг учраас ханшийн тогтвортой байдлыг ихэсгэж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Инфляцийг онилогч Төв банкууд нь зөвхөн инфляцийн хэмжээнд анхаарах бус бодит эдийн засгийн өсөлт, тогтвортой байдалд мөн анхаарах ёстой байдаг ч манайд инфляцийн түвшинг түлхүү анхаарсаар байна. Мөнгөний бодлогын хэрэгсэлүүд нь тодорхой хугацаанд хоцрогдолтойгоор нөлөөлдөг.

### Инфляцийг онилох бодлогын гол шинжүүд нь:

1. Зорилтот инфляцийн хэмжээгээ зарладаг бөгөөд энэ нь тодорхой хэлбэлзэлтэй байж болно.
2. Ямар арга хэрэглэх талаар тогтсон дүрэм байдаггүй.
3. Валютын хөвөгч ханшийн системтэй байдаг /зарим оронд өөр байдаг./

Судалгааны эмхтгэл, XI боть

4. Ил тод байдал буюу үйл ажиллагаагаа тайлагнах явдал маш сайн хөгжсөн байдаг.

Мөн инфляцийг онилсон бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн нөхцөл бурдсэн байхыг шаарддаг байна.

#### **Инфляцийг онилох мөнгөний бодлогын утгвар нөхцлүүд:**

- Хараат бус байдал
- Эдийн засгийн бүтэц
- Эрүүл санхүүгийн салбар
- Θндөр хөгжсөн техникийн дэд бүтэц

Инфляцийг онилох мөнгөний бодлогын хамгийн гол урьдчилсан нөхцөл нь Төв банк улс төрийн ямар нэг дарамтгүйгээр мөнгөний бодлого явуулах арга хэрэгсэлээ бие даан сонгох чадвартай байх явдал юм.

Инфляцийг онилох мөнгөний бодлого нь мөнгөний бодлогыг дотоод эдийн засгийн шокод хариу үйлдэл хийх болон дотоодын эдийн засгийн төлөв байдлыг хянахад чиглүүлэх боломж олгодгоороо валютын ханшийг зорилт болгосон мөнгөний бодлогоос ялгаатай бол мөнгө болон инфляцийн хооронд тогтвортой хамаарал байх эсэхээс үл хамаардагаараа мөнгөний агрегатыг зорилт болгосон бодлогоос ялгаатай байдаг байна.<sup>85</sup> Төв банк нь дунд хугацаанд инфляцийг барих түвшингээ тодорхойлох бөгөөд завсрын зорилтугуйгээр бодлогын хэрэгслүүдээр зохицуулах замаар зорилгодоо хүрдэг. Энэхүү бодлого нь 5 үндсэн элементтэй:

- 1) Инфляцийн дунд хугацааны тоон утгыг олон нийтэд зарлах;
- 2) Мөнгөний бодлогын гол зорилго болгож инсититуудад итгэл үзүүлснээр үнийг тогтвorumжуулах, бусад зорилгуудыг түүнд нийцүүлэх;
- 3) Олон төрлийн стратегийн талаарх тодорхой мэдээллийг гаргах ба зөвхөн мөнгөний агрегат бус валютын ханш зэргийг бодлого тодорхойлох арга хэрэгсэлээ болгоно;
- 4) Мөнгөний бодлого хэрэгжүүлэгчдийн төлөвлөгөө, зорилго, шийдвэрийг олон нийтэд танилцуулснаар мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх
- 5) Төв банкны тавьсан инфляцийн зорилтонд хүрэхээр санхүүгийн тооцоог сайжруулах. Эдгээр нь инфляцид чиглэсэн бодлогын нэг чухал санааг тодруулж байна.<sup>86</sup>

Энэ нь дараа жилийн инфляцийн түвшин ямар байхыг тоон үзүүлэлтээр олон нийтэд зарлана гэсэн үг. Инфляцид чиглэсэн бодлого нь олон нийтэд хялбар ойлгогддог, ил тод байдаг нь түүний хамгийн том давуу тал юм. Яагаад гэвэл инфляцийн нэрлэсэн зорилт нь төв банкны санхүүгийн тооцоотой байдлыг нэмэгдүүлж, цаг хугацааны зангад орох магадлалыг бууруулдаг.

Инфляцид чиглэсэн бодлогын хүлээгдэж буй үр дүнг гаргахын хувьд төв банкны үндсэн зорилго болох хүчирхэг институцийн бүтцээр үнийн тогтвортой байдлыг бий болгох юм. Аж үйлдвэржсэн болон хөгжик буй эдийн засагтай орнуудын аль алиний туршлагаас харахад төв банкны инфляцид чиглэсэн бодлого нь засгийн газартай хамтын холбоотой ажиллаж, тэдгээрийн албан тушаалтуудад мөнгөний бодлогын талаар олон нийтэд мэдээлэл хийх боломж бүрийг олгодог.

<sup>85</sup> Д.Баярмаа. Монгол Улсад инфляцийг онилох бодлого хэрэгжүүлэх нөхцөл боломж. 2008 он  
86 Monetary Policy. Frederic S. Mishkin. <http://www.nber.org/reporter/winter02/mishkin.html>

Инфляцид чиглэсэн бодлогын бас нэг сонирхолтой онцлог байдал нь инфляцид чиглэсэн бодлогын ил тод байдал нь төв банкны санхүүгийн тооцоог олон нийтэд ойлгомжтой, нээлттэй болгодог. Мөнгөний бодлого явуулсны тогтвортой бодлого нь урьдчилан зарласан, сайн тодорхойлсон инфляцийн түвшингийн эсрэг ажиллахаар төлөвлөж буй нь хуулийн хүрээнд үйл ажиллагаанд нь хийх үнэлгээ, шийтгэлээс ч зайлсхий боломж олгож, бие даасан төв банкинд олон нийтийн дэмжлэг үзүүлэх нэг хэрэгсэл болдог байна.

#### **Валютын ханшид чиглэсэн бодлого:**

Валютын ханшинд чиглэсэн бодлого нь үйлдвэржсэн болон хөгжих буй зах зээлтэй орнуудад өргөн хэрэглэгддэг ба инфляцийг түргэн хугацаанд үр дүнтэй бууруулдаараа онцлогтой. Хэдийгээр тийм ч валютын ханшид чиглэсэн бодлого нь бие даасан мөнгөний бодлогыг алдагдуулдаг. Валютын ханшинд чиглэсэн бодлого нь хоёр үндсэн төрөлтэй, “зөөлөн ханшийн бодлого,” ба “хатуу ханшийн бодлого”

Төв банкны ханшийн бодлого нь инфляцийн зорилгод захирагдсан байх ёстай. Ханшинд нөлөөлөхөд чиглэгдсэн интервенц болон бодлогын хүүний өөрчлөлт нь зөвхөн түр хугацааны шокын нөлөөллийг зөөлрүүлэхэд чиглэгдэх байх ёстай. Монголбанк банк хоорондын захын хүүг үйл ажиллагааны зорилт болгосон ч хөгжингүй Төв банк шиг инфляцийг дан ганц хүүний сувгаар дамжуулан барих оролдлого хийвэл үр дүнгүй болдог.

Иймээс ханшийг завсрлын зорилт болгон гадаад валютын зах дээр интервенци хийх замаар валютын эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлж ханшийг өөрчлөх болон валютын ханшийн хэлбэлзлийг бууруулах замаар валютын ханшийг зорилтот түвшинд барьдаг. Энэхүү бодлогын хэлбэрийг сонгон ажиллаж буй орнуудын туршлагаас хараад валютын ханшийг илүү хатуу барьсан орнуудын инфляцийн түвшин бага байдаг ч эдийн засгийн өсөлт нь ханшийн уян хатан бодлоготой орнуудаас доогуур байдаг байна. Үүнээс гадна төв банкууд нь хараат бус бие даасан байдлаа алдах, долларжилт эрс нэмэгдэх, ханшийг тогтвортой байлагах зардал нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавартай байдаг байна.

Валютын уясан ханш болон мөнгөний агрегатуудыг завсрлын зорилт болгон мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх явцад гарсан дээрх хүндрэлүүдээс шалтгаалж 1990-ээд оны эхнээс Шинэ Зеланд, Канад, Англи, Швейцар, Финлянд, Испани болон Австрали, 1990 оны сүүлчээс Чех, Польш, Бразил, Чили, Израил зэрэг улс орон инфляцийг онилох мөнгөний бодлогын хэлбэрийг сонгон хэрэгжүүлж эхэлсэн байна.

#### **Эцсийн зорилгоо албан ёсоор зарладаггүй мөнгөний бодлого буюу “Зүгээр л хий” стратеги**

Эн нь ямар нэг зорилго, зорилтыг онцполгүйгээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэгддэг бөгөөд үүний тод жишээ нь АНУ юм. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах нь өөрөө мөнгөний бодлогын зорилгууд болж байдаг. Инфляцийг онилох мөнгөний бодлоготой нэгэн адил энэхүү бодлогын онцлог нь урьдчилан харж, уртаж хийхэд оршино. АНУ -ын хувьд өнөөдөр явуулсан мөнгөний бодлого 2 жилийн дараа инфляцид нөлөөлөх бөгөөд 2 жилийн дараа инфляци өснө гэж таамаглаж буй тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийг одооноос хумиж эхэлдэг байна. Энэхүү бодлогын сул тал нь албан ёсоор зорилгоо зарладаггүй, мөнгөний бодлогын стратегийн ил тод байдал нь сул зэрэгт орших бол гол давуу тал нь урьдчилж харсан мөнгөний бодлого хэрэгжүүлдэг тул цаг хугацааны нийцгүй байдал үүсдэггүй байна. Хөгжик буй эдийн засгаас ийм хэлбэрийг сонгосон улс орон хараахан байхгүй байна.

Бүрэн ажил эрхлэлт, тогтвортой үнэ болон урт хугацааны хүүний түвшний зохицуулалт

Судалгааны эмхтгэл, XI боть

байх бөгөөд урт хугацаанд эдгээр зорилгууд нь нийцтэй бөгөөд бие биенийгээ бататгадаг боловч богино хугацаанд зөрчилдэж болох юм. Хамгийн гол зорилго нь үнийн тогтвортой байдал юм. Үнийн тогтвортой байдал нь бүрэн ажил эрхлэлт болон урт хугацааны хүүний түвшинг зохицуулах суурь шалтгаан болдог. Зорилгуудын гол утга санаа нь Потенциал ДНБ-ий өсөлтийн түвшинтэй зохицох мөнгөний хэмжээний өсөлтийн түвшинг хадгалснаар үнийн түвшинг тогтвортой барьж, бүрэн ажил эрхлэлтийг дэмжих боломжтой болно гэсэн санаа юм. Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлыг хэмжихдээ үйлдвэрлэлийн зөрүү буюу потенциал ДНБ-ээс бодит ДНБ-ий хазайсан хувийг ашигладаг. Эерэг үйлдвэрлэлийн зөрүү инфляцийн өсөлтийг харуулна. Сөрөг үйлдвэрлэлийн зөрүү ажилгүйдэл хэвийн түвшнээсээ их байгааг илэрхийлнэ. Иймээс үйлдвэрлэлийн зөрүүг хамгийн бага байлгахыг эрмэлзэдэг бодлого юм.

Сүүлийн жилүүдэд нилээд хэдэн орнууд тэр дундаа АНУ тус загварыг хэрэглэж байгаа бөгөөд жишээ нь валютын ханш, мөнгөний агрегатын нэрлэсэн үзүүлэлт, эсвэл инфляци зэргийг хэрэглэхгүйгээр макроэдийн засгийн сайн орчинг бүрдүүлж чадсан байна. (тэр дундаа бага ба тогтвортой инфляцийн түвшин). Хэдийгээр ямарваа нэгэн стратегийг АНУ-ын тохиолдолд хэрэглээгүй боловч тодорхой хэмжээнд мөнгөний бодлого нь хэрэгждэг. Ф.Мишкины тодорхойлсон “Зүгээр л хий” гэдэг стратеги нь эцсийн зорилгоо зарладаггүй мөнгөний бодлоготой бараг ижил гэж хэлж болохоор байна.

“Зүгээр л хий” гэдэг энэхүү стратегийн амжилтанд хүрч хэрэгжсэн гол санаа нь “хэрвээ энэ эвдрээгүй юм бол яагаад засах ёстой гэж?” Хэдийгээр “зүгээр л хий” стратеги нь төв банкны санхүүгийн тооцоо ба ил тод байдлын хязгаарлагдмал байдлаас болж амжилттай хэрэгжихгүй байх болон инфляцийн эсрэг мөнгөний бодлогын үр нөлөө дэмжлэгийг супруулахаас гадна ардчиллын суурь ойлголттой харшлах юм. Мөн “Зүгээр л хий” гэдэг энэхүү стратегийг инфляцид чиглэсэн бодлогоор сольсноор хувийн шалтгаанаас хамааралгүй болгож, Төв банкны урт хугацааны үнийн тогтвржуулах, бага инфляцийн түвшинд, өрсөлдөөнөөс салангид, хэдэн хүний оролцоноос салангид байж чадна.

#### **Мөнгөний агрегатад чиглэсэн мөнгөний бодлого:**

Мөнгөний агрегатыг зорилтоо болгож буй мөнгөний бодлого нь мөнгөний нийлүүлэлтийг өөрчлөлгүй тэнцвэрийг хүүгийн өсөлтөөр хангаж байдаг байна. Манай улсын хувьд энэ бодлогыг 1990-ээд оны дунд үеэс 2006 он хүртэл ашиглаж байсан бөгөөд энэхүү арга хэлбэрийн хүрээнд Төв банк үйл ажиллагааны зорилтоор нөөц мөнгөний өсөлтийг, завсрьн зорилтоор мөнгөний нийлүүлэлтийг, эцсийн зорилгоор үнийн тогтвортой байдлыг сонгож ажиллаж байсан байна. Манайд 2007 он хүртэл, хөгжингүй орнууд 1990 оний эхэн хүртэл мөнгөний агергатуудад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж байсан. Судлаачид энэ бодлогын хувилбарыг буурай хөгжилтэй орны эдийн засагт илүү тохирно гэж үздэг бөгөөд Төв банкнаас M2 мөнгийг зах зээлд нийлүүлэн, буцаан татан авах замаар үнийн тогтвортой байдлыг хангадаг байсан.

Мөнгөний агрегатыг онилж буй мөнгөний бодлогын хувьд үйл ажиллагааны зорилт нь нөөц мөнгө, завсрьн зорилт нь мөнгөний нийлүүлэлт (M2) байдаг байна. Банкуудын нөөцийг өөрчилснөөр мөнгөний үржүүлэгч болон бусад сувгаар дамжин мөнгөний агрегатуудад, улмаар инфляцид нөлөөлдөг. Ийм бодлого үр дүнтэй байхын тулд мөнгөний эргэлтийн хурд, мөнгөний эрэлт, мөнгөний үржүүлэгч тогтвортой, мөн мөнгөний агрегат болон инфляцийн хооронд тогтвортой хамаарал байх ёстой. Мөнгөний агрегатыг онилсон бодлогыг хэрэгжүүлэхэд үндсэн 2 сув тал байдаг.

- Мөнгөний агрегатуудыг олон нийтэд тайлбарлахад хялбар бус
- Мөнгөний агрегат болон инфляцийн хоорондох хамаарал тогтвортой байх шаардлагатай.

Мөнгөний эрэлтийн тогтвортой байдал нь хөгжиж буй орнуудад санхүүгийн либералчлалын явц доогуур байгаатай, харин аж үйлдвэржсэн орнуудын хувьд санхүүгийн либералчлалд хязгаарлалт хийдэггүйтэй холбоотой байдаг.

Фридманы санал болгосон мөнгөний агрегатыг зорилтоо болгож буй мөнгөний бодлогыг цөөхөн орон хэрэглэж байгаа ч энэ нь өнөөдөр олонх төв банкуудын хэрэглэж байгаа инфляцийг онилсон бодлогын үндэс суурь нь юм.

Мөнгөний бодлогын хэлбэрээ сонгохын зэрэгцээ удирдах шийдвэр гаргах түвшинд мөнгөний бодлогын ямар арга хэрэгсэл, ямар дүрмийг ашиглахаа сонгодог. Мөнгөний бодлогын дүрмийг оновчтой сонгож баримтлах нь инфляцийг таамаглах, удирдахад хялбар байдаг бөгөөд таатай эдийн засгийн орчинг үүсгэхэд нөлөөлдөг.

Мөнгөний бодлогын дүрмийг:

- Арга хэрэгслийн дүрэм\
- Зорилтод дүрэм гэж ангилдаг

Арга хэрэгслийн дүрэм нь эдийн засгийн одоогийн нөхцөл байдлын түвшинд суурилсан бодлогын арга хэрэгслийт төлөвлөдөг. Орчин үед хамгийн алдартай арга хэрэгслийн дүрэм нь Тейлорын дүрэм бөгөөд хүүний түвшинг “Зорилтод түвшнээс инфляцийн түвшний хазайх хазайлт”, “Үйлдвэрлэлийн зөрүүний чиглэл ба хэмжээ” гэсэн хүчин зүйлсээс хамааруулан тогтоодог.

Зорилтод дүрэм нь бодлогын зорилтын таамаглал зорилтод түвшинд байхаар бодлогын арга хэрэгсэлээ төлөвлөдөг. Хэрэв бодлогын туйлын зорилго **X** хувийн инфляцийн түвшин бөгөөд арга хэрэгсэл нь бодлогын хүү бол зорилтод дүрэм нь бодлогын хүүг инфляцийн түвшний таамаглалыг жилийн **X** хувьтай тэнцүү байх түвшинд тогтооно. Өнөөдөр МБ-ны хэрэглэж буй дүрэм.


Иймэрхүү зорилтод дүрмийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, түүний шоконд болон бодлогод хариу үзүүлэх арга замын талаар их хэмжээний мэдээлэл цуглуулж, сайтар дүгнэлт хийн боловсруулах ёстой. Эдгээр бүх өгөгдлийг боловсруулсныхаа дараагаар бодлогын арга хэрэгслийн хамгийн сайн түвшний талаарх шийдвэрт хүрдэг. Судлаачид зорилтод дүрмийн стратегийг баримтлахыг санал болгодог бол зарим эдийн засагчид бодлогын хүүний түвшинг Тейлорын дүрмээр маш сайн тооцох нь илүү үр дүнтэй гэж үздэг.

Мөнгөний бодлогын алтернатив дүрмүүд

Эдгээрийн хоёр нь арга хэрэгслийн, гурав нь алтернатив зорилтод дүрэм юм.

- Нөөц мөнгөний арга хэрэгсэлийн дүрэм
- Мөнгөний зорилтод дүрэм
- Валютын ханшний зорилтод дүрэм
- Инфляцийн зорилтод дүрэм
- Тейлерийн дүрэм (Taylor rule)

Тейлерийн дүрэм буюу инфляци ба ажилгүйдлийн холбоог ашиглан урт болон дунд хугацааны хүүгээр дамжуулан удирдах бодлогын хувилбар юм. Тейлер (1994) оновчтой мөнгөний бодлогын арга хэрэгслийг инфляци, үйлдвэрлэлийн вариацуудын жигнэсэн нийлбэрийг хамгийн бага байхаар тодорхойлж, инфляци ба үйлдвэрлэлийн алдагдлын функциыг хамгийн бага байлгахад мөнгөний агрегатын арга хэрэгсэл бүхий оновчтой мөнгөний бодлого нь үйлдвэрлэлийн гарц ба инфляцийн функцийн бүрдэл байж болно гэдгийг Тейлер тогтоосон.



д/д	Мөнгөний бодлогын алтернатив дүрмүүд	Тайлбар
1	Нөөц мөнгөний арга хэрэгслийн дүрэм	МакКолумын дүрэм нь нөөц мөнгөний эргэлтийн хурдны дундаж хугацааны өөрчлөлт болон бодит ДНБ-ний урт хугацааны дундаж өсслтэй тохирох нөөц мөнгөний өсслтийн түвшинг тогтоодог. Уг дүрэм мөнгөний тооны онолд суурилна. МакКолумын дүрэмд үйлдвэрлэлийн зөрүү, бодит хүүний түвшний алиных нь ч үнэлгээ хэрэггүй. МакКолумын дүрэм мөнгөний эрэлт, тогтвортой байх магадлалтай нөөц мөнгөний эрэлтээс хамаардаг.
2	Мөнгөний зорилтод дүрэм	Фридманы К-хувийн дүрэм нь мөнгөний хэмжээг нэг жилд потенциал ДНБ-ий өсслтийн түвшинтэй тэнцүү К хувиар өсгөхийг санал болгодог. Аж үйлдвэржсэн орнууд Фридманы санааг ашигладаг байсан боловч 1970, 1980-аад онд татгалзсан. Мөнгөний эрэлт мөнгөний зорилтын ашиглалтыг найдвартай гүйцэтгэхд хэт тогтвортгүй гэж үздэг.
3	Валютын ханшны зорилтод дүрэм	Тогтмол валютын ханштай үед тухайн улс инфляцийн түвшинд хяналт тавьдаггүй. Инфляцийн түвшинг зорих валютын ханшийг харьцангуй тогтвортой түвшинд барихын сул тал нь бодит валютын ханш ихэвчлэн таамаглашгүй байдлаар өөрчлөгддөгтэй холбоотой. Валютын ханшийг харьцангуй тогтвортой түвшинд барих замаар инфляцийн түвшнийг зорих үед бодит валютын ханшны өөрчлөлтийг тогтоох болон түүнийг балансжуулах хэрэгтэй.
4	Инфляцийн зорилтод дүрэм	Инфляцийн түвшний зорилт нь төв банкнаас олон нийтэд мэдэгдэл хийдэг мөнгөний бодлогын стратеги юм. Уг мэдэгдэл нь: 1. Тодорхой инфляцийн зорилтод хүрэх 2. Энэ бодлогын үйл ажиллага зорилтдоо хэрхэн хүрэхийг тайлбарлана. Зарим улсын төв банкууд инфляцийн зорилтыг 1990-ээд оны дунд үеэс хойш хэрэгжүүлж байна. Инфляцийн зорилт далд зорилтоос илүү сайн үр дүн авчрах эсэх нь тодорхойгүй юм.
5	Тейлерийн дүрэм (Taylor rule)	Тейлерийн дүрэм (Taylor rule) буюу инфляци ба ажилгүйдлийн холбоог ашиглан урт болон дунд хугацааны хүүгээр дамжуулан удирдах бодлогын хувилбар

Хүүний түвшний арга хэрэгсэл бол хоцрогдолтой хүүний түвшин, тэнцвэрт хүүний түвшин, тухайн жилийн инфляцийн түвшин, таамагласан жилийн инфляцийн түвшний хазайлт, ДНБ-ний зөрүү ба бодит валютын ханшийн өөрчлөлтөөр тодорхойлгодноо.

Энэ онол нь inflation онилох мөнгөний бодлогын улс орнууд хэрэгжүүлж эхлэснээс хойш судлаачдын сонирхолыг татаж эхэлсэн. АНУ-д 1960 онд далд эдийн засгийн өсслтөө хянаж чадахаа байсан боловч эдийн засгийн зөрүү гэдэг ойлголт гарч ирсэнээр эдийн засгийн өсслт нь жигдэрсэн байна. Тэйлорын дүрэм нь эдийн засгийн өсслтийн зөрүү болон үнийн өсслтийн зөрүүн дээр тулгуурладаг.

**Үнийн зөрүү = бодит үнийн өсслт – далд үнийн өсслт**  
**Эдийн засгийн өсслтийн зөрүү = бодит өсслт – далд өсслт**

Эдийн засгийн өсслтийн зөрүү нь бодит өсслт нь өнөөгийн далд эдийн засгийн түвшингээс дээш эсвэл доош байна уу гэдгийг харуулдаг. Өөрөөр хэлбэл далд эдийн засгийн түвшин ерөнхий түвшингээс дээш байгаа нөхцөлд эдийн засгийн зөрүү нь (+) байгаад эсэргээрээ энгийн түвшингээс доош байх нөхцөлд эдийн засгийн зөрүү нь (-) байдаг байна. Жишээлбэл АНУ-ын мөнгөний бодлогод Тейлорын дүрэм нь холбооны сангийн хүү (FFR)-г тэнцвэрт бодит хүүний түвшин (Тейлор үүнийг жилийн 2 хувь гэж үзсэн) дээр инфляцийн түвшин (INF) болон үйлдвэрлэлийн зөрүү (GAP)-г дараах томъёоны дагуу нэмж тогтоодог (бүх

утгууд нь хувиар илэрхийлэгдэнэ):  $FFR = 2 + INF + 0.5 (INF - 2) + 0.5GAP$

Хэрэв инфляци зорилтод түвшиндээ байвал үйлдвэрлэлийн зөрүү тэг (бүрэн ажил эрхлэлттэй), 2 хувийн инфляцийн зорилттой үед холбооны сангийн хүү жилийн 4 хувь байна. Өргөтгөсөн Тейлорийн арга хэрэгсэл нь нэрлэсэн түвшинг бодит валютын ханшийн түвшин, инфляцийн хазайлт ба үйлдвэрлэлийн зөрүүний өөрчлөлтийн функц хэлбэрээр авч үздэг.

Эдийн засгийн байдал бууралттай байгаа нөхцөлд Төв банк бодлогын хүүгээ бууруулж эдийн засгийн байдал сайн байгаа нөхцөлд Төв банк бодлогынхоо хүүг өсгөдөг байна. Энэ мэтчилэн Төв банкны бодлогын хүүгээр эдийн засгийн зохицуулалт хийгддэг. Тэйлорын дүрэм нь бодлогын хүүгээрээ дамжуулаад эдийн засаг зохицуулагдана гэсэн зарчимтай.

## Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд, аливаа улс орон мөнгөний бодлогоо тодорхойлоходоо бусад орнуудын туршлага, өөрийн орны нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил болон мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх тодорхой чадавхийг бүрдүүлсэн байх шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Тухайлбал:

- ✓ Аль болох экспортод чиглэсэн эдийн засгийн зөв бүтцийг бий болгосон эсэх
- ✓ Санхүүгийн зах зээл нь жигд сайн хөгжсөн эсэх, хөрөнгийн зах зээл болон банкны систем аль аль нь эдийн засгийг санхүүжүүлэх ба тогтвортой байх
- ✓ Төв банкын хувьд Засгийн газраас хараат бус ажиллаж, төсвийн бодлоготой мөнгөний бодлогоо уялдуулж чаддаг байх
- ✓ Төв банк нь инфляцийн таамаглал судалгаа, прогноз хийх чадвартай сайн боловсон хүчинтэй байх зэрэг нөхцөлүүд хангагдсан байх нь мөнгөний бодлогыг зөв тодорхойлоход тодорхой хэмжээнд нөлөөлнө хэмээн үзэж болно

Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлж байна. Гэвч инфляцийг онилох бодлогын сул тал нь эдийн засгийн өсөлтийн сааруулах, ханшийн тогтвортой байдлыг алдагдуулах, хэрэгжүүлэхэд төвөгтэй, үр дүн нь удаан гардаг, тодорхой хугацаа шаарддаг зэрэг сул талтай болох нь харагдаж байна. Энэ арга нь харьцангуй ил тод, нээлттэй арга хэдий ч нийгэмд хүлээлт үүсгэх, улс төржих зэрэг олон шалтгаанаас зарим тохиолдолд зорилтот түвшиндээ хүрэхэд Монгол банкинд хүндрэл учруулах талтай. Мөн нарийвчилсан тооцоо судалгаа, эдийн засгийн болон санхүүгийн зах зээлийн угтвар нөхцөл шаарддаг онцлогтой.

Ийм учраас Монгол банкны зүгээс мөнгөний бодлогоо сайжруулах, бодлогын арга хэлбэрийн сонголт зөв эсэх талаар нухацтай судалж шийдвэр гаргах шаардлагатай гэж үзэж байна.


Дүгнэж хэлэхэд, сүүлийн үед мөнгөний бодлогын онолд шинээр бий болсон урсгал болох АНУ-н нэрт эдийн засагч Frederic Mishkin-ий дэвшүүлсэн стратеги буюу: “Зүгээр л хий” стратеги Монгол улсын хувьд тохиромжтой байж болох юм гэсэн таамаглалыг дэвшүүлж байна. Энэхүү мөнгөний бодлогын стратегийн давуу тал нь ямар нэгэн тодорхой зорилго, зорилтыг онцлохгүйгээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэгддэг ба хэдэн жилийн өмнөөс урьдчилж харсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг тул цаг хугацааны хувьд нийцгүй байдал үүсгэдэггүйгээрээ онцлогтой.

Уг бодлогыг хэрэгжүүлж буй орны тод жишээ бол Америк. Тус улсын төв банкнаас хэрэгжүүлдэг уг бодлого хоёр жилийн дараа инфляцидаа нөлөөлдөг буюу инфляцийн таамаглалыг дэвшүүлж, мөнгөний бодлогоо алсаас хумиж эхэлдэг нь инфляцийн хүлээлт зэрэг цаг үеийн нөлөөллөөс хамгаалагдсан байдаг.

Инфляцийн зорилтот түвшин хугацааг хатуу тогтоох, олон нийтэд нээлттэй мэдээлэх болон энэ хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь үнийн хийсвэр өсөлтөөс үүдэлтэй болгоомжлол бий болох, арилжааны банкуудын зээлийг хязгаарлах, эдийн засгийн өсөлтийг бууруулах зэрэг олон сөрөг үр дагавартай байна хэмээн судлаачид, олон нийт үздэг.

#### **Ашигласан материал:**

1. Санхүү, мөнгө зээлийн харилцаа. Д.Моломжамц. 2008 он
2. Эдийн засгийн ухаан макроэкономикс. Грегори Менкью.
3. Монголбанк судалгааын ажил. 2004 он
4. Д.Баярмаа. Монгол Улсад инфляцийг онилох бодлого хэрэгжүүлэх нөхцөл боломж. 2008 он
5. Мөнгөний бодлогын оновчтой хэлбэрийг тодорхойлох нь. П.Авралт-Од. 2004 он.
6. <http://www.mongolbank.mn>
7. Monetary Policy. Frederic S. Mishkin. <http://www.nber.org/reporter/winter02/mishkin.html>
8. [http://en.wikipedia.org/wiki/Monetary\\_policy](http://en.wikipedia.org/wiki/Monetary_policy)
9. Frederic S.Mishkin. International experiences with different monetary policy regimes. National Bureau of economic research.



**МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ:  
ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХАДГАЛАМЖ БОЛОН КАСТОДИАН ҮЙЛЧИЛГЭЭ**

*Ц. Норовдондог - Эдийн засгийн ухааны доктор (Ph.D)*

**Агуулга:**

1. Үнэт цаасны бүртгэл, хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээний зохион байгуулалт, онцлог
2. Үнэт цаасны хадгаламж, клиринг, төлбөр тооцооны үйл ажиллаганы стандарт, бусад орнуудын туршлага
3. Кастодиан банк уу, депозитар уу?
4. Монгол улс дахь үнэт цаасны төлбөр, тооцоо хадгаламжийн үйлчилгээ, эрх зүйн орчин
5. Санал , зөвлөмж

\* \* \*

Үнэт цаасны зах зээл бол нэг талаасаа, хүн төрөлхтөний түүхэнд одоогоор бий болгоод байгаа санхүүгийн зах зээлийн “төгс” хэлбэр буюу сонгодог зах зээл, нөгөө талаас, маш олон оролцогчдыг хамарсан нарийн төвөгтэй зохицуулалт, дэд бүтэц шаардсан стандарт зах зээл юм. Энэ нь бүхэл бүтэн системийн үйл ажиллагаа учраас эрсдэл ямагт дагалдаж байдаг тул өндөр түвшний мэдлэг, үнэнч шударга үйл ажиллагаа, ил тод байдал, хяналт хариуцлагын нарийн тогтолцоотой байхыг шаарддаг. УЦЗЗ -ийн дэд бүтцийн хүрээнд эрх бүхий мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд ажилладаг, хянах зохицуулах үүрэг бүхий төрийн зохицуулалтын болон өөрийгөө зохицуулах байгууллагууд ажилладаг.

Дэлхий даяар хөрөнгийн зах зээл цар хүрээгээ улам тэлж хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зөвхөн дотоодын зах зээлээс бус хил хязгааргүй орон зайд татан төвлөрүүлэх болсон байна. Санхүүгийн зах зээлийн шинэ шинэ үйлчилгээний хэлбэрүүд, шинэ хэрэгсэлүүд бий болсоор байна. Үүнийг танин мэдэхгүйгээр, зах зээлийн хөгжлийн шинэ арга барилыг эзэмшихгүйгээр өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа санхүүгийн хэрэгцээгээ улс орон дотооддоо хангах боломжгүй юм.

Үнэт цаасны зах зээл улам бүр дэлхий нийтийг хамрах чиг хандлагатай болж байгаа тул олон улсын стандартад нийцсэн эрх зүйн болон үйл ажиллагааны системийг төлөвшүүлэх асуудал чухал байна. Олон Улсын Үнэт Цаасны зохицуулах байгууллага /IOSCO/ -аас гаргасан үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын зарчим нь нэг талаас зах зээлийг илүү глобалчлагдсан, ойлгомжтой болгож байгаа ч нөгөө талаас манайх шиг зах зээлийн багтаамж багатай, хөгжил буурай орнуудын хувьд зах зээлийн нүсэр дэд бүтцийг сонгодог хэлбэрээр нь төлөвшүүлэхэд тодорхой бэрхшээлийг бий болгож байгаа юм. Ялангуяа Үнэт цаасны төлбөр тооцоо, клиринг, хадгаламжийн үйл ажиллагаа нь зөвхөн үнэт цаасны зах зээлд төдийгүй Монгол улсын банк санхүүгийн салбарт хамаарах асуудал учраас институциональ бүтцийн хэлбэр, эрх зүйн орчин, функциональ үйл ажиллагаа талаасаа аль болох бодит нөхцөлд тохирсон, нөгөө талаасаа хөрөнгийн зах зээлийн нийтлэг стандартад нийцсэн байх учиртай.

Дэлхийн хөрөнгийн зах зээлд Монгол улсын компаниудыг гаргах, гадаадын үнэт цаас, хөрөнгө оруулалтыг Монгол улсын хөрөнгийн зах зээлд татах зорилгыг хэрэгжүүлэх, үнэт цаасны зах зээлийг эрсдэл багатай, хүртээмжтэй болгож хөгжүүлэх зорилгын үүднээс үнэт цаасны төлбөр, тооцоо хадгаламжийн үйлчилгээг үзүүлж ирсэн өнөөгийн тогтолцоог өөрчлөх, илүү боловсронгуй болгох шаардлага байна.

## 1. Үнэт цаасны бүртгэл, хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээний зохион байгуулалт, онцлог

### 1.1 Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ / депозитари/

Депозитари - гэдэг нь биет болон биет бус хэлбэрийн үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг байгууллага. Өөрөөр хэлбэл, харилцагчидтай хийсэн гэрээний үндсэн дээр түүний нэр дээр нээгдсэн дансанд үнэт цаасыг бүртгэх, хадгалах, данс бүртгэл хөтлөх, гэрээний үндсэн дээр харилцагчийн нэрийн өмнөөс үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг мэргэжлийн байгууллага юм.

#### Депозитари яагаад хэрэгтэй вэ?

Зохион байгуулалттай үнэт цаасны зах зээлд төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, зах зээлийг эрсдэлгүй, шуурхай ажиллуулахад депозитари чухал үүрэгтэй. Бусад орны туршлагаас хараход, үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ нь нь эхэндээ Хөрөнгийн биржид үйлчлэх зорилгоор ихэвчлэн байгуулагдаж байжээ. Учир нь зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын /брокер, дилерүүд/ хооронд байнга хэлцэл хийгдэж хэлцэлд оролцогч талууд хооронд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх шаардлага их байсан учир энэ схем нь үр ашигтай ажиллаж чадаж байлаа. Тухайлбал, дараах нөхцөл байдлыг авч үзье.

Биржийн арилжаанд оролцож буй брокерууд өөрийн болон өөрсдийн харилцагчдын нэр байсан бүх үнэт цаасыг /биет/ биржийн хадгаламжид хадгалууллаа гэж бодье. Энэ тохиолдолд эдгээр үнэт цаасыг брокерийн данснаас хасаж биржийн депозитарийн дансанд бүртгэх ба депозитари нь номинал эзэмшигч болно гэсэн үг. Депозитари брокерийн пүүс бүр дээр депо данс нээх ба уг дансанд тухайн пүүсийн эзэмшигч байсан бүх үнэт цаасыг бүртгэнэ гэсэн үг. Ингэснээр хэлцлийн үр дүнгээр өмчлөх эрхийг регистратор буюу трансфер агентаар заавал дамжуулж илүү зардал гаргахгүйгээр депозитари дээр шууд данс хооронд бичилт хийгдэж үнэт цаас нь тэндээ хадгалагдсан хэвээр байх бөгөөд зөвхөн өмчлөгч нь өөрчлөгднө гэсэн үг. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн механизмын аль болохоор үнэт цаасны эргэлтийг идэвхжүүлэх бөгөөд хэрвээ үнэт цаас гаргагч эзэмшигчдийн нэрийн жагсаалтыг гаргуулахыг хүсвэл ТТХ нь номинал эзэмшигчийн хувьд бүрэн хэмжээний реестрийг гаргаж өгөх боломжтой.

#### Депозитари нь

- Харилцагчдын нэр дээр үнэт цаасыг бүртгэх, хадгалах
- Үнэт цаас өмчлөх болон үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх
- Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх, үнэт цаас гаргагчын хүсэлтээр эзэмшигчдийн нэрийн жагсаалтыг гаргах
- Үнэт цаас гаргагчаас шилжүүлсэн ногдол ашигийг хувьцаа эзэмшигчдийн дансанд хуваарилах
- Үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан мэдээллийг түгээх
- Хэрвээ эмитент хүсвэл эчнээ санал хураалтын арга хэмжээг зохион байгуулах гэх мэт ...

Эдгээр үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх нь үнэт цаас гаргагчид ашигтай бөгөөд хялбар байх тул депозитари нь нэг ёсондоо үнэт цаас гаргагч - хувьцаа эзэмшигч хооронд нэгэн төрлийн зуучлагч болдог байна. Гэвч эдгээр төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд зайлшгүй “эрх зүйн орчин” бүрдсэн байх шаардлагатай. Хууль, журмаар энххүү

эрхийг хэр хэмжээнд олгосноос шалтгаалан үнэт цаас гаргагчид болон тухайн гаргалтын үнэт цаастай холбогдох ажил үйлчилгээний хэм хэмжээгээ харилцан тохиролцдог байна.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, тухайлбал, ОХУ-д депозитари нь хөрөнгийн зах зээлийн институциональ бүтцийн томоохон хэсэг болох бөгөөд үнэт цаасаар олгосон эрхийг гэрчлэх, бүртгэл хөтлөх томоохон систем болон төлөвшсөн байна. Учир нь ихэнх өндөр хөгжилтэй орнуудад үнэт цаас нь “биет бус” хэлбэрээр эргэлтэнд орж байдаг учраас үүнд тохирсон “бүртгэлийн нэгдсэн систем” зайлшгүй байдаг. Бүртгэлийн нэгдсэн систем гэдэгт регистратор болон депозитари хамаарна.

**Регистратор буюу бүртгэгч** нь ихэвчлэн үнэт цаас гаргагчтай хийсэн гэрээний үндсэн дээр нэрийн үнэт цаас эзэмшигчийн бүртгэл хөтлөнө. Үнэт цаас эзэмшигчийн бүртгэл / реестр/ гэдэг нь тодорхой хугацаагаар тасалбар болгон гаргасан үнэт цаас эзэмшигчдийн нэrsийн жагсаалт.

**Реестрийг** үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах зэргээр хувьцаа зэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор гаргуулан авдаг. Мөн Хувьцаат компанийн удирдлагын зүгээс компанийн хувьцааны багцыг хэн эзэмшиж байна, зах зээлд хувьцааг нь бөөнөөр нь худалдан авах эсвэл ямар нэгэн санаатай үйлдлийг хийж байгаа эсэхэд хяналт тавих боломж олгоно. Нэрийн үнэт цаасны тухайд реестр чухал ба хэрвээ үзүүлэгчийн үнэт цаас бол энэ төрлийн жагсаалтыг заавал гаргуулах шаардлагагүй. Тухайн үед эзэмшиж байгаа этгээдэд ногдол ашиг хуваарилагдана.

Хувьцаат компаниуд өөр дээрээ реестр хөтөлж болох боловч ихэвчлэн хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг байна. Энэ төрлийн мэргэшсэн үйлчилгээг ихэвчлэн банкууд, эсвэл төрөлжсөн бүртгэлийн байгууллагууд гүйцэтгэдэг. АНУ-д тухайлбал, трансфер агентууд гүйцэтгэдэг бол, ОХУ-д яんз бүрийн хэлбэртэй байна.

**Регистратор** нь зөвхөн реестр хөтлөх бус мөн үнэт цаас эзэмшигчийн сертификат олгох, үнэт цаасыг шилжүүлэх, шинэ эзэмшигчийн нэр дээр бүртгэх, өмчлөх эрхийг нь баталгаажуулах, хэрэгжүүлэхэд нь туслах зэрэг үйлчилгээ үзүүлнэ. Мөн шүүхийн шийдвэрээр тусгаарлах, барьцаалах, үнэт цаасыг хуваах, нэгтгэх, хөрвүүлэхтэй холбоотой бүртгэл, өмчлөх эрхийг гэрчлэх үйлчилгээ үзүүлнэ. Регистратор дараах төрлийн дансанд үнэт цаасыг бүртгэнэ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн эмиссийн данс / Эрх бүхий байгууллагаас гаргахыг зөвшөөрч үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн үнэт цаасыг бүртгэж зах зээлд гаргах, эргүүлэн татах хэмжээгээр хасалт хийнэ/
- Үнэт цаас гаргагчийн нэрийн данс- Үнэт цаас гаргагчын зах зээлд гаргасан нийт үнэт цаас болон Компанийн шийдвэрээр буцаан худалдаж авсан үнэт цаас буюу халаасны хувьцааг бүртгэх/
- Үнэт цаас эзэмшигчдийн данс – үнэт цаас эзэмшигч, номинал эзэмшигч, барьцаа эзэмшигч, итгэмжлэгдсэн удирдагчийн нэр дээр нээгдсэн дансууд

Бусад орнуудын туршлагаас үзэхэд бие даасан бүртгэлийн байгууллага/ регистратор/ дангаар ажиллах нь хүндрэлтэй. Тэр болгон регистратор дээр очиж бүртгэлийн өөрчлөлт хийлгэх нь цаг их авдаг, хүндрэлтэйгээс гадна реестрийг ХК -үүд тэр бүр гаргуулан авдаггүй байна. Иймээс сүүлийн үед регистраторийн үүргийг “номинал эзэмшигч” буюу үнэт цаасны хадгаламжийн байгууллага / депозитари/ гүйцэтгэх болсон байна.

**“Номинал эзэмшигч”** гэдэг нь – үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтөлдөг байгууллага бөгөөд өөрөө өдгөөр үнэт цаасыг өмчлөх эрхгүй гэсэн үг юм. Хэрвээ талууд аль аль

Судалгааны эмхтгэл, XI боть

дансаа нээлгэсэн тохиолдолд талууд хооронд хийгдсэн хэлцлийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлэх эрхтэй байна. Зах зээл өндөр хөгсөн орнуудын хувьд регистратор тусдаа үйл ажиллагаа явуулах нь ховор, ихэвчлэн депозитари энэ үүргийг гүйцэтгэдэг байна.

**Депозитари** нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлдэг УЦЗЗ -ийн мэргэжлийн оролцогч бөгөөд үйлчлүүлэгчдийг нь депонент гэж нэрлэдэг. Депозитари нь үүнээс гадна үнэт цаас эзэмшигчдэд тодорхой үйлчилгээ үзүүлж болдог. Тухайлбал, үнэт цаасаар олгогдсон өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх буюу хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөн оролцох, үнэт цаасны хүү болон ногдол ашгийг үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс тооцож авах, биет үнэт цаасны бурдэл үнэн зөв, баталгаатай эсэхийг тодорхойлж өгөх, биет бус үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр үнэт цаас эзэмшлийн сертификат бичиж олгох, үнэт цаас өмчлөх эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх гэх мэт.

Депозитарийн үйл ажиллагааг зөвхөн хуулийн этгээд эрхлэх бөгөөд энэ төрлийн үйл ажиллагааг үнэт цаасны реестр хөтлөх буюу бүртгэлийн үйл ажиллагаатай хослуулж болохоос гадна үнэт цаасны клиринг- төлбөр тооцооны үйл ажиллагаатай хавсан эрхэлж болно. Эдгээр төрлийн үйл ажиллагааг эхрэхэд тавигдах тусгай зөвшөөрлийн гол шаардлага нь өөрийн хөрөнгө болон мэргэжлийн шаардлага байна.

Орчин үед депозитарийн 2 төрөл төлөвшин бий болжээ. Үүнд:

1. Төлбөр тооцооны депозитраи
2. Кастодиан депозитари

**Төлбөр тооцооны депозитари**- нь зохион байгуулалттай ихэвчлэн зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлнэ. Төлбөр тооцооны гэж нэрлэсний учир нь энэ төрлийн депозитари нь үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээнээс гадна хэлцлийн үр дүнгээр хийгдэх төлбөр тооцооны ажиллагааг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчдийнхээ хооронд хийгдсэн үнэт цаасны хэлцлийн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх үүднээс арилжаа эрхлэх байгууллага / бирж/ болон клирингийн байгууллагатай нягт уялдаатай ажиллана.

**Кастодиан депозитари** - нь ихэвчлэн үнэт цаас эзэмшигчид буюу харилцагчдад үйлчилгээ үзүүлнэ. Кастодиан үйлчилгээ нь төрөлжсөн болон төрөлжсөн бус хэлбэртэй байна. Төрөлжсөн бус кастодиан нь депозитари үйлчилгээнээс гадна брокер, дилерийн болон хөрөнгийн итгэмжлэгдсэн үйлчилгээ зэрэг үнэт цаасны зуучлагчийн үйл ажиллагааг эрхэлж болдог. Төрөлжсөн кастодиан нь ихэвчлэн Хөрөнгө оруулалтын сангүүд болон тодорхой үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлдэг. Хэрвээ үнэт цаас гаргагч үнэт цаас гаргахдаа биет хэлбэрээр гаргасан нэрийн үнэт цаасны сертификатaa заавал төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хадгалуулах шийдвэр гаргасан байж болно.

Депозитарийн үйл ажиллагаа эрэхлж буй байгууллага нь зайлшгүй харилцагчидтайгаа бичгээр гэрээ байгуулах бөгөөд үүнийг "депозитарийн гэрээ" гэж нэрлэнэ. Энэхүү гэрээгээр талуудын гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээ тодорхойлогдоно. Тухайлбал, Депозитари харилцагчийн даалгавраар ямар ямар үйлчилгээ үзүүлэх эрхтэй вэ? Үүнд: зөвхөн үнэт цаас хадгалах, бүртгэх, эсвэл үнэт цаасыг түүний нэрийн өмнөөс худалдах, худалдан авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд төлөөлөн оролцох, үнэт цааст ногдох ашиг, хүүг тооцож авах зэрэг эрхүүдийг тодорхой заасан байна.

Гэрээнд депонент /харилцагч/ болон депозитарийн ажилтаны аль алины хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой заах ба энэхүү гэрээ нь "депо данс" нээх үндсэн баримт бичиг болно. Депо дансны хувьд хэд хэдэн хэлбэртэй байж болно. Тухайлбал, нэг гаргалтын үнэт цаасны хувьд зарим нь тухайн харилцагчийн нэр дээрээ хадгалагдаж байхад заримыг нь арилжаанд эргэлтэнд оруулж байх жишээтэй. Иймд үнэт цаасны ашиглалтын тухайн

байдалд нь тохируулан лицевой счет / субсчет/ нээж болно.

Субсчет нээснээр ашиглалтын нэг хэлбэрт байгаа үнэт цаасуудыг тухайн дансанд түр хугацаагаар төрөлжүүлэн байршуулна. Нэг эзэмшигчийн нэр дээр нэг л депо данс нээгдэх бөгөөд хичнээн ч субсчет нээгдэж болно. Эдгээр субдансуудын нийлбэр нь тухайн харилцагчийн депо дансны үлдэгдэлтэй тэнцэнэ. Субсчет нээхэд тусгайлсан гэрээ хийх шаардлагагүй. Зөвхөн үнэт цаасны тухайн үеийн ашиглагдаж буй хэлбэр, шинж чанараар нь агилан бүртгэхэд ашиглана гэсэн үг.

Нягтлан бодох бүртгэл талаас нь авч үзвэл, депо данс нь мөнгөн хөрөнгийн дансны адилаар актив -пассив хэлбэртэй байна. Өөрөөр хэлбэл, актив талд нь хадгалагч буюу депозитарит хадгалагдаж байгаа үнэт цаас, пассив талд үнэт цаас эзэмшигчдийн нэр дээр эзэмшиж байгаа бүх үнэт цаас бүртгэгдэх бөгөөд , эдгээр үлдэгдэл нь “балансалсан” байх ёстой.

Үнэт цаасны дансны бүртгэлийн энэхүү зарчим нь мөнгөн хөрөнгийн стандарт бүртгэлд депо дансыг аль болох ойртуулж, бүртгэлийн нэгдсэн стандартад тусгах боломжийг олгодог байна. Мөн депозитарит үнэт цаасны бүртгэлийн өөрийн гэсэн стандарт , нягтлан бодох бүртгэлийн аргуудыг хэрэглэдэг байна. Үнэт цаасны зах зээлийн онцлог, гаргаж буй үнэт цаасны хэлбэрээс хамааран үнэт цаасны бүртгэлийн нээлттэй, хаалттай, холимог бүртгэлийн системийг ашиглаж байна. Тухайлбал, нээлттэй бүртгэлийн системийн үед бүх нэг гаргалтын үнэт цаасны сертификатийг нэг багц болгон бүртгэх бөгөөд хэн чухам ямар үнэт цаас эзэмшиж байгааг хэлэх боломжгүй.

Хаалттай бүртгэлийн системийн үед Хэн , ямар төрлийн, хичнээн ширхэг үнэт цаас эзэмшиж байгааг хэлэх боломжтой. Ал аль хэлбэр нь давуу болон суп талтай. Нээлттэй бүртгэлийн арга нь илүү технологи сайтай, нэг төрлийн шинж чанар бүхий эмиссийн үнэт цаасыг биет бусаар гаргаж буй зохион байгуулалттай зах зээлд илүү тохиромжтой, харин хаалттай бүртгэлийн аргыг хэрвээ нэг төрлийн үнэт цаасыг гаргахдаа өөр өөр онцлог шинжтэйгээр гаргаж байгаа бол илүү тохиромжтой гэж үздэг байна.

## 1.2 Клиринг- төлбөр тооцооны үйлчилгээ

Үнэт цаасны зах зээлд хэлцэл хийгдсэнээр зөвхөн үнэт цаасыг нэг эзэмшигчийн гараас нөгөө эзэмшигчид шилжүүлэх, бүртгэх, өмчлөх эрхийг шилжүүлэх бус нөгөө талаас, энэхүү үнэт цаасыг шилжүүлэхийн тулд худалдан авагч тал нь нөгөө талдаа мөнгөн хөрөнгө шилжүүлэх шаардлагатай. Хэрвээ үнэт цаасны зах зээл идэвхгүй, цөөхөн хэлцэл хийгдэж байгаа тохиолдолд ердийн аргаар талууд хооронд мөнгө шилжүүлж болно. Гэвч зохион байгуулалттай бирж дээр арилжаа компьютерийн системээр дамжин тасралтгүй явагдаж байгаа үед төлбөртооцоо-клирингийн мэргэшсэн үйүчилгээ зайлшгүй шаардлагатай.

Практикт энэ төрлийн үйлчилгээ эрхэлж буй мэргэжлийн байгууллагыг төлбөр тооцооны төв, клирингийн төв, гэх мэтээр нэрлэсэн байлаг. Төлбөр тооцоо-клирингийн үйлчилгээ гэдэг нь – Бирж дээр хийгдсэн хэлцлийг үндэслэн позицийг тодорхойлох, зах зээлд оролцогчдод төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллага. Үндсэн зорилго нь:

- Хэлцэлд оролцогч талуудын позицийг тодорхойлж тохируулга хийх
- Үнэт цаасны зах зээлийн төлбөр тооцооны үйлчилгээний зардлыг бууруулах
- Төлбөр тооцоо гүйцэтгэх хугацааг богино, шуурхай болгох
- Төлбөр тооцооноос үүдэн зах зээлд гарч болохуйц эрсдэлийг бууруулах

Клиринг - төлбөр тооцооны байгууллага нь зөвхөн нэг биржид үйлчлэх, эсвэл нэгэн зэрэг хэд хэдэн биржид үйлчлэхээр зохион байгуулагдаж болно. Ихэвчлэн ХХК болон ашгийн

Судалгааны эмхтгэл, XI боть

бус түншлэл хэлбэрээр байгуулагддаг. Судлаачдын үзэж байгаагаар хэд хэдэн биржид нэгэн зэрэг үйлчилэхүйц төлбөр тооцоо - клирингийн систем нь илүү тохиромжтой ба учир нь зах зээлд зуучлагч байгууллагууд ихэвчлэн хэд хэдэн бирж дээр зэрэг ажилладаг тул тэдний хувьд илүү тохиромжтой, ашигтай гэж үздэг байна.

Клиринг - төлбөр тооцооны байгууллага нь зөвхөн үндэсний хэмжээнд байгаад зогсохгүй олон улсын хэмжээнд, улмаар ирээдүйд бүх дэлхийг хамарсан глобал шинжтэй болох хандлагатай байна. Мэдээжийн хэрэг үндэсний хөрөнгийн зах зээл олон улсын зах зээлд хэдий чинээ интеграцид орнов төдийн чинээгээр үйлчилгээний цар хүрээ нь тэлэх болно.

**Клиринг - төлбөр тооцооны** байгууллага нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- Өөрийн гишүүдийн хооронд төлбөр тооцоо хийх/ зарим тохиолдолд зах зээлд оролцогч бусад байгууллага хооронд /
- Төлбөр тооцоонд оролцогч талуудын хооронд өр, авлагын тооцоо гаргах, клиринг
- Үйлчилж буй зах зээл дээр нь хийгдсэн хэлцлийн талаархи мэдээллийг нэгтгэж цуглуулах, үнэн зэвийг шалгах, мэдээлэл буруу өгөгдсөн бол запруулах
- Төлбөр тооцоо гүйцэтгэх график гаргах, төлбөр тооцооны төвд мөнгөн хөрөнгө болон холбогдох мэдээлэл, баримт бичгийг ирүүлэх хугацааг хатуу тогтоох
- Хэлцэл хийгдсэнд дараагаар биржийн хэлцлийн суурь актив/ үнэт цаас болон бусад/-ийг эзэмшигч буюу өмчлөгчийн нэр дээр шилжүүлсэн эсэхийг хянах
- Бирж дээр хийгдэж буй гэрээ хэлцэлийн баталгааг гаргах / ирээдүйд биелэгдэх хэлцлийн/
- Төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэл, баримт хөтлөлтийг зохион байгуулах

Төлбөр тооцоо - клирингийн байгууллага нь ихэвчлэн ашгийн төлөө байгууллага байх бөгөөд дүрмийн сан нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэнэ. Орлогын гол эх үүсвэрүүд нь:

- Хэлцэл бүртгэсний төлбөр
- Мэдээлэл худалдсанаас олох орлого
- Гүйлгээний шимтгэл
- Төлбөр тооцооны технологи, программ хангамж худалдсаны орлого
- Бусад

Төлбөр тооцоо-клирингийн байгууллагын үүрэг ялангуяа үүсмэл үнэт цаасны арилжаа / фьючерс, опционы/-ны зах зээлд туйлын чухал. Бусад орнуудын туршлагаас үзэхэд, КТТБ-ын гишүүд нь ихэвчлэн томоохон банк санхүүгийн байгууллага, хөрөнгийн болон фьючерсийн биржүүд байдаг байна.

КТТБ нь арилжааны банкнаас ялгагдах онцлог нь зээл олгох, үнэт цааст хөрөнгө оруулах эрхгүй байдаг байна. Гэхдээ клиринг төлбөр тооцооны үйлчилгээг депозитарийн үйлчилгээтэй хавсрان эрхэлж болно. Орчин үед арилжааны банкууд универсал хэлбэртэйгээр ажиллах болж үнэт цаасны зах зээлд голлоо үүрэг гүйцэтгэж байна. Банкууд үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч байхаас гадна үнэт цаасны зах зээлд мэргэжлийн оролцогч хэлбэрээр ажиллах боллоо. Банкууд хувьцаа гаргах замаар дүрмийн сангаа нэмэгдүүлж байна.

Мөн бусад үнэт цаас гаргагчаас ялгаатай нь банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхийн тулд хадгаламжийн болон, татан төвлөрүүлсэн хөрөнгийн сертификат, вексель зэрэг хэлбэрээр үнэт цаас гаргаж байна. Банкуудын үнэт цаасны хөрөнгө

оруулалтын тухайд, өөрийн болон татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө тодорхой хэмжээний үнэт цаасны хөрөнгө оруулалт хийж портфель бүрдүүлж байна. Үүнээс гадна арилжааны банкууд ҮЦЗЗ -д мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ингэхдээ ихэвчлэн охин компани, банк санхүүгийн групп байгуулах хэлбэрээр зах зээлд оролцож байна.

## **2. Үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээний олон улсын стандарт, бусад орнуудын туршлага**

Олон улсын хэмжээнд Үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцооны үйлчилгээнд дагаж мөрддөг Үнэт Цаасны Хорооны Олон Улсын Байгууллага /IOSCO/-aac 1998 онд гаргаж 2003 онд шинэчлэн баталсан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим” / Objectives and Principles of Securities Regulation/, мөн 2001 онд баталсан “Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж” хэмээх баримт бичгүүд байдаг.

“Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим” хэмээх баримт бичигт Үнэт цаасны зохицуулалтын дараахь үндсэн З зорилгыг нийтээр дагаж мөрдөхөөр тодорхойлсон. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдыг хамгаалах
- Зах зээлийн үнэнч шударга, үр ашигтай, ил тод механизмыг бүрдүүлэх
- Системийн эрсдлийг багасгах

Энэхүү турван зорилгын хүрээнд Үнэт цаасны зохицуулалтын 8 төрлийн 30 зарчмыг баталгаажуулж Олон Улсын Үнэт Цаасны Хорооны Байгууллага /IOSCO/-ын гишүүн орнууд холбогдох хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд:

- ✓ Зохицуулалттай холбоотой зарчмууд
- ✓ Өөрийгөө зохицуулах зарчмууд
- ✓ Үнэт цаасны зохицуулалтын албадан хэрэгжүүлэх зарчмууд
- ✓ Зохицуулалтын хамтын схемийн зарчмууд
- ✓ Үнэт цаас гаргагчдын зарчмууд
- ✓ Хамтын хөрөнгө оруулалтын зарчмууд
- ✓ Зах зээлд зуучлагчдын зарчмууд
- ✓ Хоёрдогч зах зээлийн зарчмууд

### IOSCO –гийн 30 -р зарчим

“Үнэт цаасны хэлцлийн клиринг, төлбөр тооцооны систем нь зохицуулах байгууллагын хяналтанд байх ба үнэнч шударга, үр ашигтай, системийн эрсдэлийг аль болохоор бууруулсан байхаар зохион байгууллагдах шаардлагатай.” Зохицуулах байгууллагын зүгээс үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системд хяналт тавихад бүрдүүлэх орчин:

- Клиринг - төлбөр тооцооны системийн үйл ажиллагааны зохион байгуулалт, дүрэм журам нь зах зээлд оролцогчдод нээлттэй байх
- Клиринг, төлбөр тооцооны систем болон түүнд оролцогчдын үйл ажиллагааг Зохицуулах байгууллагын зүгээс шууд хяналт тавих боломж бүрдсэн байх
- Зохицуулах байгууллага нь клиринг, төлбөр тооцооны байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх заавар журмыг мөрдүүлэх ба мониторинг хийх, шаардлагатай бол үйл ажиллагааг нь шалгах, зөрчлийг арилгуулах, хариуцлага хүлээлгэх эрхтэй байх. Холбогдох байгууллагуудаас тайлан, мэдээлэл гаргуулан авах систем бүрдсэн байх.
- Зохицуулах байгууллага нь КТТБ-ын үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт

хийх, тайлан мэдээг тогтмол гаргуулч авах, хөндлөнгийн хяналтын байгууллагар шалгуулах эрхтэй байх

- КТТБ нь арилжааны болон төлбөр тооцооны мэдээлэлийг шалгаж нягтлах, эцэслэн тооцоолох, хугацаанд нь төлбөр хийх, зах зээлд оролцгчдын хооронд шууд төлбөр хийх, зах зээлийн болон зээлийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн хөрвөх чадвар болон үйл ажиллагааны эрсдэлийг удирдах олон улсын стандартад нийцсэн байхаар зохион байгуулагдах
- Эрсдэлийг явцын дунд/ on-going/ олж илрүүлэх, удирдах процедурыг бий болгох
- Үүсмэл үнэт цаасны төлбөр тооцооны систем нь хөвөх чадварын эрсдэлийг буурулсан байх.
- Марж болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих
- Хэлцлийн суурь активийг нийлүүлэхгүй байх эрсдэлээссэргийлэх, ялангуяа үнэт цаас зээлэх, богино хугацаат арилжааны үед
- Эрх зүйн орчинг талуудын эрх ашгийг тэнцүү хангасан, өөрийгөө хянах боломж олгосон, неттинг болон г хуульчилсан, төлбөр тооцоо бүрэн хийгдсэн, төлбөрийг үндэслэн харилцан шилжүүлэг хийгдсэн, эрсдэл болон хөрвөх чадварыг удирдах олон улсын стандартад нийцсэн байхаар бүрдүүлэх

2001 онд IOSCO-гийн Техникийн Хороо болон Төлбөр тооцооны Хороо хуралдаж энэхүү зарчмыг хэрэгжүүлэх “Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж” хэмээх баримт бичгийг батлан гаргасан. Энэхүү аргачлалд Үнэт цаасны төлбөр тооцооны процесс болон төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах аргачлал, нийтлэг стандартыг тусгасан байна.

**Үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны процесс нь** зах зээлд оролцогч 2 талын хэлцлийн нөхцлийг баталгаажуулах - 2 талын хүлээх үүргийг / мөнгөн хөрөнгө болон үнэт цаас/ тооцоолж гаргах - талууд хооронд үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх гэсэн дарааллаар хийгдэнэ. Үүнд:

1. **Баталгаажуулалт / confirmation/** буюу зах зээлд оролцогчдын хооронд хийгдсэн арилжааны нөхцөлийг баталгаажуулах
2. **Клиринг /calculation** буюу clearance/ - баталгаажуулсан нөхцөлийн дагуу талуудын хүлээх үүргийг тооцоолж гаргах
3. **Төлбөр тооцоо / settle/** буюу арилжаанд оролцогч талуудын хооронд мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг шилжүүлэх

Үнэт цаасны киринг төлбөр тооцооны стандарт, эрсдэлийг бууруулах зөвлөмжүүд:

1. **Хуулийн эрсдэл /legal risk/** - Үнэт цаасны төлбөр тооцооны системийг зөв зохион байгуулах, ойлгомжтой, ил тод эрх зүйн системийг бүрдүүлэх
2. **Төлбөр тооцооны өмнөх эрсдэл /Pre-settlement risk/**

Trade confirmation- Зах зээлд шууд оролцогчдын хооронд хийгдсэн хэлцлийг арилжаа дуусангут аль болох хурдан баталгаажуулах (T+0). Шууд бус оролцогчид буюу институциональ оролцогчдын хэлцлийг мөн аль болох арилжаа дууссаны дараа шууд баталгаажуулах, болж өгвөл T+0 хугацаанд T+1 ээс доошгүй өдрийн дотор байж болно.

Төлбөр тооцооны цикл - Төлбөр тооцооны эргэлтийн хугацааг үнэт цаасны зах зээлд тогтоох ба төлбөр гүйцэтгэх эцсийн хугацаа T+3-аас илүү байж болохгүй. Үүнээс бага хугацаанд төлбөрийн ашиг болон зардал боломжийн түвшинд байна.

Арилжаанд оролцогч талууд / Central counterparties CCPs/ - Хэлцэл хийгч 2 талын олох ашиг, төлөх төлбөр нь харилцан тэнцвэртэй байх. Хэлцэлд оролцогч талууд бие биендээ маш хатуу хяналт тавих механизмыг бүрдүүлэх

Үнэт цаас зээлдүүлэх – Үнэт цаасыг зээлэх болон зээлдүүлэх ажиллагааг үнэт цаасны хэлцлийн төлбөрийг хурдавчлах хэрэгсэл болгон ашиглахыг дэмжих. Үнэт цаас зээлдүүлэх ажиллагааг хориглосон аливаа барьер, хоригийг практик дээр арилгах

### 3. Төлбөрийн эрсдэл /Settlement risk/

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж (CSDs) - Үнэт цаасыг book-entry хэлбэрээр аль болох их хэмжээгээр татан төвлөрүүлэх, биет бус хэлбэртэй болгох, шилжүүлэх Үнэт цаасны нийлүүлэлтийн төлбөр / Delivery versus payment DVP)- CSDs нь үнэт цаасны шилжүүлгийг сангийн шилжүүлэг рүү холбох хүргэлтийн төлбөрийн эрсдэлийг аль болох бууруулах Төлбөр тооцоог эцслэн гүйцэтгэх хугацаа –Төлбөр тооцооны эцсийн өдөр нь төлбөр тооцоог гүйцэтгэхээр товлосон хугацаанаас хэтэрч болохгүй. Өдрийн туршид бодит цагийн горимд (real time)-төлбөр тооцоо байнга хийгдэж байх нь эрсдэлийг бууруулна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн эрсдэлийн хяналт нь оролцгчдын төлбөр гүйцэтгэх чадварт чиглэгдэж байх ёстой. ҮЦТХ нь аль болохоор арилжаанд оролцогчдод өдрийн зээл олгоход чиглэгдэх, ялангуяа төлбөр тооцооны нэттинг системийн үед. Институциональ эрсдэлийг аль болох бууруулах үүний тулд хугацаатай төлбөрт сайтар хяналт тавих, ялангуяа томоохон хэмжээний төлбөрийн үүрэг хүлээсэн оролцогчын төлбөрийн чадварыг анхаарах. Хамгийн тохиромжтой арга нь нэмэлт шаардлага буюу барьцаа шаардах, лимит тогтоох зэрэг аргуд болно.

Мөнгөн хөрөнгийн төлбөр (Cash settlement assets) - үнэт цаасны хэлцлийн төлбөрт зориулагдан шилжүүлэх мөнгө нь хөрвөх чадварын, зээлийн болон бусад ямар нэгэн эрсдэлээс ангид байх ёстой. Хэрвээ Төв банкаар дамжуулан төлбөр тооцоо хийгдэхгүй тохиолдолд ҮЦТХТ -ийн харилцагчдын мөнгийг томоохон хэмжээний эрсдэлээс хамгаалсан байх шаардлагатай.

### 4. Үйл ажиллагааны эрсдэл ( Operational risk)

Үйл ажиллагааны найдвартай байдал ( Operational reliability)

- Үнэт цаасны қдиринг, төлбөр тооцоотой холбогдон гарч буй эрсдэлийн шалтгааныг цаг тухай бурт нь илрүүлж аль болох тохиромжтой систем бий болгох, хяналтын болон үйл ажиллагааны процедурыг сайжруулах замаар засаж залруулах. Систем нь өөрөө найдвартай, аюулгүй, бодит нөөц, хучин чадалдаа тохирсон байх ёстой. Урьдчилан төлөвлөлт болон дагалдах үйл ажиллагаа нь төлбөр тооцооны процесийг үе шаттайгаар сайжруулахад чиглэгдэх ёстой.

### 5. Кастодиан эрсдэл

Харилцагчдын үнэт цаасыг эрсдэлээс хамгаалах - харилцагчдын үнэт цаасыг хадгалж буй этгээд нь нягтлан бодох бүртгэлийн болон үнэт цаасыг бүрэн бүтэн найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн, мэргэшсэн боловсон хүчинээр хангагдсан байх ёстой. Харилцагчдын үнэт цаас нь кастодианы хөрөнгө оруулагчдын үнэт цааснаас тусгаарлагдсан, хамгаалаглан байх шаардлагатай

### 6. Бусад асуудал

Засаглал - Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон зах зээлд оролцогч компанийн засаглал нь олон нийтийн эрх ашиг, эздийн эрх ашиг, үйлчлүүлэгчдийн эрх ашигт аль алинд нь нийцсэн байх шаардлагатай.

Хандалт (access)- ҮЦТХ болон зах зээлд оролцогч компаниуд бодитой, олон нийтэд

Судалгааны эмхтгэл, XI боть

нээлттэй мэдээллийн критери гаргах, үнэнч шударга, аль болох нээлттэй хандалтын системийг бий болгох

Үрashiig (efficiency)- Найдвартай, аюулгүй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ харилцагчдын шаардлагад нийцсэн ажил үйлчилгээг өртөг зардлаа нэхсөн, ашигтай хэлбэрээр явуулах Олон улсын сүлжээ болон стандарт ( communication procedures and standards) – төлбөр тооцооны систем нь олон улсын харилцааны холбооны тохирсон системийг ашиглан хил дамнасан үйлчилгээ үзүүлэх стандарт болон технологийг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх Ил тод байдал / transparency / - төлбөр тооцооны болон зах зээлд оролцогчдын үйлчилгээг авч буй харилцагчдад эрсдэлээ тооцох, өртөг зардал болон үр ашгаа тооцож шийдвэр гаргахад нь шаардагдах үйлчилгээний болон бусад мэдээллээр хангах

Зохицуулалт болон хяналт / regulation and oversight / - Үнэт цаасны төлбөр тооцооны систем нь ил тод, үр ашигтай зохицуулалт, хяналтын дор байна. Төв банк болон үнэт цаасны зах зээлийг зохицуулах байгууллага нь өөр хоорондоо болон холбогдох бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллана. Олон улсын зах зээлд холбогдох чийн эрсдэлийг бууруулах - Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж нь үнэт цаасны олон улсын арилжааны системд холбогдох, эрсдэлийг бууруулах, олон улсын хэмжээнд төлбөр тооцоо гүйцэтгэх техникийн нөхцөлийг бүрдүүлэх

### **Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагууд, бусад орны туршлага**

#### **АНУ-ын туршлага**

АНУ-ын үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйлчилгээний байгууллагууд:

1. DTCC Depository Trust and Clearing Corporation
2. NSCC National Securities Clearing Corporation
3. GSCC Government Securities Clearing Corporation
4. MBSCC Mortgage - Backed Securities Clearing Corporation
5. DTC Depository Trust Company

**DTCC Depository Trust and Clearing Corporation:** DTCC 30 гаруй жилийн турш өөрийн сүлжээгээр дамжуулан автомат, төвлөрсөн, стандартчлагдсан хэлбэрээр хөрөнгийн зах зээлд нөлөө бүхий мэргэшсэн үйлчилгээ үзүүлж байна. Тус компани нь өөрийн салбаруудаар дамжуулан клиринг, төлбөр тооцоо болон мэдээллийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд хувьцаа, компанийн болон орон нутгийн, Засгийн газрын бонд, мөнгөний зах зээлийн хэрэгсэлүүд, дериватив арилжааны хэрэгсэлүүдийн клиринг - төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж байна. Мөн түүнчлэн хамтын сан, даатгал, холболтын сангүүд болон тэдгээрийн хооронд шилжүүлэг хийх сүлжээний лидер компани юм. DTCC –ийн депозитари нь АНУ болон 121 өөр орон, газар нутагт ойролцоогоор 34 триллион долларын 3.6 сая үнэт цаасны гаргалтын кастодиан болон хөрөнгийн шилжүүлгийн үйлчилгээг үзүүлж байна.

DTCC –ийн Thomson Reuters, Omgeo-той хамтарсан joint venture компани нь дэлхий 45 оронд 6000 гаруй харилцагчидтай. Арилжааны дараах процесс, мэдээллийн менежмент, брокерууд, хөрөнгө оруулалтын менежерүүд, кастодиан банкуудад чухал үүрэгтэй. DTCC-ийн Maerkit болон Market SERV -тэй хамтарсан joint venture компани нь DTCC Deriv/SERV болон Market wire арилжааны хэлцлийг баталгаажуулах томоохон платформ бөгөөд зээл, хүү, хувьцаа, таваарын дериватив зэрэг олон төрлийн хөрөнгийн арилжааны хэлцлийг биелүүлэхэд үйлчилгээ үзүүлнэ гэх мэт .

DTCC 10 салбартай, салбар бүр нь өөр өөрийн гэсэн онцлог чиг үүрэг, сегмент болон эрсдэлийн профилтэй байдаг. Үүнд:

- National Securities Clearing Corporation (NSCC)
- Depository Trust Company (DTC)
- Fixed Income Clearing Corporation (FICC)
- DTCC Deriv/SERV LLC / The Warehouse Trust Company LLC, DTCC Derivatives Repository Ltd.
- DTCC Solutions LLC / DTCC Loan/SERV LLC/
- EuroCCP Ltd.
- Avox Ltd.

**National Securities Clearing Corporation (NSCC):** DTCC-ын охин компани болох National Securities Clearing Corporation (NSCC) бол 1976 онд байгуулагдсан, clearing, төлбөр тооцоо, эрсдлийн удирдлага, хэлцэлд оролцогч талуудын үйлчилгээ, /central counterparty services/, хэлцэл биелэгдэх баталгаа гаргах чиглэлээр хувьцаа, корпораци ба орон нутгийн захирагааны өрийн бичг, америкийн хадгаламжийн гэрчилгээ, биржийн болон хөрөнгө оруулалтын сангудад үйлчилж байна.

NSCC –гийн сүлжээнд T+3 хугацаанд неттинг, клиринг, төлбөр тооцооны үйлчилгээ хийгдэх ба ойролцоогоор нийт хийгдсэн хэлцлийн 98% орчим нь энэ хугацаанд бүрэн хийгдэж байна. Үйлчилгээний төрлүүд нь:

- Automated Customer Account Transfer Service (ACATS)
- Continuous Net Settlement (CNS)
- Index Share Processing
- Trade Comparison and Reporting
- Real-Time Trade Matching (for fixed income securities)
- Reconfirmation and Pricing Service
- Settlement Services
- Stock Borrow Program

**Fixed Income Clearing Corporation (FICC):** 2003 онд байгуулагдсан, DTCC-ийн салбар бөгөөд Government Securities Clearing Corporation and the Mortgage-Backed Securities Clearing Corporation –тай хамтран тогтмол хүүтэй хэрэгсэлийн арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

**Depository Trust Company (DTC):** 1973 онд байгуулагдсан, DTCC-ын салбар компани. Үнэт цаас эзэмшигчдийн нэр дээр “book-entry” зарчмаар шилжүүлэлт хийх, клиринг, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. NSCC сүлжээнд болон интституциональ оролцогчдын /кастодиан банк хооронд, брокер-дилер хооронд, мөнгөний зах зээлд / төлбөр тооцоо хийх үндсэн чиг үүрэгтэй. Үзүүлж буй үйлчилгээнүүд нь:

- Custody & Safekeeping Services
- Underwriting Services
- Deposit & Withdrawal Services
- Dividend, Reorganization and Proxy Services
- Restricted Securities Family of Services
- Direct Registration Service

DTC нь АНУ-ын Холбооны Нөөцийн системийн гишүүн бөгөөд New York State банкны хуулиар /New York State banking law/ хязгаарлагдмал үүрэгтэй траст компани, АНУ-ын үнэт цаас биржийн комисс /the U.S. Securities and Exchange Commission (SEC)/-д

бүртгэлтэй, клирингийн агентлаг юм.

## ОХУ -ын туршлага

### Үнэт цаасны төлбөр тооцооны систем.

- Үндэсний хадгаламжийн төв /National Depository Centre (NDC)/
- RTS Fund Exchange-ийн төлбөр тооцооны систем
- Moscow Interbank Currency Exchange (MICEX)
- Бусад

**Үндэсний хадгаламжийн төв /National Depository Centre (NDC)/** Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, үнэт цаас өмчлөх эрх шилжүүлэх процессийг хурдастах, үнэт цаасны хадгаламжийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор 1997 онд ОХУ -ын Төв банк /Bank of Russia/ болон Moscow Interbank Currency Exchange (MICEX)-ийн хамтран байгуулсан ашгийн төлөө бус байгууллага.

NDC нь хөрөнгийн биржүүд болон бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран ажилладаг төвлөрсөн депозитарийн байгууллага. Үүнээс гадна биржийн гадуур зах зээл буюу over-the-counter зах зээлд оролцгчдын хоорондхи хэлцлийн үүргийн биелэлтийг “free delivery” нөхцөлөөр гүйцэтгэнэ. Үндсэн үйлчилгээнүүд нь:

- Кастодиан үйлчилгээнүүд
- On-exchange хэлцлийн төлбөр тооцоо
- OTC арилжааны төлбөр тооцоо
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг баталгаажуулах үйлчилгээ
- Үнэт цаас гаргагчтай холбоотой үйлчилгээ
- Мэдээллийн үйлчилгээ гэх мэт
- ISIN allocation

**RTS Fund Exchange settlement.** Оросын хамгийн анхны зохицуулалттай үнэт цаасны зах зээл бол RTS Stock Exchange нь 1995 онд байгуулагдсан, одоогоор мөнгөний зах зээлийн хэрэгсэлүүдээс авахуулаад фьючерс /commodity futures/ хүртэл бүх төрлийн санхүүгийн хэрэгслийн худалдаа хийдэг. RTS Group нь үнэт цаасны арилжааны хэлцлэ /central counterparty/, үнэт цаасны хадгаламж /the settlement securities depository/, төлбөр тооцооны /settlement house/ үйл ажиллагаа эрхэлдэг.

2000 оноос биржийн арилжааны эрх авч, ашгийн бус байгууллага болсон . Арилжаа нь бодит цагийн горимд тасралтгүй явагдана. / нэг ёсондоо биржийн гадуурхи арилжааны систем юм/ Хөрөнгийн биржийн арилжааны төлбөр тооцоо T+0 хугацаанд хийгддэг бол энэ системд төлбөр тооцоо ерөнхийдөө T+3 нөхцөлөөр хийгдэнэ. The RTS Fund Exchange бол Оросын хамгийн том мэдээллийн сайт, бүх төрлийн биржийн мэдээллээр хангадаг.

**Moscow Interbank Currency Exchange (MICEX).** Оросын хамгийн том, хамгийн олон биржийн өдөр тутмын мэдээлэл, харат бус шинжээчдийн үнэлгээ, үнэ ханшийн өөрчлөлт, дэд-индекс болон корпорацийн мэдээллийн баазыг агуулсан. Эдгээр мэдээлэл нь худалдаачид, шинжээчид, брокер, сангийн удирдлага болон хэвлэл мэдээллийнхэнд чухал ач холбогдолтой. 1992 онд ОХУ-ын Төв банк гадаад валют болон бусад санхүүгийн хэрэгслийг банк хоорондын зах дээр арилжаалах зорилгоор байгуулсан.

MICEX-ын тусламжтайгаар валютын ханшийн бодлого, бус нутгийн хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа. ОХУ-ын валют арилжааны холбоонд /the Association of Russian Currency Exchanges/ нэгддэг. ОХУ-ын Төв банктай гэрээний үндсэн дээр

үйл ажиллагаагаа уялдуулдаг. 1993-1995 онд ОХУ, Сангийн яамтай хамтран Organised Market of Securities and Other Financial Assets (OMS) –ын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж Засгийн газрын болон municipal үнэт цаас, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хэрэгсэлүүдийг арилжаалж эхэлсэн.

OMS-ын дэд бүтэц нь үндэсний хэмжээний 1, найман бүс нутаг дахь биржийн валют арилжааны үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Москва, Санктпетербург, Новосибирск, Нижний новгород, Ростовна Дону, Екатеринбург, Владивосток, самарт эдгээр салбарууд нь байрлаж байна. Арилжааны служээ, төлбөр тооцооны цахим сүлжээний технологи, software программ ашигладаг. Толгой хадгаламжийн үйл ажиллагааг Үндэсний хадгаламжийн төв /National Depository Centre (NDC)/ гүйцэтгэнэ.

Үйл ажиллагааны зарчим нь: Арилжаанд оролцогч этгээд ОMS төлбөр тооцооны төв болон NDC –д үнэт цаасны депо данстай, мөнгөн хөрөнгийн сантай байх ёстой. Энэ мэдээллийг OMS төлбөр тооцооны төв ба NDC нь MICEX-д мэдээлнэ.

MICEX ын оролцогч этгээдийн төлбөрийн үүргийг нийт фонд ба үнэт цаасны хадгаламжийн хэмжээнээс хөтүүлэхгүй байхыг батлана. Арилжаанд оролцогч этгээдийн net position болон захиалгын мэдээллийг MICEX –аас OMS төлбөр тооцооны төв ба NDC рүү илгээнэ. Тиймээс MICEX нь үнэт цаас ба фондын төлбөр тооцооны гүйцэтгэл нь DVP зарчимтай нийцсэнийг батална.

ОХУ-ын Төв банк OMS төлбөр тооцооны төвүүдийн хооронд төлбөр тооцоог зохион байгуулах ба удирдлага, хяналтын үүрэг гүйцэтгэнэ. ГКО, ОФЗ зах зээлийн хувьд үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн шилжүүлэг T+0 зарчмаар он-лайн явагдана.

Олон улсын Төвлөрсөн үнэт цаасны хадгаламж /International central securities depositories (ICSDs) /кастодион, clearing ба төлбөр тооцооны үйлчилгээнүүдийг нийлмэл зах зээлээс илүү өргөн хүрээтэй өр зээл болон энгийн хувьцаануудад үзүүлдэг. Эдгээр хадгаламжууд дотоодын үнэт цаасны хадгаламжууд руу өөрсдийн үйлчилгээгээ линкээр шууд эсвэл шууд бусаар (дотоодын кастодион -аар) үзүүлнэ.

Шилжүүлэх зааврын процесс, үнэт цаас шилжүүлэх систем ба төлбөр тооцоогоо шилжүүлэх систем нь худалдагч ба худалдан авагчдын эрх үүргүүд өөр өөр байдаг, хэд хэдэн үе шатыг агуулдаг. Үнэт цаасны эцсийн шилжүүлэг худалдагчаас худалдан авагч руу шилжүүлснээр гүйцэтгэгдэнэ, мөн худалдан авагчаас худалдагч руу эцсийн төлбөрөө шилжүүлснээр төлбөр тооцоо гүйцэтгэгдэнэ.

Олон төлбөр тооцооны системд үнэт цаасны эрх өмчлөгчдийг жагсаасан, үнэт цаас гаргагчийн тэмдэглэлтэй холбогдох бүртгэлийн дэвтэр байдаг. Бүртгэгч үнэт цаас өмчлөгчтэй холбогдон компанийн үйл ажиллагаа ба ноогдол ашиг гэх мэтийн тал дээр үнэт цаас гаргагчид туслана. Үнэт цааснууд эцсийн хөрөнгө оруулагчдын нэрээс илүү брокер-дилер эсвэл кастодионы нэрээр бүртгэгдсэн байж магадгүй байдаг.

Бүртгэлийн системийн үр дүнд нь clearing ба төлбөр тооцооны процесс агуулагддаг, учир нь энэ хялбаржуулсан байдал ба хурдтай цуг хуулийн өмчлөх бүрэн эрх шилжигдэнэ. Бүртгэлийн жагсаалтад бүртгэгдэх хүртэл өмчлөгчдөд хуулийн бүрэн эрх олгогдохгүй байх магадлалтай, тиймээс бүртгэл дуусах хүртэл төлбөр тооцооны процессад эцсийн шийдвэр амжилтгүй болох магадлалтай.

### **Хадгаламж уу эсвэл кастодион уу?**

“Кастодиан” буюу “кастодиан үйлчилгээ” хэмээх ойлголт харьцангуй сүүлд бий болсон . хэдийгээр кастодиан үйлчилгээний талаар мэргэжлийн түвшинд ч ихээхэн ярьдаг боловч

Судалгааны эмхтгэл, XI боть

энэ талаар нэгдсэн ойлголтодн хараахан хүрээгүй, энэ төрлийн үйлчилгээ төлөвшөөгүй байна. Кастодиан үйлчилгээг депозитари үйлчилгээтэй адилтгаж болох авч яг үнэндээ регистратор, депозитари, кастодиан үйлчилгээний хооронд ижил төстэй, ялгаатай асуудлууд олон байна.

Монгол улсын одоо мөрдөгдөж буй хууль “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөлд энэхүү үйлчилгээг хуульчлаагүй. 2010 онд батлагдсан “ Банкны тухай ” хуулийн -д арлжааны банкууд энэ төрлийн үйл ажиллагааг эрхэлж болохоор заасан . гэвч ҮЦТТХТ энэ чиглэлийн үйлчилгээг өөрийн эрхлэх үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа боловч бүрэн утгаар нь үйлчилгээ хэлбэржээгүй байна.

Түүхийн хувьд авч үзвэл депозитари гэдэг ойлголт харьцангуй эрт бий болсон . Өөрөөр хэлбэл банкны сейфийн үйлчилгээнэс авахуулаад үнэт цаас хадгалах, бүртгэх үйл ажиллагаа болон өргөжиж ирсэн. Үнэт цаасны зах зээлийн хөгжил сул, үнэтцаасны портфелийн хөрөнгө оруулалтууд сонгодог утгаараа хийгдэхгүй цөөхөн тооны компанийн хувьцаа арилжигдаж байгаа үед магадгүй депозитарийн хэрэгцээ бага байж болох юм.

Бие хэлбэрийн үнэт цаасны сертификат эзэмшигч депозит үйлчилгээгээр яах билээ, гэртээ хадгалаад л, шаардлагатай бол компани дээр нь очиж бичилт хийлгээд л болоо биш үү. Гэвч зах зээл хөгжихийн хирээр төрийн болон хувийн хэвшлийн үнэт цаасны томоохон багц эзэмшигчид, портфелийн хөрөнгө оруулагчид энэхүү үйлчилгээг авахаас өөр аргатгүй байдалд хүрсэн. Их хэмжээний үнэт цаас худалдан авсан этгээд үнэт цаасаа хадгалах, өмчлөх эрхээ гэрчлүүлэх, хэрэгжүүлэх, хурдан шуурхай арилжих, хөрөнгийн удирдлагаа сайжруулах үүднээс энэ төрлийн үйлчилгээг ихээхэн сонирхох болсон.

Өөрөөр хэлбэл, кастодиан гэдэг бол депозитарийн боловсронгуй хэлбэр юм. Кастодиан үйлчилгээнд юу юу хамаарах вэ?

- Үнэт цаасыг хадгалах, бүртгэх
- Төлбэрийн эсрэг нийлүүлэлт” зарчмаар үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх, үнэт цаасыг шилжүүлэх
- Үнэт цаасны хүү, ногдол ашиг хуваарилах
- Үнэт цаасыг хуваах, нэгтгэх, хөрвүүлэх
- Харилцагчийн итгэмжлэлээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх
- Татвар төлөлт, татварын хөнгөлөлт эдлэх эрхийг хэрэгжүүлэх, зөвлөгөө өгөх
- Үйлчлүүлэгчдэд хийгдсэн хэлцлийн талаар, үнэт цаасны портфелийн талаархи мэдээлэл өгөх
- Мөнгөн хөрөнгийн данс хөтлөх, нэг төрлийн болон олон төрлийн валютаар гүйлгээ хийх, валюту хооронд хөрвүүлэх, дансны үлдэгдэл хүү бодох, “repo” гүйлгээ хийх гэх мэт.

Мөн түүнчлэн,

- Хөрөнгө оруулалттай холбоотой мөнгөн урсгалын шинжилгээ хийх, үнэт цаасны дортфелийн шинжилгээ хийх,\
- Үнэт цаасны зээл олгох
- Үнэт цаасны портфелийн итгэмжлэгдсэн удирдлагатай холбогдох үйлчилгээ үзүүлэх

ОХУ-д үйлчилж байгаа хууль тогтоомжоор кастодиан суурь үйлчилгээний төрлүүд нь депозитари үйлчилгээний төрлүүдээс ялгаагүй бөгөөд нэмэлт үйлчилгээнүүдээс үнэт цаасны итгэмжлэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг одоогоор хуулиар

хориглосон байна. Кастодианы бас нэг чухал үйлчилгээ бол мэдээллийн үйлчилгээ юм. Ялангуяа хөрөнгө оруулагчдад мэдээллийн эрэлт хэрэгцээ маш их байдаг.

Тухайлбал, тухайн үнэт цаас гаргагчын улсын үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжид оруулсан өөрчлөлт, татварын хууль тогтоомжийн өөрчлөлт, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын талаархи мэдээлэл, үнэт цаас гаргагчийн зүгээс хэрэгжүүлэх гэж буй аж ахуйн шинжтэй томоохон арга хэмжээ, ногдол ашиг болон бондын хүү хуваарилалт, бондын төлбөр гүйцэтгэх, хувьцаа эзэмшигчдийн хурал, хэлэлцэх асуудал болон гаргасан шийдвэр, үнэт цаасны зах зээлийн байдал болон тодорхой сегментийн талаархи мэдээлэл, хөрөнгө оруулагчийн депо данс түүнд гарсан өөрчлөлт зэрэг мэдээллүүдийг хөрөнгө оруулагч хүсдэг.

Ялангуяа эдгээр мэдээллүүд үнэт цаасны портфелд гадаадын компанийн үнэт цаасыг эзэмшиж байгаагаадын кастодианы үйлчилгээнд хамрагдаж байгаа хөрөнгө оруулагчдад ихээхэн чухал. Хэдийчинээн хөрөнгө оруулагч зах зээлээс алслагдсан байна тэдийчинээн өөрийнхөө эзэмшиж байгаа үнэт цаасны хувь заяанд санаа зовж, мэдээллээр дутагдаж байх болно. Ийм учраас ихэвчлэн кастодиан үйлчилгээг мэдээллийн үйлчилгээтэй адилтгах бөгөөд нэг ёсондоо үнэт цаасны зах зээлийн “нүд” ба “чих” гэж үздэг байна.

### **Яаж кастодиан болох вэ?**

Одоогийн үйлчилж байгаа “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиар энэ төрлийн үйлчилгээ эрхлэхийг хүссэн байгууллага СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд депозитари үйлчилгээг эрхэлж болно. /ҮЦТТХТ/Хэрвээ арилжааны банк энэ төрлийн үйлчилгээг эрхлэхээр бол Тв банкны зөвшөөрлийг үндэслэн СЗХ эрх олгоно. ОХУ-д банкуудад энэ эрхийг Төв банк нь олгодог байна.

Тэгвэл, яаж кастодиан эрх авах вэ? Юуны өмнө кастодиан үйлчилгээг эрхлэх эрх зүйн болон эдийн засаг, зах зээлийн тааламжтай нөхцөл бүрдсэн байхаас гадна энэ үйлчилгээг эрхлэх хэмжээнд тухайн байгууллага өөрөө хөгжик бэлтгэгдэх ёстой. Жишээ нь, депозитарийг төрүүлж болно, харин кастодиан бол бэлтгэгдэх ёстой гэсэн хэлц үг байдаг.

Кастодиан үйлчилгээний хүрээнд эрхлэх ажил үйлчилгээнүүдийн жагсаалтаас харсан ч гэсэн энэ төрлийн үйлчилгээг банкууд эрхлэх нь илүү тохиромжтой гэдэг нь олон улсын практикт нотлогдсон байна. АНУ-ын 1940 онд батлагдсан “Хөрөнгө оруулалтын компанийн тухай” хуулийн 17f -5д зааснаар АНУ -ын хилийн чанадад кастодиан үйлчилгээ үзүүлэх найдвартай байгууллага бол тэдгээр улс орнуудын хууль тогтоомжид нийцүүлэн байгуулагдсан банк болон траст компаниуд юм. Иймд АНУ-аас тухайн улсын зах зээлд хөрөнгө оруулж буй инвесторууд кастодиан үйлчилгээг сонгоходоо энэхүү зарчмыг удирдлага болгодог байна.

Гадаад зах зээлд оролцоход олон улсын болон бус нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй гадаадад өөрийн салбар, сүлжээтэй кастодианууд ихээхэн тохиромжтой байдаг байна. Гадаадын хөрөнгө оруулагчид кастодиан банкыг сонгоходоо, хэрвээ өөрийн орны болон олон улсын хэмжээний кастодиан байхгүа тохиолдолд ихээхэн болгоомжтой хандаг байна. Тухайлбал, процедурын хувьд кастодианыг сонгоходоо эхлээд Request for Proposal буюу 100 гаруй тодорхой болон ерөнхий асуултуудыг багтаасан мэдээллийг гаргуулан авна, дараагаар нь шаардлагатай асуудлуудаар тайлбар, тодруулга авч, яриа хэлэлцээр хийх, газар дээр нь ирж үйл ажиллагаатай нь танилцах, үнэт цаас болон мэдээллийн сүлжээ, найдвартай байдал зэрэгтэй биечлэн танилцана. Хэрвээ боломжтой гэж үзвэл, кастодиан үйлчилгээний гэрээ хийх зарчмаар ажиллана.

Кастодиан үйлчилгээг сонгоходоо гадаадын компаниуд дараахь нөхцөл бүрдсэн эсэхэд

онцгойлон анхаарна. Тухайлбал:

- Үйл ажиллагаа нь харилцагчдын ашиг солнирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн эсэх
- Мэргэжлийн хувьд сайн бэлтгэгдсэн гадаад хэл дээр чөлөөтэй харьцах чадвартай ажилтнуудтай эсэх
- Харилцагчийг түүний багцад байгаа үнэт цаасны өртөг болон статусын талаархи мэдээллээр өдөр тутам шуурхай хангаж чадах эсэх
- Харилцагчдад үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, зах зээл дээр гарч буй өөрчлөлт, түүний тухайн харилцагчийн үнэт цаасны багцад үзүүлж болохуйц нөлөөллийн талаархи сээрэмжүүлэх болон шуурхай мэдээллийг цаг тухай бүрт нь өгч байх боломж бүрдсэн эсэх, өгдөг эсэх
- Цаг тухай бүрт нь найдвартай байдлаар” төлбөрийн эсрэг нийлүүлэлт”, “төлбөрөөс чөлөөлөгдсөн нийлүүлэлт”-ийн зарчмаар төлбөр тооцоо хийх чадвартай эсэх
- Төлбөр тооцоо гүйцэтгэх өдөртхэлцилийг бүрэн биулуулэх чадвар
- Харилцагчдыг дансны үлдэгдлийн талаархи үнэн зөв мэдээллээр хангах чадвар
- Депозитари болон кастодиан үйлчилгээний хүлээн зөвшөөрөхуйц хэмжээний хөлс, шимтгэл
- Мэдээллийг хүлээн авах дамжуулах, тоон мэдээлэл боловсруулах орчин үе ийн технологи, нягтлан бодох бүртгэлийн систем, харилцагчдын хүсэлтээр дансны болон үнэт цаасны протфелийн тайлан, гүйлгээний мэдээлэл зэргийг гаргаж өгөх боловсронгуй системтэй эсэх
- Олон улсын аудитийн SAS-70 системд нийцсэн депозатирийн гүйлгээ, тайлан мэдээний системийг практикт нэвтрүүлсэн эсэх
- Кастодиан байгууллагын удирдлага нь үйлчилүүлэгчдийн эрх ашигт нийцсэн төр засгийн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааны тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлж чадахуйц чадвартай эсэх

Мэдээжийн хэрэг эдгээр өндөр түвшний шаардлагыг хангах кастодиан одоогоор манайд байхгүй. Гэвч уул уурхайн хөгжил, сүүлийн үед зах зээлд бий болж байгаа нөхцөл байдлууд нь үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг боловсронгуй болгох, ялангуяа дотоодын зах зээл рүү гадаадын хөрөнгө оруулалтыг татахуйц хэмжээний дэд бүтцийг бий болгохыг шаардаж байна. Зах зээл буурай хөгжсөн орнуудын хувьд депозитари, кастодиан үйлчилгээ нь гадаадын оролцогчдын шаардлагыг хангахгүй байгаа тул гадаадын хөрөнгө оруулагчид ихэвчлэн Chase, Citi, ING, ABN AMRO Bank зэрэг дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын банкуудаар үйлчилүүлж байна. Эдгээр банкууд нь дэлхийн ихэнх орнуудад салбар, сүлжээтэй бөгөөд кастодиан үйлчилгээг эрхлэх туршлагатай байдаг байна.

Нэгэнт гадаадын хөрөнгө оруулагчдын өндөр хэмжээний шаардлагад нийцүүлэн кастодиан үйлчилгээг эрхлэх боломж бүрдээгүй байгаа тохиолдолд үндэсний кастодиануудыг бий болгох ядаж үндэсний хэмжээнд дотооддоо үйлчилгээ үзүүлэх, зах зээлийн хөгжлийг дагаад аянаа үйлчилүүлэгчдээс тавих шаардлага өндөрсөж энэ хэмжээгээр кастодиан үйлчилгээ төлөвшиж, хөгжих, улмаар олон улсын стандарт руу тэмүүлэх нь гарцаагүй.

Кастодиан гэдэг нь хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий депозитари банк юм. Ажил үйлчилгээ нь олон улсын стандарт болон тухайн улсын хууль тогтоомжоор тавигдаж буй шаардлагад нийцсэн байх бөгөөд өндөр түвшний мэдээллийн болон техникийн боломжийг бүрдүүлсэн дэд бүтэц, харилцаа холбоо, боловсон хүчинээр хангагдсан байх шаардлагатай.

## 1. Хөрөнгийн зах зээлд кастодианы үүрэг

Олон улсын практикаас харахад, хөрөнгийн зах зээлд кастодиан чухал үүрэгтэй. Хөрөнгийн зах зээлд оролцогчдын шударга бус өрсөлдөөн, хууль бус үйлдлээс харилцагчдын дансанд байгаа үнэт цаас, мөнгөн хөрөнгө найдвартай хамгаалагдсан байх ёстой. ҮҮний тулд депозитарийн үйл ажиллагаа эрхлэх бие даасан байгууллага байгуулдаг нь олон улсын жишиг. Гэвч зах зээлийн хөгжил сүл орнууд депозитарийг “бэк - оффис” маягаар зөвхөн брокерийн пүүсүүд тэдгээрийн харилцагчдад үйлчилгээ үзүүлэх маягаар ажиллуулж байна. Зах зээл мэдрэг биш, харилцагчид зах зээлд идэвхтэй оролцохгүй байгаа үед байж болох авч депозитийн талаархи мэдээллийг найдвартай хадгалах, зах зээлийн бусад мэдээллүүдээс тусгаарлах талаасаа учир дутагдалтай учир олон улсын кастодиан байгууллагуудтай иттеграцид орох боломжгүй юм.



Тухайлбал, ОХУ-д үнэт цаасны хадгаламж, төлбөр тооцооны төвлөрсөн байгууллага толгой компани хэлбэрээр байгуулагдаагүй. Национальный депозитарный центр,, Депозитарно-клиринговая компания, Депозитарно-расчетный союз зэрэг хэд хэдэн тусдаа компаниуд байдаг. Эдгээр компаниуд нь тус тусдаа, өөрийн гэсэн дүрэм журмаар үйл ажиллагаа явуулж, байнга дүрэм журмаа өөрчилж байгаа нь харилцагчдад хүндрэл учруулдаг байна.

Төвлөрсөн депозитарийг байгуулах нь зүтэй гэсэн үзэл санаа байвч амьдралд хэрэгжжэгүй банийа. ОХУ-ын УЦЗХ, СЯ, Төв банкны хамтарсан шийдвэрээр депозитари үйл ажиллагааг кастодиан болон төлбөр тооцооны депозитари гэж 2 ангилж байна. Кастодиан депозитарийн үйлчлүүлэгч нь брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаггүй, биржийн арилжаанд оролцогч этгээд биш байдаг. Тэгвэл төлбөр тооцооны депозитарийн харилцагчид нь биржийн арилжаанд оролцогч брокер, дилерийн компаниуд байдаг байна.

Кастодиан депозитари нь төрөлжсөн болон төрөлжсөн бус брокер, дилерийн үйл ажиллагааг эрхлэхгүй, гэхдээ регистраторийн үүргийг хавсрان эрхэлж болох, эсвэл тодорхой хөрөнгө оруулалтын санд үйлчлэх зэргээр төрөлжсөн байдаг. Төрөлжсөн бус кастодиан нь депозитари үйл ажиллагааг брокер, дилерийн үйл ажиллагаатай хавсарч болно. Гэхдээ регистраторийн үүрэг гүйцэтгэж болохгүй. Практикт заримдаа брокер депозитари ч гэж нэрлэдэг. Гэвч брокерийн компани кастодиан үйлчилгээ эрхэлнэ гэдэг нь практикт маш их зөрчилтэй асуудал. Харилцагчдад үзүүлдэг кастодиан үйлчилгээг брокерийн үйлчилгээтэй хавсрах нь ашиг сонирхолын зөрчлийг дагуулах маргаантай асуудал юм.

Судалгааны эмхтгэл, XI боть

ОХУ -ын хууль тогтоомжоор, кастодиан үйлчилгээг арилжааны банкууд, эсвэл санхүүгийн компаниуд эхрлэх ба ингэхдээ зөвхөн энэ төрлийн үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдийг охин компани, салбар хэлбэрээр ажиллуулахаар зохицуулсан байна. Хамгийн гол тавигдах шаардлага нь харилцагчдын дансны үлдэгдэлийн талаархи мэдээллийг нууцлах, депозитийн үйлчилгээний явцад олж авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглах зэргийг хориглосон хатуу зохицуулалттай байх ёстай.

Үнэт цаасны зах зээлийн тухай ярихдаа зөвхөн зах зээлд оролцогчид болон дэд бүтэц, эсвэл эргэлтэнд байгаа нийт үнэт цаасны тухай ярих асуудал биш энэ нь их өргөн хүрээтэй асуудал гэдгийг бодолцох ёстай. Тухайлбал, зах зээлд гаргасан зөвхөн 1 төрлийн үнэт цаас гэхэд өөрийн гэсэн зах зээлийн эргэлтийг бий болгож байдаг. Зах зээлд оролцогчид өөрсдийн санаснаар тухайн үнэт цаасны котировкид өөрчлөлт оруулах, үнэ ханшийг өсгөх бууруулах замар мөнгө хийх" боломж нь байдаг учраас харилцагчдын дансны талаархи мэдээллийг тусгаарлах, нууцлах нь ҮЦЗЗ-ийн чухал асуудал байдаг.

### **Кастодианы тулгамдсан асуудлууд**

Кастодиан болон кастодиан депозитарийн хувьд дараах асуудлууд тулгардаг. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийндэд бүтэц, эрх зүйн орчин сул
- Үнэт цаас гаргагчийн талаар болон санхүүгийн байдлын талаархи мэдээлэл хомс
- Үнэт цаасны бүртгэгч, регистраторын бүртгэлд байгаа үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл найдвартай хамгаалагдаж чадаагүй, техникийн болон бусад шалтгаанаар мэдээллийн бааз устаж үгүй болох магадлалтай
- үнэт цаас гаргагчдын зүгээс хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, ногдол ашиг олгохгүй байх
- үнэт цаас гаргагчдын зүгээс сэтгэл зүйн хувьд хөрөнгө оруулагчдын эрх ашигт үйл ажиллагаагаа нийцүүлэх сонирхол бага
- үнэт цаасны үйл ажиллагааны шимтгэл хураамж, татварын нөхцөл үйлчлүүлэгчдийг татах хамжээнд бус
- жижиг депозитари компаниуд өөр хоорондоо уялдаатай ажиллах, төвлөрсөн хадгаламжийн нэгдсэн систем дотроо үнэт цаасны депозитарийн компаниудын хооронд үнэт цаасны хөдөлгөөн хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн төвлөрсөн хадгаламжийн/толгой / төв байхгүй байх гэх мэт.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв байхгүй байгаа явдал нь гадаадын хөрөнгө оруулагчид, ялангуяа портфелийн хөрөнгө оруулагчдыг татахад сөрөг нөлөөтэй байна. ОХУ-д гэхэд 1998 онд Төвлөрсөн хадгаламжийн системийг бүрдүүлэх Засгийн газрын тогтоол гарч үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигчдийн талаархи мэдээллийг нэгдсэн байдлаар хадгалах үүрэгтэй болохыг заасан байна.

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд / тухайлбал, НУ-д DTC Германд- DTV, Францад- SICOVAM / гэх зэргээр төвлөрсөн депозитарийг байгуулсан, ОУУЦЗХ-ны зөвлөмжид ч мөн энэ төрлийн нэгдсэн систем байж болохыг зөвлөсөн байдаг. Хэрвээ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн нэгдсэн төв байх тохиолдолд кастодиан болон төлбөр тооцооны депозитари үйлчилгээ эрхэлдэг компаниудын хувьд нэг корреспондент данстай байхад хангалттай бөгөөд төвлөрсөн хадгаламжийн төв нь бүх гаргасан үнэт цаасны хувьд номинал эзэмшигч байх боломжтой.

Үүнээс үзэхэд төвлөрсөн депозитари нь хөрөнгө оруулагчидтай шууд харьцаж үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй бөгөөд өөрийн сүлжээнд харьяалагдаж буй бусад кастодиан болон төлбөр тооцооны депозит компаниудаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлэх

нөхцөл бүрдэнэ. Гэхдээ төвлөрсөн хадгаламжийн төв нь эдгээр жижг депозитариуттай өрсөлдөгч байж болохгүй бөгөөд үйл ажиллагаа нь дараахь З чиг үүргээр хязгаарлагдана. Үүнд:

- Төвлөрсөн хадгаламжид нээгдсэн бусад кастодиан болон төлбөр тооцооны депозитари компаниудын корреспондент дансанд гүйлгээ хийх, үнэт цаасны сертификатийг хадгалах
- Өөрийн сүлжээний кастодиан ТТД-иудын корреспондент данс хооронд “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчмаар үнэт цаасны хэлцлийн үр дүнд үнэт цаас шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх
- Бусад кастодиан ТТД-уудыг өөрийн харилцагчиддаа үнэт цаас гаргагч болон зах зээлийн талаархи мэдээллэр хангах нөхцөлийг бүрдүүлэх

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийг тусгайлан байгуулах нь дараахь ач холбогдолтой. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдын эрхгийг үнэт цаас эзэмшигч гэдэг утгаар нь найдвартай батлгаажуулах
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчлүүлэгчиддээ өөрийн харьяа кастодиан, бусад ТТД-уудаар дамжуулан хүртээмжтэй, үр ашигтай, шуурхай, мэргшсэн үйлчилгээ үзүүлэх, зах зээлийг идэвхжүүлж хүрээг нь тэлэх, портфелийн хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын багцаа сайжруулах, диверсификац хийх боломжтой болгох

Дээрхи 2 зорилгыг хэрэгжүүлсэнээр үнэт цаасны зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийг идэвхжүүлэх нөхцөл боломжтой. Өөрөөр хэлбэл, тухайн улсын доторхи төвлөрсөн хадгаламжийн систем дотроо харилцагчдын депо дансны хооронд үнэт цаасыг шуурхай шилжүүлэх нөхцөл бүрдсэнээр биржийн болон биржийн гадуурхи арилжааны систем идэвхтэй хөгжих боломж бүрдэнэ. Ялангуяа биржийн гадуурхи арилжааны систем идэвхитэй хөгжих нь зах зээлд жижг хөрөнгө оруулагчид, хувь хүмүүсийг татан оролцуулах, хөрөнгө оруулалтын потенциалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Гэхдээ хамгийн гол нь Төвлөрсөн хадгаламжийн системийн системийн хувьд өөрийн корреспондентуудтай харилцах универсал технологийн системийг бүрдүүлэх асуудал туйлын чухал.

Энэ нь юуны өмнө МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ - ДАМЖУУЛАХ СИСТЕМ байх болно. Тухайлбал, S.W.I.F.T сүлжээг ашиглан тусгай форматаар, телексээр корреспондентийн хүссэн газраас алслагдсан орон зайд хандалт хийх боломжийг Төв депозитарийн хувьд бусад корреспондентууддаа бүрдүүлж өгөх шаардлагатай.

Төвлөрсөн хадгаламжийн төв нь Төрийн мэдэлд /төрийн өмчтэй/ байх бөгөөд ийм хэмжээний технологийн өндөр хүчин чадалтай мэдээлэл дамжуулалтын систем бүрдүүлэх нь өндөр зардал шаардах ажил юм. Гэвч төрөөс санаачлага гаргаж энэ асуудлыг шийдэж өгч чадахгүй байгаа зарим орны хувьд, тухайлбал ОХУ-д, хамгийн тохиромжтой арга бол үнэт цаасны зах зээлд оролцогчид, бусад кастодиан депозитари компаниуд хамтран төрийн оролцоотой ашгийн бус байгууллагыг байгуулдаг туршлага байна. Тухайлбал, ОХУ-д Национальный депозитарный центр /Үнэт цаасны Үндэсний хадгаламжийн төв/-ийг өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан туршлагад нь тулгуурлан төвлөрсөн хадгаламж хэлбэрээр өөрчлөн байгуулж байна.

Үүний тулд Үнэт цаасны зохицуулах байгууллага /СЗХ/-ноос санаачлага гарган үнэт цаасны зах зээлд оролцогчид, үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчид болон зах зээлийн хөгжлийн ирээдүйн ашиг сонирхолыг нэгдсэн байдаар, хангах, зохицуулах үүргийн хүрээнд асуудлыг Засгийн газар холбогдох байгууллагуудад хандан тавих, “ хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрт тусгуулах талаар санаачлагатай ажиллах

Эхний ээлжинд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн мэдээллийн сүлжээг байгуулах асуудлыг шийдвэрлүүлсэнээр үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн асуудал төгс хэлбэрээр шийдвэгдэж, “Банкны тухай” хуульд заасан эрхийн дагуу арилжааны банкууд болон бусад этгээдүүд үнэт цаасны зах зээлд кастодиан болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдэх ба зах зээл одоогийн зогсонги байдлаас гарч хүрээ нь тэлэх, улмаар олон улсын зах зээлд интеграцчилагдах нөхцөл бүрдэнэ.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН БОДЛОГЫН УЯЛДАА  
ХОЛБОО, ИРГЭДИЙН ОРОЛЦОО**

Ц. Нороөвондоог (Ph. D), Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа,  
Ц. Болормаа, Г. Билгээ

**Агуулга:**

1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын сургаалиудын харьцуулалт, чиг хандлага
2. Монгол улсын нийгэм - эдийн засаг дахь төрийн бодлого, хэрэгжилт, үр дүн, уялдаа холбоо
  - 2.1 Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн уялдаа холбоо
  - 2.2 Монгол улсын нийгэм - эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
3. Төрийн бодлого ба иргэдийн оролцооны асуудал
4. Дүгнэлт, зөвлөмж

\* \* \*

**Оршил**

Монгол улс сүүлийн 20 гаруй жилийн туршид нийгэм - эдийн засгийн тогтолцоогоо зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцүүлэх шилжилтийн эдийн засгийн болон тогтвортжуулалтын бодлогыг хэрэгжүүлж, улмаар эдийн засгийн өсөлтийг хангасны үндсэн дээр хүний хөгжилд тулгуурласан нийгмийн чиг баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх зорилт тавин хэрэгжүүлж байна. Гэвч төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог бүрэн шинэчилж эдийн засаг, нийгмийн харилцааны цоо шинэ дэглэмийг тогтоох процесс Монгол улсад хэрхэн явагдаж байгаад дүн шинжилгээ хийх, төрийн бодлогын онолын үзэл баримтлал, уялдаа холбоо болон практик үр дүнг харьцуулан судлах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Асуудлыг судлахдаа төрийн нийгэм эдийн засгийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжаа нь ямар байгааг тодруулах, өнгөрсөн хугацаанд төрөөс явуулсан бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, уялдаа холбоо, мөн иргэний нийгмийн оролцоо ямар байгааг судалгаагаар харуулахыг зорьсон болно.

**1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онолын сургаалиудын харьцуулалт, чиг хандлага**

Нийгэм-эдийн засаг дахь төрийн бодлогын уялдаа холбоо нь үндсэндээ эдийн засагт гүйцэтгэж буй төрийн үүргийн тухай асуудал юм. Онолын хувьд меркантилизмаас авахуулаад неоинституционализм, орчин үеийн нийгмийн ардчилсан үзэл/ социал демократизм/ хүртэл онолын сургааль үзэл баримтлалууд бүрэлдэн бий болж хөгжлийн шат бүхэнд өөрийн өвөрмөц загвар, практик хэрэглээг бий болгосон бөгөөд тухайн онол, үзэл баримтлал бүрт эдийн засагт гүйцэтгэх төрийн үүрэг роль харилцан адилгүй байсан байна. Практикаас харахад, улс орон бүр өөрийн орны хөгжлийн өвөрмөц нөхцөл байдал, урт болон богино хугацааны зорилтоосоо хамааран төрийн үүрэг ролио тодорхойлсон байдаг.

Зах зээлийн эдийн засаг дахь нийгэм-эдийн засгийн харилцаа нь нэг талаас, аж ахуйн

харилцаанд орж буй субъектуудын харьцангуй “эрх чөлөөтэй” байх объектив хүсэл сонирхол, нөгөө талаас нийтийн эрх ашгийн үүднээс төрийн бодлогоор “дэглэм” тогтоох субъектив сонирхолын харилцан хамаарлаар илэрч байдаг. Төрийн зүгээс эдийн засгийн суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн харилцаанд оролцогч субъектуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, нийгэм-улс төрийн тодорхой зорилго, зорилтыг ханган биелүүлэх үүргийг хүлээнэ.

Төрийн оролцоо, үүрэг роль нь эдийн засаг, нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээг тогтооход оршино. Төр үүргээ биелүүлэхдээ өмчлөгч хэлбэрээр эдийн засгийн харилцаанд шууд оролцох буюу эсвэл зах зээлийн механизмуудыг ашиглан шууд бусаар оролцож байдаг. Гэвч орчин үед төрийн зохицуулалт нь улам бүр хэлбэржиж, комплекс шинж чанартай болж байна. Тухайлбал:

- Төрд материаллаг болон мөнгөн хөрөнгийн ихээхэн хуримтлал бий болж, эдийн засгийн болон захиргааны арга хэрэгсэлүүдийг ашиглан эдийн засгийн гадаад болон дотоод хүчин зүйлд нөлөөлөх боломжтой болсон учраас төрийн бодлого илүү төвлөрсөн шинжтэй болж байна.
- Төрийн зүгээс урт болон богино хугацаанд бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж аж ахуйн үйл ажиллагааны бүх түвшинд, бүх салбарт нөлөө үзүүлэх боломжтой учраас зохицуулалтын цар хүрээ нь өргөн байна.
- Төрийн бодлого, үйл ажиллагаа тасралтгүй тогтмол шинжтэй болсон.
- Төрийн зүгээс эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон захиргааны олон арга хэрэгсэлүүдийг ашиглах боломжтой болсон.

Практикаас үзэхэд, төрийн бодлого тодорхойлох үйл явц нь нарийн төвөгтэй , илүү шинжлэх ухаанд тулгуурласан байх шардлагатай ба ийм ч учраас нэр хүнд бүхий эдийн засагчид, шинжлэх ухааны томоохон зүтгэлтнүүдийг төрийн бодлого тодорхойлох үйл ажиллагаанд татан оролцуулах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч Кеннедигийн 16 эдийн засгийн зөвлөхийн нэг нь П.Самуэлсон, Ерөнхийлөгч Рейганы эдийн засгийн зөвлөх нь М.Фридман нар байжээ.

Эдийн засгийн онол бол зүй тогтолт хөгжлийн загвар, сайтар бодож боловсруулсан бодлого, хөтөлбөр юм. Онол өөрөө өөрчлөгдэн хувьсаж улам бүр боловсронгуй болсоор байна. Иймд онолын урсгалууд дахь төрийн үүрэг ролийн талаархи үзэл баримтлалуудыг харьцуулан судлах нь хөгжлийн зөв тактик, бодлогын хувилбарыг тодорхойлоход тустай юм. Иймд сэдвийн хүрээнд онолын сургаалиудыг харьцуулан судалж, тэдгээрийн онцлогийг практик хэрэглээ талаас нь системчлэн харуулсан болно.

- 15-р зууны үед бий болсон **меркантилист** онолд(гол төлөөлөгчид- )анх удаа эдийн засаг дахь төрийн үүрэг роль, зорилго, арга хэрэгсэлүүдийг тодорхойлсон байдаг.
  - Төр нь зах зээлийн эдийн засаг хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн бүх хэлбэр чөлөөтэй оршин тогтоно эрх чөлөөг олгох
  - Төрийн зүгээс анхны капиталын хуримтлал болон шинэ анги давхаргуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх
  - Төр үүргээ гүйцэтгэхийн тулд хүчтэй, шийдвэртэй, хатуу төвлөрсөн бодлоготой байх ба зах зээлийн механизmtай үйл ажиллагаагаа уялдуулах шаардлагатай гэж үзсэн
- **Классик онол** (Гол төлөөлөгчид – А. Смит, Д. Рикардо) нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн онол юм. Зах зээлийг үл үзэгдэгч гар удирдах ба зах зээл өөрөө өөрийгөө зохицуулах чадвартай гэж үздэг. Үг онолоор эдийн засаг дахь төрийн оролцоог үндсэнд нь угүйсгэх ба төрийн зүгээс зөвхөн:
  - Улс оронд дэг журам тогтоох

- Улс орны гадаад аюулгүй байдлыг хангах
- Төрийн санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулах
- Засгийн газрын зайлшгүй зардалыг нөхөх хэмжээнд татварын хувь хэмжээг тогтоох

ёстай гэж үздэг.

- **Марксист онолд** (гол төлөлөгчид- К. Маркс, Ф. Энгельс төрийн бодлогын эдийн засгийн болон улс төрийн хүчин зүйлийн харилцан хамаарлыг гаргаж ирсэн. Эдийн засгийн хүчин зүйл шийдвэрлэх нөлөөтэй боловч улс төрийн хүчин зүйл үүнд нөлөөлнө, төр засаг бие даасан үүрэг ролтой гэж үзсэн. Хөрөнгөтний нийгмийг чөлөөт коммунист нийгмээр солих шилжилтийн эдийн засгийн бодлого хөтөлбөр нь өмч хөрөнгө, эрх мэдлийг төр засагт төвлөрүүлж төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны үндсэн дээр бүх хүмүүс тэгш хөдөлмөрлөх, тэгш хүртэх зарчим дээр тулгуурласан байна.
- **Неоклассик онол** (гол төлөөлөгч - А. Маршалл) нь классик онолын үргэлжлэл бөгөөд чөлөөт өрсөлдөөний эдийн засаг нь дотоод мөн чанараараа тогтвортой байдаг, төрийн зохицуулалт шаардлагагүй гэж үздэг. Төрийн бодлогоор эдийн засгийг тогтвортжулах оролдлого нь үр ашиггүй бөгөөд энэ нь нийт эрэлтэд нөлөөлөх боломжгүй. Зах зээл өөрөө өөрийгөө зохицуулах зарчим нь төрийн оролцоог бүрэн угүйсгэдэг. Төгс өрсөлдөөний зах зээлд төрийн оролцоо шаардлагагүй, төгс бус өрсөлдөөний үед төр оролцож өрсөлдж буй үйлдвэрлэгчдийг зохицуулах ёстой. Жишээ нь:
  - Зүй ёсны монопольд төрийн зүгээс үнийг хянах, үнэ тариф тогтоох, алдагдалыг төсвөөс санхүүжүүлэх, буцаан нийгэмчлэх гэх мэтээр зохицуулалт хийх.
  - Тэнцвэржүүлэх татвар, татаасын бодлого хэрэгжүүлэх. Үйлдвэрлэлийн явцад нийтийн эрх ашигт хохирол учрах, эсвэл боломж нэмэгдэх үед авдаг нэмэлт татвар тогтоох буюу компенсаци олгох.
  - Нийтийн хэрэглээнд зориулан нөөц бүрдүүлэх (батлан хамгаалах, байгаль орчин, дэд бүтэц, нийгмийн хэв журам сахиулахад гэх мэт)

Неоклассик онолоор үндэсний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд микро эдийн засгийн онолын үүднээс төр дараахь бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Чөлөөт өрсөлдөөний орчинг бүрдүүлэх
- Мөнгөний массыг тогтвортой байлгах /орлого, зарлага төсвийн алдагдалаа хянах/
- Гадаад эфектэд компенсаци хийх
- Нийтийн хэрэглээний нөөц бүрдүүлэх
- ОҮ-ын төлбөр тооцоо, валютын ханшийг зохицуулах
- **Кейнсийн онолд** (Дж. Кейнс, А. Маршалл ) эдийн засгийн шинжлэх ухааны онолд төрийн оролцоог илүү тодорхой болгосон байдаг. Дайны дараахь үе, хямралын үеүдэд эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн оролцоо илүү чухал байсан тул:
  - Төсвийн зардлыг бууруулах, орлого зардлыг тэнцвэржүүлэх
  - Төсвийн алдагдалыг ЗГ-ын үнэт цаас болон эмиссийн аргаар санхүүжүүлэх
  - Мөнгө-зээлийн бодлогыг төсвийн бодлоготой нийцүүлэх гэх мэтийн макро эдийн засгийн бодлого явуулах. Ингэхдээ Төв банк инфляцийг дарангуйлах мөнгөний хатуу бодлогоос илүүтэй үр ашигтай эрэлтийг дэмжсэн бодлогыг эдийн засгийн мөчлөгт тохируулан явуулах шаардлагатай гэж үздэг. Кейнсийн онолд төсвө-мөнгөний бодлогыг уялдуулах, ингэхдээ төсвийн хатуу бодлого, мөнгөний зөөлөн

бодлого явуулах нь үр ашигтай гэдгийг нотолсон.

- **Неолибералист онол** (Людвиг Эрхард Баруун Герман) нь дэлхийн 2-р дайны дараагаас 60-70 оны хямралын үе хүртэл Баруун Германанд хэрэгжүүлсэн эдийн засгийн бодлого юм. Дайны дараах эмх замбараагүй байдлыг цэгцлэх үүднээс реформын шинжтэй хэд хэдэн арга хэмжээг төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн. Тухайлбал:
  - Эдийн засгийн шинэчлэлийг мөнгөний бодлогын шинэчлэлтэй хамтруулан явуулж 100 рейсмаркийг 6,5 ДМ -аар солих, өрийг хүчингүй болгох, Засгийн газраас хараат бус төвлөрсөн банкийг байгуулах зэргээр инфляцийг бүрэн хяналтанд авсан.
  - Нийгмийн шинжтэй томоохон реформуудыг хүрээнд ажиллах хүчиний чөлөөт зах зээлийг бий болгох, нийгмийн даатгалын системийг өөрийгөө зохицуулах зарчимд шилжүүлэх, ажилчид болон эмзэг бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, орон сууцны хангамжийг сайжруулах, хувьд өмчлүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх гэх мэт..
- **Неоконсерватизм** (М. Фридман) 1970 аад оны үед АНУ (рейганомика) болон Англи (тетчеризм)-д амжилттай хэрэгжүүлсэн төрийн бодлого. Уг онолоор, зах зээл болон өрсөлдөөн нь зохицуулалтын хамгийн сайн механизм мөн боловч урт хугацаандаа нийлүүлэлтийг дэмжсэн төрийн зохицуулалт үр ашигтай гэж үздэг. Төрийн зохицуулалтын бодлого нь хэрэглээг биш хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх, орлогын тэгш бус байдлыг арилгах, мөнгөний бодлого, татварын бодлогыг сайжруулах замаар төсвийн алдагдалыг бууруулах, инфляцийг тодорхой хэмжээнд зөвшөөрөх гэх мэт бодлогын арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн.
- **Институционализм** (У. Митчелл ) Үүссэн шалтгаан нь нийгмийн чиглэлийн бодлогыг түлхүү анхаарах, хөгжих буй орнуудын хөгжлийн эрс тэс ялгааг арилгах гэх мэтийн хүчиний зүйлс 20-р зууны дундуур бий болсон. Гол үзэл баримтлал нь эдийн засагт төрийн оролцоо буюу төлөвлөлтийн арга зайлшгүй бөгөөд хими, машин үйлдвэрлэл, электроник, шинжлэх ухааны салбар зэрэг салбарууд , өндөр технологид суурилсан эдийн засаг нь хөгжлийг хурдасгах гол түлхүүр гэж үзсэн. хүчин зүйл мөн гэж үздэг.
- **Неоинституционализм** (Р. Кроуз) 1970-аад оны сүүлчээр “нийтийн хэрэглээний нийгэм” гэх ойлголт бий болж зах зээлийн эдийн засгийн зохицуулалтын зарчмууд тодорхой болж эхэлсэн. Неоинституционал онолд улс төр судлал, эрх зүйн болон нийгмийн шинжлэх ухааны олон асуудлуудыг орчин үеийн микро эдийн засгийн онол болон тоглоомын онол, нийгмийн зөвшилцлийн онолын тусламжтайгаар тайлбарласан. Бие хүн бол анхдагч, институт-хоёрдогч боловч хувь хүний үйлдэл, ашиг сонирхолоос хамт олны, нийгмийн үйлдэл шалтгаална гэсэн ерөнхий санааг дэвшүүлсэн. Төрийн үүрэг ролийг төр – иргэн хоорондын эрх үүргийн хуваарилалтаар тодорхойлж Үндсэн хуулиар баталгаажуулсан явдал юм. Нийгэм - эдийн засаг - экологийн баримжаатай эдийн засаг хэмээх ойлголт бий болсон.
- **Социал демократизм** (Тони Блейр, Герхард Шредер, Билл Клинтон). 1980-аад оноос хойш нийгмийн хөгжлийн чиг хандлагыг зах зээлийн үр ашигтай систем ба нийгмийн хамгаалал, шударга ёсны чиг хандлагатай хослуулах тухай онолын үзэл баримтлал бий болсон. Уг үзэл баримтлалыг хэрэгжүүлэгч гол төлөөлөгчид нь Их британий ерөнхий сайд Тони Блейр, Германы канцлер Герхард Шредер, Билл Клинтон нар бөгөөд Социнтернийн гишүүн орнуудын улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгалаа олох болсон.
- Онолын хувьд, хөгжлийн ямарч үе шатанд, ямар ч ч түвшинд зайлшгүй баримтлах

Төрийн бодлогын зарчим бол – зах зээлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн механизмуудын сөрөг үр нөлөөг бууруулахад чиглэгдсэн байх ёстой, өөрөөр хэлбэл, төрийн бодлого нь зах зээлийн бодит механизмтай байнгын зөвшилцөлд байх ёстой гэсэн нийтлэг зарчим юм.

Төрийн бодлого оновчтой, үр дүнтэй байх нь дараахь хэд хэдэн нөхцөлөөс шалтгаална. Үүнд:

- Зах зээлийн бодит механизм нь ургалаар зохицуулагддаг учраас бодит нөхцөл байдлыг хурдан мэдэрч зохицуулж чадаагүйгээс төрийн бодлого шийдвэр **цаг хугацааны хувьд хоцорч гарах**, ингэснээр хямралыг үүсгэхэд хүрдэг
- Төрийн бодлого олон нийт, нийгмийн эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцээгүйгээс хэрэгжих боломжгүй болдог.
- Төрийн эдийн засгийн бодлогыг үр ашигтай болгохын тулд нийгэм дэх цөөнхийн эрх ашигт бус, **олон нийтийн эрх ашигт нийцсэн** бодлого шийдвэр гаргах,
- Төрийн бодлогыг боловсруулахдаа эдийн засгийн загварчлал, математик анализын аргуудыг ашиглан **эдийн засгийн төлөв байдлыг шинжлэх, прогноз хийх шаардлагатай**. Ингэснээр болзошгүй хямрал, бодит байдлыг мэдрэх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох улмаар шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах боломж бүрддэг.
- Төрийн эдийн засгийн бодлого үр ашигтай хэрэгжих нэг хүчин зүйл бол **бодлогын уламжлал** юм. Бодлогын уламжлал алдагдах нь төрийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх чадвар дутмаг, хэт улс төржсөн байдлаас үүдэлтэй. Улс төрчдийн оролцоо хэдийчинээн бага байнав, төрийн бодлогын хэрэгжилт төдийчинээн сайн байна.

Макро эдийн засгийн бодлогын хувьд авч үзвэл, тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэх түйлын зөв ганц хариулт гэж үгүй. Төрийн бодлогыг аль нэгэн онолын чиг баримжаагаар явуулна гэдэг нь олон янзын онолын ургалуудыг эмх замбараагүй хуулбарлан дууриах, хэлбэр төдий хэрэгжүүлэх, эсвэл аль нэг онолыг хатуу баримтлах тухай асуудал биш юм. Бодит нөхцөл байдал, ойрын болон урт хугацааны бодлого, зорилтдоо нийцүүлэн нэгтгэн боловсруулж, үр дүн өгөхүйц элементүүдийг нь сонгон авах, цогц байдлаар практикт хэрэгжүүлэх диалектик процесс юм.

Монгол улс 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжиж байх үед эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдал хүнд, туршлага дутмаг байсан учраас төрийн бодлогыг тодорхойлоход бэрхшээлтэй байсан. Гэвч 20 гаруй жилийн түүхэн хөтөлбөрийн хугацаанд төрийн үүргийн тухай онолын болон практик ойлголт цэгцэрч төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах шаардлага улам нэмэгдэж байна.

## 2. Монгол улсын нийгэм эдийн засаг дахь төрийн бодлого, хэрэгжилт, уялдаа холбоо, үр дүн

Энэ асуудлын хүрээнд Монгол улсын нийгэм-эдийн засаг дахь төрийн бодлогын уялдаа холбоог дараахь асуудлуудын хүрээнд авч үзлээ. Үүнд:

- ✓ Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоо
- ✓ Монгол улсын нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын арга хэрэгсэлүүд, бодлогын хэрэгжилтийн үр дүн
- ✓ Төрийн бодлого тодорхойлоход иргэдийн оролцоо

## 2.1 Монгол улсын төрийн бодлогын стратеги зорилт, тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоо

Монгол улсад УИХ болон Засгийн газраас тогтоолоор баталсан 1000 гаруй бодлогын болон стратегийг баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг гэсэн статистик тоо байна. Үүнээс ЗГ-ын түвшинд хэрэгжиж байгаа үндэсний хэмжээний 177 төсөл, хөтөлбөр байгаагаас нийгэм, эдийн засгийн чиглэлийн 60 гаруй бодлогын хөтөлбөр хэрэгжиж байна. Монгол улсын хэмжээнд төрийн бодлого тодорхойлж буй стратегийн гол баримт бичгүүдэд тусгасан урт болон дунд хугацааны үндсэн зорилтууд нь:

1. УИХ-ын 1996.05.03 өдрийн №26 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” -д тусгаснаар Монгол Улс ойрын ирээдүйд оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын баримжаатай, харьцангуй биеэ даасан эдийн засагтай, үйлдвэржсэн орон болно”.
2. Энэхүү зорилтыг 1996-2020 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосон (1996-2000 ) онд эдийн засгийг тогтвортжуулан сэргээж, цаашдын өсөлтийн үндсийг тавих, хөгжилд шаардлагатай хуримтлалыг бий болгох үе, (2001-2010) онд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн түүний экспортод баримжаалсан чиглэлийг хүчтэй болгох, (2010-2020) онд эдийн засгийн голлох салбаруудад үндэсний болон дэлхийн өндөр технологийг нэвтрүүлж Монгол Улсын өрсөлдөх чадварыг бий болгох, улмаар экспортод баримжаалсан оновчтой бүтэц бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай орон болох зорилтыг дэвшүүлжээ.
3. УИХ-ын 2008.01.31 өдрийн №12 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг дор дурдсан зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх”-ээр зорилтоо дэвшүүдсэн байна. Үүнд:

- мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, монгол хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологт, суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно.
- стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг хангаж, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон арга чадавхийг бий болгох, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгоно.
- улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлнэ гэсэн байдал.

**Монгол Улсын хөгжлийн 2 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Монгол Улс экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн стратегийг сонгож байна”**

4. УИХ -ын 2008.11.21 өдрийн №35 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 -т Үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилтыг дэвшүүлсэн .
5. УИХ-ын 2010.07.09 өдрийн №45 тоот тогтоол “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Хүний хөгжлийг хангах макро эдийн засгийн бодлого хүрээнд
  - Макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүний хөгжлийг хангахад чиглүүлнэ.
  - Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэнэ гэсэн зориултуудыг дэвшүүлсэн байна.
6. УИХ-ын 2010.07.15 өдрийн №48 тоот тогтоол “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” -д Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.
7. Засгийн газрын 2009 оны 324 дүгээр тогтоолоор “Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжих, хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд гадаад бодлогын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.

Эдгээр бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн ямар байгаад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн цэгтэй мэдээлэл, судалгааны тайлан одоогоор алга байна. Төр засгийн бодлогыг оновчтой боловсруулах, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх нь нийгэм-эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх үндэс, суурь нь болдог.

Бодлогын зорилтот хөтөлбөрүүдийн үр дүнг сайжруулахад оролцогч талууд буюу Парламент, Засгийн газар, иргэд, хувийн салбар, ТББ, иргэний нийгэм, ОУБ, хандивлагч байгууллагуудын үүрэг роль их юм. Бодлого, төсөл, хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх нэг хэрэг, хамгийн гол нь “ ямар үр дүнд хүрэв ” гэдгийг анхаарах, үүний тулд Үр дүнд сууринсан хяналт-шинжилгээ үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Төрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн хүрээнд дараахь асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүнд:

- Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах. Төрийн бодлогын суурь концепц, түүнд нийцүүлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжкаа болон практик үр дүнг тодорхой болгож, бодлого, зорилтуудыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүдийг зөв тодорхойлох
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах. Монгол улсад ижил зорилго, чиглэл бүхий маш олон бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч тэдгээр нь агуулга, зорилтын хувьд давхардсан, эсвэл бие биенээ үгүйсгэсэн, уялдаа холбоо муутай байна гэх шүүмжлэл нэлээд гарч байна
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох. УИХ болон Засгийн газраас батлан гаргаж буй бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байдгаас

хэрэгжилт нь хангалтгүй байдаг. Улс төрийн амлалт, нийгмийн сэтгэл зүйд нийцүүлэх хандлагатай олон янзын бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд цаасан дээр батлагдсан боловч хэрэгжих боломжгүй байсаар байна.

- Хяналт шинжилгээ-үнэлгээг сайжруулах. Сүүлийн үед төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарсан уламжлалт аргаас үр дүнд сууринсан хяналт шинжилгээ-шнэлгээний аргад шилжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлого, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн боловч хүсэн хүлээсэн үр дүнг бий болгож чадсан уу? гэдгийг анхаарах шаардлагатай. Үүний тулд төсөл, хөтөлбөрийн үр дагавар, үр нөлөөг тооцон гаргаж цаг хугацааны явцад зорилт биелэгдсэн эсэх, хэрхэн биелэгдэв гэдэгт хариулт өгөх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Иргэдийн оролцоог хангах. Ардчилсан засаглалын суурь зарчим болох сайн засаглал, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлыг бий болгох үүднээс төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудал чухал юм. Хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад иргэд, олон нийтийн оролцоо чухал бөгөөд төр засгийн зүгээс гадад, дотоодын оролцогч талуудаас тавьж буй шахалт, шаардлагад илүү мэдрэмжтэй хандах шаардлага бий болж байна.
- Дэлхийн болон бус нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах. Дэлхий дахины эдийн засаг, зах зээлийн харилцаанд хүн амын, мэдээлэлийн болон бараа бүтээгдэхүүний асар их шилжилт хөдөлгөөн гарч хил хязгааргүй урсгалд татагдан орох даяаршилын шинэ нөхцөл байдал бүрдэж байгаа учраас хүн ам, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн бодлого нь дэлхийн болон бус нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдах шаардлагатай болж байна. дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал, хөрш орнуудын нөлөөлөл, уул уурхайн салбарын хөгжил , гадаадад хөдөлмөр эрхлэлт, хүн ам, шилжих хөдөлгөөн, цаг агаар, экологи зэрэг олон асуудлуудыг олон улсын хэмжээнд авч үзэх шаардлагатай болж байна.

## **2.2 Монгол улсын нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төрийн бодлогын арга хэрэгсэлүүд, бодлогын хэрэгжилтийн үр дүн**

Монгол улсын төрөөс эдийн засаг - нийгмийн салбарт явуулж буй бодлого, түүний үр дүнг дараах асуудлуудын хүрээнд судалсан болно. Үүнд:


1. Эдийн засаг дахь төрийн үүрэг роль, оролцоо
2. Эдийн засгийн шинэчлэлийн стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
3. Төрийн санхүү, төсвийн бодлого
4. Мөнгө зээлийн бодлого
5. Монополийн эсрэг бодлого
6. Валютын ханш, гадаад худалдааны бодлого
7. Хөрөнгө оруулалтын бодлого
8. Нийгмийн салбарын бодлого

### **a/ Эдийн засаг дахь төрийн оролцоо**

Зах зээлийн харилцааны үед төрийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оролцоо ямар байх вэ, ямар арга хэрэгсэлүүдээр дамжуулан төрийн зохицуулалтын механизмууд ажиллах вэ, төрийн оролцооны зохистой хязгаар ямар байх вэ? зэрэг асуудлууд судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн. Монгол улсын эдийн засаг-нийгэмд төрийн гүйцэтгэж буй үүрэг роль, оролцоо ямар байгаа, шиний ээрэг сөрөг нөлөөл нь ямар байж болохыг судалгаагаар харуулахыг зорилоо. Асуудлыг дараах хэд хэдэн үзүүлэлтүүдийн харьцаагаар тодруулав. Үүнд:



Зураг 1. ДНБ-д Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцлийн эзлэх хувь



\*\*\*

**Дүгнэлт:**

Судалгаанаас үзэхэд эдийн засагт төрийн оролцоо өндөр байгаа нь харагдаж байна. 2003 оноос хойшхи үзүүлэлтээр, ДНБ-д эзлэх төсвийн орлогын дунджаар 37%, зарлага - 40%, төсвийн алдагдал- (-2.0%) байна. Бусад оруулдтай харьцуулахад ДНБ/ Төсвийн зарлагын харьцаа харьцангуй өндөр байна./ Тухайлбал, орлогын тундаж түвшинтэй 11 орны дундаж үзүүлэлт - 14% байна.<sup>87</sup> Үүдэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Эдийн засагт төрийн оролцоо харьцангуй өндөр байна. ДНБ/ Төсвийн зарлагын харьцаанаас үзэхэд нийгмийн баялгийн үйлдвэрлэлийн хэмжээ бага, төсвөөр дамжуулан эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж буй нөлөөлөл, төрийн оролцоо өндөр байгаа нь бодит үйлдвэрлэлийг дэмжих бус хэрэглээг дэмжсэн, үр ашиггүй бодлого байх талтай.
2. Эдийн засагт төрийн оролцоо өндөр байх тусам нь хүнд суртал, авилгал нэмэгдэх хандлагатай.

**1.2. Төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүд, төрийн оролцоо****Хүснэгт 2.**

- Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй нийт ААН, төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой ААН, тэдгээрийн эзлэх хувь

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО /хариуцлагын хэлбэрээр, жил бүрийн эцэст/				
Хариуцлагын хэлбэр	2007	2008	2009	2010
Компани	38 011	43 130	46 893	55 996
Төрийн өмчтэй үйлдвэрийн газар	562	651	660	557
Хоршоо	3 223	2 595	2 681	2 563
Нөхөрлөл	3 801	3 174	3 304	3 303
Төсөөт байгууллага	4 191	4 044	4 047	4 410
Төрийн бус байгууллага	6 050	6 858	6 908	6 915

<sup>87</sup> И.М. Албегова и др. "Государственная экономическая политика", 1998, Москва, стр33

Судалгааны эмхтгэл, XI боть

Бусад (хувийн цэцэрлэг, сургууль г.м.)	63	83	81	78
БҮГД	55 901	60 535	64 574	73 822

2010 оны статистик мэдээлэлд дурьдсан Аж ахуйн нэгж, байгууллагын улсын нэгдсэн тооллогын дүнгээр нийт 73822 ААН бүртгэгдсэнээс, төрийн өмчийт үйлдвэрийн газар 557 (0.7 хувь), төсөвт байгууллага-4410 (5.0%) байна. Тооны хувьд хувийн хэвшлийн ААН нэгж давамгайлсан мэт харагдавч бодит байдалд ДНБ-д хувийн хэвшлийн эзлэх хувь хэмжээ, жижиг дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр харьцангуй бага байгаа нь харагддаг. Улсын бүртгэлд бүртгэлтэй ихэнх ААН идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь судалгаанаас харагдсан.

## 5. Эдийн засгийн шинэчлэлийн стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Монгол улс 1990 онд зах зээлийн харилцаанд шилжих үедээ хөгжлийн бодлого, стратегийн хувьд огцом өөрчлөлт буюу “шоковая терапия” бодлогыг хэрэгжүүлсэн гэж үздэг. Тухайлбал, өмч хувьчлал, үнийн либеральчлал, гадаад худалдааг чөлөөлөх валютын ханшиг чөлөөлөх, хувийн хэвшлийг дэмжих зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг авч зах зээлийн харилцааны суурь бүтцийг бий болгох, улмаар эдийн засгийг тогтвроржуулах арга хэмжээнүүдийг авч ирсэн байна. 1996 оноос эхлэн үндэсний хэмжээний томоохон бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийг батлан гаргасан байна.

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод-суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” -д тусгасан эдийн засгийн бодлогын гол зорилт нь 2007-2015 онд “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 14 хувьд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүнийг 5 мянгаас доошгүй ам. долларт хүргэж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавих зорилтыг дэвшүүлсэн байна.

Хүснэгт 3.

- ДНБ-ний өсөлт, бууралт:

Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд	1995 он	2000 он	2005 он	2009 он	2010 он
ДНБ-оны үнээр /тэрбум төг/	550.2	1.172.7	2524.3	6590.6	8255.1
Нэг хүнд ногдох ДНБ /оны үнээр / төгрөгөөр/	246.1	426.2	899.3	2432.3	2992.8
ДНБ-ны өсөлт	2,4	1,1	7,3	-1,3	6,1

\*\*\*

### Дүгнэлт:

2007 оноос хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш дээрхи үзүүлэлтүүд харьцангуй бага байгаагаас үзэхэд 2015 он гэхэд бодлогын зорилтууд хэрэгжих магадлал бага байна. Ул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалан үзүүлэлтүүд харьцангуй сайжирч болох юм.

**в/ Төрийн санхүү, төсвийн бодлого, төлөвлөлт**

Хүснэгт 4. Улсын нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд

	2008	2009	2010	2011 тод	2012 төс
Нийт орлого	2170,3	1993,9	3122,5	3919,9	6352,2
Нийт зарлага	2466,7	2314,2	3080,7	4912,3	7093,0
Хөрөнгийн зардал	624,4	460,5	590,6	1187,0	2 390,9
Гадаад худалдааны тэнцэл /сая.ам.долл/	-710,1	252,3	-291,6	-	-
Нийт тэнцэл	-296,4	-341,2	417,8	-992,4	-740,9

Сүүлийн жилүүдэд төсвийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдэж, төсөв огцом тэлэх хандлагатай байна. өмнөх жилүүдэд төсвийн зарлагын өсөлт өндөр байсан хэдий ч 2012 оны төсөвийн төсөлд тусгагдсан шиг өндөр үзүүлэлт байгаагүй юм. Төсвийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 32,8% иар нэмэгдүүлэхээр төлөвлөсний дийлэнхийг татварын орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Сүүлийн 2 жилд орлогын албан татвар буурсан бол НӨАТ-ын орлого өссөн байна.

2012 онд гаалийн татвар/56,6%, тусгай зориулалтын орлого /46,1%/ нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээ 2012 онд 39,4% болж Засгийн газрын 33%-иас хэтрүүлэхгүй байх бодлогоос давж төсөвлөгдсөн байна. 2012 онд төсвийн тогтвортолтын санд 381,2 тэрбум төгрөгийг /42% нэмэгдүүлэх/ төвлөрүүлэхээр, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас 1669,5 тэрбус төгрөг төвлөрүүлэхээр тусгасан нь нийт тэнцвэржүүлсэн орлогын 42%-ийг эзэлж байна.

2002 онд ашигт малтмалын экспорт нийт экспортын 50% -ийг эзэлж байсан бол 2010 онд 90% орчим эзэлж байна. 2012 онд төсвийн нийт орлого 61.7 % -иар, төсвийн нийт зарлага 69.2%-иар, хөрөнгө оруулалтын зардал 49.6%-иар нэмэгдэхээр тус тус төлөвлөсөн байна.

**Хүснэгт 5 .Төсвийн алдагдалын санхүүжилт**

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011 тод	2012 төс
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	39.4	-73.3	-123.4	-133.2	296.4	342.6	-41.8	992.4	740.9
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	12.5	-135.2	-126.4	181.3	275.0	-464.0	-182.6	-3.8	-162.0
2. МҮХС-гаас улсын төсөвт шилжүүлэх	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	168.5	0.0	0.0
3. Засгийн газрын бонд	-61.0	-25.8	-94.4	-16.4	-20.3	623.5	114.7	337.0	-83.5
4. Засгийн газрын зээл	71.7	82.9	67.3	46.8	32.9	209.6	24.5	83.5	-491.1

Судалгааны эмхтгэл, XI боть

5. Урьдчилгаа төлбөр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	414.2
6. Өмч хувьчлал	16.2	5.0	30.1	17.7	8.8	-26.5	3.5	114.8	1,263.3

Төсвийн алдагдалын дийлэнхийг 2012 онд өмч хувьчлалын орлого, ЗГ-ын зээл болон урьдчилгаа төлбөрийн эх үүсвэрээр нөхөхөөр төсвийн төсөлд тусгасан байна. Судалгаанаас үзэхэд, Засгийн газрын өрийн удирдлагад анхаарал хандуулах цаг болсон нь харагдаж байна.

#### г/ Мөнгө- зээлийн бодлого

Сүүлийн жилүүдэд эдийн засаг өсч байгаа боловч инфляцийн түвшин зорилтот түвшингөөс хэтэрч 10-аас дээш хувьтай гарсаар байгаа тул Монголбанк мөнгөний бодлогоо чангруулах арга хэмжээ авч байна.

Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох буюу инфляцийг тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгдсэн бодлого явуулж ирсэн. Инфляцийг онилох бодлогын гол хэрэгсэл нь Төв банкны бодлогын хүү юм. Төв банкнаас бодлогын хүүг нэмэгдүүлэх арга хэмжээг удаа дараа авахаас аргагүй байдалд хүрсэнийг Засгийн газрын үйл ажиллагаа, төсвийн тэлэлттэй холбон тайлбарлаж байна. Монголбанк болон Засгийн газрын хооронд бодлогын **уялдаагүй зөрчилдөөнтэй байдал** бий болж энэ нь 2012 оны төсөв, мөнгөний бодлогыг УИХ-аар хэлэлцэх явцад улам тодорхой болсон.

Бодлогын хүү:

Монголбанк 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.25 хувьд хүргэх шийдвэр гаргасан. ҮСХ-ноос мэдээлснээр 2011 оны 9 дүгээр сарын байдлаар ХҮИ-ээр хэмжсэн инфляци улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотынх жилийн 11.9 хувьд хүрээд байгаа бөгөөд төсвийн зардал хурдтай тэлж, Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож, зээлийн өсөлт хурдасч байгаа зэрэг нь нийт эрэлтийг нэмэгдүүлж байна. Нийт нийлүүлэлт болон эдийн засгийн бодит хүчин чадал дорвийт өсч амжаагүй байхад нийт эрэлт ийнхүү огцом өсөх нь суурь үнэ өсөх дарамтыг бий болгож байгаа тул бодлогын хүүг нэмэхээс өөр аргагүйд хүрсэн гэж Монголбанк тайлбарлаж байна. Харин бодлогын хүү өсөхөд бусад хүү болон арилжааны банкуудын хадгаламж зээлийн хүү дагаж өөрчлөгдхө байна нь бодит секторын санхүүжилтийг хязгаарлах болно.

#### Хүснэгт 6: Монголбанкны хүү, жилийн хувь

Хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн	Бодлогын хүү	Репо	Овернайт	Барьцаат зээл
2011.10.25	12.25	16.25	21.25	20.25
2011.08.29	11.75	15.75	20.75	19.75
2011.04.28-6.23	11.50	15.50	20.50	19.50
2010.05.12 - 2011.2.24	11.00	15.00	20.00	19.00
2009.09.30	10.00	14.00	19.00	18.00
2009.06.12	11.50	17.50	21.50	20.50

2009.05.12	12.75	18.75	22.75	21.75
2009.03.11	14.00	17.00	21.00	20.00
2008.11.19	9.75	18.00	23.00	13.86
2008.09.10 - 2011.11.13	10.25	18.00	23.00	13.86
2008.03.19	9.75	18.00	23.00	
2007.11.21	8.40	18.00	23.00	
2007.10.17	7.40	18.00	23.00	
2007.07.09	6.40	18.00	23.00	

Эх сурвалж: <http://www.mongolbank.mn/dblistmongolbankrate.aspx>

#### Инфляцийн түвшин:

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд дурьдсанаар хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тоонд буюу 10 хувиас хэтрүүлэхгүй байхаар, 2013-2014 онд 8 хувиас хэтрүүлэхгүй байхаар тусгасан байна. Бусад орнуудын инфляцийн түвшинтэй харьцуулахад 10 хувь гэдэг хэдий өндөр боловч манай орны нөхцөл байдалд үүнээс нам зорилт дэвшиүүлэх боломжгүй хэмээн Монголбанк үзэж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар үндсэн чиглэлд тусгасан инфляцийн түвшин болон үр дүнг харьцуулбал:

#### Хүснэгт 7. Инфляцийн зорилтот түвшин, үр дүн

Үзүүлэлтүүд	Үндсэн чиглэлээр батлагдсан инфляцийн зорилтот түвшин	Гүйцэтгэлээр гарсан үр дүн буюу инфляцийн түвшин	Төв банкны бодлогын хувь	Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь	ДНБ-ний өсөлт хувь
2007 он	5,0	17,8	7,4	37,9	10,2
2008 он	6,0	22,1	10,25	40,2	8,9
2009 он	<10%	4,2	14,0	48,6	-1,3
2010 он	<10%	13,0	11,0	43,3	6,1
2011 он ХБГ	<10%	11,9	12,25	52,1	20,0
2012 он төсөөлөл	<10%	-	-	39,4	25,6

\*2011 оны эхний 9 сарын байдлаар

Хүснэгтээс үзэхэд 2007-2008 онуудад инфляцийн түвшин үндсэн чиглэлд тусгасан зорилтот түвшнээс 3,0-3,5 дахин их гарсаныг судлаачид эдийн засгийн хямралтай холбон тайлбарладаг. Инфляцийг 10-аас доош хувьд барих зорилт зөвхөн 2009 онд л хэрэгжсэн байна.

**1.1 Нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд**

Хүснэгт 8

	1995 он	2000 он	2005 он	2009 он	2010 он
Суурин хүн амын тоо /мян.хүн/	2 243.0	2 407.5	2,562.4	2,735.8	2780.8
Эдийн засгийн идэвхтэй хүн /мян. хүн/	812.7	847.6	1001.2	1137.9	1147.1
Үүнээс: Ажиллагчид	767.6	809.0	968.3	1006.3	1033.7
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	45.1	38.6	32.9	38.1	38.3
Ажилгүйдлийн түвшин % -аар	5.5	4.6	3.3	3.3	
ААН байгууллагын ажилчдын дундаж цалин /мян.төгрөгөөр/		62.3	101.2	300.5	379.4
Хүн амын амьжиргааны доод түвшин /мян.төг/	8000	19300	30000	101100	101600
Нэг өрхийн сарын дундаж орлого /мян.төгрөгөөр/	38.3	92.1	172.0	402.5	448.0
Нэг өрхийн сарын дундаж зарлага /мян.төгрөгөөр/	38.3	111.8	194.0	437.6	450.2

Нийгмийн хөгжлийн статистик мэдээллээс үзэхэд, хүн амын амьжиргааны түвшин, өрхийн сарын дундаж орлого болон дундаж цалин өссөн, ажилгүйдлийн түвшин буурсан харагдаж байгаа боловч инфляцийн түвшин, өрхийн зарлагын түвшинтэй харьцуулахад энэ нь хангалтгүй үзүүлэлт юм.

**Төрийн бодлого ба иргэдийн оролцоо**

Парламентаас батлагдсан хууль, бодлогын баримт бичгүүд бодитойгоор хэрэгжиж иргэдийн амьдралын чанараыг сайжруулахад чиглэгдсэн байх ёстой. Сүүлийн жилүүдэд бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэний нийгэм, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал ихээр хөндөгдөх боллоо. Олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн шахалтаар ардчилсан засаглалын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар тодорхой алхамууд хийгдэж байна.

Энэ асуудалд ОУБ болон судлаачид, парламентын зүгээс тодорхой хэмжээнд анхаарал хандуулж байна. Тухайлбал:

- 2007 онд ННФ, УИХ-ын Тамгын газар хамтран “Хууль боловсруулах, хэлэлцэх явцад иргэдийн оролцоо” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулсан
- 2004 онд НУБХХ, Монгол Улсын Их Хурал хамтран “Ардчилсан засаглалын парламентыг бэхжүүлэх” хамтарсан төслийг хэрэгжүүлж Монгол Улсын Их Хурал болон УИХ-ын Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх талаар судалгаа хийж санал, зөвлөмж боловсруулсан
- 2006 онд ННФ-ийн бодлогын тэтгэлэгт судлаач Ч. Тамир нар “Парламентад бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт бодлогын судалгааг гүйцэтгэсэн байна.

Мөн УИХ болон Засгийн газрын түвшинд засаглалын чадавхийг сайжруулах, сайн засаглалыг дэмжих чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөрүүд нэлээд хэрэгжиж байна. Монгол Улсын Их Хурлын хувьд УИХ -ын хууль тогтоох, хянан шалгах, төлөөллийн чиг үүргийн хэрэгжүүлэх арга механизмуудыг боловсронгуй болгох, урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан мөрдүүлэх арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал:

- 2002 онд УИХ -ын тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө”
- 2004 онд УИХ-ын Тамгын газрын чиг үүргийн матриц , үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө/бизнес стратеги/ зэргийг батлан гаргаж эдгээр бодлогын баримт бичигт заасны дагуу УИХ-ын хууль тогтоох, бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

УИХ Болон УИХ-ын Тамгын газрын түвшинд дээрхи нөхцөл байдалтай уялдуулан бүтцийн өөрчлөлт хийж УИХ-аар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах үүднээс бодлогын судалгаа, мэдээлэл, лавлагагаар шуурхай хангах, парламентыг олон нийтэд нээлттэй байлгах , олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор парламентын албан ёсны мэдээллийн телевизийг ажиллуулах, Байнгын хороны түвшинд нээлттэй сонсгал, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, иргэд олон нийтээс хуулийн төсөлд өгч буй саналуудыг вэб сайт болон бичгээр хүлээн авч УИХ-ын гишүүд, Байнгын хороодод хүргүүлэх зэргээр ажиллаж байна. Тухайлбал:

- УИХ-ын Тамгын газрын бүтцэд Судалгаа, шинжилгээний алба
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
- Хууль сурталчлах алба байгуулж эдгээр нэгжүүд нь олон нийт, парламентыг холбох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч практикаас үзэхэд, төр-иргэн хоорондын харилцааг бий болгох, олон нийттэй харилцах ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн оновчтой механизмыг, арга хэрэгсэлүүд дутагдалтай байгаа нь харагдаж байна. УИХ-аар батлагдан гарч буй хууль тогтоомжууд нь нийгмийн эрэлт шаардлагад нийцээгүй, тухайн зах зээлийн харилцааны эрх зүйн хэм хэмжээг оновчтой зохицуулж чадаагүй, Үндсэн хууль болон бусад хуультай зөрчилдөх, олон улсын стандарт нийтлэг хэм хэмжээтэй зөрчилдөх зэрэг дутагдалууд байсаар байна.

Бодлого боловсруулах, хууль санаачлах эрх бүхий субъектууд бүгд энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. УИХ-д өргөн баригдаж буй хууль болон бодлогын шийдвэрийн төслийн дийлэнх нь Засгийн газрын түвшинд боловсруулагдсан байдаг. Иймд анхан шат/ Засгийн газар/ болон хэлэлцүүлгийн шат /УИХ/-ын түвшинд аль алинд нь иргэд, судлаачдын оролцоог хангах оновчтой систем бүрдсэн байх ёстой. Энэхүү тогтолцоог бий болгох нь хууль санаачлагчид, бодлого боловсруулагчдаас өөрсдөөс нь ихээхэн шалтгаална. Иймд бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүх шатанд иргэдийн оролцоог хангах үүднээс дараахь асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй юм.

“Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 18-р зүйлд зааснаар “... хууль санаачлагч хуулийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана гэж заасан байдаг. Иргэн, хуулийн этгээдээс санал авахдаа дараахь аргуудыг хэрэглэнэ хэмээн хуульд заасан байдаг. Үүнд:

- Хуулийн төслийг бүрэн эхээр нь цахим хуудсанд 10-аас доошгүй хоног байрлуулж, олон нийтэд танилцуулах

Судалгааны эмхтгэл, XI боть

- Хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдэд нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр явуулах.

2009 оны 6-р сард орсон нэмэлт өөрчлөлтөөр хууль санаачлагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хуулийн төслийн танилцуулгад тусгана хэмээн заасан боловч одоогоор хэрэгжилт хангалтгүй байна.

Практикт иргээдээс дорвитой санал ирүүлэхгүй байх ба вэб хуудсанд хуулийн төслийн танилцуулах, тодорхой асуудлаар хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах, ирүүлсэн саналуудад дун шинжилгээ хийж хууль болон шийдвэрт тусгах эсэхийг Байнгын хороодоор хэлэлцэх, иргэдтэй эргэх холбоо тогтоох зэрэг асуудлууд хангалтгүй байна.

Зарим орнуудын туршлагаас үзэхэд, хуулийн төсөл боловсруулах шатанд Засгийн газрын түвшинд олон нийтийн оролцоог хангах ажиллагааг зохион байгуулдаг байна. Учир нь хуулийн төсөл боловсруулах ажил нь ихэнхи тохиолдолд Засгийн газрын холбогдох яамдын “Хуульчийн зөвлөл”-өөр хийгддэг ажээ. Ингэхдээ тухайн хуулийн зорилтот бүлгүүдэд бүлгийн ярилцлага хийх, уулзалт зохион байгуулах болон иргэдийн саналыг электрон шуудангаар авдаг байна. Харин мэргэжлийн судлаачид буюу экспертийн түвшний оролцоог хэлэлцүүлэг явуулах хэлбэрээр саналыг нь авдаг байна.

Зарим орнуудад /Польш, Румын, Эстони, Словак, Чех/:

- мэдээлэх /албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, вэб сайтад байршуулах гэх мэт/
- зөвлөлдөх /нээлттэй хэлэлцүүлэг явуулах, эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс санал авах, практик зөвлөмж авах гэх мэт/
- идэвхитэй оролцоог хангах /иргэд өөрсдөө хууль санал болгох, ажлын хэсэгт ажиллах, санал солилцох/-иргэд ажлын хэсэгт ажиллах зэргээр оролцоог хангах арга хэмжээнүүдийг авдаг байна.

#### Дүгнэлт, зөвлөмж:

##### 1. Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах хүрээнд:

Монгол улс 21 -р зууны босгон дээр дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын баримталж буй социал демократ үзэл баримтлал буюу нийгмийн ардчилсан үзэл баримтлалыг төрийн бодлогын суурь үзэл баримтлалаа болгох хандлагатай байна. Гэвч эдийн засгийн онолын сургаалиуд төлөвшин бий болсон байдал, шилжилтийн эдин засагтай орнуудын сайн туршлага, өндөр хөгжилтэй орнуудын туулж өнгөрөөсөн эдийн засгийн түүхээс үзэхэд нийгмийн баримтжаатай эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийн баялгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, материаллаг хүчин чадал, эдийн засгийн нөөц боломжийг тогтвортой нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн зөв бүтэц, зах зээлийн хэвийн орчинг бүрдүүлэх шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна.

Социал демократ үзэл баримтлалд зарим улс төрчид, судлааид шүүмжлэлтэй ханддаг. Учир нь хэт улс төржсөн байдлаар нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөхүйц амлалт өгч, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө бодлогогүй алхамуудыг хийх нь улс орны дотоод нөөц боломжоос давсан, эмх цэгцгүй, ойлгомжгүй бодлогын орчинг бий болгож улмаар хямралд хүргэх аюултай хэмээн үзэж байна.

##### 2. Төрийн бодлого төлөвлөлтийг сайжруулах, бодлогын хэрэгжилт, үр дүн, уялдаа холбоог сайжруулах хүрээнд:

- Төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах. Төрийн

бодлогын суурь концепц, түүнд нийцүүлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл, онолын чиг баримжаа болон практик үр дүнг тодорхой болгож, бодлого, зорилтуудыг зөв тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүдийг зөв тодорхойлох

- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах. Монгол улсад ижил зорилго, чиглэл бүхий маш олон бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч тэдгээр нь агуулга, зорилтын хувьд давхардсан, эсвэл бие биенээ үгүйсгэсэн, уялдаа холбоо муутай байна гэх шүүмжлэл нэлээд гарч байна.
- Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох. УИХ болон Засгийн газраас батлан гаргаж буй бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байдгаас хэрэгжилт нь хангалтгүй байдаг. Улс төрийн амлалт, нийгмийн сэтгэл зүйд нийцүүлэх хандлагатай олон янзын бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд цаасан дээр батлагдсан боловч хэрэгжих боломжгүй байсаар байна.
- Хяналт шинжилгээ - үнэлгээг сайжруулах. Сүүлийн үед төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарсан уламжлалт аргаас үр дүнд суурилсан хяналт шинжилгээ-шнэлгээний аргад шилжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар бодлого, хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлсэн боловч хүсэн хүлээсэн үр дүнг бий болгож чадсан уу? Гэдгийг анхаарах шаардлагатай. Үүний тулд төсөл, хөтөлбөрийн үр дагавар, үр нөлөөг тооцон гаргаж цаг хугацааны явцад зорилт биелэгдсэн эсэх, хэрхэн биелэгдэв гэдэгт хариулт өгөх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Иргэдийн оролцоог хангах. Ардчилсан засаглалын суурь зарчим болох сайн засаглал, хариуцлагатай, ил тод, нээлттэй байдлыг бий болгох үүднээс төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудал чухал юм. Хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад иргэд, олон нийтийн оролцоо чухал бөгөөд төр засгийн зүгээс гадад, дотоодын оролцогч талуудаас тавьж буй шахалт, шаардлагад илүү мэдрэмжтэй хандах шаардлага бий болж байна.
- Дэлхийн болон бус нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах. Дэлхий дахинь эдийн засаг, зах зээлийн харилцаанд хүн амын, мэдээлэлийн болон бараа бүтээгдэхүүний асар их шилжилт хөдөлгөөн гарч хил хязгааргүй урсгалд татагдан орох даяаршилын шинэ нөхцөл байдал бүрдэж байгаа учраас хүн ам, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийн бодлого нь дэлхийн болон бус нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдаа шаардлагатай болж байна. дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал, хөрш орнуудын нөлөөлөл, уул уурхайн салбарын хөгжил, гадаадад хөдөлмөр эрхлэлт, хүн ам, шилжих хөдөлгөөн, цаг агаар, экологи зэрэг олон асуудлуудыг олон улсын хэмжээнд авч үзэх шаардлагатай болж байна.

### **3. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах бүх түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын хэмжээнд зохион байгуулалтын арга механизмуудыг тодорхой болгож, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүнг сайжруулах
- Хууль болон бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах хэлэлцэн батлах шатанд иргэний нийгэм, хууль хэрэгжүүлэгч субъектүүд, зорилтот бүлгийн төлөөлөгчидтэй газар дээр нь уулзаж ярилцах, идэвхтэй хэлэлцүүлэг,

мэтгэлцээн өрнүүлэх хэлбэрийг өргөн ашиглах

- Иргэд, олон нийт, судлаачдын саналыг Ажлын хэсэг, Засгийн газар, УИХ-ын түвшинд зайлшгүй хэлэлцэж төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэх, энэ тухай эргэж хариу мэдэгдэх эргэх холбоог бий болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Иргэд олон нийтэд төрийн бодлогыг таниулах, хууль хэрэгжүүлэх, дагаж мөрдөхтэй холбоотой хялбаршуулсан заавар зөвлөгөө өгөх ажиллагааг УИХ, Засгийн газрын түвшинд зохион байгуулах
- Төр-иргэний нийгмийн харилцаагдэмжсэн институциональ дэд бүтэц/ мэдээллийн суваг, үйлчилгээний систем, иргэний танхим, эрдэмтдийн зөвлөл гэх мэт/-ийг байгуулж идэвхтэй ажиллуулах
- Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд шинжлэх ухааны байгууллагууд/ ЭШХ, судалгааны институт, эрдэмтэн, судлаачид, think thank/-ыг сайтар оролцуулж, бодлогын шинжтэй томоохон асуудлуудаар мэргэшсэн судалгааны байгууллагуудаар судалгаа шинжилгээ хийлгэх
- Төрийн үндсэн институцийн бүтцэд болон харьяанд ажиллаж буй судалгааны шинжилгээний нэгж, институтуудийг чадавхижуулж, академик болон суурь судалгааны байгууллагуудтай няйт уялдаатай ажиллуулах, олон улсын болон дотоодын мэдээллийн баазад хандах, мэдээлэл солилцох, мэдээллийн ургсалыг сайжруулах арга хэмжээ авах



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

# 2

## БҮЛЭГ

---

НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН  
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

(Монгол, Япон, ОХУ, Казакстан, Швед, БНЧУ)

*Ц. Төвүүсүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг,  
А. Пагма, Б. Хатантуул*

## Оршил

Өндер хөгжилтэй орнуудад хүн амын нийгмийн хамгааллын систем төлөвшиж, ядуурал, ажилгүйдэл зэрэг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрджээ. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь “нийгмийн зөвшилцэл дээр суурилсан сайтар бодож боловсруулсан нийгмийн хамгааллын системтэй холбоотой” гэдэгтэй эрдэмтэд, судлаачид сүүлийн жилүүдэд санал нэгдэж байна. Гэхдээ нийгмийн хамгаалалын асуудал нь онол арга зүйн талаасаа нарийвчлагдан судлагдаагүй, маргаантай асуудлын нэг хэвээр байна.

Нэрний хувьд ч янз бүрээр нэрлэгдэж байна. Тухайлбал, “нийгмийн хамгаалал”, “бүх нийтийн хангалиун байдал”, “нийгмийн үйлчилгээ”, “эдийн засгийн хамгаалал” “нийгмийн дэмжлэг” гэх мэт олон янзаар нэрлэгдэж хамрах хүрээний хувьд “бүх нийтийг хамрах”, “эмзэг хэсгийг хамгаалах”, “ажилчдыг хамгаалах” гэсэн олон хувилбаруудыг улс бүр өөр өөрөөр хэрэглэж байна.

“Дэлхийн нийгмийн хамгааллын хөтөлбөр” /Social Security Program Throughout the World буюу “SSPTW” нь 178 орны нийгмийн хамгааллын асуудлыг нэгдсэн системд оруулсан. Энэ хөтөлбөрийг АНУ-ын нийгмийн хамгааллын захиргаа/ U.S. Social Security Administration “SSA”, /Олон улсын нийгмийн хамгааллын холбоо/ International Social Security Association “ISSA”/ хамтарч боловсруулдаг бөгөөд гишүүн орнуудын тайлан мэдээг үндэслэн 2-3 жил тутам шинэчлэгдэж байдаг.

Энэ хөтөлбөрт Ази, Номхон далайн - 51, Европын 45, Америкийн 37, Африкийн 45 нийт 178 орнууд хамрагдаж нийгмийн хамгааллын асуудлууд нь нэгтгэгдсэн боловч Монгол улс одоогоор хамрагдаж чадаагүй байна. Энэ нь манай улсад зах зээлийн шилжилтийн үйл явц үргэлжилж байгаагаар тайлбарлагдаж болох боловч Орос, Киргиз, Казахстан, Вьетнам, Комбож, Польш, Унгар орнууд дэлхийн нийгмийн хамгааллын системд нэгджээ.

Энэ судалгаанд Монгол Улсын энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж , нийгмийн халамж үйлчилгээний талаархи өнөөгийн байдал, мөн ОХУ, БНКазУ, Швед, Чех, Япон улсын холбогдо хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын талаар хэрхэн зохицуулсаныг судлав.

### **Монгол Улсын энгийн иргэд ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгаалал халамжийн харьцуулсан судалгаа**

Монгол улсын хэмжээнд иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгаалал халамжийн асуудал нь дараахи 9 хуулиар зохицуулагдаж байна.Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 1994.05.31
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай 1994.06.13
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2002.04.25
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай 1994.06.07

Судалгааны эмхтгэл, XI боть

- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 1994.07.05
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай 1994.06. 13
- Нийгмийн халамжийн тухай хууль 2005.12.01
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай 2005.12.08
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай 2005.12.08

Эдгээр хуулийн хүрээнд тэтгэвэр тэтгэмж нийгмийн халамжууд нь тус тусын сангугаас санхүүжигдаж явна. Үүнд:

- Нийгмийн даатгалын сан / орлогын эх үүсвэр нь даатгуулагчийн төлсөн НДШ, ажил олгогчийн төлсөн НДШ, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого, НДШ төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги, улсын төсвөөс олгох хөрөнгө,
- Халамжийн сан, / орлогын эх үүсвэр нь төсвөөс олгох хөрөнгө, сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, ОУБ, гадаад орнуудаас өгсөн хандив тусламж, ААН байгууллага, иргэнээс өгсөн хандив тусламж, бусад эх үүсвэр.

## **НЭГ: МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, ТЭТГЭВЭР АВАГСАД**

### **1.1/ Нийгмийн даатгалын сангийн тэтгэврийн даатгалын сангаас олгох**

**Өндөр насны тэтгэвэр** – 20- оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл / ТДШ/ төлсөн 60 хурсэн эрэгтэй , эмэгтэй хүн бүр. Хэрвээ өөрөө хүсвэл 55 нас хурсэн эмэгтэй. 2010 оны III улирлын байдлаар 200372 иргэн өндөр насны тэтгэвэр авч байна. Хавсралт №1/

**Тахир дутуугийн тэтгэвэр** – ТДШ-ийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, тарилтын дараахь хүндрэл, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол энэ тэтгэврийг тогтоолгон авах эрхтэй. 2010 оны III улирлын байдлаар 52669 иргэн энэ тэтгэврийг авч байна. /Хавсралт №1/

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр** - ТДШ-ийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн тэжээгч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжинд байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй дор дурдсан гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. 2010 оны III улирлын байдлаар 27806 иргэн энэ тэтгэвэр авсан байна. /Хавсралт №1/ НДС-ын сангаас 2010 оны III улирлын байдлаар дээрхи 3 төрлийн энгийн тэтгэвэр авагч 280847 иргэн байна. /Хавсралт №1/

### **1.2/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр**

Дараах нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод даатгуулагч өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

- ✓ ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад;
- ✓ ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед;
- ✓ ажилдаа ирэх, буцах замд

- Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид “Хөдөлмөрийн хөлс” гэх-/оос хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтооно.
- Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж тахир дутуу болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлслний доод хэмжээний 75 хувиас багагүй байна. 2010 оны III улиралд 6318 иргэн авсан байна. /Хавсралт №1/
- **Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх, тэтгэврийн хэмжээ** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дор дурдсан хувь хэмжээгээр тогтооно:
  - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 3 ба түүнээс дээш бол 100 хувь;
  - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2 бол 75 хувь;
  - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 1 бол 50 хувь

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатаглын сангаас 2010 оны III улиралд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тэтгэмжид 7026 иргэн хамрагджээ. 2010 оны III улирлын байдлаар 708 иргэн авсан байна./Хавсралт №1/

### **1.3 / Халамжийн сангаас олгох нийгмийн халамжийн тэтгэвэр**

- Ахмад настны халамжийн тэтгэвэр - Тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангийн хүнгүй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр - 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр 16 хүртлэх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг/-
- Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр

Халамжийн сангаас олгох эдгээр 4 төрлийн тэтгэврийг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 242 дугаар тогтоолоор сар бүр 53800 төгрөгөөр олгохоор тогтоожээ. Эдгээр тэтгэврийг 2010 онд Монгол Улсын 56677 иргэн авчээ. Хавсралт №1

### **ХОЁР: МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭМЖИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, ХАМРАГДАГСАД**

#### **2.1 Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас олгох**

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж
- Өвчтөн сахисны тэтгэмж

Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас 2010 онд Монгол Улсын нийт 90014 иргэн дээрх 4 төрлийн тэтгэмжийг авсан байна. /Хавсралт №1/

Судалгааны эмхтгэл, XI боть

**2.2 Ажилгүйдлийн даатгалын сангаас** - ажилгүйдлийн тэтгэмж – 2010 онд 7942 иргэн авчээ.

### 2.3 Халамжийн сангийн амьжиригааг дэмжих сангаас

#### Нөхцөлт мөнгөн тэтгэмж

- ✓ Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Гэр булийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Ганц бие ахмад настан иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох
- ✓ Ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох

Халамжийн сангийн амьжиригааг дэмжих сангаас Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 242 тогтооолоор дээрхи 6 төрлийн тэтгэмжид сар бүр 31200 төгрөг олгож байхаар тогтоожээ. Эдгээр тэтгэмжид 2010 онд Монгол Улсын 120846 иргэн хамрагджээ./ Хавсралт №2/

- ✓ Эхийн алдар 1,2-р зэргийн одонтой эхэд олгох тэтгэмж 127500 иргэн авсан
- ✓ Эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж.

Энэ тэтгэмжийг 2010 онд 85243 иргэн авсан.

#### Нийгмийн халамжийн туслалцаа шаардлагатай өрх , иргэний амьжиригаанд үзүүлэх хөнгөлөлт тусламж

##### Амьжиригааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж

- 3 хүртэл насны ихэр хүүхдэд жилд 1 удаа 60000 төгрөг хүүхдийн тоогоор,
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа 30000 төгрөг,
- 3 ба түүнээс дээш 14 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэл жилд 1 удаа 60000 төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд 1 удаа 500000 төгрөг
- Гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад дэмжлэг үзүүлж 1 удаа 500000 т өгөх/
  - ✓ Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт
  - ✓ Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт
  - ✓ Протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хангамж
  - ✓ Сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт
  - ✓ Эх орны рашаан сувилалын зардлын хөнгөлөлт

Энэ төрлийн хөнгөлөлт тусламж нь МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтооолоор олгогддог бөгөөд 2010 онд 154013 иргэн хамрагджээ./ Хавсралт №2/

#### Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

- ✓ Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг дэмжих

зорилгоор зөвөлгөө өгөх, сургалт зохион байгуулах

- ✓ Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гаражад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих тесөл хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах
  - ✓ Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
  - ✓ Түр байрлуулан асрамжлах
  - ✓ Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах

Энэ төрлийн халамж үйлчилгээний хэмжээг ХХҮГ-ыг даргын 2010 оны ... тоот тушаалын 2 дугаар хавсралтаар тогтоосон /хавсралт №3/ бөгөөд 2010 оны III улиралд 21401 иргэн хамрагджээ. /Хавсралт №2/

### Төрөлжсөн халамж үйлчилгээ

- ✓ Ахмад настны асрамжийн / Тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангуй, бие даан амьдрах чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан/
- ✓ Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний / Мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардсан ХБИ
- ✓ Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн / Хүнд нөхцөлд байгаа эсхүл байнгын асрамжинд байдаг Хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэл насны хүүхэд/
- ✓ Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн / 4 нас хүртэл төрийн зардлаар асрамжилна/

**НДС-аас оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй** ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны оршуулгын тэтгэмж

### ГУРАВ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХАМРАГДАЖ БҮЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2005 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын” тухай хуульд “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” иргэн гэж тодорхойлоод эдгээр иргэд нь дараах үйлчилгээнд хамрагдах эрхтэй гэж заажээ. Үүнд:

- нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- нийгмийн халамжийн тэтгэвэр;
- нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- тусlamж, хөнгөлөлт;
- төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- эрүүл мэндийн үйлчилгээ;
- боловсрол, соёл, урлагийн үйлчилгээ.

Энэ хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн сангаас олгох тусlamж хөнгөлөлтийг дурдвал:

- ✓ Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дулий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт



- амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусlamж олгох;
- ✓ 18 хүртэлх насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
  - ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
  - ✓ 18 хүртэлх насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
  - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх;
  - ✓ Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувиланд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
  - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;
  - ✓ Насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;
  - ✓ Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
  - ✓ Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;
  - ✓ Бүрэн хараагүй хүн эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувиланд сувилуулхаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
  - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусландаа амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;
  - ✓ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусlamж олгох.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт тусlamж нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 161 дүгээр тогтоол, НХХ-ийн сайдын 2009 оны 24 тоот тушаалаар зохицуулгадаг бөгөөд 2010 оны III улиралд 30466 иргэн хамрагджээ.

\* \* \*

## ДҮГНЭЛТ

Төрөөс иргэдэд 7 төрлийн тэтгэвэр, 12 төрлийн тэтгэмж, 6 төрлийн тусламж хөнгөлөлт, 3 төрлийн 10 зүйл халамж үйлчилгээ үзүүлж байна. Эдгээрт энгийн иргэд болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэрхэн хамрагдаж байгааг тоймлон үзүүлвэл:


№	Төрөл	Санхүүжүүлэх эх үүсвэр	Нийт	Энгийн иргэд	ХБ иргэд
1.	Тэтгэвэр	НДС- гаас	3	1,5	1,5
		Халамжийн сангаас	4	2	2
2.	Тэтгэмж	НДС-гаас	5	3	2
		Халамжийн сангаас	8	4	4
3.	Тусlamж, хөнгөлөлт	Халамжийн сан болон улсын төсвөөс	27	14	13
4.	Халамж үйлчилгээ	Халамж сан, ОУБ болон ААН-ийн хандив	10	5	5
5.	Бүгд		57	29,534	27,5

Хүснэгтээс харахад манай улсын энгийн иргэд болон ХБИ-ийн авч байгаа тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлт, халамж үйлчилгээ нь ижилхэн, ялгаваргүй байгаа нь харагдаж байна. Бүх үйлчилгээнээс тэтгэвэр - 7 буюу 12,28%, тэтгэмж - 13 буюу 22,81%, тусламж хөнгөлөлт – 27 буюу 47,37%, халамж үйлчилгээ -10 буюу 17,54% -ийг эзлэж байна.

Өнөөдөр Монгол Улсын 926780 иргэн тэтгэвэр, тэтгэмж, халамж үйлчилгээ, хөнгөлөлт тусламжид хамрагдаж байгаагаас тэтгэвэрт 358549 иргэн, тэтгэмжид 219431 иргэн, халамжид 21401 иргэн, хөнгөлөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд 327399 иргэн хамрагдаж байна.<sup>88</sup> Хүний хөгжил санг оруулахгүй тооцвол манай улсад мөрдөж байгаа нийгмийн даатгал, халамжийн шугамаар энгийн иргэд болон тахир дутуу иргэдэд олгодог тэтгэвэр тэтгэмж тооны хувьд хангалттай бараг хэт хавтгайрсан, харин хүртээмжийн тухайд улс орны эдийн засгийн чадамжтай уялдан учир дутагдалтай байгааг анхаарч авах хүнээ олж цөөн тооны оновчтой тэтгэмжийг ахиуухан хэмжээтэй олгох хувилбарыг сонгох зүйтэй байна.

Нийгмийн даатгалын сангаас 2010 онд тэтгэвэр тэтгэмж авсан хүний тоог Хавсралт №1<sup>89</sup>-ээр, Халамжийн сангаас 2010 онд тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоог Хавсралт №2<sup>90</sup>-оор, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, халамж үйлчилгээ, хөнгөлөлт тусламжийн төрөл хэмжээг олгох эрх зүйн актыг Хавсралт №3<sup>91</sup>-д тус тус харуулав.

\* \* \*



<sup>88</sup> НДЕГ болон ХХҮГ-ын 2010 оны 3 дугаар улирлын тайлан мэдээ /Хавсралт №1,2/

<sup>89</sup> НДЕГ-н 2010 оны 3 дугаар улирлын мэдээ

<sup>90</sup> ХХҮГ-ын 2010 оны 3 дугаар улирлын тайлан

<sup>91</sup> Холбогдох тогтоол, тушаал эрх зүйн актаас

**Нийгмийн даатгалын сангаас 2010 оны 3 дугаар улирлын байдлаар нийт тэтгэвэр тэтгэмж авагсадын тоо**

(Хавсралт №1)

Тэтгэвэр тэтгэмжийн төрөл		Хүний тоо
• Энгийн тэтгэвэр авагчид		280,847
1. Өндөр нас		200,372
2. Тахир дутуу		52,669
3. Тэжээгчээ алдсаны		27,806
Цэргийн албан хаагчдын тэтгэвэр авагчид		13,999
1. Өндөр нас		12,534
2. Тахир дутуу		540
3. Тэжээгчээ алдсаны		925
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр авагчид		7,026
1. Тахир дутуу		6,318
2. Тэжээгчээ алдсаны		708
<b>Нийт тэтгэвэр авагчдын тоо</b>		<b>301,872</b>
Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид		90,014
1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны		59,365
2. Жирэмсний, амаржсаны		19,880
3. Оршуулгын		9,713
4. Өвчтөн сахисны		1,056
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж авагчид		629
1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны		629
Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагчид		7,942
1. Ажилгүйдлийн тэтгэмж		7,942
<b>Нийт тэтгэмж авагчдын тоо</b>		<b>98,585</b>
<b>Нийт тэтгэвэр тэтгэмж авагчийн тоо</b>		<b>400,457</b>

\* \* \*

**Халамжийн сангаас 2010 онд нийт тэтгэвэр тэтгэмж авагсдын тоо  
/2010 оны жилийн эцэс/**

Хавсралт №2

№	Тэтгэвэр тэтгэмжийн төрөл	Нийт хүний тоо
1.	<b>Халамжийн тэтгэвэр</b>	56,677
2.	<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	120,846
	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох	15800
	Байнгын асаргаа шаардлагатай ХБ иргэнийг асарч байгаа	9410
	Байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхдийг асарч байгаа	7267
	Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид	2076
	Гэр булийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	626
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	150
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	274
	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	85243
3.	<b>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн</b>	21401
	Зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	11746
	Хөдөлмөр эрхэлж, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах	2682
	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	2601
	Түр байршуулан асрамжлах	2200
	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	638
	Нөхцөлт мөнгөн тэтгэмж авч байгаа асаргаа, сувилгаа үзүүлж байгаа иргэдэд зориулсан сургалтын зардал	1534
4.	<b>Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж /45+...+51/</b>	154013
	Цэрцэрлэгийн хүүхдийн хоолны үнийн хөнгөлөлт	
	3 хүртэлхи насны ихэр хүүхдэд жилд нэг удаа	1476
	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа	22012
	3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа	1270
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа	1050
	Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа	705
	Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	127500

Судалгааны эмхтгэл, XI боть

5.	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж	136106
6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/	30466
7.	Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	6814
8.	Хүний хөгжил сангийн хишиг, хувь	2560900

\* \* \*

**ОХУ -ын хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын талаархи зохицуулалт**

“Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуулийн дагуу 1,2,3 дугаар групптэй хүмүүс тахир дутуугийн тэтгэвэр авдаг ба тэтгэвэрийн хэмжээ нь тогтоосон тахир дутуугийн группээс хамаарна. Үүнд:

- ✓ 1 дүгээр групп - сард 5124 рубль
- ✓ 2 дугаар групп - сард 25262 рубль
- ✓ 3 дугаар групп - сард 1281 рубль

Түүнчлэн тахир дутуугийн тэтгэвэрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу тодорхой тохиолдол бүрт бусад шалгуурийг мөн харгалздаг. Түүнчлэн 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” Холбооны хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр нийгмийн үйлчилгээний төлбөр 641 рублийг олгодог ба үүнээс 570 рубль нь нэмэлт эмнэлгийн тусламж, 71 рубль нь төмөр зам болон эмчилгээний замын зардалд зориулан олгодог байна.

Дараах хүснэгтэнд ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийн хэмжээг үзүүлэв.

№	Ангилал	Сар бүрийн мөнгөн төлбөрийн хэмжээ ( руб.)	Нийгмийн үйлчилгээний төлбөрийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ (HYT=641 руб.)	Төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ	Үнэгүй эмээр хангадах болон үнэ төлбөргүй сувилуулах эрхийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ
1	Тахир дутуугийн I групп (3 түвшин)	2162.00	1521.00	2091.00	1592.00
2	Тахир дутуугийн II групп (2 түвшин)	1544.00	903.00	1473.00	974.00
3	Тахир дутуугийн III групп (1 түвшин)	1236.00	595.00	1165.00	666.00
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд	1544.00	903.00	1473.00	974.00

5	Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс	772.00	131.00	701.00	202.00
---	--	--------	--------	--------	--------

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

ОХУ-ын 2001 оны “Хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуульд 2009 онд нэмэлт өөрчлөлт оруулсанаар 2010 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хөдөлмөрийн суурь тэтгэвэрийн оронд хөдөлмөрийн тэтгэвэрийн даатгалын хэсгийг тогтоосон суурь хэмжээгээр тодорхойлох болсон байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн тэтгэвэрийн даатгалын хэсгийг индексжүүлсэн ба Засгийн газрын шийдвэрээр тухайн үеийн өсөлт, хөдөлмөрийн хөлслний сарын дундажтай уялдуулан индексийн коэффициентийг тодорхойлж байхаар болсон байна.

2011 онд л гэхэд ОХУ-д хөдөлмөрийн тэтгэвэрийг хоёр удаа индексжүүлжээ. Үүнд:

- 2011 оны 2 дугаар сарын 1-нээс хөдөлмөрийн тэтгэвэрийн хэмжээ 8,8 хувиар өссөн,
- 2011 оны 4 дүгээр сарын 1-нээс халамжийн тэтгэвэр 10,27 хувиар өсчээ.

#### ОХУ-ЫН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭНИЙ ӨСӨЛТ /2011 оны 2 дугаар сарын 1-ны байдлаар/

	Тэтгэвэрийн дундаж хэмжээ		2011.02.01-нээс хойш тэтгэвэрийн дундаж хэмжээний өсөлт
	2011.02.01-нээс өмнө	2011.02.01-нээс хойш	
Нийт хөдөлмөрийн тэтгэвэр авагсдын хувьд Эдгээрээс:	7820	8498	678
Өндөр насны	8177	8886	709
Тахир дутуугийн	5147	5600	453
Тэжээгчээ алдсаны	4813	5236	423
Хоёр төрлийн тэтгэвэр авагсад:			
Цэргийн гэмтлийн улмаас тахир дутуу болсон	19075	20016	941
Эх орны дайнд оролцсон тахир дутуу иргэд	19278	20295	1017
Цэргийн албан хаагчдын бэлбэсэн гэргий нар	14169	14882	713
“Бүсэлгэдсэн Ленинградын оршин суугчид” тэмдэгтэй тахир дутуу иргэд	14478	15348	870

\* \* \*

**БНКазУлсын хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын талаархи зохицуулалт**

Казахстан улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын асуудлыг 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”, 1997 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай” хуулиар тус тус зохицуулж байна.

БНКазУлсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэмж олгоходо тэдгээрийг 5 ангилалд хуваадаг байна. 1 дүгээр ангилалд өвчний улмаас, хөдөлмөрийн явцад, мэргэжлийн өвчний улмаас тахир дутуу болсон мөн төрөлхийн тахир дутуу хүмүүсийг хамруулдаг ба эдгээрээс тахир дутуугийн 1 дүгээр групптэй хүмүүст сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 2 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,06 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 3 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0,74 –тэй тэнцэх хэмжээний тэтгэмж, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,00–тай тэнцэх, төрөлхийн тахир дутуу хүүхдэд тахир дутуугийн группээс нь хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36-0,87-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

3 дугаар ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад хашиж буй албатай нь холбоогүйгээр золгүй явдлын улмаас тахир дутуу болсон цэргийн албан тушаалтнууд мөн тогтоогдсон тарих дутуугийн группээс хамааран 1 дүгээр ахглалын хүмүүстэй ижил хэмжээний ияигамж олгодог. 2, 5 дугаар ангилалын буюу хугацаат цэргийн алба хааж байхдаа тахир дутуу болсон хүмүүс ба иргэний болон цэргийн зориулалттай цөмийн объект дээр гарсан осолын улмаас, экологийн онцгой байдал, түүний дотор цөмийн дэлбэрэлт, туршилтийн үед цацраг түяаны улмаас тахир дутуу болсон хүмүүст мөн тэдгээрийн тахир дутуугийн группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,61-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

4 дүгээр ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад цэргийн албаны үүрэг гүйцэтгэж байхдаа осолын улмаас тахир дутуу болсон цэргийн албан хаагчдад тогтоогдсон группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2, 09-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгож байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн хамгаалал, түүний дотор нөхөн сэргээгдэх, нийгэмтэйгээ хөл нийлүүлэн амьдрах, тоноглогдсон орон байраар хангагдах, үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ хүртэх эрх эдэлдэг.

**Швед улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж хамгаалал, тэтгэвэр тэтгэмжийн талаархи судалгаа**

К. Марксын дэвшүүлсэн “Зүүний буюу Нийгмийн хамгааллын тухай ардчилсан социалист онол арга зүй” нь орчин үеийн нийгмийн ШУ-ны сэтгэлгээнд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь онолын сэтгэлгээний олопт төдийгүй, “ардчилсан социализмын үзэл буюу Шведийн загварын хувилбар”-аар нийгмийн хөгжилд бодит биелэлээ олсон. Энэ онолын гол үндэслэл нь: - иргэн бүрийн ажил эрхлэлт - чинээлэг хангалуун амьжиргаа - олон ургальч үзэл - улс төрийн ардчилал - байгаль орчны хамгаалал зэрэг асуудлуудыг хамарч байв. Мөн энэ арга зүй нь одоогийн Европын Холбооны хэмжээнд баримталж байгаа нийгмийн баримжаат 33-ийн бодлогыг боловсруулах үндэс болсон. Сүүлийн үед зарим талаараа Шведийн загвар мухардالд ороод байгаа ч ардчилсан социалист үзэл зөвхөн Европт төдийгүй дэлхийн олон оронд, түүний дотроос Австрали, Япон, Монгол оронд ч хэсэгчлэн хэрэгжиж байна.

Швед Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт”(1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977)-уудаар тэтгэвэрийн насыг тогтоох, ажиллах нөхцөл, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, сэтгэцийн болон биеийн хөгжлийн өөрчлөлтэй хүмүүст тохирсон ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх, 18 насанд хүрээгүй боловч хуулинд заасан хөдөлмөр эрхэлж болох 16 насанд хүрсэн насанд хүрээгүйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, ажлаас халагдсаны нөхөн төлбөр, ажилгүй болсон ажилтанг эргүүлж авах нөхцөл, ажлын байрны аюулгүй байдал болон ажлын байрыг хадгалах зэрэг асуудлыг хуульчилсан байдаг байна.

Мөн түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт” (1999) -аар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил олгогч ялгаварлан гадуурхахгүй байхыг дэлгэрэнгүй зүйлчилж өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ тэтгэвэр тэтгэмж болон нэмэлт үйлчилгээг Нийгмийн даатгалын тухай акт-1999, Нийгмийн хамгаалалын акт - 2001, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжилэг туслалцааны тухай акт-1988, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж болон асран хагаалах тухай акт-1998-уудаар тус тус зохицуулдаг байна.

#### Тахир дутуугийн байнгын тэтгэмж

Нийгмийн хамгаалалын системийн үүрэг: Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд:

1. өвчлөх, өтлөх, осолдох, гэмтэх, ядуурах, орлогогүйдэх зэрэг хүмүүний амьдралын нийгмийн шинжтэй эрсдлээс ард иргэдийг хамгаалах үүргийг нийгмийн өмнөөс гүйцэтгэх.
2. Төрийн нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар иргэдийн амжиргааны доод түвшингийн баталгааг хангах.
3. Хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх гэсэн гурван үндсэн үүргийг нийгмийн хамгааллын систем гүйцэтгэдэг.

Нийгмийн хамгааллын тогтолцоог бүрэлдэхүүний хувьд нь:

1. Нийгмийн даатгал
2. Нийгмийн халамж
3. Нийгмийн бодлого дахь хамгааллын асуудлууд гэсэн 3 хэсэгт авч үзэх нь ихэнх оронд түгээмэл байна. Зах зээлийн харилцаа хөгжсөн орнуудад нийгэм хангамжийн дараахь таван төрлийн аргыг хэрэглэдэг.
  1. Нийгмийн даатгал
  2. Нийгмийн халамж
  3. Бүх нийтийн тэтгэврийн тогтолцоо
  4. Ажил олгогчийн буюу эздийн үүрэг хариуцлага
  5. Үндэсний нөөцийн сан

Нийгмийн даатгалын төрөл

Дараахи 5 төрөлтэй бөгөөд тус бүр бие даасан мөнгөн хөрөнгийн сантай. Сангийн хөрөнгийг шилжүүлэн зарцуулахыг хориглоно. Зориулалтын дагуу зарцуулна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
- Эрүүл мэндийн даатгал

Судалгааны эмхтгэл, XI боть

- Ажилгүйдлийн даатгал

Нийгмийн даатгалын хэлбэр:

1. Заавал даатгал
2. Сайн дурын даатгал гэсэн 2 хэлбэртэй

ААНБ болон иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид нь заавал даатгуулагч байна. Дээр зааснаас бусад иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол сайн дураар даатгуулж болно.

НДСангийн орлого бүрдэлт:

НДС-н эх үүсвэр:

- Даатгуулагч болон ААНБ-аас төлөх шимтгэлийн орлого
- Улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгө
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү
- Шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулах алданги
- Бусад эх үүсвэр

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ:

Сангийн орлогын дийлэнхи хувийг шимтгэлийн орлого бүрдүүлдэг. НДШ-ийг ажил олгогчид сар бүр цалингийн сангаас, даатгуулагч цалин түүнтэй адилтгах нийт орлогоосоо хуулинд заасан дараахи хувь хэмжээгээр төлнэ.

Тэтгэврийн даатгал түүний шинэчлэл:

1. Тэтгэврийн даатгалын агуулга, төрөл
2. Тэтгэврийн даатгалын сан/ ТДС/ -ийн эх үүсвэр, зарцуулалт
3. Тэтгэврийн дааталын нэрийн данс түүний агуулга, ач холбогдол

Өтлөх, өнчрөх, бэлэвсрэх, осол гэмтэлд өртөх эрсдэлээс хамгаалах арга хэмжээг ихэнх оронд “Тэтгэврийн даатгал”-аар дамижуулан гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл өндөр насыны, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдсаны улмаас орлого нь буурсан, амьдралын хэвийн нэхцэл алдагдсан иргэдэд тэтгэвэр олго замаар орлогын эрсдэлээс хамгаалах үүргийг тэтгэврийн даатгал гүйцэтгэдэг.

Тэтгэврийн даатгал нь 100 гаруй жилийн үүсэл, хөгжлийн түүхтэй, сүүлийн 50 жилд эрчимтэй хөгжиж, өөрчлөгдөж шинэчлэгдэж байгаа нийгмийн хамгааллын үндсэн чиглэлийн нэг юм. Иргэдийг ямар төрлийн эрсдлээс хамгаалах зорилгоос нь шалтгаалж З төрөлд ангилдаг. Үүнд:

1. Өндөр настаны тэтгэвэр
2. Тэжээгчээ алдсны тэтгэвэр
3. Тахир дутуугийн тэтгэвэр

1. Өндөр насыны тэтгэвэр

Тухайн улсын хууль тогтоомжид заасан тэтгэврийн насыны болзлыг хангасан, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд төлсөн иргэдэд олгодог тэтгэврийг өндөр насыны тэтгэвэр гэдэг бөгөөд тэтгэвэр олгох шалгур нь тэтгэврийн наас юм. Тэтгэврийн насыг хуульчлан тогтоох, тэтгэврийн наасаа өөрсдөө сонгох гэсэн хоёр үндсэн арга хэрэглэдэг. Ихэнх оронд тэтгэвэр олгох нийтлэг ба ердийн насыг хуульчлан тогтоодог бөгөөд 60-65

насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, хүйс зэргээс шалтгаалан иргэд харилцан адилгүй наснаас тэтгэвэр тогтоолгох тохиолдол нилээд байдаг. Швед Улсын хувьд 67 нас хүртэл ажил логогчтэй гэрээ байгуулан хөдөлмөр эрхэлж болдог.

## 2. Хөдөлмөрийн чадвар алдалтын буюу тахир дутуугийн тэтгэвэр.

Хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдсан бие эрхтний эрсдэлтэй иргэдэд тахир дутуугийн тэтгэвэр олгодог. Энэ тэтгэврийг тогтооход "насны босго"-ыг харгалзахгүй төдийгүй шимтгэл төлсөн, ажилласан хугацаа нь харьцангуй бага байх боломжтой, ажиллах чадваргүй гэдгийг зөвхөн эмнэлэгийн үзүүлтүүдэд үндэслэдэг зэрэг нь түүний хамрах хүрээг нэмэгдүүлэхэд хүргэдэг.

### 3. Тахир дутуугийн тэтгэвэр

Мөн энэ төрлийн тэтгэврийн хэмжээ харьцангуй өндөр, авах хугацаа нь урт учраас ажилгүйдлийн г.м тэтгэвэр, тэтгэмж авахаасаа илүү хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох сонирхлыг иргэдэд илүүтэй бий болгодог сөрөг талууд ажиглагддаг. Англи, Швед, АНУ, Итали зэрэг орнууд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт шинэчлэл хийснээр тэтгэврийн хуримтлалыг нэмэгдүүлэх нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

#### Тахир дутуугийн тэтгэвэр

Өөрчлөлт шинэчлэлийн гол мөн чанар нь эхлээд хүмүүсийн эрүүл мэндэд анхаарч дараа нь хөдөлмөрийн үйл ажиллагаанд дахин оролцуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Тахир дутуугийн тэтгэвэр авагчид нь тэтгэврийн насны болзлыг хангасан нөхцөл өндөр насны тэтгэвэрт шилждэг.

### 3. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Даатгуулагч буюу тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан хүмүүст тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох аргыг ихэнх оронд хэрэглэдэг. Энэ тэтгэвэр олгох гол шалгур нь бэлэвсрэгчид, өнчрөгчид нь хөдөлмөрлөх чадваргүй байх, бага насны хүүхэд буюу тэтгэврийн насандаа хүрсэн байх, амьдрах бэлгүй болсон байх зэрэг нөхцөлүүд ордог.

#### Тэтгэврийн хэлбэр

Үндэсний онцлог, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж ихэнх орон тэтгэврийн хоёр хэлбэрийг хэрэглэдэг.

1. Төрийн тэтгэврийн системд иргэдийг заавал хамруулах "суурь тэтгэвэр", ажиллагчдын орлогын "нэмэгдэл тэтгэвэр" хамрагддаг. Суурь тэтгэвэр нь нийт үндэсний шинжтэй, бүх иргэдийг хамрах тэдэнд амьдралын боломжит нөхцөлийг бүрдүүлэх зорилготой, эдийн засаг, нийгмийн өндөр хөгжилтэй Англи, Япон, Швейцар зэрэг орнуудад хэрэглэгдэж байгаа бөгөөд нэр нь "түгээмэл", "нийтлэг" "үндэсний" "гэх зэрэг янз бүр байдаг
2. Хувийн тэтгэвэр: Төрийн тэтгэврийн бий болгож байгаа иргэдийн нэмэгдэл орлого хүссэн орон зайд зах зээлийн харилцаанд илүү тохирсон, даатгалын зарчимд тулгуурласан хувийн тэтгэврүүд эзлэдэг. Хувийн тэтгэврийн системийн гол шинж нь удирдлага бүтэц, санхүүжилт, ашиг тодорхойлох, ажлын хөлс, төлбөрийг тогтоох зэрэг нь чөлөөтэй байдаг боловч тодорхой эдийн засаг, нийгэм, эрх зүйн орон зайд төрийн зохих хэмжээний оролцоотой үүсч хөгждөг байна.

**Чех Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн дэмжлэг,  
тахир дутуугийн тэтгэвэр**

Тахир дутуугийн тэтгэврийг 2010 оны I сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн актын дагуу тогтоож олгодог байна.

#### 1. Бүрэн тахир дутуугийн тэтгэвэр

Даатгалд хамрагдсан дор дурдсан иргэн бүрэн тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй:

- ✓ ендөр насы тэтгэвэр тогтоолгох болзол хангагүй, бүрэн тахир дутуу иргэн
- ✓ Үйдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бүрэн тахир дутуу болсон иргэн

Тахир дутуугийн бүрэн тэтгэвэр нь Үндсэн ба нэмэгдэл тэтгэврээс бүрдэнэ. Хөдөлмөрийн чадвараа 66 хувиас дээш алдсан иргэн насы хязгаараар даатгалын шимтгэл төлсөн байх болзлыг хангасан тохиолдолд олгодог.

- ✓ Суурь тэтгэвэр – 2170 крон
- ✓ Нэмэгдэл тэтгэвэр жилийн турш төлөх шитгэлийн тооцооны сууриас 1,5 хувь

#### 2. Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан тахир дутуу иргэдийн тэтгэвэр

Даатгалд хамрагдсан дор дурдсан иргэн тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй:

- ✓ Даатгалд хамрагдвал зохих хугацааны болзол, журмыг хангасан
- ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болсон

Тэтгэврийн хэмжээ 2 хэсгээс бүрдэнэ:

- ✓ Үндсэн тэтгэвэр – 2170 крон
- ✓ Нэмэгдэл тэтгэвэр жилийн турш төлөх шитгэлийн тооцооны сууриас – 0,75 хувь

#### 3. Тахир дутуу иргэдэд үзүүлэх төрийн дэмжлэг

- ✓ Тахир дутуу хүүхэд бүхий гэр бүлийн дэмжлэг – хуанлийн сард 7600 крон/хүүхэд 7 нас хүртэл/
- ✓ Хүүхэд асарсны дэмжлэгийг өрхийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингөөс 2 дахин илүү байхаар бодож олгоно.
- ✓ Өргөмөл хүүхдийн тэтгэмж – эрүүл хүүхэд амьжиргааны баталгаажих доод түвшинг 2,3 дахин удаан хугацааны өвчтэй хүүхдэд 2,9 дахин, тахир дутуу хүүхэд 3,1 дахин нэмэгдүүлж олгоно.
- ✓ Өргөж авсан эцэг, эхийн тэтгэмж. Хүүхдийн тооноос хамаарч 3 хүртэл насын хүүхдийн насы хүүхдэд амьжиргааны баталгаажих доод түвшингийн үнэлгээг 1-5,5 дахин өсгөж олгодог

#### 4. Нийгмийн тусламж

Тахир дутуу иргэдэд тусгай хэрэгсэл худалдан авах, зориулалтын автомашин авах, засварлах, хүүгүй зээл зэрэг тогтоосон жагсаалтын дагуу нэг удаагийн нийгтийн тусламж олгодог.

\* \* \*

**Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр нийгмийн хамгаалалын талаар**

Япон улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005 онд батлагджээ.

28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад зориулсан тэтгэмж

- ✓ Гэр оронд нь очиж үйлчилгээ үзүүлэх;
- ✓ Үйл ажиллагааны дэмжлэг, эрүүл мэндийн хамгаалал;
- ✓ Өдөр тутмын амьдралд үзүүлэх үйлчилгээ;
- ✓ Хүүхдийн өдрийн халамж, богино хугацаагаар асрах;
- ✓ Бүлгээр нь асрах байранд байлгах

28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Сургалтын төлбөрын тэтгэлэг:

- a) Нөхөн сэргээх үйлчилгээ;
- b) Хөдөлмөр эрхлэлтэд шилжихийг дэмжих;
- c) Бүлгээр нь дэмжих;

зэрэг тэтгэлгийг орон нутгийн байгууллага шийднэ.

29 дугаар зүйл. Зардлыг нь Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам төлнө. Тэтгэлгийг 90 хүртэл хувиар төлөхийг хуулиар тогтоосон.

**Тайлбар:**

Эдгээр хуулиудын /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль“ 1966, “Хөдөлмөр эрхлэлтын аюулгүй байдлын тухай хууль“ 1947, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль“ 2005/ хүрээнд авч үзвэл ихэвчлэн сургалтуудыг зохион байгуулан хэрэгжүүлж байна.  
Тодруулбал: Мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх сургалт болон техникийн дэвшил үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан шаардлагатай ур чадварын тест, сургалт, зөвлөгөөг боловсруулж Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам тусгай зөвшөөрөл олгож, баталгаажуулдаг нь онцлог, ач холбогдолтой байна.

Хавсралт №3

**МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ**

д/д	Төрөл	Нэг удаа олгох мөнгөний хэмжээ / төгрөгөөр/	Олгох давтамж буюу хугацаа	Хэмжээ, хугацааг тогтоосон эрх зүйн баримт бичиг
-----	-------	---	----------------------------	--

**А.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР**

1	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
---	--	--------	---------	--

Судалгааны эмхтгэл, XI боть

2	Хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, ХБИ бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй тогтоогдсон 60 ба түүнээс дээш насны эрэгтэй, 55 ба түүнээс дээш насны эмэгтэй	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
3	16 насанд хүрсэн одой иргэн	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
4	Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн ХБИ	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
5	16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
6	Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол

## Б.НӨХЦӨЛТ МӨНГӨН ТЭТГЭМЖ

1	Бүтэн өнчин хүүхдийг хууль ёсоор үрчлэн авсан болон хууль ёсоор асран хамгаалж харгалзан дэмжих байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
2	Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
3	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
4	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй, ганц бие ХБИ-тэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
5	Байнгын асаргаа шаардлагатай, ахмад настныг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
6	Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
7	Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол

## В. АМЖИРГААГ ДЭМЖИХ НӨХЦӨЛТ МӨНГӨН ТУСЛАМЖ

1	3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа мөнгөн тусламж	60,000	жилд нэг удаа /хүүхдийн тоогоор/	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа мөнгөн тусламж	30,000	улиралд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
3	3 ба түүнээс дээш насны /14 хүртэлх насны/ хүүхдэтэй өрх толгойлсон эх/эцэг/-т жилд нэг удаа	60,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
4	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа	500,000	нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа	500,000	нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол

## Г. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТУШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1	Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох авьяасыг дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	14,500	7 хоногт	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
2	Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах үйлчилгээ	1 сая төгрөг хүртэл	жилд нэг удаа	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
3	Сэргээн засах үйлчилгээ	55,000	сард	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
4	Түр байрлуулан асрамжлах	9,000	өдөрт	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
5	Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ	48,400	сард	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт

## Д. АХМАД НАСТАНД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖ

1	Хөл, гар, шүд/үнэт металлаар хийхээс бусад/-ний протезийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутамд нэг удаа нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал
2	Сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутамд нэг удаа нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал

Судалгааны эмхтгэл, XI боть

3	Ахмадын зориулалттай амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
4	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь үзүүлэх тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь үзүүлэх тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
6	Эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашиаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
7	Хүндэт донор ахмад настан дотоодын рашиаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
8	НД-ын тухай хууль тогтоомжинд заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд олгох тусламж	225,000	нэг удаа	Нийгмийн халамжийн тухай хууль /НДСангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох тухай заалт/
9	Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин судаг ахмад настан нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
10	Ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл	хүлээн авч хүндэтэл үзүүлнэ	жил бүр	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль

## Е. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖ

1	Бүрэн хараагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Бүрэн хэлгүй дүлий хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол

3	Одой иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
4	Байнгын асаргаа шаардах, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	3 жилд нэг удаа	HXXСайдын 2009 оны 24 тоот тушаал
6	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалыг сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	HXXСайдын 2009 оны 24 тоот тушаал
7	18 хүртэлхи насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүчинлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний худалдан авсан болон ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 5 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	HXXСайдын 2009 оны 24 тоот тушаал
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардалд хөнгөлөлт үзүүлэх	90,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
9	Нийслэл болон хот суурин газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн сургуульд хүүхдийг хүргэж өгөх, авах унааны зардалд жилд нэг удаа хөнгөлөлт үзүүлэх	90,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
10	Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
11	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль

Судалгааны эмхтгэл, XI боть

12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	тухай бүр	сар бүр	Хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийг төрөөс 100% даадаг болсонтой холбогдон зогссон
13	18 насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа, холбооны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	10,000	сар бүр	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
14	Нийслэлийн 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эсхүл иргэн аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тариифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
15	Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх	орон нутгийн тариифт үнээр тооцон олгох	тухай бүр	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
16	Бүрэн хараагүй иргэн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймагаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай боловол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тариифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох	орон нутгийн тариифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
18	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулыг тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тусламж олгох	225,000	нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль /НДСангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох тухай залтг/
19	Хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурх бичиг, сонин сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах	судалгааны үндсэн дээр олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль

## Ё. АЛДАР ЦОЛТОЙ АХМАД НАСТАНД УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОЖ БАЙГАА ТУСЛАМЖ

1	Монгол улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үргэдсэн эхнэр / нөхөрт/-т сар бүр мөнгөн тусламж	200,000	сар бүр	УИХ-ын 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тогтоол
2	Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон болон гавьяат цолтон, төрийн соёрхолт, ахмад дайчин, ударник, ХТАЗ-д үзүүлэх хөнгөлөлт	150,000	сар бүр	УИХ-ын 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тогтоол
Ахмад дайчдын орон сууц		30000000 төгрөгийн үнэтэй	нэг удаа	МУ-ын Ерөнхийлөгчийн 2008 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 170 дугаар зарлиг

## Ж. МОНГОЛ УЛСЫН БААТАР, ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН БОЛОН ГАВЬЯАТ ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС ОЛГОХ НЭМЭГДЛИЙН ТУХАЙ

1	Монгол Улсын гавьяат, төрийн соёрхолт, улсын ударник, ХТАЗутгэлтэн ахмад настанд жилд нэг удаа мөнгөн тусламж	100,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Нийслэлээс аймагт аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	дээрх хуулийн дагуу
3	Дотоодын рашаан сувилалд ирэх, буцах, замын зардал эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	дээрх хуулийн дагуу
4	Орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламжийг 2 дахин нэмэгдүүлж авсан ахмад настан	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
6	Төрийн өндөр албан тушаал хашиж байсан ахмад настанд түлээ, нүүрс авах тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр		том хүн - 10,000 хүүхэд - 5,000	сар бүр	НХХсайд, Сангийн сайдын 2009 оны 152/251 дугаар хамтарсан тушаал

## 3. ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ


1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	зогсоогдсон
2	Шинэ төрсөн хүүхдэд 1 удаа олгох мөнгөн тусламж	
3	Шинэ гэр бүлд 1 удаа олгох мөнгөн тусламж	

Судалгааны эмхтгэл, XI боть

4	Эхийн алдар одонтой эхчүүдэд жилд 1 удаа олгох мөнгөн тусламж	1-р одон - 200,000 2 -р одон - 100,000	жилд нэг удаа	УИХ-ын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол
5	Жирэмсэн болон хөхүүл нярай хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	26,000	сар бүр	УИХ-ын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол

## И. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИАР ИРГЭН БҮРТ ОЛГОХ ХИШИГ ХУВЬ

1	Монгол улсын иргэн бүрт олгох хишиг хувь	21,000	сар бүр	Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хууль
---	--	--------	---------	---



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СТАНДАРТ, ЭРХЗҮЙН ОРЧНЫ  
ТАЛААРХИ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Г. Алтан-Оч (*Ph.D.*), С. Дорждаагва, Θ. Мөнхтүнгэлэг,  
Б. Мөнхцэцэг

### **АГУУЛГА**

1. ОРГАНИК ХҮНС
2. ОРГАНИК ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ЗАРИМ ТОО БАРИМТ
3. ОЛОН УЛСЫН ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДСЭН ХӨДӨЛГӨӨН БА ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРЧМУУД
4. АНУ -Д ҮНДЭСНИЙ ОРГАНИК ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТУРШЛАГА

### **ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

\* \* \*

### **НЭГ. ОРГАНИК ХҮНС**

Үйлдвэржилт хөгжсөнөөр хүнсний хангамжийг шийдвэрлэхийн тулд хүнсэнд олон төрлийн боловсруулалт хийх, нэмэлт бодисоор баяжуулах байдал нилээдгүй түгээмэл болсон байдаг. Энэ нь хэдийгээр хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, шимт байдлыг сайжруулах гэх мэт олон ач холбогдолтой ч сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд хүнсийг органик байдлаар хэрэглэх хандлага улам нэмэгдэх болжээ. Өөрөөр хэлбэл, уламжлалт хөдөө аж ахуйн аргаар боловсруулсан, бий болгосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн буюу бий болгох явцад ашиг шимийг нь нэмэгдүүлэх хандлагатай байлаа. Харин сүүлийн үед уламжлалт хөдөө аж ахуйгаас органик хөдөө аж ахуй руу шилжих шилжилт явагдаж байна.

Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ нь органик хүнсийг үйлдвэрлэх, борлуулах зах зээлд манай орны хувьд багагүй боломж байгааг харуулж олон улсын стандартуудыг чиг баримжаагаа болгон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж чадвал ихээхэн боломжийг бий болгож өгч байгаа юм.

ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙ гэдэг нь хүний эрүүл мэнд, экосистемийн хэвийн байдал, хөрсний үржил шимийг алдагдуулахгүй эрүүл байлган, үйлдвэрлэл явуулахыг илэрхийлсэн цогц систем юм. Энэхүү систем нь тухайн байгалийн болон бусад нөөцийг ашиглахдаа орон нутгийн нөхцөл байдалд дасан зохицсон биологийн төрөл зүйлийн зохицоп, байгаль экологийн өөрийн хэвийн үйл явцыг хангахад суурьладаг ба уламжлалт арга барилыг шинжлэх ухаан технологийн дэвшлийг хослуулснаар, үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэл бүхий л шат дамжлагад, хүн болон байгалийн харилцан шүтэлцээг хангаж, энэхүү харилцаанд оролцогч талуудын амьдралын чанарыг хамгийн сайн байлгах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Органик хөдөө аж ахуй нь эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчны хамгаалал, хүнсний чанар, аюулгүй байдлын асуудал, цаг уурын өөрчлөлт, нийгмийн шударга байдал гэсэн олон ойлголтуудыг хамарсан сайн нөлөөг үзүүлдэг.

Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого нь үйлдвэрлэгч хэрэглэгчийн эрх ашгийг аль альныг нь хамгаалан экологи болон нийгмийн дадал туршлагын сайн хэсгийг дэмжих ёстой ба улс орон бүрийн хувьд органик хөдөө аж ахуйг дэмжсэн бодлого болон дэмжих хүчин зүйл байгаа, байхгүй гэдгээрээ өөр хоорондоо ялгаатай байдаг. Органик хөдөө аж

Судалгааны эмхтгэл, XI боть

ахуйн үндсэн стандартууд нь тогтвортой хөдөө аж ахуйг бий болгоход чиглэгдсэн байдал ба дэлхийн улс орон бүр өөр өөрийн гэсэн онцлогтой бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг органик шинж чанартай болгосноор гарц нэмэгдэж эрчим хүч, газар, хүн хүчийг хэмнэх боломжийг бурдүүлж байна гэж үздэг. Үр ашиг гарч байгаа жишээ: Өмнөд Бразилын улаан буудайн тариаланг органикаар эрхэлж азот шингээгч хүнсний ногоо тариалсны үр дунд химиин бордоо хэрэглэх шаардлагагүй болсон ба Мексикийн коффены тариалан эрхлэгчдийн хувьд бүрэн органик аргаар тариалсны үр дунд буурцагны жин 50% иар нэмэгдсэн байна гэсэн судалгаанууд байна<sup>92</sup>.

Хотжих, үйлдвэржих процесс нэмэгдсэн, цөлжилт гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалж хүний хэрэгцээнд хэрэглэх ургамлыг ургуулахад шаардагдах газар хомсдож байгаа, сүл чөлөөтэй газар нутгийн ихэнх хувийг мал аж ахуйн зориулалтаар ашиглаж, малын тэжээл тариалж буй тариалангийн талбай, энэхүү талбайг гаргахын тулд устгаж буй ойн асуудалтай нягт уялдаж байна.

Үүний нэгэн жишээ: Энэтхэг улс хүн амын өсөлтөө хязгаарлаж чадаагүйгээс өнөөдөр 1,2 тэрбумыг даваад байна. Үүний улмаас хотжих процесс маш хурдацтай өсч тус улсын хөдөө аж ахуй эрхлэх газрын хэмжээ эрс багасжээ. Нөгөө талаар газар их үнэд орж байгаа учраас хөдөө аж ахуй эрхлэгчид газраасаа зарах хандлага нэмэгдэж, тухайн зарагдсан газар нь хөдөө аж ахуйд бус барилга, үйлдвэрийн зориулалтаар ашиглагдаж байгаа нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг бууруулах үндэс болжээ.

Өөр нэгэн жишээ: Европын орнуудын фермерийн аж ахуй өндөр хөгжсөн улсуудад малаас гарах ашиг шимийг нэмэхэд зориулж малын тэжээл, малд зориулсан нэмэлт хүнсийг ихээр тариалсанаар шууд хүний хэрэгцээнд зориулсан хүнсний тариалалтын хэмжээ нэмэгдэж чадахгүйд хүрэх хандлага үүсгэжээ. Эндээс органик хүнс бэлтгэх хэрэгцээ, өсөн нэмэх боломж нь газар тариалан, мал аж ахуйн салбарт бас хоорондын зөрчил эдгээр орнуудад бий болж байгааг харж болох юм.

Органик хөдөө аж ахуй эрхлэх боломж нь үйлдвэржсэн хөгжингүй орнуудад тийм амаргүй нөхцөл байдалтай байдгийн гол шалтгаан нь дэлхий нийтийн хүн амын хэт их хэрэглээ буюу өдөр тутмын хүнсний хэрэгцээний орц найрлага хэт замбараагүй болсон түүнийг хангахын тулд эрхэлж буй үйлдвэрлэлийн хэмжээ төдий хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой.

Дэлхийн уушиг болсон олон ширэнгэн ой, мал ахуйг өргөжихийн хэрээр устаж, агаараас хорт бодисыг шүүж цэвэрлэх, дэлхийн агаарын чадамж, экологийн үйл явц доголдож агаарын байх хорт бодисын хэмжээ хэт ихсэн, энэ нь эргээд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг хязгаарлаж байна. Мөн хүний хэрэгцээнд зориулан органик байдаар үйлдвэрлэх боломжтой бүх төрлийн хүнсний ашигт ургамлуудыг тарьж ургуулах зардлаас мал аж ахуйг тэжээх зардал хэдийн хол давжээ.

Энэ бүхэн бол дэлхий нийт органик хөдөө аж ахуй тэр дундаа органик газар тариалангийн салбарыг нэн даруй анхааралдаа авч дорвитой арга хэмжээ авах цаг нь болсон гэдгийг харуулж байна.

\* \* \*

<sup>92</sup> [http://wwwIFOAM.org/growing\\_organic/1\\_arguments\\_for\\_oa/arguments\\_main\\_page.html](http://wwwIFOAM.org/growing_organic/1_arguments_for_oa/arguments_main_page.html)

## ХОЁР. ОРГАНИК ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ЗАРИМ ТОО БАРИМТ

Дэлхий нийтэд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж буй нийт 1.4 сая үйлдвэрлэгч байдаг ба 2009 оны байдлаар тэдний үйлдвэрлэлдээ ашиглаж буй нийт 35,0 сая га талбайг албан ёсоор органик тариалан гэж баталгаажуулсан байна. Органик тариалан эрхлэгч, дэлхий нийтэд тэргүүлэгч орнуудыг дурьдвал:


Indicator		Leading countries 2009
Countries with data on certified organic agriculture 20091	2009: 160 countries (2008: 154; 2000: 86)	
Organic agricultural land 2009	37.2 million hectares (2008: 35.2, 1999: 11)	Australia (12 million ha), Argentina (4.4 million ha), US (1.9 million ha)
Number of countries with more than five percent organic agricultural land 2009	24 countries (2008: 22); More than ten percent: 7 countries (2008: 6 countries)	Falkland Islands (Malvinas) (35.7 %), Liechtenstein (26.9 %), Austria (18.5 %)
Further, non-agricultural organic areas 2009	41.9 million hectares (2008: 31 million)	Finland (7.8 million ha), Brazil (6.2 million ha); Cameroon (6 million ha).
Producers 2009	1.8 million producers (2008: 1.4 million)	India (677'257), Uganda (187'893), Mexico (128'826)
Organic market size 2009	54.9 billion US dollars or 40 billion euro (2008: 50.9 billion US dollars; 1999: 15.2 billion)	US (17.8 billion euro), Germany (5.8 billion euro), France (3 billion euro)
Number of countries with organic regulations 2010	74 countries (2008: 73 countries)	
Organic certifiers 2010	523 certifiers (2008: 489)	Japan, USA, South Korea
Number of IFOAM affiliates 2011	1.1.2011: 757 affiliates (2008: 734 affiliates 2000: 606 affiliates)	Germany: 98 affiliates; United States: 45 affiliates; India: 44 affiliates

Source: FiBL and IFOAM; for total global market: Organic Monitor; for certifiers: Organic Standard/Grolink.


**Organic agricultural land (including in-conversion areas) and regional shares of the global organic agricultural land 2009<sup>93</sup>**

Region	Organic agricultural land (hectares)	Regions' share of global agricultural land
Africa	1'026'632	2.8
Asia	3'581'918	9.6
Europe	9'259'934	24.9
Latin America	8'558'910	23.0
Oceania	12'152'108	32.6
Northern America	2'652'624	7.1
Total	37'232'127	100.0

**Дэлхийд тэргүүлэгч органик тариалан эрхлэгчид/тариалан эрхлэлтийн газар нутгийн хэмжээгээр**



**Газар нутгийн бүсчлэлээр ангилсан байдлаарх органик хөдөө аж ахуй эрхлэлтийн байдал дэлхий нийтэд:**



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>93</sup> The World of Organic Agriculture Statistics and Emerging Trends 2011. FiBL and IFOAM

Дэлхийн хэмжээнд ашиглах чөлөөтэй, боломжтой гэж үзсэн нийт газар нутгийн 52% ийг хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа үлдсэн 48% ийг одоо болтол ашиглаагүй хэвээр байна. Эдгээр ашиглагдаагүй газар нутагт ой хөвч, усан сангүудын эргэн тойрон, бэлчээр болон зэрлэг байгалийн зүй тогтол багтаж байгаа. Ашиглагдаж байгаа газар нутаг нь тариалангийн газар, бусад хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа гэж хуваагдаж байна. Дэлхийн хэмжээнд нийт 154 орон органик газар тариалан эрхэлж байгаа гэсэн мэдээ байдаг ба эдгээр нь газар нутгийн хэмжээгээр харилцан адилгүй.

Органикаар тариалж буй нийт ургамлын 45% нь эрдэнэшиш, 34% нь буудай болон түүнтэй төстэй ургамлууд, 5% өндөр уурагт ургамлууд, 5% нь хүнсний ногоо, 11% нь жимс жимсгэнэ, самар, кофе, цайны ургамал, хөвөн, болон ил талбайн хүлэмжийн бүх навчт, үрт ургамлууд орж байна. Эдгээр нийт тариалж буй эрдэнэшиш болон буудай, буурцагт ургамлуудын 80% ийг хүний биш малын тэжээлийн зориулалтаар ашиглаж байна<sup>94</sup>.

Ази тивийн хувьд органик байдлаар ашиглаж байгаа нийт газар нутгийн 56% нь Хятад, 31% нь Энэтхэг, 3% Казакстан, 2% Индонез, 8% нь бусад орнуудад ноогдох байна. Мөн Ази тивийн хувьд Япон органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлттэй зах зээл бөгөөд тогтвортой өсөлттэй үнийн өндөр мэдрэмжтэй зах зээл юм.

Органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлт хэрэгцээтэй газар буюу хамгийн их борлуулалт хийгддэг газарт Европ тивд Герман, Франц, Англи, Итали орнууд ордог ба нэг хүнд ноогдох органик бүтээгдэхүүний хэрэглэгээр Дани, Швецарь, Австри, Герман, Швед улсууд тэргүүлдэг байна. Европын хувьд нэг хүнд ноогдох органик бүтээгдэхүүний борлуулалт 1 жилд 28 еврол, буюу жилийн нийт борлуулалт 18 тэрбум евро байдаг байна. Мөн Европ тивийн 38 орон нь органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар бүрэн хэмжээний цогц дагаж мөрдөх журам, албан ёсны хууль тогтоомжтой байдаг.

2011 оноос эхлэн органик бүтээгдэхүүний зах зээл 4%-8% болон түүнээс дээш жилийн өсөлттэй байхаар харагдаж байгаа ба энэхүү өсөлтийг даган хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийн сэтгэл зүйд дараах өөрчлөлтүүд гарч эхэлжээ.

Хэрэглэгчдийн хэрэглээний өөрчлөлтийн хандлага:

- Байгаль орчиндоо анхаарал хандуулах нь нэмэгдэж байна
- Химиин элемент ороогүй бүтээгдэхүүнийг илүүд үзэх болсон
- Бүтээгдэхүүний гарал үүслийг анхаарч шалгадаг болсон
- Оршин сууж байгаа орон нутгаасаа шинэ бүтээгдэхүүн авах сонирхолтой болсон
- Хаяг, шошго, баталгаанд анхаарлаа хандуулдаг болсон
- Чанарыг нэг хэвийн байнга найдвартай байхыг хүсдэг болсон

\* \* \*

#### **ГУРАВ. ОЛОН УЛСЫН ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДСЭН ХӨДӨЛГӨӨН БА ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРЧМУУД**

IFOAM<sup>95</sup>-Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Нэгдсэн Хөдөлгөөн нь дэлхийн 750 гишүүн байгууллага, 116 орныг өөртөө нэгтгэсэн органик хөдөө аж ахуйн нэгдсэн томоохон хөдөлгөөн бөгөөд дэлхий дахинд тасралтгүй өсөн нэмэгдэж буй органик бүтээгдэхүүний

<sup>94</sup> [www.organicmongol.mn](http://www.organicmongol.mn)

<sup>95</sup> <http://www.ams.usda.gov/AMSV1.0/nop>

эрэлт хэрэгцээг хангахын тулд 2008 оны байдлаар дэлхий нийтэд 26 сая га, 2010 оны байдлаар 35 сая га газарт органик тариалан эрхэлж байна гэсэн мэдээг гаргажээ. Тухайн бүтээгдэхүүний органик мөн эсэхийг батлах дэлхий нийтийн баталгааны систем байдаг ба энэ нь зах зээлийн тодорхойлолт, нотлох баримт, стандартуудаас бүтсэн бүгдэд ойлголжтой систем юм. Хэрэглэгчдийг тухайн бүтээгдэхүүнийг органик мөн эсэхэд итгэх итгэлийг олж авахын тулд үйлдвэрлэгчдийн дагаж мөрдөх бүхий л хэм хэмжээг органик бүтээгдэхүүний стандартад тодорхойлж өгсөн байдаг.

Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Хөдөлгөөн нь органик бүтээгдэхүүн болон түүний үйлдвэрлэлийн явцад тавигдах нормыг гаргасан байдаг. Одоо мөрдөгдөж байгаа стандартыг 2005 онд баталсан. Энэ стандартыг шинэчлэхээр төсөл боловсруулан хэлэлцүүлгийн шатанд явж байна. Энэ төслийг хэлэлцүүлгийн явцад гарсан саналын хамт мөн хавсралтад орууллаа /4-р хавсралтыг үз/.

Тус стандарт, нормд баримтлах үндсэн 4 зарчмыг тодорхойлсон байна. Органик хөдөө аж ахуйн зарчмууд нь органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх үндэс бөгөөд дэлхийн хэмжээнд хөдөө аж ахуй эрхлэлтийг сайжруулах замаар органик хөдөө аж ахуйг энхийн зорилгоор бий болгох бүхий л боломжийг тусгасан байдаг. Хөдөө аж ахуй нь хүний өдөр тутмын амьдралын хэрэгцээт хүнсийг бий болгож байдгаараа хүн төрөлхтний амьдрал үйл ажиллагааны үндсэн хэсэг болдог.

Түүх, соёл, нийтмийн үнэт зүйлүүд нь хөдөө аж ахуйд өөрийн тусгалаа олсон байдаг ба органик хөдөө аж ахуйн зарчмуудыг хүмүүс янз бүрийн арга хэрэглэн газар усыг тордох замаар амьтан ургамлыг өөрчлөн хүнсний бүтээгдэхүүн болон бусад эд зүйлсийг үйлдвэрлэх, дахин боловсруулах, хуваарилах, түгээх зорилгоор өргөнөөр хэрэглэх болно. Эдгээрт хүн төрөлхтөн байгалийн бүхий л төрх байдалтай /ландшафт/ харилцан үйлчлэх явцдаа түүнийг үеийн үед ирээдүй хойчдоо үлдээх, бие биетэйгээ харилцан холбоотой байгаль хамгаалах аргууд хамаарна.

Органик хөдөө аж ахуйн зарчмууд нь органик хөдөлгөөнүүдийн бүх хэлбэрийг хөхижүүлэн дэмжихэд чиглэдгээс гадна энэ хөдөлгөөний стандарт, хөтөлбөр, хөгжлийн үндсийг зохицуулж, эдгээрийг дэлхий даяар хэрэглэх бүхий л бололцоог боловсронгуй болгож байдаг. Органик хөдөө аж ахуй нь

- Эрүүл мэндийн
- Экологийн
- Шударга ёсны
- Хариуцлагатай харилцан ашигтай байх

зарчмуудад үндэслэгддэг. Энэ зарчмууд нь нэгдмэл зорилгоор ашиглагдана.

## 1. Эрүүл ахуйн зарчим

Энэ зарчим нь эрүүл хөрсөнд, эрүүл ургамал ургаж энэ нь эрүүл хүн, амьтныг бий болоход нөлөөлөх буюу өөрөөр хэлбэл нийгэм болон амьд бие бүрийн эрүүл мэнд нь экосистемийн эрүүл мэндээс салангид тусдаа оршихгүй гэдгийг харуулна.

\

Эрүүл байна гэдэг нь, амьд биеийн нэгдмэл цул чанар бөгөөд энгийн өвчинеөс биеэ хамгаалах төдийгүй оюун санаа бие бялдраа нийгэм, экологийн сайн сайхны төлөө эрүүл байлгах явдал юм. Органик хөдөө аж ахуйн үүрэг нь хувийн аж ахуй эрхлэгчид бүтээгдэхүүнээ боловсруулахаас эхлээд, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх бүх шатандаа энгийн хөрснөөс эхлээд хүн төрөлхтөн хүртлэх бүх амьд организм болон экосистемийн эрүүл мэндийг дэмжих түүнийг сайжруулахад анхаарах ёстой. Тухайлбал, органик хөдөө аж ахуй нь эрүүл, амар мэнд оршин тогтонохын тулд аливаа өвчинеөс урьдчилан

сэргийлэхэд тус нэмэр болохуйц дээд зэргийн чанартай хүнсний бүтээгдхүүн үйлдвэрлэх ёстойг ойлгох явдал юм.

Энэ зарчим ёсоор эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлж болох хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, амьтанд зориулсан мал эмнэлгийн бэлдмэл, хорхой шавьж устгах химиин хорт бодис / пестицид/, ургамлын бордоо ашиглахаас зайлсхийх ёстой.

## 2. Экологийн зарчим

Органик хөдөө аж ахуйг эрхлэхдээ амьдарч байгаа хүрээлэн буй орчинд нь түүнтэй салшгүй холбоотойгоор зэрэгцэн аливаа үйл ажиллагааг явуулах зарчимд үндэслэгдэх ёстой. Энэ зарчим нь амьд экосистемийн орчинд нь органик хөдөө аж ахуйг эрчимжүүлэх явдал бөгөөд үйлдвэрлэл болон дахин боловсруулалтыг байгалийн нөхцөлд нь явуулахад үндэслэгдэнэ. Жишээ нь, ургамлыг амьд хөрсөнд, амьтдыг цэвэр байгалийн орчинд, загас болон далайн амьтдыг усан орчинд нь өсгөх зэргийг дурдаж болно. Энэ зарчмаар, ургац авах зорилгоор атар газар эзэмших, онгон байгалийн нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх нь байгалийн эргэлт тэнцвэржилтэнд зохистой нөлөө үзүүлдэг гэж үздэг.

Органик хөдөө аж ахуйг удирдахдаа хүрээлэн байгаа орчин, соёл, хүрээлэлд нь дасан зохицох ёстой. Органик хөдөө аж ахуй нь амьд организмын генетикийн олон төрөл зүйл амьтдыг өсгөн орших газар нутаг бий болгох замаар экологийн тэнцвэржилтэнд хүрэх ёстой. Үйлдвэрлэгчид, дахин боловсруулагчид, худалдаачид, органик бүтээгдхүүнийг хэрэглэгчид нь хүрээлэн байгаа орчин, орчны уур амьсгал, ландшафт, биологийн олон төрөл зүйл амьтан, агаар, усыг хамгаалах ёстой.

## 3. Шударга ёсны зарчим

Органик хөдөө аж ахуй нь хүрээлэн байгаа орчин бүхий л амьд биеийн оролцоотой шударга ёсыг бий болгох харилцааг бүтээх ёстой. Шударга ёс гэдэг нь аж ахуй хоорондын харьцаа болон хүмүүс хоорондын харьцаа, бүх амьтдын өөр хоорондын харьцаанд бодитой, хүндэтгэлтэй, тэнцвэртэй хандах байдлаар тодорхойлогдоно. Энэ зарчим нь органик хөдөө аж ахуйд ажиллагсад, аж ахуй эрхлэгчид, дахин боловсруулагчид, түгээн дэлгэрүүлэгчид, худалдаачид, хэрэглэгчид зэрэг оролцогч талуудаас бүхий л түвшинд шударга ёсыг батлан харуулах, энэрэнгүй байх зарчим баримтлахыг шаардана.

Энэ зарчим ёсоор, органик хөдөө аж ахуй нь ядуурлыг бууруулахад субъект бүрийг хамруулж хүрэлцэхүйц хэмжээний сайн чанарын хүнсний бүтээгдхүүнийг үйлдвэрлэхэд эх орны үйлдвэрлэлийг чиглүүлэх ёстой. Мөн амьтан хүртэл өөрийн физиологи, эрүүл мэнд, байгалийн зан үйлдээ тохирсон амьдралын орчин нөхцлөөр хангагдах ёстой гэж заасан байна. Ирээдүй хойч үеийнхээ ашиг сонирхолд нийцсэн экологи нийгмийн шударга ёсны үзэл санааг тооцож байгалийн нөөц баялгаа үйлдвэрлэлд ашиглана. Шударга ёс нь экологи нийгмийн бодит сүйрлийг харгалзан тооцсон нээлттэй тэгш эрхт худалдаа үйлдвэрлэлийн системийг шаардаж байна.

## 4. Харилцан хариуцлагатай байх зарчим

Органик хөдөө аж ахуйн удирдагчид нь хүрээлэн байгаа орчин болон одоогийн ба ирээдүй хойч үеийнхний сайн сайхан аж байдал, эрүүл мэндийг хамгаалахын тулд хариуцлагатай, урьдаас сэрэмжилсэн чанарыг тээж явах ёстой. Органик хөдөө аж ахуй нь гадаад дотоод нөхцөл ба хэрэгцээг нөхцөлдүүлсэн амьд хөдөлгөөнт систем юм. Хэн ч органик хөдөө аж ахуйн аргыг ашиглаж үйлдвэрлэлээ нэмэгдүүлж үр ашгаа дээшлүүлж болох боловч бусдын эрүүл мэнд, сайн сайхан, аж байдалд эрсдэл учруулах ёсгүй. Иймээс, хөдөө аж ахуй эрхлэгчид шинээр бий болж буй аргыг тогтмол хянаж шинэ технологийг байнга үнэлж байх ёстой.

СУДАЛГААНЫ САН

Судалгааны эмхтгэл, XI боть

Хөдөө аж ахуй эрхлэх талаар хангалттай ойлголтгүй тохиолдолд зохих ёсны арга хэмжээнүүдийг урьдчилан авах ёстай. Харилцан хариуцлагатай байх зарчим нь органик хөдөө аж ахуйд хэрэглэгдэх дэвшилтэй технологийн хөгжлийг бэхжүүлэх аргыг нэвтрүүлэхээс гадна эрсдлээс урьдчилан сэргийлэх ёстай.

Энэ тохиолдолд зөвхөн салангид шинжлэх ухааны мэдлэг хангалттай бус, дадлага туршлага, хуримтлагдсан уламжлалт ухаан, орчин үеийн мэдлэг нь оновчтой шийдвэр шалгарсан хэрэглээг бий болгохыг үргэлж сануулж байдаг. Органик хөдөө аж ахуй нь зохицтой технологи ашиглах замаар эрсдлийг арилгах ёстай. Гарах үр дүн нь тодорхой бус генийн инженерчлэл мэтийн өндөр технологиос татгалзах чадвартай байх ёстай.

## **ДӨРӨВ. АНУ-Д ҮНДЭСНИЙ ОРГАНИК ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТУРШЛАГА**

АНУ-ын органик хүнсний үйлдвэрлэл нь /Organic Foods Production Act of 1990/ органик хүнсний бүтээгдэхүүний тухай хуулиар органик хүнсний бүтээгдэхүүний үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна<sup>96</sup>. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас /United States Department Of Agriculture/ органик стандартын шаардлага хангасан мал аж аүйн болон газар тариалангийн органик бүтээгдэхүүнийг баталгаажуулдаг байна. Тус яам нь нийт 90 гаруй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд органик бүтээгдэхүүний үйлдвэрлэх, боловсруулах, худалдаалах бүх шатанд хяналт тавьж ажиллахаас гадна эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөрчил гаргасан аж ахуйн нэгжүүдэд албадлагын арга хэмжээ ч авах эрхтэй байдаг байна.

Үндэсний органик хөтөлбөр /National Organic Programm/ нь органик бүтээгдэхүүнийг АНУ-д болон дэлхий нийтэд таниулах болон баталгаажуулах, хөдөө аж ахуйн маркетингийн үйлчилгээ үзүүлэх, хөгжик байгаа орнуудад органик бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандарт тогтооход дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллаж байна. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс таны ширээн дээр, органик шошго бол баталгаатай органик бүтээгдэхүүн гэдгийг хэрэглэгчдэд итгүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Органик бүтээгдэхүүний стандарт болон шинэчлэгдсэн стандартуудыг зохицуулах;
- Үндэсний хэмжээнд ашиглаж болох бодисуудын жагсаалт гаргаж зөвшөөрөл олгох;
- Баталгаажсан органик бүтээгдэхүүнүүдийг дахин баталгаажуулах;
- Органик бүтээгдэхүүнийг экспортлох болон импортлох бодлогын зохицуулалт;
- Хэрэглэгчдийн санал, гомдлын дагуу хянан шалгах;
- Холбооны зөвлөлийн хороо, үндэсний органик стандартын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх;
- АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны албан хаагчид, хамтран ажиллаж буй байгууллагуудад сургалт зохион байгуулах.

### **Органик стандартын тухай**

Органик стандартыг тогтоохдоо 3 ангилан авч үздэг.

<sup>96</sup> [www.wikipedia.org](http://www.wikipedia.org)

- Газар тариалангийн гаралтай органик бүтээгдэхүүний стандарт: АНУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас органик бүтээгдэхүүн гэж баталгаажулахдаа цацрагийн бохирдолгүй, байгалийн гаралтай хөрс шороонд тарьсан, азотын бордоо болон хортон шавьжны эсрэг пестицид ашиглаагүй, генийн өөрчлөлтгүй байх;
- Мал аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүний стандарт: Мал аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ байгалийн гаралтай органик нэгдлүүдээр боловсруулсан хоол хүнсээр, ямар ч химийн найрлага хольц, технологийн боловсруулалт хийлгүйгээр үйлдвэрлэсэн байх;
- 95 хувиас багагүй хувийн органик бүтээгдэхүүний стандарт: Тус стандарт нь тухайн хүнсний бүтээгдэхүүний 95-аас багагүй хувь нь органик бүтээгдэхүүн байх үндсэн шаардлагуудыг тус тус тавьдаг байна.

Үндэсний органик хөтөлбөр нь эдгээр стандартуудыг таниулах, үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, худалдаалах, борлуулах, маркетингтэй холбоотой бүх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход үндсэн үйл ажиллагаа чиглүүлдэг байна.

\* \* \*

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

- Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалттай орнуудын жагсаалт /2x./
- Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалт бий болгохоор ажиллаж байгаа орнуудын жагсаалт /1x./
- Зарим улс орнуудын органик хөдөө аж ахуйн эрхзүйн баримт бичиг болон танилцуулгуудын файлын жагсаалт /2x., 26 холбоос/
- Олон Улсын Органик Хөдөө Аж Ахуйн Нэгдсэн Хөдөлгөөн (IFOAM)-ий Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн стандарт, 2010 оны төсөл /англиар, 49x./
- АНУ-ын Органик хүнсний үйлдвэрлэлийн тухай холбооны хууль /англиар, 12x./
- АНУ-ын Үндэсний органик хөтөлбөр /англиар, 8x./
- Швейцарийн Органик фермийн аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, маркетингийн стандарт (Bio Suisse), 2011 он /англиар, 58x./
- Европын холбооны биш улсын үйлдвэрлэгчийн органик орлуулагчийн стандарт (IMO), 2010 он /англиар, 100x./

\* \* \*

Хавсралт - 1.

**Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалттай орнуудын жагсаалт**  
List of countries with regulations on organic agriculture

Region	Country	Status
European Union (27)	Austria	Fully implemented
	Belgium	Fully implemented
	Bulgaria	Fully implemented
	Cyprus	Fully implemented
	Czech Republic	Fully implemented
	Denmark	Fully implemented
	Estonia	Fully implemented
	Finland	Fully implemented

	France	Fully implemented
	Germany	Fully implemented
	Greece	Fully implemented
	Hungary	Fully implemented
	Ireland	Fully implemented
	Italy	Fully implemented
	Latvia	Fully implemented
	Lithuania	Fully implemented
	Luxembourg	Fully implemented
	Malta	Fully implemented
	Poland	Fully implemented
	Portugal	Fully implemented
	Romania	Fully implemented
	Slovak Republic	Fully implemented
	Slovenia	Fully implemented
	Spain	Fully implemented
	Sweden	Fully implemented
	The Netherlands	Fully implemented
	United Kingdom	Fully implemented
<b>Others Europe (10)</b>	Albania	Not fully implemented
	Croatia	Fully implemented
	Iceland	Fully implemented
	Macedonia	Fully implemented
	Moldova	Fully implemented
	Montenegro	Fully implemented
	Norway	Fully implemented
	Serbia	Not fully implemented
	Switzerland	Fully implemented
	Turkey	Fully implemented
<b>Asia and Pacific Region (11)</b>	Australia	Only export regulations
	Bhutan	Not fully implemented
	China	Fully implemented
	India	Only export regulations
	Israel	Fully implemented
	Japan	Fully implemented
	New Zealand	Only export regulations
	Philippines	Not fully implemented
	South Korea	Fully implemented
	Taiwan	Fully implemented
	Thailand	Fully implemented
<b>The Americas and Caribbean (14)</b>	Argentina	Fully implemented
	Bolivia	Not fully implemented
	Brazil	Fully implemented
	Canada	Not fully implemented
	Chile	Fully implemented

	Costa Rica	National regulations not fully implemented
	Dominican Republic	Not fully implemented
	Ecuador	Fully implemented
	El Salvador	Not fully implemented
	Honduras	Fully implemented
	Mexico	Not fully implemented
	Paraguay	Not fully implemented
	Peru	Not fully implemented
	US	Fully implemented
Africa' (2)	Ghana	Not fully implemented
	Tunisia	Fully implemented

\* \* \*

**Хавсралт - 2.**

Органик хөдөө аж ахуйн эрх зүйн зохицуулалт бий болгохоор ажиллаж байгаа  
орнуудын жагсаалт

Countries with regulations in development

Region	Country
'Europe' (3)	Bosnia Herzegovina
	Russia
	Ukraine
'Asia' and Pacific Region (8)	Armenia
	Azerbaijan
	Georgia
	Hong Kong
	Indonesia
	Lebanon
	Saudi Arabia
	Vietnam
The Americas & Caribbean (3)	Cuba
	Nicaragua
	St. Lucia
'Africa' (2)	Cameroon
	Egypt
	Madagascar
	South Africa

**Хавсралт-3**

- Зарим улс орнуудын органик хөдөө аж ахуйн эрх зүйн баримт бичиг болон танилцуулгуудын файлын жагсаалт

**ХАВСАРГАСАН PDF-ФАЙЛУУД**

1. Basic Standards list. IFOAM /4 pages - [www.ifoam.org/](http://www.ifoam.org/)
2. The IFOAM Basic Standards for Organic Production and Processing. Version 2005 /136 pages - [www.ifoam.org/](http://www.ifoam.org/)
3. The Process of Certification. IFOAM./17 pages – [www.ifoam.org/](http://www.ifoam.org/)
4. An International Standard for Forest Garden Products (FGP). IFOAM. /53 pages - [www.analogforestrynetwork.org/](http://www.analogforestrynetwork.org/)
5. OFDC Organic Certification Standards. Organic Food Development and Certification Center. April 2009. /68 pages - [www.ifoam.org/](http://www.ifoam.org/)
6. The World of Organic Agriculture. (Statistics & Emerging Trends 2011) FiBL AND IFOAM /292 pages - [www.ifoam.org/](http://www.ifoam.org/), [www.fibl.org/](http://www.fibl.org/)
7. The IFOAM STANDARD for ORGANIC PRODUCTION and PROCESSING Version 2010 – Draft version 0.1. Compilation of comments and responses from the IFOAM Standard Committee. Comments received during the consultation period February – March 2011. Responses prepared during the period April-August 2011. /125 pages - [www.ifoam.org/](http://www.ifoam.org/)
8. The World of Organic Agriculture: Regulations and Certification: Emerging Trends 2008. Presented at BioFach Congress 2008, Nuremberg, February 2008. /13 pages – [www.fibl.org/](http://www.fibl.org/)
9. Organic production and labeling of organic products and repealing Regulation. (EEC) No 2092/91. Council Regulation (European Council) No 834/2007. June 2007. /23 pages - [www.ifoam-eu.org/](http://www.ifoam-eu.org/)
10. Overview of the implementation of the EU organic regulatory system. Standards & regulations. /8 pages - [www.ifoam-eu.org/](http://www.ifoam-eu.org/)
11. Organic production of agricultural products and indications referring thereto on agricultural products and foodstuffs. COUNCIL REGULATION (EEC) No 2092/91. of 24 June 1991 /95 pages – [www.ifoam-eu.org/](http://www.ifoam-eu.org/)
12. Bio Suisse Standards for the production, processing and marketing of produce from organic farming. Edition of 1 January 2011. /58 pages - [www.bio-suisse.ch](http://www.bio-suisse.ch)
13. IMO Organic Equivalence Standard for Operators in Non-EU countries. Vers1.2. 2010 /100 pages [www.imo.ch/](http://www.imo.ch)
14. The law concerning standardization proper labeling of agricultural and forestry products. Japan. 2006 /20 pages/
15. Organic Foods Production Act Backgrounder. US. /11 pages - [www.ota.com/pp/legislation/](http://www.ota.com/pp/legislation/)
16. FEDERAL ORGANIC FOODS PRODUCTION ACT OF 1990. (7 U.S. Code including amendments as of January 1, 2004) /13 pages - [www.sarep.ucdavis.edu/organic/complianceguide/](http://www.sarep.ucdavis.edu/organic/complianceguide/)
17. QUALITY CONTROL FOR PROCESSED FOODS. Report of the APO Seminar on Quality Control for Processed Food held in the Republic of China, 8-14 May 2002. /68 pages - [www.cpc.org.tw/](http://www.cpc.org.tw/)
18. ARGENCERT S.A. is a Certification Body offering independent third party certification. ARGEN-TINA. Version V1.09 /77 pages - [www.argencert.com.ar/](http://www.argencert.com.ar/)
19. The National standard for organic and bio-dynamic produce. Australia. Third edition. December 2002. /67 pages - [www.analogforestrynetwork.org/](http://www.analogforestrynetwork.org/)
20. NASAA Organic Trader Standard. August 2005. Australia. /14 pages - [www.nasaa.com.au/](http://www.nasaa.com.au/)
21. Organic Standards for Agriculture Production. TanCert-Tanzania Organic Certification Association. Short Standards for Local Market. December 2003. /13 pages/
22. East African Organic Standard-Draft. With comments. September 15, 2006. /42 pages - [www.beesfordevelopment.org/](http://beesfordevelopment.org/)
23. EnCert Organic Standards. Africa. June 2007. /61 pages - [www.encert.co.ke/](http://www.encert.co.ke/)
24. Food and Agricultural Import Regulations and Standards – Narrative. Israel. 2010. /33 pages -

[http://gain.fas.usda.gov/recent gain publications/ /](http://gain.fas.usda.gov/recent_gain_publications/)

25. Food and Agricultural Import Regulations and Standards – Narrative. Japan. 2009. /12 pages -  
[http://gain.fas.usda.gov/recent gain publications/ /](http://gain.fas.usda.gov/recent_gain_publications/)
26. Organic Agriculture in Turkey. Trade opportunities for organic fruit and vegetables. Applied Plant Research. 2008. /27 pages - [www.ppo.wur.nl/](http://www.ppo.wur.nl/)



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БОДЛОГО ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ц. Товуусүрэн, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа,  
Ө. Мөнхтунгалаг, С. Дорждагва

### Агуулга

#### Оршил

1. **ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ**
  - 1.1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрх зүйн орчны тойм
  - 1.2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, стандартын хяналтын талаар албан ёсны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
    - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2010 оны шалгалтын дүн мэдээлэл
    - Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад атестатчилал явуулсан дүн
  - 1.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын ангилал, онцлог зохицуулалт
2. **ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**
  - 2.1. Нийслэлийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
  - 2.2. Улсын хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ
  - 2.3. 2005 - 2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар

#### Судалгааны дүгнэлт, санал, зөвлөмж

#### Ашигласан материал

\* \* \*

### ОРШИЛ

“Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлыг УИХ-ын гишүүн Ч. Улааны захиалгаар УИХ -ын Тамгын газрын судалгааны төвийн ахлах-референт Ц.Товуусүрэн, шинжээч Ч.Онончимэг, референт Ц.Элбэгзаяа, Ө. Мөнхтунгалаг, С.Дорждагва нар гүйцэтгэв.

**Судалгааны зорилго.** Судалгааны сэдвийн хүрээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж тус салбарын тулгамдсан асуудлуудыг судлан тодруулж судалгааны мэдээлэл бэлтгэх, санал, зөвлөмж боловсруулахад энхэхүү судалгааны ажил чиглэгдсэн болно.

**Судалгааны арга:** Судалгааны ажилд баримт бичгийн контент-анализ, харьцуулалт, статистикийн шинжилгээний аргууд болон холбогдох мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудын дунд явуулсан фокус бүлгийн ярилцлага, диалогийн аргуудыг ашиглав.

**Мэдээллийн эх сурвалж.** Судалгаанд Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого болон энэ салбарт хэрэгжиж байгаа 2 хөтөлбөр, ХХААХҮЯ-наас 2009 оноос хойш боловсруулан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт баримтлан ажиллаж буй 1 журам, 3 стандартын талаарх тус яамнаас ирүүлсэн танилцуулга, НМХГ-ын газрын 2010 оны шалгалтуудын дүгнэлт, НЗАА -ы YYХ-ийн Согтууруулах ундаа худалдаа, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад атестатчилал явуулсан 2010 оны дүн мэдээлэл, УСГ-ын жилийн болон улирлын статистик мэдээллүүд, Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын агентлагаас 2005-2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл, Монгол Улсад Худалдаа, нийтийн хоолны байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой, хүнс, хоол үйлдвэрлэлийн салбарт инженер бэлтгэж эхлэсний 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулгадсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний инновацийн асуудал” сэдэвт онол-практикийн хурлын материал зэрэг албан ёсны мэдээллийг ашиглав.

**Судалгааны агуулга.** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ судалгааны ажлын хүрээнд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдлын талаархи нэгдсэн мэдээллийг тоймлон гаргаж Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэх буй байр суурийг тодорхойлох, улмаар энэ салбарын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч тулгамдсан асуудлуудыг тодруулах зорилго тавив.

Судалгааны “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний өнөөгийн байдлын тойм” хэсэгт тус салбарт хэрэгжиж байгаа эрх зүйн баримт бичгүүд, үндэсний хөтөлберийн хэрэгжилтийн байдал цаашид хийгдэхээр төлөвлөгдсэн ажлын хийсэн дүн шинжилгээг тоймлон оруулав. Энэ хэсэг Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрх зүйн орчны тойм, Хоол үйлдвэрлэл үйлчилгээний технологи стандартын хяналтын талаарх албан ёсны мэдээлэд хийсэн дүн шинжилгээ, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ангилал, онцлог зохицуулалт гэсэн 3 дэд хэсгээс бүрдэж байгаа.

**“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын статистик мэдээлэл”** хэсэгт Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт улсын хэмжээнд нийт хэдэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулж байгаа талаархи нэгдсэн тоо баримтыг гаргахыг зорьж УСГ-ын жилийн болон улирлын статистик мэдээлэл, Худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар дүн шинжилгээ хийсэн. Энэ хэсэгт Нийслэлийн хоол, үйлдвэрлэл үйчилгээний салбарын статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, Улсын хэмжээнд хоол, үйлдвэрлэл үйчилгээний салбарын статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, 2005-2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэлийг багтаав.

**“Судалгааны дүгнэлт, санал, зөвлөмж”** хэсэгт судалгааны мэдээлэлд үндэслэн тус салбарын хэмжээнд анхаарал татсан асуудлуудыг тодорхойлж, мэргэжлийн байгууллагууд болон мэргэжилтнүүдээс гаргасан саналуудыг багцлан тусгав.

\* \* \*

## **Нэг. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

### **1.1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрх зүйн орчны тойм**

Нийтийн хоолны салбарыг онолын хувьд “хоол үйлдвэрлэлийн” гэж нэрлэдэг байна. Үүнээс үзэхэд нийтийн хоолны салбар бол “худалдааны” салбарт хамаарах бус “үйлдвэрлэлийн” салбарт хамаарч явах учиртай юм. Өөрөөр хэлбэл, нийтийн хоолны салбар бол хүнсний бүтээгдэхүүн буюу “түүхий эд”-ийг үйлдвэрлэлийн явцад боловсруулалт хийж хэрэглэгчдэд

шууд хүргэж байгаа нэмүү өртөг бий болгож байгаа үйлдвэрлэлийн салбар юм. 1990-ээд онд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш үндсэндээ төрийн оролцоо, дэмжлэгүйгээр цэвэр зах зээлийн зохицуулалтаар явж иржээ.

Салбарын эрх зүйн зохицуулалтын хувьд хэд хэдэн эрх зүйн баримт бичгийг хамааруулж ойлгож болох ч хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын тусгайлсан хууль байхгүй бөгөөд Хүнсний тухай хуулиар Засгийн газар, салбарын сайдад олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гаргасан эрх зүйн баримт бичиг, холбогдох стандартын хүрээнд зохицуулагдаж явж иржээ. Мөн түүнчлэн, УИХ, Засгийн газраас тус салбарт хамаарах төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, дагнасан үндэсний хөтөлбөрүүдийг батлан гаргаж хэрэгжүүлж иржээ. Үүнд: Монгол Улсын Засгийн газраас "Хүнсний аюулгүй байдал" хөтөлбөр, Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн цай" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. ХХААХҮЯ-наас 2009 оноос хойш дараах эрх зүйн эрх зүйн баримт бичгийг боловсруулан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар баримталж ажиллаж байна.<sup>97</sup> Үүнд:

1. Хоолны газрын нийтлэг журам:
  - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/206 дугаар тушаалаар баталж мөн оныхoo 10 дугаар сараас эхлэн мөрдөгджэй байна.
2. Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага
  - Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 4946:2005
3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал:
  - Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 39: 2009.
4. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг. Техникийн ерөнхий шаардлага:
  - Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 6192 : 2010

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчин 2000 оноос өмнө дүрэм, журмаар зохицуулж байсан. Үүнд:

- "Хоолны газрын ажлын үлгэрчилсэн дүрэм" Худалаа, үйлдвэрийн сайдын 1996 оны A/103 дугаар тушаалаар баталсан
- "Хоолны газрын ариун цэврийн нийтлэг дүрэм" Худалаа, үйлдвэрийн сайдын 1996 оны A/343 дугаар тушаалаар батлагдсан
- "Хоол үйлдвэрлэлийн чанарт тавих хяналтыг хүчтэй болгох тухай" / технологийн карт мөрдөх журам/ ХААҮ-ийн сайдын 1997 оны A/42 тоот тушаал

Эдгээр дүрэм журмыг Үйлдвэр, худалдааны сайдын 2002 оны 46 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна. Үндэслэл нь, суурь стандарт болох "Хоолны газрын үйлчилгээ" Монгол улсын стандартыг анх 2000 онд батлан 2005 оноос "Хоолны газрын ангилал, зэрэглэл Ерөнхий шаардлага" MNS 4946:2005 стандартыг шинэчлэн мөрдүүлж эхэлсэн. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт өөр хяналт шалгалтын хууль эрх зүйн дүрэм, журам батлагдан гараягүй байна. Энэхүү стандарт нь хоолны газрын үйлчилгээний ангилал, зэрэглэлд тавих үндсэн шаардлагыг тогтооход хамаарч байна.

МУ-ын "Мастер тогооч" шалгаруулах журмыг шинэчлэн батласан. Хүнсний тухай хуульд салбарын асуудал төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд "6.1.2. хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх технологи болон ургамал, амьтны гаралтай түүхий эдийн ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг журам, хэм хэмжээ, шаардлагыг тогтоох," хэмээн заасны дагуу дээрх "Хоолны газрын нийтлэг журам"-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү

<sup>97</sup> ХХААХҮЯ-ны ХҮХҮБХЗГ-аас ирүүлсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга 2011 он

журмыг гаргахаас өмнө бусад 3 стандартыг мөрдөж, хэрэгжилтэд нь мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт тавьж ажиллаж иржээ.

**ХХААХҮЯ-наас хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн баримт бичгийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тодруулахад:**

- Худалдаа, бэлтгэлийн сайдын 1985 оны 314 дугаар тушаалаар батлагдсан нийтийн хоолны газруудад мөрдөх “Хоолны жор, технологи”-ийг 26 жил хоол үйлдвэрлэлийн салбарын ажиллагсад, оюутан сурагчдын гарын авлага, салбарын чухал эрх зүйн баримт бичиг болж ирсэн гарын авлагыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баяжуулж гаргахаар салбарын эрдэмтэн, доктор, инженер технологич, мастер тогооч нар оролцсон баг судалгаа шинжлэгээний ажил хийгдэж эхэлсэн.
- “Хоолны газрын ангилал, зэрэглэл Үндсэн шаардлага” MNS4946:2005 стандартын шинэчлэн боловсруулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

### **ХХААХҮЯ-наас Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 2012 онд**

- Нийтийн үйлчилгээний хоолны газрудад /эмнэлэг, цэргийн анги, үйлдвэрийн ажилчдын хоолны газар/ НАССР- системийг нэвтрүүлэж эхлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сурх бичиг, гарын авлагагаар хангах
- Холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран Тогооч нарын мэргэжил ур чадварын аттестатчилж явуулж улмаар 2013 оноос эхлэн мэргэшлийн зэргээр цалинжуулах шинэ журамд шилжүүлэх.
- ЕБС-ын “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд БСШУЯ-тай хамтран сургуулийн хоолны комбинат, нэгдсэн үйлдвэрлэлийн газрыг байгуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөгдсөн байна.

### **1.2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, стандартын хяналтын талаар**

Хоол үйлдвэрлэлийн технологийн хяналтын талаар ярихын өмнө зайлшгүй тавигдах нөхцөл, шаардлагуудыг товчхон авч үзье. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага” 4946-2005 улсын стандартыг 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж байгаа бөгөөд энэхүү стандартын улсын үзлэг 2010 онд, дараа нь 5 жил тутамд хийгдэх ёстай.

Энэхүү стандарт нь хоолны газрын үйлчилгээний ангилал, зэрэглэлд тавих үндсэн шаардлагыг тогтооход хамаарах бөгөөд хамаарах бөгөөд уг стандартын норматив шаардлагыг заавал мөрдөх ёстай. Үүнд:

- Хоолны газрын барилга байгууламжид тавих шаардлага
- Хоолны газрын галын аюулгүй байдлын шаардлага
- Хоолны газарт тавих эрүүл ахуйн шаардлага
- Хоолны газрын инженерийн байгууламж, техникийн байдалд тавих шаардлага
- Хоолны газрын орчны тохижилтод тавих шаардлага
- Хоолны газрын хүний нөөцөд тавих шаардлага
- Техникийн шаардлага
- Хавсралтуудад гадаад орчин, дотоод ерөнхий зохион байгуулалт, үйлчилгээний танхим, үйлдвэрлэлийн байранд тавих шаардлага, туслах байр, үйлдвэрлэл, үйлчилгээ, цэнгээн, үйлчилгээний сав багаж хэрэгсэл, хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага, мэргэжил ур чадварын шалгуурууд зэрэг багтдаг байна.

## Дотоод хяналт

Аливаа хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн шат дамжлаг бүрт хяналж чанар болон аюулгүй байдлыг тодохойлж, үнэлэх, засварлах, цогц арга хэмжээг дотоодын хяналт гэнэ. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад дотоодын хяналт маш чухал үүрэгтэй байдаг. Ийм газруудад хяналт тавих үүрэг бүхий ажилтан заавал байх шаардлагатай байдаг. Хяналт хийж буй ажилтан нь үйлдвэрлэл, үйлчилгээний явц, дотоод ажлын талаар маш туршлагатай хүн байж хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх дотоодын стандарт, дүрэм журмыг хэрхэн үр өгөөжтэй хангуулах арга замыг тодорхойлж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд гарах эрсдлээс сэргийлэх үүрэгтэй.

### Хоол үйлдвэрлэлийн технологийн хяналт

**Хоолны газар** - хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулдаг объектыг хэлнэ.

**Хоолны газрын үйлдвэрлэл** - Шаардлага хангасан байранд зориулалтын тоног төхөөрөмж, чанарын батиалгаатай түүхий эд, материал ашиглан, зөвшөөрөгдсөн жор технолиор, мэргэжлийн ажилчдад тулгуурлан хэргэлээний шаардлага хангахуйц чанартай хоол, унд үйлдвэрлэх ажиллаа юм. Хоол үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа нь тодорхой үүрэг зорилго бүхий үе, шат дамжлага, ажилбаруудаас бүрддэг. Технологийн үйл ажиллагаа нь хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авч хадгалах, хоолны бэлдэц, хоол ундаа үйлдвэрлэх, борлуулах гэсэн үе шаттай байна.

### Үйлчилгээний технологийн хяналт

Хэрэглэгчийн хоол, үйлчилгээний хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааг –хоолны газрын үйлчилгээ. Үйлчилгээний технологи нь хоол ундаа, бүтээгдэхүүн борлуулах явцад тодорхой уялдаа холбоо тогтсон дэс дарааллын дагуу хийгддэг нэгдмэл ажилбарыг хэлнэ. Судалгааны сэдвийн хүрээнд тус стандартын дагуу НМХГ-ын 2010 оны шалгалтын дүн мэдээлэл болон судалгааны санал асуулгын дүнг авч үзье.

### Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын 2010 оны шалгалтын дүн мэдээлэл болон судалгааны санал асуулгын дүн

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын дотоод хяналтын тогтолцоо ямар байгааг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын 2010 оны шалгалтын дүн мэдээлэл болон судалгааны санал асуулгын дүнгээс авч үзье.<sup>98</sup> Судалгааг 16-40 суудалтай 31 газарт хийсэн байна. Судалгаанд нийт цэг салбарын 7 буюу 22,5 % нь мэргэжлийн удирдлагатай, бусад нь мэргэжлийн бус удирдлагатай /45 хоногийн дамжаагаар олгогдсон үнэмлэхтэй эздийг мэргэжлийн гэж тооцсон/.

- Хоолны чанар аюулгүй байдлыг хянах дотоодын хяналтын тогтолцоо бүрэн нэвтэрсэн 12,7%
- Хоолны амт чанарт үнэлгээ өгч борлуулалтанд гаргадаг 32,0%
- Хоолны дээжийг шаардлагад нийцүүлэн тогтмол авч хэвшсэн 16,4%
- Дотоодын хяналт шалгalt гэж юу болохыг отг мэдэхгүй 38,9% байна.

Хоол, хүнсний аюулгүй байдлын талаар үйлчлүүлэгч 100 хүнээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд:

- Хоол хүнсний зүйлийн баталгааг 100% найдвартай гэж тооцдог 8,6 %
- Хоолны газарт хийсэн хоолыг дотооддоо шалгаж гаргадаг гэж найддаг 51,2%

<sup>98</sup> НМХГ-ын улсын ахлах байцаагч С.Нарангэрэл /Ph.D/, “Хоол үйлдвэрлэлийн технологийн хяналт”, онол-практикийн бага хуралд тавьсан илтгэл, 2011 оны 04 сар.

- Хоолны газарт хийсэн хоолыг огт шалгадаггүй тул найдвартгүй гэж үздэг 34,4%
- Энэ талаар огт мэдэхгүй гэж 5,8% нь хариулт ёгсөн байна.

Харин үйлчилгээний танхимд тавьдаг хяналтын талаар авсан санал асуулгын дүнгээс үзвэл үйлчилгээний танхимд 82,7% нь байнга хяналт тавьдаг гэсэн хариулт өгчээ. Дээрх санал асуулга болон удаа дараагийн хяналт шалгалтын дүнгээс үзэхэд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад дотоодын хяналт шалгалтын талаар хэвшил тогтоогүй, хоолны жор технологийн хяналт орхигдсон, дурын жор технологиор хоол, ундаа үйлдвэрлэж байгаа нь эдгээрийг зохицуулах зөвлөмж, аргачлал байхгүй, бизнес эрхлэгчдэд хоол, хүнсний аюулгүй байдлын талаар мэдлэг дутмаг байгаатай холбоотой юм.

Учир нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ихэнх нь мэргэжил олгох түр дамжаа төгссөн боловч амьдрал дээр тэдний мэргэжлийн ур чадвар шаардлагын хэмжээнд хүрэхгүй, онолын наад захын мэдлэггүй хүмүүс өөр өөрийн дур зоргоороо хоол үйлдвэрлэл, үйлчилгээ удирддаг нь өнөөгийн тавигдаж байгаа шаардлагад нийцэхгүй үйлчилүүлэгчдийг хохироох, зөвхөн мөнгө олох үйлчилгээ мэт ойлгогдох явдал илэрхий ажиглагдаж байна.

Хэрэглэгчдийн зүгээс нийтийн хоолны үйлдвэрлэлд онцгой анхаарал тавьж өдөр тутмын амин дэм, шим тэжээл гэдгийг ухаарагч гэж үйлчилгээний чанарт ахиц гарагч гэж үзэж болно. Орчин үед нийтийн хоолны үйлчилгээ өнгөн талаас нь харвал их өргөжин хөгжсөн мэт харагдах боловч гадаад үзэмж, үйлчилгээний заалны үзэмжид илүү анхаараад үйлдвэрлэлийн ариун цэвэр, эрүүл ахуйн журам, үйлчилүүлэгчдийн эрүүл мэндэд бага анхаарч хоолны жор технологийг мөрдөхгүй байх зөрчил нийтлэг байна.

### **Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад явуулсан атестатчиллын дүн**

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны даргын баталсан “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад атестатчилал явуулах тухай” удирдамжийн дагуу Захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналт, Цагдаагийн хэлтсийн нийт 30 гаруй ажилтан улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй 9 групп 2010 оны 04 дугээр сарын 12-ноос 05 сарын 10-ний хооронд нийслэлийн хэмжээнд 221 ресторан, 302 баар, 115 кафе, нийт 827 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартын биелэлт, хүнсний аюулгүй байдал, жор, технологийн мөрдөлт, эрүүл ахуй, ариун цэвэр нийгмийн дэг журмыг хэрхэн хангаж байгаа байдлыг шалгасан байна.<sup>99</sup>

### **Стандартын шаардлагын биелэлт**

Энэхүү атестатчилал нь нийслэлийн хэмжээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээ ямар түвшинд байгааг тогтоох, цаашдын бодлого чиглэлийг боловсруулах, авах арга хэмжээг төлөвлөх үндсэн зорилгоор атестатчилал явуулсан байна. Атестатчилалд нийт 1017 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар хамрагдахаас нийт 827 буюу 81 хувь нь хамрагджээ. 19 хувь нь үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон, засвар тохижилтын ажил хийж байгаа зэрэг шалтгаанаар шалгалтанд хамрагдаагүй байна.

Стандартын шаардлага хангасан газруудын дундаж түвшинг авч үзвэл ресторан 92,9%, баар 89,5%, кафе 90,6% шалгагдаж, нийт хамрагдсан цэг салбаруудын дундаж 91%

<sup>99</sup> Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Д.Доржцэнд, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад явуулсан атестатчиллын дүнгээс” онол-практикийн бага хуралд тавьсан илтгэлээс, 2011 оны 04 сар.

байна. Энэ дүнг 2009 оны мөн үеийн атестатчилын дүнтэй харьцуулан үзэхэд стандартын шаардлага хангасан түвшин 2,5 хувиар дээшилсэн байна. Шалгалтаар ресторан, бар, кафенууд нь үйлчилгээний танхимын дотор тохижилт, засаг чимэглэлийг өөрийн онцлог, нэр хаяганд нийцүүлэн хийсэн, тоног төхөөрөмжүүдийг технологийн урсгал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тохируулан хийсэн, хоолны нэр төрлийг олшуурах, өнгө үзэмжийг дээшлүүлэх, нэмэлт шинэ үйлчилгээг нэвтрүүлэх талаар санаачлага гарган ажиллаж байгаа хэдий ч дараах зөрчил нийтлэг байна.

- Ажлын байрны эрүүл ахуйн төлөв байдлын хувьд зориулалтын бус байранд 50 гаруй хувь,
- Хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалт, бэлтгэн боловсруулах өрөө тасалгаа нь стандартын шаардлага хангаагүй 62,6 хувь,
- Хятад, Солонгос хоолны газруудын хоол үйлдвэрлэлд хэрэглэж буй амтлагч, нарийн ногоонууд хэзээ, хаана бэлтгэсэн нь тодорхойгүй, шинжилгээнд бүрэн хамруулдаггүй
- Хоолны газруудын хоолны хэрэгсэл нэг суудалд 2-оос доошгүй ээлжээр хангагдсан байхаар заагдсан ч нэг ч цэг салбарт 50 хувийг ч хангахгүй
- Аяга, таваг угааж халдвартгүйжүүлэх ажиллагаа, ажилчдын хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм хангалгүй зэрэг зөрчил түгээмэл байсан байна.


Тус атестатчиллаар 58 аж ахуйн нэгжид 2 жилээр 580 аж ахуйн нэгжид жилийн хугацаатайгаар нийт 680 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл эзэмшүүлэхээр, 180 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

### **1.3 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ангилал, онцлог зохицуулалт**

Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл хоол хэрэглээг зохион байгуулахад хоолны газар чухал үүрэгтэй. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг тогтоосон технологийн горим мөрдөөгүй, ариун цэврийн зохистой дадал хэвшил тогтоогүй нөхцөлд хүний эрүүл мэнд, амь насанд хор хохирол учруулж болзошгүй, хүнсний аюулгүй байдал алдагдах магадлал бүхий үйлдвэрлэл үйлчилгээний салбар гэж үздэг.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг үндсэн хоёр хэсэгт хуваан авч үздэг. /Схем 1/

1. Бизнесийн байгууллагууд: /зочид буудал, зоогийн газар, тээврийн үйлчилгээ, клубууд, түргэн үйлчилгээний хоолны газар, хүлээн авалтын үйлчилгээ/
2. Нийгмийн халамжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага: /хоолны газрууд, сургууль, эмнэлэг, цэрэг, цагдаагийн, хорих байгууллага, ажилчдын хоолны газар, гэрээт хоол үйлчилгээ/



## Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын ангилал



Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг **бизнесийн** болон **нийгмийн халамжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд** гэж ангилдаг бөгөөд эдгээр байгууллагуудын онцлог зохицуулалтын талаар товч дурьдъя.

**Бизнесийн байгууллагуудын** хувьд өрсөлдөөний зарчмаар хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн хэдий ч хоол үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдал, үйлчилгээний соёл, мэргэжилтэй боловсон хүчиний дутагдалтай зэрэг бэрхшээлүүд их байна.

**Нийгмийн халамжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг хоол үйлчилгээний байгууллагуудын** хувьд сургууль, коллеж, их, дээд сургууль, эмнэлэг, шорон, цэрэг, арми зэрэг байгууллагуудын хоол үйлчилгээг хамруулан авч үздэг. Эдгээр байгууллагуудын хоол үйлчилгээний онцлог нь засгийн газраас зохих хэмжээний тэтгэмж, татаас олгосноор санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг онцлогтой.

Төрийн халамж үйлчилгээнд байдаг, орлого багатай эмзэг хэсгийн хоол үйлчилгээний асуудлыг өөрчлөн зохион байгуулах шаардлага тулгарaad байна. Учир нь дунд сургуулийн хоол үйлчилгээний байдлыг авч үзвэл төрөөс татаас олгон “үйдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь дийлэнх сургуулиудын хувьд стандартын шаардлагыг зохих түвшинд хангаж чадахгүй байна. Төр засгаас их сургуулийг хоткон хэлбэрээр өөрчлөн хөгжүүлэх төслийг эхлүүлж байгаатай зэрэгцэн оюутан залуусын хоол үйлчилгээнд шинэчлэлт хийх зайлшгүй нөхцөл байгааг салбарын эрдэмтэн судлаачид дурьдаж байсан.

Эмнэлгийн хоол үйлчилгээний гол зорилго нь тухайн өвчтөний эмийн эмчилгээнд хоол эмчилгээгээр шууд болон дам үзүүлэн зэрэгээр нөлөөлөхөд оршидог. Гэвч манай эмчилгээний хоол үйлдвэрлэл үйлчилгээний одоогийн байдлаас үзвэл дээрх зорилгодоо бүрэн хүрээгүй, зарим тохиолдолд хоол өгч байгаа нэр төдий, эрүүл ахуй, шим тэжээлийн чанарын асуудлыг шийдвэрлээгүйгээс “өвчтөний эргэлт” хэмээх үйлчилгээ байсаар байна.

### Хоёр. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд энэ цаг хугацаанд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бүр өөрийн онцлогийн дагуу хөгжлийн чиг хандлага нь тодорхойлогдоор байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар” түргэн хурдацтай хөгжиж байгаа нь нийгмийн хөгжил дэвшил эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой гэж үзэж болно. Мөн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн үндсэн зарчмын дагуу явагдаж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг түргэн шуурхай хангахын зэрэгцээ, иргэдийг ажлын байраар хангаж, ажлын байрны тоог ихээр нэмэгдүүлж байгаа салбарын тоонд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар зүй ёсоор ороод байна.

**“Хоолны газар”** гэж зах зээлийн эдийн засгийн утгаараа хоол, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглэгчийн үйлчилгээг нэгэн зэрэг хослуулан цогц удирдлагаар хангаж зохион байгуулдаг, төрөл ангилал, хэв маяг, төрөлжилтөөр өөр хоорондоо ялгаатай, өмчийн олон хэвшилд хамаарах ашгийн төлөө болон нийгмийн үйлчилгээний хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хувьд үйлдвэрлэл борлуулалт, үйлчилгээг нэгэн зэрэг явуулдаг онцлог салбарын хувьд хүмүүсийн өдөр тутмын хамгийн чухал хэрэгцээ болох хоолны хэрэгцээг хангах чухал үүрэгтэй салбар юм. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зөв зохион байгуулж төлөвлөлттэй явуулах нь энэ салбарын үйл ажиллагаа, хөгжил, дэвшил мөн бизнесийн байгууллагын ашигт үйл ажиллагаанд тодорхой үүргийг гүйцэтгэнэ.

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар хурдацтай хөгжиж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг түргэн шуурхай хангаж, эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулж байгаа боловч нөгөө талаас зарим газруудын хувьд чанар, хариуцлагын асуудал орхигдож, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллаж буй зарим бизнес эрхлэгчид зөвхөн ашиг орлого хөөж ажиллах, үйлдвэрлэл үйлчилгээнд дотоодын хяналтыг тогтмолжуулах, хяналтын байгууллага, улсын байцаагчийн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх тал дээр анхаарах явдал хангалтгүй байгаагаас зөрчил дутагдал гарсаар байна.

**ХХААХҮ-ийн сайдын 2010-08-27-ны өдрийн №А/206 тоот** тушаалаар батлагдсан хоолны газрын нийтлэг журамд заасны дагуу Нийтийн хоолны газарт зоогийн газар, кафе, баар, гуанз, цайны газар, түргэн хоолны газар, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газар, албан газрын дэргэдэх хоолны газар, эмнэлэг, сувилал, сургууль, ясли, цэцэрлэг, оюутан сурагчдын дотуур байр, цэргийн болон хорих ангийн хоолны газруудыг багтаан үздэг байна.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт улсын хэмжээнд нийт хэдэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулж байгаа талаархи нэгдсэн тоо баримтыг гаргахыг зорьж, судалгааны багаас Үндэсний статистикийн хороо, Нийслэлийн статистикийн хэлтэс, Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, хэлтэс, Нийслэлийн захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн нийтийн хоолны салбар хариуцсан мэргэжилтэн, ХХААХҮ-ийн яамны мэргэжилтэн зэрэг холбогдох албаны хүмүүстэй уулзаж санал бодлоо солилцсон.

Гэвч уулзалтын явцад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн хоолны салбарын нийт тоон мэдээлэл, статистикиг гаргахад хүндрэлтэй төдийгүй нийтийн хоолны салбарын үйлдвэрлэл үйлчилгээний мэдээлэл үндсэндээ байхгүй гэж хэлж болохоор байна. Тухайлбал: мэргэжлийн хяналтын газар зөвхөн ажлын байрны дүгнэлт өгөх, төлөвлөгөөт хуваарийн дагуу тодорхой хэдэн газарт шалгалт хийдэг, өөрийн чиг үүргийн дагуу зөвхөн тухайн хоолны газрын зөрчилдийг чухалчлан үздэг, ХХААХҮ-д одоогийн байдлаар нэгдсэн бүрэн гүйцэт тоо баримт байхгүй 2011 оны 7 сард 2010 оны тоо гаргахаар ажиллаж байгаа гэсэн хариулт өгсөн.

Энэ бүгдээс харахад улсын хэмжээнд нэгдсэн албан ёсны статистик тоо гаргахад хүндрэлтэй байгаа бөгөөд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын нэгдсэн тоо

мэдээллийг хариуцсан газар байхгүй гэж хэлэхэд болохоор байна.

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллээр тус салбарт зочид буудлын үйлчилгээ хамрагддаг нь зөвхөн нийтийн хоолны салбарын мэдээллийг тусгайлан гаргах, уг салбарын үйлдвэрлэлийн мэдээллийг нарийвчлан гаргах боломжгүй юм.

#### **Судалгааны хүрээнд:**

- Нийслэлийн хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдал
- Улсын хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдал гэсэн хоёр чиглэлээр олдсон тоон мэдээллийн хүрээнд ажиллаа.

#### **1.2. Нийслэлийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдал:**

ҮСХ-ны мэдээллээр сүүлийн жилүүдэд зочид буудал, зоогийн газраар үйлчлүүлэгчдийн тоо тогтмол өссөөр байна. Зөвхөн нийслэл хотын хэмжээнд авч үзэхэд хоол үйлдвэрлэл үйлчилгээний аж ахуйн нэгжийн тоо 2000-2004 онуудад дунджаар 2200 аж ахуйн нэгж байсан бол 2005 - 2009 онд 2823 болж өссөн байна.


#### **Хүснэгт 1. Нийслэл хот дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын тоо**

Үзүүлэлт		2000 ОН	2001 ОН	2002 ОН	2003 ОН	2004 ОН	2005 ОН	2006 ОН	2007 ОН	2008 ОН	2009 ОН
Зоогийн газар	тоо	262	262	199	239	277	450	405	434	454	500
	дундаж суудлын тоо	55	53	79	74	77	55	55	58	97	80
Кафе	тоо	74	74	145	168	208	206	133	136	207	300
	дундаж суудлын тоо	23	24	35	34	30	31	25	24	40	24
Баар	тоо	585	561	557	514	464	635	546	528	580	620
	дундаж суудлын тоо	39	38	40	49	60	50	50	51	90	50
Гуанз, цайны газар	тоо	1400	1276	1247	1260	1246	1232	1539	1850	2158	1200
	дундаж суудлын тоо	19	50	23	23	23	24	19	15	30	40
Бүгд	тоо	2321	2173	2148	2181	2195	2523	2623	2948	3399	2620

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

\* \* \*

**Зураг 1: Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны ангилалаар нь харуулвал**



**Зураг 1-ээс** харахад нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын 50-иас илүү хувийг цайны газар, гуанз эзэлж байгаа нь жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа нэмэгдэж байгаа, цайны газар, гуанзын эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Хэдийгээр эндээс харахад жижиг цайны газар, гуанзын асуудал ярьж байгаа боловч энэ нь эрүүл ахуйн болон эрхлэж буй үйл ажиллагаа, чанарын шаардлага ямар түвшинд хангагдаж байгаа нь тодорхойгүй, төдийгүй энэ нь цаашид хүн амын эрүүл мэндийн асуудалд хэрхэн нөлөөлөх вэ гээд олон асуудлыг хөндөж байгаа юм. Өөрөөр хэлбэл хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг улсын хэмжээний бодлогын асуудал болгон хэрэгжүүлэх нь чухал юм. Мөн түүнчлэн томоохон ресторан зоогийн газрууд, болон хотын төв газруудаар үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс бусад тухайлбал захын гэр хороололд үйл ажиллагаа явуулж байгаа цайны газар, гуанз нь дээрх бүртгэлд хамрагддаг эсэх нь ч эргэлзээтэй байна.

Нийслэлд 2753 нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар үйл ажиллагаа явуулж байгаагаас архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоо 1326 байна.

**Хүснэгт 2-оос** согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн тоог дүүрэг тус бүрээр харна уу.

**Хүснэгт 2: Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн тоо, дүүрэг тус бүрээр**

д/д	Дүүргүүд	Хоолны газрын ангилал			Дүн
		ресторан	баар караоке диско г.м	кафе	
1	Сүхбаатар	107	95	61	263
2	Баянгол	117	207	63	387
3	Чингэлтэй	118	47	53	218
4	Баянзүрх	88	106	38	232
5	Хан-уул	26	33	12	71
6	Сонгинохайрхан	21	50	36	107
7	Налайх	9	15	1	25

8	Багануур	8	10	5	23
	Дүн	494	563	269	1326

**Эх сурвалж: Нийслэлийн захирагчийн ажлын алба**

Нийслэлд нийтийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл бүхий цэгийн тоог манай улсын насанд хурсэн хүн амын тоотой харьцуулж үзэхэд 610 орчим, хүнд 1 цэг ногдооор тооцоо гарч байна.<sup>100</sup>

2010 оны байдлаар Нийслэлийн хэмжээнд 1326 тусгай зөвшөөрөл олгогдсон нь 2009 онтой харьцуулахад согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоо 159 цэгээр буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2010 онд нийт 1124 архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, 202 шинээр тусгай зөвшөөрөл олгож, 279 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Мөн орон сууцны зориулалтыг өөрчлөн /орон сууцны 1 давхарт/ хоолны үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 521 цэг ажиллаж байна.

Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсээс гаргасан мэдээллээр 2010 онд нийслэлийн хэмжээнд нийтийн зориулалттай орон сууцны зориулалтыг өөрчлөн 176 цайны газар, 179 ресторан, 164 кафе нийт 520 гаруй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар ажиллаж байна.

**2.2. Улсын хэмжээнд хоол, үйлдвэрлэл үйлчилгээний салбарын өнөөгийн байдал**

Улсын мэргэжлийн ерөнхий газраас 2010 оны 9 сард хийсэн нийтийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж иргэдийн үйл ажиллагаанд стандартын түвшин тогтоох улсын үзлэг шалгалтыг явуулсан бөгөөд энэ шалгалтын дүнгээр улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй нийт хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 6877 газраас 4884 буюу 79,3 хувийг шалгалтанд хамруулсан байна.

**Хүснэгт 3. Улсын хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрхлэж байгаа аж ахуйн нэгжийн тоо**

Үзүүлэлт		2000 он	2001 он	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
Зоогийн газар	тоо	262	262	199	239	277	450	405	434	454	500	446
Кафе	тоо	74	74	145	168	208	206	133	136	207	300	360
Баар	тоо	585	561	557	514	464	635	546	528	580	620	572
Гуанз, цайны газар	тоо	1400	1276	1247	1260	1246	1232	1539	1850	2158	1200	1984
Бүгд	тоо	2321	2173	2148	2181	2195	2523	2623	2948	3399	2620	3362


Нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэлт оны үнээр 2010 онд 71.9 тэрбум төг болж, өмнөх оныхоос 22.1 тэрбум төг буюу 44.4 хувиар өссөн байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр энэ салбарын нийт ажиллагсадын тоо 2010 оны жилийн эцэст 4.6 мянга болж, өмнөх оныхоос 470 хүнээр буюу 9.4 хувиар буурсан байна.

<sup>100</sup> Нийслэлийн захирагчийн ажлын алба

### 2.3. 2005-2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар

Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын агентлагаас авсан мэдээллээр манай улсад хийгдэж байгаа нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 19,6 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт хийгдсэн байна. **Тухайлбал:** 1990 оноос хойш 2011 оны 5 сарыг хүртэлх байдлаар манай улсад худалдаа нийтийн хоолны салбарт нийт 970 310,35 мянган ам долларын хөрөнгө оруулалт хийгдээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүртгэхдээ нийтийн хоолны салбарыг худалдааны салбартай хамтруулан нэг ангилалд оруулан тооцдог нь нийтийн хоолны салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтыг нарийвчлан тооцох боломжгүй байна.

#### Зураг 2. 2005-2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ /мянган амдоллараар/



2011 оны эхний 5 сарын байдлаар 56 608,31 мянган ам долларын хөрөнгө оруулалт худалдаа, нийтийн хоолны салбарт хийгдээд байна. Худалдаа нийтийн хоолны салбарт 2006-2008 онд дунджаар 1377 гадаадын хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдэж байсан бол 2009 онд 572 компани, 2010 онд 731 компани бүртгэгдсэнээс харахад нийтийн хоолны салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурах хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд Солонгос, Хятад, Япон, Европ зэрэг улс үндэсний хоолны газрууд ихээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээрийн хувьд гадаадын хөрөнгө оруулалттай бус харин зөвхөн хоол хийж буй ерөнхий тогтооч нь тухайн улсын иргэн байх нь түгээмэл байна. Үүнээс үүдээд гадаадын хөрөнгө оруулалттай мэт харагдаж буй улс үндэсний хоолны газруудын хувьд монгол эзэнтэйгээр зөвшөөрлийг авдаг учир нарийвчилсан тоон мэдээллийг гаргах боломжгүй байна.

Мөн сүүлийн жилүүдэд олширч байгаа Тухайлбал: “Хаан хуушуур”, “Хаан бууз”, “BBQ chicken”, “Broadway” зэрэг сүлжээ түргэн хоолны газар, ресторанууд хэдийгээр олон салбар сүлжээтэй байсан ч бүртгэлийн хувьд нэг аж ахуйн нэгжээр бүртгэгддэг нь бодит тоон мэдээлэл болж чадахгүй байгаа юм. Тиймээс улсын хэмжээнд нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 6877 аж ахуйн нэгжийн хувьд бодитой тоон мэдээлэл биш юм.

Зах зээл өргөжихийн хэрээр үйлчлүүлэгчдийн эрэлт шаардлага өмнөх жилүүдийн үеийнхээс үндсээрээ өөрчлөгдөж байгаа бөгөөд үүнийг даган нийтийн хоол үйлчилгээний шинэ дэвшилтэй үйлчилгээний хэлбэрүүд бий болсоор байна. Эдгээрийн түгээмэл хэлбэр нь хоол захиалга, хүргэлтийн үйлчилгээ юм. Манай улсын хувьд энэхүү үйлчилгээний хэлбэрт тохируулан шинээр түргэн хоолны стандарт шаардлагыг боловсруулаад байна.

Нийтийн салбарын үйлчилгээнээ хамаарч буй нэг томоохон хүчин зүйл нь хоол, хүнсний үйлдвэрлэл үйлчилгээнээс хамааралтайгаар эрүүл ахуйн аюулгүй байдал юм. ДЭМБ-аас гаргасан мэдээгээр өнөөдөр 440 гаруй төрлийн өвчин буртгэгдэж байгаагаас 370 гаруй нь хоол хүнснээс шалтгаалсан өвчин байна. Монголчуудын хувьд дэлхийн нийтийн наслжилтийн индексээс хараад бусад улс орнуудын хүн амын индексээс богино наслаж байгаа нь ч хоол хүнсний буруу хэрэглээтэй холбоотой юм. Иймд нийтийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээний стандарт, техник технологийн шаардлагаас гадна нийтийн хоолын худалдаа үйлдвэрлэлтэй холбоотойгоор нэгдсэн цогц бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчныг шинээр бий болгох шаардлагатай байна.

### Судалгааны дүгнэлт

Улсын хэмжээнд 2010 оны байдлаар 6770 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар үйл ажиллагаа явуулж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний борлуулалт 49,0 тэрбум төгрөг хүрч жилээс жилд өсч байна. Улсын хэмжээнд 17,0 мянган тогооч, үйлчилгээний ажилтан 9,0 мянга гаруй хүн ажиллаж байна. Хоолны газруудад ажиллагасдын 90 хувь мэргэжлийн тогоочтой ажиллаж байгаагаас 30 гаруй хувь нь 1-р зэрэгтэй байна.<sup>101</sup>

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын мэргэжилтэй боловсон хүчин инженер технологич, тогооч, зоогийн газрын менежер нарыг бэлтгэн гаргаж байгаа их дээд сургууль, коллеж 5, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 35 үйл ажиллагаа явуулж байна. Мөн Монголын тогооч нарын холбоо, Монголын хоолзүйн, Технологичдын холбоо, Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хөгжлийн төв зэрэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Нийтийн хоолны салбарын тусгайлсан хууль байхгүй бөгөөд Хүнсний тухай хуулиар Засгийн газар, салбарын сайдад олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гаргасан эрх зүйн баримт бичиг, холбогдох стандартын хүрээнд зохицуулагдаж явж иржээ. Мөн түүнчлэн, УИХ, Засгийн газраас салбарт хамаарах төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, дагнасан үндэсний хөтөлбөрүүдийг батлан гаргаж хэрэгжүүлж иржээ.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад 2010 онд Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Хоолны газрын ангилал, зэрэглэл” Үндсэн шаардлага MNS4946:2005 стандартын мөрдөлтийн түвшинг тогтоох чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтаар нийтийн үйлчилгээтэй хоолны газарт стандартын мөрдөлт аймаг, сумдад дундажаар 74,5 хувь, нийслэлийн түвшинд дундажаар 67 хувь хангагдсан, нийслэлийн дүнг хоолны газрын ангилал тус бүрээр авч үзвэл зоогийн газар, бар, кафе дундажаар 68 хувь, цайны газар 49,7 хувь хангагдсан үзүүлэлттэй байна. Шалгалтаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын талаарх ололтой болон нийтлэг зөрчлийн талаарх мэдээллийг 1.2-оос үзнэ үү.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бизнесийн байгууллагуудын хувьд өрсөлдөөний зарчмаар хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн хэдий ч хоол үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдал, үйлчилгээний соёл, мэргэжилтэй боловсон хүчний дутагдалтай зэрэг бэрхшээлүүд их байна.

Судалгааны явцад нийгмийн хalamжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг хоол үйлчилгээний байгууллагууд болох сургууль, коллеж, их, дээд сургууль, эмнэлэг, широн, цэрэг, арми зэрэг байгууллагуудын хоол үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодруулахаар салбарын яам, мэргэжлийн хяналтын газраас тодруулсан боловч төвлөрсөн мэдээлэл үндсэндээ байхгүй гэж хэлж болохоор байна. **Тухайлбал:** Мэргэжлийн хяналтын газар зөвхөн ажлын байрны дүгнэлт өгөх, төлөвлөгөөт хуваарийн дагуу тодорхой хэдэн

<sup>101</sup> ХХААХҮЯ-ны ХҮХҮБХЗГ-аас ирүүлсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга 2011 он

газарт шалгалт хийдэг, өөрийн чиг үүргийн дагуу зөвхөн тухайн хоолны газрын зөрчилийг чухалчлан үздэг, ХХААХҮ-ийн яаманд одоогийн байдлаар нэгдсэн тоо баримт байхгүй 2010 оны тоо гаргахаар ажиллаж байгаа гэсэн хариулт өгсөн.

Нийслэлд 2753 нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар үйл ажиллагаа явуулж байгаагаас архи согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоо 1326 байна. Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл бүхий цэгийн тоог манай улсын насанд хүрсэн хүн амын тоотой харьцуулж үзэхэд 610 орчим, хүнд 1 цэг ногдохоор тооцоо гарч байна.<sup>102</sup>

Зөвхөн нийслэл хотын хэмжээнд авч үзэхэд хоол үйлдвэрлэл үйлчилгээний аж ахуйн нэгжийн тоо 2000-2004 онуудад дунджаар 2200 аж ахуйн нэгж байсан бол 2005-2009 онд 2823 болж ессчээ. Эдгээр хоол үйлчилгээний байгууллагын 50-иас илүү хувийг цайны газар, гуанз эзэлж байгаа нь жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа нэмэгдэж байгаа, цайны газар, гуанзын эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Манай улсад хийгдэж байгаа нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 19,6 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт хийгдсэн байна. **Тухайлбал:** 1990 оноос хойш 2011 оны 5 сарыг хүртэлх байдлаар манай улсад худалдаа нийтийн хоолны салбарт нийт 970 310,35 мянган ам долларын хөрөнгө оруулалт хийгдээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүртгэхдээ нийтийн хоолны салбарыг худалдааны салбартай хамруулан нэг ангилалд оруулан тооцдог нь нийтийн хоолны салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтыг нарийвчлан тооцох боломжтүй байна.

2011 оны эхний 5 сарын байдлаар 56 608,31 мянган ам долларын хөрөнгө оруулалт худалдаа, нийтийн хоолны салбарт хийгдээд байна. Худалдаа нийтийн хоолны салбарт 2006-2008 онд дунджаар 1377 гадаадын хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдэж байсан бол 2009 онд 572 компани, 2010 онд 731 компани бүртгэгдсэнээс харахад нийтийн хоолны салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурах хандлагатай байна.

### Санал, зөвлөмж

- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын одоо мөрдөгдөж буй дүрэм журмуудын агуулга, ач холбогдол цаг үеийн нөхцөл шаардлагаас зохицуулалтын чанар нь хоцрогдонгуй байгаа тул олон улсын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ерөнхий стандартын түвшинд нийцүүлэх /Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсад мөрдөж буй стандартын бодлого, хэрэгжилтийг боловсронгуй болгох, олон улсын түвшинд нийцүүлэх ажлын хэсгийн чиглэл, төлөвлөгөөн дээр үндэслэн гүйцэтгэсэн Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа хүнсний салбарын нийт 667 стандартын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний терөлд багтах стандартуудыг судлан үзэх/
- Судалгааны хүрээнд хоол, үйлдвэрлэл үйлчилгээний салбарын чиглэлийн яам, харъяа газрууд, хяналт шалгалтын чиг үүргээр ажилладаг байгууллагуудын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалан судалгааны мэдээлэл туйлын хомс байсан нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгуулагын тулгамдсан ауудлуудыг тодруулахад бэрхшээлтэй байсан. Өнөөгийн байдлаар ХХААҮЯ-нд хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан газрын 2 мэргэжилтэн энэ салбарын асуудлыг хариуцаж байгаагаас үзэхэд салбарын бодлого, зохицуулалтын асуудал үндсэндээ орхигдсон гэж хэлж болохоор байна. Иймд

<sup>102</sup> Нийслэлийн захирагчийн ажлын алба

төрөөс тус салбарын бодлогыг цогц байдлаар авч үзэж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын тулгамдаж буй асуудлыг системтэй судлан үзэх зайлшгүй шаардлагатай.

3. Тус салбарын үйл ажиллагааны стандартын биелэлт, хяналт шалгалтын чиг үүргээр ажиллаж буй байгууллагууд зөвхөн бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгжийг үйл ажиллагаанд илүү анхаарал тавьж нийгмийн халамжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд төдийлөн анхаарч ажиллахгүй улсын хэмжээнд нийт хэдэн байгууллага ажиллаж байгаа зэрэг статистик мэдээллийг ч бүрэн гүйцэд гаргадаггүй байна. Хоол үйлдвэрлэлийн салбарт УМХЕГ, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн захирагчийн алба, Цагдаагийн алба зэрэг хяналт шалгалтын чиг үүрэгтэй маш олон байгууллагууд давхардсан хяналт шалгалт хийж байдаг нь энэ салбарт ихээхэн дарамт учруулдаг байна. Эдгээр байгууллагуудын зүгээс ялангуяа бизнесийн чиглэлээр хоол үйлдвэрлэл эрхэлж буй байгууллагууд /бар, ресторан, кафе зэрэг/-д хяналт шалгалт хийсэн тоо харьцангуй олон боловч мэргэжил, арга зүйн туслалцаа заавар зөвлөгөө өгч ажиллах тал дээр хангалтгүй, хоорондоо зөрчилтэй үндэслэлгүй шаардлага тавьдаг нь дарамт шахалт учруулдаг байна. Гэтэл нийгмийн халамжийн салбарын хоол үйлдвэрлэл /эмнэлэг, сургууль, цэцэрлэг, цэрэг, хучний байгууллага зэрэг/-д хяналт шалгалт хангалтгүй хийгддэг, чанар аюулгүй байдлыг хангаж ажиллах тал дээр дутагдалтай, нэгдсэн тоо мэдээлэл хомс байдал ажиглагдлаа.
4. Зориулалтын бус, стандарт хангаагүй ажлын байрыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ашиглуулахыг зогсоох, тусгай зөвшөөрөл олгохгүй байх
5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ихэнхи нь мэргэжил олгох түр дамжаа төгссөн боловч амьдрал дээр тэдний мэргэжлийн ур чадвар шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа тул хоол үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэжилтэй боловсон хүчин асуудлыг анхаарах
6. Хоол үйлдвэрлэлийн газрууд нь мэргэшсэн бус байдлаар үйл ажиллагаа явуулж үйлчилүүлэгчдийг хохироодог, хоол үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй боловч архи согтууруулах ундаагаар тулхүү үйлчилж ашиг олох зорилготой үйл ажиллагаа явуулдаг, стандартын бус аргаар хоол үйлдвэрлэдэг зэргийг анхаарч хоол, ундаа үйлдвэрлэхгүйгээр зөвхөн согтууруулах ундаагаар үйлчилдаг хоолны газар /ресторан, баар, кафе/ байгаа зөрчлийг таслан зогсоох
7. Нийгмийн халамжийн хүрээнд үйлчилгээ үзүүлдэг их, дээд сургууль, эмнэлэг, үйлдвэр, албан байгуулагын хоол үйлчилгээний салбарыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хоол үйлдвэрлэлийн стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн тогтоох, эрүүл хүнс, хүний эрүүл мэндэд хоргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр анхаарах
8. Өнөөгийн дэлхий дахини хоол үйлчилгээний зохион байгуулалтын туршлагаас үзэхэд үйл ажиллагаа нь дөнгөх эхлэж байгаа аж ахуйн нэгжийн хувьд франчайзингийн системийг нэвтрүүлэх нь дампуурлаас сэргийлэх, цаашилбал ашигтай ажиллах бололцоог олгодог байна. Франчайзинг нь бусдын эзэмшиж байгаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний брэндийг ашиглан зах зээлд бизнесээ хамгийн түргэн хугацаанд өргөжүүлэх боломжтой, эрсдэл багатай бизнесийн систем юм.

\*\*\*

## Ашигласан материал

- Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого
- Хүнсний тухай хууль
- “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр, Ерөнхий боловсролын сургуульд “Үдийн цай” хөтөлбөр
- Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 4946:2005
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS CAC RCP 39: 2009.
- Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг. Техникийн ерөнхий шаардлага: Монгол Улсын стандарт. Дугаар: MNS 6192 : 2010
- ХХААХҮЯ-ны XYXYБХЗГ-аас ирүүлсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга 2011 он
- НМХГ-ын газрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын 2010 оны шалгалтуудын дүгнэлт,
- НЗАА-ы YYX-ийн Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад атестатчилал явуулсан 2010 оны дүн мэдээлэл,
- МСГ-ын жилийн болон улирлын статистик мэдээллүүд,
- Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын агентлагаас 2005-2009 онуудад худалдаа нийтийн хоолны салбарт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл,
- Монгол Улсад Худалдаа, нийтийн хоолны байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой, хүнс, хоол үйлдвэрлэлийн салбарт инженер бэлтгэж эхлэсний 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний инновацийн асуудал” сэдэвт онол-практикийн хурлын материал
- НМХГ-ын улсын ахлах байцаагч С.Нарангэрэл /Ph.D/, “Хоол үйлдвэрлэлийн технологийн хяналт”, онол-практикийн бага хуралд тавьсан илтгэл, 2011 оны 04 сар.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ  
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА, 2011) -ЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА<sup>103</sup>**

УИХ -ын Тамгын газрын Эрх зүй хууль тогтоомжийн  
хэлтэс, Судалгааны төв

**I. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн товч танилцуулга**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг анх 2002 онд баталсан. Өнгөрсөн 10 шахам жилийн хугацаанд энэ хуульд хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон боловч, нийгэм, эдийн засгийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарч, уг хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн болон практик шаардлага бий болсон байв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай (2011 оны шинэчилсэн найруулга) -ын төслийг Засгийн газар санаачилсан. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн агуулга ийн шинэчлэгдсэнээр, хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлцуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглах, түүнтэй холбогдсон болон хангагч, хэрэглэгчийн хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн үндэс боловсронгуй болсон гэж үзнэ. Энэ хуулийг 2012.01.01 –нээс мөрдөж эхэлсэн болно.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар доорхи зарим асуудлыг зохицуулж шийдсэн. Үүнд:

- Усны хэрэглээг зүй зохистой болгох үүднээс ахуйн хэрэглээнээс гарсан саарал усыг эргүүлж ашиглах;
- Уул уурхай, эрчим хүчиний үйлдвэрүүд нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглах;
- Шинээр төлөвлөж байгаа барилга байгууламжийн зураг төсөлд саарал усыг цуглуулах, хуримтлуулах, цэвэрлэх, дахин ашиглах боломжийг тусгах, [тэдгээрийн] цэвэрлэх байгууламж нь саарал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байх; -ыг зааж тусгасан.
- Шинэчилсэн найруулгын өмнөх [хуучин] хуульд энэ асуудал тодорхойгүй байснаас болж уг хуулийг хэрэгжүүлэх явцад ихээхэн хүндрэл бэрхшээл учирч байсан болно. Тиймээс, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрхийг, хуулийн шинэчилсэн найруулгаар нарийвчлан тогтоосон болно.
- Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах зорилгоор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний өмчлөл, эзэмшилийн заагийг хуульд нарийвчлан тусгасан. Ус хангамжийн эх үүсвэр, цэвэр усны дамжуулах, түгээх болон бохир ус цуглуулах, татан зайлцуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн тодорхойлолтуудыг “цэгцэлсэн” байна.
- Хүн амьг ундны усаар хангах үйлчилгээ нь ямагт хэрэглэгчийн эрх ашигийг хөнддөг. Олон улсын туршлагаас үзэхэд, энэ чиглэлийн асуудлыг хариуцан зохицуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг тусгайлан байгуулах нь түгээмэл юм. Тиймээс хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох оновчтой механизмыг бүрдүүлэх, үйл ажиллагааг боловсронгуй

<sup>103</sup> Танилцуулгад УИХ -ын Тамгын газрын Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн Зөвлөх Э. Түвшинжаргал, Судалгааны төвийн ажилтан, шинжээч Г. Чулуун нарын бэлдэж боловсруулсан зарим материалын ашиглал. [Ред.]

болгох зорилгоор ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлийг шинээр байгуулж ажилуулах талаар туссан.

- Зохицуулах Зөвлөл нь цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, цэвэр усны үнэ, үйлчилгээний тариф тогтоох аргачлал боловсруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг хянаж батлах, шалгах, нийтлэх, шугам сүлжээ, тоног төхөөрөмжжөөр дамжуулан цэвэр ус түгээх, бохир усыг татан зайлуулсаны шимтгэлийг тогтоох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, аж ахуйн харилцааны дүрэм батлах, техникийн нөхцөл олгох журам батлах зэрэг эрхтэй.

Сүүлийн үед шугам сүлжээний хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй барилга байгууламж барих, төвлөрсөн системд холболгүйгээр өөрийн эх үүсвэрийг шинээр бий болгох, ус хангамжийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авалгүйгээр энэ үйлчилгээг эрхлэх ... зэрэг зөрчил дутагдал газар авсан тул эдгээрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангаттах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг уг хуулиар зохицуулсан ... мөн энэ чиглэлийн холбогдох харилцаанд [буруутай этгээдийн хүлээх] хариуцлагын тогтолцоог бий болгосон.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль дөнгөж хэрэгжиж эхэлж байна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга амьдралд амжилттай хэрэгжсэнээр дараахи үр дүн гарна гэж үздэг. Үүнд:

- төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах Зөвлөл байгуулагдсанаар ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үнэ, төлбөрийг бодитойгоор тогтоож, энэ харилцаанд оролцогчдын эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах боломжтой болно;
- усны эх үүсвэр, усны чанарт төр, олон нийтийн зүгээс хяналт тавих нөхцөлийг бүрдүүлснээр хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангахаас гадна байгаль орчныг бохирдуулах, усны нөөц хомсдох зэрэг сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөл боломж бүрдэнэ;
- барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөх эрхийн асуудал тодорхой болсноор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлдэг ашиглагч байгууллагын үүрэг, хариуцлага дээшилж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна;
- хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлснээр ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд газрын зөвшөөрөл олгох, зөвшөөрөлгүй барилга байгууламж барих, ашиглалтын талаар хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг зөрчил дутагдлыг арилгах нөхцөл бүрдэх болно.

## **II. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн агуулгыг шинэчлэхэд хүргэсэн (нөхцөлдүүлсэн) бодлогын зарим асуудал**

Улс орон эдийн засаг, нийгмийн хөгжлийн огцом зэрэг өөрчлөлтийн “шинэ гарааны босго” –н дээр тулж ирчихээд байгаа өнөө үед бүхнийг байгаль орчинд ээлтэйгээр зохицуулах тогтвортой хөгжлийн нийтлэг зарчмыг хангах чиг зорилтод нийцсэн засаг төрийн бодлого хэрэгжих учиртай. Төр засгаас хэрэгжүүлж байгаа байгаль орчны өнөөгийн бодлогод өөрчлөлт, шинэчлэлт хийх нь байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, улмаар эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн шийдэл мөн гэж үзнэ.

Бодлогын шинэчлэл хийхдээ бид улсын хэтийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд “эдийн засгийн өсөлт, экологийн үр ашиг хоорондоо адил тэнцүү байх” зарчим сахих ёстай. Монгол Улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт, улс орны амьдралын бүх салбарын хөгжлийн асуудлыг өөр хооронд нь болон байгаль орчны асуудалтай уялдуулан цогцоор нь авч үзэж, хөгжлийн бодлого, стратеги, арга ажиллагааг нэгтгэн тодорхойлсныг зориуд энд дурдмаар байна.

Байгаль орчны салбарт мөрдөж байгаа 30 гаран<sup>104</sup> хууль бий. Засгийн газраас тэдгээрт хийдэгдэл, давхардлын судалгаа хийж, 18 хуулийг системчлэн нэгтгэх, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн багц төслийг боловсруулж УИХ-д ирүүлсэн. Байгаль орчны салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэгжик байгаа хууль тогтоомжийн эрх зүйн чадамжийг сайжруулах зорилгоор байгаль орчны [эдгээр] багц хуулийн төсөл дээр УИХ, түүний холбогдох байнгын хороо ажиллаж байна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн үзэл баримтлалд ч “ashiглагч нь хамгаалагч байх, бохирдуулагч нь хохирлыг нөхөн төлөх” зарчим туссан.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байгаль орчны талаарх зорилтыг хэрэгжилтэд тухайн салбарын эрх зүйн зохицуулалт эерэг нөлөөлөл, зохих дэмжэгийг үзүүлэх ёстой. Үйлдвэржилт, хотжилт эрчимтэй явагдаж байгаатай уялдан хүрээлэн буй орчны бохирдол, доройтол, хог хаягдлын асуудал Монгол орны хувьд бас нэг байнгын гэмээр сорилт үүсгэх болоод удаж байна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн үзэл баримтлалд ч “ashiглагч нь хамгаалагч байх, бохирдуулагч нь хохирлыг нөхөн төлөх” зарчим туссан.

Байгаль орчныг хамгаалахад зориулагдсан дэд бүтэц болж өгдөг бохир ус цэвэрлэх байгууламжийн хангамж, хүрэлцээг өргөжүүлэх, химиин хорт бодисын менежментийг сайжруулах, хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах шаардлага, эрэлт хэрэгцээ аль хэдийн бий болсон ч өнөөдөр эдгээр асуудлыг шийдвэрлэх талаар эдийн засгийн гол салбаруудаас олигтойхон санаачлан хийсэн бодит ажил ахиц байхгүй шахуу явж ирсэн. Цаашид, ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль гарснаар үйлдвэрлэл, үйлчилгэнээс төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд болон байгальд шууд нийлүүлж буй хаягдал усны хэмжээ, бохирдуулах бодисын агууламж буурч, улмаар байгаль орчны бохирдол багасах боломж нөхцөл бүрдэнэ. Холбогдох хууль тогтоомж батлагдсанаар энэ байдал цаашид аэргээр өөрчлөгднө гэж найдаж байна.

Усны бохирдлыг арилгах санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилго бүхий ус бохирдуулсны төлбөр тогтоох, ус ашигласны төлбөрийн хэмжээг экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн тогтоох, байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлдэг бараа, бүтээгдэхүүний хэрэглээг багасгахад чиглэсэн экологийн татвар бий болгох асуудлыг ч бид авч үзэх ёстой. Хүрээлэн буй орчинд тулгарч буй эрсдэл сорилтыг давах боломж бол орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай холбогдуулан, аймгийн төв, үйлдвэр хөгжүүлэх томоохон суурин газруудыг технологийн шаардлага хангасан цэвэрлэх байгууламжтай болгох явдал гэж үзнэ.

■ ■ ■

СУДАЛГААНЫ САН

#### Жич:

1. Монгол Улсын Засгийг газрын мөрийн хөтөлбөрт хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаар нарийвчилж заасан үг өгүүлбэр нэгээхэн үгүй. Байгаль орчны хамгаалал, эдийн засаг татвар, хотын хөгжил төлөвлөлт ... гэхчилэнгийн том том бүлэг асуудлуудын ерөнхий агуулгад уг

<sup>104</sup> Мэн, энэ чиглэлээр “нэгдэн орсон буюу соёрхон баталсан” олон улсын 14 гэрээ, конвенци бий.

асуудал дам байдлаар багтаад явчихдаг учир тодорхой нарийн заагаагүй орхисон болов уу. Тэгээд ч асуудал өөрөө олон салбарын уулзвар дээр оршдог “жижиг асуудал” юм. Тиймээс, УИХ –ын даргын хэлэх угэнд хэт жижиг асуудал хөндсөн үг санаа орох нь зохимжтой биш гэж үзнэ. Тэгээд ч,

- Байгаль орчны бодлогын шинэчлэлийн стратеги (УИХ –ын тогтоол);
- Усны тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль;
- Усны нөөцийг бохирдлоос хамгаалах, усны бохирдлын хяналтын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль;
- Хог хаягдлын тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга;

... зэрэг хүрээлэн байгаа орчныг хамгаалах чиглэлийн багц хуулийг цогцоор хэлэлцэн баталж хараахан амжаагүй байна. Иймээс одоохондоо Хот, сууринь ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн талаар нийт багцаас нь ангид тусаар “цоопдож” дэлгэрэнгүй ярихыг энэ удаад чухалчилсангүй. Дээрх нэр бүхий хуулийн төслүүдийг Нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэхийг УИХ -ын 2012.02.02-03 –ны өдрийн [Чуулганы] нэгдсэн хуралдаанаар шийдэхээр төлөвлөсөн байгаа болно.

2012.02.01;



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**ЯСЛИ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО БОЛОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, УЛААНБААТАР ХОТОД  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН БУС ӨМЧИТ  
ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨЛБӨРИЙН  
ТАЛААРХ СУДАЛГАА (Харьцуулсан судалгаа)**

*T. Мягмаржав*

Нийгмийн бодлого боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Д. Очирбатын захиалгаар ясли, цэцэрлэгийн тоо болон барилга байгууламж, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн бус өмчит их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудын төлбөрийн талаарх судалгааг захиалгын дагуу хийж гүйцэтгэв.

#### **Хувьчлалын талаарх мэдээлэл<sup>105</sup>**

Улсын Их Хурлын “Аймаг нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” 1999 оны 29 дүгээр тогтоолоор аймаг орон нутаг, нийслэлийн цэцэрлэг яслиудын өмч төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжсэн бөгөөд 1990-1999 оны хооронд Төрийн өмчийн цэцэрлэг, ясли хувьчлагдаагүй байна.

2010 оны байдлаар 162 цэцэрлэгт яслийн бүлэг шинээр нээн ажиллуулсанаас 33 нь хувийн ясли ажээ. Боловсрол, соёл шинжлэх ухааны яамнаас гаргасан 2011-2012 оны хичээлийн жилийн урьдчилсан мэдээгээр нийт улсын хэмжээнд 880 цэцэрлэг байгаагийн 735 нь төрийн өмчит, 145 нь төрийн бус өмчит ба зөвхөн нийслэлийн хэмжээнд 172 төрийн өмчит, 128 төрийн бус өмчит цэцэрлэг тус тус ажиллаж байна. Улаанбаатар хотод нийслэлийн өмчит Баянгол дүүрэгт нялхасын клиник сувилал, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг тус бүрт нэг хүүхдийн клиник сувилал нийт 4 сувилалтай.

#### **Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл<sup>106</sup>**

Сургуулийн өмнөх боловсролын өнөөгийн байдал

- Улсын хэмжээнд цэцэрлэгт 166,7 мянган хүүхэд хүмүүжиж байгаа ба сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 76,7 хувь, цэцэрлэгийн хамран сургалт 62,0 хувьд хүрч сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2008 онтой харьцуулахад 20,5 хувиар өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Эрх зүйн таатай орчин бүрдсэн 2008 онд батлагдсан сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиар хүүхдийн цэцэрлэгийн бүх зардлыг төрөөс хариуцан санхүүжүүлэх болсон нь гэр бүл, эцэг эхчүүдэд, ялангуяа нийгмийн эмзэг давхаргын гэр бүлд эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн.

Сургуульд элсэх нас өөрчлөгдсөн Боловсролын тухай хуульд заасны дагуу ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж байгаатай холбоотойгоор хүүхдийн сургуульд элсэн суралцах нас 6 болсон нь эцэг эх, хүүхдэд сургуульд элсэх бэлтгэлийг хангах зайлшгүй хэрэгцээ бий болсон.

<sup>105</sup> Төрийн өмчийн хорооноос ирүүлсэн мэдээлэл

<sup>106</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

**Цэцэрлэгийн барилгын тухай мэдээлэл<sup>107</sup>**

Цэцэрлэгийн барилгыг шинээр барих болон хувилбарт сургалтыг өргөжүүлэх талаар Засгийн газраас жил бүр шинээр барих хүүхдийн цэцэрлэгийн тоог 2008 оноос хойш нийт 101 цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, орны тоог 8355-аар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 1

д/д	Он	Суудал	Барилга
1.	2008	720	17
2.	2009	1825	22
3.	2010	2640	29
4.	2011	3170	33
	Дүн	8355	101

**Шинээр ашиглалтанд оруулсан цэцэрлэгийн барилгын болон орны тоо**

Мөн хөдөөгийн баг бүрийг гэр цэцэрлэгтэй болгоход анхаарч одоогийн байдлаар нийт багийн 50 хувьд буюу 600 багт гэр цэцэрлэг ажилласан бегеөд 2011 онд 200, ирэх онд 200 гэр цэцэрлэг нэмж ажиллуулахаар төлөвлөжээ. Жил бүр хүүхдийн цэцэрлэгийн барилгыг засварлахад улсын төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж 2008-2011 онд нийтдээ 231 цэцэрлэгийн барилгыг засварлахад нийт 8,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2

д/д	Он	Зарцуулсан хөрөнгө	Барилгын тоо
1	2008	2,9 тэрбум	82
2	2009	1 тэрбум	23
3	2010	2,7 тэрбум	63
4	2011	2,3 тэрбум	63
	Дүн	8,9 тэрбум	231

**2008-2011 онд засварласан цэцэрлэгийн барилгын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ**

**Жич:** Нэг гэр цэцэрлэг нь: сургалтын болон амрах, хооллох зориулалттай 2 гэрээс бүрдэнэ.

**Барилгын хүчин чадал, цаашид авах арга хэмжээний талаарх санал**

Засгийн газраас цэцэрлэгийн барилгыг шинээр барихад болон гэр цэцэрлэг нийлүүлэх, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх, нэг бүлэгт буюу нэг багшид ноогдох хүүхдийн тоог норматив хэмжээнд байлгахын тулд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг жил бүр нэмэгдүүлж байгаа хэдий ч үүсэн бий болсон хэрэгцээг хангаж чадахгүй байна. Хүн амын өсөлт, аймаг, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн үүнд ихээхэн нөлөө үзүүлж байна. Үндэсний статистикийн мэдээгээр 2000-2009 оны хооронд эхийн дундаж төрөлт 2,2-оос 2,7 болтол

<sup>107</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

өссөн байна. Төрөх насны буюу 20-29 насны хүн ам ба 0-4 насны буюу цэцэрлэгийн насны хүүхдийн тоо нийт хүн амын насны ангилал дотор эхний байруудыг эзэлж байна.

Төрөөс сургуулийн өмнөх боловсролын зардлыг хариуцаж байгаа бодлого эрх зүйн таатай орчин, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, цэцэрлэгийн барилгын хүрэлцээ зэрэгээс шалтгаалан үүссэн цэцэрлэгийн хүрэлцээгүй байдал ойрын жилүүдэд үргэлжлэх, цашид хамран сургалт буурах хандлагатай байгааг 2010-2015 оны боловсролын салбарын мастер төлөвлөгөөнд тусгасан байна.<sup>108</sup>

Хүснэгт 3

	2011	2012	2013	2014	2015
2-5 насны хүн ам	197,046	228,863	235,735	236,920	238,109
Цэцэрлэгийн хүчин чадал (хүүхдийн тоогоор)	96,652	99,652	102,652	105,652	108,652
Цэцэрлэгт хамрагдалт (хүүхдийн тоогоор)	122,105	122,105	122,105	122,105	122,105
Цэцэрлэгт хамрагдалт (хувиар)	62	53	52	52	51

Одоогийн байдлаар нийслэлийн 6 дүүргийн 40 хороо цэцэрлэггүй байна.

Хүснэгт 4

#### НИЙСЛЭЛИЙН ЦЭЦЭРЛЭГГҮЙ ХОРООД<sup>109</sup>

д/д	Дүүрэг	Хорооны тоо /дугаар/		Цэцэрлэггүй хороодын дугаар	Тайлбар
		Нийт	Цэцэрлэггүй		
1	Баянгол	23	8	5,12,16,17,19,21,22,23	баригдахаар
2	Баянзүрх	28	8	4,7,17,21,24,26,27,28	
3	Багануур	5	1	5	
4	Багахангай	2			
5	Налайх	7	1	7	
6	Сүхбаатар	20	7	2,5,9,11,12,19,20	
7	Сонгинохайрхан	32	7	4,5,22,26,28,29,32	тавигдсан
8	Хан-Уул	16	4	6,8,15,16	
9	Чингэлтэй	19	4	5,8,11,16	
		152	40	26,30 хувь	

2011 оны 10 сарын 18-ны байдлаар

<sup>108</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэдээлэл

<sup>109</sup> Нийслэлийн боловсролын газар

Судалгааны эмхтгэл, XI боть

Боловсролын салбарын статистик мэдээгээр одоо ашиглаж буй цэцэрлэгийн барилгуудын 68 хувь нь 1990 оноос өмнө баригдсан 20-50 жил ашиглагдсан эдгээрийн 30 хувь нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй болсон. Нийслэлийн цэцэрлэгийн 158 барилгын 34 хувь нь 1970 оноос өмнө баригдсан барилгудууд байна. Түүнчлэн хуучирсан барилгууд урсгал засвар ашиглалтын зардлуудыг нэмэгдүүлдэг.

Иймд улсын хэмжээнд боловсролын салбарт нийт хэрэгцээтэй байгаа барилгын 36 хувь буюу 23,1 мянган хүүхдийн ор бухий хүчин чадалтай 150 цэцэрлэгийн барилгыг барихад 66,2 тэрбум төгрөг шаардлагатай байна. Мөн боловсролын салбарын 165 барилгад мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтээр “хангалтгүй” гэсэн үнэлгээ өгч яаралтай засвар шинэчлэлийн ажлыг хийх шаардлагатайг тогтоосон ба үүнийг оролцуулбал нийт 10,7 тэрбум төгрөг хэрэгцээтэй байна.

### **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ТАЛААР**

2010-2011 оны хичээлийн жилийн эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн хэмжээнд Ерөнхий боловсролын төрийн өмчит сургууль 75, Ерөнхий боловсролын төрийн бус өмчит сургууль 72 хичээллэж байна. Төрийн өмчийн их, дээд сургууль 14 хичээллэж байгаа бөгөөд орон нутагт 3 салбартай, төрийн бус дээд сургууль нь 55 түүнээс орон нутагт 2 салбартай, төрийн өмчийн бус коллеж 23 байгаагийн орон нутагт 3, гадаадын их сургуулийн 5 салбар байдгаас орон нутагт 1 тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.<sup>110</sup>

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТӨРИЙН БУС ӨМЧИЙН  
СУРГУУЛИУДЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН СУДАЛГАА<sup>111</sup> 2010 оны 11 сарын 13-ны байдлаар**

Хүснэгт 5

Дүүрэг	Сургуулийн нэр	Сургалтын чиглэл	Сургалтын төлбөр /нэг хүүхдийн төлбөр мян.төг/		
			Бага анги	Дунд анги	Ахлах анги
БГД	Атланта	Ердийн, англи, хятад, солонгос хэл, математик	500	600	600
БГД	Билиг Оюу	Ердийн, англи хэл, математик	580	800	880
БГД	Гурван тамир	Ердийн, англи хэл, математик	980	980	980
БГД	Ирээдүй	Ердийн, математик	-	-	500
БГД	Номч	Ердийн, математик	800	800	-
БГД	Номуундалай	Ердийн, англи, хятад хэл, нийгмийн ухаан, математик	500	500	650
БГД	Оюуны нахиа	Ердийн, англи хэл, математик	990	990	1,100
БГД	Оюуны төв	Ердийн, англи хэл, мэдээлэл зүй, математик	1,100	1,100	1,500

<sup>110</sup> БСШУЯ-ны мэргэжлийн боловсролын газар, Нийслэлийн боловсролын газар, Хувийн их, дээд сургуулиудын холбооноос ирүүлсэн мэдээлэл

<sup>111</sup> БСШУЯ-ны мэргэжлийн боловсролын газар, Нийслэлийн боловсролын газар, Хувийн их, дээд сургуулиудын холбооноос ирүүлсэн мэдээлэл

БГД	Русская гимназ	Орос хэлний	1,900	1,900	2,400
БГД	Сен Лизе	Ердийн, хятад хэл, математик	650	650	750
БГД	Хүслийн Өргөө	Ердийн, хятад хэл	500	800	800
БГД	Цацраг-Эрдэм	Ердийн, англи хэл	800	-	-
БГД	Шатлал	Ердийн, хятад хэл	750	750	750
БГД	Эхлэл	Ердийн, англи хэл, физик, математик	1,000	1,200	1,200
БГД	Эрдмийн далай	Ердийн, англи хэл, математик	800	800	1,200
БГД	Төгсбилэг	Ердийн, англи хэл, математик	800	-	-
БГД	Ургах наран	Ердийн, хятад хэл	1,200	1,200	1,400
БГД	Хүрээ - Тулга	Ердийн, гүнзгийрсэн бүлэгтэй	900	900	1,200
БГД	Гэгээрэл	Ердийн, гүнзгийрсэн бүлэгтэй	1,040	780	585
БЗД	Арвис	Ердийн, англи хэл, математик	850	950	950
БЗД	Алтан зам	Хятад хэлний	950	950	-
БЗД	Билгүүн номч	Орос хэлний	850	900	900
БЗД	Их засаг	Ердийн, хятал хэл	1,000	1,000	1,000
БЗД	Кириллица	Орос хэлний	1,200	-	-
БЗД	Хишиг	Хятад хэл, математик	1,050	1,050	1,050
БЗД	УБ дунд	Англи хэл	900	1,000	1,000
БЗД	УБ лицей	Орос хэлний	1,680	1,780	3,466
БЗД	Мон-Турк	Англи хэл, математик	-	-	1,800
БЗД	Төгс-Дэлгэрэх	Математик, англи хэлний	850	950	1,150
БЗД	Шинэ Монгол	Ердийн, математик, англи хэл	1,800	1,900	2,000
БЗД	Эрэл	Англи хэлний	2,450	2,650	2,850
БЗД	Оюунлаг	Ердийн, математик, англи хэлний	1,000	1,000	1,000
БЗД	Билгийн үүдэн	Орос хэлний	770	850	950
БЗД	Нан Шен	Ердийн, гадаад хэлний	360	300	250
БЗД	Итгэл	Англи хэлний	-	2,800	4,500
БЗД	Халх сэтгэмж	Гадаад хэлний	550	600	600
СБД	Орчлон	Англи хэлний	7,000	9,000	6,975
СБД	Кингс Кидс	Англи хэлний	1,500	1,500	1,500
СБД	Эрдэм төгс	Математик	750	750	750
СБД	Ертөнц	Ердийн, англи, хятад хэл	600	600	600

Судалгааны эмхтгэл, XI боть

СБД	Сант	Англи хэлний	1,500	2,250	3,000
СБД	Шинэ ўе	Англи хэлний, математик	1,300	1,300	1,300
СБД	Евро-Ази	Ердийн, англий хэл, математик	300	-	600
СБД	Сакура	Япон	600	650	700
СБД	Үй цай	Хятад хэлний	1,500	1,500	1,500
СБД	Галакси	Орос хэлний	1,500	1,500	1,500
СБД	Хобби	Англи хэл	4,200	4,500	5,000
СБД	Монгол Хятад найрамдал	Хятад хэлний	700	700	700
СБД	Соёмбо	Ердийн, математик	800	-	-
СБД	Молор	Ердийн, математик	350	-	-
СБД	Болор	Ердийн, математик	700	700	700
СБД	Искра	Ердийн, англий, орос хэл, математик	400	400	400
СБД	Түгээмэл	Ердийн, англий, хятад хэл, математик	-	-	500
СБД	Хүлэг	Ердийн, англий, хими, биологи, математик	-	-	1,020
СБД	Ub элит	Англи хэлний	6,000	7,000	8,000
СБД	Солонго	Ердийн, хятад хэл	300	-	-
СХД	Батномуун	Англи хэл, математик, компьютер	450	450	450
СХД	номуун	Математик	1,000	850	850
СХД	Чандмань	Ердийн, англий хэл, математик	300	300	350
СХД	ромашка	Ердийн, англий хэл, математик	950	950	1,250
СХД	толт	Гадаад хэлний	800	900	1,000
ЧД	Зуунбилиг	Англи хэлний	650	750	850
ЧД	Наран	Япон хэлний	700	800	800
ЧД	Чинхур	Хятад хэлний	700	700	700
ЧД	Чингай	Хятад хэлний	400	650	650
ЧД	Тоолол	Математик	-	-	300
ЧД	Олонлог	Англи хэлний	2,000	2,000	2,000
ХУД	Орхон	Ердийн, гадаад хэлний	680	580	540
ХУД	Аварга	Биентамир, гадаад хэл	-	-	300
ХУД	Америк сургууль	Гадаад хэлний	7,975	9,425	12,325
НД	Голомт ЦС	Ердийн, англий хэл, математик	-	-	40

Хүснэгт 6

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТӨРИЙН ӨМЧИЙН СУРГУУЛИУДЫН  
СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН СУДАЛГАА<sup>112</sup>**

2010 оны 11 сарын 13-ны байдлаар

Сургуулийн нэр	Сургалтын чиглэл	Сургалтын төлбөр /нэг хүүхдийн төлбөр мян.төг/		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги
13-р сургууль	Ердийн, англи хэл, математик	90	110	100
19-р сургууль	Ердийн, англи, хятад хэл мате	25	40	40
20-р сургууль	Ердийн, англи, орос хэл, хими, математик	60	70	80
28-р сургууль	Ердийн, англи хэл хими	70	80	0
38-р сургууль	Ердийн, герман хэл	60	70	80
40-р сургууль	Ердийн, математик	65	80	0
47-р сургууль	Ердийн, англи, математик	65	90	95
51-р сургууль	Ердийн, англи хэл, математик	80	100	0
73-р сургууль	Ердийн, англи хэл, математик	65	85	90
93-р сургууль	Ердийн, англи хэл, математик	80	112	0
113-р сургууль	Ердийн, хими, математик	0	80	80
Монгени	Ердийн, гадаад хэл математик	288.5	288.5	288.5
Сэтгэмж	Ердийн, англи хэл, математик	50	70	20
ОУЦС	Ердийн, англи хэл, математик	97	97	97
ЭӨЦС	Ердийн, англи хэл, математик	88	125	0
ЭҮЦС	Ердийн, англи, хятад, япон хэл, мэдээлэл зүй, математик	50	60	0
14-р сургууль	Ердийн, физик, математик	60	90	95
21-р сургууль	Ердийн, хими			Лицей-400
33-р сургууль	Ердийн, англи, орос хэл, хими, математик	69	98	103
44-р сургууль	Ердийн, анли хэл, хими, математик	60	70	75
48-р сургууль	Ердийн, гадаад хэл, математик	70	80	90
53-р сургууль	Ердийн, математик	45	50	50
79-р сургууль	Ердийн, математик		45	


<sup>112</sup> БСШУЯ-ны мэргэжлийн боловсролын газар, Нийслэлийн боловсролын газар, Хувийн их, дээд сургуулиудын холбооноос ирүүлсэн мэдээлэл

## Судалгааны эмхтгэл, XI боть

84-р сургууль	Ердийн, англи, япон хэл, математик	90	128	134
87-р сургууль	Ердийн, англи хэл, математик		60	
92-р сургууль	Ердийн, япон хэл	0	0	0
97-р сургууль	Ердийн, математик		90	100
111-р сургууль	Ердийн, математик			75
102-р сургууль	Ердийн, математик			80
Амгалан ЦС	Ердийн, англи хэл, хими, биологи, физик, математик		120	130
Баянзүрх ЦС	Ердийн, англи хэл, математик	60	80	80
Шавь ЦС	Ердийн, англи хэл, математик	60	70	80
Хангай цогцолбор	Ердийн, математик	50	50	50
1-р сургууль	Математик	90.5	128.0	134.5
2-р сургууль	Ердийн, англи хэл, математик		115.0	134.0
3-р сургууль	Ердийн, англи, солонгос хэл, математик	72.3	102.3	107.4
4-р сургууль	Ердийн, англи хэл, математик	-	-	-
6-р сургууль	Ердийн, англи хэл, хими, математик		74.0	96.0
11-р сургууль	Физик, математик		120.0	120.0
16-р сургууль	Ердийн, математик		41.0	41.0
31-р сургууль	Ердийн, математик, компьютер		30.0	30.0
35-р сургууль	Ердийн, англи хэл, математик		50.0	50.0
45-р сургууль	Ердийн, математик	35.0	40.0	45.0
58-р сургууль	Ердийн, монгол хэл, уран зохиол	40.0	40.0	40.0
Монгол Оросын 3-р сургууль	Орос хэлний	1,500.0	1,500.0	1,500.0
МУИС Байгаль-Эх лицей	Хими, биологи, физик, математик			600.0
Монгол Энэтхэгийн хамтарсан сургууль	Математик		200.0	200.0
ШУТИС Математик лицей	Математик		510.0	
ШУТИС Гадаад хэл лицей	Гадаад хэл		510.0	
ШУТИС Дизайн лицей	Зураг, дизайн		510.0	
ХҮДС Манлай лицей	Математик, гадаад хэл		615.0	
Спортын дунд сургууль	Спорт	90.0	90.0	90.0

12-р сургууль	Ердийн, англи, орос хэл, математик, компьютер	80	76	80
62-р сургууль	Ердийн, англи хэл, математик	-	50	55
67-р сургууль	Ердийн, англи хэл, математик	-	40	45
76-р сургууль	Ердийн, математик	30	-	40
105-р сургууль	Ердийн, англи хэл, хими, мате-к	-	40	50
Ирээдүй	Ердийн, англи хэл, хими, мате-к	50	70	90
5-р сургууль	Ердийн, хими, математик	80	90	100
17-р сургууль	Ердийн, математик	-	65	75
23-р сургууль	Гадаад хэлний	64.8	93.3	98.2
24-р сургууль	Ердийн, англи хэл, математик	76	90	95
49-р сургууль	Ердийн, англи хэл, математик	35	40	x
50-р сургууль	Ердийн, гадаад хэлний	50	70	-
57-р сургууль	Ердийн, хятад математик	-	60	-
БУЦСургууль	Ердийн, англи хэл, математик	54	64	74
15-р сургууль	Ердийн, математик	35	40	45
18-р сургууль	Гадаад хэлний	70	96	101
32-р сургууль	Ердийн, математик	70	90	105
41-р сургууль	Ердийн, хими, математик	45	50	55
52-р сургууль	Ердийн, математик	75	85	95
75-р сургууль	Ердийн, англи хэл, математик	70	80	90
114-р сургууль	Ердийн, англи хэл, математик	35	40	45
Гүн галуутай	Ердийн, англи хэл, математик	50	70	70
Боловсрол цогцолбор	Ердийн, англи хэл, математик	50	70	70

\*\*\*



Судалгааны эмхтгэл, XI боть

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР, БАЙРШИЛ, ТӨЛБӨРИЙН  
СУДАЛГАА<sup>113</sup> (2010-2011 оны хичээлийн жилийн эхний хагасын байдлаар)**

Хүснэгт 7

№	Сургуулийн нэр	Байршил		Төлбөрийн хэмжээ	Тайлбар
		УБ хотод	Хөдөө орон нутагт		
	Төрийн өмчийн их сургууль (байршил)	9	1		
1	Батлан хамгаалахын их сургууль (УБ)	1		780 000	
2	Боловсролын их сургууль (УБ)	1		990 000	Архангайд салбартай.
3	Монгол Улсын их сургууль (УБ)	1		1 035 000	Завхан, Орхонд салбартай.
4	Соёл, урлагийн их сургууль (УБ)	1		959 322	Завханд салбартай.
5	Удирдлагын академи (УБ)	1			
6	Ховд их сургууль (Ховд)		1	1 148 700	Баян-Өлгийд салбартай.
7	Хөдөө аж ахуйн их сургууль (УБ)	1		1 092 000	
8	Шинжлэх ухаан, технологийн их сургууль (УБ)	1		1 041 000	Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сүхбаатарт салбартай.
9	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль (УБ)	1		962 500	Говь-Алтай, Дархан-Уул, Дорнговьд салбартай.
10	Дотоод хэргийн их сургууль (УБ)	1		710 000	
	Төрийн өмчийн дээд сургууль (байршил)	2	2		
11	Дорнод дээд сургууль (Дорнод)		1	715 000	
12	Төмөр замын дээд сургууль (УБ)	1		875 000	
13	Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн (ХААИС, Дархан-Уул)		1	775 000	
14	Үндэсний тагнуулын академи (УБ)	1		700 000	
	Төрийн өмчийн коллеж (байршил)	1	0		
15	Хөгжим бүжгийн коллеж (УБ)	1		660 000	
	Төрийн өмчийн сургуулийн дүн	12	3		

<sup>113</sup> БСШУЯ-ны мэргэжлийн боловсролын газар, Нийслэлийн боловсролын газар, Хувийн их, дээд сургуулиудын холбооноос ирүүлсэн мэдээлэл

Төрийн бус өмчийн их сургууль (байршил)		4	0		
1	Их засаг их сургууль (УБ)	1		1 075 000	
2	Орхон их сургууль (УБ)	1		960 000	
3	Отгонтэнгэр их сургууль (УБ)	1		920 000	
4	Хүмүүнлэгийн ухааны их сургууль (УБ)	1		1 377 000	Дархан-Уулд салбартай.
Төрийн бус өмчийн дээд сургууль (байршил)		49	2		
5	Аварга дээд сургууль (УБ)	1		725 000	
6	Ач дээд сургууль (УБ)	1		1 650 000	
7	Билиг дээд сургууль (Хүмүүнлэгийн их сургуулийн харьяа, УБ)	1			
8	Бурхан шашны дээд сургууль (УБ)	1			
9	Газарчин дээд сургууль (УБ)	1		882 000	
10	Гурван-Эрдэнэ багшийн дээд сургууль (УБ)	1		803 000	
11	Дархан дээд сургууль (Дархан-Уул)		1		
12	Евро-Ази дээд сургууль (УБ)	1		845 000	
13	Жонон дээд сургууль (УБ)	1		798 000	
14	Засагт хан дээд сургууль (УБ)	1		750 000	
15	Зохиомж дээд сургууль (УБ)	1			
16	Идэр дээд сургууль (УБ)	1		800 000	
17	Их Монгол дээд сургууль (УБ)	1		750 000	
18	Либерти дээд сургууль (УБ)	1			
19	Мандах бүртгэл дээд сургууль (УБ)	1		850 000	Дархан-Уулд салбартай.
20	Маргад дээд сургууль (Орхон)		1		
21	Монгол дээд сургууль (УБ)	1		700 000	
22	Монгол бизнес дээд сургууль (УБ)	1		580 000	
23	Монголын үндэсний дээд сургууль (УБ)	1		895 000	
24	Монос дээд сургууль (УБ)	1		1 290 000	
25	Нийгмийн ухааны дээд сургууль (УБ)	1			
26	Олимп дээд сургууль (УБ)	1		750 000	
27	Олон улс судлалын дээд сургууль (УБ)	1		850 000	

Судалгааны эмхтгэл, XI боть

28	Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургууль (УБ)	1		680 000	
29	Оточ Манрамба дээд сургууль (УБ)	1		1 500 000	
30	Сан дээд сургууль (УБ)	1		1 000 000	
31	Санхүү, эдийн засгийн дээд сургууль (УБ)	1			
32	Сити дээд сургууль (УБ)	1		950 000	
33	Соёл-Эрдэм дээд сургууль (УБ)	1			
34	Соёмбо дээд сургууль (УБ)	1		760 000	
35	Сутай дээд сургууль (УБ)	1		780 000	
36	Сэргүүлэг дээд сургууль (УБ)	1		970 000	
37	Технологийн дээд сургууль / хуучнаар «Хүнсний технологийн коллеж» (УБ)	1		750 000	
38	Түшээ дээд сургууль (УБ)	1			
39	Тэнгэр дээд сургууль (УБ)	1		764 000	
40	Улаанбаатар дээд сургууль (УБ)	1		850 000	
41	Улаанбаатар-Эрдэм-Оюу дээд сургууль (УБ)	1		875 000	
42	Улаанбаатар-Эрдэм судлал дээд сургууль (УБ)	1			
43	Урлах эрдмийн дээд сургууль (УБ)	1			
44	Үндэсний биеийн тамирын дээд сургууль (УБ)	1			
45	Хангай дээд сургууль (УБ)	1		690 000	
46	Хөдөлмөрийн дээд сургууль (УБ)	1			Увсад салбартай.
47	Хүрээ дээд сургууль (УБ)	1		1 200 000	
48	Хэл иргэншлийн дээд сургууль (УБ)	1		890 000	
49	Хэл судлаач дээд сургууль (УБ)	1			
50	Чингэс хаан дээд сургууль (УБ)	1		750 000	
51	Шинэ иргэншил дээд сургууль (УБ)	1		800 000	
52	Шихихутаг дээд сургууль (УБ)	1		1 000 000	
53	Эдийн засаг, бизнесийн дээд сургууль (УБ)	1		780 000	
54	Эм Ай Ю дээд сургууль (УБ)	1		1 942 000	
55	Этүгэн дээд сургууль (УБ)	1			
Төрийн бус өмчийн коллеж (байршил)		23	3		

56	Барилгын технологийн коллеж (УБ)	1			
57	Бизнесийн коллеж (УБ)	1		700 000	
58	Глобал удирдагч коллеж (УБ)	1		1 650 000	
59	Гурван тамир коллеж (Архангай)		1		
60	Гүүр коллеж (УБ)	1		770 000	
61	Гэгээ коллеж (УБ)	1			
62	Далай ван коллеж (Хөвсгөл)		1		
63	Дизайн урлагийн коллеж («Барилга-Архитектур» корпораци, УБ)	1			
64	Их шавь коллеж (УБ)	1			
65	Мон-Алтиус коллеж (УБ)	1		750 000	
66	Монгол фермер коллеж (УБ)	1			
67	Номун далай коллеж (УБ)	1			
68	Санко коллеж (УБ)	1		700 000	
69	Сод хийморь коллеж (УБ)	1			
70	Старс коллеж (УБ)	1			
71	Сэтгүүлч коллеж (УБ)	1			
72	Техник, технологийн коллеж (УБ)	1			
73	Түгээмэл коллеж (УБ)	1		830 000	
74	Удирдлагын хөгжлийн коллеж (Дархан-Уул)		1		
75	Утга зохиол, нийгмийн ажилтны коллеж (УБ)	1			
76	Хантайшир коллеж (УБ)	1		710 000	
77	Цахим коллеж (УБ)	1			
78	Цэцээ гүн коллеж (УБ)	1		750 000	
79	Эко-Ази коллеж (УБ)	1			
80	Энх орчлон коллеж (УБ)	1		700 000	
81	Энэрэл коллеж (УБ)	1		765 000	
Төрийн бус өмчийн сургуулиудын дүн		76	5		
1	Плехановын нэрэмжит Эдийн засгийн академийн УБ дахь салбар (ОХУ, УБ)	1			
2	Дорнод Казакстаны их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар (Казакстан, Баян-Өлгий)		1		

ИНДИКТОРЫН  
СТАДГААНЫ САН

3	Дорнод Сибирийн Технологийн их сургуулийн УБ дахь салбар (ОХУ, УБ)	1			
4	Рафлес олон улсын институтын УБ дахь салбар (Сингапур, УБ)	1			
5	Эрхүүгийн Зам харилцааны улсын их сургуулийн УБ дахь салбар (ОХУ, УБ)	1			
	Гадаадын их сургуулийн салбарын дүн	4	1		
	Нийт дүн	92	9		

**Тайлбар:**

Хувийн их, дээд сургуулиудын холбоонд бүртгэгдээгүй сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг бүртгэх боломжгүй байна.

**Дүгнэлт:**

- Төрийн өмчтөй их, дээд сургуулийн сургалтын төлбөр 660 000 – 1 148 000 төгрөг, төрийн бус өмчтөй их, дээд болон коллежийн төлбөр 690 000 – 1 650 000 төгрөг байна. Эдгээр сургуулиудад өдөр, орой, эчнээ ангиуд болон бакалавр, магистрийн сургалт төлбөрийн ялгаатай байдаг ч нийт төлбөрийн дунджаар гаргасан үзүүлэлт юм.
- Төрийн өмчийн их дээд сургуулиудын сургалтын төлбөр 2010 оны хичээлийн жилд 9,4 хувиар өссөн байна.
- Төрийн өмчийн сургуулийн сургалтын төлбөрийг төрийн бус (хувийн хэвшлийн) сургуулийн сургалтын төлбөртэй харьцуулбал 30 000 – 500 000 төгрөгийн зөрүүтэй байна.
- “Эм АЙ Ю” хувийн дээд сургуулийн төлбөр 1 942 000 байгаа нь төрийн болон төрийн бус өмчтөй сургуулиудаас хамгийн өндөр төлбөртэй нь байна.
- Нийслэлийн ерөнхий боловсролын төрийн өмчийн сургуулиудаас Орос хэлний сургалттай Монгол-Оросын 3-р сургууль 1 500 000 төгрөг, Ердийн гадаад хэл, математикийн сургалттай Монгени сургууль 288 500 төгрөг, Ердийн гадаад хэл, мөтөмөтикийн сургалттай бусад сургуулиудын бага анги 25 000 - 97 000 төгрөг, дунд болон ахлах анги 40 000 – 615 000 төгрөгийн төлбөртэй,

Нийслэлийн ерөнхий боловсролын төрийн бус өмчийн сургуулиудаас Англи хэлний сургалттай Эрэл 2 450 000 – 2 850 000 төгрөг, Англи хэлний сургалттай УБ Элит 6 000 000 – 8 000 000 төгрөг, мөн Америк сургууль 7 975 000 – 12 325 000 төгрөг, Ердийн гадаад хэл, математикийн сургалттай бусад сургуулиудын бага анги 300 000 – 2 000 000 төгрөг, дунд болон ахлах анги 350 000 – 3 466 000 төгрөгийн төлбөртэй байгаа нь ерөнхий боловсролын сургуулийн төрийн өмчтөй сургуулийн сургалтын төлбөрийг төрийн бус өмчтөй сургуулийнхтай харьцуулахад бага ангийн хувьд 18 дахин бага, дунд болон ахлах ангийн төлбөр нь 6 дахин багаар төрийн өмчтөй сургуульд төлдөг тооцоо гарч байна.

\* \* \*

Эх сурвалж:

1. БСШУЯамны Ерөнхий боловсролын газар
2. БСШУЯамны Мэргэжлийн боловсролын газар
3. Нийслэлийн боловсролын газар
4. Хувийн их, дээд сургуулиудын холбоо
5. Төрийн өмчийн хорооноос ирүүлсэн мэдээ материал



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# 3

## БҮЛЭГ

---

ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛ

*Ц. Норовдондог /УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, доктор Ph.D/  
Хамтран оролцсон: Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа*

### **Илтгэлийн агуулга:**

1. Эдийн засгийн өсөлт ба хөрөнгийн зах зээлийн харилцан хамаарал
2. Монгол улсын эдийн засгийн өсөлт ба хөрөнгийн зах зээлийн хамаарлын шинжилгээ
3. Хөрөнгийн зах зээлд оролцогчдын засаглалыг сайжруулах асуудал

\* \* \*

Эдийн засгийн өсөлт ба түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлын асуудал нь эрдэмтэд, судлаачдын анхаарлын төвд байдаг макро эдийн засгийн судалгааны томоохон асуудал юм. Илтгэлийн сэдвийн хүрээнд эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн дундаас санхүүгийн зах зээл, тэр дундаа хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг роль болон нөлөөллийн асуудлыг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, нэр хүнд бүхий эдийн засагчдын хийсэн онолын болон эмпирик судалгаанд тулгуурлан авч үзсэн болно.

Мөн Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төлөв байдал, түүнд хөрөнгийн зах зээл нөлөө үзүүлж буй эсэх талаар тодорхой тоо мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийх, цаашид хөрөнгийн зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үүднээс зах зээлд оролцогчдын засаглалын чанарыг сайжруулах асуудал зайлшгүй чухал болохыг энэхүү судалгаагаар харуулахыг зорьсон болно.

### **1. Эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн үүрэг**

Эдийн засгийн уламжлалт онолын сэтгэлгээгээр, эдийн засгийн өсөлтийг байгалийн баялаг, капитал, ажиллах хүчин, хөдөлмөрийн бүтэээмж, техникийн дэвшил зэрэг бодит хүчин зүйлүүд тодорхойлдог хэмээн ихэнх эрдэмтэн судлаачид үзэж байсан. Санхүүгийн зах зээлийн эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл нь харьцангуй бага бөгөөд сайн хөгжсөн санхүүгийн сектор нь эдийн засагт хуримтлалыг бий болгож богино хугацаандаа эфект үзүүлнэ гэсэн онолын тайлбарыг Бланшар нарын эрдэмтэд хэлж байсан байна.

Санхүүгийн зах зээл болон эдийн засгийн өсөлтийн хамаарлын талаархи анхны судалгааны бүтээлүүдийг Gurley J, Shaw E нар туурвисан бөгөөд санхүүгийн зах зээл болон эдийн засгийн өсөлтийн хооронд тодорхой нөхцөл шалтгаант уялдаа холбоо байдаг гэдгийг нотлох оролдлого хийжээ. Дэлхийн банкны эдийн засагч Николас Стерн “Эдийн засгийн систем хэвийн байх үед санхүүгийн зах зээлийн үүрэг роль анзаарагдахгүй мэт боловч нөхцөл байдал муудах үед санхүүгийн секторын хямрал нь маш их хортой үр дагаврыг авчирдаг” гэжээ.

Сүүлийн үеийн санхүү эдийн засгийн хямралуудын сургамж нь эдийн засагт гүйцэтгэж буй санхүүгийн секторын үүрэг ролийг үгүйсгэж болохгүй бөгөөд санхүүгийн сектор нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход чухал үүрэг бүхий салбар мөн гэдгийг эрдэмтэд хүлээн зөвшөөрч энэ асуудалд анхаарлаа хандуулах болсон байна.

Санхүүгийн салбар болон эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарлын асуудлыг орчин

Судалгааны эмхтгэл, XI боть

үеийн хандлагаар нь анх Шумпетер Й хөндөж тавьсан бөгөөд эдийн засаг дахь санхүүгийн секторын хөгжил нь ДНБ болон 1 хүнд ногдох ДНБ-ний өсөлт зэрэг үзүүлэлтүүдэд эерэг нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлт хийжээ.

Шумпетерийн үзэж байгаагаар “санхүүгийн зуучлагчид/ зөвхөн банкыг авч үзсэн/хөрөнгө татан төвлөрүүлж хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх, эрсдэлийг удирдахад үйл ажиллагаагаа чиглүүлсэнээр бие даасан хөрөнгө оруулагчдаас илүү мэргэшсэн байдлаар компанийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой. Энэ нь эдийн засагт хийгдэж буй хэлцлийн тоог нэмэгдүүлж техникийн шинэчлэл хийх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөшүүрэг болдог гэж үзжээ. Санхүүгийн салбар нь хөрөнгө оруулалтыг хамгийн сайн өгөөж өгөх төслүүдэд чиглүүлж хөрөнгийг дахин хуваарилалтыг явуулдаг тул өсөлтийг дэмжих катализатор болдог” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Шумпетер нь банкны салбарын үүрэг рольд ач холбогдол өгч байсан бол орчин үеийн судлаачид хөрөнгийн зах зээлийн үүрэг ролийг судлан шинжлэх болсон байна. Р. Камерона, Х. Патрик, Р. Голдсмит, Дж. Хикс нарын томоохон судлаачид энэ асуудлыг судалж эхэлсэн. 18-р зуунд Их британийг дэлхийн хүчирхэг гүрэн болгосон аж үйлдвэрийн хувьсгал нь зөвхөн технологийн дэвшлийн үр дүнд биш санхүүгийн зах зээлийн хөгжлийн үр дүнд бий болсон амжилт юм. Санхүүгийн зах зээлийн хөгжил нь эдгээр төслийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг олгосон юм” гэж Дж. Хикс хэлсэн байна.

Санхүүгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг судлаачид онолын загварууд, эдийн засгийн математик аргуудыг ашиглан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан олон бүтээлүүд байна. Эдгээрээс нөлөө бүхий концепц нь посткейнсийн онолын төлөөлөгч Х. Минскийн дэвшүүлсэн “санхүүгийн хэрэг байдлын “тухай гипотез юм. Энэ онолоор бол, санхүүгийн институт болон үйлдвэрлэлийн компаниудын эцсийн зорилго нь ашгийн төлөө байдаг учраас бодит секторт санхүүгийн хэрэгцээ / зээл, үнэт цаас гаргах/ өсөхийн хэрээр санхүүгийн институтууд энэхүү хэрэгцээг хангахыг тэмүүлнэ.

Зохицуулах байгууллагуудын зүгээс банкны заавал байлгах нөөц, бодлогын хүүг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээг хязгаарласан байлаа ч санхүүгийн зуучлагчид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох замаар энэхүү саадыг давж чаддаг. Тухайлбал, олгосон зээлээ үнэт цааст хөрвүүлэх, санхүүгийн институт хоорондоо зээлийн шугам нээх, синдикат хэлбэрээр хамтран зээл олгох, пассивийн удирдлагыг сайжруулах замаар урт хугацааны эх үүсвэрийг бий болгох зэрэг шинэлэг аргуудыг нэвтрүүлсээр байгаа нь санхүүгийн зах зээлийн хөгжилд түлхэц болж байна.

## **2. Хөрөнгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл**

Санхүүгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг судлах З язын хандлага буюу парадигм бий болжээ. Үүнд:

1. Санхүүгийн зах зээл дэх зээлдэгч –зээлдүүлэгчдийн харилцааны субъектив хүчин зүйлээс хамааралтай микроэдийн засгийн шалтгааныг судлах. Үүнд ёс зүйн эрсдэл, буруу сонголт, принципал-агентын харилцааны асуудал хамаарна. Амьдрал дээр зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд мэдээллийн үнэн зөвийн тухайд асуудал үүсдэг.

Зээлдэгч төслийнхөө бодит байдал / эрсдэл, орлого гэх мэт/-ын талаар туйлын үнэнийг мэдэж байдаг боловч зээлдүүлэгчийн хувьд зээлдэгчийн найдвартай байдлыг тодорхойлоход хүндрэлтэй. Зээлдэгч аль болохоор үнэнийг нууна, зээлдүүлэгч зээлдэгчийн үйл ажиллагаанд мониторинг хийх шаардлагатай болдог ч энэ нь зардал шаардана. Үүнээс үүдэн болгоомжлол үүсч хөрөнгө оруулалт хумигдсанаар эдийн засгийн өсөлт буурдаг гэж Дж. Стиглиц, Б. Смит нар үзжээ.

2. Эдийн засгийн өсөлтийн эндоген загварт санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдийн нөлөөг оруулж тооцоолох. М. Пагано, П. Хоуитт нарын эрдэмтэд энэ загвараар тооцоо хийж санхүүгийн зах зээл нь эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлэх үү, эсвэл шинжлэх ухаан техникийн дэвшлээр дамжуулж нөлөө үзүүлэх үү гэсэн 2дмр парадигмийг судалж үзээд санхүүгийн зах зээлийн хөгжил болон эдийн засгийн өсөлтийн хооронд эерэг хамаарал байдаг гэдгийг онолын хувьд нотолжээ.
3. Эконометрик шинжилгээний арга. Эмпирик тооцооны аргаар эдийн засгийн өсөлт болон санхүүгийн зах зээлийн хөгжлийн хооронд мөн ийм эерэг хамаарал байдгийг “Барро-регрессийн” томъёоллоор тооцож гаргасан байна. Математик аппарат ашиглан олон янзын регрессийн шинжилгээнд санхүүгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийн нөлөөллийг оруулж тооцохи замаар тооцооллуудыг хийдэг. Энэхүү парадигмийн төлөөлөгчид Р. Левин, Т. Бек, А. Демиргуч-Кунта, Р. Раджан нарыг нэрлэж болно.

Мэдээжийн хэрэг эдийн засгийн өсөлт ба санхүүгийн зах зээлийн хамаарлын асуудал нь онолын хувьд судлагдахуун хэвээр байсаар байгаа боловч “санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин нь эдийн засгийн өсөлтийн катализатор мөн” гэдэг дээр онолчид, судлаачид санал нэгдсэн байна.

Нобелийн шагналт эрдэмтэн Самуэльсоний тодорхойлсоноор” Эдийн засгийн өсөлт болон хөрөнгө оруулалтын харилцан хамаарлын механизм нь “акселлераторийн зарчмаар” явагдах ба ДНБ-ийн бодит өсөлт нэмэгдэх нь бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ, бодит хөрөнгө оруулалт нэмэгдсэний үр дүнд ДНБ өснө” гэж үзжээ. Гэхдээ бодит хөрөнгө оруулалт гэдэгт зөвхөн үл хөдлөх хөрөнгө/ барилга байшин, машин тоног төхөөрөмж/ болон үйлдвэрлэлийн нөөцийг тооцсон байна.

Абрамов нарын эрдэмтэдийн дэлхийн 20 өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудыг 1961-2005 оны хоорондхи 45 жилийн ДНБ-ний бодит өсөлт болон бодит хөрөнгө оруулалтын өсөлтийн хамаарлын судалгаа үүнийг мөн нотолжээ.

Эдгээр эрдэмтэдийн тооцоолсоноор, Өндөр хөгжилтэй орнуудын хувьд дунджаар ДНБ-ны бодит өсөлт 1%-иар нэмэгдэхэд 2,8%-ийн бодит хөрөнгө оруулалт шаардлагатай, тухайлбал, Их британид-3,7%, Германид 2,9%, Францад-2,7%, канадад-2,3%, АНУ-д 2,2%, Японд-1,8% байна гэсэн тооцоо хийжээ.

Дэлхийн банк болон ОУВС-ийн мэргэжилтнүүдийн янз бүрийн он жилүүдэд хийсэн судалгаагаар, “Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшин нь эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлдэг” гэдгийг нотолжээ. Гэхдээ энэхүү шууд хамаарал нь аяндаа бий болдоггүй бөгөөд байнгын мониторинг, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын нягт уялдаа холбоо бүхий ажиллагаа, мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг зохицуулах байгууллагуудын үйл ажиллагаанаас хамаардаг гэжээ.

Эдийн засгийн өсөлтөнд санхүүгийн зах зээлийн үзүүлэх нөлөөлөл нь тухайн орны хөгжлийн түвшнээс шалтгаалан янз бүр байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд (G-8 – ийн орнууд, ОЭСР болон ЕС-ийн орнууд ) санхүүгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөл нь харьцангуй өндөр, эерэг хамааралтай байна гэдгийг Дэлхийн банкны судалгаагаар тогтоожээ. /табл/

Хөгжиж байгаа орнуудын хувьд байдал өөр байна. Улс бүрийн хөгжлийн түвшин өөр, эдгээр үзүүлэлтийг үнэн зөв тооцох статистик мэдээлэл хангалтгүй зэргээс шалтгаалан одоогийн байдлаар хжигж байгаа орнуудын хувьд тооцоо судалгааг бүрэн дүүрэн гаргаж чадаагүй байгаа учраас эдгээр орнуудад санхүүгийн зах зээл нь эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж байна гэж хэлэхэд учир дутагдалтай гэж үздэг байна. Хөгжиж буй

орнуудын хувьд ядуурлыг бууруулах, тэгш бус байдлаг арилгах, инфляцийг бууруулах зэрэг олон асуудлууд байдаг нь судалгаа шинжилгээний явцад хүндэрэл үүсгэдэг. Судлаачдын үзэж байгаагаар, санхүүгийн секторын хөгжил нь эдгээр орнуудын хувьд эцсийн дүндээ ядуурлыг бууруулахад нөлөө үзүүлэх боловч харамсалтай нь эхний үедээ тэгш бус байдлыг үүсгэдэг гэжээ.

Хөгжих буй орнуудын хувьд инфляци өндөр байдгаас санхүүгийн зах зээлийн эдийн засагт үзүүлэх зэрэг нөлөөллийг бууруулж байдаг. Эмпирик судалгаанаас үзэхэд, инфляц жилд 13-25% өсөхөд ЭЗӨ болон С33-ийн хооронд зэрэг хамаарал ажиглагдахгүй. Иймээс инфляц бага байх нь С33-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг сайжруулна гэж үздэг байна. Гэхдээ Хятад, Энэтхэг, Бразил зэрэг хөгжих буй эдийн засагтай орнуудын хувьд бага зэрэг зэрэг хамаарал байгаа болохыг судлаачид тогтоожээ.

### **3. Монгол улсын хөрөнгийн зах зээл ба эдийн засгийн өсөлтийн хамаарлын шинжилгээ**

Монгол улсын эдийн засгийн төлөв байдал, түүнд үзүүлж байгаа санхүүгийн зах зээлийн хүчин зүйлийн нөлөөллийг тооцох үүднээс судалгааг 2 шаттайгаар гүйцэтгэв. Үндсэн схем:/ ЭЗӨ, инфляц, санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдийг графикаар харуулах/

**1-рт: Санхүүгийн зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж тэдгээрийн өсөлт бууралтын динамик судалгаагаар харуулав. Үүнд:**

1. Санхүүгийн секторын бүтцийн үзүүлэлт (Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ/ нийт зээлийн хэмжээ)

Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ ба арилжааны банкуудын олгосон нийт зээлийн харьцаагаар санхүүгийн зах зээлд банкны сектор болон хөрөнгийн зах зээлийн аль нь илүү үүрэг рольтой байна вэ гэдгийг тодорхойлдог. / Дээрхи коэффициент 1-ээс их буюу бага байх нь С33-д хөрөнгийн зах зээл ба банкны салбарын аль нь давамгайлж байгааг харуулна/

1995-2010 оны хоорондхи динамик судалгаанаас үзэхэд , 1995 он гэхэд дээрхи коэф 0.2 байсан бол 1997 онд 0.8 хүрч улмаар 2004-2005 онд 0.5 болсон байна. 2006 оноос бага зэрэг сэргэж 2010 оны эцэст 0.6 болсон. Өөрөөр хэлбэл, Монгол улсын санхүүгийн зах зээлд банкны сектор болон хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэж буй үүрэг 60/40-ийн харьцаатай байна гэж үзэж болох боловч Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааг үндсэндээ бодит хөрөнгө оруулалт гэж тооцох боломжгүй. / хувьчлалын журмаар үнэгүй тараагдсан хувьцаа учраас/ Үүнээс , хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэнээс хойш шинээр IPO хийж гаргасан хувьцаа болон бондын дүнг хөрөнгө оруулалтын үнэт цааст тооцож тооцвол хөрөнгийн зах зээлийн санхүүгийн зах зээл дэх үүрэг оролцоо маш бага гарах болно. / Шинээр гаргасан үнэт цаасны мэдээлэл тодорхойгүй, оддохгүй байв. /график дүрслэл 1/

2. Санхүүгийн зах зээлийн тэлэлт (Санхүүгийн нийт актив/ ДНБ ) Энэхүү үзүүлэлтийг санхүүгийн нийт активийг ДНБ-нд харьцуулах замаар тооцдог. 1995-2010 оны хоорондхи динамик судалгаанаас үзэхэд, 1995 онд дээрхи үзүүлэлт 18,6% байсан бол аажмаар өссөөр 2010 оны эцэст 71,1% болсоноос үзэхэд санхүүгийн зах зээл тэлж байна гэдэг нь харагдаж байна/ финансовая глубина/
3. Эдийн засаг дахь бодит хөрөнгө оруулалт (Нийт хөрөнгө оруулалт/ ДНБ) 1995-2010 оны динамик судалгаанаас үзэхэд, 1995-2008 оны хооронд дээрхи үзүүлэлт үндсэндээ тогтол 20%-30% хооронд хэлбэлзэж байсан бол 2009 онд 32,5, 2010 онд 40,8% болж өсөх хандлагатай байгаа нь уул уурхайн салбарт оруулсан шууд хөрөнгө оруулалттай

холбоотой гэж үзэж болохоор байна.

- Хөрөнгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг / ХЗЗ-ийн нийт үнэлгээ/ ДНБ/ Дээрх харьцааны 1995-2010 оны динамик судалгаанаас үзэхэд, 1995 онд 2,3%тай байсан бол 1997 онд 5,2% болж бага зэрэг өссөнөө 2004 онд 1,0% хүртэлээ буурсан байна. 2005 оноос энэ үзүүлэлт өсч 2010 онд 16,6% болсоноос үзэхэд хөрөнгийн зах зээл сэргэх хандлагатай болж эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь нэмэгдэх хандлагатай байна.

**2-рт: Хөрөнгийн зах зээл, Санхүүгийн зуучлал болон Бодит хөрөнгө оруулалтын ДНБ-ний өсөлтөд нөлөөлж буй нөлөөллийг “Барро-регрессийн” аргачлалаар тооцож гаргав.**

#### Ашигласан мэдээлэл

obs	G_GDP	MV_LO	FA_GDP	I_GDP
1996	2.4	27.6	19.7	20.9
1997	4	85.9	22.2	21.7
1998	3.5	41.9	25	28.8
1999	3.2	44.4	23.3	29
2000	1.1	60.7	18.3	24.3
2001	1	30.6	23.7	24.1
2002	3.9	15.3	31.7	23.3
2003	7	11.2	46.2	25.2
2004	10.6	4.9	41.5	27.3
2005	7.3	6.5	49.3	25.8
2006	8.6	10.7	51.1	23.7
2007	10.2	34.8	57.7	25.3
2008	8.9	19.6	51.2	27.2
2009	-1.6	23.4	62.1	32.6
2010	6.1	42.1	71.1	40.8

Эдийн засагч Баррогийн ДНБ-ний өсөлтөд хөрөнгийн зах зээлийн нөлөө, санхүүгийн зуучлалын нөлөө, бодит хөрөнгө оруулалтын нөлөөлөл хэр байгааг тодруулбал ДНБ-ний өсөлтийн хэдэн хувийг эдгээр 3 үзүүлэлт бүрдүүлж байгааг харуулах зорилгоор регрессийн тэгшитгэлээр тооцож үзлээ.

$$\Delta \text{ДНБ}_{\text{өсөлт}} = a + b * \frac{\text{хөрөнгийн зах зээлийн үнэлгээ}}{\text{нийт зээлийн хэмжээ}} + c * \frac{\text{санхүүтийн актив}}{\text{ДНБ}} + d * \frac{\text{бодит хөрөнгө оруулалт}}{\text{ДНБ}} + e$$

- ДНБ -нд хөрөнгийн зах зээлийн үзүүлэх нөлөөлөл
- ДНБ -нд санхүүгийн зуучлалын үзүүлэх нөлөөлөл
- ДНБ -нд бодит хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөөлөл

**Анхны үнэлгээ**

Dependent Variable: G\_GDP

Method: Least Squares

Date: 09/15/11 Time: 21:50

Sample: 1996 2010

Included observations: 15

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	8.938744	5.066077	1.764431	0.1054
MV_LO	-0.020426	0.047595	-0.429162	0.6761
FA_GDP	0.142053	0.079006	1.798004	0.0996
I_GDP	-0.332217	0.249892	-1.329441	0.2106
R-squared	0.355942	Mean dependent var		5.080000
Adjusted R-squared	0.180290	S.D. dependent var		3.646956
S.E. of regression	3.301875	Akaike info criterion		5.450036
Sum squared resid	119.9262	Schwarz criterion		5.638850
Log likelihood	-36.87527	Hannan-Quinn criter.		5.448025
F-statistic	2.026404	Durbin-Watson stat		2.212346
Prob(F-statistic)	0.168629			

Анхны хийсэн үнэлгээний хувьд хөрөнгийн зах зээлийн ДНБ-нд нөлөөлөх магадлал нь 0,6761 буюу энэ нь статистикийн хувьд хамгийн ач холбогдол багатай буюу ДНБ-нд нөлөөлөл байхгүй байна. Онолын хувьд үнэлгээнд хамгийн ач холбогдол багатай / хөрөнгийн зах зээлийн/ үнэлгээг хасаж тооцвол дараахь үр дүн гарч байна.

\* \* \*

**Эцсийн үнэлгээ**

Dependent Variable: G\_GDP

Method: Least Squares

Date: 09/15/11 Time: 22:03

Sample: 1996 2010

Included observations: 15



Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	8.647040	4.846617	1.784139	0.0997
FA_GDP	0.160577	0.063884	2.513561	0.0272
I_GDP	0.372260	0.223801	-1.663357	0.1221

R-squared	0.345158	Mean dependent var	5.080000
Adjusted R-squared	0.236018	S.D. dependent var	3.646956
S.E. of regression	3.187660	Akaike info criterion	5.333308
Sum squared resid	121.9341	Schwarz criterion	5.474918
Log likelihood	-36.99981	Hannan-Quinn criter	5.331800
F-statistic	3.162519	Durbin-Watson stat	2.172780
Prob(F-statistic)	0.078853		

Эцсийн үнэлгээгээр манай улсын хувьд банкны салбарын зуучлал болон шууд хөрөнгө оруулалтын хэмжээ/ гадаадын/ ДНБ-ний өсөлтийн 34 хувийг бүрдүүлж байна гэсэн тооцоо гарч байна.

Бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нэг арга бол Хөрөнгийн бирж дээр –IPO гаргах. Дэлхийн хэмжээнд авч үзвэл IPO хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн үед хурдтай өсөх хандлагатай байна. IPO хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд болон эдийн засгийн бодит өсөлтийн хооронд корреляцийн өндөр хамаарал байдаг учраас хөрөнгийн зах зээлийн хөгжлийн асуудалд тулхуу анхаарах цаг болжээ.

IPO хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийн хүчийн чадлыг нэмэгдүүлэх бодит хөрөнгө оруулалтад чиглэгдэх ёстой байдаг ч зах зээл шинэ тутам хөгжиж байгаа орнуудын хувьд хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах явдал байна. Монгол улсын хувьд хөрөнгө оруулалтын утгаараа IPO гаргах ажиллагаа эхлэл төдий байна. 1990-ээд оны үед ягаан, цэнхэр тасалбараар хувьчилсан 470 гаруй үйлдвэр аж ахуйн газруудад үндсэндээ хөрөнгө оруулалт хийгээгүй бөгөөд өмчлөх эрх шилжүүлэх ажиллагаа л явагдсан юм. Хөрөнгө оруулалтын IPO гаргасан байдлыг статистик мэдээллээс үзвэл, 1990-2010 оны байдлаар шинээр гаргасан хувьцаа - байгаа нь бодит хөрөнгө оруулалтын %, бонд - төгрөг нь % байгаас компанийн бонд , ЗГ -ын бонд байна.

Хөрөнгийн зах зээлийн потенциалыг эдийн засгийн өсөлтийн боломж болгон ашиглахад IPO хэлбэрээр гаргасан хувьцаа, болон бондын санхүүжилтийг зориулалтын дагуу бодит хөрөнгө оруулалтанд зориулж байгаа эсэхэд тавих хяналт, мониторинг чухал үүрэгтэй. Үүнтэй уялдан хөрөнгийн зах зээлд оролцогчдын удирдлага, менежмент засаглалын чанаарын асуудлыг сайжруулах нь эн тэргүүний асуудал юм. Зах зээлд оролцогчдын засаглалыг сайжруулах үүднээс удирдлага, менежментийн шинэ арга, стандартуудыг нэвтрүүлэх, биржид бишрэгтэй компаниудын засаглалыг сайжруулах, мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангах шаардлагатай.

Эдгээр шаардлагуудыг хангаснаар компаниудын зээлжих чадварын үнэлгээ сайжрах бөгөөд энэ хэмжээгээр ур хугацаатай хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодын зах зээл дээрээс татах боломж бүрдэнэ. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болох бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хөрөнгийн зах зээлийн үүрэг роль чухал юм .

### Хөрөнгийн зах зээлд оролцогчдын засаглалыг сайжруулах асуудал

Монгол улсын Ерөнхий сайд С. Батболд саяхан “Хөрөнгийн зах зээл бол хөгжлийн хөшүүрэг “сэдэвт төрийн өмчийн ААН, үнэт цаас, даатгалын салбарын төлөөлөлтэй хисэн уулзалтан дээр хэлсэн үгэндээ “... Хөрөнгийн зах зээл бол Монгол улсад бол шинэхэн хөгжиж буй салбар юм. Өнгөрсөн 18 жилд өсөлтийн бэрхшээл, туршлагагүйн балчирдал байсан нь мэдээж боловч өнөөгийн бодит шаардлага Та биднээс илүү ихийг хүсэн хүлээж

байна. Хөгжилтэй орнуудын иргэд гэрээсээ буюу гар утаснаасаа аль ч хөрөнгийн биржэд холбогдож, сонирхсон арилжаагаа хийх боломжоор хангагдах хэмжээнд хүрчээ. Манайд байдал ямар байна вэ?

Хувьцаа худалдах худалдан авах сонирхол бүхий хүн аль нэгэн брокер дилериин компанийг царайчлах шаардлага гардаг. Үүнийг дагасан хүнд суртлаас иргэд халширч, яваандаа сонирхолгүй болдог. Хийгдэж байгаа арилжаа нь Засгийн газраас гаргасан бондын хэдэн төгрөг, аль хэзээнийн цэнхэр тасалбараар хувьчлагдсан цөөхөн компанийн хэдхэн хувьцаа. Ийм байж өнөөдөр таарахгүй. Өнөөгийн дэлхийн жишгээс бид дэндүү хол байна“ гэдгийг дурьдсан байна.

Мөн уул уурхайн салбарын хөгжлийг дагаад бидэнд хөрөнгийн зах зээлийн дэлхий нийтийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах, энэ салбарт ахиц дэвшил гаргах шаардлага байна гэдгийг тоо баримтаар дурьдсан байна. Тухайлбал, Хонг-Конгийн хөрөнгийн биржид бүртгэгдсэн Хөшөөтийн нүүрсний орд газрын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг “Mongolia Energy Corporation Limited” компани нийт 6,1 тэрбум ширхэг хувьцаа гаргаж 27,0 тэрбум хонг-конг долларын санхүүжилтийг бий болгосон бол, Нью Йоркийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Оюутолгойн ордын эзэмшигч Айвенхоу майнз компани 424,9 сая ширхэг хувьцаа гаргаж 5,6 тэрбум канад долларын эх үүсвэрийг тус тус бий болгож чаджээ. Өнөөдөр Торонто, Лондон, Хонг Конг, Нью Йоркийн хөрөнгийн биржүүдэд Монгол улсын уул уурхайн ордтой хамаарлтай 20 гаруй компанийн хувьцаа арилжаалагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монголын орд газрыг барьцаалан хөрөнгө босгож болоод байхад бид өөрсдөө яагаад хийж чадахгүй байгаа юм бэ? Тэдний туршлагаас суралцах боломж бүрэн бий. Гагцхүү идэвхи санаачлага, эрэл хайгуул, өрсөлдөх чадвар дутаж байна. Бид үүнд маш хурдан суралцах хэрэгтэй. Ингэснээр Оюутолгой, Таван толгой, Эрдэнэт, Монголросцветмет гэх зэрэг дэлхийн зах зээл дээр өрсөлдөхүйц томоохон төсөл, аж ахуйн нэгжүүдийн хувьцааг олон улсын болон дотоодын бирж дээр шууд гарган арилжаалах боломж бүрдүүлэх явдал нэн чухал . Бид үр ашигтай байхын тулд бүхий л үйл ажиллагаагаа олон улсын нийтлэг дэг журмаар явуулж, нэг хэлээр ярьж, тэнд үйлчилдэг зарчим, дүрмийг шууд авч хэрэгжүүлэх нь өнөөгийн зайлшгүй шаардлага болоод байна” гэсэн байна.

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөр”, Ерөнхий сайдын гаргасан санал санаачлагатай уялдуулан хөрөнгийн зах зээлийг дэлхийн нийтлэг стандартын дагуу зөв зохион байгуулж төлөвшүүлэхэд ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СТАНДАРТ болон КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СТАНДАРТ –ыг нэвтрүүлэх асуудал туйлын чухал юм. Энэ асуудалд САНХҮҮГИЙН зохицуулах хороо болон зах зээлд оролцогч субъектууд онцгой анхаарах ёстой. Эдгээр стандартыг нэвтрүүлж зөв төлөвшүүлэхгүйгээр Монгол улсад хөрөнгийн зах зээл хөгжих, олон улсын зах зээлтэй интеграцид орох нөхцөл бүрдэхгүй юм.

1/ ҮЦЗЗ-ийн зохицуулалтын стандартыг нэвтрүүлэх асуудал

Олон улсын хэмжээнд Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага /IOSCO/-аас 1998 онд гаргаж 2003 онд шинэчлэн баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын зорилго ба зарчим” /Objectives and Principles of Securities Regulation/, мөн 2001 онд баталсан “Үнэт цаасны төлбөр тооцооны зөвлөмж” хэмээх баримт бичгүүд байдаг. “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим” хэмээх баримт бичигт Үнэт цаасны зохицуулалтын дараах үндсэн 3 зорилтыг нийтээр дагаж мөрдөхөөр тодорхойлсон. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах
- Зах зээлийн үнэнч шударга, үр ашигтай, ил тод механизмыг бүрдүүлэх
- Системийн эрсдлийг бууруулах

Дээрх З зарчим нь хоорондоо нягт холбоотой, зарим тохиолдолд давхацсан шинж чанартай байдаг. Тухайлбал, зах зээл ил тод, үр ашигтай, цэвэр тунгалаг байх зарчим нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах, системийн эрсдлийг бууруулахад чиглэгдсэн байдаг бол эрсдлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулагчдыг хамгаалахад мөн чиглэгдэж байдаг юм. Мөн хяналт шалгалт, зөрчил илрүүлэх, хохирол гомдлыг барагдуулах, хууль хэрэгжүүлэх ажиллагаа болон зохицуулах байгууллагуудын хамтын ажиллагаа нь эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөөтэй юм.

## 1. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зарчим.

Хөрөнгө оруулагчид нь дотоод мэдээллийг ашиглан арилжаа хийх, харилцагчдын өмнүүр орж гүйлгээ хийх, харилцагчдын мөнгөн хөрөнгийг үрэгдүүлэх зэрэг хууль бус үйл ажиллага, манипуляцаас хамгаалагдсан байх ёстой.

Хөрөнгө оруулагчдыг шийдвэр гаргахад нь зайлшгүй шаардлагатай мэдээллээр бүрэн хангах нь маш чухал. Ингэснээр хөрөнгө оруулагчид юуны өмнө учирч болзошгүй эрсдэл болон үр ашгаа зөв тооцоолж, өөрсдийнхөө ашиг сонирхолыг хамгаалах боломжтой болно. Мэдээллийг ил тод байлгах шаардлагын гол үндэс болохын хувьд нягтлан бодох бүртгэл, аудитийн стандарт нь чанартай, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай.

Зөвхөн эрх бүхий байгууллагаас лиценз авсан хүн, эсвэл байгууллага хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх эрхтэй. Тухайлбал, зах зээлийн зуучлагч байгууллагууд болон биржийн операторууд. Эдгээр лиценз бүхий байгууллага болон хувь хүнд эхлэлтийн болон өөрийн хөрөнгийн шаардлага зайлшгүй тавигдана. Учир нь үнэт цаасны компаниуд нь харилцагчид болон хамтран ажиллагсадынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн нөхцөлийг бүрдүүлж, харилцагчдын хөрөнгийт хамгаалах үүрэгтэй.

Зах зээлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт нь зах зээлд оролцогчдод тавигдах минимум шаардлагыг хангуулах, хөрөнгө оруулагчдыг хамгаалахад чиглэгдсэн байх ёстой. Иймд уг шаардлагад нийцсэн хяналт шалгалт хийх, зөрчил илрүүлж, хохиролыг барагдуудах үр ашигтай систем байх ёстой. Юуны өмнө үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хэрэгжилт маш сайн байх ёстой. Хяналт шалгалтын тогтолцооны үр ашигтай байдал нь зохицуулах байгууллагууд дотооддоо болон олон улсын түвшинд хэрхэн хамтран ажиллаж байгаагаас шалтгаална.

## 2. Үнэнч шударга, ил тод, үр ашигтай зах зээл

Зохицуулах байгууллагын зүгээс бирж болон арилжааны операторуудын үйл ажиллагааг зохицуулж буй байдал, арилжаатай холбоотой журам заавар нь зах зээл хир зэрэг шударга байгааг илэрхийлнэ. Зах зээлийн үнэнч шударга байх зарчим нь хөрөнгө оруулагчдыг арилжааны буруу практикаас хамгаална. Зах зээлийн зохион байгуулалт нь зах зээлд оролцогчдод ижил тэгш нөхцлийг бүрдүүлэх ёстой. Зохицуулагч зах зээлийн манипуляц болон бусад хууль бус ажиллагааг таслан зогсоох, арга хэмжээ авах үүрэгтэй.

Зохицуулагч байгууллага нь зах зээлийн холбогдолтой мэдээллүүд, үнэ ханшийн мэдээллийг хөрөнгө оруулагчид үнэнч шударгаар олж авч чадаж байгаа эсэх, зах зээлд үнэ бүрдэх, харилцагчдын захиалгыг биелүүлэх ажиллагаа үнэнч шударга хийгдэж байгаа эсэхэд хяналт тавина.

Үр ашигтай зах зээл дээр зах зээлийн үнэ бүрдэлтэд нөлөөлөх мэдээллүүдийг тодорхой үе шаттайгаар, тогтмол нийтэд хүргэж байгаа эсэхэд хяналт тавина. Ялангуяа мэдээллийг ил тод болгох, нийтэд хүргэх асуудал маш чухал.

### 3. Системийн эрсдлийг бууруулах

Хэдийгээр зохицуулагч байгууллага зах зээлд зуучлагч нь дампуурах эсэхийг урьдчилан таамаглаж чадахгүй ч гэсэн дампуурах эрсдлийн бууруулах ёстай. Жишээ нь, цэвэр хөрөнгө болон дотоодын хяналтын хэрэгслүүдийг ашиглана. Ийм тохиолдол гарсан тохиолдолд зохицуулагч үйл ажиллагааг нь таслан зогсоохдоо харилцагч, үйлчлүүлэгчдийг аль болохоор хохирол багатай байх арга хэмжээг авсан байх ёстай.

Эрсдлийг удирдах нь ялангуяа тасралтгүй ажиллагаатай, идэвхтэй зах зээлд маш чухал. Зохицуулагч нь эрсдлийн үр ашигтай менежментийг цэвэр хөрөнгө, бусад арга хэрэгслүүдийг ашиглан зохицуулна. Үр ашигтай, зөв зохион байгуулагдсан төлбөр тооцооны системтэй үед эрсдлийн менежментийг үр ашигтай явуулж болно. Дээрхи З зорилтын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын 8 төрлийн 30 зарчмыг баталгаажуулж, Олон Улсын Үнэт Цаасны Хорооны Байгууллага /IOSCO-/ын гишүүн орнууд холбогдох хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд:

- ✓ Зохицуулагчтай холбоотой зарчмууд
- ✓ Өөрийгөө зохицуулах байгууллагын зарчмууд
- ✓ Үнэт цаасны зохицуулалтын албадан хэрэгжүүлэх зарчмууд
- ✓ Зохицуулагчийн хамтын ажиллагааны зарчмууд
- ✓ Үнэт цаас гаргагчдын дагаж мөрдөх зарчмууд
- ✓ Хамтын хөрөнгө оруулалтын зарчмууд
- ✓ Зах зээлд зуучлагчдын зарчмууд
- ✓ Хоёрдогч зах зээлийн зарчмууд

#### 2/ Компанийн засаглалыг сайжруулах асуудал

АНУ -д 19 дүгээр зуунд нээлттэй буюу хувьцаа нь олон нийтэд чөлөөтэй арилжигддаг томоохон корпорациуд нэгдэх болон төрийн өмчт компаниуд хувьчлагдах үйл явц өрнөж байх тэр үед “Корпорацийн тухай” Холбооны Улсын хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар компанийн төлөөлөн удирдах зөвлөлд шийдвэр гаргах илүү эрх олгогдсон байна. Үүнтэй холбоотойгоор компанийн цөөн тооны буюу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх болсон нь Компанийн засаглал болон Компанийн зохистой удирдлагыг шинэ түвшинд гаргах хэрэгцээ шаардлагыг бий болгожээ.

Мөн 1929 оны Их хямрал, 1997 оны зүүн Азийн санхүүгийн хямрал болон 2008 оны дэлхий нийтэд нүүрлэсэн санхүү эдийн засгийн хямралд бусийн болон дэлхийн хэмжээний томоохон хөрөнгө оруулалт, банк санхүүгийн байгууллагын засаглалын зарчим, зүй зохист удирдлага, хяналтын зарчим алдагдсан нь зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж судлаачид үздэг байна.

Компанийн засаглал нь компанийн хувь нийлүүлэгч / хувьцаа эзэмшигч / , менежер болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээний зохистой хуваарилалт юм. Өөрөөр хэлбэл аливаа компанийн томоохон хувьцаа эзэмшигч нийт хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хангах үүднээс компанийн өдөр тутмын болон урт хугацааны хэтийн төлөвлөлт, бодлогыг тодорхойлох чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн санал, шийдвэрийг эрхэмлэн дээдлэх явдал байдаг.

Мөн зөвлөлийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулах болон мэдээллийн ил тод байдлыг хангахад компанийн зохистой удирдлагын зарчим чиглэгдэж байдаг.

Q харьцаа =	Пүүсийн зах зээлийн нийт үнэ цэнэ
	Нийт хөрөнгийн үнэ цэнэ

Компанийн сайн засаглал нь компаниудын, ялангуяа үнэт цаас нь нийтэд чөлөөтэй арилжаалагдаг хувьцаат компаниудын удирдлага, зохион байгуулалтын тогтвортой бөгөөд зохистой ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж хувьцаа эзэмшигчид болон компани хоорондын итгэлцэл хэвээр хадгалагдаж улмаар тухайн компаниудад хөрөнгө оруулалт татах чадвар болон харилцагч байгууллага, бизнесийн түншүүдийн дунд нэр хүнд нь өсөн нэмэгдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Өнөөдрийн байдлаар дэлхийн улс орнууд төдийгүй олон улсын байгууллагуудын хэмжээнд 1999 онд анх баталж, улмаар 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулаад байгаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын баталсан “Компанийн засаглалын зарчмууд” -ыг хүлээн зөвшөөрөөд байна.

Компанийн засаглалын үндсэн 4 зарчим байдаг. Үүнд:

- Ил тод, нээлттэй байх
- Тайлагнадаг байх
- Хариуцлагатай байх
- Шударга, адил тэгш хандах

Сүүлийн үед Компанийн засаглалыг сайжруулах асуудалд төр засаг, хувийн хэвшлийн хүрээнд нэлээд олон чухал арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал:

- “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” –ийг баталсан
- Засгийн газрын 2009 оны 377 дугаар тогтоолын дагуу ҮХШХ-ноос Компанийн засаглалын хөгжлийн хөтөлбөр “ баталсан,
- Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлан гаргасан.

Хорооноос зөвлөмж болгон гаргасан уг кодексын зарчмуудыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компани бүр баримтлан ажилласнаар хувьцаа эзэмшигч болон компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТҮЗ/ нь:

- Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцох замаар компанийн удирдах үйл ажиллагаанд оролцож хувьцаагаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ шуурхай, баталгаатайгаар хянах боломжоор тэгш хангагдах эрхээ хэрэгжүүлэх бодит боломж бүрдэх;
- Хуралд оролцохдоо саналлаа хэлэх, сонирхсон асуултаа тавьж зохих хариултыг авах, компанийн хийх аливаа сонирхлын зөрчилтэй эсвэл их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудлаар ижил төрлийн хувьцаа эзэмшигчдэд адил тэгш эрх эдлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой болох;
- Ил тод байдлаар, хууль тогтоомжийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн саналыг бүрэн хэлэлцүүлсний үндсэн дээр сонгогдсон, хангалттай тооны хараат бус гишүүд бүхий ТҮЗ нь компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар бүрэн хангахын хамт гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд байнгын зохистой хяналтыг тавьж, хувьцаа эзэмшигчдийн өмнө үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн тайлагнах;

- Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ганцаар болон хамтын зарчим бүхий багаар /Кодекст зөвлөснөөр/ гүйцэтгэх удирдлага нь ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн өмнө ажлаа тогтмол тайлгаха;
- Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргахад шаардлагатай компанийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, емч хөрөнгийн болон удирдлагын бүтэц зохион байгуулалт зэрэгтэй холбоотой үнэн зөв мэдээллээр цаг тухай бүрд нь хангагдах зэрэг боломжтой болох юм.

2010 онд УИХ -д өргөн барьсан Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хувьцаа эзэмшигчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн засаглалыг нэвтрүүлэх, хуулийн зарим зүйл заалтыг олон улсын жишигт нийцүүлэх, компанийн үйл ажиллагаанд хяналт тавих төрөл бүрийн арга, боломжийг нээх зорилгоор Компанийн засаглалын кодекст заасан төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, тохиромжтой этгээд болон тэдгээрийг сонгох, мэдээллийн ил тод байдал болон ногдол ашиг хуваарилах эсэх тухай тооцоо судалгаа, үндэслэл зэрэг мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тайлгаха, хулиар хүлээсэн үргээ хэрэгжүүлээгүй этгээдэд авах арга хэмжээ болон хорооны эрх хэмжээтэй холбоотой бусад олон заалтуудыг уг хуулийн төсөлд тусган хэлэлцүүлж байна.

Компанийн засаглалыг сайжруулсанаар :

- Гаднаас хөрөнгө авах боломж нэмэгдэнэ.
- Хөрөнгийн зардлыг бууруулдаг
- Компанийн үйл ажиллагааг сайжруулдаг
- Компанийн үнэлээмжийг өсгөдөг
- Компанийн үйл ажиллагаанаас шалтгаалсан хямрал, дуулиант хэрэг гарах эрсдлийг бууруулдаг

Олон Улсын хэмжээнд Компанийн засаглалыг тооцоходоо Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага буюу /OECD/ -аас гаргасан “Корпорацийн Засаглалын үнэлгээний загвар”-ын дагуу Тобины Коэффициентоор үнэлдэг. Тобины Q харьцаа нь хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж байгаа компанийн нийт хувьцааны зах зээлийн үнэ цэнийг тухайн компанийн нийт хөрөнгийн өнөөгийн үнэ цэнэтэй харьцуулсан харьцаагаар илэрхийлэгддэг. Q харьцаа нь 1-ээс бага 0-оос их байвал пүүсийн хөрөнгийн үнэ цэнэ хувьцааны үнэ цэнээс өндөр байна. Энэ нь хувьцаа зах зээлд хямд байгааг илтгэнэ. Харин Q харьцаа нь 1-ээс их байвал пүүсийн хувьцааны үнэ цэнэ хөрөнгийн үнэлгээнээс өндөр байгааг харуулах бөгөөд зах зээлд хувьцаа нь өндөрөөр үнэлэгдэнэ.

Манай улсын хувьд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нь Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн чиг үүргийн нэг бөгөөд тус Хороо нь хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болон зохицуулалтын хүрээний байгууллагын удирдлагын зохистой үйл ажиллагаанд анхаарал хандуулж ажиллах ёстой.

Сүүлийн үед хөрөнгийн зах зээлийг либеральчлах, хөрөвх чадварыг сайжруулах, хөрөнгө оруулагчдыг татах асуудал судлачдын анхаарлыг татаж байна. Үүний тулд:

- Гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын хөрөнгийн зах зээлд ямар нэгэн хязгаарлалтгүй оролцуулах, дотоодын зах зээлийг дэлхийн зах зээлтэй нэгтгэх, хөрөнгийн урсгалыг саадгүй болгох
- Дотоодын компаниудын гадаад зах зээлд гарах үндсэн нөхцөл болох нягтлан бодох бүртгэл, аудит, мэдээллийн системийг нэвтрүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулагчид зах зээлд оролцсоноор арилжааны систем, хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудал тулгардаг. Ингэснээр хөрөнгө оруулагчдыг

улам бүр татдаг.

Дээрх байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хориг саадыг арилгаснаар хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа сайжирдаг. Дээрхээс дүгнэхэд зах зээлийн либеральчлах нь хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэн хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулснаар эдийн засгийн өсөлтөнд нөлөөлдөг.

Монгол Улсын хувьд Хөрөнгийн зах зээл үүсэж хөгжсөнөөс хойших хугацааны хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүдээс харахад эдийн засгийн өсөлтөнд хамаарал ажиглагдсангүй. Гэвч уул уурхайн салбарын хөгжил эрчимжсэнтэй холбоотойгоор сүүлийн 3-4 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээл хөгжиж байна. Иймд хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгосоноор хөрвөх чадвар сайжирч энэ нь улмаар манай улсын эдийн засгийн хөгжилд эрэгээр нөлөөлөх боломжтой юм.

Сүүлийн үеийн судлаачдын хүчтэй тавьж буй нэг санаа нь хөрөнгийн зах зээл буюу үнэт цаасны зах зээл нь янз бүрийн механизмыг ашиглан хөрөнгө оруулалтыг үр ашигтай хуваарилснаар эдийн засгийн өсөлтөд хүрнэ. Механизмууд нь:

1. Хөрөнгийг цуглуулах: Энэ нь маш том хөрөнгө оруулалтын боломжит төслүүдэд хямд хөрөнгө оруулалт хийх зорилгоор хөрөнгийг төвлөрүүлэх.
2. Эрсдлийг ялгах: Энэ нь ялгаатай багц хөрөнгүүдийг тодорхойлсноор эргэн төлөгдөхгүй байх, бүтээмжийн эрсдлийг бууруулна.
3. Хөрвөх чадварын менежмент: Энэ нь хөрөнгө оруулалтын төслийг хөрвөх чадвараар хангах
4. Шалгаруулах: Төслийн мэдээллийг цуглуулж үнэлэн хамгийн ашигтайд нь хөрөнгийн сувгийг чиглүүлэх
5. Хяналт: Энэ нь зээлдэгчийн хэлэлцээрээ бүрэн гүйцэтгэж байгаа эсэхийг тодорхойлох



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ НЬ: ИРГЭДИЙН ОРОЛЦОOG ХАНГАХ БОЛОН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, БОДИТОЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

*Ч. Базар (Ph.D)*

### **Асуудлууд:**

- Үндэсний, орон нутгийн ба хувь хүний түвшинд баримтлах тогтвортой хөгжлийн зарчмууд
- Хамтын ажиллагааны үйл явцыг бий болгох нь
- Иргэдийн оролцоог хангах нь
- Мэдээлэл авах эрх ба байгаль орчны хуулиуд
- Шийдвэр гаргахад оролцох эрх ба байгаль орчны хуулиуд
- Байгаль орчны эрхийн талаарх олон улсын хууль тогтоомж, хэрэгжүүлж болохуйц арга барил:
  - Олон улсын гэрээ конвенци - Аархусын Конвенци
  - Байгаль орчны эрхийн Билл-Канад улсын туршлага

\* \* \*

### **1. Үндэсний, орон нутгийн ба хувь хүний түвшинд баримтлах тогтвортой хөгжлийн зарчмууд**

Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх 1992 оны дэлхийн дээд хэмжээний уулзалтаар хүлээн зөвшөөрсөн Хөтөлбөр 21-ийн үндсэн зарчмын нь улс орны хөгжил нийгэм -эдийн засгийн байдлыг сайжруулахад чиглэгдэхийн сацуу хойч үеийнхний эрэлт хэрэгцээг хангахад бэрхшээл учруулахгүй байх ёстой гэдэгт оршиж байна. Энэ нь байгалийн нөөцийн хэрэглээг нөхөн сэргээгдэх буюу зохистой түвшингээс хэтрүүлэхгүйгээр байгалийн нөөцийг хамгаалан хадгалж үлдэнэ гэсэн үг юм. Хөтөлбөр-21-ийн тогтвортой хөгжлийн зарчмуудад дараахи зүйлүүд орно:

- Хүний амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Орон нутгийн иргэдэд хүрээлэн буй орчноо хамгаалах боломж олгох;
- Өөрчлөлтөд зохицох газар дэлхийн даацыг харгалзан үзэх;
- Байгалийн сэргээгдэх нөөцийг нөхөн сэргээх түвшинд ашиглах;
- Байгалийн дахин сэргээгдэхгүй нөөцийг шавхаж ашиглахаас зайлсхийх, ашиглалтыг багасгах, ашиглалтын үр дагаврыг арилгах;
- Байгаль экологийн нөөц, үйл явц, экологийн тогтолцоог хамгаалан хадгалах;
- Хөгжлийг байгаль хамгаалалттай нэгдмэл байдлаар үзэх зэрэг болно.

Үндэсний түвшинд	Орон нутгийн түвшинд
<ul style="list-style-type: none"> <li>Өнөөгийн, хойч үеийн хэрэгцээг харгалзан үзсэн хэтийн төлвийг баримтлах</li> <li>Хувь хүн байгаль орчныг хайрлан хамгаалдаг байх (боловсрол, ухамсыг дээшлүүлэх, зан үйлийг өөрчлөх)</li> <li>Хил залгаа улс орнуудтай хамтран ажиллах</li> <li>Үндэсний зохих хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны аргачлалыг хэрэглэх</li> <li>Үрьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх хоёрын хоорондын зааг ялгааг сайтар ухамсарлаж ойлгосон байх (урьдчилан сэргийлэх нь хямд тусдаг)</li> <li>Бохирдуулагч нь хохирлыг барагдуулах зарчмийг баримтлах</li> <li>Шийдвэр гаргахдаа санхүү, эдийн засгийн үнэлгээг харгалзахтай адил түвшинд БОНБҮ-г заавал харгалзах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өнөөгийн болон хойч үеийн хэрэгцээг харгалзан үзсэн хэтийн төлвийг баримтлах, бусдыг ийм байр сууринаас хандуулах</li> <li>Бусадтай хамтран ажиллах, тоон болон бусад мэдээлэл солилцох</li> <li>Аль болох нээлттэй байх</li> <li>Байгаль орчны эсрэг бус байгаль орчинтой хамтарч ажиллах (байгалийн чадавхи, байгалийн хязгаарлалтын хүрээнд)</li> <li>Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийг тэргүүний чиглэл болгох</li> <li>Хөрөнгө оруулагчдыг аль болох байгаль орчинд халгүй эд материал, үйл ажиллагаа ашиглахыг уриалах</li> <li>Хэт өндөр зардал өртөггүйгээр аль болох сайн техник, технологи ашиглах</li> <li>Хөрөнгө оруулагчидтай түншлэл байгуулан ажиллах</li> </ul>

\* \* \*

## 2. Хамтын ажиллагааны үйл явцыг бий болгох нь

Хамтын ажиллагааны үйл явц нь:

- Сонирхогч бүх талын санал, хүсэлтийг харгалзан хүлээн авах нээлттэй хөтөлбөр бүхий байх;
- Шударга байх;
- Итгэлцэлд суурилсан байх;
- Бүх талын нөөц бололцоог тэгшээр дайчлах, хангах;
- Яриа хэлэлцээрт тэгш эрхтэйгээр оролцох боломжтой байх;
- Тодорхой байх гэсэн зарчимд суурилдаг.

Энэхүү зарчмийг хэрэгжүүлэхдээ хамтын ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд улс орны арга зүйгээс жишигэлхэд түүндээ хамтын ажиллагааны зохион байгуулагчийг сонгох, оролцогч талууд, шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлох, оролцогчдод мэдээлэл түгээх, санал хүсэлт авах арга замаа тохиролцох, нөөц бололцоогоо үнэлэн тэгш дайчлах, мэдээлэл болон шийдвэрийг түгээх харилцаа холбооны стратеги зэрэг үе шатыг тусгагдаг байна.

Байгаль орчны асуудалд өөр хоорондоо зөрчил бүхий ашиг сонирхолтой олон тал оролцдог тул шийдвэрлэхдээ хэцүү байдаг. Тухайлбал, бизнесийн байгууллагууд төсөл хэрэгжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэхийг хүсдэг бол иргэд өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үр хүүхэддээ санаа зовж, унаган байгаль, өмч хөрөнгөө бүрэн бүтэн байлгах, төв, орон нутгийн захиргаа нь иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахаас гадна татвар авч, төсвөө нэмэгдүүлэх сонирхолтой байдаг. Харин Засгийн газар нь улс орныхоо сайн сайхан байдалд бүхэлд нь анхаарахын хажуугаар дээрх бүх ашиг сонирхлыг хангаж байх үүрэгтэй.

Иймээс бүх талын тэгш оролцоотойгоор байгаль орчны асуудлыг шударгаар шийдвэрлэхэд энэхүү хамтын ажиллагааны үйл явцыг зайлшгүй бий болгон хэрэгжүүлэх ёстой гэж олон

нийтийн байгууллага, эрдэмтэн судлаачид үздэг. Үүний тулд дараахи зүйлүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Монгол улсын Их хурал нь Байгаль орчны асуудлаарх аливаа шийдвэрийг сонирхогч бүх талын оролцоотойгоор шийдвэрлэх “хамтын ажиллагааны үйл явц”-ыг байгаль орчны болон бусад холбогдох хуулиудад тусгах. Ялангуяа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон дэд бүтцийн барилга байгууламжийн томоохон төслүүдэд зөвшөөрөл олгоход дээрх тогтолцоог хэрэгжүүлэх заалтыг Ашигт малтмалын болон бусад хуульд тусгах;
2. Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчны хуулиуд дахь иргэдийн оролцоог хангахад чиглэсэн заалтуудыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд “хамтын ажиллагааны үйл явц”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжилтэд хяналт тавих;
3. Мэргэжлийн хяналтын байгууллагууд нь төв, орон нутгийн түвшинд байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад “хамтын ажиллагааны үйл явц”-ыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих
4. Иргэд, ИНБ-үүд нь байгаль орчны асуудалд иргэдийн оролцоог хангах хуулийн заалтыг амьдралд нэвтрүүлж, “хамтын ажиллагааны үйл явц”-ыг буй болгох үйл явцыг эхлүүлж, жишиг тогтоох зэрэг болно.

### **3. Иргэдийн оролцоог хангах нь**

Байгаль хамгаалахад чиглэгдсэн иргэдийн оролцоо нь доорх гурван хэлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд энэхүү оролцоог хангахад хууль эрх зүйн таатай орчин чухал юм.

Мэдээлэл авах эрх

- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн 5.2.4-д “...байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн”;
- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн 4.1-д “... иргэд холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн зөв, мэдээлэл авах эрхтэй”;
- “Агаарын тухай хууль”, “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль”, “Ойн тухай хууль”, “Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль”-д мөн мэдээлэл авах эрхтэйг хуульчилсан;
- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль” - ийн 19, 22, 26, 28, 42, 50, 55, 56 зүйлүүд тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны ил тод байдлын тухай;
- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль” - ийн 42-р зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах....асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллах тухай”;
- Мөн хуулийн 42.2-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай”;
- Мөн хуулийн 42.3-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулах тухай”;
- Мөн хуулийн 48.10-р зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлберийн хэмжээг ... нийтэд мэдээлэх тухай”;
- Мөн хуулийн 57-р зүйлд Байгаль орчин, хүний эрүүл мэндэд серөг нөлөө

- үзүүлэх үйл ажиллагааны тухай мэдээллийг нууцлахыг хориглох тухай;
- Мөн хуулийн 19.3-19.6-р зүйлд Хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход аймгийн Засаг даргын санал авах тухай;
- “Байгууллагын нууцын тухай Монгол улсын хууль”-ийн 6-р зүйлд Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагааны тухай мэдээллийг нууцлахыг хориглох тухай;
- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хууль”-ийн 8-р зүйлд “Аливаа асуудлыг иргэдийнхээ нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн буюу иргэд, ТББ нь ИТХ-д асуудал оруулж хэлэлцүүлэх эрхтэй гэж тус тус заасан байна.

Байгаль орчны мэдээллийг авах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн ч тэдгээрийг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх тал дээр ихээхэн дутагдалтай байна. Мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх нэг арга нь “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”, “Усны тухай Монгол улсын хууль”, “Ойн тухай Монгол улсын хууль”-д заасан байгаль орчны мэдээллийн санг нэн даруй олон нийт болон орон нутгийн иргэдэд нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэх юм.

Дээрх мэдээллийн санд тухайн орон нутагт явагдаж байгаа үйлдвэр, үйлчилгээний БОНБҮ-ний тайлан, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, газар, ус, мод, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг бусдад эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарах гэж байгаа болон гарсан шийдвэрийг байршуулахи замаар орон нутгийн иргэд хэн ямар үйлдвэр, үйлчилгээг орон нутагт нь эрхэлж байгаа, үр дагавар нь юу болох, байгаль орчныг хамгаалах үргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дэлгэрэнгүй мэдээллийг саадгүй авч, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал байна.

### Шийдвэр гаргахад оролцох эрх

- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль” болон Ойн тухай Монгол улсын хууль”-д нөхөрлөл байгуулж ажиллах;
- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 5.4.8-д “БОНБҮ-ний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг тусгана”;
- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 7.3-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, тухайн төсөл хэрэгжих газрын иргэдийн саналыг харгалзан төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ”;
- “Газрын тухай Монгол улсын хууль”-ийн 53.2-д “Хадлан, бэлчээрийг ашиглах хуваарь гаргахад баг, хорооны ИНХ-ын саналыг харгалзана”;
- “Газрын хэвллийн тухай Монгол улсын хууль”-ийн 44.2-д “Иргэд газрын хэвллийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах санал санаачлага гаргаж, энэ талаар илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, таслан зогсоох болон төрийн байгууллагаас зохион байгуулж буй бусад ажилд идэвхтэй оролцож байвал зохино”;
- “Усны тухай Монгол улсын хууль”-ийн 19.1-д “Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаархи нутаг, дэвсгэрийн усны менежментэд нутгийн иргэдийг оролцуулах зорилгоор гол, мөрний сав газрын зөвлөл байгуулан ажиллана” буюу тус зөвлөлийн бүрэн эрхэд хяналт тавих, хамгалаах, нөхөн сэргээх талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, ус ашиглах эрхийг бүр

мөсөн цуцлах дүгнэлт гаргах зэргээр тусгасан;

- “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол улсын хууль”-ийн Орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүн;
- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай Монгол улсын хууль”-ийн 5.3-д “Олон нийтийн хяналтыг ТББ-уудад гэрээгээр хариуцуулж болно” хэмээн тус тус заасан байна.

**Нэгтгэн дүгнэхэд,** Байгаль орчны чиглэлээр аливаа шийдвэр гаргахад иргэд, олон нийт, ТББ-ийн саналыг харгалзан үзэж, олон нийтийн оролцоог хангах талаархи эрх зүй тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болно. Гэхдээ одоо мөрдэж буй хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавихын хажуугаар цаашид эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох чиглэлээр “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах, ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулсан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлах, орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал юм.

#### **4. Байгаль орчны эрхийн талаархи олон улсын хууль тогтоомж, хэрэгжүүлж болохуйц арга барил**

##### **Олон улсын гэрээ конвенци - Аархусын Конвенци**

Монгол Улс хүний эрхийн болон байгаль орчны гэрээ, конвенци, тунхаглалын ихэнхэд элсэн орсон ч хүний эрхийн зөрчил гарсаар байна. Хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд Монгол улс Аархусын конвенцид нэгдэх ёстой гэсэн байр суурьтай байдаг.

**Бодит байдал дээр жинхэнэ өөрчлөлт авчрахад бусад гэрээ хэлэлцээр амжилт олж чадахгүй байхад яагаад Аархусын конвенци амжилттай байдаг вэ?**

Энэ цаг үе бол НҮБ-ын ивээл, санаачлагаар байгаль орчны ардчиллын салбарт ихийг хийж бүтээхийг зорьж буй цаг үе юм гэж дэлхий хүлээн зөвшөөрөх байна. Аархусын конвенцийн албан ёсны нэр нь НҮБ-ийн баталсан “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай конвенци”.

1992 онд болсон Хүрээлэн буй орчин хөгжлийн талаархи Дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр Монголын болоод дэлхийн бусад улсын Засгийн газрууд Риогийн тунхаглалыг баталсан. Энэхүү тунхаглалын “Байгаль орчны аливаа асуудал нь бүх шатанд, сонирхсон бүх иргэдийн оролцоотойгоор л хамгийн оновчтой шийдвэрлэгдэж чадна. Үндэсний хэмжээнд засаг захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ялангуяа химийн хорт бодисын хэрэглээ, газар нутаг дээр нь явагдах үйл ажиллагааны талаар хүн бүр хангалттай мэдээлэл авч, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжоор хангагдах ёстой.

Төр холбогдох мэдээллийг нийтэд ил болгох замаар иргэдийн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээн хамгаалах,

шударгаар хянан шийдвэрлэх захиргааны болон шүүхийн процессуудаар хангагдах ёстой” гэсэн нь Аархусын конвенцийн 10 дугаар зарчмын хэрэгжилт мөн гэж үздэг.

Уг конвенци нь Мэдээлэл авах (түгээх), Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад оролцох, Зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулах гэсэн 3 үндсэн элементтэй.

### **Засгийн газар уг конвенцийг зөрчиж болох уу?**

Маш ховор бөгөөд үндэслэл нь:

- Аархусын конвенци Гомдол хүлээн авч, шийдвэрлэх өөрийн механизмтай (15 дугаар зүйл)
- Хэрвээ зөрчил гарвал иргэд, олон нийт Гомдлын хороонд хандаж болно.

Анхаарах зүйл:

- “Гомдол хүлээн авч шийдвэрлэх энэхүү механизм нь бусийн болон Засгийн газар хоорондын бусад гэрээ хэлэлцээрийн гомдлын механизмд жишиг болох ёстой гэж үздэггүй.”

#### **Шигтгээ:**

- “АНУ нь хэдийгээр Конвенцийн гишүүн бус боловч гомдол хүлээн шийдвэрлэх механизмтай холбоотой шийдвэр гаргахад саад болохгүй” гэж үздэг.

Гомдлын хороо нь Конвенцийн хэрэгжилтэд хяналт тавина, зөрчлийг хэлэлцэн шийдвэрлэнэ, сөргөлдөөнгүй ба шүүхийн бус үйл ажиллагаатай байдгаараа онцлог. 9 гишүүнтэй. Хорооны гишүүдийг конвенцийн гишүүн улсууд болон төрийн бус байгууллагууд нэр дэвшигж, Конвенцийн хурлаас гишүүд томилно. Дани, Украин, Польш, Швед, Гурж, Болгар, Нидерланд, Казакстан, Австри улсууд гишүүнээр одоо ажиллаж байна Женев дэх НҮБ-ын Европын Ажлын албаны байранд жилд 4 удаа хуралдана.

### **Хороонд хэн хандаж болох вэ?**

- Өөрийн улс нь Конвенцийн заалтыг зөрчсөн гэж үзвэл иргэд дангаараа болон хамтран гомдол гаргаж болно.
- Конвенцийн гишүүн улс бусад гишүүдийн талаар мэдээлэл өгч болохоос гадна Нарийн бичгийн дарга нарын газар нь Хороонд мэдээлж болно.
- Мөн Хороо өөрийн санаачлагаар хэрэг үүсгэж шийдвэрлэж болно.

### **Гомдлын хороо юу хийж чадах вэ?**

- Тухайн улс Конвенцийг хэрэгжүүлэхгүй байгаа талаар дүгнэлт хийнэ.
- Зөвлөмж гаргана. Бусад арга хэмжээ авч болно.

Гэхдээ Хорооны зөвлөмж, шийдвэрийг Конвенцийн гишүүдийн хурлаар батална. Бүх гишүүдийн хурал нь жинхэнэ эрх мэдэл бүхий байдаг. Гомдлын хорооны зөвлөмж, шийдвэрийг батлах эрхтэй. Хатуу арга хэмжээ авах тухай шийдвэр болон конвенцийг зөрчсөн талаарх дүгнэлтийг зөвхөн Бүх гишүүдийн хурал гаргаж болно. Түүнчлэн тухайн улсыг гишүүнээс хасч болно.

### **Яагаад Аархусын конвенци амжилттай хэрэгждэг вэ?**

Аархусын конвенцийн дагуу тухайн улсад үүсээд байгаа байгаль орчны шударга ёстой холбоотой олон асуудлыг шийдвэрлэх боломжтой. Олон нийт, төрийн бус байгууллагууд

Судалгааны эмхтгэл, XI боть

хэрэглэж болохуйц, үндэсний хууль тогтоомжоос дээгүүр хүчин чадалтай, үр дүнтэй хууль зүйн хэрэгсэл байж чадна.

### **Монгол улс Аархусын конвенцийг хэрэглэх боломжтой юу?**

Монгол улс одоогоор конвенцийн гишүүн бус. Гэхдээ гишүүнээр элсч болно. Аархусын конвенцийн 19.3 зүйл “Гэрээний талуудын уулзалтаар батлагдсан бол НҮБ-ын гишүүн аль ч улс Конвенцид нэгдэж (accede) болно” гэсэн заалт бий. Тиймээс Монгол улс энэ конвенцийн гишүүн болж болно

#### **Байгаль орчны эрхийн Билл – Канад улсын туршлага**

1970 оноос Канад улсын Байгаль орчны хуульчдын холбоо болон бусад байгууллагууд байгаль орчны хуулийг сайжруулахын төлөөх нөлөөллийг тасралтгүй хийснээр 1990 онд Зөвлөх хороо байгуулагдаж, 1994 онд Канадын Онтарио муж “Байгаль орчны эрхийн Билл” хуультай болжээ. 8 хэсэг бүхий энэхүү хуулиар зохицуулдаг гол харилцаа нь:

- Засгийн газар байгаль орчны үн цэнийг үнэлэх, шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоонд түшиглэх, жил бүрийн тайлан гаргах үүрэг хариуцлага хүлээх
- Байгаль орчны шийдвэр гаргах аливаа үйл явц дахь олон нийтийн оролцоо, шийдвэрүүдийг үнэлгээний ангилал, гомдол гаргах, шүүхэд хандах
- Байгаль орчинтой холбоотой шийдвэрүүдийг бүртгэх
- Иргэд, олон нийт байгаль орчны талаар гаргасан дүрэм журамд гомдол гаргах, мэдэгдэл хийх, шийдвэрийг хянуулахаар өргөдөл гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг болно.

Үг хуулийн бусад улсад туршлага болохуйц үзэл санаа нь байгаль орчны аливаа шийдвэрт иргэд, олон нийтийн оролцоог түшиглэх, иргэд шийдвэр болон байгаль орчны зөрчлийн талаар мэдэгдэл, гомдол санал гаргах, шүүхэд хандах, Засгийн газар үйл ажиллагаагаа олон нийтэд жил бүр тайлгнах зэргийг зохицуулж өгсөнд оршино.

Илтгэлд өгүүлснээ ерөнхийлөн дүгнэхэд үндэсний, орон нутгийн ба хувь хүний түвшинд баримтлах тогтвортой хөгжлийн зарчмууд нь байгалийн нөөцийн хэрэглээг нөхөн сэргээгдэх буюу зохистой түвшингээс хэтрүүлэхгүйгээр байгалийн нөөцийг хамгаалан хадгалж үлдэхэд чиглэдэг бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн иргэдийн оролцоог хангах нь чухал юм. Иргэдийн оролцоог хангахын тулд тэдний мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхийг нь хангахад чиглэсэн эрх зүйн орчныг зөв бүрдүүлж, улмаар бодитой хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар НҮБ-ийн баталсан “Байгаль орчны асуудлаа мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай конвенци”-д нэгдэн орох санаачллага гаргах нь зайлшгүй хийх, хойштуулшгүй ажил юм.

#### **Ашигласан эх сурвалж:**

- <http://www.unece.org/env/documents/2002//pp/ece.2.e.pdf>
- Хүний эрх хөгжил төв. FK fredskorpset байгууллагаас зохион байгуулсан “Байгаль орчин, Хүний эрх: Шударга ёс” үндэсний бага хурлын илтгэлүүд. 2009
- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Байгаль орчны талаархи багц хууль, Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль
- [www.ebr.gov.on.ca/](http://www.ebr.gov.on.ca/)

\* \* \*

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

# ХАВСРАЛТ

---

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“Бодлогын судалгаа, шинжилгээ”  
эмхтгэл (XI боть) -ийн хавсралт

**УИХ -ын 2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж  
гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа**

(XII ботид орсон бусад судалгааны жагсаалт)

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
-	<p>Парламентын үйл ажиллагаанд Тамгын газрын үүрэг (Үдирдамж)</p> <p>Ц. Шаравдорж (УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга)</p>	

#### Нэг. Хууль ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

1	<ul style="list-style-type: none"> <li>Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудлаархи бусад орны эрх зүйн зохицуулалт</li> </ul>	Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр
2	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын авилгын эсрэг хуулийн хэрэгжилт ба авилгатай тэмцэх орчны эрх зүйн чадамжийн талаархи тойм судалгаа</li> </ul>	Р. Хатанбаатар, Б. Хатантуул, Б. Мөнхцэцэг, А. Пагма
3	<ul style="list-style-type: none"> <li>Парламентын гишүүний халдашгүй байдлыг цуцлах бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</li> </ul>	Б. Буяндэлгэр, Г. Алтан - Оч (Ph.D), П. Амаржаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул, А. Пагма
4	<ul style="list-style-type: none"> <li>Гадаадын зарим орны парламентын шинжлэх ухааны шагналын талаархи товч мэдээлэл</li> </ul>	А. Пагма, Г. Гэрлээ

#### Хоёр. УЛСТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ, СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР

5	<ul style="list-style-type: none"> <li>Улстөрийн намын гишүүнчлэл, төлөвшил, нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль, парламент болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь</li> </ul>	Ч. Базар (Ph.D), П. Амаржаргал, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр
6	<ul style="list-style-type: none"> <li>Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улстөрийн намын орцлоо, үүрэг, нөлөө, гишүүдийн орон нутгийн хуралд нэр дэвших эрх, улстөрийн намуудын гишүүнчлэлийн тухай харьцуулсан судалгаа</li> </ul>	П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн
7	<ul style="list-style-type: none"> <li>Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг хамтад нь явуулах боломжтой эсэх асуудлаар харьцуулсан судалгаа болон лавлагаа мэдээлэл</li> </ul>	Р. Хатанбаатар, Б. Цолмонбаяр, Б. Хатантуул
8	<ul style="list-style-type: none"> <li>Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд</li> </ul>	Ц. Төвүүсүрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул

Судалгааны эмхтгэл, XI боть

9	<ul style="list-style-type: none"> <li>• Унитар улсуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишиг (Харьцуулсан судалгаа)</li> </ul>	Р. Хатанбаатар, А. Пагма, Б. Цолмонбаяр
10	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн эмэгтэйчүүдийн улстөрийн оролцоо (Харьцуулсан судалгаа)</li> </ul>	Ч. Базар (Ph.D), Т. Мягмаржав
<b>Гурав. ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР</b>		
11	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн зарим улсын парламентын ажлын албадын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа</li> </ul>	Ц. Нороевондог (Ph.D), Ц. Товуусурэн, А. Пагма, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, Г. Билээз, Ц. Болормаа, Б. Буюндэлгэр, Г. Гэрэл, Б. Дуламсурэн, Б. Мөнхцэцэг, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр
12	<ul style="list-style-type: none"> <li>• Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актуудын талаархи лавлагаа мэдээлэл</li> </ul>	Д. Жиагваагүнсэл, О. Нарантуяа, Θ. Мөнхтунгаглаг
13	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажлын албанаас үзүүлж буй үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)</li> </ul>	А. Пагма, Г. Гэрэл, Б. Мөнхцэцэг
14	<ul style="list-style-type: none"> <li>• Монголын парламент дахь иргэдийн оролцоо, цаашид сайжруулах арга зам</li> </ul>	Ч. Базар (Ph.D)
15	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентаас төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ажлын албанаас үзүүлж буй үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)</li> </ul>	К. Пүрээсурэн, Т. Мягмаржав
16	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)</li> </ul>	Ц. Мягмарцэрэн, П. Амаржаргал, Г. Билээз, Б. Дуламсурэн
17	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентад Ажлын албанаас үзүүлж буй судалгаа, архив, номын сангийн үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)</li> </ul>	Ц. Болормаа, Б. Хатантуул
18	<ul style="list-style-type: none"> <li>• Парламентын Тамгын газрын бүтэц дэх мэдээллийн технологийн албаны чиг үүрэг, түүний зохицуулалт (Харьцуулсан судалгааны дүгнэлт)</li> </ul>	Г. Алтан-Оч (Ph. D), С. Дорждагва
<b>Дөрөв. ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР</b>		
19	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хуулиа дээдлэхүй</li> </ul>	Ц. Товуусурэн
20	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, Япон улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийг үндсэн хуулийн эрхзүйн үүднээс харьцуулах нь</li> </ul>	П. Амаржаргал

21	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын [шинэ] Үндсэн хууль (1992)-ийн төслийг хэлэлцэж баталсан БНМАУ -ын Ардын Их Хурлын хуралдааны үйл явцын зарим тэмдэглэл (Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн оид зориулан бэлтгэв)</li> </ul>	Г. Чулуун
----	--	-----------

Тав. ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад		
22	<ul style="list-style-type: none"> <li>Монголын эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага</li> </ul>	H. Лүндэндорж (Sc.D), П. Амаржаргал
23	<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдлын секторын шинэчлэл ба түүнд тавих парламентын хяналт</li> </ul>	Г. Алтан - Оч (Ph. D)
24	<ul style="list-style-type: none"> <li>“Улаан түүх” -ийн босгон дээрх Богдын хүрээ (Нийслэл Хүрээ – 100 жил” сэдэвт Эрдэм шинжилгээний хуралд зориулав)</li> </ul>	Г. Чулуун
25	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээллийн аюулгүй байдлын талаархи зарим орны эрх зүйн зохицуулалт</li> </ul>	Ч. Базар (Ph.D)




UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



## Үншигчийн тэмдэглэл

# СИНЕМА СЧЛАПАДНЫСАН



## Үншигчийн тэмдэглэл

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©  
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»  
(Судалгааны эмхтгэл, XI боть)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр  
Хэвлэлтэд шилжүүлсэн 2012.3.09  
Тираж 400, Хэвлэлийн хуудас 20  
Цаасны хэмжээ 176 \* 250  $\frac{1}{10}$   
(Анхны хэвлэл)

УБ, 2012

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН